

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ISSN: 2313-6170

Түлхүүр үг: Орчуулгазүй

ОРЧУУЛГА ЗҮЙ

XI

(Орчуулагчийн чадамжийн асуудал)

Эрхлэн хэвлүүлсэн: Г.Элдэв-Очир

Улаанбаатар

2023

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ОРЧУУЛГА ЗҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦУВРАЛ

№11 (591)

Ариутган хянах зөвлөл

Эрхлэгч:	Ш.Эгшиг (доктор, дэд профессор)
Нарийн бичгийн дарга:	Г.Элдэв-Очир (доктор, дэд профессор)
Гишүүд:	Э.Равдан (ШУ-ны доктор, профессор) Го.Аким (доктор, профессор) С.Эрдэнэмаам (доктор, профессор) Л.Чулуунбаатар (доктор, профессор) Г.Буяннэмэх (доктор, профессор) О.Чинбаяр (МОЭ-ийн ерөнхийлөгч) М.Чимэдцэеэ (доктор, дэд профессор) К.Окада (Токиогийн ГСИС, доктор, профессор) Б.Баярмэнд (ӨМИС-ийн МСС, доктор, профессор) В.В.Мароши (Новосибирскийн УБИС, доктор, профессор) Мари Доминик Эвен (ФҮШУСТөв, доктор, профессор) Хоу Ваньжуан (Бээжингийн их сургуулийн Монгол судлалын төвийн зөвлөх, профессор)

Санаачлагч: МУИС, ШУС, ХУС, Орчуулга зүйн профессорын хамтлаг

Хянан засварласан: Ш.Эгшиг, Г.Элдэв-Очир

Хуудасны хэмжээ: А4

Хэвлэлийн хуудас: 31.57 хх

Хэвлэсэн тоо: 100 ш

Хэвлэлийн газар: “Удам соёл” хэвлэлийн газар

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

ISSN: 2313-6170

Key title: Орчуулгазүж

TRANSLATION STUDIES

XI

Compiled by: G.Eldev-Ochir

Ulaanbaatar

2023

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

TRANSLATION STUDIES

RESEARCH SERIES №11 (591)

Editor:

Egshig.Sh (National University of Mongolia, Mongolia)

Secretary:

Eldev-Ochir.G (National University of Mongolia, Mongolia)

Editorial Boards:

Ravdan.E (National University of Mongolia, Mongolia)
Akim.G (Ph.D, Professor, Mongolia)
Erdenemaam.S (Mongolian State University of Education, Mongolia)
Chuluunbaatar.L (National University of Mongolia, Mongolia)
Buyannemekh.G (National University of Mongolia, Mongolia)
Chinbayar.O (President of the Mongolian Translators Union, Mongolia)
Chimedtseye.M (National University of Mongolia, Mongolia)
Okada.K (Tokyo University of Foreign Studies, Japan)
Bayarmend.B (Inner Mongolia University, P.R.China)
Maroshi.V.V (Novosibirsk State Pedagogical University, Russia)
Marie-Dominique Even (French National Center for Scientific Research, France)
Hou Wanzhuang (Center of Mongolian studies of Peking University, P.R.China)

Founder:

Professors Team for Translation Studies, Division of Humanities, School of Arts and Science, National University of Mongolia

Edited by:

Egshig.Sh, Eldev-Ochir.G

Paper size:

A4

Number of pages:

31.57

Number of prints:

100

Press:

“Udam soyol” LLC

ГАРЧИГ

Өмнөтгөл үг		9
-------------	--	---

ОРЧУУЛГА ЗҮЙ

Г.Элдэв-Очир	Орчуулгын нэгжийн тухай ойлголт	12
Ш. Эгшиг	Орчуулагч хэлмэрчийн чадамжийн судалгааны зайлшгүй болох нь	19
Т.Мягмарсүрэн, Н.Ууганцэцэг	Орчуулах чадамж, түүний хөгжил, төрөл ангилал	27
С.Дугармаа, М.Нямдолгор, Б.Оюунсайхан, А.Амарзаяа	Шинжлэх ухаан, техникийн нэр томъёог гүүгл орчуулга ашиглан орчуулах нь	36
Т.Мөнхзул, Ц.Эрдэнэзаяа	Баримт бичгийн хэл найруулга, нэр томъёоны орчуулгын судалгаа	44
Б.Ариунбайгаль	Монголын эзэнт гүрний албан бичгийн уламжлал ба зарим тогтсон үг хэллэгийн орчуулгын тухайд	56
Д.Долгорсүрэн, У.Лхагвасүрэн	Орчуулах чадамж орчуулагчийн чадвараас хамаарах нь	66
Г.Бат-Учрал, В.И.Павлов	“Марко Пологийн аялал” бүтээлийн орчуулгын стратегид хийсэн дүн шинжилгээ	74
С.Энхчимэг	Монгол-солонгос албан бичгийн орчуулгын асуудалд	84

ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ СУДЛАЛ

Д.Бүрнээ	Л.Н.Толстойн нэгэн зохиолын орчуулгын тухай	91
С.Эрдэнэмаам	Шүүмжлэл судлал “унтсан” гээд “сулдаа ганхаж” болох уу?	98
Ц.Ичинхорлоо	“Шинэ орчуулсан улаан асрын зүүд”-ийн орчуулгын уран чадварт хийсэн ажиглалт	106
М.Амартайван	Орчуулгыг даатгая	117
Ч. Золзаяа	Монгол романы соёлын онцлог үгийн орчуулгын судалгаа	129

Д.Энхжаргал	Монгол яруу найргийн чех орчуулгад хийсэн ажиглалт	137
Г.Эрдэнэчимэг	Ирйөн үү? Иль ноён уу?	154
Л.Одонтуяа, Б.Гэрэлт-Ирээдүй, Навий Л.Н, Саригай	Хятад хэлний “把(Ба)” бүхий өгүүлбэрийг орос хэлнээ орчуулах нь (Зян Руны “Чонон сүлд” романы жишээгээр)	160
Э.Батжавхлан	Монгол улсын ардын уран зохиолч Т.Галсангийн орчуулгын ур чадварын тухай (Л.Ребрянугийн “Ион” романы монгол орчуулгын жишээн дээр)	171
Я.Бадамсүрэн, Ц.Энхцэцэг, Л.Халиун	Англи-монгол зүйр цэцэн үгийн орчуулгад хийсэн анализ	180
Б.Дулмаа	Яруу найрагч Ким Со Вөлийн шүлгийн монгол орчуулгын тухайд	190
О.Дэмчигмаа	“Субашид”-ын тайлбарын Чойжамцын орчуулга	206
Б.Одгэрэл, Д.Бадмаанямбуу	Хятад хэлний “bei” (被) бүхий өгүүлбэрийн монгол орчуулгын харьцуулсан судалгаа	219

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОРЧУУЛГА

Ж.А.Бойле Ким Ходон	Төв Азид дэлгэрсэн Александрын тууж Улс уу? Хант улс уу? Монголын эзэнт гүрний хаан болон хан цолны тухай	228 239
------------------------	---	------------

CONTENTS

Preface		9
TRANSLATION STUDIES		
G.Eldev-Ochir	Conception of translation unit	12
Sh.Egshig	Determining translation competence of translators and interpreters in Mongolia	19
T.Myagmarsuren, N.Uugantsetseg	Translation competence and its development and classification	27
S.Dugarmaa, M.Nyamdolgor, B.Oyunsaikhan, A.Amarzaya	Use of Google translate for translating scientific and technical terms	36
T.Munkhzul, Ts.Erdenezaya	Research on translation of terms and syntax of documentation	44
B.Ariunbaigal	About official document's traditions and the translation of some fixed words and expressions of the Mongol Empire (On an example of a letter sent by Kublai Khan to the king of Goryeo)	56
D.Dolgorsuren, U.Lkhagvasuren	Relationship between translation competence and translator's skills	66
G.Bat-Uchral, V.I.Pavlov	An analysis of Translation Strategies on "Travel of Marco Polo"	74
S.Enkhchimeg	Translation issues on Mongolian-Korean formal documents	84
TRANSLATION CRITICISM		
D.Burnee	Concerning on translation of one novel by Leo Tolstoy	91
S.Erdenemaam	Is it right to sway loosely for the reason that translation criticism 'has stagnated'?	98
Ts.Ichinkhorloo	Observations on translation skill of "Newly translated Ulaan Asriin Zuud"	106

M.Amartaivan	Let's leave translation to talented translators	117
Ch.Zolzaya	A study on translation of culture-specific realia in Mongolian novel	129
D.Enkhjargal	Observations on Czech translation of Mongolian poetry	137
G.Erdenechimeg	Iryon or Il noyon?	154
L.Odontuya, B.Gerelt-Ireedui, Navii L.N, Sarigai	Chinese sentences “把(ba)” and their translation into Russian (Based on the example of Jiang Rong's “Wolf Totem” novel)	160
E.Batjavkhlan	About translation skills of T.Galsan, the Honored People's Writer of Mongolia (On the example of Mongolian translation of the novel “Ion” by Liviu Rebreanu)	171
Ya.Badamsuren, Ts.Enkhtsetseg, L.Khaliun	Analysis of English-Mongolian Proverb translation	180
B.Dulmaa	About Mongolian translation of poems by Kim So-Wol	190
O.Demchigmaa	Chojiamts's translation of “Subhashita” commentaries	206
B.Odgerel, D.Badmaanyambu	A comparative study of the Mongolian translation of the Chinese sentence with “Bei”	219

ACADEMIC TRANSLATION

Boyle J.A.	Alexander Romance in Central Asia	228
Kim Hodong	Ulus or Khanate? An Analysis of the Titles of ‘qa’an’ and ‘khan’ in the Mongol Empire	239

ӨМНӨТГӨЛ ҮГ

“Орчуулга зүй” сэтгүүл 2013 онд анхны дугаараа гаргаснаас хойш эдүгээ арван нэг дэх дугаараа толилуулж байна. Сэтгүүлийн бодлого бол дэлхийн орчуулга зүйн чиг хандлагыг даган, орчуулга судлал ба хэлмэрчлэхүйн түвшинд судалгаа хийхийг дэмжих, олон улсын өндөр түвшний эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэн нийтэлдэг сэтгүүлийг хөгжүүлэх явдал юм.

Манай улсад эдүгээ албан ёсоор түм гаруй монгол орчуулагч, хэлмэрч ажилладаг гэсэн тооцоо гарсан юм. Харин зах зээлд үүнээс ч олон гадаад хэлний мэргэжилтэн бэлтгэгдсэн байдаг ажээ. Энэ хэрээр Монгол улсад гадаад харилцаа өргөжин тэлж, эдийн засагт орчуулгаар дамжсан олон бүтээн байгуулалт өрнөж, улс орон маань цэцэглэн хөгжихөд хэлмэрч, орчуулагчдын хувь нэмэр их юм. Мөн бичгийн орчуулгаар дамжин гадаадын шилдэг, сонгодог уран зохиолыг монголчууд аль түүхэн үеэс орчуулан, эх хэлээрээ дэлхийн соёлоос шимтэн хүртэж оюуны цангаагаа тайлдаг уламжлал өнөө хэр хэвээр хадгалагдан, дэлхийн хамгийн их зарагддаг ном хэвлэлийн орчуулгын ажлыг ч манай орчуулагч нар цаг алдалгүй орчуулж, уншигчдын хэрэгцээг хангаж ирлээ. Ийм сайхан ажлын хажуугаар орчуулагч, хэлмэрч нийтээрээ орчуулгыг чанартай хийдэг эсэхэд зарим уншигч, хэрэглэгч нар эргэлзсэн хандлага нийгмийн орчинд бас байсаар байна. Иймд чанартай орчуулга гарахын үндэс нь чадамжтай мэргэжилтнийг олшруулахад анхаарах явдал юм.

Манай сэтгүүлийн зөвлөл уламжлал ёсоор тухайн жилд зохион байгуулагдсан Орчуулга зүйн эрдэм шинжилгээний хурлын сэдэвт төвлөрч, уг сэдвээр бичсэн өгүүллийг түлхүү хэвлэж ирснийг байнгын уншигчид маань анзаарсан буй заа. Энэ дугаар орчуулагчдын чадамжийн судалгаагаар бичсэн хэдэн судалгааны өгүүллийг нийтэлж байгаа бөгөөд, 2021 онд эхэлсэн “Орчуулагч, хэлмэрчийн чадамжийн судалгаа” МУИС-ийн өндөр түвшний судалгааны төслийн багийн ажил ч зохих хэмжээнд нийгэмд хандсан ажил болж, судалгааны үр дүнг шууд амьдралд нэвтрүүлэх боломжийг олгоно гэж үзэж байна. Мөн онд байгуулагдсан “Орчуулагч, хэлмэрчийн мэргэшлийн үнэлгээний төв” орчуулгын мэргэжилтнүүдийн ур чадварыг шалгах шалгалтын аргазүй, аргачлал боловсруулах ажлыг эхлүүлээ.

2012 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн МУИС-ийн Орчуулга зүйн хамтлагаас зохион байгуулж ирсэн эрдэм шинжилгээний арван нэгдүгээр бага хурал энэ жил “Орчуулгын чадамжийн асуудал” сэдэвтэйгээр цахим-танхимын хосолсон орчинд амжилттай зохион байгуулагдлаа. 2023 оны 4 дүгээр сарын 10-нд болсон уг эрдэм шинжилгээний хуралд олон судлаач илтгэл хэлэлцүүлж, улсынхаа орчуулгын үйл ажиллагааг хөгжүүлэхэд үнэтэй санал, зөвлөмжийг дэвшүүлж, орчуулга зүйн чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлэв. Ялангуяа орчуулгын дэд чадамжийн тухай илтгэлийг баг багаар ажилласан эрдэмтэд хамтран тавьж хэлэлцүүлсэн нь энэ хурлын нэг онцлох тал боллоо.

МУИС-ийн ШУС-ийн Орчуулагч, хэлмэрчийн мэргэшлийн үнэлгээний төв (ОХМҮТ) Монгол Улсын Гадаад Харилцааны Яамтай хамтран 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр олон улсын орчуулгын өдрийн уулзалтыг зохион байгууллаа. Энэ жилийн олон улсын орчуулгын өдөр “Орчуулгаар хүн төрөлхтний олон төрхийг илрүүлдэг” /‘Translation unveils many faces of humanity’/ гэсэн уриатай болж өнгөрөв. Уулзалтад Монгол Улсын ГХЯ-ны БТГ-ын захирал Г.Бямбасүрэн, тус газрын дэд захирал Д.Бямбадорж, АОДАГ-ын захирал А.Ананд, ТЗУГ-ын дэд захирал Д.Амарсайхан, нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц.Ганбаатар, МУИС-ийн ШУС-ийн ОХМҮТ-ийн эрхлэгч, АСТ-ийн дэд профессор Ш.Эгшиг, Ази судлалын тэнхимийн эрхлэгч, дэд профессор Г.Элдэв-Очир, тэнхимийн профессор Д.Бадмаанямбуу, профессор Ц.Онон, дэд профессор Б.Азаяа, дэд профессор Н.Гэрэлмаа, дэд профессор Б.Нэргүйжаргал, ахлах багш Э.Тогтуун, Т.Болдбаатар, Л.Соёл, Б.Дулмаа, багш С.Энхчимэг, Т.Загарпэрэнлэй, Европ судлалын тэнхимийн зөвлөх дэд профессор В.В.Павлов, Ж.Алтангэрэл, дэд профессор Л.Дорждэрэм, Их Британи, Америк судлалын тэнхимийн ахлах багш Ж.Эрдэнэбат, Ц.Отгонсүрэн нар оролцож, орчуулагч, хэлмэрч мэргэжилтний ур чадварыг үнэлэх, ахиулах, хамтарсан, захиалгат хөтөлбөр хэрэгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, оюутан дадлагажуулах, харилцан туршлага солилцох зэрэг чиглэлээр ажиллаж, цаашид хамтран ажиллах санамж бичиг байгуулан үйл ажиллагаагаа уялдуулахаар тогтлоо. ОХМҮТ-өөс сар тутмын “Орчуулгын дугуйлан”-г 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдөр нийгмийн бүх хүрээнийхэнд зориулсан индэр болгон эхлүүлэв.

“Орчуулгазүй” сэтгүүлийн арван нэг дэх дугаар ийнхүү нийтлэгдэж байна. Бид сэтгүүлийг анх үүсгэн хэвлүүлж эхэлснээс хойш жил тутам тогтмол гаргасаар ирлээ. Энэ дугаар Орчуулга зүй, Орчуулгын шүүмж судлал, Эрдэм шинжилгээний орчуулга гэсэн булантай гарч байна. Дугаарын онцлог бол орчуулгын чадамжийн тухай асуудлыг анх удаа хөндөж байгаа ба орчуулгазүйн чиглэлийн янз бүрийн байгууллагын эрдэмтэн судлаачдын өгүүлэл шалгаран хэвлэгдэж буй юм. Манай сэтгүүлийн зорилго бол Монгол дахь орчуулга зүйн чиг хандлагыг тодорхойлж, тулгамдаж буй асуудлыг шийдэх эрдмийн индэр болох явдал билээ.

Эрдэмтэн судлаач, номын садан, уншигч та бүхнээс сэтгүүлийн талаарх санал, шүүмж, зөвлөгөө хийгээд бүтээл туурвилаа байнга ирүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Орчуулга бол дэлхийн олон соёлын уулзвар, үндэстэн хооронд бие биеэ танин мэдэх гүүр нь юм. Сэтгүүлийн бичигч, уншигч, дэмжигчдийн эрдэм оюуны гэгээн мэлмий тунгалаг байж, бүтээл туурвилын уран найралт цагаан мөр ямагт дурайж байх болтугай.

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбар

“Гадаад хэлний орчуулга” хөтөлбөр

Таргуд Шагдарсүрэнгийн Эгшиг (Ph.D)

ОРЧУУЛГА ЗҮЙ

ОРЧУУЛГЫН НЭГЖИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Г.Элдэв-Очир¹

Abstract: *An important concept in translation theory is the translation unit. As a translator, having this knowledge is essential to fully understand and translate the source. Understanding the source means determining which part of the source corresponds to which vocabulary and syntax of the target language. Translation units can be words, conjunctions, independent structures, sentences, and source. In this regard, scientists have expressed their own opinion, and this concept needs to be taken seriously.*

Түлхүүр үг: *Орчуулгын нэгж, авиалбарын түвшин, бүтээврийн түвшин, үгийн сангийн түвшин, холбоо үгийн түвшин, өгүүлбэрийн түвшин, эхийн түвшин*

И.И.Ревзин, В.Ю.Розенцвейг нар “Ерөнхий ба машины орчуулгын зарчим” (1964) хэмээх бүтээлдээ, орчуулгын нэгжийг ангилан хуваасан нь орчуулгын дүн шинжилгээний үе шатын үндсэн үүргийн нэг гэжээ. Орчуулагч эх бичвэрийг ойлгох гэдэг нь эх бичвэрийн аль аль хэсгүүд нь орчуулах хэлний ямар үгийн сангийн нэгж болон өгүүлбэрзүйтэй тохирох харьцааг тодорхойлохыг хэлдэг. Энэ нь угтаа орчуулгын нэгжийн тухай ойлголт юм. “Орчуулгын нэгж бол эх хэлний бичвэрийн хамгийн бага хэсэг бөгөөд энэхүү хэсэг нь орчуулгын хэлний бичвэрийн аль нэг хэсэгтэй тохирох ёстой.” (В.Н.Комиссаров, 2002:48) Үүнээс үзэхэд, орчуулгын нэгж нь үг, холбоо үг, эсвэл бие даасан бүтээвэр ч (жишээ нь, сэтгэл хөдлөлийн утга илтгэсэн бүтээвэр) байж болно.

Я.И.Рецкер (1974:24-28) хэлэхдээ, өнөөг хүртэл маш олон судлаач “орчуулгын нэгж”-ийн талаар судалдаг ч бичгийн орчуулгад энэхүү асуудал байдаггүй гэжээ. “Орчуулгын нэгж” нь машины орчуулга болон аман орчуулгад (хам цагийн буюу синхрон орчуулга болон дараалсан орчуулга) чухал ач холбогдолтой ажээ. Гэвч үнэндээ, бичгийн орчуулгад орчуулгын нэгж нь үг, холбоо үг, өгүүлбэр, тэр бүү хэл бүхэл эх бичвэр ч байж болно. И.И.Ревзин, В.Ю.Розенцвейг нар “орчуулгын нэгж нь орчуулгад оролцож буй тухайн хоёр хэлэнд хамааралтай бөгөөд тухайлбал, франц-орос хэлний

¹ Доктор, МУИС, ШУС, ХУС, ORCID: 0000-0002-2735-0313

орчуулга дахь орчуулгын нэгж нь франц-герман хэлний орчуулгад огт хамааралгүй болно” гэжээ.

В.Н.Комиссаров (1990:187-189) орчуулгын нэгжийг “орчуулгын үйл явцын нэгж” гэж нэрлэжээ. Тэр бээр үзэхдээ, орчуулгын үйл явцад тодорхой цаг хугацаа шаардлагатай байдаг. Томхон хэмжээтэй зохиолыг нэг амьсгаагаар орчуулж барахгүй. Иймээс орчуулагчид эх зохиолыг хэсэг хэсгээр буюу тодорхой дэс дараалалтайгаар орчуулдаг. Үүнээс үзэхэд, орчуулгын үйл явцын хамгийн бага нэгж бол эх бичвэрийн нэг өгүүлбэр болно. Гэвч ганц өгүүлбэрт хангалттай мэдээлэл агуулагдахгүй учир орчуулагч тухайн агуулгыг бүрэн гаргахын тулд дараагийн өгүүлбэрүүдийг ар араас нь орчуулах болдог гэжээ.

Л.С.Бархударов үзэхдээ, орчуулга бол тухайн хэлний хэлэхүйн бүтээлийг агуулгын түвшинд өөрчлөхгүйгээр өөр нэгэн хэлний хэлэхүйн бүтээл болгон хувиргах үйл явц юм гэжээ. Энэ нь орчуулгад илэрхийлэх түвшний нэгжийг хувиргах шаардлагатайг илтгэсэн болохоос агуулгын түвшний өөрчлөлт биш юм. Үүнээс үзэхэд, орчуулагч нь орчуулгын үйл явцад эх бичвэрээс орчуулгын хамгийн бага нэгжийг олох ёстой бөгөөд энэ нь орчуулгын нэгж ажээ.

Орчуулгын нэгж бол орчуулгын онолд хамгийн ярвигтай асуудлуудын нэг юм. Учир нь хоорондоо адилгүй маш олон ойлголт байх бөгөөд зарим хүн орчуулгын нэгж хэмээх ойлголтыг эрс үгүйсгэдэг. Тухайлбал, орчуулгын нэгж гэж чухам юу болох, эх хэлний нэгж үү, эсвэл, орчуулгын хэлний нэгж үү, мөн хэлний хэлбэр буюу бүтэцтэй холбоотой юу, эсвэл, агуулга буюу утгын нэгж үү гэх мэт олон асуудлууд байна.

Л.С.Бархударов үзэхдээ, орчуулгын нэгж гэж эх хэлнээс орчуулгын хэлэнд дүйцэж буй нэгж юм. Өөрөөр хэлбэл, эх бичвэр нь орчуулгын хэлэнд дүйцэж байх хамгийн бага хэлний нэгж ажээ. Орчуулгын нэгж нь нэлээд ярвигтай бүтэцтэй агаад эх хэлний хамгийн бага нэгжээс бүрддэг гэж ойлгож болно.

Орчин цагийн хэл шинжлэлд хэлний 6 түвшин байна гэж үздэг. Үүнд: 1. Авиалбарын түвшин 2. Бүтээврийн түвшин 3. Үгийн сангийн түвшин 4. Холбоо үгийн түвшин 5. Өгүүлбэрийн түвшин 6. Эхийн түвшин

Орчуулгын нэгжийн түвшинг үүнд тулгуурлан авч үзэж бас болох юм. Иймд авиалбарын түвшний орчуулга, бүтээврийн түвшний орчуулга, үгийн сангийн түвшний орчуулга, холбоо үгийн түвшний орчуулга, өгүүлбэрийн түвшний орчуулга, эхийн түвшний орчуулга гэж ангилан үзэж болно.

1. Авиалбарын түвшний орчуулга

Авиалбар нь бие даасан утга агуулдаггүй бөгөөд зөвхөн утга ялгах үүрэгтэй юм. Авиалбар нь орчуулгын дадлагад заримдаа орчуулгын нэгж болдог бөгөөд эх хэлний авиалбарыг орчуулгын хэлний хамгийн ойролцоо дуудлагатай авиалбараар солих, эсвэл, эх хэлний үсэглэлд хамгийн ойролцоо үсгээр орлуулан сольж болно. Жишээлбэл, англи хэлний “Heath” гэх овгийг орос хэлнээ буулгахдаа авиалбар бүрд орос хэлний дуудлага

ойролцоо авиалбараар солино. [h]-г орос хэлний [х'] авиалбараар, [i:] -г орос хэлний [и] эгшгээр, [θ]-г орос хэлний [т] гийгүүлэгчээр тус тус солих бөгөөд англи хэлний “Heath” гэх овгийг орос хэлнээ “Хит” гэж буулгаж болно. Энэ тохиолдолд орчуулгын нэгж нь авиалбар болох бөгөөд эх хэл болон орчуулгын хэлний нэгж хоорондын дүйцсэн харьцаа нь орчуулгын хэлбэрийг тодорхойлжээ. Үүнийг транслитерация буюу авиачлан орчуулах (үсэгчлэн буулгах) гэж хэлж болно.

Хэрэв дүйцсэн харьцаа нь үсэглэлийн түвшинд байвал дамжуулж буй агуулга нь эх хэлний үгийн авиатай холбоогүй бөгөөд харин бичлэгийн хэлбэрт хамаатай байдаг. Энэхүү аргыг орчуулгад үсэгчлэн буулгах гэдэг. Жишээлбэл, англи хэлний Lincoln гэх оноосон нэрийг орос хэлнээ Линкольн гэсэн хэлбэрээр буулгадаг бөгөөд энэ нь үсэгчлэн буулгах аргыг ашигласан байна. Хэрэв авиачлан орчуулах аргыг ашигласан бол Линкен гэх ёстой байв. Учир нь англи хэлнээ энэхүү оноосон нэрийн дуудлага нь [ˈlɪŋkən] болно.

Анхаарууштай нь, бодит байдал дээр авиачлан орчуулах болон үсэгчлэн буулгах хоёр аргыг нарийн ялгаж үзэх нь маш бага бөгөөд үргэлж хослуулан хэрэглэдэг.

Авиалбарын түвшний орчуулгын бусад орчуулгын хэлбэрээс ялгаатай тал нь авиалбарт утга агуулагддаг гүйд оршино. Иймд энэхүү түвшний орчуулгын хэрэглээний хүрээ харьцангуй хязгаарлагдмал бөгөөд дараах хоёр нөхцөл байдаг. Үүнд: 1. Хүний нэр, газар усны нэр зэрэг оноосон нэрийн орчуулга. Жишээ нь: Churchill – Черчилль, Liverpool – Ливерпуль 2. Улс төр, соёл болон өдөр тутмын амьдралд онцгой байр суурьтай зүйлсийн орчуулга. Жишээ нь: brain drain – брейндрейн (авьяас чадвараа алдах), shop steward (ажилчдын төлөөлөл) – шопстюард, office – оффис

2. Бүтээврийн түвшний орчуулга

Зарим тохиолдолд бүтээвэр нь орчуулгын нэгж болох бөгөөд эх бичвэрийн дан үгийн бүтээвэр бүрд орчуулгын хэлний тохироог олно гэсэн үг юм. Тухайлбал, англи хэлний *tables* гэх үгийг орос хэлнээ *столы* гэж орчуулах үед, эх хэлний үгийн үндэс болох “*table-*” нь орос хэлний “*стол-*” хэмээх үгтэй тохирч байна. Харин эх хэлэнд олон тооны утга илтгэдэг “*-s*” бүтээвэр нь орос хэлний “*-ы*” бүтээвэртэй тохирч байна. Мөн англи хэлний *backbencher* гэх үгийг орос хэлнээ *заднескамеечник* гэж орчуулна. Үүнийг задалж үзүүлбэл:

Back – задне, bench – скамееч, er – ник

Энэхүү тохиолдлыг бүтээврийн түвшний орчуулга гэж үзэж болно. Гэвч хоёр ондоо хэлний утга дүйцсэн үгийн сан, түүний бүтээврийн бүтэц өөр байдаг тул ийм орчуулга нь авиалбарын түвшний орчуулгаас ховор тохиолддог.

3. Үгийн сангийн түвшний орчуулга

Авиалбарын түвшин болон бүтээврийн түвшний орчуулгатай харьцуулбал, үг нь орчуулгын нэгж болох тохиолдол түгээмэл байдаг. Доор хэдэн жишээ авъя.

He came home.
↓ ↓ ↓

Он пришел домой.

My brother lives in Moscow.
↓ ↓ ↓ ↓ ↓

Мой брат живет в Москве.

Дээрх жишээнд дүйцсэн харьцаа нь үгийн сангийн түвшин болох нь тодорхой байна. Анхаарах шаардлагатай нэг асуудал бол энд өгүүлж буй орчуулгын нэгж хэмээх ойлголт нь эх хэлний нэгжийг хэлж байна. Иймээс эх хэлний аль нэгэн үг орчуулгын хэлэнд хэд хэдэн үгээр орчуулагдсан тохиолдолд мөн л үгийн сангийн түвшний орчуулгад хамаарна. Жишээ нь:

...Jane and her mother were sort of **snubbing** her.

... Джейн и ее мать **относятся** к ней **свысока**.

Дээрх жишээнд буй англи хэлний *snub* гэх үгийн орос хэлнээ тохирсон хэлбэр нь “относиться свысока” юм. Гэвч энэ нь үгийн түвшний орчуулгад хамаарна. Учир нь энэ тохиолдолд эх хэлний нэгж нь үг байна. Эх хэлний нэгж ба орчуулгын хэлний тохирсон нэгж нь хэл шинжлэлийн ижил түвшинд хамаарахгүй тохиолдлыг олон түвшний тохироо (Разноуровневое соответствие) гэнэ. Харин үүний эсрэг тохиолдлыг дан түвшний тохироо (Одноуровневое соответствие) гэж нэрлэдэг.

Үгийн сангийн түвшний орчуулга нь хэдийгээр түгээмэл үзэгдэл боловч хэрэглээний хүрээ хязгаарлагдмал байдаг. Бүтэн өгүүлбэрийн хувьд үгийн сангийн түвшний орчуулгыг ашиглах тохиолдол маш ховор бөгөөд гагцхүү энгийн бүтэцтэй өгүүлбэрт л боломжтой юм.

4. Холбоо үгийн түвшний орчуулга

Хэлц үг болон тогтвортой холбоо үгийн орчуулга дээр энэхүү холбоо үгийн түвшний орчуулга хамгийн тод харагддаг. Хэл шинжлэлийн эдгээр нэгжийн утга нь тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн (үг) утгын цогц биш юм. Ийм нэгжийг үгчлэн орчуулах тохиромжгүй тул холбоо үгийг бүхэлд нь буюу цогц байдлаар орчуулах шаардлагатай болно. Жишээлбэл:

to catch fire – загореться

first night – премьера

to come to the wrong shop – обратиться не по адресу

to spill the beans – выдать секрет (проболтаться)

Эх хэл болон орчуулгын хэлэнд холбоо үгсийн “дотоод бүтэц” нь тохирч буй тохиолдолд л үгчлэн орчуулах боломжтой байдаг. Жишээлбэл:

to play with fire – играть с огнем

Хэлц үг болон тогтвортой холбоо үгээс гадна, чөлөөт холбоо үг ч мөн холбоо үгийн түвшний орчуулгын нэгж болно. Жишээлбэл:

to come late – опоздать

to get dressed – одеться

book parcel – бандероль

Эдгээр жишээнд англи хэлний холбоо үгийг бүрдүүлэгч үгс үндсэн утгаа хадгалсан байна. Гэвч орос хэлнээ орчуулахад орчуулгын нэгж нь бүхэл холбоо үг болно. Өөр жишээ авч үзье.

I improved her game immensely, though.

Но я ее здорово **натренировал**.

“He’s **got this superior attitude** all the time”, Akey said.

- Он всегда **задирает нос**, - говорит Экли.

Холбоо үгийн түвшний орчуулга харьцангуй их тохиолддог орчуулгын төрөл юм. Орчуулгын дадлагад эх хэлний өгүүлбэрийн аль нэгэн хэсгийг үгчлэн орчуулах буюу үгийн түвшний орчуулга хийж, харин бусад хэсгийг холбоо үгийн түвшинд орчуулах явдал түгээмэл байдаг. Жишээлбэл:

The terrestrial globe is a member of the solar system.



Земной шар входит в солнечную систему.

Энэ жишээнд, үгийн түвшинд тохирсон харьцаа нь terrestrial – земной, globe – шар, solar – солнечную, system – систему болно. Харин холбоо үгийн түвшинд тохирсон харьцаа нь “is a member of” – “входит в” болж байна.

5. Өгүүлбэрийн түвшний орчуулга

Холбоо үг орчуулгын нэгж болох аргагүй үед өгүүлбэрийн түвшинд сая орчуулгын дүйцсэн харьцааг тогтоох боломжтой болдог. Энэ нь ихэвчлэн өгүүлбэр нь хэлц үгээс бүтсэн тохиолдол байх бөгөөд тухайн өгүүлбэрийн утга нь өгүүлбэрийн гишүүдийн утгаас хамааралгүй байдаг. Зүйр цэцэн үгийн орчуулга нь энэ төрөлд багтдаг. Жишээ нь:

Every dark cloud has a silver lining.

Нет худа без добра.

Birds of a feather flock together.

Рыбак рыбака видит издалека.

Too many cooks spoil the broth.

У семи нянек дитя без глаза.

Үүнээс харахад, ийм төрлийн орчуулгын нэгж нь бүтэн өгүүлбэр байх тул өгүүлбэрийн доторх үг, холбоо үгийн хооронд дүйцсэн харьцааг тогтоох аргагүй юм. Өгүүлбэрийн түвшний орчуулгад мөн янз бүрийн анхааруулах бичиг, замын тэмдэг, мэндчилгээний үг зэрэг хэвшиж тогтсон үг хэллэгийн орчуулга багтдаг. Жишээ нь:

Keep off the grass. – По газонам не ходить.

Slow, men at work. – Тихий ход, дорожные работы.

There's a good boy. – Вот умница. / Вот паинька.

Өгүүллэгийн орчуулга дахь хэдэн жишээг дахин ажиглая.

I have to admit it. – Тут ничего не скажешь.

Don't even mention them to me. – Терпеть не могу.

...But outside of that I don't care much. – ...Но в общем это ерунда.

Дээрх жишээнээс харахад, англи хэлний өгүүлбэрүүд бүгд хэлц үгээс бүтээгүй бөгөөд тэдгээр өгүүлбэрийн утга нь өгүүлбэрийн гишүүдийн утгын нэгдэл байх тул өгүүлбэрийн түвшний орчуулга хийхээс өөр аргагүй болжээ.

6. Эхийн түвшний орчуулга

Өгүүлбэр нь орчуулгын нэгж болж чадахгүй тохиолдол орчуулгад мөн гарч болно. Ийм үед орчуулж буй бүхэл эх тэр чигтээ орчуулгын нэгж болдог. Энэхүү үзэгдэл нь үргэлжилсэн үгийн зохиолын орчуулгад тун ховор үзэгдэх бөгөөд харин яруу найргийн орчуулгад түгээмэл тохиолддог. Яруу найргийн орчуулгад эх болон орчуулгын хооронд үгийн сангийн түвшинд, холбоо үгийн түвшинд, цаашлаад өгүүлбэрийн түвшинд ч дүйцэх харьцааг тодорхойлох боломжгүй байх үед бүхэл эх тэр чигтээ орчуулгын нэгж болдог. Энэ тохиолдолд орчуулгын эх бүхэлдээ эх зохиолтойгоо дүйцэх ёстой бөгөөд учир нь ижил утга агуулга болон уран сайхны өнгө аясыг үндсэндээ хадгалсан байдаг.

Ерөнхийд нь авч үзвэл, орчуулгын нэгж нь авиалбараас эх хүртэлх бүхий л түвшинг хамарч байна. Тухайн эхийн хүрээнд орчуулгын нэгж нь үг, холбоо үг, өгүүлбэр гэх мэт аль ч түвшинд шилжиж болдог өвөрмөц онцлогтой ажээ. Иймд орчуулгын гол бэрхшээл бол тухайн тохиолдол болгонд тохирсон орчуулгын нэгжийг зөв оновчтой олох явдал юм.

Л.С.Бархударов эдгээр зургаан түвшний орчуулгын нэгжийг судалсныхаа дараа, “орчуулгын түвшин” гэх ойлголт нь орчуулгын онолын “дүйцсэн орчуулга”, “үгчилсэн орчуулга”, “чөлөөт орчуулга” зэрэг ухагдахуунуудтай холбоотой байж болох юм. Учир нь энэ бүхэн орчуулгын чанарын үнэлгээнд чухал үүрэгтэй юм гэж үзжээ.

Эх бичвэрийн агуулгыг тэр хэвээр нь дамжуулахын тулд орчуулгын түвшний шаардлагыг хангавал дүйцсэн орчуулга болдог. Түүнчлэн орчуулах хэлний хэлзүй, үгийн сан, найруулга зүйн дүрэм горимд яв цав нийцсэн байх учиртай. Харин үүний эсрэг байвал үхмэл орчуулга болно. Жишээлбэл, “The terrestrial globe is a member of the

solar system” гэсэн өгүүлбэр дэх “is a member” гэдгийг орос хэлнээ “является членом” гэж орчуулбал үхмэл орчуулга болно. Учир нь энэхүү холбоо үгийн утгыг үгийн сангийн түвшинд орчуулж болохгүй. Мөн англи хэлний “Keep off the grass” гэсэн анхааруулгыг орос хэлнээ “Держитесь прочь от травы” гэж орчуулбал бас л үхмэл орчуулга болно. Учир нь энэхүү анхааруулгыг үгийн сангийн түвшинд бус өгүүлбэрийн түвшинд орчуулах ёстой тул “По газонам не ходите” гэж орчуулбал сая дүйцсэн орчуулга болно.

Үгчилсэн орчуулга нь эхийн утга агуулгыг гажуудуулах, мөн орчуулгын хэлний дүрэм горим, дадал зуршлыг эвдэх аюултай юм.

Чөлөөт орчуулга нь үгчилсэн орчуулгыг бодвол эхийн утга агуулгыг гажуудуулаагүй, мөн орчуулгын хэлний дүрэм горимыг эвдээгүй байдаг. Гэвч эх бичвэрийн өөрчилж болохгүй хэсгийг дураараа өөрчилдөг тул эхийн утгыг бүрэн гүйцэт, зөв оновчтой дамжуулаагүй байх бөгөөд багагүй мэдээллийг орхичихдог. Үүнээс гадна, чөлөөт орчуулгын хамгийн аюултай нь өөрийн дураар нэмж хасдаг явдал юм. Уран зохиолын орчуулгад чөлөөт орчуулгыг тэвчиж болох ч албан бичгийн орчуулга, хууль эрхзүйн орчуулга, дипломат орчуулга зэрэгт яагаад ч хүлээн зөвшөөрч үл болно.

Дээрхээс үзэхэд, ямар ч төрлийн орчуулга байсан дүйцсэн орчуулга л орчуулагчийн баримтлах ёстой орчуулгын хэлбэр ажээ.

Ашигласан номзүй:

Бархударов Л.С. (1975), Язык и перевод. Москва

Комиссаров В.Н. (1990), Современное переводоведение. Москва

Комиссаров В.Н. (2002), Лингвистическое переводоведение. Москва

Комиссаров В.Н. (2008), Орчуулгын онол, УБ /орчуулсан Л.Үржиндорж/

Ревзин И.И., Розенцвейг В.Ю. (1964), Основы общего и машинного перевода. Москва

Рецкер Я.И. (1974), Теория перевода и переводческая практика. Москва

ОРЧУУЛАГЧ, ХЭЛМЭРЧИЙН ЧАДАМЖИЙН СУДАЛГААНЫ ЗАЙЛШГҮЙ БОЛОХ НЬ

Ш.Эгшиг²

***Товч агуулга:** Монгол үндэстэн оршин тогтносон бүхий л үедээ орчуулах хэлмэрчлэх ажлаас ангид байгаагүй бөгөөд, эртний соёлт, бичиг үсэгтэй үндэстнийхээ хувьд утга зохиолын арвин өвтэйн дээр орчуулгын өв нь түүнээсээ дутахааргүй юм. Монгол хүн ямагт өөр үндэстэн угсаатны тухайн үеийнхээ хамгийн тэргүүний уран зохиол, сургаал номын охь ундаргаас орчуулгаар дамжин хүртэж ирсэн байдаг. Энэ үйл хэргийг орчуулагч хэлмэрч гүүш нар гүйцэтгэдэг байсан билээ. Бид “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг” хэмээх орчуулгын нэр томъёоны толио XVIII зуунд туурвин бүтээсэн нь орчуулагч нарын чадамж тухайн үедээ ямар байсныг илтгэнэ. Өнөөгийн Монголын орчуулагч, хэлмэрч нарын ур чадварын байдлыг тогтоох, чадамжийг нь дээшлүүлэх аргазүй, аргачлалыг боловсруулах шаардлага тулгарч байгаа тул, энэ асуудлыг уг илтгэлд хөндлөө.*

***Түлхүүр үг:** орчуулгын чадамж, орчуулагчийн чадамж, хэлмэрчийн чадамж, орчуулгын стандарт*

Монголчууд дундад зууны үеэс гаднын зохиол бүтээлийг бодлоготойгоор орчуулж, мөн өөрсдийн зохиол бүтээлийг харь хэлд орчуулан түгээх, эзэнт гүрний бодлогыг хэрэгжүүлэхдээ өөр хэлт олон үндэстний ард иргэдтэй нэвтрэлцэх, өөр хоорондоо ойлголцох, мөн монгол хэлийг олон хэлтэнд заан сургах, олон үндэстний номтой мэргэдээс суралцах зэрэгт орчуулга ямар чухал болохыг хэн бүхнээс илүү мэдэж, төрийн албан харилцааны нэг чиг үүрэгт орчуулагч, хэлмэрч нарын ажил үүргийг чухалчлан авч үзэж байсан юм. Дундад зууны үед хэлмэрч болон бичгийн орчуулга хийдэг түшмэдийн үүрэг³ тодорхой байв. Эзэнт гүрний харьяаны харь хэлт угсаатны

²Доктор, МУИС, ШУС, ХУС, ORCID: 0000-0002-5904-9867

³商周时期已有“翻译” 古代翻译人员级别不高

<https://www.chinanews.com.cn/cul/news/2009/08-11/1812797.shtml>

дунд “хэлмэрч” гэх үг монгол үгийн утгаа хадгалсан монгол дуудлагаараа хэрэглээнд орж, үгийн санд нь сууж хэрэглэгдэх⁴ болсон жишээ цөөнгүй. Тэр бүү хэл, Хятадын Хань улсын түүхэнд торгоны замыг үүтгэгч Жан Чяний аян замын дагуул, хэлмэрч нь хүннү хүн⁵ байсан тухай “Бүс ба Зам”-ын судалгааны явцад хятадын эрдэмтэд тодотгон бичиж, арилжааны шинж бүхий уран сайхны кино хүртэл хийжээ.

Богд хаант Монгол улсад Консулын дэнжийн орчуулагчийн сургууль оршиж байсныг 1910 оны илтгэх гэрэл зураг⁶ дэлгэгдсэн байдаг. Харин олон улсын хурлын буюу хам цагт хэлмэрчлэх хэлмэрчийн сургалтыг 1930 онд Москвад эхлүүлж байсан баримт⁷ бий.

Орчин үеийн хэл шинжлэлийн ухааны ‘орчуулга зүй’ хэмээх ухаанд нэг хэлээр илэрхийлсэн утга санааг өөр нэг хэлээр илэрхийлэн хөрвүүлэхдээ хэрэв бичгээр илэрхийлж байвал бичгийн орчуулга, амаар илэрхийлэн санааг гаргаж байвал хэлмэрчлэл гэж үзэж байна. Энэ нь үндэстний нийтлэг хэл аялгуу хооронд, нийтлэг аялгуунаас нутгийн аялгуунд, эртний хэлнээс орчин цагийн хэлд гэх мэтээр аль нэг хэлбэрээс дурын хэлний хэлбэрт хөрвөх үйл явц юм.

“... орчуулга бол нэг хэлээр илэрхийлсэн санааг нөгөө нэг хэлний бүх хэрэглүүрийг ашиглан бүрэн төгс гаргах бүтээлч хөдөлмөрийн үр дүн мөн. Хэлний бүх хэрэглүүр гэдэг ухагдахуунд авиазүй, үгийн сан, өгүүлбэрзүй, найруулга зүйд хамаарах бүх хэрэглүүр багтана.”⁸ Орчуулга хэмээх ухагдахуунаар сүүлийн үед бичгийн орчуулгыг төлөөлүүлэн хэрэглэх болжээ. XX зууны дунд үеэс дэлхийн хамтын нийгэмлэг байгуулагдсан үеэс аман орчуулга буюу хэлмэрчлэх эрэлт хэрэгцээ өссөнтэй холбоотойгоор хэлмэрчлэхүйн үүрэг аяндаа тодрон, энэ талын судалгаа олноор гарах болов. Энэ үеэс бичгийн орчуулгыг хэлмэрчлэхээс тусад нь судлах болсон ч гэж үзэж болно. Орчин үеийн орчуулга зүй (Translation Studies) нь үндсэндээ бичгийн орчуулга ба хэлмэрчлэхийн гэсэн хоёр үндсэн чиглэлд хөгжиж байна.

Бичгийн орчуулга ч бай хэлмэрчлэх ч бай аль аль нь орчуулагч, хэлмэрчийн оролцоотой бүтэх үйл бөгөөд энэхүү үйл хэрхэн бүтэх, хэр зэрэг чанартай болох нь орчуулагч ба хэлмэрчийн ур чадвар, авьяас, мэдлэг, боловсрол, хичээл зүтгэлээс ихээхэн хамаарна.

⁴ Зограф.И.Т “Монгольско-китайская интерференция” Москва: Издательство “Наука” 1984, стр.39.

⁵ 冉诗洋,译者“堂邑氏胡奴甘父”姓名考辨,民族翻译 2019 年第 2 期 (总第 111 期) 65-69 页。

⁶ “Монгол орон ба монголчууд” цуврал

⁷ Weiwei Wang, Yi Xu, Binhua Wang, and Lei Mu, Developing Interpreting Competence Scales in China, Original Research, *Frontiers in Psychology*, April 2020, Volume 11, Articles 481 doi: 10.3389/fpsyg.2020.00481

⁸ Гүрбазар Р. Орчуулгын онол, дадлагын үндэс, Улаанбаатар, 1996, 5-р тал.

Уламжлалт хэлшинжлэлийн хийгээд орчуулга зүйн судалгаанд хүний хүчин зүйлийг авч үзэж, үүнийг голдуу орчуулгын шүүмжээр дамжуулан судлан шинжлэх гэж оролддог байсан ба орчуулгын тухай судалгааны сэтгүүл, сонин хэвлэлийн нийтлэл, өгүүллийн бараг талаас илүү нь хэн нэгэн орчуулагчийн хийсэн орчуулгыг үнэлж дүгнэсэн, шүүмжилсэн шүүмжийн шинжтэй бүтээл зонхилон гарч байв. Орчуулгын шүүмж нь зөвхөн эхийн түвшинд, хэл найруулга, үг сонголт, оноолтын байдалд шинжилгээ хийж, илэрхий алдааг заан шүүмжлэгч өөрийн зөв хувилбарыг дэвшүүлж, онолын үндэслэлтэйгээр тайлбар хийсэн шинжтэй байх нь түгээмэл байдаг юм. Энд бид “Утга зохиол, урлаг” сонин, “Орчуулах эрдэм”, “Цог” сэтгүүл, зарим судлаачийн нэг сэдэвт зохиол, орчуулгын бүтээлийн удиртгалд, ялангуяа эрдэм шинжилгээний бичиг болон хурлын илтгэлд ихээр хөндөгддөг байснаа, 1990-ээд оноос шинээр нээгдэж эхэлсэн гадаад хэлний хөтөлбөртэй их дээд сургуулийн багш, оюутан, аспирантын судалгааны ажилд түлхүү тусах болсныг тэмдэглэж байна. Сүүлийн үед орчуулгын шүүмжийн гол талбар нь интернэт орчинд шилжиж, илүү нийтлэлийн шинжтэй, цэвэр шүүмж яриа хэлбэрээр илүү тархаж эхэлсэн байна. Судлаачийн блог, цахим хэлэлцүүлэг, подкаст, коммент хэлбэрээр өрнөж байгааг өнөөгийн хүмүүсийн хандлагаас бид үзэж байна.

Тэдгээрийн нийтлэг хөндөж буй сэдэв, асуудлын тоонд орчуулагч, хэлмэрчийн ур чадварыг магтсан, сайшаасан, шүүмжилсэн, сайжруулах арга замыг эрэлхийлсэн агуулга их байна. Энэ байдал нь манай улсад орчуулгын үйлчилгээний салбарт идэвхтэй ажиллаж буй орчуулагч, хэлмэрчийн мэдлэг ур чадварыг үнэлэн дүгнэх, тэдний ур чадварыг дээшлүүлэх ажил зайлшгүй болж байгааг илтгэж байгаа хэрэг юм. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын гадаадтай хамтарсан зарим үйл ажиллагааны орчуулгын байдал, орчуулагч, хэлмэрчийн мэргэжлийн ур чадвар, орчуулгын бүтээлийн чанарыг шүүмжлэн хэлэлцэх нь нийгмийн орчин болон цахим орчинд элбэг тохиолдож байгаад анхааран, тухайн асуудлыг шийдэх гарц олох, гаргалгаа хийх нь орчуулга зүйн салбарын эрдэмтдийг нэгдэн ажиллахад хүргэж байна.

Нийт орчуулагч, хэлмэрчийн чадамж, мэргэжлийн ур чадварын түвшинг бодитоор үнэлэн тогтоох шинжлэх ухаанд суурилсан өргөн хүрээтэй судалгаа явуулах зайлшгүй шаардлага үүсжээ. Монгол улсад 2018 оны тоон мэдээгээр албан ёсны бүртгэлтэй буюу Орчуулгын үйлчилгээ эрхлэх тамгатай хэлмэрчлэх, орчуулах үйлчилгээ эрхэлдэг 630 гаруй байгууллага байдаг бөгөөд давхардсан бүртгэлээр 14 гадаад хэлний 800 гаруй орчуулагчид зөвхөн орчуулгын үйлчилгээний салбарт ажиллаж байна. Монгол Улсад бүртгэлтэй ААН байгууллагын 1200 байгууллага гаднын улстай хамтарсан, 2000 байгууллага гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байна. 50-аас дээш ажиллагчидтай байгууллага гадаад харилцааны хэлтэстэй гэж тооцож болох юм, тэгвэл 1600 байгууллага үүнд хамаарахаар байна. Үүнд дээр дурдсан орчуулгын 800 товчоо, төрийн 80 байгууллагыг нэмбэл, 5680 байгууллагад орчуулагч

хэлмэрч мэргэжилтнүүд ажиллаж байгаа юм. Нэг байгууллагад дунджаар 2 гадаад хэлний мэргэжилтэн ажиллаж байгаагаар тооцоход 12000 орчим идэвхтэй ажиллаж буй гадаад хэлтэй мэргэжилтэн Монгол Улсад ажиллаж байгаа багцаа тоо байна.

Дэлхийн хэмжээнд орчуулгын үйлчилгээний зах зээл сүүлийн 10 жилийн хугацаанд жил тутам өсөлттэй явж ирсэн юм. 2009-2021 онд дэлхийн орчуулгын үйлчилгээний үйлдвэрлэл 23.5%-56.18%-ийн өсөлттэй явж байгаа бөгөөд, зөвхөн 2009-2019 оны хооронд орчуулгын үйлчилгээний зах зээлийн хэмжээ хоёр дахин өсөж, зах зээлд эргэлдэх хөрөнгийн хэмжээ 49.6 тэрбум ам.долларт хүрсэн⁹ байна. Гадаад дотоодын орчуулгын үйлчилгээний зах зээл тэлэх хандлагатай байгаа өнөө үед мэргэжилтнийг бэлтгэх, сургах, мэргэшүүлэх шаардлага урган гарна. Бид өөрийн орны мэргэжилтний ур чадвар, боловсрол мэдлэгийг дээшлүүлэх талаар хийж бүтээж байгаа ажлаа үнэлж үзсэнээр цаашид ахин дэвших ажлаа төлөвлөх зураглалыг тодруулна. Үүний тулд, орчуулагч, хэлмэрч нарыг бэлтгэж ирсэн түүхийг нягтлах, мэргэжилтний эрэлтийн зах зээлийг судлан тогтоохын зэрэгцээ одоо байгаа мэргэжилтний чадамж ямар байгааг олон улсын түвшний эрдэмтдийн тогтоосон аргазүй, аргачлалаар үнэлж үзэх хэрэгтэй байна.

Манай улсад олон улсад мөрдөж буй орчуулгын үйлчилгээний стандарт (ISO17100, 2015)-ыг МУИС-ийн Орчуулга зүйн профессорын баг болон салбарын мэргэжилтний төлөөллийн саналаар 1:1 хэлбэрээр орчуулж авах хүсэлтээ СХЗГ-т гаргаж, 2017 онд СХЗГ-ын Нийтлэг үйлчилгээний Техникийн хороогоор хэлэлцүүлж, Монгол Улсын үндэсний стандарт (MNS ISO 17100:2017)-аар тооцуулж, хэрэглээнд оруулсан билээ. Өнөөдөр бид орчуулагч хэлмэрчийг хэрхэн үнэлэх жишиг, шалгуурыг тогтоон гаргах ажлын босгон дээр байна. Иймд, мөн дээрх стандартыг бүртгүүлж, хэрэглээнд оруулсны адил, олон улсын стандартын байгууллагын (ISO) хүчин төгөлдөр стандарт болон орчуулагч хэлмэрчийн ур чадвар, чадамжийн шалгуурыг тогтоосон бусад орны стандартыг жишиг болгон авч нэвтрүүлэх нь манай орчуулагч, хэлмэрч нарыг үнэлэх, зэрэг тогтоох нэг гаргалгаа болно.

Монгол улсын өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэшсэн орчуулагчдыг бэлтгэх, давтан сургах, тэдний ур чадварыг үнэлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан нийгэмд үйлчлэх сургалт, судалгааны төв бол МУИС-ийн ШУС-ийн Орчуулагч, хэлмэрчийн мэргэшлийн үнэлгээний төв юм. Энэ төвөөс МУИС-ийн өндөр түвшний судалгааны төсөл болох “Орчуулагч хэлмэрчийн чадамжийн судалгаа”¹⁰-г санаачлан, хэрэгжүүлж байна. Энэ төслийн судалгааны үр дүнд орчуулагч хэлмэрчийн ур чадварын түвшинг тодорхойлж, Монгол улсад орчуулагч боловсон хүчин бэлтгэх, тэдний ур чадварыг байнга ахиулах, давтан сургахад анхаарвал зохих санал зөвлөмжийг дэвшүүлж, салбарын хөгжлийг урагшлуулах, улмаар дэлхийн

⁹ <https://www.statista.com/statistics/257656/size-of-the-global-language-services-market>

¹⁰ МУИС-ийн өндөр түвшний судалгааны төсөл: P2021-4188

стандартад нийцсэн орчуулагч, хэлмэрч мэргэжилтнийг бэлтгэх, цаашид салбарын хөгжлийг шинэ түвшинд хүргэх олон ажлын эхлэлийг тавих нь зүйтэй гэж үзэж байна.

Өнөөгийн орчуулгын салбарт идэвхтэй ажиллаж буй орчуулагч, хэлмэрчийн мэдлэг ур чадварыг үнэлэн дүгнэх, тэдний ур чадварыг дээшлүүлэх талаар дорвитой ажил хийж буй төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо байхгүй байна. Тиймдээ ч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын гадаадтай хамтарсан аливаа үйл ажиллагаанд оролцож буй болон орчуулгын ном зохиолын орчуулагч, хэлмэрчдийн ур чадвар дутмаг, хэлмэрчлэх, орчуулах ажлын чанар хангалтгүй байгааг шүүмжлэн хэлэлцдэг ч бодит алхам хийхгүй байна. Одоо орчуулагч, хэлмэрчийн чухам хэдэн хувь нь ажил гүйцэтгэх өндөр ур чадвартай байгаа, хэдэн хувь нь мэргэжлийн чадамж дутмаг, цаашид давтан сургах шаардлага байгааг тогтоохыг зорих нь бидний ажлын эхний алхам юм.

Төслийн ажлаар орчуулагч, хэлмэрч хийгээд орчуулгын хичээл заадаг багш нарыг хамруулсан судалгааг эхлүүллээ. Үүгээр мэргэжилтний мэргэшсэн байдлын болон орчуулгын ажлыг хавсарга байдлаар гүйцэтгэж байгааг ялган тогтоох, мэргэжилтний өөрсдийн үнэлэмж, санаа бодлыг мэдэх, чадавхыг үнэлэх хэд хэдэн ажлыг давхар гүйцэтгэх боломжтой. Улсын хэмжээний орчуулагч хэлмэрчийн зах зээлийг үнэлэхдээ орчуулга зүйн Зорилгын онол (Scopos theory) болон хэл шинжлэлийн дискурсын шүүмжлэлт задлал (Critical discourse analysis-CDA)-ын аргыг бодитоор хэрэглэх, орчуулга зүйн орчин үеийн шинжлэх ухааны чиг хандлагаар хөгжүүлэх нэг чухал алхам болно. Бид энэ ажлыг хийхдээ Европын Холбооны орчуулгын чадамжийн судалгаа хийдэг Испанийн Пактегийн баг, Австрийн Гёпферих (Susanne Göpferich)-ээр удирдуулсан TransComp багийн болон Бразилийн Алвес ба Гонзалесын загваруудаас¹¹ Пактегийн багийн судалгааны загварыг ашиглаж байна.

Судалгааг хийхдээ холимог судалгааны аргазүйг ашигласан бөгөөд судалгааны өгөгдлийг цуглуулж, анализ хийхэд хэд хэдэн аргыг хослуульж хийдэг онцлогтой. Чанарын болон тоон судалгааны аргыг хослуулан хэрэглэдэг учир холимог судалгааны арга нь судалгааны өгөгдлийг чанарын болон тоон аргаар зэрэг эсвэл аль алианаар нь ээлжлэн өгөгдлийг цуглуулж, урьдчилсан туршилт судалгаа, асуумжийн судалгаа, түүврийн судалгаа, дискурсын шүүмжит задлагийн аргыг хослуулсан чанарын судалгааны аргазүй, асуулт таамаглал дэвшүүлэх, кодлох, дүн шинжилгээ хийх, тайлан гаргах, дүгнэлт хийх ажилбарыг хамарсан тоон (статистик) судалгааны аргазүйг хэрэглэсэн болно.

Монгол хүний сэтгэлгээгээр аливаа мэргэжилтэн хүний чадамжийг тухайн мэргэжлийг сурч эзэмшсэн хүний чадамжийн (орчуулагч, хэлмэрчийн чадамж translator's competence or interpreter's competence) буюу хүнд тулгуурласан ойлголт гэж үздэг. Харин өрнийн орнуудад “орчуулгын чадамж” (translation competence) гэж

¹¹ 杨志红 2019, 翻译测试与评估研究, 北京: 外语教学与研究出版社, 第4页.

хүншүүлсэн бус тухайн салбарын чадамжийн тухай ойлголтоор тэмдэглэн нэрлэж байна. Иймд цаашид бид орчуулгын чадамж гэх үү, орчуулагч, хэлмэрчийн чадамж гэх үү гэдэгт санал бодлоо уралдуулан, нэгэн шийдэлд хүрэх нь зүйтэй юм.

Орчуулгын чадамжийн тухай хамгийн анх өнгөрсөн зууны 70-аад оноос ярьж эхэлжээ. Орчуулгын чадамж бол зөвхөн нэг талын чадамж бус, харин эхнээсээ эхлэн чадамжийн олон бүрэлдүүлбэрийн цогц байх тухай эрдэмтдийн дэвшүүлсэн саналд туссан байдаг. Орчуулгын чадамжийн олон судалгаа гарсан¹² ч, чадамжийн асуудлыг дэд чадамжуудын цогц болох талаар үзэл онол гарч ирсэн юм. 1997 онд Испанийн Барселоны Автономит Их сургуулийн Орчуулга зүй, Хэлмэрчлэхүйн факультетын судлаачдаас бүрдсэн Пакте группынхан орчуулгын чадамжийн анхны загвараа танилцуулсан ба үүнийг багаараа 6 хос хэлний нааш цааш 2 чиглэлийн орчуулгын ойролцоо төрөл болон төрөл бус бүлгийн хэлний хоёр бүлэгт дахин туршилт судалгаа хийж, 2001 онд үр дүнгээ гаргаж аван, 2003 онд албан ёсоор хэвлүүлэн тархаасан байдаг билээ. Энэ загварчлал нь эдүгээ орчуулгын чадамжийн хүлээн зөвшөөрөгдсөн загвар¹³ болсон юм.

Бид мөн төслийн багийн идэвхтэй гишүүн Осакагийн Их сургуулийн үндсэн багш Г.Сайнбаярын дэвшүүлснээр Климчак-Павлакийн гаргасан соёл хоорондын дэд чадамжийн асуумж, Пактегийн зарим дэд чадамжийн тухай асуулт багтаасан тэдний асуумжийн загварыг ашиглан Монголын гадаад хэлний орчуулга заадаг багш нар ба мэргэжлийн орчуулагч нараас судалгаа авсан болно. Судалгаанд нийт 131 орчуулагч, 132 багш асуумж бөглөж оролцов. Судалгааны зорилго нь мэргэжлийн орчуулагч болон гадаад хэлний багш нарын орчуулгын чадамжийг тодорхойлох явдал юм.

Судалгааны үр дүнгээс тоймлон үзвэл,

1. Стратегийн чадамж хангалтгүй дутмаг

Орчуулагчдын хувьд эх бичвэрийн болон хэл шинжлэлийн асуудал, багш нарын хувьд ерөнхий мэдлэг, хэл шинжлэлийн асуудлыг стратегийн чадамжаар нөхөж, шийдвэрлэж чадаагүй

2. Орчуулгын чиглэлийн хувьд зорилтот хэлний орчуулгын үзүүлэлт тааруу

3. Орчуулагчид болон багш нар орчуулгын статик аргаас илүү динамик арга барилтай байгааг тогтоов.

4. Сүүлийн нэг дүгнэлт гэж үзэх орчуулгын чадамжийн гол цөм нь болох стратегийн дэд чадамж дутмаг байгаа нь орчуулгын чадамж бүхэлдээ тааруу дутмаг байна гэж тооцоход хүргэж байна. Орчуулгын чиглэлийн хувьд зорилтот хэлний орчуулгыг хамгийн тааруу гэж үнэллээ. Энэ нь орчуулгын чадамжид

¹² 1976 оноос хойш 2017 он хүртэлх орчуулгын чадамжийн бүрэлдүүлбэрийн тухай санал дэвшүүлсэн 20 гаруй эрдэм шинжилгээний саналыг доктор Г.Сайнбаяр нэгтгэн гаргасан юм.

¹³ РАСТЕ (2003). "Building a Translation Competence Model". In: Alves, F. (ed.). *Triangulating Translation: Perspectives in Process Oriented Research*, Amsterdam: John Benjamins.

шаардлагатай ур чадварыг хөгжүүлэхэд зорилтот хэлний орчуулгын хичээлд илүү анхаарал хандуулах шаардлагатайг харуулав.

Судалгаагаар орчуулагч, багш нарын орчуулсан орчуулгын гүйцэтгэлд үнэлгээ өгсөн бөгөөд гүйцэтгэлийн дундаж үзүүлэлтийн хамгийн их ялгаа нь зорилтот хэлний орчуулгаас ажиглагдаж байна. Сурвалж болон зорилтот хэлний орчуулгын хувьд багш нарын бүлэг орчуулагчдын бүлгийнхээс илүү хийсэн байлаа. Эдгээр үр дүн нь орчуулгын чадамж орчуулгын чанарт нөлөөлдөг болохыг баталж байна. Орчуулагчид багш нарын бүлгээс бага үзүүлэлттэй байсан нь орчуулгын туршлага бага, ялангуяа зорилтот хэлний орчуулга хийдэггүйтэй холбоотой байж магадгүй. Орчуулагчид хэдийгээр орчуулгын туршлага багатай байсан ч, орчуулгын тухай мэдлэг, орчуулгын стратеги, бэрхшээл, шийдвэрлэх арга замыг сайн мэдэж байгаа нь харагдав. Энэ нь орчуулагчдын орчуулгын туршлага дутмаг байдлыг манай судалгааны орчуулгын чадамжийн загварын бүрэлдүүлбэр болох стратеги, орчуулгын мэдлэг, ерөнхий мэдлэг, соёл хоорондын мэдлэгийг идэвхжүүлснээр нөхөж болдог гэдгийг баталж байна.

Орчуулагчид болон багш нар орчуулгын статик аргаас илүүтэйгээр орчуулгын динамик аргатай болох нь тогтоогдлоо. Бидний судалгаа нь Ю.А.Найдагийн динамик дүйцэл (Nida, 1964) зэрэг орчуулга судлалд дэвшүүлсэн онолын загваруудыг баталж байна. Орчуулагчид орчуулгын үгчлэн орчуулах арга барилыг харин багш нар харилцааны болон хэрэглээний орчуулгын аргыг илүү баримтлах хандлагатай харагдаж буй хэдий ч судалгааны хоёр бүлэг хоёулаа хоёр хэлний хооронд зуучлан дамжуулах бүрэн ойлголттойг харууллаа.

Орчуулгад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох, шийдвэрлэх үзүүлэлтийг харахад орчуулгын эх бичвэр дэх хэл шинжлэл болон ерөнхий мэдлэгийн асуудлыг хоёр бүлэг хангалттай сайн шийдэж чадаагүй. Тиймээс цаашид орчуулгын хичээлдээ үүнийг харгалзан үзэж, оюутнуудын хэл шинжлэлийн болон ерөнхий мэдлэгийг илүү хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Дүгнэлт

Орчуулгын чанарыг сайжруулахад хүний хүчин зүйл хамгийн чухал хүчин зүйл болдог гэдэг үүднээс, өнөөгийн нийгмийн хүрээнд орчуулгын үйл ажиллагааны байдал болон нэгэнт гарсан орчуулгыг шүүмжлэн хэлэлцэх нь ихэссэн тул орчуулгын чанарын асуудлыг зайлшгүй сөхөн судлах зайлшгүй хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ. Иймд, хэл судлаач эрдэмтдийн зүгээс орчуулгын ажлыг чанаржуулахад юу юу чухал болох, ямар ажлыг онолын үндэслэлтэй хийх ёстойг судлан тогтоох хэрэгтэй болж байна. Энэ ч үүднээс, орчуулагч, хэлмэрч нарын чадамж ямар түвшинд байгааг тогтоох, үүний зэрэгцээ мэргэжлийн ур чадвар, мэргэжилтний чадавхыг дээшлүүлэх арга замыг тодорхойлох ажлыг эхлүүлэх нь зүйн хэрэг болж байна.

Suumary: The Mongolian nation has never been free from the work of translation and interpretation throughout its existence, and as an ancient cultured and literate nation, the heritage of translation is no less in addition to the rich heritage of literature. Mongolians have always benefited from the original classical literature and teachings of other nations through translation. These noble duties were carried

out by translators and interpreters in early time. Our ancestors created a dictionary of the translation term in the 18th century, which shows the capabilities of translators at that time.

In Mongolia, no research has been done to determine the status of the translator's competence until last year. Therefore, it was mentioned in the report that there is a need to develop methods and methodologies to determine the translation skills of Mongolian translators and interpreters and to improve their capabilities. We, Translation Studies team based in National University of Mongolia are presenting herewith some results of the research conducted by the research methods of the Spanish Pacte team.

НОМЗҮЙ

1. Гүрбазар Р. 1996, Орчуулгын онол, дадлагын үндэс, Улаанбаатар.
2. Зограф.И.Т 1984,“Монгольско-китайская интерференция” Москва: Издательство “Наука”.
3. 杨志红 2019, 翻译测试与评估研究, 北京: 外语教学与研究出版社.
4. 冉诗洋, 译者 “堂邑氏胡奴甘父” 姓名考辨, 民族翻译2019年第2期 (总第111期) .
5. PACTE (2003). “Building a Translation Competence Model”. In: Alves, F. (ed.). *Triangulating Translation: Perspectives in Process Oriented Research*, Amsterdam: John Benjamins.
6. Weiwei Wang, Yi Xu, Binhua Wang, and Lei Mu, Developing Interpreting Competence Scales in China, Original Research, *Frontiers in Psychology*, April 2020, Volume 11, Articles 481 doi: 10.3389/fpsyg.2020.00481

ОРЧУУЛАХ ЧАДАМЖ, ТҮҮНИЙ ХӨГЖИЛ, ТӨРӨЛ АНГИЛАЛ

Т. Мягмарсүрэн¹⁴

Н. Ууганцэцэг¹⁵

Abstract: *This study aims to examine the concept of translation competence, as well as its historical development and common classification. According to the purpose of this study, four research questions were asked. 1) What exactly is the translation competence?, 2) How many translation competences have been defined?, 3) Are there any social impacts on translation competence?, 4) If this is the case, is the impact taken into account in PLO and CLO in educational programs for English Translation and Interpretation?*

After the study, we found the answers. 1) The translation competence is a set of required skills to make a translation. 2) Although there are categories for translation competence, such as main and sub, they will never be the final version. The reason for this is that during the translation process, the more the translator faces challenges, the more new competences are increased. 3) Translation has already seen a social impact, and this impact will undoubtedly persist. 4) In educational programs for English Translation and Interpretation, educators should include the technical and technological competence that students need today.

Түлхүүр үг: *ойлголт, онол, хандлага, төрөл, PLO, CLO*

Оршил

Аливаа ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтанд тавигдах шаардлага, эзэмшсэн байвал зохих мэргэжлийн мэдлэг, чадвар гэж бий. Орчуулагч хүнд ч мөн адил орчуулга хийхэд шаардагдах мэргэжлийн шаардлага гэж байх бөгөөд энэ нь орчуулах чадамж юм. Орчуулгын шинжлэх ухаан нь харьцангуй хожуу хөгжиж байгаа шинжлэх ухаан хэдий ч өнөөгийн XXI-р зууны мэдээлэл технологийн энэ эрин үед ихээхэн хурдтай хөгжиж байна. Энэ нь орчуулагчдад хэрхэн нөлөөлөх болсон, орчуулгын мэргэжлээр суралцаж

¹⁴ Доктор Ph.D, Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль, Англи хэлний тэнхим

¹⁵ Доктор Ph.D, Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль, Англи хэлний тэнхим

байгаа одоогийн суралцагчдад шаардлагатай мэдлэг, чадварыг хөтөлбөр хэрэгжүүлэгчдийн зүгээс эзэмшүүлж байгаа эсэх, цаашид орчуулгын мэргэжлийн хөтөлбөрт ямар ямар орчуулах чадварыг нэмж тусгах шаардлагатай болсон талаар гарцаагүй авч үзэх шаардлагатай болжээ. Иймээс тус судалгаанд дараах 4 асуултыг тавилаа.

1. Орчуулах чадамжийг хэрхэн тодорхойлж байна вэ?
2. Орчуулах чадамжийг хэдэн төрөлд ангилж байна вэ?
3. Орчуулах чадамжийн хөгжилд нийгмийн нөлөө байна уу?
4. Үүний нөлөөг PLO, CLO-д тусгаж байна уу?

Орчуулах чадамж

Орчуулах чадамж гэдэг бол орчуулга хийхэд зайлшгүй шаардагдах чадварын цогц юм. Орчуулах чадамжийн талаар судлахаас өмнө чадамж гэсэн ойлголтыг тодруулан авч үзвэл энэ нь ямар нэг зүйлийг маш сайн хийх чадвар (Cambridge dictionary , n.d.) буюу чадамжтай байна гэдэг нь ажил үүргээ үр өгөөжтэй гүйцэтгэдэг, ажилдаа мэргэшсэн, гаршсан байна гэсэн үг ажээ (Sieck, 2021). Түүнчлэн *“Чадамж гэдэг бол аливаа ажлын гүйцэтгэлийн үнэ цэнийг харьцуулан шинжлэх замаар түүнийг шүүн хэлэлцэх тухай ойлголт юм.”* (Gilbert, 2007) гэж үзсэн бол *“Чадамжийн мөн чанарыг ажлын байртай л холбож ойлгоно. Учир юунд вэ гэхээр ажлын байран дээр байнга гардаг эрсдэл, түүнээс үүсэн гарах үр дагаврын аль алинд нь зайлшгүй чиглэж байх ёстой гол зүйл нь чадамж юм. Тиймээс чадамж гэдэг дарга, захирал, ажилтан гээд бүгдийнх эт хувьд хариуцсан үйл ажиллагааныхаа явцад үүсэж болох эрсдэлийг олж таних чадвар нь бөгөөд эрсдэл бий болсон тохиолдолд чадамжаа ашиглан зөв арга хэмжээ авч, түүнийг хяналтдаа оруулах явдал юм.”* хэмээн (Haskitt, 2023) тодорхойлсон нь ч байна. Энэ бүхнээс үзэхэд чадамжийг тодорхой ажил үүрэг гүйцэтгэж байгаа хэн бүхэнд хамаатуулж байгаа төдийгүй энэ нь тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд ажилтнаас заавал шаардах мэдлэг, чадвар, туршлагын цогц болж байна.

XIX-р зууны дунд үед орчуулгын чадамжийг тодорхойлж байсан тодорхойлолтыг авч үзэхэд *“Орчуулах чадамж бол орчуулга хийх суурь мэдлэг.”* (Chomsky, 1965), *“Хоёр хэл эзэмшсэн хүн буюу “төрөлхийн орчуулагч”-д яваандаа суусан чадвар.”* (Harris, 1977) гэх зэргээр орчуулгад хэл шинжлэлийн нөлөө хамгийн их байсан энэ үеийг тодруулсан хэлтэй холбож тайлбарласан нэг хэсэг судлаачид байхад нөгөө нэг хэсэг нь орчуулгын чадамж нь хүнд төрөлхийн заяасан заяагдмал шинжтэй байдаг гэж тайлбарлаж байжээ. Харин XX зуун гарахад энэ ойлголт өөрчлөгдөж, (Fraser, 2000) *“Онолыг мэдлэг, орчуулгын практик туршилагаа ашигласны үр дүнд бий болсон мэргэжлийн орчуулагчийн мэдлэг, туршилага, шүүмжлэл.”* хэмээн орчуулах чадамжийг өмнөх үеийнхнээс илүү шинжлэх ухаанчаар өргөн хүрээнд тодорхойлжээ. Түүнчлэн орчуулах чадамж нь хэд хэдэн төрөл ангиллаас бүрдэнэ гэж үзэх судлаачид байсан ба (Schaffer, C and Adab, B,(eds), 2000) нарын судлаачид *“Хэлний, соёлын, мэргэжлийн*

салбарын гэх мэт орчуулга хийхэд заавал шаардагдах наад захын мэргэжлийн ур чадвар.”
гэж тодорхойлжээ.

Орчуулах чадамжийн онолын чиг хандлага

Орчуулах чадамжийн талаарх онолын чиг хандлага хэрхэн хувьсаж ирснийг судалж, үнэлж дүгнэсэн (Kiraly, 1995; Hansen 1997; РАСТЕ, 2000; Рум, 2003; Lesznyak, 2007) нарын олон судлаачид байх бөгөөд энэ судалгаанд Антони Пим, Лэсник нарын судалгааг жишээ болгон авлаа. Австралийн эрдэмтэн, орчуулга, соёл судлаач (Рум, 2003) мэдээллийн технологийн эрин үед орчуулах чадамж ямар байх вэ гэдэг талаас нь судалгааны тоймоо гаргажээ. Тэрээр 1970-д оноос хойш нийтэд өргөн дэлгэрсэн орчуулах чадамжийн талаарх ойлголтыг нэгтгэж, 4 хэсэгт хуваасан байна.

- Орчуулах чадамжийг тодорхойлоогүй үе
- Хэлний чадамжийн нийлбэр
- Нэг супер чадамж
- Олон бүрэлдэхүүнт

Орчуулах чадамжийг тодорхойлоогүй үе: Орчуулах чадамжийн талаар судлаачид ярьж, тодорхойлох хүртэлх хугацаанаас өмнөх цаг үеийг орчуулах чадамжийг тодорхойлоогүй үе гэж судлаачид нэрлэж байгаа бөгөөд нэгэнт энэ талаарх тодорхой ойлголт, үзэл санаа байхгүй тул энэ ангиллыг цаашдаа байлгах шаардлага ер нь байхгүй гэж үзжээ (Lesznyak, 2007).

Хэлний чадамжийн нийлбэр: 1970-д онд орчуулга судлалд хэл шинжлэлийн нөлөө их байсан үе гэгдэх бөгөөд орчуулах чадамжийг дан хэлний чадвараар тодорхойлох нь түгээмэл байсан (Mohamed Reza Esfandiari, Tengku Sepora, Tengku Mahadi, 2014) ба сурвалж хэл, зорилтот хэл хоёрын хэлний чадварыг хамааруулан авч үзэж байв (Lesznyak, 2007). Тиймээс орчуулагч хүн сурвалж хэлний бичвэрийг задлан шинжлээд, зорилтот хэлний нийцэх бичвэрээр утга санааг илэрхийлж байх нь чухал гэсэн хандлага зонхилж байжээ (Wills, 1982). Энэ үеийн орчуулга судлалын судлаачид орчуулах чадамжийг зөвхөн хэл шинжлэлийн талаас нь авч үзэн, орчуулагч хүний бусад чадвар, дадал, туршлагыг хараахан хөндөж эхлээгүй байжээ. Хэлний үндсэн чадварууд орчуулах чадамжид хэдий чухал байр суурь эзлэх ч дан ганц хэлний чадамжаар орчуулах чадамжийг тодорхойлох боломжгүй.

Нэг супер чадамж: 1980-д оны эхэн үеэс (Shreve, 1986; Toury, 1995; Krings, 1986; Koller, 1992) нарын орчуулга судлалын судлаачид орчуулах чадамжийн талаарх өмнөх үзэл баримтлалаас арай өөр үзэл санааг дэвшүүлсэн. Тэд орчуулах чадамж бол төрмөл ч бус, зөвхөн хэлний чадамж ч биш, өөр цогц чадвар байх ёстой гэсэн байр суурьтай байв. Уг судлаачид орчуулах чадамжийн нэг л супер чадамж байх нь зүйтэй гэж үзэж байсан бөгөөд улмаар эндээс орчуулгын минималист хандлага бий болжээ. (Рум, 2003) орчуулах чадварыг ийм тийм гэж тодорхойлох боломжгүй, орчуулагч хүний эзэмшвэл зохих гэсэн чадамжийн жагсаалт гэж байх албагүй. Тэрээр ер нь орчуулагч хүнд

орчуулах явцад нь тулгарч байгаа асуудал, нийгмийн нөлөөгөөр үүссэн хэрэгцээ шаардлагын улмаас шинээр эзэмших чадамж нь нэмэгдсээр байх тул орчуулах тодорхой үзүүлэлтээр хязгаарлах шаардлагагүй гэсэн байр суурийг илэрхийлж байжээ. Пим минималист хандлагаараа хоёр чадварыг тодорхойлсон бөгөөд орчуулагч хүн нэгд, орчуулгаа хийхдээ боломжит хэд хэдэн дүйцлийг олж тогтоогоод, хоёрт, түүн дотроос хамгийн сайн нийцэж байгааг нь сонгоно гэжээ. Орчуулах чадамжийн талаарх энэ үеийн судлаачдын үзэл санааг дүгнэхэд өмнөх үеэ бодвол орчуулагчдад хэлний чадвараас гадна өөр чадварыг эзэмшсэн байх ёстой гэж үзэж байснаараа сайшаалтай байна. Гэвч орчуулах чадамжийн талаарх тодорхой ангилал гараагүй байв.

Олон бүрэлдэхүүнт: Нэг супер чадамж орчуулах чадамжийн онолын хандлага хөгжиж байсан цаг хугацаанаас арав хүрэхгүй жилийн дотор дараагийн шинэ хандлага гарч иржээ. Тухайлбал (Pietrzak, 2019) орчуулах чадамжийн талаарх нэгэн өгүүлэлдээ *“Орчуулга судлал нь дискурс анализ, эх судлал, прагматик, сэтгэц хэл шинжлэл, нийгмийн хэл шинжлэл, соёл судлал, мэдээллийн технологи гэх мэт салбар дундын шинжлэх ухаан юм. Саяхнаас орчуулагчид орчуулгын бизнес, орчуулгын зах зээлтэй холбогдох болсноор хийсэн орчуулгаа баримтжуулах, нэр томъёо оноох, хянан засварлах, нутагшуулах зэрэг процессын улмаас орчуулгын чадамжийн төрөл даган баяжих боллоо.”* хэмээсэн нь тун оновчтой дүгнэлт болжээ. Учир нь орчин үед хүмүүс дэлхий ертөнцөөрөө хэрэн хэсэж аялах, зугаалах, ажил хэрэг хөөцөлдөх, эмчилгээ хийлгэх, суралцах, гадаад хүнтэй гэрлэж олон улсын гэр бүлийн тоо өсөх хандлагатай болсноор ах дүү хамаатан садандаа зочлох гэх зэрэг олон янзын зорилгоор гадаад хэлийг өргөн ашиглах боллоо. Энэ хэрэгцээ нь орчуулгыг бие даасан бизнесийн нэгэн салбар болон хөгжихөд хүргэснээр орчуулах чадамжийн төрөл, ангилал ихээхэн тодорхой болж иржээ гэж үзэх үндэстэй юм.

Олон бүрэлдэхүүнт онолын энэ чиг хандлагаар орчуулах чадамж нь хэл шинжлэлийн хэд хэдэн үндсэн ба дэд салбараас бүрдэнэ гэсэн үзэл санаанд тулгуурлаж байгаа бөгөөд энэ үед орчуулах чадамжийн нэлээд олон загвар бий болжээ. Эдгээрээс дурдвал,

- “Хойнгийн орчуулах төгс процесс загвар” (Hoing, 1991)
- “Бэллийн орчуулгын процесс загвар” (Bell, 1991)
- “Столзийн загвар” (Stoze, 1992)
- “Киралийн загвар” (Kiralý, 1995)
- “Бийбийн орчуулгын харилцааны төгс чадамж” (Beeby, 1996)
- “Хатим, Масоны орчуулгын цогц чадамж загвар” (Hatim & Mason, 1977)
- “Рискугийн загвар” (Risku, 1998)
- “Каймплийн загвар” (Campbell, 1998)
- “Албрэт Ньюбэртийн гурвалсан загвар”(Albrecht Neubert, 2000)

- “РАСТЕ бүлгийн цогц загвар” (РАСТЕ, 2003)
- “Гоперкийн орчуулах чадвар эзэмших загвар” (Gopferich, 2007) зэрэг байна.

Онолын энэ хандлага нь орчуулах чадамжийн талаарх ойлголтыг өмнөх хоёр хандлагаас илүү өргөн хүрээнд гүн гүнзгий судалж, хөгжүүлж чадсан, орчуулга бол зөвхөн хэл шинжлэлийн салбар шинжлэх ухаанаар хязгаарлагдахгүй, өөрөө бие даасан шинжлэх ухаан болж, дангаараа бусад шинжлэх ухаантай хавсарсан салбар дундын шинжлэх ухаан болсныг илтгэж байна. Түүнчлэн дэлхийн иргэдийн амьдралын хэв маяг эрс өөрчлөгдөж, хил хязгаар дамнан ажиллах амьдрах болсон, ялангуяа залуус үндэстний ялгааг үл тоон хоорондоо цахим сүлжээгээр эелдгээр нөхөрлөх болсон зэрэг нэг дэлхийдээ нэгдэж амьдрах хандлага хүчтэй газар авах болсон нь орчуулгын цар хүрээг улам томсгож байна. Энэ хэрээр мэргэжлийн орчуулагч бусдаас ялгарсан чадамжтай байх шаардлагатай болж, орчуулах чадамжийн төрөл ч илүү тодорхой болох болсон байна.

Орчуулах чадамжийн хөгжлийн явц

Орчуулах чадамжийн хөгжил нь онолын чиг хандлагатайгаа нягт холбоотой. Тухайлбал (Chomsky, 1965) бүтээлд дурдсанаар орчуулах чадамж гэдэг бол хэлний чадамж бөгөөд энэ нь хэл зүйн түвшинд сурвалж хэлээс зорилтот хэлд бичвэрийн утгын зөв илэрхийлэх явдал гэж үзэж байжээ.

Зураг 1. Орчуулах чадамжийн хөгжлийн явц



Гэвч гучаад жилийн дараа энэ ойлголт ихээхэн өөрчлөгдөж баяжсан байна. Орчуулагч нь нэгд, өөрт байхгүй шинэ чадамжийг эзэмших; хоёрт, одоо байгаа чадамжаа сайжруулах; гуравт, орчуулах арга зүйн чадамж эзэмших нь чухал гэж үзэх болжээ (Presas, 2000). Үүнтэй холбоотойгоор Пресас орчуулагчид хэлний чадамж дээрээ нэмээд танин мэдэхүйн болон зөөлөн ур чадваруудыг эзэмшсэн байх талаар тэмдэглэжээ. Тухайлбал үүнд, урт хугацааны санах ойгоо хөгжүүлэх, орчуулгад 3 дахь хэлийг ашиглах, өөртөө итгэлтэй байх, эелдэг зөв харилцаатай байх, тууштай байх зэргийг багтаажээ.

Хорин нэгдүгээр зууны эхэн үед орчуулагч нь мэргэжлийн үндсэн чадамжаасаа гадна орчин үеийн чадамжийг эзэмших шаардлагатай тулгарч эхэлжээ, үүнд хоёр хэлний редактор, шүүн тунгаагч, мультимедиа дизайнер, мэдээллийн технологийн мэргэжилтэн, соёлын зууч, нутагшуулагч, нэр томьёо судлаач зэрэг чадамж багтаж байна (Piotrowska, 2007). Хорьдугаар зууны дунд үед гэхэд зөвхөн хэлний чадамжаар тодорхойлогдож байсан орчуулах чадамж дөчөөдхөн жилийн дотор эрчимтэй хөгжиж

хорьдугаар зууны эхэн үе гэхэд мэдээллийн эрин зууны нөлөөгөөр орчуулагчийг хувийн суурь ур чадвараа сайжруулах, оюуны чадвараа хөгжүүлэх, төрөл бүрийн шинжлэх ухааны мэдлэгтэй болох, мэдээлэл технологи, техникийн зэрэг шинэ шинэ ур чадварыг эзэмшихэд хүргэжээ.

Орчуулах чадамжийн төрөл

Орчуулах чадамжийн төрлийг судлаачид үндсэн, дэд гэж бүлэглэх эсвэл ерөнхийд багцлах байдлаар ангилсан байна. Энэ судалгаанд ерөнхийд нь ангилсан ангиллыг авч үзэж байгаа бөгөөд орчуулах чадамжийн дараах нийтлэг 6 төрөл байна (Zainurrahman, 2010), (Nord, 2005). Эдгээр нь,

1. Хэл
2. Эх /текст/
3. Салбар
4. Соёл
5. Хувиргах /дамжуулах/
6. Техник, технологи

Хэлний чадамж: Орчуулга нь хэлний онолд тулгуурлах ба орчуулах чадамжийн суурь чадамж гэгдэх энэхүү хэлний чадамжийг илэрхийлэх, мэдээлэх, дуудлага гэсэн гурван төрлийн хэлний үүргийг эзэмшсэнээр орчуулагч нь хэлний төгс чадамжтай болно (Newmark, 1998). Бусад судлаачид ч “*Орчуулга нь хэлний онолд тулгуурлах ёстой.*” (Catford in Baker&Malmkjaer, 2001:120), “*Орчуулга бол хэл юм, тиймээс орчуулагч хүн сурвалж ба зорилтот хоёр хэл (үг, хэллэг, өгүүлбэр, дискурс)-ний гүн мэдлэгтэй байх ёстой.*” (Jakobson in Munday, 2001:5) гэж үзэж байв. Орчуулах чадамжийг хэлний чадамжаас ангид авч үзэх огт боломжгүй. Учир нь хэлний чадамж орчуулгын чадамжгүйгээр үүргээ гүйцэтгэж чадах бол орчуулах чадамж нь хэлний чадамжгүйгээр оршин тогтнож үл чадна (Pietrzak, 2019). Тиймээс орчуулагч хүн хоёр хэлний авиа зүй, үг зүй, үгсийн сан, өгүүлбэр зүй, найруулга зүй гэх мэт хэл шинжлэлийн бүхий онолын мэдлэгийг эзэмших нь зүй ёсны хэрэг юм.

Эхийн чадамж: Эхийн чадамж гэдэгт эхийн бүтэц, жанр, төрөл хэлбэрийг авч үзэж байна. Текст бүр өөр өөрийн гэсэн онцлог бүтэцтэй тул орчуулагч хүн тэр бүрийг ялгаатай байдлаар нь орчуулж чаддаг чадвартай байх ёстой. Тухайлбал захиа захидал орчуулах нь урилга орчуулахаас, эрдэм шинжилгээний өгүүллэг орчуулах нь үргэлжилсэн үгийн зохиолоос ялгаатай. Тиймээс эхийн төрөл жанр, хэлбэрээс хамаараад өөр өөр үг сонгох болдог. Учир нь текст бүр тогтсон үг хэллэгтэй тул зорилтот хэлдээ хэлж, бичиж заншсан тэр үг хэллэгийг олж орчуулах учиртай. Түүнчлэн текст бүрийн төрөлд тохирсон орчуулгын тусгай арга бий (Zainurrahman, 2010). Орчуулагч хүн эхийн чадамжийг эзэмшсэнээр эх хэлний текстийн төрөл жанр, тогтсон ёс горимыг хадгалах, хүлээн авагчид үл ойлголцол үүсгэхээс сэргийлэх, мэдээллийг илгээгч ба хүлээн авагч хоёрын хооронд харилцах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болно (Zainurrahman, 2010).

Салбарын чадамж: Орчуулагч хүн орчуулж байгаа мэдээллийнхээ холбогдох салбар шинжлэх ухааны мэдлэгтэй байх шаардлагатай (Zainurrahman, 2010). Жишээ нь, энэ нь худалдааны тэнцэл, мэдээллийн технологи, гэрлэлтийн хууль гэх мэт нарийн мэргэжлийн салбарын мэдээллийг орчуулах чадамж юм (Nord, 2005). Тиймээс орчуулагч нь орчуулж байгаа эхийн цаад салбар шинжлэх ухааны өргөн мэдлэгтэй байж гэмээ нь сая орчуулга нь оновчтой болно.

Соёлын чадамж: Орчуулга хийх явцад сурвалж хэлний зарим үгийг зорилтот хэлд өөр үг хэллэгээр орчуулах болдог, заримдаа ямар ч огт орчуулж чадахгүй мухардалд ч ордог. Хэрвээ орчуулагч нь сурвалж ба зорилтот хэлний аль алины соёлын чадамжтай байвал үгийн утгын дүйцлийн хангаж чадна (Kastberg, 2007). Өнөө үед орчуулагч нь зөвхөн орчуулах хэлний ард түмний соёлын мэдлэгтэй болохоос гадна өөрийн төрөлх улс орны соёл, ёс заншил, уламжлалыг ч ялгаагүй сайтар таньж мэдэх шаардлагатай болсон байгаа.

Хувиргах чадамж: Хувиргах буюу дамжуулах чадамж нь орчуулагчийг хэлний ба хэлний бус гүн мэдлэгтэй байхыг хэлнэ. Орчуулгын хамгийн дээд түвшний чадамж гэгдэх энэ чадамж нь орчуулагчаас хэлзүй, утга зүйн хувиргалыг сайн хийхийг шаардахаас гадна тухайн текстэд буусан төсөөлөл, дүр дүрслэлийг ч давхар оновчтой хувиргахыг шаардана. Хувиргах чадамж нь хэлний, текстийн, салбарын, соёлын гэх мэт бүх чадамжийн уулзвар юм (Zainurrahman, 2010). Орчуулагчийн хувиргах чадамж сайжирснаар ойлгомжгүй, алдаа мадагтай орчуулах эрсдэл буурч, цагаа хий дэмий үрэх нь багасна.

Техник, технологийн чадамж: Нийгэм хувьсан өөрчлөгдөхийн хэрээр орчуулагчдад шинэ шинэ чадамж эзэмших шаардлага нэмэгдсээр байна. Жишээ нь, орчуулгыг дэмжих программ, апп ашиглах, шаардлагатай компьютерын программ хангамж дээр ажиллах, хийсэн орчуулгадаа эшлэл зүүлт хийх гэх мэт нэмэлт ажиллагааг компьютерын цэс ашиглан хийх, орчуулсан бичвэрээ янз бүрийн хэлбэрээр онлайн орчинд болон компьютерт хадгалах, онлайн толь бичиг ашиглах зэрэг сүүлийн үеийн хиймэл оюун ухааны давуу талыг ашиглаж сурах чадамж юм.

Орчуулах чадамж ба PLO, CLO

Тус судалгааны явцад судлан тодруулсан орчин үеийн орчуулагч, хэлмэрч мэргэжилтэнд тавигдаж байгаа орчуулах чадамжийг өөрийн сургууль /Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль/-ийн “Гадаад хэлний орчуулга /Англи хэл” бакалаврын хөтөлбөрийн “Орчуулагч мэргэжлийн загвар”-т тодорхойлсон чадамжтай харьцууллаа. Тус загвар нь хөтөлбөрийн цөм, мэргэжлийн мэдлэг чадвар, мэргэжлийн чадамж, олон улсын түвшний боловсрол гэсэн 4 хүрээтэй бөгөөд хэл, соёл, салбар, текст, хувиргах, техник технологи гэсэн дээрх 6 чадамжийг бүгдийг багтаасан ч хэрэгжилт дээрээ техник, технологийн чадамжийг эзэмшүүлэх хичээлийн агуулга нь тодорхой биш байсаар байна. Тус бакалаврын хөтөлбөр нь 2021 онд дотоодод магадлан итгэмжлэгдэж 5 жилийн эрх

авсан бөгөөд хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн нэгдсэн дүгнэлтэд мөн суралцагчдад орчуулгад техник, технологи ашиглах талаарх чадвар эзэмшүүлэх шаардлагатай байгааг дурдан бичиж байсан. Тус өөрийн үнэлгээний тайлангийн дүгнэлт, энэ судалгааны ажлын ажлын дүгнэлтийн аль аль нь орчуулагч, хэлмэрч мэргэжилтэн нь орчин үеийн техник, технологийг ашиглах чадамжтай байх зайлшгүй шаардлагатай тулгарсныг нотоллоо. Тиймээс орчуулагч мэргэжлийн хөтөлбөрт суралцагчдад энэ чадамжийг эзэмшүүлэх хичээл төлөвлөн заах хэрэгтэй байна.

Дүгнэлт, санал

Орчуулах чадамж, түүний хөгжил болон орчуулах чадамжийн нийтлэг төрөл ангиллыг судлах бүхий зорилгын дагуу 4-н судалгааны асуултыг тавьсан бөгөөд дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Орчуулах чадамж гэдэг бол орчуулга хийхэд зайлшгүй шаардагдах чадварын цогц юм.
2. Орчуулгын чадамжийг үндсэн, дэд гэх зэрэг олон төрлөөр ангилан, төрөлжүүлэх ч энэ нь хамгийн эцсийн хувилбар биш юм. Орчуулга хийх явцад нь хэдий олон бэрхшээл орчуулагчид учирна тэр хэрээрээ чадамж нь нэмэгдсээр байх болно.
3. Нийгэм нь орчуулгын чадамжид нөлөөлсөөр ирсэн, цаашдаа нөлөөлнө.
4. Орчуулагч, хэлмэрч мэргэжлийн хөтөлбөрт сүүлийн үеийн мэдээллийн технологи, хиймэл оюун ухааны хэрэгслийг ашиглах, техник ажиллагаа хийх чадамжийг тусгах шаардлагатай.

Ном зүй

1. *Cambridge dictionary* . (огноо байхгүй).
2. Chomsky, N. (1965). *Aspects of Theory of Syntax*. Cambridge: Massachusetts: MIT Press.
3. Fraser, J. (2000). The Broader View: How Freelance Translators Define Translation Competence. *Developing Translation Competence, Schaffer, C and Adab, B., (eds) Amsterdam/Philadelphia: Benjamins* , 51-62.
4. Gilbert, T. F. (2007). *Human Competence*. San Francisco : Pfeiffer.
5. Hackitt, J. (2023). *HSE. What is competence?*: <https://www.hse.gov.uk/competence/what-is-competence.htm>-ээс Гаргасан
6. Harris, B. (1977). The Importance of Natural Translation. *Working Papers in Bilingualism 12*, 96-114.
7. Kastberg, P. (2007). Cultural Issues Facing the Technical Translator. *The Journal of Specialized Translation, Issue 8*.
8. Lesznyák, M. (2007). Conceptualizing translation competence. *Across languages and cultures*, 8 (2), 167-194.

9. Mohamed Reza Esfandiari, Tengku Sepora, Tengku Mahadi. (2014). Translation Competence: Aging Towards Modern Views. *Procedia: Social and Behavioral Science*
 10. Newmark, P. (1998). *A textbook of translation (Vol 66)*. New York: Prentice Hall.
 11. Nord. (2005). *Text Analysis in Translation: Theory, Methodology, Didactic Application of a Model for Translation-Oriented Text Analysis*, Amsterdam: Rodopi .
 12. Pietrzak, P. (2019 оны September 24). *Researchgate*. Translation Competence: <https://www.researchgate.net/publication/330134904-ээс> Гаргасан
 13. Piotrowska, M. (2007). *Process Decyzyjny Tlumacza. Podstawy Metodologii Nauczania Przekladu Pisemnego*, Krakow: Wydawnictwo Naukowe Akademii Pedagogicznej.
 14. Presas, M. (2000). Bilingual Competence and Translation Competence, in Schaffer, Ch Adab,B. (eds). *Developing Translation Competence*, Amsterdam/Philadelphia: Benjamins, 19-31.
 15. Pym, A. (2003). Redefining Translation Competence in an Electronic Age . *In Defence of a Minimalist Approach*, in *Clas, A (ed.) Meta: Translators' Journal vol 48, no. 4, Dec*, 481-497.
 16. Schaffer, C and Adab, B,(eds). (2000). *Developing Translation Competence*, Amsterdam/Philadelphia: Benjamins.
 17. Sieck, W. (2021 оны September 17). *Global Cognition*. What is Competence and Why is it Important?: <https://www.globalcognition.org/what-is-competence/-ээс> Гаргасан
 18. Wills, W. (1982). *The science of translation*. Tübingen: Gunter Narr.
- Zainurrahman. (2010). Five translation competencies. *Zainurrahman's Personal Journal*.

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНИКИЙН НЭР ТОМЬЁОГ ГҮҮГЛ ОРЧУУЛГА АШИГЛАН ОРЧУУЛАХ НЬ

С. Дугармаа¹⁶
М.Нямдолгор¹⁷
Б. Оюунсайхан¹⁸
А. Амарзаяа¹⁹

Хураангуй: Сүүлийн жилүүдэд шинжлэх ухаан, техникийн орчуулгыг Гүүгл орчуулгаар хийх гэж оролдох нь элбэг болжээ. Энэ судалгааны зорилго нь англи хэлний шинжлэх ухаан, техникийн нэр томъёоны дүйцэл монгол хэлнээ хэрхэн буулгасныг илрүүлэн үүнийг эх сэдвийн хувьд таарах тохирох байдлаар буулгах талаар юм. Мөн түүнчлэн Гүүгл орчуулгаар орчуулсан монгол хэлний дүйцэх үгсийн утга, хам сэдэв контекстийн хүрээнд авч үзсэн.

Судалгааны ажилдаа грек ба латин үндэс дээр янз бүрийн угтвар, дагавар залгаж үүссэн түүвэрлэсэн англи хэлний шинжлэх ухаан, техникийн нэр томъёог түүвэрлэн монгол хэлнээ болон монгол хэлнээс англи хэлнээ Гүүгл орчуулгаар орчуулсан баримт материалыг хам сэдвийн хүрээнд авч үзсэн.

Түлхүүр үг: машин орчуулга, шинжлэх ухааны бичвэр, жишээ баримт, үгийн утга

Оршил

2006 оны 4 сард Гүүгл орчуулга (Google Translate) нь статистикийн машин орчуулгын үйлчилгээ хэлбэрээр гарсан. Ингэснээр та текстийг англи хэл рүү орчуулах хүнд хүчир цаг хугацаа шаардсан ажил хийх шаардлагагүй болсон. Эхэн үед текстийг орчуулахын тулд урьдчилан таамаглах алгоритмуудыг ашигласан.

¹⁶ Доктор, ШУТИС, ГХС, Англи хэлний тэнхим

¹⁷ ШУТИС, ГХС, Англи хэлний тэнхим

¹⁸ ШУТИС, ГХС, Англи хэлний тэнхим

¹⁹ ШУТИС, ГХС, Англи хэлний тэнхим

Статистикийн машин орчуулгын (SMT) шинжилгээгээр англи хэл болон зургаан гадаад хэлний орчуулга хос био анагаахын домэйн нь герман, франц, испани хэлнүүдэд өндөр гүйцэтгэлийг харуулсан. Гүүгл орчуулга нь англи хэлний хоёр чиглэлтэй орчуулга юм. Wu, Xia, Deleger and Solti (2011)

Францын судлаач Sheppard (2011) Франц хэлнээс орчуулга хийхэд Гүүгл орчуулгыг ялангуяа техникийн баримт бичиг орчуулахад ашиглаж болох бөгөөд гэхдээ ихээхэн хязгаарлагдмал гээд хэрэглэгчид үүнийг ашиглахдаа мэдэж байх ёстой гэхдээ үгчлэн орчуулах, бичвэрт тохирох эквивалентыг сонгож чадахгүй, өгүүлбэрийн бүтэц алдаатай зэрэг олон саад бэрхшээлийг цаашид арилгах ёстой гэжээ.

Машин орчуулгын систем нь ихэвчлэн өгсөн үгсийн ерөнхий утгыг гаргадаг ч заримдаа бүүр хаа хамаагүй үг явж байдаг. Зарим үед хэрэглэгчдийн хувьд сэтгэл ханамжгүй байх элбэг байсан ба орчуулгыг үнэн зөв болгохын тулд машин орчуулгыг 3 сая гаруй сайн дурын орчуулагчдыг ашигладаг.

2016 онд 10 жилийн ойгоо тэмдэглэх үед Google Translate нь 103 хэлийг багтаасан байна гэж мэдэгдэж байсан. 2018 онд үед Google Translate -д 133 хэл орсон гэсэн бол 2021 онд нэмж 5 хэлийг нэмж оруулж ашиглах боломжтой боллоо гэж мэдэгдсэн байна. (Humphries, Matthew, 2020)

Монгол хэлний хувьд 2013 онд “Гүүгл дээр монгол хэл оржээ. Одоохондоо үгийн сан цөөн, ойр зуурын холбоо үг, энгийн өгүүлбэр төдийг орчуулж байна. Мэдээж засварлах зүйл байгаа ч энэ бол гайхамшигтай сайхан үйлс” гэж нийтлэлч Б.Индра бичжээ. Тэрээр цааш нь англи хэлтэй монголчууд мөн англи хэл сурч байгаа хүмүүс translate.google.com орж Монгол хэлний хуудас руу орно. Хуудасны доор Please help Google Translate improve quality for your language here гэсэн дээр дараад энгийн өгүүлбэрүүдийг орчуулбал Google-ийн залууст тусалж хэлний мэдлэгээ сайжруулахад дөхөм болно шүү. Зөвхөн энэ Гүүглийн программ дээр ажиллаж, хөгжүүлэхэд Монгол хэлний нэлээн их судалгаа хийх хэрэг болох байхдаа. Цаад утга, холбоо үгийн утгыг гаргахгүй бол энэ программ бүрэн ажиллаж тусаа өгч чадахгүй шүү дээ...Эрдэмтэд ийм зүйл дээр л хэрэгтэй дээ. Монголоос мөн бусад хэл рүү орчуулж л таарна...гэжээ. (Индра.Б, 2013)

Энэ цаг хугацаанаас хойш бид Гүүгл орчуулга ашиглан орчуулга хийж байна. Гүүгл орчуулгын чанар жил ирэх тутам сайжирсаар байгааг Монголын хэрэглэгчид мэднэ.

Гүүгл орчуулга нь машин орчуулгыг ашиглан хийгддэг байна. Машин орчуулга гэдэг нь нэг хэлээс нөгөө хэл рүү текстийн кодыг тайлахын тулд тодорхой программчлалыг ашигладаг компьютерын программ юм. (Peris, A., & Casacuberta. F., 2019).

Машин орчуулга нь 1950 -аад оноос АНУ-ын их дээд сургуулиудад туршигдан сайжирсаар байгаа юм. Машин орчуулга нь мэдээж компьютер ашиглан хийгдэнэ. Машин орчуулга нь богино хугацаанд өгөгдсөн текстийн мэдээллийг бүртгэж аваад тухайн хоёр хэлний тохирох үг хэллэг, хэлцийг орчуулгын зарчмуудаар зохицуулан этимологи, хүний оруулсан орчуулгын тусламжтайгаар явагддаг. (Petrucci G., et al., 2018)

Машин орчуулгын аргаар орчуулдаг Гүүглийн орчуулгын хувьд хүний хөдөлмөрийг болон цаг хугацаа хэмнэдэг сайн талууд байгаа ч үг болгоныг хэтэрхий махчлан орчуулах, олон утгатай үгийг тухайн бичвэрийн сэдэвт тохирох дүйцэх үгийг сонгож чадахгүй, товчилсон үгийг орчуулахгүй галигчлан буулгах мөн шинжлэх ухааны нэр томъёог зарим тохиолдолд галигчлан буулгаж байгаа зэрэг дутагдалтай талууд ажиглагддаг. Машин орчуулга нь ихэвчлэн тухайн үгийн ерөнхий утгыг гаргаж чаддаг ч энэ нь заримдаа тухайн бичвэрийн хувьд тохирохгүй байдаг.

Шинжлэх ухаан, техникийн нэр томъёоны орчуулга ба машин орчуулга

Хүний мэдлэгийн бүх салбар дахь юм, үзэгдлийг нэрлэсэн үг, нийлэмж үгийг бид нэр томъёо гэдэг. Ихэнхдээ олон салаа утгатай ердийн өдөр тутмын хэрэглээний жирийн үгтэй харьцуулахад нэр томъёо нь ганц утгатай, сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлдэггүй гол онцлогтой. Гэхдээ нэг үг шинжлэх ухааны өөр өөр салбарт нэр томъёо болж хэрэглэгдэхдээ бас өөр өөр үгээр илэрдэг байж болно. (Гүрбазар Р., 1996)

Нэр томъёоны орчуулгад болгоомжтой хандах алдаа гаргахгүй нь тулд шинжлэх ухаан, техникийн тухайн салбарын мэдлэгтэй байх шаардлагатай байдаг. Мөн орчуулгад тухайн улсын хэлний дүрэм журмыг мөрдөн нягт нямбай хандан аль болох хам сэдвийн хүрээнд орчуулга хийх нь чухал юм. (Мөнхцэцэг Н., 2020)

Шинжлэх ухаан, технологийн асар их дэвшлийн эрин үед англи хэлнээс техникийн нэр томъёо орчуулах, шинэ ойлголт, ололт нээлтийг нэрлэсэн шинэ нэр томъёо үүсэж байгаа тул нэр томъёог машин орчуулгаар хийхэд анхаарч байна. .

Интернэт нь оюутнуудын хэл, харилцааны олон хэрэглүүрт нэвтрэх боломжийг ихээхэн нэмэгдүүлж байгаа ч вебд суурилсан машин орчуулга нь текстийг буюу бичвэрийг нэг хэлнээс өөр хэл рүү хөрвүүлэхэд үргэлж сайжруулж байх шаардлагатай байна. Иймээс ч энэхүү судалгааны ажлаараа англи хэлний техникийн нэр томъёог монгол хэл рүү хөрвүүлэх хэрэгсэл болох Гүүгл орчуулгын давуу ба сул талыг илрүүлэхийг зорилоо.

Энэ ажилдаа машин орчуулгын тусламжтайгаар англи-монгол болон монгол англи хэлээр орчуулсан техникийн нэр томъёо, үг хэллэгийг сайжруулах шаардлагатай байгааг жишээн дээр тайлбарлаж, англи-монгол болон монгол-

англи хэлний Гүүгл орчуулгын чанарыг сайжруулахын тулд мэдээллийн технологийн, тооцооллын болон хэл шинжлэлийн мэргэжилтнүүдэд зарим санал дэвшүүлэх цаашилбал хэрэглэгчдэд болон оюутнуудад Гүүгл орчуулгыг хэрхэн зөв ашиглах талаар зөвлөмж өгөхийг хичээлээ.

ШУТИС-ийн бизнес менежмент, инженер, технологийн оюутнуудын мэргэжлийн ном хэвлэл уншиж ойлгоход зарим хүндрэлтэй нэр томъёог Гүүгл орчуулга ашиглан орчуулж ойлгох шаардлагатай болдог. Оюутнуудад шинжлэх ухааны нэр томъёоны Гүүгл орчуулгын давуу болон дутагдалтай байдлын талаар ойлгуулах тэдний орчуулгыг хянаж болгоомжтой хэрэглэх үүднээс орчуулгаа багш эсвэл мэргэжилтэнтэйгээ хянаж үзэн зөвлөх нь зүйтэй гэж үзэж байна.

Гүүгл орчуулгад монгол хэлээр бичсэн ба түүнийг нь англи хэлнээ маш сайн орчуулсан хам сэдэв буюу бүтэн тайлан, дипломын ажил, ном, сурах бичиг зэргийг зохиолчоос нь зөвшөөрөл авч <https://translate.google.com/intl/en-GB/about/contribute/> гэсэн линкээр орж оруулбал алгоритм ашиглан Гүүгл орчуулгын чанар улам сайжирна.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба дүн шинжилгээ

Техник технологийн, анагаах ухаан, технологи, нийгэм улс төр, эдийн засаг, компьютерын шинжлэх ухаан, ус судлал болон бусад салбарыг хамарсан шинжлэх ухааны нэр томъёог толь бичиг, шинжлэх ухааны ажлууд болон ном, сурах бичиг, сэтгүүл, мэдээллийн вэбсайтаас санамсаргүй түүврийн аргаар цуглуулсан. Түүвэрлэсэн жишээ баримтыг утгын хувьд дараах байдлаар ангилж болох юм. Үүнд.

- Грек, Ром гаралтай өөр өөр үндэс язгуур, дагавартай нэр томъёо: hydrology, geotechnics, electroencephalograph, tomograph, counterproductive, instrumentalization, , paralympic, psychometric, hermeneutics, endocentric, exocentric, internationalization, biometeorology. macroeconomics

- Нийлмэл нэр томъёо: bypass surgery, extended family, facial expressions, handling services, video message, workstation, workshop, video games, bionic bodies, arctic archaeology

- Холимог аргаар бүтсэн нэр томъёо: socioeconomic, workaholic, radiotherapy, aromatherapy, counter-productive, videoconferencing

- Товчилсон нэр томъёо: HTML, LAB, CAES, TIN

Эдгээр жишээ баримтыг бид контекст буюу бичвэртэй нь хамт авсан энэ нь монгол, англи хэлний нэр томъёог харьцуулж судлах боломж олгож байна.

Дээрх жишээ авсан нэр томъёог Гүүглээр орчуулахад олон нэр томъёог галигчлан, цөөн хэдэн нэр томъёог тайлбарлан орчуулсан байна. Жишээ нь:

Геотехник, томограф, паралимпик, герменавтик, эндоцентрик, экосентрик, арктикийн аихеологи, үнэр үнэртэх байдлыг ашиглан эмчлэх эмчилгээ, үржиж өргөжсөн гэр бүл, үйлчлүүлэгчийн гарт хүргэх үйлчилгээ

Бид мөн бичвэр хам сэдвийн хүрээнд Гүүгл орчуулгаар хийснийг авч үзсэн. Мөн түүнчлэн холбооны системийн төхөөрөмж бүр дээр болон нийт системийн хувьд тус бүрд нь гэнэтийн болон төлөвлөгөөт засварын нөлөөлөл, нэг ба хоёр нөөцтэй системийн найдвартай ажиллагааны бэлэн байдлын зэрэглэлийг симуляци хийж туршин, симуляцийн үр дүнгүүдийг харьцуулж авч үзсэн. Энэ өгүүлбэрийг Гүүгл орчуулгаар орчуулж үзэхэд:

*Also, the effects of **unexpected and planned repairs** on each device of the **broadband** system and for the entire system, and **the degree of availability of reliability** of systems with one and two resources were tested by simulation, and the simulation results were compared.*

Энэ радио холбооны мэргэжлийн бичвэр нь зүй ёсоороо бол дараах байдлаар бууна.

*Also, the effect of **corrective and preventive maintenance** on each device of the **communication** system and on the entire system; **the rating of standby systems availability** for underground mine communication systems with one shaft, two shafts and three shafts were tested by simulation; and the simulation results were compared.*

Мөн дараах орчуулгыг Гүүглээр **Slip-Form** Application to Concrete Structures гэснийг **Бетон бүтээц дэх *гулсах маягтын* хэрэглээ** гэж буруу орчуулсныг залруулбал:

***Slip-Form** concrete is a method of construction in which concrete is poured into the top of a continuously moving shallow form.*

Гулсах хэлбэрийн бетон нь тасралтгүй хөдөлж буй гүехэн хэлбэрийн дээд хэсэгт бетон цутгах барилгын арга юм.

Дараах өгүүлбэрт **apron slab- хормогч хавтан** гэж Гүүглээр орчуулсан байгааг нэр үгийн хормой гэсэн үндэс дээр вч гэсэн дагавар залгаж хормойвч гэх нь зүйтэй байна.

*An **apron slab** is a smooth impermeable surface constructed around a water point to prevent spilt water soaking into the ground.*

***Хормойвч** хавтан нь асгарсан усыг газарт нэвт норгохоос сэргийлж усны цэгийн эргэн тойронд баригдсан гөлгөр ус үл нэвтрэх гадаргуу юм.*

*A slope **failure** is a phenomenon that a slope collapses abruptly due to weakened self-retainability of the earth under the influence of a rainfall or an earthquake* гэсэн геологийн тодорхойлолтыг Гүүглээр орчуулахад:

Налуугийн эвдрэл гэдэг нь хур тунадас, газар хөдлөлтийн нөлөөгөөр дэлхийн өөрийгөө хадгалах чадвар суларснаас налуу огцом нурах үзэгдэл юм.

Failure гэдэг үгийг толь бичиг дээр алдаа эндэл, бүтэлгүйтэл гэх зэргийн олон утгаар тайлбарласан байдаг ч жинхэнэ цөм санаа нь “гүйцэтгэж байсан эсвэл гүйцэтгэх ёстой үүргээ биелүүлж чадахгүй байх” юм. Геологид *failure* гэдэг үгийг газар гэдэг зүйл цул, бүтэн байх ёстой байтал тэгж чадалгүй *failure* үүссэн гээд бодвол “хагарал” гэсэн утга гарч байна. Ингээд *deep failure* гэвэл гүний хагарал гээд орчуулах боломжтой юм. Тэгэхээр налууугийн хагарал гэдэг нь гээд орчуулах нь зөв болов уу.

Харин дараах өгүүлбэрийг Гүүглээр орчуулсан нь зөв дүйлгэн буулгасан байна.

Усан сан руу шахаж буй *шахсан агаарын* температур Фаренгейтийн ойролцоогоор 95 градус байна. The temperature of the **compressed air** being pumped into the reservoir is approximately 95 degrees Fahrenheit.

Товчилсон үгийг Гүүглээр орчуулахад орчуулагдахгүй байгаа нь тухайн орчуулагч эрэл хайгуул хийн товчлолыг орчуулах шаардлагатай болж байна.

A **CAES** can be constructed on ground surface or in underground. The underground CAES cavern has been constructed in different rocks such as salt formation [6], hard rock formation [7], depleted oil and gas reservoirs [8], aquifers [5], and abandoned mines [9].

CAES-ийг газрын гадаргуу дээр эсвэл газар доор барьж болно. Газар доорх CAES агуйг давсны тогтоц [6], хатуу чулуулгийн тогтоц [7], шавхагдсан газрын тос, байгалийн хийн нөөц [8], уст давхарга [5], орхигдсон уурхай [9] зэрэг өөр өөр чулуулагт барьсан.

CAES *Compressed air energy storage* - *Шахмал агаарын эрчим хүчний хуримтлал*

LAB also produces tiny organic molecules that give the fermented product its aroma and flavor.


LAB нь мөн исгэсэн бүтээгдэхүүний үнэр, амтыг өгдөг жижиг органик молекулуудыг үйлдвэрлэдэг.

LAB *lactic acid bacteria* - *Сүүн хүчлийн бактери*

In a **TIN**, the flat surface of a triangle bounded by three edges and three nodes. faces do not overlap; each face is adjacent to three other faces of the TIN. A face defines a plane with an aspect and slope. **TIN**-д гурвалжны тэгш гадаргуу нь гурван ирмэг ба гурван зангилаагаар хязгаарлагддаг. нүүр царай нь давхацдаггүй; нүүр бүр нь

TIN-ийн бусад гурван нүүртэй зэргэлдээ байна. Нүүр нь тал ба налууугай хавтгайг тодорхойлдог.

face 1. [MATHEMATICS] A planar surface of a geometric shape, bounded by edges.



TIN- Triangular Irregular Networks- Гурвалжин жигд бус сүлжээ

Дүгнэлт

Машин орчуулгад тулгуурласан Гүүгл орчуулгыг ашиглах нь интернэт хэрэглэгчдийн хувьд өргөн боломж нээж өгсөн.

Бид шинжлэх ухаан, техникийн баримт материалыг орчуулахад Гүүгл орчуулга ашиглах талаар монгол хэлнээс англи хэлэнд ба англи хэлнээс монгол хэлэнд орчуулсан цөөн тооны жишээ түүвэрлэн судалж үзэхэд Гүүгл орчуулгаар олон нэр томъёог галигчлан буулгах нь элбэг ба товчилсон нэр томъёог англи үгээр нь харин монгол хэлний товчилсон үгийг латин латин үсгээр буулгаж байна.

Хэд хэдэн сонирхолтой алдаатай орчуулгыг олж харсан. Иймэрхүү алдааг Гүүглд засаж оруулахад хэлний болон шинжлэх ухааны салбаруудын мэргэжилтнүүд оролцсон баг ажиллах хэрэгтэй гэж үзэж байна. Цаашид Гүүгл орчуулгаар орчуулсан нэр томъёог орчуулгад ашиглахдаа хянаж нягталж багш мэргэжилтнүүдтэй зөвлөж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Ашигласан ном хэвлэл

Гүрбазар Р., (1996) *Орчуулгын онол, дадлагын үндэс*

Индра Б. (2013) “Гүүгл-Монгол хэл-Хэл шинжлэл” [http://:www.baabar.mn](http://www.baabar.mn)

Мөнхцэцэг Н. (2020) Нэр томъёоны тогтолцоот шинж ба орчуулгын танин мэдэхүйн хэл шинжлэлийн талаас судлах нь, *Хэрэглээний хэл шинжлэл* Боть 4(19), 41-56

Humphries, Matthew (Feb. 27, 2020) "*Google Translate Adds 5 New Languages*". *PCMag*. *Ziff Davis*. Retrieved December 25, 2021

Peris, A., & Casacuberta. F., (2019). Online learning for effort reduction in interactive neural machine translation. *Computer Speech & Language*, 58, 98-126.

Petrucci G., Rospocher M., & Ghidini C., (2018) *Expressive ontology learning as neural machine translation*. *Journal of Web Semantics*, 52, 6

Wu C, Xia F, Deleger L, Solti I. (2011)

Statistical machine translation for biomedical text: are we there yet?

Resume

In recent years, it has become common to try to do scientific and technical translation with Google Translate. The purpose of this study is to find out whether the translation of English scientific and technical terms is correct. Also, we have tried to translate terms in context through Google Translate and have compared translation from English to Mongolian and vice versa.

БАРИМТ БИЧГИЙН ХЭЛ НАЙРУУЛГА, НЭР ТОМЬЁНЫ ОРЧУУЛГЫН СУДАЛГАА

Т.Мөнхзул²⁰, Ц.Эрдэнэзаяа²¹

***Abstract:** The process of presenting the results of the work done in a certain period of time and getting an evaluation is called a report. A report is part of a research or project work and uses formal and professional terminology. Therefore, when translating a report, it is important not to make mistakes in wording and terminology. In our presentation, we have studied the basic research report on the development of the infrastructure of the environment of Ulaanbaatar in the Japanese language from the aspect of language syntax and translation of terms, and we aim to show the features that can be found based on the works of researchers.*

Түлхүүр үг: тайлан, хэл, найруулга, нэр томьёо, орчуулга

УДИРТГАЛ

Бид хорин нэгдүгээр зуун буюу мэдээлэл технологийн эрин үед амьдарч байна. Өнөөдрийн техник, технологийн хурдацтай хөгжил нь бидний ажил хөдөлмөрийг хөнгөвчилж байгаа боловч сөрөг үр дагавар багагүй байна. Эх хэлний зөв хэрэглээ тэр дундаа хэлний найруулга, үгийн сан, хэл зүй, орчуулга тэдгээрийн уламжлал, сэтгэлгээний зарчмыг баримтлан тухайн хэлний онцлог шинж чанарт тохируулан оноон хэрэглэж сурах явдал оюутан залуусын хувьд чухал юм.

Манай улс Япон улстай улс төр, эдийн засаг, боловсрол соёл, худалдаа аж үйлдвэр, зам тээвэр, аялал жуулчлал гээд бараг бүхий л салбарт хамтран ажиллаж байна. Иймд аман, бичгийн болон нэр томьёоны орчуулгыг монгол хэлнээс япон хэл рүү, япон хэлнээс монгол хэл рүү зөв оноож хэрэглэх, цаашлаад практикт өргөн хэрэглэх шаардлага зайлшгүй гарч ирж байна.

²⁰ Магистрант, ШУТИС, ГХС, Ази судлалын салбар

²¹ Доктор Ph.D, ШУТИС, ГХС, Ази судлалын салбар,

Аливаа хэлний найруулга нь түүхийн явцад бүрэлдэн тогтсон, нийт ард түмэн үг ярианы харилцуурын хэрэглүүрийг шилж сонгох, хэрэглэх арга барилыг мэдсэн, өнгө аяс болон хэлний нарийн ялгамжааг илтгэсэн, хэлний тогтолцоо юм. Байгууллагын үүрэг, зорилт, зохион байгуулалтын бүтэц, эрхзүйн байдлыг тодорхойлсон үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоох, зохицуулах, журамлах шинжийг агуулсан бичиг баримтыг зохион байгуулалтын баримт бичиг гэнэ.

Тайлан нь тодорхой хугацаанд гүйцэтгэсэн ажил үүргийн явц, үр дүн, биелэлтийг мэдээлсэн баримт бичиг юм. Тайланг орчуулах явцад нэр томьёоны орчуулга онцлох байр эзэлдэг. Нэр томьёо гэдэг нь тусгай үг биш харин тусгай үүрэгтэй үг учир тэрхүү үүргийг зөв оноож орчуулах нь тун чухал байдаг. Бид илтгэлийн хүрээнд япон хэлний Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны дэд бүтцийг хөгжүүлэх суурь судалгааны тайланг хэл найруулгын болон нэр томьёоны орчуулгын талаас судлан жишээ баримтаар нотлон, судлаач эрдэмтдийн бүтээлд үндэслэн илрэх онцлогийг харуулахыг зорилоо.

Бид судалгааны тайлангийн хэл найруулгыг японы эрдэмтэн Таканаши Шино, Наканиши Күмико “Японы хэлний дүрмийн гарын авлага”-ын 高梨紫乃、中西久美子 「日本語文法ハンドブック」 2000 онол жишээ баримт, монголын эрдэмтэн Ц.Сүхбаатар “Монгол хэлний найруулга зүй” 2015 бүтээлийн ангилалд, нэр томьёоны тухай Огава Ёшио, Хаяаши Масарү “Япон хэлний боловсролын нэвтэрхий толь”-оос, 小川芳男、林大、「日本語教育事典」 2002, орчуулгыг эрдэмтэн Р.Гүрбазарын “Орчуулгын онол дадлагын үндэс” 1996 бүтээлийн ангилалд тулгуурлан, эрдэмтэн Дэмбэрэл С. “Шинэ- Монгол их толь бичиг” 2018, эрдэмтэн Энхсайхан Л. “Япон-Монгол, Монгол-Япон байгаль орчны үг хэллэгийн толь” 2012-ийг лавлагаа болгон, Япон улсын Жайка олон улсын байгууллагаас хийсэн Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны дэд бүтцийг хөгжүүлэх суурь судалгааны тайлан /2021/-гийн жишээгээр гаргахыг зорилоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

Зохих бүрдэл бүхий бодит тээгчид агуулж, баримтжуулсан мэдээлэл буюу улс нийгмийн өдөр тутмын амьдралыг албан ажлын хүрээнд зохицуулах хэрэглүүр болгохын тулд тусгайлан боловсруулж найруулсан Төрийн хэлний бичмэл хэлбэрийг баримт бичиг гэнэ.

Баримт бичиг гэдэг ухагдахуун нь анх “documentum” буюу “баталгаа” хэмээх грек үгээс үүссэн бөгөөд энэхүү нэр томьёо нь “баримт бичиг, баримтжуулах” гэсэн утгатай.

Баримт бичгийн хэл найруулгын үндсэн шаардлагууд: товч тодорхой, оновчтой, ойлгомжтой, энгийн төв, итгэл үнэмшилтэй, утга төгөлдөр, загварын дагуу найруулсан байх.

Баримт бичгийн найруулгын гол онцлогууд: тогтсон стандарт загвартай, хувь хүний найруулгын онцлог бага туссан, юм үзэгдлийг бодит байдлаар бичдэг, товч, тодорхой байх зарчим баримталдаг, уран яруу, гоёж чимж найруулан бичдэггүй.

Байгууллагын үүрэг, зорилт, зохион байгуулалтын бүтэц, эрхзүйн байдлыг тодорхойлсон үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоох, зохицуулах, журамлах шинжийг агуулсан баримт бичгийг зохион байгуулалтын баримт бичиг гэнэ.

Зохион байгуулалтын баримт бичгийг дотор нь хурлын тэмдэглэл, хөтөлбөр, удирдамж, төсөл, төлөвлөгөө, тайлан, санамж бичиг, санал, илгээлт гэж ангилдаг.

Тодорхой хугацаанд гүйцэтгэсэн ажил үүргийн явц, үр дүн, биелэлтийг мэдээлсэн баримт бичгийг тайлан гэнэ.

Тайлангийн онцлог:

-Энгийн дэлгэрэнгүй өгүүлбэр, хүүрнэх өгүүлбэр ихтэй	-Тайлбарлах, тоочих аргаар бичдэг. -Үндсэн дэс дараалалтай.	- Мэдэгдсэн шинжтэй. -Загвар, тоо баримт, судалгаа, хугацаатай.
-Өнгөрсөн цагийн лаа ⁴ , -сан ⁴ , -в	-Ажил түүний явц, үр дүнг илтгэдэг учир үнэлэлт, дүгнэлттэй.	-Ажил эрхэлдэг хүн бүр албан тушаалаас үл хамааран тайлан бичих үүрэгтэй.
Ирээдүй цагийн -на ⁴ нөхцөл түлхүү хэрэглэнэ.		

1. Тайлангийн хэл найруулга

Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны дэд бүтцийг хөгжүүлэх суурь судалгааны тайлангийн хэл найруулгад ажиглалт хийн, ажлын тайлангийн онцлогт тулгуурлан тодорхойлохыг зорилоо.

Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны дэд бүтцийг хөгжүүлэх суурь судалгааны тайлангийн баримт бичгийн хэл найруулгыг ажиглахад хүснэгтэн мэдээлэл гол төлөв тоочих аргаар, холбогдох хуулийн хэсэгт тайлбарлах аргаар бичсэн нь ажиглагдлаа. Жишээ нь:

Тоочих аргаар:

Air 06 DPF モコビーの製品 サイズ: フィルタ: 直径 6.5 インチ (約 165 mm)、長さ 6 インチ (約 150 mm) 設置場所: UB 市の公共交通用大型バス 今回提案する機材の数量: カセット式 DPF モコビー CT3 24 組 DPF 再生装置モコビー RE 15 台 [1] オパシメータ 3 台 [2] エンジンクリーニング装置 3 台 [3] 一酸化炭素検出・警報装置 6 台 [4] ドライブレコーダー 24 台 価格 1) カセット式 DPF モコビーCT3 [5] 1 式当たりの販売価格 750 千円	Air06: DPF төхөөрөмж (MoCobee)-ийн бүтээгдэхүүн Хэмжээ: Шүүлгүүр: 6.5 инч диаметртэй (165 мм орчим), 6 инч урттай (150 мм орчим) Хаана суурилуулах: Улаанбаатар хотын нийтийн тээврийн том оврын автобус Санал дэвшүүлэх : Кассет хэлбэрийн DPF MoCobee CT3 24 хос төхөөрөмжийн тоо : DPF шатаан цэвэрлэх төхөөрөмж MoCobee RE15 ширхэг Хэмжээ: •Тортог хэмжигч 3 ширхэг •Хөдөлгүүр цэвэрлэгч төхөөрөмж 3 ширхэг •Угаар мэдрэгч, дохиоллын төхөөрөмж 6 ширхэг •Автобусны камер 24 ширхэг Үнэ 1) Кассет хэлбэрийн DPF MoCobee CT3 -1 комын худалдах үнэ 750,000 иен
--	--

Жишээ нь:

Тайлбарлах аргаар:

危険廃棄物の定義は、「爆発性、可燃性、化学反応を有する廃棄物、空気や水との反応によって有害ガス発生する廃棄物、感染性廃棄物、人間や動物に対して短期・長期にわたり有害な影響を及ぼす廃棄物、自然環境に対して有害な影響を及ぼす廃棄物、埋立処分後に有害な物質を発生される廃棄物」となっているが、具体的な品目は定めがなく、有害性を示すもの全般と認識されている【廃棄物法 4 条 4.1.2】。

-“аюултай хог хаягдал гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг” гэж заасан бөгөөд тодорхой нэр төрлөөр нь заагаагүй, хортой шинж чанартай бүхий л эд бодисыг хамруулсан байна. (Хог хаягдлын тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.2-р заалт)

Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны дэд бүтцийг хөгжүүлэх суурь судалгааны тайлангийн баримт бичгийн хэл найруулгыг өгүүлбэр зүйн талаас ажиглахад **энгийн дэлгэрэнгүй** болон **хүүрнэх өгүүлбэр** түлхүү илэрч байна. Жишээ нь:

Энгийн дэлгэрэнгүй өгүүлбэрээр:

プロジェクトチームが組成され、チームメンバーの選考中であり、SC 会議を行い、実施計画の作成段階にある。p.118

Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдаж ажилтнуудын сонгон шалгаруулалт явагдаж байгаа бөгөөд Төлөөлөн удирдах хорооны хурлыг зохион байгуулж үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах шатанд ажиллаж байна. х.154

Мөн хэлний хэмнэлтийн зарчмаар хэлэх зүйл нь ойлгомжтой нийтлэг тал ажиглагдлаа. Жишээ нь:

ゲルでは、夏季に 26.5%、冬季では 75.2% 灰が占めていた。p.60

Гэрт амьдардаг айл өрхийн зун 26.5%, харин өвөл 75.2%-ийн хог хаягдлыг үнс эзэлж байна. 80х

Жишээ нь:

Хүүрнэх өгүүлбэрээр:

有価物の回収は地域のインフォーマルセクターとの競合する可能性がある。p.197

Үнэд өртөг бүхий түүхий эдийг цуглуулахад бүс нутгийн иргэдтэй өрсөлдөөн үүсэж болзошгүй юм. х.250

水質汚濁に関しては、上水源の現状や上水源保護区、トーラ川の汚染状況や中央下水処理場による汚染について記載されている。p.26

Усны бохирдлын тухайд ундны усны эх үүсвэрийн өнөөгийн байдал ба ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, Туул голын усны чанар болон төв цэвэрлэх байгууламжаас үүдэлтэй усны бохирдлын талаар өгүүлсэн. х.36

Харин үг зүйн талаас ажиглахад өнгөрсөн цагийн -сан⁴, -в, ирээдүй цагийн –на⁴ нөхцөл түлхүү хэрэглэж байна. Жишээ нь:

Өнгөрсөн цагийн –сан⁴ нөхцөлөөр:

UB 市において、2030 年を目標とする上下水道のマスタープラン（以下、2013 年上下水 MP）を策定した。

Улаанбаатар хотын 2030 он хүртэлх ус хангамж, ариутгах татуургын салбарын хөгжлийн төлөвлөгөө (цаашид “2013 оны ус хангамж, ариутгах татуургын ерөнхий төлөвлөгөө” гэх)-г боловсруулсан.

Жишээ нь:

Өнгөрсөн цагийн –в нөхцөлөөр:

本事業想定では、処理対象となる廃棄物は UB 市から排出される全ての一般ごみとする。

Уг төслийн төсөөллийг гаргахдаа шатаах хог хаягдал нь Улаанбаатар хотоос гарах бүхий л ахуйн хог байна гэж үзэж тооцов. х.244

Жишээ нь:

Ирээдүй цагийн –на⁴ нөхцөлөөр:

廃棄物管理のためのデータベース構築、関係機関の役割と情報公開等について定める。

Хог хаягдлын менежментийн мэдээллийг бүрдүүлэх, мэдээллээр хангах хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоотой холбоотой харилцааг зохицуулна. Бидний гол хэрэглэгдэхүүн суурь судалгааны тайлангийн хэл найруулгыг өгүүлбэр зүйн талаас дүгнэхэд хүүрнэх болон энгийн дэлгэрэнгүй өгүүлбэрээр ихэвчлэн бичигдсэн нь ажиглагдлаа. Үг зүйн талаас ажиглахад өнгөрсөн цагийн –сан⁴ нөхцөл, ирээдүй цагийн –на⁴ нөхцөлөөр ихэвчлэн хэлбэржсэн бол өнгөрсөн цагийн –в нөхцөлөөр харьцангуй цөөн илэрч байна. Харин уг тайланд өнгөрсөн цагийн –лаа⁴ нөхцөлөөр илэрсэн жишээ хараахан илэрсэнгүй. Мөн тайлангийн өнгөрсөн цагт тайлагнаж бичдэг шаардлагатай нийцэж байна.

2. Тайлангийн нэр томъёоны орчуулга

Нэр томъёо (terminology) гэдэг нь тусгайлан тогтоосон, шинжлэх ухааны хүрээнд тодорхой ухагдахуун илэрхийдэг үгийг хэлнэ. Өөрөөр нэр үг буюу шинжлэх ухааны нэр үг гэж нэрлэдэг. Нэр томъёо нь нэг л ухагдахуун илэрхийлэх бөгөөд үсгээр илэрхийлэгдэх хязгаарлан тогтоосон хэлний тэмдэгт юм.

“Орчуулга гэдэг бол нэг хэлээр илэрхийлж буй санааг нөгөө хэлний бүх хэрэглэгдэхүүнийг ашиглан, бүрэн төгс илэрхийлэн гаргах бүтээлч хөдөлмөрийн үр дүн юм.” гэж эрдэмтэн Р. Гүрбазар гэж үзсэн бол, эрдэмтэн Г.Аким “Орчуулга гэж нэг хэлний хэрэглүүрээр илэрхийлсэн зүйлийг нэг хэлний хэрэглүүрээр үнэн зөв илэрхийлэхийг хэлнэ” хэмээн тодорхойлжээ.

Баримт бичгийг орчуулах явцад нэр томъёог хэрхэн зөв орчуулах вэ? гэсэн асуудал гарч ирдэг. Нэр томъёо нь янз бүрийн ухагдахууны нэр болж баримт бичиг, тайланд ч өргөн хэрэглэгддэг.

Нэр томьёо орчуулахад орчуулагч хүний орчуулах ур чадвараас гадна, тухайн салбарын мэдлэг зайлшгүй чухал байдаг.

Нэр томьёог орчуулахдаа дараах аргуудыг гол төлөв орчуулдаг. Үүнд:

1. Галигчлан буулгах
2. Үгсийн сангийн үүднээс таарч тохирох үг эх хэлнээсээ сонгон орчуулах
3. Хуулбарлах буюу үгчлэн орчуулах
4. Дүйх нэр томьёоны бүтцийн нэг хэсгийг нь үгчлэн орчуулж нөгөө хэсгийг галигчлан буулгах
5. Үгсийн сангийн бололцоотой хоёр хувилбарын аль нэгийг сонгох

2.1 Галиглах аргаар орчуулсан нэр томьёо

Галиглах аргыг олон улсын шинжтэй үг хэллэгийг орчуулахад өргөн хэрэглэдэг бөгөөд бусад хэлэнд ч ижил утгатай гадаад үгийн дуудлагыг өөрийн хэлний үсгээр буулгахыг хэлдэг. Жишээ нь:

1-р хүснэгт

Япон	Монгол	Л.Энх сайхан “Япон-Монгол, монгол-япон байгаль орчны үг хэллэгийн толь”	С.Дэмбэрэл “Шинэ япон монгол их толь бичиг”
バッテリー	батерей	-	зай, цэнэг хураагуур, батерей 1690х
コークス	кокс	кокс 199х	кокс (нүүрс) 686х
アスベスト	асбест	асбест, шөрмөсөн чулуу 7х	шөрмөсөн чулуу 49х
オゾン	озон	озон 20х	озон 288х
セメント	цемент	цемент 93х	цемент 1108х
バイオマス	биомасс	биомасс 119х	биомасс 1638х
ジメチルエーテル	диметил эфир	-	диметил 874х эфир 222х
プラスチック	пластик	-	пластик, хуванцар 1895х
ボイラー	бойлуур	уурын зуух 132х	бойлуур, уурын тогоо 1956
ディーゼル	дизель	дизель 105х	дизель 1371х

Судалгааны хэрэглэгдэхүүнээс түүвэрлэн авсан 204 нэр томьёоны 20 буюу 10 хувийг галиглах аргаар орчуулсан байна.

Дээрх япон хэлнээс монгол хэлнээ галигчлан авсан жишээг гол хэрэглэгдэхүүн болгон авсан толь бичгүүд өөр өөр орчуулсныг бид монгол хэлний болон мэргэжлийн тайлбар толь бичгээс нягталж үзлээ.

Жишээ 1. アスベスト гэдэг нэр томьёо нь хэрэглэгдэхүүнд нийт 4 өгүүлбэрт 6 удаа хэрэглэхдээ бүх тохиолдолд **асбест** гэж орчуулагдсан байна.

また、アスベスト、セメント管も残存しており、当該管は経年劣化が早く、強度が低下しやすいため、早急に更新する必要がある。

Мөн **асбест**, цементэн хоолой ч бий ба цаг хугацааны явцад хурдан элэгдэж бат бөх чанар нь мууддаг тул яаралтай шинэчлэх шаардлагатай.

Хэрэглэгдэхүүн болгон сонгон авсан Л.Энхсайханы толь бичигт **асбест, шөрмөсөн чулуу** гэж орчуулсан бол С.Дэмбэрэлийн толь бичигт **шөрмөсөн чулуу** гэж орчуулсан байна.

“Монгол хэлний их тайлбар толь”-д “шөрмөс мэт торгомсог бат бэх, нягт ширхэгтэй, галд тэсвэртэй нэг зүйл чулуулаг, өргөн хэрэглээний эдлэл хийнэ” (х.1797)

Жишээ 2. コークス гэдэг нэр томъёо нь хэрэглэгдэхүүнд нийт 3 өгүүлбэрт 5 удаа хэрэглэхдээ бүх тохиолдолд **кокс** гэж орчуулагдсан байна.

改良燃料の改善材料としてセミコークスとバイオマスを検討しており、いずれか一つの場合一部機器構成が変わるが、高圧成型機の仕様、台数は変わらない。

Сайжруулсан шахмал түлшний чанарыг сайжруулахад хагас **кокс** болон биомассыг түүхий эд болгон ашиглах талаар судалгаа хийгдэж буй бөгөөд аль ч тохиолдолд үйлдвэрийн зарим тоног төхөөрөмжийн бүтцэд өөрчлөлт орох боловч өндөр даралтын брикетэн машины техникийн үзүүлэлт, тоо ширхэг өөрчлөгдөхгүй.

Эрдэмтэн Л.Энхсайхан толь бичигтээ **кокс** гэж орчуулсан бол эрдэмтэн С.Дэмбэрэл толь бичигтээ **кокс (нүүрс)** гэж орчуулсан байна. “Монгол хэлний их тайлбар толь”-д “Кокс: чулуун нүүрс, хүлэр зэргээс агаар оруулахгүй улайсгах замаар гаргаж авдаг хатуу түлшний нэг төрөл; шатанги хүлэр” (х.664)

Жишээ 3. バッテリー гэдэг нэр томъёо нь хэрэглэгдэхүүнд нийт 7 удаа хэрэглэхдээ бүх тохиолдолд **батерей** гэж орчуулагдсан байна.

バッテリーや E-Waste 等の処理が必要な廃棄物は、どの住居においても殆どない結果となった。p.60

Батерей болон электрон гэх зэрэг дахин боловсруулалт шаардлагатай хог хаягдлын хувьд, аль ч сууцны төрөлд бараг гараагүй дүнтэй байна. (х.80)

Хэрэглэгдэхүүн болгон сонгон авсан Л.Энхсайханы толь бичигт хараахан илрээгүй бол С.Дэмбэрэлийн толь бичигт **зай, цэнэг хураагуур, батерей** гэж орчуулсан байна.

2.2 Дүйлгэх аргаар орчуулсан нэр томъёо

Орчуулгын энэхүү арга нь нэр томъёо тогтооход өргөн хэрэглэгддэг арга юм. Үгийн сангаас тохирох үгийг ашиглан орчуулахад тухайн үг нь хэлбэр, бүтцээрээ гадаад нэр томъёотой тохирох албагүй. Гадаад нэр томъёог зээлдэн авч эх хэлээ баяжуулах нь зүй ёсны үзэгдэл боловч, нэр томъёог замбараагүй зээлдэн авч хэрэглэхийг хориглодог бөгөөд тухайн ухагдахууныг нэрлэсэн оновчтой үг эх хэлэнд байвал аль болох эх хэлээрээ дүйлгэн орчуулах аргыг сонгох нь зүйтэй. Жишээ нь:

2-р хүснэгт

Япон	Монгол	Л.Энх сайхан	С.Дэмбэрэл
------	--------	--------------	------------

		“Япон-Монгол, монгол-япон байгаль орчны үг хэллэгийн толь”	“Шинэ япон монгол их толь бичиг”
大気汚染	агаарын бохирдол	агаарын бохирдол 95х	агаарын бохирдол 1187х
二酸化炭素	нүүрс төрөгчийн давхар исэл	нүүрс төрөгчийн давхар исэл 114х	нүүрс төрөгчийн давхар исэл 1562х
蓄電池	аккумулятор	цахилгаан хураагуур 102х	аккумулятор, зай хураагуур 1282х
土壌汚染	хөрсний бохирдол	хөрсний бохирдол 110х	хөрсний бохирдол 1474х
太陽光発電	нарны цахилгаан станц	нарны цахилгаан үүсгүүр 98х	нарны цахилгаан үүсгүүр 1208
処理技術	боловсруулах технологи	боловсруулах технологи (хог хаягдал) 78х	зохицуулах, захирах 973х техник, технологи 477х
ゴミ焼却炉	хог шатаах зуух	хог шатаах зуух 60х	хог 728х шатаах, устгах зуух 932х
発熱	дулаан ялгаруулах	дулаан ялгаруулах 125х	халуун, халуурах 1691х
再生可能エネルギー	сэргээгдэх эрчим хүч	сэргээгдэх эрчим хүч 62х	-
汚泥	лаг	Бохир, лаг 21х	шавар, шавхай 292

Судалгааны хэрэглэгдэхүүнээс түүвэрлэн авсан 204 нэр томъёоны 151 буюу 74 хувийг дүйлгэх аргаар орчуулсан байна.

Жишээ 1. 汚泥 гэдэг нэр томъёо нь хэрэглэгдэхүүнд нийт 95 удаа хэрэглэхдээ бүх тохиолдолд **лаг** гэж орчуулсан байна.

下水処理場及びゲル地区の衛生施設の**汚泥**を環境に優しい方法で処理する。p.18

Цэвэрлэх байгууламж болон гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн **лагийг** байгальд ээлтэй аргаар боловсруулна. (х.25)

Эрдэмтэн Л.Энхсайхан толь бичигтээ **бохир, лаг** гэж орчуулсан бол эрдэмтэн С.Дэмбэрэл **шавар, шавхай** гэж орчуулсан байна. “Монгол хэлний их тайлбар толь”-д “Лаг: Өтгөн, лаагалдсан, зууралдсан, багширсан: лаг хоол (өтгөн хоол), лаг шавар (зунгааралдсан шавар)” а. Хөрснөөс гарах наалданги хар шороо; б. Усны ёроол дахь шавартай шороо), лаг шөл (лаагалдсан өтгөн шөл). (х.653)

Жишээ 2. 蓄電池 гэдэг нэр томъёо нь хэрэглэгдэхүүнд нийт 2 өгүүлбэрт 2 удаа хэрэглэхдээ бүх тохиолдолд **аккумулятор** орчуулсан байна.

バッテリー及び蓄電池、液体及び容器が一体となって使用される廃棄物の埋立は可能である【廃棄物法 34 条】。

Батерей, **аккумулятор** гэх мэт шингэн болон түүний сав нь хамтдаа нэг зорилгоор ашиглагддаг хог хаягдлыг ландфилд булшилж устгаж болохоор заагдсан байна. (Хог хаягдлын тухай хуулийн 34-р зүйл, х.53)

Эрдэмтэн Л.Энхсайханы толь бичигт **цахилгаан хураагуур** гэж орчуулсан бол эрдэмтэн С.Дэмбэрэлийн толь бичигт **аккумулятор, зай хураагуур** гэж орчуулсан байна.

“Монгол хэлний их тайлбар толь”-д “Зай хураагуур, эрчим хүчийг хэрэглэх зорилгоор хуримтлуулан хадгалах төхөөрөмж” гэжээ. “Викитоль чөлөөт толь бичиг”-т “Зай

хураагуур, эрчим хүчийг хэрэглэх зорилгоор хуримтлуулан хадгалах төхөөрөмж аккумулятор” гэжээ.

Ч.Зундуйсүрэн, Д.Дашпүрэв “Шинжлэх ухааны, техникийн толь бичигт”д

Цахилгаан эрчим хүчийг химийн эрчимд хувиргаж, улмаар урвуу хувиргалт хийх замаар эргүүлэн шаардлагатай тогтмол гүйдэл, хүчдэл бүхий цахилгааныг ашиглах зарчмаар ажилладаг.

2.3 Нэр томъёоны бүтцийн нэг хэсгийг үгчлэн орчуулж, нөгөө хэсгийг галиглах аргаар орчуулсан нэр томъёо

Энэхүү аргаар холбоо үгээс бүтсэн нэр томъёог орчуулдаг. Холбоо үгийн нэг хэсгийг үгчлэн орчуулж бусад хэсгийг галигчлан буулгадаг. Жишээ нь:

3-р хүснэгт

Япон	Монгол	Л.Энхсайхан “Япон-Монгол, монгол-япон байгаль орчны үг хэллэгийн толь”	С.Дэмбэрэл “Шинэ япон монгол их толь бичиг”
オゾン層	озоны давхарга	Озоны үе, давхарга	озоны давхарга 288х
アスベスト管	асбест хоолой	-	шөрмөсөн чулуу 49х Хоолой, гуурс 434х
エコ車両、エコバス	эко автобус	-	эко 226х вагон машин 886
自動車リサイクルシステム	авто машин боловсруулах систем	-	автомашин 861х Систем бүтэц 840х
セメント管	цементэн хоолой	-	цемент 1108 Хоолой, гуурс 434х
ガスタービン	хийн турбин	-	Турбин, хөдөлгүүр 1181
エコ住宅	Эко орон сууц	-	Эко 226х Орон сууц, орон байр 896х

Судалгааны хэрэглэгдэхүүнээс түүвэрлэн авсан 204 нэр томъёоны 16 буюу 8 хувийг Нэр томъёоны бүтцийн нэг хэсгийг үгчлэн орчуулж, нөгөө хэсгийг галигчлах аргаар орчуулсан байна.

Жишээ 1. オゾン層- гэдэг нэр томъёог 10 хэрэглэхдээ бүх тохиолдолд озоны давхарга гэж орчуулсан байна.

冷蔵庫やエアコンに含まれるオゾン層を破壊するフロンについても、液状フロン回収、断熱材のフロン回収を行うことが可能となっている。p.197

хөргөгч болон агаар хөргүүрт **озоны давхарга** устгадаг хлор-фтор-нүүрстөрөгчийн төрлийн бодис агуулагддаг бөгөөд энэхүү бодисын шингэн төлөв болон дулаалгын материалд ашиглагдсан бодисыг ялган авч цуглуулах боломжтой болсон. х.250

Эрдэмтэн Л.Энхсайхан толь бичигтээ **озоны үе, давхарга** гэж орчуулсан бол эрдэмтэн С.Дэмбэрэл толь бичигтээ **озоны давхарга** гэж орчуулсан байна.

“Монгол хэлний их тайлбар толь”-д **озоны давхарга** (нарны хэт ягаан туяанаас газар дээрх амьд махбодыг хамгаалах бүрхүүл үүсгэдэг агаар мандлын давхарга). х.834

Жишээ 2. ガスタービン гэдэг нэр томьёог 2 удаа хэрэглэхдээ **хийн турбин** гэж орчуулсан байна.

外国からウランバートル市に貨車で LNG（液化天然ガス）を輸入し、第 2 火力発電所のガスタービンに NG（天然ガス）を供給する設備で、見積範囲は LNG 貯蔵タンクから気化後の NG 貯蔵タンクまでとする。

Хилийн чанадаас Улаанбаатарт ачааны машинаар шингэрүүлсэн байгалийн хий (LNG) тээвэрлэж, 2-р ДЦС-ын **хийн турбинд** байгалийн хий (NG) нийлүүлэх байгууламж бөгөөд өртгийг шингэрүүлсэн байгалийн хий (LNG) хадгалах байгууламжаас ууршуулсны дараах байгалийн хий хадгалах байгууламж хүртэлх хэсгийг хамруулан тооцсон.

2.4 Үгчлэх аргаар орчуулсан нэр томьёо

Үгчлэн орчуулах арга нь нэр томьёог ерөнхий утгаар нь шууд загварчлан буулгадаг арга юм. Энэхүү аргаар холбоо үгээс бүтсэн нэр томьёог орчуулдаг. Холбоо үгийн нэг хэсгийг үгчлэн орчуулж, бусад хэсгийг шууд галиглан орчуулах хандлага байдаг. Жишээ нь

4-р хүснэгт

Япон	Монгол	Л.Энх сайхан “Япон-Монгол, монгол-япон байгаль орчны үг хэллэгийн толь”	С.Дэмбэрэл “Шинэ япон монгол их толь бичиг”
地下水井戸	гүний усны худаг	-	гүний ус 1278х худаг 142х
排出量	ялгарлын хэмжээ	ялгарлын хэмжээ 122х	ялгарлын хэмжээ 1643х
改良ストーブ	сайжруулсан зуух	-	сайжруулах, боловсруулах 350х зуух, пийшин 1047х
電気ボイラー	цахилгаан зуух	-	цахилгаан, гэрэл чийдэн 1416х бойлуур, уурын тогоо 1956
ガスボイラー	хийн зуух	-	шатдаг хий, газ 385х бойлуур, уурын тогоо 1956
電気ヒーター	цахилгаан халаагуур	-	цахилгаан, гэрэл чийдэн 1416х дулаацуулга 1744х
沈殿タンク	Тунадасны сав	-	тунадас, тунамал, тунах 1325х төмөр торх 1262х
雨水管	борооны ус зайлуулах хоолой	борооны ус зайлуулах хоолой 12х	-
熱量計	дулааны тоолуур	-	калориметр 1599х

Судалгааны хэрэглэгдэхүүнээс түүвэрлэн авсан 204 нэр томьёоны 17 буюу 8 хувийг үгчлэх аргаар орчуулсан байна.

Жишээ 1 沈殿タンク - гэдэг нэр томъёог 1 удаа хэрэглэхдээ **тунадасны сав** гэж орчуулсан байна.

排水管、沈殿タンク、砂、油等を検査し違反を犯している場合は指摘事項を提出する。p.52
Ус зайлуулах хоолой, **тунадасны сав**, элс, тос зэргийг шинжилж үзээд ямар нэгэн зөрчил илэрвэл түүний талаар мэдээлэл өгдөг. х.69

Эрдэмтэн Л.Энхсайханы толь бичигт хараахан илэрсэнгүй, эрдэмтэн С.Дэмбэрэл **тунадас, тунамал, тунах, төмөр торх** гэж орчуулсан байна.

“Монгол хэлний их тайлбар толь”-д шингэн зүйлээс тунаж үлдсэн юм: **тунадас үлдэх** (шаар үлдэх, тунасан юм үлдэх), **тунадас үүсэх** (юм тунах)

Жишээ 2: 電気ヒーター гэдэг нэр томъёог 9 удаа хэрэглэхдээ цахилгаан халаагуур гэж орчуулсан байна.


エネルギー標準とラベリングによる規制実施の枠組み内での**電気ヒーター**のエネルギー性能の計算方法の開発 p. 125

Эрчим хүчний стандарт, шошгын зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цахилгаан халаагуурын эрчим хүчний хүчин чадлыг тооцоолох арга зүйг боловсруулах х.164

Эрдэмтэн Л.Энхсайханы толь бичигт хараахан илэрсэнгүй, эрдэмтэн С.Дэмбэрэл цахилгаан, гэрэл чийдэн, дулаацуулга гэж орчуулсан байна.

Бидний гол хэрэглэгдэхүүн тайлангийн түүвэрлэсэн жишээнд тайлбарлах аргаар орчуулсан жишээ хараахан илэрсэнгүй. Судалгааны хэрэглэгдэхүүнээс түүвэрлэн авсан нийт 204 нэр томъёог орчуулгын аргуудаар эзлэх хувийг харуулбал:

График 1



ДҮГНЭЛТ

Бид илтгэлдээ япон хэлний Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны дэд бүтцийг хөгжүүлэх суурь судалгааны тайланг хэл найруулгын болон нэр томъёоны орчуулгын талаас судлан жишээ баримтаар нотлон, судлаач эрдэмтдийн бүтээлд үндэслэн илрэх онцлогийг харуулахыг зорьж дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Бидний гол хэрэглэгдэхүүн суурь судалгааны тайлангийн хэл найруулгыг өгүүлбэр зүйн талаас дүгнэхэд хүүрнэх болон энгийн дэлгэрэнгүй өгүүлбэрээр

ихэвчлэн бичигдсэн байна. Үг зүйн талаас ажиглахад ихэвчлэн өнгөрсөн цагийн –сан⁴ нөхцөл, ирээдүй цагийн –на⁴ нөхцөлөөр хэлбэржсэн бол өнгөрсөн цагийн – в нөхцөлөөр харьцангуй цөөн илэрч байна. Харин уг тайланд өнгөрсөн цагийн – лаа⁴ нөхцөлөөр илэрсэн жишээ хараахан илэрсэнгүй. Мөн тайлангийн өнгөрсөн цагт тайлагнаж бичдэг шаардлагатай нийцэж байна.

2. Судалгааны хэрэглэгдэхүүнээс түүвэрлэн авсан жишээг орчуулгын түгээмэл аргуудаар орчуулагдсаныг эзлэх хувиар нэгтгэн үзвэл хамгийн их буюу дүйлгэх аргаар 74%, галиглах аргаар 10, нэр томъёоны бүтцийн нэг хэсгийг үгчлэн орчуулж, нөгөө хэсгийг галиглах аргаар орчуулсан нэр томъёо хамгийн бага буюу 8%, үгчлэх арга мөн адил 8%-тай илэрч байна.

Аливаа хэлний орчуулгыг хийхдээ тухайн хэлний хэл найруулгын онцлог, бүтцийг ойлгож байж орчуулга хийх нь маш чухал. Иймд орчуулагчаар суралцаж буй оюутан залуус тухайн хэлний хэл найруулгын онцлогийг маш нарийн судалж ойлгох шаардлагатай гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

- [1] Аким Г. “Орчуулгын санг судлахад” 1984
- [2] Баярсайхан Б. “Монгол хэлний их тайлбар толь” 2011
- [3] Гүрбазар Р. “Орчуулгын онол дадлагын үндэс” 1996
- [4] Дэмбэрэл С. “Шинэ Япон- Монгол их толь бичиг” 2018
- [5] Зундуйсүрэн Ч., Дашпүрэв Д. “Шинжлэх ухаан, техникийн тайлбар толь бичиг” 2006
- [6] Монгол Улсын Боловсролын Их Сургууль
- [7] Номиндарь Б. “Хүрээлэн буй орчны салбарын нэр томъёоны орчуулгын судалгаа” 2017
- [8] Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль “Орчин цагийн монгол хэл” 2020
- [9] Сүхбаатар Ц. “Монгол хэлний найруулга зүй” 2015
- [10] Отгонсүрэн Д. “Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй” 1998
- [11] Энхсайхан Л. “Япон-Монгол, Монгол-Япон байгаль орчны үг хэллэгийн толь” 2012
- [12] Эрдэнэзаяа Ц. “Нэр томъёо бүтээх зарим дагаврын утга, хэрэглээ” ШУТИС, ГХИ “Хавсарга хэл шинжлэл” ЭШБ №13,16-22
- [13] Эрдэнэзаяа Ц. “Шинжлэх ухаан техникийн нэр томъёоны орчуулгын асуудалд” "Монгол хэл бичиг" сэтгүүл 2017/№10 БНХАУ, ӨМӨЗО, 33-45 2017
- [14] 高梨紫乃、中西久美子 「日本語文法ハンドブック」 2000
- [15] 小川芳男、林大、 「日本語教育事典」 2002

Викитоль чөлөөт толь бичиг

**МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ АЛБАН БИЧГИЙН УЛАМЖЛАЛ
БА ЗАРИМ ТОГТСОН ҮГ ХЭЛЛЭГИЙН ОРЧУУЛГЫН ТУХАЙД
(Хубилай хаан Корйю улсын ванд илгээсэн жуу бичгийн жишээгээр)**

Б.Ариунбайгаль²²

***Abstract:** Korean historical sources contain a lot of information related to Mongolia and Mongolian-Korean relations written in ancient Korean original text, which is in Chinese. In this research, we aim to narrate the tradition of official letters of the Mongol Empire, as well as how certain fixed words and expressions were translated in diplomatic correspondence and how they were reflected through "A letter sent by Kublai Khan to the king of Goryeo".*

***Түлхүүр үг :** Албан бичиг, Хубилай, Корйю, Гуулин улс, солонгос, уламжлал, харилцаа.*

Оршил

Монголчуудын албан бичгийн уламжлал нь маш эртний түүхтэй. Тухайлбал, бидэнд мэдэгдээд байгаа Монголын хамгийн анхны гадаад харилцааны захидал бичиг болох НТӨ 192 онд Хүннүгийн Маодун шаньюйгаас Хятадын Хан улсын хатан хаан Гао хоу-д илгээсэн захидал²³ бөгөөд Сяньби, Тоба, Хятан, Их Монгол, Их Юань улс гээд манай түүхийн үе үед холбогдох олон арван захидал харилцааны бичиг нь жинхэнэ эхээрээ, эсвэл, монгол болон харь орны түүх сударт тэмдэглэгдэн өнөө үед уламжлагджээ.

Тухайлбал, Солонгосын түүхийн сурвалжуудад Монголтой холбоотой мэдээ занги болон эртний Солонгос эх буюу нангиадаар тэмдэглэсэн Монгол-Солонгосын

²²Ph.D, МУИС, ШУС, ХУС, Ази судлалын тэнхим, ORCID: 0000-0002-7733-9235.

²³Энэхүү захидлын эх бидэнд уламжлагдан ирээгүй бөгөөд уг захидлын тухайт мэдээ хийгээд нангиад орчуулга нь “Ши-цзи (史記, shi ji, 사기)”-гийн 110-р дэвтрийн 136, Бань Гу-гийн “Цянь Ханьшу (前漢書, qian han shu, 전한서)”-гийн 94-д тэмдэглэгдэн үлдсэн байна. Уг захидлын талаар Сумьяабаатар Б., “Монгол хэл, утга зохиол, аман зохиолын ном зүй. 1”, Монгол хэл. Шинжлэх ухааны академийн хэвлэл, УБ., 1972, тал 5-9, Содном Б., Цоггэрэл нар, “Уран зохиолын цоморлог” сэтгүүл, №11, УБ., 1958, тал 171, Ариунбайгаль Б., “1270 онд Гуулин улсаас Монголд илгээсэн төрийн захидал бичгүүд” магистрын ажил, МУИС., 2011, 6-14 талаас дэлгэрэнгүй үзнэ үү.

харилцааны бичгүүд нэлээд их буйг дурдвал эрт, дунд үеийн Солонгосын түүхийн сурвалжууд болох “Гурван улсын түүхэн тэмдэглэл (сол. 삼국사기, нан. 三國史記)”, “Гурван улсын нөхсөн судар (삼국유사, 三國遺事)”, “Зүүн гүрний цэргийн толь (동국병감, 東國兵鑑)”, “Гуулин улсын судар (고려사, 高麗史)”, “Гуулин улсын судрын чухал анги (고려사절요, 高麗史節要)”, “Чосонь улсын магад тэмдэглэл (조선왕조실록, 朝鮮王朝實錄)” зэрэг болно. Эдгээрээс гадна, Солонгосын хойгт оршиж байсан үе үеийн төрт улсуудын элчсийн замын тэмдэглэлүүд байх бөгөөд Монголд өнөөгийн байдлаар дээрх сурвалжуудад үлдсэн Монгол-Солонгосын захидал харилцааны бичгүүдийн талаарх судалгаа харьцангуй богино хугацаанд чамлахааргүй хэмжээнд хийгджээ.

Тэдгээрээс томоохныг нь дурдах аваас, “Гуулин улсын судар”-ын “Сурвалжит гэр”-ийн 1218-1294 оны хэсэгт холбогдох мэдээнд Монголоос Корйё улсад илгээсэн 136 захидал бичиг, Корйё улсаас Монголд илгээсэн 171 захидал харилцааны бичиг буйг доктор Б.Сумьяабаатар орчуулан судалж судалгааны эргэлтэд оруулсан бол, дээрх судалгааны үргэлжлэл болох 1270-1280 онд хамаарах хоёр улсын 150 гаруй захидал харилцааны бичгийг бид судлаад байна.²⁴ Түүнчлэн доктор Ц.Цэрэндорж “Чосонь улсын магад тэмдэглэл”-д үлдсэн Монголтой холбоотой бүхий л мэдээ занги болон баримт сэлтүүдийг судалж олны хүртээл болгожээ.

Харин энэ удаа бид Монголын эзэнт гүрний албан бичгийн уламжлалыг тодруулахын зэрэгцээ зарим тогтсон үг хэллэг нь гадаад харилцааны захидал бичигт хэрхэн орчуулагддаг байсан агаад хэрхэн туссаныг “Хубилай хаан Корйё улсын ванд илгээсэн нэгэн жуу бичиг”-ээр дамжуулан өгүүлэхийг зорилоо.

1. Монгол албан бичгийн ангилал ба хэлбэр

Монголын их хаад, хааны угсааны ноёд эздийн буулгасан бичиг баримтын зүйлсийг зарлиг, үг, захидал, гэрэгэ гэх мэтээр ангилан хэлэлцэж болно.

-Зарлиг. Их хааны буулгадаг зарлиг тушаалыг л монгол хэлээр “зарлиг”, харин түүнээс бусад хааны угсааныхан, хатад, аймгийн ахлагч, сайд, түшмэдийн тушаал зааврыг “үг” хэмээн нэрлэдэг байсан агаад энэ нь Хубилай хаан Их Юань улсыг зарлан тунхагласан 1260 оноос Тогоонтөмөр хаан Дайдуг орхин умар тийш одсон 1368 он хүртэлх 100 орчим жилийн хугацаанд мөрдөгдсөн Их Юань улс дахь бичиг хэрэг хөтлөлтийн онцлог гэж хэлж болно.

-Үг (тушаал). Дээр өгүүлсэнчлэн их хаанаас бусад их бага хаад ноёдын гаргаж буй захирамж тушаалыг “үг” хэмээн нэрлэдэг байжээ. Харин түүнийг бичгийн хэлбэрт оруулсныг “бичиг” хэмээн нэрлэдэг байсан бололтой.

²⁴Ариунбайгаль Б., “Гуулин улсын судар Монгол-Солонгосын харилцааны түүхийн сурвалж болох нь (1270-1280 оны Монгол-Солонгосын харилцааны бичгийн жишээн дээр)”, докторын диссертаци, МУИС., 2018, “Гуулин улсын судар дахь Монгол-Солонгосын харилцааны бичгүүд”, Соёмбо принтинг ХХК., 2021.

-*Захидал*. Гадаад орны хаад ноёд, шашны тэргүүнд явуулах захидлын хүлээн авагч нь захидал илгээгч монгол хаад эздийн шууд харьяаны этгээд биш учир (хэдийгээр Монголын хаад өөрсдийгөө мөнх тэнгэрийн тааллаар дэлхий ертөнцийг бүхэлд нь захирах ёстой гэж үздэг байсан боловч) Монголын эзэнт гүрэн дотроо буулгадаг зарлигтай адилхан байх боломжгүй байсан гэлтэй. Тиймээс тэдгээр захидал нь зарлиг, захидлын хоёрдмол шинжтэй байсан бололтой. Монголын их хаадын харь улсад илгээсэн захидал монгол эхээрээ үлдэж хоцроогүй учир бусад хэлээрх эхээр дамжуулан таамаглаж болно. Тэдгээрээс үзэхэд шууд зарлиг хэмээн нэрлэсэн зүйл үгүй боловч, агуулга хийгээд дээр нь дарсан тамганаас үзэхэд “зарлиг”-ийн шинжийг бас агуулж байжээ. Гүүг хааны Ромын Папад илгээсэн захидалд “Мөнх тэнгэрийн хүчинд Их Монгол улсын Далай ханы зарлиг. Ил, булха иргэнд хүрвээс биширтүгэй, айтугай” хэмээх үсэг бүхий тамга дарснаас үүнийг таамаглан мэдэж болно (Ц.Цэрэндорж, 2015:121-122).

Монголын их хаад харь улсын хаадад захидал бичиг явуулахдаа ихээхэн хашир болгоомжтой хандаж байсныг 1266 онд Хубилай хаанаас Японы ванд илгээсэн захидлаас харж болно. Тэрхүү захидлын нэр нь хүртэл “Их Монгол улсын хааны барьсан бичиг” хэмээх туйлын даруухан байсан ажээ. Өөрөөр хэлбэл, үе үеийн Хятадын төр улсуудаас хөрш зэргэлдээ улс орнуудад илгээдэг байсан төрийн бичигтэй харьцуулахад тун даруухан үг хэллэгтэй байжээ. Энэ захидалд урьдын судлаачдын үзэж ирсэн биш ямар нэгэн сүрдүүлэг, дарамт гэхээр зүйл байхгүй, нэгэн төрлийн амар мэндийг асуусан захидалтай ойрхон гэж зарим судлаач үздэг (Sugiyama, 1996 :120).

Монголын эзэнт гүрэн даяар албан бичгийн гол хэл нь монгол хэл байжээ. Хаад эздийн зарлиг, тушаал, захидал бичгийг монгол хэлээр бичиж, түүнийгээ харь хэлээр орчуулдаг байв.

Харин хэрэглэх бичгийн хувьд, дор хаяж 1269 оноос хойш хаад эздийн зарлиг тушаалыг монгол бичгээр бус, дөрвөлжин бичгээр бичиж эхэлсэн бололтой. Үүнийг *“Монгол үсэгт хоёр зүйлийн хэлбэр буй. Нэгийг нь уйгуржин, харин нөгөөг нь дөрвөлжин хэмээмүй. Урьд цагт жуу бичиг, тамганы бичээст дөрвөлжинийг нь хэрэглэж, өдөр тутмын ажил хэрэг явуулахад уйгуржныг хэрэглэдэг байсан...”* хэмээх солонгос сурвалжийн мэдээнээс харж болно. Дөрвөлжин бичгийг тархаах тухай Хубилай хааны зарлигт ч “Аливаа хаш тамга, тархаах зарлигийг монголын шинэ үсэг (дөрвөлжин үсэг)-ээр бичээд, бус улсын үсгийг дагалдуулан хавсаргагтун” гэж энэ талаар машид тодорхой заасан байдаг.

Үүнээс үзэхэд хаад эздийн зарлиг, тушаалыг дөрвөлжин үсгээр бичиж байсан нь тодорхой агаад Их Юань улсын үеийн зарлиг тушаал монгол бичгээс илүүтэйгээр дөрвөлжин бичгээр үлдэж хоцорсон нь ч үүнтэй холбоотой болов уу.

Их Юань улс нь нангиад газрыг эрхэндээ оруулсан тул монголоор бичсэн зарлиг, тушаалыг нангиадаар орчуулах зайлшгүй шаардлагатай байжээ. Тиймээс албан бичгийн

тогтсон үг хэллэгийг нангиадаар орчуулах нарийн дэг ёс байсан агаад тухайлбал зарлиг, захидлын хамгийн эхэнд бичдэг “Мөнх тэнгэрийн хүчинд” хэмээх хэллэгийг “長生天氣力[裡]” хэмээн орчуулж хэвшсэн ажээ. Гэвч дээрх нангиад орчуулгын үг хэллэг нь анхнаасаа шууд хэлбэршин тогтсон зүйл бус, нэлээд урт хугацааг туулсны эцэст нангиадаар ингэж орчуулна гэж тогтож, хэвшсэн ажээ. Тухайлбал, Хубилай хаанаас Японы ванд илгээсэн захидалд “上天眷命” гэсэн нь “Мөнх тэнгэрийн хүчинд” гэдгийн орчуулга агаад анхандаа захидал, зарлигийг хүлээн авч буй улс орны албан бичгийн хэллэгт тааруулан, ийнхүү нангиадаар арай өөрөөр орчуулж байсныг харуулж байна. Өөрөөр хэлбэл, Хубилай хааны үед албан хэргийг нангиадаар хөглөх, орчуулах систем бүрэн хэлбэршин тогтохоос өмнө шилжилтийн шинжтэй үе байсан ажээ. Их Юань улсын эзэн хааны зарлигийг “шэнчжи (聖旨)”, “жуу [бичиг](詔)” хэмээн 2 янзаар ялгаварлан нэрлэдэг, түүнийгээ ч хатуу чанд мөрддөг байсан билээ. “Шэнчжи” гэдэг нь монгол хэлээрх зарлигийг нангиадаар орчуулсныг, харин “жуу” гэдэг нь анхнаасаа нангиад хэлээр үйлдсэн зарлигийг хэлдэг байжээ (Ц.Цэрэндорж, 2015 : 130).

2. Цагаагчин хонин (신미, 辛未, 1271 он) жилийн хаврын тэргүүн сарын шарагчин туулай (기묘, 己卯) өдөр Корёе улсын ванд илгээсэн Хубилай хааны жуу бичиг

Эртний солонгос эх

8	7	6	5	4	3	2	1
致稽緩匱乏王迎詔于郊	所需糧餉卿專委官赴彼逐近供給鳩集船艦待於金州無	昌洪茶丘將兵送抵海上比國信使還姑令金州等處屯住	輯爾家復遣趙良弼充國信使期于必達仍以忽林赤王國	爲渠疆吏所梗不獲明諭朕意後以林衍之故不暇及今既	好中國又與卿國地相密邇故嘗詔卿道達去使講信修睦	忽林赤王國昌洪茶丘等四十人來詔曰朕惟日本自昔通	己卯蒙古遣日本國信使秘書監趙良弼及

Эхийн сийрүүлэг (Солонгос, Нангиад дуудлага)

Мөр 1

Эртний	己	卯	蒙	古	遣	日	本	國	信	使	秘	書
Солонгос												
эх:												
Солонгос	자	기	몽	고	견	일	본	국	신	사	비	서
дуудлага:												
Нангиад	jǐ	mǎo	méng,	gu	qiǎn	rì	běn	guo	xìn	shǐ,	mì,b	shu
дуудлага:			mēng							shì	ì	
	良	弼										
	양	필										
	Lián	bì										
	g											

Мөр 2

Эртний	及	忽	林	赤	王	國	昌	洪	茶	丘	等	四
солонгос												
эх:												
Солонгос	급	홀	임	적	왕	국	창	홍	다	구	등	사
дуудлага:												
Нангиад	jí	hū	lín	chì	wáng	guo	chāng	hóng	cha	qiu	děng	sì
дуудлага:					,wàn							
	來	詔	曰	朕	惟	日	本	自	昔			
	래	조	왈	짐	유	일	본	자	석			
	lái,lài	zhào	yue	zhè	wéi	rì	běn	zi	xī			
				n								

Мөр 3

Эртний	通	好	中	國	又	與	卿	國	地	相	密	邇
солонгос												
эх:												
Солонгос	통	호	중	국	우	여	경	국	지	상	밀	이
дуудлага:												
Нангиад	tōng,	hǎo,	zhōng	guó	yòu	yǔ,	qīng	guo	dì,dè,	xiā	mì	ěr
дуудлага:	tǒng	hào	zhòng			yú,			dì	ng,		
						yù				ng,		
	詔	卿	道	達	去	使	講	信	修			
	조	경	도	달	거	사	강	신	수			

	zhào	qīng	dào	dá,t à	qu	shǐ, shì	jiǎng	xìn	xiū			
<i>Мөр 4</i>												
<i>Эртний</i>	睦	爲	渠	疆	吏	所	梗	不	獲	明	諭	朕
<i>солонгос эх:</i>												
<i>Солонгос</i>	목	위	거	강	이	소	경	불	획	명	유	짐
<i>дуудлага:</i>												
<i>Нангиад</i>	mu	wéi, wèi	qú	jiān g	lì	suo	gěng	bu	huò	mí ng	yu	zhè n
<i>дуудлага:</i>												
	以	林	衍	之	故	不	暇	及	今			
	이	임	연	지	고	불	가	급	금			
	yǐ	lín	yǎn	zhī	gù	bu	xia	jí	jīn			
<i>Мөр 5</i>												
<i>Эртний</i>	既	輯	爾	家	復	遣	趙	良	弼	充	國	信
<i>солонгос эх:</i>												
<i>Солонгос</i>	기	집	이	가	복	견	조	양	필	충	국	신
<i>дуудлага:</i>												
<i>Нангиад</i>	jì	jí	ěr	jiā,g ū,jiá ,jiè	fu	qiǎ n	zhào	liáng	bì	chō ng	guo	xìn
<i>дуудлага:</i>												
	于	必	達	仍	以	忽	林	赤	王			
	우	필	달	잉	이	홀	임	적	왕			
	yu	bì	dá,ta	réng	yǐ	hū	lín	chì	wáng, wàng g			
<i>Мөр 6</i>												
<i>Эртний</i>	國	昌	洪	茶	丘	將	兵	送	抵	海	上	比
<i>солонгос эх:</i>												
<i>Солонгос</i>	국	창	홍	다	구	장	병	송	저	해	상	비
<i>дуудлага:</i>												
<i>Нангиад</i>	guo	chān g	hóng	cha	qiū	jiān g,ji àng	bīng	sòng	dǐ	hǎi	shàn gshǎ ngsh àng	bǐ, bì
<i>дуудлага:</i>												
	使	還	姑	令	金	州	等	處	屯			
	사	환	고	령	금	주	등	처	둔			
	shǐ,sh ì	hái,h uán	gu	lǐng, lǐng	jīn	zhō u	děng	chù, chu	tún,z hūn			
<i>Мөр 7</i>												
<i>Эртний</i>	住	所	需	粮	餉	卿	專	委	官	赴	彼	逐
<i>солонгос эх:</i>												

<i>Солонгос</i>	주	소	수	량	향	경	전	위	관	부	피	축
<i>дуудлага:</i>												
<i>Нангиад</i>	zhu	suo	xu	lián	xiǎng	qīn	zhuān	wěi,	guān,	fu	bǐ	zhú
<i>дуудлага:</i>				g		g		wēi	guǎn			
	給	鳩	集	船	艦	待	於	金	州			
	급	구	집	선	함	대	어	금	주			
	gěi,jǐ	jiū	jí	chu	jiàn	dài,	yú,wú	jīn	zhōu			
				án		dāi	yu					

Мөр 8

<i>Эртний</i>	無	致	稽	緩	匱	乏	王	迎	詔	于	郊
<i>солонгос эх:</i>											
<i>Солонгос</i>	무	치	계	완	궤	핍	왕	영	조	우	교
<i>дуудлага:</i>											
<i>Нангиад</i>	wú,m	zhì	jī,qì	huǎ	kuì,g	fa	wáng,	yíng	zhào	yú	jiāo
<i>дуудлага:</i>	ó			n	uì		wàng				

Орчин цагийн солонгос хөрвүүлэг 1.

Гиймийл. Могог 일본에 국신사 (國信使)로 비서감 조량필 (趙良弼) 및 홀림적 (忽林赤), 왕국창 (王國昌), 홍다구 (洪茶丘) 등 40 여명을 보내어 왔다. 그들이 가져온 조서에 이르기를

“내가 생각하건데 일본은 예로부터 중국과 교통하여 우호관계를 맺어왔고 또 당신의 나라와는 그 국경이 아주 가깝기 때문에 일찌기 당신에게 조서를 보내고 사신을 파견하여 국교를 열어 우호를 맺게 하도록 하였다. 그러나 일본 지방 관리들의 방해로 나의 뜻이 명확히 전달되지 못 하였었다. 그 후에는 림연의 사건으로 그 문제를 미처 제기하지 못 하였다. 이제 와서는 당신의 나라가 안정되었으므로 다시 조량필을 국신사로 보내니 반드시 일본에 그가 도착하도록 할 것이다. 이와 아울러 홀림적, 왕국창, 홍다구의 장병들을 해변가에까지 보내어 국신사가 돌아올 무렵까지 우선 금주 (金州-김해) 등처에 주둔하게 되었으니 이에 필요한 군량은 당신이 그 사업을 전임 관리에게 맡기여 그 지방에 파견하고 그 린근 지방에서 마련하여 공급하도록 할 것이며 선박과 군함들을 모두 금주에서 대기하게 하되 늦어지거나 부족함이 없도록 할 것이다.”라고 하였다. 왕이 교외에 나가서 조서를 받았다.

북역 “고려사”, ‘세가’ 27 권, 평양, 1975, 91 쪽.

Орчин цагийн солонгос хөрвүүлэг 2.

Гиймийл. Могог 일본국신사 日本國信使로 비서감秘書監 조량필趙良弼과 쿠림치[忽林赤], 왕국창王國昌, 홍다구洪茶丘 등 40 명을 보내면서 다음과 같은 조서를 전달했다.

“짐이 생각하건데 일본은 예로부터 중국과 서로 교류했으며 또한 경의 나라와 지역이 서로 가깝기에 진작 경에게 지시해 사신을 인도하고 우호관계를 맺도록 한 바있다. 그러나 그 나라의 국경을 지키는 관리들이 저지하는 바람에 짐의 뜻을 분명히 전달하지 못했으며, 그뒤에는 임연林衍의 일 때문에 겨를이 없었다. 이제 그대 나라가

안정을 되찾았기에 다시 조양필趙良弼을 국신사國信使로 보내니 반드시 일본에 당도할 수 있게 만전을 기하라. 또한 쿠름치, 왕국창, 홍다구로 하여금 군사를 거느리고 해안까지 호송하게 하고 국신사가 돌아올 때까지 임시로 금주金州 등지에 주둔하게끔 조치했다. 주둔하는 동안 소요되는 군량은 경이 전담관리를 주둔지로 보내 가까운 곳에서 마련해 공급하게 할 것이며, 전함을 금주에 집결 대기시켜 출발이 지체되거나 물자가 부족하는 일이 없도록 하라.”

왕이 도성 밖까지 나가 조서를 맞이했는데...

국역 “고려사”, ‘세가 27’, 이현재 옮김, 서울, 경인출판사, 2008, 155 쪽.

Монгол хөрвүүлэг:

Шарагчин туулай өдөр. Монголоос Япон руу улсын элчээр писөгам Чо Янп_{хил}²⁵, К_{хүрүмчи}, Ван Гүгч_{хан}, Хон Дагү нарын 40 хүн илгээн дараах жуу бичгийг уламжлав.

“Миний бодоход Япон улс эртнээс Дундад улс лугаа харилцаж ирсэн бөгөөд чиний улстай хил хязгаар харилцан ойр тул, урьд чамд заавар өгч элчийг газарчлан, найрамдал тогтооё хэмээсэн нь бий. Гэтэл тэр улсын хил сахигч түшмэд саад хийсний уршгаар миний санааг ёсчлон уламжилж чадаагүй ба түүний дараа Им Йөнъ-ий хэрэг явдлын улмаас завдсангүй. Харин одоо улс чинь тайван амгалан болсон тул дахин Чо Янп_{хил}-ыг элчээр илгээх тул заавал түүнийг Японд хүргэсүгэй. Түүнээс гадна, К_{хүрүмчи}, Ван Гүгч_{хан}, Хон Дагү нарыг цэргээ удирдан далайн эрэг хүртэл дагалдуулан элчийг буцаж ирэх хүртэл Кымжү нутагт цэрэг суулгахаар боллоо. Цэрэг суух хугацаанд шаардлагатай цэргийн хэрэгслийг чи хариуцсан түшмэлийг илгээн, ойр орчмын нутгаас бэлдэн нийлүүлж, хөлөг ба завийг цуглуулан Кымжү-д бэлэн байлгаж, явдал удаашрах, гачигдах зүйлгүй байлга.” гэжээ. Ван жуу бичгийг ордноос гарч хүлээн авав.

Дүгнэлт

Хубилай хаан Гуулин улсын ванд илгээсэн дээрх жуу бичгээс үзвэл, өгүүлэн бүхий үеийн монгол албан бичгийн онцлог болох үг хэллэг, агуулгын ерөнхий хэлбэр зэрэг нь огт ажиглагдсангүй. Тухайлбал:

Нэгдүгээрт: Хубилай хааны үеэс эхлэн их хаадын зарлигийг “Мөнх тэнгэрийн хүчинд, их суу залийн ивээлд, хаан зарлиг ану” гэсэн 3 мөр тогтсон хэллэгээр эхлүүлэн бичдэг байсан бол энэхүү жуу бичигт тэдгээр үг хэллэг үгүй, түүний нангиад орчуулга болох “長生天氣力[裡]” буюу “上天眷命” гэсэн хэллэг огт алга байна.

Хоёрдугаарт: Уг бичгийг нангиадаар “жуу бичиг” хэмээсэн нь дээрх бичгийг анхнаасаа нангиадаар бичсэн байх магадлал өндөр байна. Учир нь Их Юань улсын эзэн хааны зарлигийг “шэнчжи (聖旨)”, “жуу [бичиг](詔)” хэмээн 2 янзаар ялгаварлан нэрлэдэг, түүнийгээ ч хатуу чанд мөрддөг байсан бөгөөд “Шэнчжи” гэдэг нь монгол хэлээрх зарлигийг нангиадаар орчуулсныг, харин “жуу” гэдэг нь анхнаасаа нангиад хэлээр үйлдсэн зарлигийг хэлдэг байсан тухай бид дээр тэмдэглэсэн билээ.

²⁵ Солонгос хөрвүүлгүүдэд зарим үгс ба хүний нэрсийг ялгаатай тэмдэглэжээ. Бид 2 дахь хувилбарыг дагав.

Гэвч дөрвөлжин үсгээр бичсэн зарим нэг зарлигийн бичгийг “Гуулин улсын судар”-т “жуу [бичиг](ᠵᠢᠰᠢ)” хэмээн тэмдэглэсэн тохиолдол бас буйг анхаарах нь зүйтэй. Баттай хэлэхэд бэрх боловч энд дурдагдаж буй дөрвөлжин үсгээрх жуу бичиг нь дөрвөлжин үсгээр нангиад хэлээр, эсвэл, монгол хэлээр бичигдсэн байлаа ч гэсэн нэгэнт нангиадаар орчуулагдаагүй учраас “шэнчжи” гэж нэрлээгүй байж болох юм. Цаашид дөрвөлжин, эсвэл, монгол бичгээр бичсэн (Монгол, нангиад хэлээр байж болно) зарлигийг нангиадаар чухам юу гэж нэрлэдэг байсныг тодруулах шаардлагатай.

“Гуулин улсын судар”-т буй Монголын хааны зарлигийн бичгүүдийг ихэвчлэн “жуу [бичиг](ᠵᠢᠰᠢ)” гэж нэрлэсэн, бас тэдгээрт монгол албан бичгийн тогтсон ёс бараг харагдахгүй байгаагаас үзэхэд Корйё улсад илгээх аливаа албан бичгийг монголоор бичээд, нангиадаар орчуулахаас илүүтэй, шууд нангиадаар бичдэг байсан байх магадлал тун өндөр байна. Үүнийг солонгосчууд эрт цагаас албан хэргээ нангиад хэлээр хөтөлдөг, нангиад хэл бичгийг маш сайн эзэмшсэнтэй холбон тайлбарлаж болно.

Нөгөө талаар, Корйё улсад илгээж байсан албан бичгүүдийн жинхэнэ эх эдүгээ уламжлагдан ирээгүй нь бидний судалгаанд бэрхшээл учруулж буй агаад монгол хэлээр бичээд, нангиадаар орчуулдаг, өөрөөр хэлбэл, монгол, нангиад хоёр хувь үйлддэг байсан байж болохыг ч үгүйсгэх аргагүй.

Нөгөө талаар, “Гуулин улсын судар”-т оруулахдаа монгол, эс бөгөөс нангиад эхийн хэлбэр онцлогийг эвдэн, агуулгыг алдагдуулалгүй, солонгос сурвалжийн хэлбэр найруулгаар тэмдэглэсэн гэж үзлээ гэхэд албан бичиг, захидлуудын монгол эхийн тухай бараг дурдахгүй байгаа нь хачирхалтай санагдана. Энэ бүхэн нь Корйё улсад илгээх аливаа албан бичгийг шууд нангиадаар бичдэг байсан гэж үзэхэд хүргэж байгаа юм. Гэвч цаашид илүү нарийн судалгаа хийж, ул суурьтай шинжлэн үзэх шаардлагатай гэж үзэж байна.

НОМЗҮЙ

Монгол хэлээр

1. Сумьяабаатар Б., "XIII-XIV зууны Монгол, Солонгосын харилцааны бичгүүд", ШУА-ийн хэвлэл, УБ., 1978.
2. Цэрэндорж Ц., “Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхэнд холбогдох солонгос сурвалжийн зарим мэдээ” - “Чин улс ба монголчууд”, Тохокү их сургууль, Сэндай, 2012.
3. Цэрэндорж Ц., “Бичиг үсэг, албан бичгийн уламжлал” - “Хубилай хаан ба түүнийг залгамжлагчид”, УБ., 2015.

Солонгос хэлээр

4. Гуулин улсын судар, “Сурвалжит гэр”, 27-р дэвтэр, Пхеньян, 1975.
5. Гуулин улсын судар, “Сурвалжит гэр”, 7-р дэвтэр, Хөрвүүлсэн Хань Жөнхый, Сөүл, Кйөн-инь хэвлэл. 2008.
6. И Хйөнъжай, “Солонгос үндэстний соёлын нэвтэрхий толь 2”, Сөүл, Самхва хэвлэл, 1994.

7. Ким Рагжунь, “Нью-эйс солонгос хэлний тайлбар толь”, Сөүл, Кымсөн сурах бичиг хэвлэл, 1987.
- Sugiyama 杉山正明, モンゴル帝国の興亡<下>, 講談社現代新書, 1996. Орчуулсан Им Дайхый нар.

ОРЧУУЛАХ ЧАДАМЖ ОРЧУУЛАГЧИЙН ЧАДВАРААС ХАМААРАХ НЬ

Д. Долгорсүрэн²⁶

У. Лхагвасүрэн²⁷

Abstract

This article is concerned from beginning to end with translation skills and translation related skills of all types. Although the study of translation skills appears to be only theoretical, this work will combine both the theoretical literature on these skills with a host of illustrative applications and examples from both languages involved, English and Mongolian. Translation skills sound familiar to everyone involved in a way or another in the field of translation. Almost all books on translation refer to these skills as though axiomatic to readers. Translation skills of all types should be developed simultaneously in both languages involved, the foreign as well as the mother tongue. Mongolian students of translation and translators alike have exhibited a number of weaknesses in their Mongolian Language skills, which have bad effects on the quality of their translations. Therefore, they must attend more seriously to mastering their native language skills of all types with a view to improving their understanding, style of writing, means of expression and, hence, translations. This paper is meant to introduce the main types of translation skills in detail in theory as much as in practice, elaborating and covering all aspects of translation as a discipline and a profession.

Keywords: translation skills, types of translation skills, native language skills, translation accuracy,

“Орчуулгад багш гэж байдаггүй, харин орчуулгыг хянаж, засаж байгаа нэгэн буюу редактор нь орчуулагчийн багш юм” гэсэн үг байдаг. Орчуулга хийдэг, орчуулгын салбарт ажилладаг хүн аливаа хэлнээс эх хэл рүүгээ, эсвэл эх хэлнээсээ гадаад хэл рүү орчуулга хийхэд тодорхой чадвар чадамжууд зайлшгүй шаардлагатай байдгийг ухаарч, суралцаж, тэдгээр чадваруудыг эзэмшсэнээр

²⁶ 1-р зохиогч, МУИС, ШУС, Гадаад хэлний төвийн ахлах багш, доктор (PhD)

²⁷ 2-р зохиогч, МУИС, ШУС, Гадаад хэлний төвийн ахлах багш, доктор (PhD)

жинхэнэ орчуулагч болдог. Орчуулагчийн чадвар гэдэг орчуулга хийж буй тухайн хэлээ хэр сурч эзэмшиж, хэрэглэж чадаж буй чадамжтай нь холбоотой байдаг. Орчуулах чадамжийг онол практикийн түвшинд эзэмшихийн тулд орчуулагч хүн ямар чадваруудыг эзэмшсэн байх ёстойг мэдээд зогсохгүй тэдгээрт суралцах нь нэн чухал, учир нь орчуулгын чанар болон орчуулах чадамж нь орчуулагчийн чадвараас ихээхэн хамаардаг билээ.

Нэг хэлээс нөгөө рүү нь хөрвүүлэх үүрэг хариуцлагатай мэргэжилтнийг орчуулагч гэх бөгөөд орчуулагчийн хөрвүүлж бичсэнийг эсвэл яриагаар дамжуулж буйг орчуулга гэдэг. Орчуулагч нь орчуулгыг алдаагүй, үнэн зөв, чанартай гүйцэтгэх үүрэгтэй. Аливаа орчуулагч хүн орчуулга хийхдээ эх дээр байгаа утга нь орчуулж буй хэлнээ буухдаа найруулгын хувьд ижил, хоёрдмол утгагүй, төгс найруулгатай сайн орчуулга хийхийг зорьдог. Орчуулгаа чанартай сайн гүйцэтгэхийн тулд орчуулагч дараах зүйлсийг хийх хэрэгтэй байдаг ажээ. Үүнд:

- Эх бичвэр эсвэл аман ярианы тэмдэглэлийг судалж, агуулгыг нь ухаж ойлгох, хөрвүүлэхдээ эх бичвэрийн үндсэн утгыг хадгалах;
- Нэр томъёог үнэн зөв оноож, утгыг нь илэрхийлэхийн тулд тохирох сайн толь бичиг болон бусад эх үүсвэрүүдийг ашиглах, ялангуяа хуулийн, техникийн, шинжлэх ухааны нэр томъёо, мэргэжлийн үг хэллэгийг зөв оноох;
- Аливаа материалыг зорилтот хэлнээ бичгээр буулган орчуулахдаа уншигдахуйц хэл найруулгатай болгох;
- Орчуулгаа нягтлан шалгаж, засварлаж, сайжруулах;
- Тодорхой салбарын хэвшсэн нэр томъёог орчуулахдаа мэргэжлийн хүний санал зөвлөгөөг сонсож, зохих лавлагаа материалыг ашиглаж, зөв тайлбарлах;
- Орчуулж буй хэл дээрээ утгыг үнэн зөв илэрхийлэн гаргах;
- Зорилтот хэлний өгүүлбэр зүйн болон зөв бичгийн дүрмийн тогтсон журмыг баримталж, цэг таслал, ялгах тэмдгүүдийн утга ялгаж буй байдлуудыг анхаарч дарааллыг нь зөв гаргаж орчуулах;
- Үгсийн сангийн уялдаа холбоог хангах, хэвшмэл болон өвөрмөц үг хэллэгийг оновчтой ашиглах;
- Тухайн салбарын бичлэгийн онцлог хэв маягт нийцүүлэх, холбогдох стандартыг мөрдөх, тухайлбал дипломат баримт бичгийн тухайд тогтсон хэв загвар, бичлэгийн дэг жаяг байдаг (дипломат албан захидал, итгэмжлэх жуух бичиг болон ноот бичгүүд дэх хүндэтгэлийн үг хэллэгийн эрхэмсэг өнгө аясыг тохирох үг хэллэгээр илэрхийлэх);

- Зохих форматад оруулах, уншихад дөхөмтэй, нүдэнд эвтэйхэн фонтоор бичих;
- Хэрэглэгчдэд буюу уншигч сонсогчдод хүргэх зорилгоо хангасан орчуулга гаргах;
- Эх хэл дээрх бичвэрийн утгыг ойлгож, зорилтот хэлнээ орчуулан буулгахад шаардлагатай хэл шинжлэлийн мэдлэгтэй байх, мөн тухайн сэдвийн буюу салбарын чиглэлээр нарийн мэдэхийн тулд мэргэжлийн ном сурах бичиг, интернэт болон бусад эх сурвалжийг ашиглах, мэргэжлийн хүнээс туслалцаа зөвлөмж авах зэргээр судалгаа хийх;

Орчуулгын чиглэлээр суралцаж буй оюутан нь мэргэжлийн орчуулагч болох хүртэлх явцдаа мэдэж, судалж, сурч эзэмшвэл зохих орчуулгын гурван тулгуур чадамж байдаг ажээ. Өөрөөр хэлбэл дараах гурван чадварыг эзэмшсэн байвал сайн орчуулах чадамжтай болдог. Орчуулах чадамжийн талаар мэдмэгц шууд чадварлаг орчуулагч болохгүй ч мэргэшсэн сайн орчуулагч болохыг зорьж буй хэн бүхэнд тэдгээр нь чухал удирдамж, зааварчилгаа болж, амжилттай мэргэшсэн орчуулагч болоход нь тустай юм. Орчуулгыг сайн хийхэд тусалдаг тэдгээр гол гурван тулгуур нь:

1. Хэлний чадвар (бичих, унших, ойлгох чадварууд, дээр нь нэмээд орчуулгын тэмдэглэл хийх чадвар)
2. Харилцааны чадвар (хэл ярианы чадвар, санах ой буюу ой тогтоолт, сэтгэл зүйн тогтвортой байдал, аман орчуулга хийж байгаа бол ярианыхаа хурдыг тохируулах хянах чадвар мөн орно).
3. Соёлын мэдлэг (Өөр хэл соёлтой хүнтэй харилцахад, эсвэл яриа болон бүтээлийг нь орчуулахад тухайн хүний төрөлх нутгийнх нь нийгэм соёлын талаар тодорхой суурь ойлголт мэдлэг байх нь зайлшгүй хэрэгтэй.)

Орчуулга хийх ур чадвар гэдэг нь олон зүйлээс шалтгаалж болох бөгөөд хэл шинжлэлийн бүрэлдэхүүн хэсэг болох хэлний дүрмийн буюу үг зүй, авиа зүй, өгүүлбэр зүй; лексик-үгийн сан, стилистик-найруулга зүй, дуудлагын талаарх мэдлэгээ мэргэжлийн харилцааны янз бүрийн нөхцөл байдалд практикт ашиглах чадварыг хэлнэ. Орчуулах эрдэм чадвар нь тухайн орчуулагчийн эх хэлээ болон орчуулга хийх хэлээ эзэмшсэн байдал, боловсрол мэдлэг, мэргэжлийн түвшинд уншиж судалсан хэмжээ далайцаас ихээхэн хамаардаг байна.

Техник технологийн хөгжил дэвшил, ардчилал чөлөөт байдлын ачаар гадаад хэлийг сонирхон суралцагсдын тухайн хэлээрээ ярих сонсох чадвар улам сайжирч, уншиж судлах зүйл ч элбэг болжээ. Харин бичгийн чадвар, тэр дундаа орчуулах эрдэм чадвар нь дээр хэлсэнчлэн тухайн хүний эх хэлээ эзэмшсэн байдал, боловсрол мэдлэг, мэргэжлийн түвшинд уншиж судалсан хэмжээ

далайцаас хамаарах нь ойлгомжтой. Гадаад хэлний боловсрол өндөртэй хэмээн тооцогддог олон хүн бичгийн орчуулга хийхдээ үг оноолт, утга найруулгын тал дээр алдаа гаргах нь элбэг. Гол шалтгаан нь тэд жинхэнэ монгол зохиолч, монгол яруу найрагчид, монгол эрдэмтэн мэргэдийн бичсэн ном зохиол, бүтээл туурвилуудыг харьцангуй бага уншдагтай холбоотой. Орчуулах ур чадвараа сайжруулахын тулд эх хэл дээрээ ном зохиол их унших сонирхол, тогтмол дадал хэрэгтэй.

Америкийн Нэгдсэн Улсын Хөдөлмөрийн Статистикийн Товчоо (Bureau of Labor Statistics (BLS)-ээс гаргасан судалгаагаар орчуулагчийн ажлыг "Bright Outlook" буюу алсдаа их эрэлттэй байх мэргэжилд оруулан ангилж байгаа бөгөөд тэндээс эрхлэн гаргадаг "Хөдөлмөр Эрхлэлтийн хэтийн төлөв 2019-2020" нэртэй гарын авлагад орчуулагчийн ажил эрхлэлт цаашдаа улам өсөх төлөвтэй байна гэжээ. Уг гарын авлагад орчуулагчийн ажил мэргэжилд шаардагдах гол чадамжуудыг доорх байдлаар задлан тайлбарласан байна:

- Сонсох чадвар – үгсийг зөв орчуулж, тайлбарлахын тулд тэдгээрийг ялгаж сонсож чаддаг, мөн сайн ойлгодог байх хэрэгтэй
- Ярилцах чадвар – тодорхой, ойлгомжтой ярих чадвар маш чухал байдаг.
- Уншиж ойлгох чадвар – уншсанаа зөв ойлгодог байх нь зөв орчуулахад нэн чухал.
- Бичих чадвар – бичгийн орчуулгын гол амин сүнс нь бичих ур чадвар байдаг.
- Соёлын мэдлэг – Энэ бол орчуулах чадамжийн чухал хэсэг юм. Соёлын талаар тодорхой суурь буюу ерөнхий ойлголтгүй байвал орчуулга сайн болох боломжгүй.

Тэгэхээр эх эсвэл "эх сурвалж" текстийг/үг яриаг/ өөр хэл дээрх текст рүү /үг яриа руу/ шилжүүлэх үйл явц болох орчуулгыг хийхэд юуны өмнө хэлний чадвар буюу бичих, унших, ойлгох чадварууд амин чухал байдаг ажээ.

Олон улсын орчуулагчдын холбооноос 1994 оны 7-р сарын 9-ны өдөр Норвеги улсын нийслэл Осло хотод болсон хурлаараа нэмэлт өөрчлөлт оруулан баталсан "Орчуулагчдын Дүрэмд" (TRANSLATOR'S CHARTER, approved by the Congress at Dubrovnik in 1963, and amended in Oslo on July 9, 1994, The International Federation of Translators) орчуулагч нарын эрх үүрэг, аюулгүй байдал, цалин хөлс, ажлын нөхцөлийн талаар олон улсын хэмжээнд баримтлах ёстой дүрэм журмуудыг нарийн тодорхой тусган оруулсан байдаг бөгөөд мөн тэдний эзэмшсэн байвал зохих чадвар чадамжуудын талаар зааж өгчээ. Тэдгээрийг судалж мэдэх нь мөн орчуулагч нарт их тустай юм.

Өнгөрсөн гуч гаруй жилийн хугацаанд орчуулгын ном олноор гарах болж, мэргэжлийн болоод сайн дурын орчуулагчдаас бүрдсэн агентлаг, орчуулгын

товчоод олноор ажиллах болж, төрөл бүрийн салбарын номыг хэвлэн гаргасаар ирлээ. Дэлхийн улс орнуудад эсвэл аль нэг бүс нутагт шилдэг борлуулалттай гэгдсэн номыг тэд шүүрэн авч орчуулах нь элбэг байна. Ялангуяа Монголд урьд өмнө нь гол төлөв орос хэлнээс орчуулсан ном бүтээл хэвлэгдэн гардаг байсан бол 20-р зууны сүүлээс англи, франц, герман, хятад, солонгос болон бусад хэлнээс орчуулга хийх нь түгээмэл болохын хирээр орчуулгын чанарын асуудал, орчуулагчдын чадвар чадамжийн асуудал салбарын судлаачдын анхаарлыг улам татаж байгаа нь зүйн хэрэг юм. Судлаачдын үзэж байгаагаар хэлмэрч/орчуулагч хүн дараах чадварыг эзэмшсэн байх шаардлагатай ажээ. Үүнд:

- ✓ Үг яриаг нь орчуулах гэж буй хүнийхээ санаа бодлыг хурдан ойлгож, асуудлын уялдаа холбоо, нөхцөл байдлыг сайн холбож сонсогчдод ойлгуулах
- ✓ Орчны мэдрэмж сайтай байж, чихэнд нийцтэй зөөлөн дуу хоолойгоор тод, жигд ярих
- ✓ Цэвэр, мөн оновчтой үг хэллэгийг сонгон, дамжуулах зүйлээ чадварлаг, энгийн боловч тодорхой илэрхийлэх,
- ✓ Уран сэтгэмжтэй, ажигламтгай, ой сайтай байх
- ✓ Түргэн бичиж тэмдэглэж авах чадвартай байх
- ✓ Сэтгэл хөдлөлөө барьдаг, тэвчээртэй, ёс зүйтэй байх
- ✓ Янз бүрийн нөхцөл байдал, орчинд зөв дасан зохицох чадвартай байх
- ✓ Өөрийн үзэл баримтлал, санаа бодлыг хавчуулахгүй байх
- ✓ Сайн толь бичгийг олж сонгож, зөв хэрэглэх аргаа мэддэг байх (учир нь сайн толь бичиг хэзээд орчуулагчийн зэмсэг, гол туслагч байсаар байх болно)
- ✓ Нүдэнд дулаахан, найрсаг, бүх давхаргын хүнтэй эвсэг, хүндэтгэлтэй харилцдаг байх зэрэг орно. Эдгээр чадваруудыг нэг бүрчлэн тайлбарлавал их нурших болох тул энэ удаад түр орхиё.

Орчуулагчид нь уран илтгэгч шиг өөрийн бодлоор аливааг илэрхийлж, үг нэмж хачирлах ёсгүй, харин орчуулж буй бичвэрээ, хэрэв аман орчуулга хийж байгаа бол яригч этгээдийн хэлсэн үг, бусдад ойлгуулах гэсэн санааг нь бүрэн гүйцэд зөв дамжуулах ёстой. Тэгэхдээ үгчлэн орчуулах шаардлагатай үе ч бий, гол утгыг нэгтгэн зангидаж, товч бөгөөд тодорхой орчуулах ёстой ч үе байдаг. Ялангуяа дипломат орчуулагч нар дээрх чадваруудыг сайтар эзэмшиж байж урлаг, спорт, уран сайхан, аялал жуулчлал болон нийгмийн бусад салбарын орчуулагчдаас ялгарах ёстой гэж үздэг. Ялангуяа дипломат орчуулагчид ухаалаг, төлөв, аажуу тайван, биеэ эзэмдэн захирч, анхаарлаа төвлөрүүлж чаддаг, амархан гомддоггүй, уурладаггүй, хөөрч догдолдоггүй, хүйтэн дүнсгэр биш, алиа марзан биш, аливаад тэнцвэртэй түвшин байдлыг сахидаг байх ёстой. Илүү олон үг

нурших, хэт гоёмсоглон номчирхох, мэдэмхийрэх зэргээс хол байхыг ямагт хичээх нь зүйтэй гэж туршлагатай орчуулагчид зөвлөдөг. *Орчуулагч орчуулж байгаа хэлээ тун сайн мэдэх ёстой нь мэдээж хэрэг боловч зөвхөн гадаад хэлийг төгс эзэмшлээ гээд дипломат орчуулагч болохгүй. Орчуулгыг сайн хийх эсэх нь орчуулагчийн зан төрхөөс хамаардаг* гэсэн байдаг.²⁸ Тэгэхээр зөв зан чанар, түвшин төлөв байдал нь орчуулагч хэлмэрч нарын хувьд чухалд тооцогддог байна.

Орчуулагчдад гадаад хэлний цогц мэдлэг зайлшгүй шаардагддаг. Цогц гэдэг нь тухайн хэлээр сайн агаад оновчтой зөв үгээр ярьж зөв ойлгуулах эв дүй, цаад талаа бүрэн гүйцэд сонсож ойлгох чадвар, санаа бодлоо утга төгөлдөр ойлгомжтой илэрхийлэн бичих чадвар болон ямарваа бичвэрийг зохих хугацаанд бүрэн зөв ойлгож унших чадвар буюу өөрөөр хэлбэл ярьж, сонсож, бичиж, уншиж мэдсэн бүхнээ гол нь зөв хөрвүүлэн орчуулах, дамжуулах мэдлэг чадварыг сайтар эзэмшсэн байхыг хэлнэ. Францын эрдэмтэн, найруулга зүйч Р. Жеоржин “Найруулгын нууцууд” номдоо: *“Найруулах эрдмийн гол сүнс нь үг сонголт мөн...”* хэмээн бичжээ. Тэгэхээр аливаа зүйлийн талаар найруулан бичнэ, зөв ярина гэдэг бол үг сонголтын асуудал юм. Ганц үг, ганц авиа ч найруулгын өнгө аясыг тодорхойлж чаддаг учраас үгийг зөв сонгох нь чухал байдаг.

Орчуулга бол аливаа улс үндэстний соёлын салшгүй хэсэг билээ. Монгол англи хэлтнүүдийн аж амьдрал, зан заншил, ахуй соёлын ялгаа их байдаг бөгөөд тэрхүү ялгаа нь хэл бичигт нь тусгалаа олж, бичгийн болон ярианы хэлэнд тод илрэн харагддаг. Тухайлбал суурьшмал амьдралын хэв маягтай англи хэлтнүүдийн хэл бичигт хүндэтгэлийн утгыг илэрхийлэхдээ нэр үгийг ихэвчлэн ашигладаг бол нүүдэлчин соёл иргэншилтэй монгол хэлтнүүд *ажсаам уу, болгооно уу, тольдоно уу* гэх зэргээр үйл үгийг голлодог. Англи хэл дээр бичигдсэн албан, сургалт судалгааны болоод эрдэм шинжилгээний бичвэрүүдэд нэр үг өргөн хэрэглэгддэг.

Нэг жишээ авья. *“With the introduction of computers, much of the routine work of bookkeeping is done by the bookkeeping program, such as processing accounts for payments received, producing checks, printing invoices, calculating payroll and deduction amounts, and producing statements.”* Орчуулгын дадал хичээл дээр энэ өгүүлбэрийг оюутнуудаар орчуулуулахад тэд ихэнхдээ *Компьютерийг танилцуулахын хамт . . .* гэж орчуулдаг. Хэрэв ингэвэл *Компьютерийг танилцуулахын хамт, өглөгийн дансыг тооцоолох, чек бичих, нэхэмжлэл гаргах, цалингийн ба суутгалын дүнг тооцон гаргах болон банкны хуулга үйлдэх зэрэг данс тооцооны тогтсон ажлын ихэнхийг компьютерээр гүйцэтгэдэг боллоо* гэж

²⁸ В. И. Попов, “Орчин үеийн дипломат ажиллагаа: онол практикийн асуудал”, 2003, х. 46

орчуулах болно. Энэ өгүүлбэрийн эхний *“With the introduction of computers . . .* “ гэсэн хэсгийг *“Компьютер нэвтрэснээр . . .* “ гэж орчуулбал зүгээр.

Ямарваа хэлнээс орчуулга хийж буй хүн зохиогчийн хэлэх гэсэн гол утга санаа болон бичвэрийн жинхэнэ утга агуулгыг алдагдуулахгүйг ямагт эрхэмлэж, дэс дараалал нь тодорхой ойлгомжтой, хэл найруулгын хувьд зохистой арга хэлбэрийг сонгож байх нь зүйтэй юм. Мөн орчуулагчийн анхаарах ёстой бас нэг зүйл бол уншигчдад өгөөжтэй, ажил амьдралд нь тус нэмэр болохуйц, үр хойчдоо сургаалтай, зөв сайн үр дүнд хүргэх тийм ном, материалыг сонгон түлхүү орчуулж байвал бүгдэд тустай билээ. Сүүлийн үед олон арван бестселлерыг янз бүрийн аргаар орчуулах нь ихсэж байгаа бөгөөд орчуулгын чанар, үр дүн, зохиолынхоо сонголтыг анхааралгүй, зөвхөн мөнгө олохын тулд ‘гэрлийн хурдаар’ орчуулж байгаа нь учир дутагдалтай юм.

Аливаа орчуулга үнэн зөв байх зарчимд тулгуурладаг бөгөөд хүний бүтээлч үйл ажиллагаа, сэтгэн бодох болон мэргэжлийн ур чадварыг илэрхийлэн харуулдаг нарийн үйл явц юм. Орчуулгыг зөв агаад оновчтой хийхийн тулд хоёр хэлний хэлзүй, үгсийн сангийн утгыг сайн мэдэх нь чухал байдаг. Үгчлэх, хуулбарлах аргаас аль болох зайлсхийж, дүйлгэх, утгачлах, тайлбарлах аргуудыг түлхүү хэрэглэх нь орчуулгыг чанартай, оновчтой болоход тустай. Ялангуяа төрөл бус хэлүүд болох монгол англи хэлний тухайд үүнийг анхаарах ёстой бөгөөд англи хэлнээс монгол хэл руу мэргэжлийн нэр томьёо, үг хэллэгийг орчуулахдаа аливаа үгийг үгийн сангийн утгын талаас нь авч үзэх хэрэгтэй байдаг. Ер нь ямарч орчуулгад нийлэмж үгс, хоршоо үгс, өвөрмөц хэллэг, өгүүлбэрийн бүтэц зэргийг яг байгаа хэлбэрээр нь буулгавал, өөрөөр хэлбэл үгчилбэл алдаа хийх магадлал ихэсдэг. Аливаа бичгийн орчуулгыг сайн хийхийн тулд орчуулах гэж буй хоёр хэлнийхээ хэлзүйн дүрмийг сайн эзэмших, тухайн бичвэрийн өгүүлбэрүүд дэх тэмдэг, тэмдэглэгээг, тэдгээрийн өгүүлбэр дэх байрлал, үүргийг анхааралтай авч үзэх нь нь сайн орчуулга хийхэд тустай. Өгүүлбэр дэх цэг таслал бүр чухал. Мөн хоёр хэлний онцлог болон ялгаатай талууд, тэдгээр хэлээр яригчдын аж амьдралын хэв маягийг судалж мэдэх хэрэгтэй юм.

Орчуулагч нар орчуулж буй бүтээл, орчуулсан үг өгүүлбэр болгоноо сайтар хянаж, засаж байх нь чухал. Тэгэхдээ зөвхөн тухайн чиглэл мэргэжлийн хүнээр хянуулах биш, харин монгол хэлний багш, хэл шинжээч, хэлний мэргэжилтнүүд, зарим тохиолдолд утга зохиолын ажилтан, зохиолч яруу найрагчдаар хянуулахад ч илүүдэхгүй. Эс бөгөөс, өөрөөр хэлбэл, бичиж гаргаж байгаа ном бүтээл, гарын авлага сэлтээ сайтар нягтлан хянаж байхгүй бол монгол хэлийг эвдэж байгаа бас нэг бүлэг хүмүүс нь орчуулагчид өөрсдөө болчихож магад. Орчуулгыг хэл мэдэхгүй хүнд л зориулж хийдэг. Орчуулах чадамж нь орчуулагчийн чадварыг илтгэн харуулдаг.

Аман орчуулга хийх үед сэргэлэн овсгоотой байх чадвар нэн хэрэг болдог. Учир нь шууд орчуулж болохооргүй үг хэллэгүүдтэй их таардаг бөгөөд ялангуяа маш хэцүү асуудлыг хэлэлцэх, мэдээлэх үед хэлц үг, өвөрмөц хэллэгүүд, шинээр үүсэн бий болсон үг хэллэг, нэр томъёонууд гарч ирдэг. Түүнчлэн, тогтсон үг хэллэгийг орчуулах амаргүй байдаг. Хэлц үг, зүйр цэцэн үгс, онигоо, тоглоом шоглоом болгосон үг хэллэгүүдийг орчуулах нь хамгийн хэцүү. Барууны улс төрчид Библиээс ишлэл татах дуртай байдаг. Тэгтэл орчуулга хийж буй нэгэн нь Библийг мэдэхгүйгээр, огт уншиж үзээгүй байгаад орчуулбал инээдтэй, эвгүй байдалд орох нь олонтоо. Тиймээс бичгийн болоод аман орчуулга хийж буй орчуулагчдын аль алинд нь их унших чухал бөгөөд өргөн мэдлэг, уужуу ухаан, их чадвар дадал шаардлагатай байдаг.

Тиймд орчуулгыг чанартай сайн хийх чадамж нь орчуулагчийн хэлний, орчуулгын, мөн хувь хүний ерөнхий чадваруудаас хамаардаг байна. Өөрөөр хэлбэл орчуулга хэр чанартай, үнэн зөв, бүрэн гүйцэт, сайн болох эсэх нь орчуулга хийх чадамжийн гол эх сурвалж болох орчуулагчийн олон талт өргөн мэдлэг, судалгаа хийж уншдаг эсэх, мэргэжлийн болоод харилцааны ур чадвар, эв дүй, зан хандлага, сэтгэл зүй, хувийн бэлтгэл зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг ажээ. Дээр нь нэмээд орчин үеийн техник технологийг ашиглаж, компьютерийн ур чадварт суралцах нь чухал юм.

Ашигласан номын жагсаалт

1. В. И. Попов, “Орчин үеийн дипломат ажиллагаа: онол практикийн асуудал”., 2003
“TRANSLATOR’S CHARTER”, approved by the Congress at Dubrovnik in 1963, and amended in Oslo on July 9, 1994, The International Federation of Translators
Employment Outlook – 2019-2020 by the Bureau of Labor Statistics (BLS
Translation Skills: A Textbook by HASAN SAID GHAZALA, (Umm Al-Qura University, Makkah Al-Mukarramah), 2014

“МАРКО ПОЛОГИЙН АЯЛАЛ” БҮТЭЭЛИЙН ОРЧУУЛГЫН СТРАТЕГИД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Г.Бат-Учрал²⁹

В.И.Павлов³⁰

***Abstract:** Many foreign scientists and researchers have classified and defined the translation strategies in many different ways, and Mongolian translators and scientists have also proposed many versions of the definition. When translating any work, it is important to preserve the source text in the target language, taking into account the thoughts and positions of the author, without losing the content and meaning, and for this, the translator needs to use a large variety of strategies. This time, we have considered the assignment, classification, and use of translation strategies terms with examples of translation works. Analyzing the translation of “Travels of Marco Polo”, focusing mainly on the historical source, we aimed to analyze whether there are selective strategies, and how the meaning of the source text was captured by identifying the commonly used strategies of the translator.*

***Түлхүүр үг:** Марко Поло, орчуулах стратеги, орчуулах арга барил*

Удиртгал

Орчуулга судлал тусгай салбар шинжлэх ухаан болон хөгжиж эхэлснээс хойш “орчуулах стратеги” хэмээх нэр томъёоны тодорхойлолтын тухай маргаан эрдэмтэн судлаачдын дунд өнөөг хүртэл үргэлжилсээр байна. “Орчуулах стратеги” хэмээх нэр томъёог орчуулгын үйл явцыг тайлбарлахад хэрэглэдэг хэдий ч утга агуулгын нарийн ялгааг багтаасан, нэгдсэн тодорхойлолт одоо хүртэл гараагүй байна. “Орчуулах стратеги” хэмээх ойлголтыг нарийн тодорхойлохын тулд энэ маргаантай асуудалд хэл шинжээч нар хэрхэн ханддаг талаар үзье.

Гадаадын эрдэмтэн судлаачид “procedures, techniques, strategies, processes, strategic processes, rules, plans, method” зэрэг үгсийг ойролцоо утга санаа илэрхийлж буй хэмээн тодорхойлоод, тэдгээрээс өөрсдийнхөөрөө сонгон зохиол бүтээлдээ хэрэглэж

²⁹ МУИС, ШУС, ХУС, Европ судлалын тэнхим, ORCID: 0000-0003-1059-1089

³⁰ Ph.D, МУИС, ШУС, ХУС, Европ судлалын тэнхим, ORCID: 0009-0003-7288-7042

байна. Дээрх нэр томьёонууд харилцан адилгүй өнгө аяс илэрхийлэх хэдий ч стратеги хэмээх нэр томьёог орчуулга зүйн гэлтгүй олон салбарт өргөн хэрэглэж байна. Иймээс юуны түрүүнд нэр томьёоны асуудлыг тогтох нь зүйтэй юм.

Зарим судлаачид “стратеги” гэдэг нэр томьёог цэргийн салбараас сэтгэл судлалын салбарт, сэтгэл судлалын салбараас орчуулгын салбарт нэвтрэн орсон гэж үздэг. Орос хэлний нэвтэрхий толь бичигт “стратеги” хэмээх нэр томьёог ихэвчлэн цэргийн үйл ажиллагаатай холбон тайлбарладаг. Жишээлбэл, С.И.Ожеговын тайлбар тольд: “Стратеги: 1. Дайн тулааны шинжлэх ухаан, дайтах урлаг. Дайны стратегийн онол 2. Дайн, дайны ажиллагаа хийх ерөнхий төлөвлөгөө” (Ожегов, 1990) гэжээ. Түүнчлэн уг тольд “стратеги” хэмээх нэр томьёог “1. Нийгэм, улс төрийн тэмцлийг удирдахуй 2. Удирдахуйг төлөвлөх урлаг” гэж тодорхойлжээ. Ямар ч үйл ажиллагааг нөхцөл байдлыг нь харгалзан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг ба орчуулах үйл ч ялгаагүй юм.

Стратеги (strategy) хэмээх үг нь грек хэлний *stratēg(ós)* буюу цэрэг, *-ēgos* буюу удирдах хэмээх үгээс үүссэн бөгөөд орчин цагийн англи хэлнээ 1. Зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлэх сайтар төлөвлөсөн үйл ажиллагаа 2. Цэрэг, дайны үйл ажиллагаа төлөвлөх ур чадвар 3. Чадварлагаар төлөвлөх гэсэн утгатай гэжээ (Summers & Gadsby, 2003).

Хэл шинжлэл, гадаад хэлний боловсролын холбогдолтой зохиол бүтээлд манай эрдэмтэн судлаачид стратеги хэмээх нэр томьёог хэрхэн монгол хэлнээ буулгасныг авч үзэхэд, Э.Равдан “стратеги зорилт” (Равдан, 2012), Г.Буяннэмэх, Д.Сайнбилэгт, Ц.Дэлгэрэхцэцэг нар “стратеги, арга барил, арга зам” (Буяннэмэх, Сайнбилэгт, & Дэлгэрэхцэцэг, 2016), Ц.Бурмаа “арга барил” (Бурмаа, 2016), Дуглас Браун “стратеги” (Браун, 2014), Л.Алтанцэцэг, Ж.Дэлгэрмаа “стратеги” (Алтанцэцэг & Дэлгэрмаа, 2004), Ц.Чимэдлхам, Ч.Ганцэцэг “арга барил” (Чимэдлхам & Ганцэцэг, 2012) хэмээн монголчилж, эсвэл, зарим тохиолдолд галигчлан буулгасан байна.

Орчуулга зүйн салбарын гадаадын судлаачид стратеги гэх нэр томьёог дараах байдлаар тодорхойлоод байна. Үүнд:

- Сэтгэц хэл шинжлэл, танин мэдэхүйн үүднээс харахад стратеги гэдэг нь орчуулах үйлд шаардагдах ухамсарт болон ухамсаргүй өрнөх сэтгэцийн бүхий л үйл ажиллагаа юм (Seguinot, 1991).
- Бичвэрийг нэг хэлээс нөгөөд орчуулахад тулгарсан асуудлыг шийдвэрлэх ухамсарт үйл (Lorscher, 1991).
- Орчуулгын асуудлыг олж илрүүлэн, түүнийг шийдвэрлэхэд тохирох арга замыг ухамсартайгаар сонгон хэрэглэх үйл (Scott-Tennent, 2000).
- Сайн орчуулах арга барилд суралцах зам (Chesterman, 1997).

- Хэлний болон хэлний бус хэрэглүүр ашиглан ухамсартай болон ухамсаргүйгээр асуудлыг шийдвэрлэх үйл явц (Hurtado Albir, 2001).
- Утга санааг тодруулах, төвөггүй ухаж ойлгоход хэрэглэх арга техник (North & Enrica, 2021).
- Орчуулагчийн мэргэжлийн ёс зүйг харгалзан бичвэр орчуулахад чиглэсэн ухамсарт үйлийн алгоритм (Алексеева, 2008).
- Орчуулах үйлийн үндсэнд оршдог, орчуулагчийн өвөрмөц сэтгэхүй (Комиссаров, 2008)
- Орчуулах төлөвлөгөө бөгөөд тодорхой нөхцөлд тохируулан орчуулга хийх ерөнхий хандлага дээр бүрэлдэнэ” (Сдобников, 2011)

Манай эрдэмтэн судлаач, орчуулагчид зохиол бүтээлдээ арга, арга барил, арга зам, зарчим зэргээр тодорхойлж, олон дэд хэсэгт ангилдаг. Тэдний эдгээр хувилбар нь бичгийн орчуулгын тухайд түлхүү тохирох бөгөөд олон арга барилаас бичвэрийн агуулга, найруулга, өнгө аяс, үйл явдал өрнөж буй газар орчны нөхцөл байдал, зохиогчийн бодол санаа зэрэг олон хүчин зүйлийг харгалзан аль тохирохыг нь сонгон хэрэглэхэд шаардлагатай цаг хугацаагаа хангалттай зарцуулж болдог. Хэлмэрчлэхүй буюу аман орчуулгын үед дээр дурдсан олон хүчин зүйлийг харгалзан илүү бага хугацаанд, тохирох аргыг сонгож, хэл яриа болон бичвэрийн утга санааг бүрэн дүүрэн илэрхийлэх, хамгийн боломжит хувилбарыг сонгон нөгөө хэлнээ бага хугацаанд нэн даруй буулгах хэрэгтэй болдог. Иймд хэлний холбогдох олон салбарт стратеги гэх нэр томъёог орчуулалгүй хэрэглэж байгаа, мөн утга агуулгыг нь бүрэн дүүрэн илэрхийлэх монгол үг хэллэг хараахан хэвшиж тогтоогүй байгаа, монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичигт “стратеги” нь толгой үгээр багтсан (Болд & Пүрэвсүрэн, 2008) зэрэгт үндэслэн энэ удаад “стратеги”-ийг тэр хэвээр нь галиглан хэрэглэлээ. Орчуулах явцад, ялангуяа аман орчуулгын үед яриа болон бичвэрийг нөгөө хэлнээ цаг алдалгүй, оновчтой, зөв орчуулахад тохирох стратегийг сонгон авч хэрэглэх шаардлага гардаг. Энэ нь орчуулагчаас шаардах чухал чадвар юм. Стратегийг зарим тохиолдолд тактик ч гэж хэлж болох талтай юм. Учир нь тактик гэдэг нь стратегитай харьцуулбал харьцангуй богино хугацаанд шуурхай арга хэмжээ авах үйл юм.

Орчуулах стратегийн онолын үндэслэл нь нэлээд бүдгэрсэн, олон утга санаа илэрхийлсэн гэж үзэн хэрэглэхээс татгалзсан судлаачид ч байна. Учир нь уг нэр томъёог оновчтой тодорхойлоогүй, шинжлэх ухааны бус буюу ердийн ахуйн ойлголтыг илэрхийлдэг гэжээ. Энэ нь тус нэр томъёог англи хэлэнд ахуйн хүрээнд маш өргөнөөр хэрэглэдэгтэй холбоотой гэж үздэг. Гэсэн хэдий ч орчуулах стратегийн олон ангиллыг судлаачид боловсруулан хэрэглээнд нэвтрүүлсээр байна.

В.В.Сдобников “орчуулагчийн ерөнхий хандлагад суурилан орчуулах стратегийг 4 хэсгээс бүрдэнэ” гэж үзжээ. Үүнд:

1. Нөхцөл байдлыг таамаглах,
2. Орчуулах зорилгоо тодорхойлох,
3. Баримжаалах,
4. Төлөвлөх

Харин Г.Хениг, П.Куссмауль нар “Орчуулгын стратеги” бүтээлдээ стратеги хэмээх ойлголтыг “Зорилгодоо хүрэхийн тулд бидэнд орчуулгын асуудлыг шийдвэрлэх хамгийн боломжит замыг зааж өгөх орчуулах стратеги хэрэгтэй. Орчуулах стратеги нь бусад стратегийн адил баримт дээр тулгуурлах ёстой” гэж практик талаас нь авч үзсэн байна (Hönig, 1982).

Орчуулах стратегийн үндсийг “орчуулагч зориуд, эсвэл, санамсаргүйгээр баримталдаг зарчим” хэмээн тодорхойлоод, дор дурдсанчлан 5 ангилсан байна (Комиссаров, 2008). Үүнд:

1. Аливаа орчуулгын үйл явц юуны өмнө эх сэдвийг ойлгохоос эхлэх бөгөөд энэ нь орчуулгын зайлшгүй нөхцөл мөн.
2. Эхийн үгийг биш утга санааг хөрвүүлэх.
3. Орчуулгын сэдвийн агуулга дах утгын хувьд харьцангуй чухал, тийм ч чухал биш элементүүдийг ялгаатай авч үзэх.
4. Бүхлийн утга нь хэсгийн утгаас илүү чухал гэсэн санаагаар томъёологддог.
5. Орчуулга нь орчуулах хэлний хэм хэмжээнд бүрэн тохирч байх ёстой.

Европын олон хэлний суурь хөтөлбөр (ЕОХСХ)-г дурдсанаар орчуулах стратеги нь утга санааг тодруулж, хялбар ойлгуулахад ашигладаг арга техник юм. Иймд орчуулах (зуучлах) чадвар гэдэгт зөвхөн хэлний мэдлэг бус, харилцааны хязгаарлагдмал орчин нөхцөлд тохирох стратегийг сонгон хэрэглэх гэсэн утга агуулга мөн багтана. ЕОХСХ-г дурдсанчлан “нэг хэлнээ, аман болон дохионы хэл хооронд, нэг хэлээс нөгөөд орчуулах, хэлмэрчлэхэд орчуулагч нь утга санааг үнэн зөвөөр хүргэх зуучлагч гүүр болдог” (North & Enrica, 2021) хэмээгээд орчуулах стратегийг “шинэ ойлголт ухагдахууныг тайлбарлах стратеги”, “бичвэрийг хялбаршуулах стратеги” гэж хоёр ангилсан байна.

Хүснэгт 1. Орчуулах стратеги

Орчуулах стратеги				
Шинэ ойлголт ухагдахууныг тайлбарлах стратеги			Бичвэрийг хялбаршуулах стратеги	
Өмнөх мэдлэгтэй холбох	Хэлийг тааруулах	Төвөгтэй мэдээллийг тайлж задлах	Гүн утга агуулгатай бичвэрийг задалж дэлгэрүүлэх	Бичвэрийг оновчтой болгох
Харьцуулах, дүрслэх замаар шинэ мэдээ	Ойролцоо утгатай үгс, зүйрлэл, зэргийг	Нарийн төвөгтэй утга санааг хэсэгчлэн	Нэг мэдээлэлд багтсан олон агуулгыг ойлгоход төвөгтэй байдаг тул	Ерөнхий ойлголт, жишээ, нэмэлт мэдээлэл, эх сурвалжийг хасаж

мэдээллийг суурь мэдлэгтэй нь холбон тайлбарлах	ашиглан бичвэрийн хэл найруулга, хэв маягийг нөгөө хэлнээ тохируулан өөрчлөх	ангилж, хэсэг тус бүр хэрхэн нэгдмэл нэг ойлголтыг илэрхийлж байгааг харуулах	хэрэгтэй үндэслэл, тайлбар, ерөнхий агуулга, жишээ, нэмэлт мэдээлэл зэргээр эх сурвалжийг баяжуулах	бичвэрийг хураангуйлах буюу шаардлагагүй мэдээллийг хасаж үндсэн, гол утга санааг хүргэх. Гэвч, зарим чухал санааг тодруулах, нэгтгэн дүгнэх, харьцуулах зорилгоор эх сурвалжийг дахин ангилж, бүлэглэж болно.
---	--	---	---	--

Дээрх стратеги нь орчуулгыг зөв ойлгуулах арга зам буюу харилцааны стратеги гэж мөн хэлж болох юм. Дээр дурдсанчлан орчуулах стратегийг олон талаас нь дэлгэрүүлэн тодорхойлж болох бөгөөд нэгтгэн үзвэл “орчуулах, хэлмэрчлэхэд тулгарах асуудлыг шийдвэрлэх арга зам” гэж томъёолж болохоор байна.

Орчуулах стратеги

Орчуулах стратегийн үндсэн зарчмыг “орчуулга эх бичвэртэй хэлбэрийн хувьд адил биш ч дүйцлийн өндөр түвшнийг хангах аргуудыг хэрэглэх нь зүйтэй” гэж тодорхойлж болно (Комиссаров, 2008). Орчуулах стратеги гэдэгт дүйцүүлэн орчуулах, үгчлэн орчуулах, утгачлан орчуулах, тайлбарлан орчуулах, чөлөөт орчуулга, үг нэмэх, үг хасах, үг зээлэх гэх мэтчилэн орчуулгын боломжит бүх аргыг багтаан ойлгож болно. Орчуулгыг шууд болон шууд бус гэж ангилан дараах стратегид хуваасан байна (Walinski, Bogucki, Gozdz-Roszkowski, & Stalmaszczyk, 2015). Шууд орчуулга эх бичвэртэй илүү ойр байдаг бол, шууд бус орчуулга нь орчуулгын олон хувилбарыг дэвшүүлсэн онцлогтой байдаг.

Шууд орчуулга

Шууд орчуулгад ихэвчлэн бичвэрийг үг тус бүрээр орчуулах буюу үг зээлэх, дуурайлган буулгах, үгчлэн орчуулах зэргийг багтаасан байна (Walinski, Bogucki, Gozdz-Roszkowski, & Stalmaszczyk, 2015).

Үг зээлэх: Эх бичвэрийн агуулга, утга санаа уншигчдад шинэ буюу уншигчид тухайн сэдвийн талаар мэдлэг, мэдээлэл хомс тохиолдолд орчуулагч хамгийн хялбар стратеги болох үг зээлэх стратегийг голчлон хэрэглэдэг байна.

Дуурайлган буулгах: Дуурайлган буулгах нь бичвэрийн нэгж хэсэг бүрийг үгчлэн орчуулж, эх бичвэрийн хэлний тогтсон үг хэллэгийг тэр хэвээр нь зээлэн авч хэрэглэх стратеги бөгөөд үгийн санг дуурайлгах, өгүүлбэрийн бүтцийг дуурайлгах гэж ангилдаг байна.

Үгчлэн орчуулах: Бичвэрийн хэл найруулга, утга санааг бүрэн дүүрэн хөрвүүлэхийг үгчлэн орчуулах гэнэ (Walinski, Bogucki, Gozd-Roszkowski, & Stalmaszczyk, 2015). Молина, Албир нар бичвэрийг эх хэлээс бусад хэлнээ үг тус бүрээр орчуулахыг үгчлэн орчуулах гэнэ хэмээн тодорхойлжээ (Molina & Albir, 2002). Үгийг үгээр, өгүүлбэрийг өгүүлбэрээр гэхчлэн эх бичвэр муу байсан ч өөрчлөлгүй тэр хэвээр нь орчуулах ёстой гэжээ (Fang & Lu, 2012).

Шууд бус орчуулга

Шууд бус орчуулгад үг шилжүүлэх, үг өөрчлөх, дүйцүүлэх, тохируулах стратегиуд нь багтдаг байна (Walinski, Bogucki, Gozd-Roszkowski, & Stalmaszczyk, 2015).

Үг шилжүүлэх: Бичвэрийн утга санааг алдагдуулалгүйгээр үгсийн байрлал өөрчлөхийг үг шилжүүлэх стратеги гэнэ. Бичвэрийг хөрвүүлэн буулгаж буй хэлний үгсийн нийлэмжээс шалтгаалан үгийг эх бичвэрийнхтэй адил байрлуулах боломжгүй тохиолдолд хамгийн төстэй хувилбарыг сонгон хэрэглэнэ.

Үг өөрчлөх: Үг өөрчлөх стратеги нь хэлзүйн хувьд зөв хэдий ч алгуурхан бичвэрийн утгыг өөрчлөх талтай байдаг. Үгчлэх, үг шилжүүлэх стратегиар бичвэрийн агуулгыг бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүйд хүрвэл үг өөрчлөх стратегиар орчуулгын асуудлыг шийдвэрлэж болно.

Дүйцүүлэх: Дүйцүүлэх стратегийг заримдаа дахин томъёолох гэж нэрлэдэг бөгөөд эх бичвэрийнхээс огт өөр найруулга, аргазүйгээр тухайн бичвэрийн утга санааг хадгалан дүйцүүлэн орчуулахыг хэлнэ.

Тохируулах: Тохируулах стратеги гэдэг нь соёлын холбогдолтой үг хэллэгийг тохирох үгээр дүйлгэн орчуулахыг хэлнэ. Гүүрра тохируулах стратегийг “эх хэлний соёлын ойлголтыг нөгөө хэлнээ ижил утга илэрхийлэх төстэй нэр томъёогоор буулгах боломжит хувилбар” хэмээн тодорхойлсон байна (Guerra, 2012). Эх бичвэрийн агуулга хөрвүүлэн буулгаж буй хэлний нийгэм соёлд тохирохгүй үед уг стратегийг хэрэглэдэг бөгөөд орчуулагч дүйцүүлэн орчуулах шаардлага гарна. Тохируулах стратегийг ном зохиол болон киноны нэр орчуулахад түгээмэл хэрэглэдэг (Jarniewicz, 2000) бөгөөд өгүүлбэрийн бүтцээс гадна, салангид өгүүлбэр, параграф, бүлэг, эхэд бүхэлд нь

нөлөөлөх талтай тул аль болох хэрэглэхгүй байхыг зорьдог байна.

Шууд болон шууд бус орчуулгын дээр дурдсан олон стратегиас гадна, **ерөнхийлөх, тайлбарлах, нөхөх, өргөжүүлэх, чөлөөтэй орчуулах, үг зээлэх, үг нэмэх, үг орхих** гэх мэтчилэн олон стратегийг орчуулгын төрөл, онцлогоос шалтгаалан хэрэглэдэг бөгөөд энэ нь орчуулагчаас ихээхэн ур чадвар шаардсан ажил болно.

Орчуулагч орчуулж буй бүтээлийн төрөл, найруулга, бүтээлд дурдаж буй цаг үе зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан тохирох стратегийг сэлгэн хэрэглэдэг. Энэ удаа бид “Марко Пологийн аялал” бүтээлд орчуулах стратегийн дүн шинжилгээ хийж, зарим нэр томъёоны боломжит хувилбар байгаа эсэхийг судлахыг зорилоо. “Марко Пологийн аялал” (Рамузио, 2019) нь Венецийн Бүгд Найрамдах Улсын төрийн удирдлагын гишүүн Ж.Б.Рамузио (1485-1557)-гийн зохиосон хувилбар бөгөөд 70 гаруй бичмэлийг нэгтгэн дүгнэж гаргасан хувилбар юм. “Марко Пологийн аялал” ном нь тухайн цаг үе хүртэл дорно дахины талаарх европчуудын олж мэдэж чадаагүй олон мэдээ, мэдээллийг багтааснаас гадна, янз бүрийн хүсэл сонирхолтой уншигчдад өөрсдийн өнцгөөс харах боломж олгосноороо өмнөх аялагчдын тэмдэглэл, бүтээлээс илүү их амжилтад хүрч чадсан байна. Уг номыг тухайн үед дараах зорилгоор түлхүү сонирхон уншдаг байв. Үүнд:

1. Гайхамшгийн чуулган
2. Худалдаа наймааны заавар, зөвлөмж
3. Монголын эзэнт гүрэн, Хубилай хааны нигүүлсэнгүй зан чанар
4. Газарзүйн ном

Түүнчлэн “Марко Пологийн аялал” номын анхдагч хувилбаруудад дурдсан газарзүйн холбогдолтой мэдээллүүдийг 1375 оны Каталан Атлас (*Catalan Atlas*) болон Фра Маурогийн 1459 оны “Дэлхийн газрын зураг” (*Mapa Mundi*)-ийг хийхэд ашигласан байна. Алдарт аялагч Кристофор Колумб “Марко Пологийн аялал” номд хөтлөгдөж түүнд тэмдэглэгдсэн нутаг оронд хүрэхээр Хятад улсын зүг баруун талаар аялж байгаад Америк тивийг нээсэн бөгөөд түүний гар тэмдэглэлтэй Марко Пологийн номын хувилбар Испанийн Сэвил хотын номын санд хадгалагдаж байна.

Марко Поло худалдаачны гэр бүлд төрж өссөн тул аяллын туршид үзэж харсан олон гайхамшигтай зүйлсээс зарж худалдвал өндөр үнэд хүрч, ашиг хонжоо олж болохыг нь л голчлон тэмдэглэсэн байна. Түүний тэмдэглэлд түлхүү дурдсан эд зүйлсийг агуулгаар ангилан үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1. Эм, эмийн ургамал, халуун ногоо, хүнсний амтлагч
2. Идээ, ундаа
3. Ашигт малтмал, эрдэс бодис, чулуулаг
4. Үнэт чулуу, шүр сувд
5. Гар урлал

Уг бүтээлд ихэвчлэн усан үзмийн дарс гэж тохиох боловч нийт 8 төрлийн дарсны тухай дурдсан байна. Тэдгээр нь нутаг орноосоо шалтгаалан янз бүр, орц найрлагын хувьд харилцан адилгүй байсан хэдий ч бүгдийг дарс гэж тэмдэглэсэн байна. Түүнийг монгол хэлнээ буулгахдаа итали эхийг баримтлан дарс гэсэн нэг үгээр буюу үгчлэн орчуулсан байна.

Нэгдүгээр номын 13-р хэсэгт:

- *Тэр газар мөн ган, хүдрийн судлаар туйлын баялаг ажээ.*

Дээр гарсан хүдэр гэх үгийг нэгэн төрлийн **дорнын ган, энэтхэг ган** хэмээн бичжээ. Тухайн үед хүдрийг мэддэггүй байсан бөгөөд анх удаа хараад тэмдэглэж үлдээсэн нь тэр байжээ. Иймд тус өгүүлбэрийн утга санааг дуурайлган орчуулсан хэдий ч үг хэллэгийн хувьд дүйцүүлэх стратеги ашиглаж, нэмэлт тайлбар оруулсан байна.

Нэгдүгээр номын 47-р хэсэгт ааруул хэрхэн бэлддэг тухай дараах байдлаар тайлбарласныг тэр хэвээр нь буюу үгчлэн орчуулах стратеги ашигласан байна.

- *“Тэд өтгөрүүлэн хатаасан зуурмаг шиг сүү авч явдаг бөгөөд түүнийгээ дараах аргаар хатаадаг гэнэ. Сүүг хөөрүүлэхдээ дээр нь хөвөх өрөм тосыг хаман авч өөр саванд юулж цөцгий хийнэ. Цөцгийг нь авахгүй бол сүү хатдаггүй бөгөөд түүний дараа сүүг наранд тавин хатаах ажээ. Өглөө хүн бүр түүнээс ... авдаг. Түүнийгээ хөхүүр шиг арьсан туламд хийж хүссэн хэмжээгээрээ ус нэмнэ. Мориор давхих зуур тулам дахь сүү сэгсрэгдэн ундаа цийдэм шиг болдог аж. Энэ нь тэдэнд унд ч, хоол ч болдог.”*

Хоёрдугаар номын 14-р хэсэгт:

- *Мөн нутгийн халуун дулаан уур амьсгалд зохицсон охор зөөлөн үстэй, бахим бүдүүн эвэртэй том цагаан үхэр их байх ажээ. Тэд **сэрвээн дээрээ хоёр төв өндөр, том бөхтэй** бөгөөд харахад үнэхээр таатай бөлгөө.*

Тус номын 23-р хэсэгт:

- *[2] Катай даяар модны **нүүрс шиг ноцож, шатдаг нэгэн төрлийн хар чулуу** буй.*

Дээр дурдсаныг “сарлаг, нүүрс” гэхчлэн үгчлэн орчуулах **стратеги** ашигласан байна. Сарлаг, нүүрс зэрэг нь тухайн цаг үеийн европ хүнд анх удаа үзэж харсан, сонин содон зүйл байсан тул дүрсэлж бичих нь зүйн хэрэг юм.

Бүтээлийг орчуулахад шууд болон шууд бус стратегийг хослуулан ашигласан бөгөөд дуурайлгах, үгчлэн орчуулах, дүйцүүлэх, тохируулах стратегийг түлхүү хэрэглэсэн байна. Харин нөхөх, дэлгэрүүлэх, гадаад үг хэрэглэх стратегийг хэрэглээгүй бөгөөд найруулгын өнгө аясаас шалтгаалан үг нэмэх, орхих стратегийг мөн ашиглажээ.

Мөн үндэсний онцлог бүхий үг цөөнгүй гарсныг тухай бүрд нь зориулалт, хэлбэр хэмжээ, өнгө дүрсийг дэлгэрэнгүй тайлбарлан, өөрийн мэдэх зүйлтэй дүйлгэн бичсэн байна.

Орчуулах стратегид суралцахад цаг хугацаа, дадлага туршлага чухал хэдий ч, гадаад хэлд суралцаж эхэлсэн үеэс сурах стратегид зэрэг суралцаж ирсэн эсэх нь чухал юм. Сурах стратегид эртнээс суралцах нь орчуулах стратегийг сайжруулах эерэг талтай.

Дүгнэлт

- Орчуулгад ашигласан стратегийг тодруулах нь бүтээлийн гол утга санаа, агуулгыг нөгөө хэлнээ үнэн зөв буулгасан эсэхийг нягтлахад тустай.
- Ялангуяа түүхэн сурвалжийн орчуулгад ашигласан стратегийг нягталснаар бүтээлийн шинэчилсэн хувилбар болон бусад хувилбар гарахад тустай.
- Орчуулах стратегийн боломжит олон хувилбарыг хэрэглэх нь бүтээлийн утга санааг алдагдуулахгүй байх практик ач холбогдолтой.
- Нэг бүтээлийн олон хувилбарыг зэрэгцүүлж, орчуулах стратегийн судалгаанд дүн шинжилгээ хийх нь бүтээлийн чанарыг батлах, сайжруулах эрдэм шинжилгээний ач холбогдолтой.

Ном зүй

- Chesterman, A. (1997). *Memes of translation*. Amsterdam: John Benjamins.
- Fang, H., & L. W. (2012). Reconsidering Peter Newmark's theory on literal translation. *Theory and Practice in Language Studies*, 741-746.
- Ghazala, H. (1995). *Translation as problems and solutions: a textbook for university students and trainee translators*. Saudi Arabia.
- Ghazala, H. (2008). *Translation as Problems and Solutions*. Dar El-Ilm Lilmalayin.
- Guerra, A. F. (2012). Translation Culture: Problems, strategies and practical realities. *Journal of Literature, Culture and Literary Translation*, 1-27.
- Hönig, H. G. (1982). *Strategie der Übersetzung: Ein Lehrund Arbeitsbuch*. Tübingen: Narr.
- Hurtado Albir, A. (2001). *Traducción y traductología, introducción a la traductología*. Madrid.
- Jarniewicz, J. (2000). Przekład tytułu: między egzotyka a adaptacja. W. T. Kubinski O. Kubinska-Д, *Przekładając nieprzekładalne* (хуудсд. 477-483). Wydawnictwo Uniwersytetu Gdanskiego.
- Lorsch, W. (1991). Thinking-aloud as a method for collecting data on translation processes. S. Tirkkonen-Condit-Д, *Empirical research in translation and intercultural studies* (хуудсд. 67-77). Gunter Narr Verlag Tubingen.
- Molina, L., & A. A. (2002). Translation techniques revisited: a dynamic and functionalis approach. *Meta*, 498-512.
- North, B., & Enrica, P. (2021). *Common European Framework of Reference For Languages: Learning, Teaching, Assessment*. Strasbourg: Council of Europe Publishing.
- Schwarz, N., Husar D. B., & Stiegelbauer L. R. (2016). Translation problems and difficulties in applied translation processes. *Studii de Știință și Cultură*, 51-58.

- Scott-Tennent, C. G. (2000). *Translation strategies and translation solutions: Design of a teaching prototype and empirical study of its results*. Amsterdam: John Benjamins.
- Seguinot. (1991). A study of student translation strategies. S. Tirkkonen-Condit-Д, *Empirical research in translation and intercultural studies* (хуудсд. 79-88). Gunter Narr Verlag Tubingen.
- Serrat, O. (2017). *Knowledge Solutions*. Singapore: Springer.
- Summers, D., & Gadsby, A. (2003). *Longman Advanced American Dictionary*. Beijing: Foreign Language Teaching and Research Press.
- Walinski, J. T., Bogucki, L., Gozdz-Roszkowski, S., & Stalmaszczyk, P. (2015). Translation Procedures. *Ways to translation* (хуудсд. 55-67).-Д Lodz University Press.
- Yan M, N. S. (2011). The skopos theory and tourist material translation: With an analysis of Mt. Lushan translation. *Cross-Cultural Communication*, 53-61.
- Алексеева, И. С. (2008). *Онолын асуудлууд*.
- Алтанцэцэг, Л., & Дэлгэрмаа, Ж. (2004). *Боловсролын нэр томъёоны англи-монгол товч толь*. Улаанбаатар.
- Болд, Л., & Пүрэвсүрэн, Т. (2008). *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*. Улаанбаатар: Бэмби Сан.
- Браун, Д. (2014). *Хэл сурах сургах зарчим*. Улаанбаатар: Удам соёл хэвлэлийн газар.
- Бурмаа, Ц. (2016). *Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, Гадаад хэл*. Улаанбаатар.
- Буяннэмэх, Г., Сайнбилэгт, Д., & Дэлгэрэхцэцэг, Ц. (2016). *Англи-монгол хэлний боловсролын нэр томъёоны хэлхээс*. Улаанбаатар: Удам соёл хэвлэлийн газар.
- Комиссаров, В. Н. (2008). *Орчуулгын онол*. Улаанбаатар: ADMON Printing and Publishing.
- Ожегов, С. И. (1990). *Орос хэлний толь бичиг*.
- Равдан, Э. (2012). *Европын олон хэлний суурь хөтөлбөр: сурах, сургах, үнэлэх*. Улаанбаатар: Удам соёл хэвлэлийн газар.
- Рамузио, Ж. Б. (2019). *Марко Пологийн аялал*. Улаанбаатар.
- Сдобников, В. В. (2011). *Орчуулгын стратеги: ерөнхий тодорхойлт*.
- Чимэдлхам, Ц., & Ганцэцэг, Ч. (2012). *Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн X-XII ангийн төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж, хичээл: англи, орос хэл*. Улаанбаатар.

МОНГОЛ - СОЛОНГОС АЛБАН БИЧГИЙН ОРЧУУЛГЫН АСУУДАЛД

С.Энхчимэг³¹

***Abstract:** In globally, the demand for official documents is increasing, as more and more people are seeking both long-term and temporary immigration. There has been a lack of research on the translation of official documents between Mongolia and Korea, and intensive research on this matter will provide methods and techniques for translating official documents, and thus the quality of translation organizations and translators will improve.*

In official documents, the source material is monotonous and standardized, does not show personal expressions, and takes into account the high use of specific terms and advanced vocabulary. The usage of the "CAT tools" could be an advanced solution for saving time and money to translate those official documents.

Түлхүүр үг: Монгол – Солонгос албан бичиг, албан бичгийн төрөл, албан бичгийн орчуулга

1990 онд Монгол солонгос улс дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр улсын харилцаа тасралтгүй хөгжиж монголд солонгосын хөрөнгө оруулалттай төрийн болон төрийн бус олон албан байгууллага, компани, үйлчилгээний газрууд идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа төдийгүй монголд ирэх жуулчдын тоо нэмэгдсээр байна. Монголчуудын хувьд солонгос улсыг зорин суралцах, ажиллах, аялах, эмчлүүлэх хүсэлтэй хүмүүс ихэссээр байна. Тэдгээр албан байгууллага, хувь хүний үйл ажиллагаа нь албан бичгээр зохицуулагддаг тул эдгээр баримт бичгийг орчуулах шаардлага зайлшгүй гарч ирдэг. Энэхүү орчуулгын баримт бичгийг монголд солонгос хэлний баталгаат орчуулгын төвүүд хийдэг бөгөөд баталгаат орчуулга гэдэг нь монголын орчуулагчдын эвлэлээс албан ёсны эрх авсан бичиг баримтын орчуулгын үйлчилгээ үзүүлдэг орчуулгын товчоогоор орчуулагдсан тамга тэмдэг бүхий орчуулгыг хэлнэ. Үүнд тусгай мэргэшсэн орчуулагч байх хэрэгтэй бөгөөд уг орчуулагч нь орчуулгын олон мэргэжлийн салбарын талаар мэдлэг, чадвартай байхаас гадна албан бичгийн орчуулгын үндсэн ойлголт, ухагдахуун, арга техникийг эзэмшсэн байх хэрэгтэй. Уг судалгаагаар

³¹ Магистр, МУИС, ШУС, ХУС, Ази судлалын тэнхим

монгол-солонгос хэлний албан бичгийн тухай ойлголт, төрөл зүйлтэй танилцаж албан бичгийн орчуулгын аргын талаар авч үзлээ.

1. Албан бичгийн тухай ойлголт

Монгол улсын хөдөлмөрийн тухай хуульд албан бичиг, хэрэг нь баримт бичгээс үүсэлтэй бөгөөд түүнтэй салшгүй холбоотой. Баримт бичиг нь аливаа мэдээллийн цогц бөгөөд ямар нэгэн мэдээллээс ялгагдах гол онцлог нь тусгай бүрдлүүдийг агуулж, баримтжуулсан байдаг явдал гэж тодорхойлжээ. Иймд Бидний албан харилцаанд байнга хэрэглэгдэж байдаг, стандартад заасан тусгай бүрдлүүд бүхий баримтжуулсан мэдээллийг баримт бичиг гэнэ. Өөрөөр хэлбэл, аливаа мэдээллийг стандартад заасны дагуу зохих бүрдлүүдийг ашиглан, зааврын дагуу боловсруулж, албан ёсны болгох явцад, тэрхүү мэдээлэл нь баримт бичиг болон хувирдаг байна. Энэ нь нэг талаас ямар нэгэн мэдээллийг өөртөө хадгалж тээж байдаг материаллаг объект, нөгөө талаас аливаа материаллаг тээгчид хадгалагдаж буй мэдээлэл юм (Р.Бигэрмаа, 2020:8).

Солонгосын засгийн газраас гаргасан албан бичгийн тухай дүрэм журамд албан бичиг гэдэг нь засаг захиргааны байгууллагад ашигладаг өгүүлбэр, стандарт, төлөвлөгөөнд заасны дагуу боловсруулсан засаг захиргааны бичиг баримтыг хэлнэ гэжээ. Мөн Ким Жүнсон (2006:169) албан бичиг нь энгийн засаг захиргааны байгууллага, эсвэл, төрийн албан хаагчийн боловсруулсан бичиг баримтыг хэлдэг бөгөөд үүнээс гадна бусад бүх хувийн баримт бичгийг хэлнэ. Гэхдээ хувийн бичиг баримт гэдэг нь хувь хүний зорилгын төлөө бус зохион байгуулалт бүхий байгууллагын нийтийн зорилгын төлөө ажил хэрэг явуулахад боловсруулсан нэг төрлийн олон нийтийн баримт бичгийг хэлнэ гэж тодорхойлжээ.

Харилцагч байгууллага болон хүмүүсийн хооронд мэдээлэл солилцох, ажил хэргийн холбоо тогтоохын тулд хэрэглэж буй баримт бичгийг “Албан бичиг” гэдэг. Албан бичгээр харилцахгүйгээр төрийн болон төрийн бус ямар ч байгууллага, хувь хүний үйл ажиллагаа хэвийн явагдах боломжгүй юм. Иймд аливаа байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэг нь баримт бичиг боловсруулж, хөтлөх явдал бөгөөд үүгээрээ дамжуулан, тухайн байгууллагын удирдах, зохион байгуулах үүргээ хэрэгжүүлж байдаг. Өөрөөр хэлбэл удирдлагын үйл ажиллагааг баримтжуулах явдал нь албан хэрэг хөтлөлтийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Нөгөө талаас, баримт бичиг нь аливаа төрийн ба төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн хооронд мэдээлэл солилцох, асуудал дэвшүүлэх, шийдвэрлэх, дамжуулах зэрэг олон зорилгоор үүсэж, хөтлөгддөг харилцааны үүрэгтэй юм (Р.Бигэрмаа, 2020:9).

2. Албан бичгийн төрөл зүйл

Монгол улс албан бичгийн нэр төрөл, тодорхойлолт тэдгээрийг бүрдүүлдэг тавигдах шаардлага зохион байгуулалтын талаарх хэм хэмжээг 1989 онд эхлэн боловсруулж, баримт бичгийн албан ёсны стандартыг 1990 оноос албан ёсоор мөрдөж

эхэлжээ. Ингээд 1996 онд энэхүү стандартыг шинэчлэн боловсруулсан бөгөөд 1991, 1999, 2000, 2002, 2021 онд нэмэлт өөрчлөлт оруулж дахин хэвлэсэн байна.

Монгол улсын стандарт, хэмжил зүйн газраас баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт стандартыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн С/30 дугаар тушаалаар шинэчлэн баталжээ. Үүнд:

Удирдлагын үйл ажиллагааны явцад хөтлөх баримт бичгийг харилцан хамаарал, зориулалт, нэр төрлийн шинжээр нь дараах 3 төрөлд ангилна.

1. Захирамжийн бичиг баримт (8): Албан даалгавар, албан шаардлага, зарлиг, захирамж, тогтоол, тушаал, хууль, шийдвэр
2. Зохион байгуулалтын баримт бичиг (17): Акт (нотломж), албан бичиг, гэрээ(хэлцэл), дүгнэлт, дүрэм, журам, заавар, зөвлөмж, илгээлт, санал, санамж бичиг, тайлан, төлөвлөгөө, төсөл, удирдамж, хөтөлбөр, хурлын тэмдэглэл
3. Мэдээлэл-лавлагааны баримт бичиг (6): Илтгэл, илтгэх хуудас, мэдэгдэл, мэдээ, танилцуулга, тодорхойлолт

Солонгос улсад албан бичиг гэсэн нэр томъёо 1909 оны 9 сард байгууллагын стандартад албан бичиг бичих талаар журамласан байна. Гэхдээ 1912 онд бичиг баримт боловсруулах аргыг нарийвчилсан хууль дүрэм журмыг тогтоон гаргажээ. Үүнээс хойш хэд, хэдэн удаа шинэчлэгдэж сүүлд 2011 оны 12 сарын тогтоолын дагуу явж байна. Энэ хууль тогтоомжийн дагуу албан бичиг болон, хувийн бичиг баримт гэсэн 2 төрөлд ангилжээ. Үүнд:

1. Албан бичиг баримт
 - 1.1. Хуулийн бичиг баримт: Үндсэн хууль, хууль тогтоомж, ерөнхийлөгчийн зарлиг, ерөнхий сайдын захирамж, яамны шийдвэр, тогтоол, дүрэм журам
 - 1.2. Заавартай холбоотой бичиг баримт: Зөвлөмж, заавар, журам, тушаал
 - 1.3. Мэдэгдлийн бичиг баримт: Хуулийн зарлал, мэдэгдэл
 - 1.4. Хадгалах бичиг баримт: Албан бичиг хөтлөх, бүртгэл, хадгалах карт
 - 1.5. Иргэний өргөдөл, хүсэлт: Зөвшөөрөл, арга хэмжээ
 - 1.6. Энгийн бичиг баримт: Мэдэгдэл, тайлан
2. Хувийн бичиг баримт
 - 2.1. Худалдааны бичиг баримт: Мэдүүлэг, зөвшөөрөл, хүсэлт, татгалзах бичиг, шаардах хуудас, мэдүүлэх бичиг, захиалгын бичиг, хүсэлт, лавлагаа, хүлцэл өчсөн бичиг, шаардах хуудас, танилцуулга, зааварчилгаа, мэндчилгээ, эсэргүүцлийн бичиг, анхааруулга, гэрээ
 - 2.2. Хувийн бичиг баримт: Танилцуулга, баярын бичиг, эмгэнэлийн бичиг, зааварчилгаа, урилга, мэндчилгээ, талархлын бичиг
 - 2.3. Компанийн тайлангийн бичиг баримт: Өдрийн тайлан, сарын тайлан, оролцох тайлан, ажлын тайлан

- 2.4. Компанийн дамжуулах бичиг баримт: Зарлал, дамжуулж үзэх баримт бичиг, мэдүүлэх бичиг, зааварчилгаа, лавлагаа, хариултын бичиг, хүсэлт, тэмдэглэл
- 2.5. Төсөл, төлөвлөгөө: Батлах хүсэлт, санал төлөвлөгөөний баримт, төлөвлөгөө, төсөл
- 2.6. Гэрээ
- 2.7. Компани үүсгэн байгуулах бичиг баримт
- 2.8. Бусад компанийн бичиг баримт

3. Албан бичгийн орчуулгын арга

Албан бичгийн орчуулгын талаар Р.Гүрбазар (1996:16) нийгэм, улс төрийн зохиол бүтээлд загварчлалын ерөнхий маягтай байдаг учир энэ төрөл зүйлд үе үеийн турш тогтсон хатуу стандартчилал бүр хэвшсэн байдгаараа ялгаатай гэж үзэн дараах онцлогийг дурджээ.

- Найруулгын өнгө аяс, зохилдлого их нягт, хэлний хэмнэлийн зарчим, логик дарааллыг сүрхий шаарддаг.
- Эх хэрэглэгдэхүүн нь нэг хэвийн стандартчилсан маягтай байдаг учир энэ төрлийн зохиол бүтээлийн орчуулгад гаршсан орчуулагчдад бэрхшээл бага тохиолддог.
- Өөрийн тодорхой нэр томъёо, нэрийн цогц их хэрэглэдэг.
- Нийгэм-улс төрийнх шиг “үндсэн дээр”, “зорилгоор” гэх мэт нэрээс үүссэн угтвар, дагавар”-тай холбогдон, уялдан, ачаар” зэрэг бүрэлдэл холбоос үгсийг түгээмэл хэрэглэдэг.
- Ерөнхий бичлэгийн аяс хүүрнэлийн шинжтэй байх боловч угсруулан тоочих арга зонхилдог.
- Дипломат албан баримт, хууль эрхийн актад өгүүлбэрийн үгийн шууд дэс дараалал чухал үүрэгтэй.
- Хүний сэтгэлийн хөдлөлийн өнгө аяс бараг илэрдэггүй.

Баримт бичиг нь хэлбэрийн хувьд тогтсон (nuts-and-bolt type documents) байдаг тул орчуулах өнгө аясаас илүү оновчтой орчуулах хэрэгтэй байдаг. Албан бичгийн орчуулах эх хэрэв хуулийн хүчин төгөлдөр бичиг баримт бол эх хувь алдаатай байсан ч алдааг хэвээр нь орчуулах шаардлагатай (Frame, 1986: 25; Taibi & Ozolins, 2016: 89). Гэхдээ бүх төрлийн хуулийн бичиг баримт тогтсон хатуу дүрэмтэй биш, хуулийн хүчин төгөлдөр байдлаас хамаараад орчуулгын арга техник өөр болж болно гэж үзжээ (Šarčević, 1997; Prieto Ramos, 2002; Mayoral Asensio, 2000, 2003). Албан бичгийг орчуулахад ашиглаж болох арга техник, хэрэгслийн талаар дараах саналыг дэвшүүлж байна.

- 1) Дээр дурдсан монгол-солонгос хоёр улсын албан бичгийн орчуулгын төрлүүдтэй танилцаж албан бичиг баримтын сан бүрдүүлэх. Ингэснээр хоёр

орны албан бичгийн үг хэллэг, хэлбэрийг харьцуулж орчуулахад дөхөм болно.

- 2) “CAT tool” ашиглах. Computer – Assisted Translation үгийн товчлол болох CAT Tool нь орчуулгад тусалдаг компьютерын программ юм. CAT Tool-ын хамгийн гол онцлог нь ТМ(Translation Memory) буюу орчуулах эх болон орчуулсан эхийг хамтад нь хадгалаад дата баазыг үүсгэдэг. Ингэснээр дахин шинэ текстийг орчуулах үед хадгалагдсан орчуулах эхтэй ижил төстэй өгүүлбэрийг автоматаар илрүүлж орчуулгад тусалж өгдөг. Мөн албан бичгийн хэлбэрт оруулж эхийг хэвлэхэд бэлэн болгодог. Албан бичгийн орчуулгын хувьд ихэвчлэн нэг загварыг олон удаа ашиглах тохиолдол их гардаг учраас CAT Tool ашигласнаар цаг хугацаа, эдийн засгийн хувьд хэмнэлттэй юм.
- 3) Сүүлийн үед албан бичиг нь гадаадад оршин суух иргэдийн биеийн байцаалт, тодорхойлолт, эрхийн үнэмлэх, гэрчилгээтэй холбоотой олон янзын баримт бичгийг орчуулах хэрэгцээ их гарч байгаа учраас, харилцаанд тулгуурласан орчуулгын нэг төрлөөр авч үзэж байна (Юү Жонжү, 2017: 47). Харилцаанд тулгуурласан орчуулга нь олон нийтийн байгууллага болон ихэвчлэн хэлний хангалттай мэдлэгтэй биш хүмүүс хоорондын харилцааг зохицуулдаг текстийг орчуулах арга юм.
- 4) Монголоос солонгос хэл рүү орчуулах үед дараах орчуулгын илэрхийллийг анхаарах.
 - Нэр үгээр хэт их илэрхийлэхгүй байх. **적극** 뒷받침하기 위해 – **적극적으로** 뒷받침하기 위해
 - Орчуулгын өнгө аястай илэрхийллээс зайлсхийх. 선정된 점포에 대해서는 → 선정된 **점포에는**
 - Гадаад үг хэллэгээс зайлсхийх. 힐링 → 치유 / 인프라 → 기반 시설 / 매뉴얼 → 지침
 - Ханзны хэцүү үг хэллэгийн оронд энгийн хялбар илэрхийллийг ашиглах. 제고하기 → 높이기 / 내수진작과 → 국내 수요를 높이고
 - Захирангуй үг хэллэг хэрэглэхгүй байх. 장관은 ~라며 치하했다. → 장관은 ~라고 말했다. 작성할 것 → 작성해 주십시오. 제출바람 → 제출해 주십시오.

Дүгнэлт

Дэлхий даяар гадаад оронд урт хугацаагаар болон түр хугацаагаар оршин суух иргэдийн тоо ихсэж байгаа холбоотойгоор албан бичгийн орчуулгын хэрэгцээ ихсэж байна. Одоогоор монгол-солонгос хоёр улсын албан бичгийн орчуулгын талаар судалгаа тийм ч их судлагдаагүй байгаа бөгөөд энэ талаарх судалгаа эрчимтэй хийгдсэнээр албан бичгийн орчуулгын арга, техниктэй болж, улмаар орчуулгын үйл ажиллагаа явуулдаг байгууллага, орчуулагчийн чанар сайжирна.

Орчуулагч бол зөвхөн орчуулга хийж байгаа хэлний хэрэглэгдэхүүн төдийгүй орчуулгад оролцож байгаа эх хэл, орчуулга хийж байгаа хэл хоёрын аль алины хуулийг бүрэн эзэмшсэн байх шаардлагатай (Р.Гүрбазар, 1996:6). Албан бичиг нь харилцагч байгууллага болон хүмүүсийн хооронд мэдээлэл солилцох, ажил хэргийн холбоо тогтоохын тулд хэрэглэж буй баримт бичиг юм. Монгол албан бичгийн төрлийн хувьд захирамжийн бичиг баримт, зохион байгуулалтын баримт бичиг, мэдээлэл-лавлагааны баримт бичиг гэсэн үндсэн гурван хэсгээр ангилдаг бол солонгос албан бичгийг албаны бичиг баримт, хувийн бичиг баримт гэж ерөнхийд нь ангилан авч үзжээ.

Албан бичиг нь эх хэрэглэгдэхүүн нь нэг хэвийн стандартчилсан маягтай байдаг, хүний сэтгэлийн хөдлөлийн өнгө аяс бараг илэрдэггүй, өөрийн тодорхой нэр томъёо, нэрийн цогц их хэрэглэдэг байдлыг харгалзан албан бичгийг орчуулахад “CAT tool” ашиглах нь сүүлийн үеийн цаг хугацаа, эдийн засгийг хэмнэх арга техник болох юм.

Номзүй

- Бигэрмаа. Р(2020), Баримт бичиг боловсруулах арга зүй, түүний найруулга, УБ. Гүрбазар. Р(1996), Орчуулгын онол, дадлагын үндэс, УБ, Отгонтэнгэр Дээд Сургууль.
- Taibi, Mustapha and Uldis Ozolins(2016), Community Translation, Bloomsbury Academic.
- 김준선(2006), 외국인의 한글공부를 위한 한국어작문, Hakmun publishing.
- 유정주(2017), 다문화사회이 공문서 번역 전략 – 민원서식 한영 번역을 중심으로-, 중앙대학교 문화콘텐츠기술연구원, 다문화콘텐츠연구, 2017, Vol.25 (41-75).
- <https://estandard.gov.mn/standard/v/410>
- <https://www.law.go.kr/LSW/lsEfInfoP.do?lsiSeq=119646#>

ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ
СУДЛАЛ

Л.Н.ТОЛСТОЙН НЭГЭН ЗОХИОЛЫН ОРЧУУЛГЫН ТУХАЙ

Д.Бүрнээ³²

***Товч агуулга:** Дэлхийн сонгодог зохиолын тоонд багтдаг оросын зохиолч Л.Н.Толстойн (1828-1910) 1886 онд хэвлүүлсэн “Смерть Ивана Ильича” гэдэг туужийн монгол орчуулга 2015 онд “Иван Ильичийн үхэл” нэртэйгээр хэвлэгдэж, монгол уншигчдын хүртээл болсон билээ. Тус орчуулгын зарим ойлгомжгүй өгүүлбэр, найруулгыг орос эхтэй тулгаж, мэргэжлийн орчуулагчийн ямар чадвар дутсанаас зарим нэг алдаа гарсныг энэхүү өгүүлэлд тайлбарлахын сацуу хэл найруулгыг сайжруулах талаар саналаа хэлсэн болно.*

***Түлхүүр үг:** Орчуулга, эх зохиол, орчуулах чадвар, хэлний чадвар, орчуулгын хэл найруулга*

Оросын алдарт зохиолч Л.Н.Толстойн (1828-1910) зохиол бүтээл дэлхийн олон хэлнээ орчуулагдсан билээ. “Дайн ба энх”, “Анна Каренина”, “Сэхээрэл” зэрэг роман, тууж өгүүллэг нь дэлхийн сонгодог уран зохиолын сан хөмрөгт хүндтэй байр суурийг эзэлдэг. Түүний бүтээлийн дотор 1882-1886 онд бичсэн “Иван Ильичийн үхэл” тууж их нэртэй. Гүн ухаан, сэтгэлзүйн тууж гэж үздэг тус бүтээлийг эрхэм нандин бүтээл болсон гэж судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг. Тус зохиолыг монгол хэлнээ 2015 онд орчуулж, энэхүү алдартай зохиолтой манай уншигчдыг танилцуулсан нь тэмдэглүүштэй чухал үйл явдал болсон юм. Тус зохиолыг орчуулах нь орчуулагчаас ихээхэн зориг тэвчээр, хөдөлмөр шаардсан ажил байсан нь ойлгомжтой. Аливаа орчуулгыг өөлөхөд амархан. Сайн буюу муу, утгачилсан буюу үгчилсэн орчуулга гэж дүгнэхэд амархан. Гагцхүү баримтат түшиглэж орчуулгын чанарын тухай авч үзэх нь үнэн зөв дүгнэлт болох болов уу. Манай ахмад үеийн нэртэй орчуулагчдын уран зохиолын олон сайхан орчуулга уламжилж ирснээс гадна орчуулгын бас үнэтэй олон шүүмж байдгийг бид мэднэ. Эдгээр шүүмж нь орчуулгын алдаа дутагдлыг сайжруулахад чухал

³² Доктор, профессор, МУИС, ШУС, ХУС-ын МХХШТэнхим

үүрэг гүйцэтгэж ирсэн тул тэдгээр шүүмжийг байнга уншиж, суралцаж байгууштай гэж боддог.

Өнөө үед улс орнуудын хоорондын харилцаа өргөжин тэлэхийн хэрээр орчуулгын ажилд тавих анхаарал, орчуулгын чанарыг сайжруулахад ихээхэн анхаарах болжээ. Орчуулгын чанартай холбоотой орчуулах чадвар (translation competence) гэдэг нэр томъёог орчуулга судлалд их хэрэглэж байна. Н.В.Комиссаров мэргэжлийн орчуулагчийн чадвар (профессиональная переводческая компетенция) гэдэгт хэлний чадвар, эхийг найруулах чадвар, харилцааны чадвар, мэргэжлийн техникийн чадвар, хувь хүний шинж чанар гэсэн таван зүйлийн чадварыг багтаажээ (2001:326). М.В.Вербицкая, М.В.Соловов нар (2010:10-11) орчуулах чадварыг ангилсан 16 ангиллыг харьцуулан үзэж, адил төстэй болон онцлог ялгааг нь харьцуулан дүгнэжээ. Эдгээр ангиллаас харвал “хэлний чадварт” “хэлний тогтолцоо, хэм хэмжээ, үүрэг, үгийн сангийн бүрэлдэхүүн болон хэлний зүйн байгуулал, хэлний нэгжийг ашиглаж хэл, ярианд ашиглах чадвар” багтана гэж үзжээ. Түүнээс гадна “эхийг найруулах чадвар” гэдэгт тухайн хэлний дүрэм журмын дагуу бүх төрлийн эхийг найруулах чадварыг багтааж үзжээ. Оросын хоёр судлаачийн “орчуулах чадвар”-ыг хэрхэн ангилан хуваасан байдлыг авч үзвэл орчуулах чадварт “хэлний чадвар” энэ тэргүүн чухал үүрэгтэй байна. Энэ нь зүй ёсны хэрэг. Учир нь орчуулгыг хэлнээс ангид авч үзэх боломжгүй. Тэгэхээр орчуулагчийн эх хэлний болон гадаад хэлний мэдлэг сайн байх, хэлний бүх түвшинд хоёр хэлийг эн тэнцүү эзэмшсэн байх явдал чухал байна.

Орчуулгын явцад өөр өөр хэлээр бүхий тодорхой эхүүдийг хооронд нь харгуулж байдаг тул орчуулга судлалд зэрэгцүүлэн шинжлэх арга голлох үүрэгтэй. Эхүүдийг зэрэгцүүлэн судлах нь орчуулгын талаар мэдээлэл олж авах чухал эх сурвалж болно. Орчуулгыг эх зохиолтой зэрэгцүүлэн шинжлэх нь эх зохиол болон орчуулга хоёр агуулга, бүтцийн талаараа хэр зэрэг ойр буй тухай, хэл найруулгын ялгаа зөрөөг ажиглах боломж өгдөг. (Комиссаров, 2001:34)

Орчуулгын нэгжийг судлаачид нэг зүйл эх (текст) гэж үздэг. Хэллэгийг (высказывание) эхийн бага нэгж гэж үздэг бөгөөд энэ нь уламжлалт нэршлээр өгүүлбэртэй дүйх ойлголт боловч өгүүлбэрээс өргөн утгатай. Хэллэг бол үг, энгийн өгүүлбэр, хэд хэдэн өгүүлбэрийн нийлбэртэй ч тэнцэх ойлголт бөгөөд түүний үндэс нь суурь өгүүлбэр болно (Папина, 2004:14). Бид энэхүү шүүмждээ “Иван Ильичийн үхэл” өгүүллэгийн орчуулгыг авч үзэхдээ “эх зохиолын агуулга орчуулгад бүрэн хэмжээгээр буудаггүй. Эх зохиол, орчуулга хоёрын агуулга эн тэнцүү (эквивалент) байх боломжгүй. Эх зохиол, орчуулга хоёрын агуулга хэдий чинээ ойр байсан ч утгын зарим нэгж орхигдож байдаг” (Комиссаров, 2001:63) гэдгийг удирдлага болгосон билээ.

Орчуулга, эх зохиол хоёрын агуулга эн тэнцүү байх боломжгүй боловч утгаас хазайх учиргүй гэдгийг анхаарах учиртай. Орчуулгад тавих үндсэн шаардлага бол орчуулга эх зохиолын утгыг үнэн зөв буулгасан байх явдал юм.

Бидний авч үзэж буй зохиолд Иван Ильич хэмээх шүүхийн танхимын гишүүний амьдрал, үхлийн тухай өгүүлнэ. Тэр бээр 45 насандаа эдгэршгүй хүнд өвчин тусаж, үхэх өдрөө хүлээж байхдаа туулж өнгөрүүлсэн амьдралаа, хүүхэд нас, идэр нас, хэрхэн сургуульд суралцсан, ажилд орсон, албан тушаал ахисан, гэр бүл болсон, эцэст нь хүнд өвчин тусаж үхлийн ирмэг дээр ирснээ эргэцүүлэн боддог. Түүний хэрхэн өвдөн шаналж буйг, үхлийг хүлээж авч чадахгүй айн балмагдаж буйг энэхүү зохиолд хурц тод дүрслэн харуулна. Түүнчлэн эргэн тойрны хүмүүс, гэр бүл үр хүүхэд нь хэрхэн хандаж буй, ерөөс хүний мөн чанар, дотоод сэтгэлийн зөрчил тэмцлийг ил тод нээн дүрсэлжээ. Уг зохиол сэтгэл зүй, гүн ухааны сэтгэмжээр бичсэн дэлхийн сонгодог зохиолд тооцогддог.

Монсудар хэвлэлийн газар, РЗ радио хамтран "Номонд багтсан ертөнц" цуврал нэвтрүүлгийн эхний дугаарт Оросын алдарт зохиолч Лев Толстойн "Иван Ильичийн үхэл" зохиолыг бүрэн эхээр нь нэвтрүүлжээ. Тус номын хэлэлцүүлгийг 2017-2021 онд зохион байгуулж, орчуулгын pdf файлыг цахимаар байршуулж, нийт уншигчдын хүртээл болгосон байна. Уншигчид тус орчуулгыг уншиж, сэтгэгдлээ бас цахимаар бичсэн зэргээс харвал манай уншигчид тус зохиолыг талархан хүлээж авсан нь харагдаж байгаа юм. Гэсэн хэдий ч энэхүү орчуулгын дотор ойлгомжгүй үг өгүүлбэр тааралдаж байсан тул бид орос эхтэй тулгаж, засаж залруулахыг зорьсон юм.

Бид тус орчуулга, эх зохиол хоёрыг харьцуулж, зарим утгаас хазайсан зүйл байгааг олж ажигласан болно.

1. *А я так и не был у него с самых праздников. Все собирался.* Энэ өгүүлбэрийг *Би харин тэднийд баяраас хойш очоогүй. Тэгэхэд бүгд цугларсан байсан* гэж орчуулжээ. Тус өгүүлбэр “очих гэж завдсаар байгаад амжсангүй” гэсэн санаатай бөгөөд *бүгд цугларсан байсан* (2015, 7) гэж буруу орчуулсан нь *Все собирался* гэсэн өгүүлбэрийг ойлгоогүйтэй холбоотой буюу “собираться” гэсэн үйл үгийн салаа утгыг нягтлаагүйтэй холбоотой. Тус өгүүлбэрийг англи хэлнээ *I always meant to go* гэж зөв орчуулснаас ч үзсэн монгол орчуулга ташаа орчуулга болохыг харж болох юм.
2. *Да, надо будет поехать.* Тус өгүүлбэрийг *Тийм дээ, түүн рүү очих хэрэгтэй болох нь* (2015:7) гэж орчуулсан нь оносонгүй. Учир нь Иван Ильичийн ажлын хамт олон түүнийг нас барсныг сонин хэвлэлээс олж мэдээд, удаан хугацаагаар өвчтэй байсан тухай ярилцаж байгаад эхнэрийнх нь тухай, эхнэр нь хэдий чинээ хөрөнгө чинээтэй болох тухай ярианы өөр сэдэв рүү орсноо эргэж үндсэн сэдэв буюу талийгчийн тухай яриа руу

эргэж орж буй тухай хэсэг бөгөөд “да” гэсэн нь ямар нэг зүйлийн талаар санал нийлж, түүнийг хүлээн зөвшөөрсөн утгаар бус, харин өмнө ярьж байсан сэдэв рүүгээ эргэн орсон буюу “за тэгэхээр бид очих хэрэгтэй болох нь” гэж байна. “Да” хэмээх үгийн салаа утгаас ч харсан үүнийг мэдэж болно.

3. *В последние дни он ужасно страдал. – Очень страдал? – спросил Петр Иванович. Энэ өгүүлбэрийг Сүүлийн хэдэн өдөр нөхөр маань маш их шаналсан. – Тэгсэн гэж үү?* (2015:14) гэж орчуулжээ. Энэ өгүүлбэрт талийгчийн эхнэр нь нөхрөө хүнд өвчтэй байсан тухай ярьж буй хэсэг бөгөөд нөхрөө их зовож шаналсан тухай ярихад Иван Ильичийн найз болох Петр Иванович түүнийг сонсоод “Их зовсон уу” гэж лавлаж асуусныг “Тэгсэн гэж үү” гэж эргэлзэж тээнэгэлзсэн байдлаар орчуулсан нь бас оновчгүй болжээ. Англиар *He suffered terribly the last few days. “Did he?” said Peter Ivanovich* гэж зөв орчуулсан байна.
4. *Одна точка светлая там, назади, в начале жизни, а потом все чернее и чернее и все быстрее и быстрее. «Обратно пропорционально квадратам расстояний от смерти», – подумал Иван Ильич. Энэ өгүүлбэрт Л.Н.Толстой хүний амьдралын эхэн үе гэрэл гэгээтэй байх бөгөөд хойшлох тусам бараан болдог гэдгийг физикийн хуулиар жишиж хэлсэн байна. Монгол орчуулгад *Тэртээ алсад, амь амьдралынх нь бүр эхэнд нэг том гэгээн цэг байх бөгөөд наашлах тусам бүгд улам хар бараан, улам хурдан түргэн болох ажээ. “Үхлээс ангид зай квадратад урвуу харьцаатай юм байна” гэж И.И. бодов* (2015:95). Энэ өгүүлбэрийг “үхэл хүртэлх зайд тэрхүү гэрэлт цэг квадратад урвуу харьцаатай юм байна” гэж орчуулсан бол ойлгомжтой болох байсан гэж бодож байна. Учир нь зохиолч тус өгүүлбэрт аливаа биет юм гэрлээс холдоход тусгалын талбай томорч гэрлээс холдохын хэрээр бүдгэрдэг гэрлийн хуулийг эш татахдаа гэрэлт цэг буюу хүний амь амьдрал хэдий чинээ үхэл рүү ойртох тусам бараан болж байдагтай зүйрлэн хэлсэн бололтой.*

Орчуулах явцад зайлшгүй үгсийн сан болон хэлний зүйн хувиргал хийх шаардлага тулгардаг. Үг нэмэх, хасах явдал бишгүй тохиолдоно. Гэхдээ үүний хэр хэмжээг тааруулахгүй бол найруулгыг сулруулж байдаг. Тухайлбал, бидний авч үзэж буй орчуулгад үг илүүдсэн тохиолдол цөөнгүй тааралдлаа. Зарим жишээг авч үзье.

1. *Сел на оттоманку* гэсэн өгүүлбэрийг *Зөөлөн буйдан дээрээ суун туслаа* (2015:58) гэж орчуулсан байна. Энэ өгүүлбэрт “туслах” гэдэг үг илүүджээ.
2. *Герасим сделал это. Опять поднял ноги и положил* гэсэн өгүүлбэрийг *Герасим хэлснийх нь дагуу хийн, хоёр хөлийг нь дээш өргөөд тавилаа*

(2015:72). Зүй нь “Герасим хэлснээр нь хоёр хөлийг нь өргөж тавив” гэж орчуулмаар байна. Энд “дагуу хийн, дээш” зэрэг үг илүүджээ.

3. *Герасим, без усилия и как будто не нажимая, свел его, почти неся, к дивану и посадил* гэснийг монгол орчуулгад *Герасим өчүүхэн ч түүртсэн юмгүй, хүрч байгаа эсэх нь мэдэгдэхгүй шахам, бараг гар дээрээ бүрэн тэвэрсээр буйдан дээр суулгалаа* гэжээ (2015:71). Энд зурсан үг илүүдсэн гэж бодож байна. Зүй нь: бараг өргөх шахам диван руу нь хүргэж суулгав гэж орчуулах саналтай байна.

Орчуулгын хэл найруулга эх зохиолоос бүрэн хамаарч байдаг. Тухайн эх зохиолын найруулгын өнгө аясыг мэдэрч орчуулах нь орчуулагчаас их ур чадвар шаарддаг гэж боддог. Өөрөөр хэлбэл, орчуулагч хүн зохиолдоо орж, зохиолын гүн нарийн утга, өнгө аясыг мэдэрч байх нь орчуулга амжилттай болохын нэг үндэс юм. Бидний авч үзэж буй орчуулгын найруулгад хүч нэмж орчуулсан зүйл цөөнгүй тааралдаж байна. Зохиолчийн санааг дэвэргэж, хүч оруулж найруулах нь оновчтой биш. Зарим жишээ авч үзье. Тус зохиолын гол дүр болох Иван Ильичийн бэлэвсэн эхнэр нөхрийнхөө ихэд зовж шаналж өөд болсон тухай яриад нулимс унагаж “нусаа арчсан” (орос эхэд: высморкалась) гэснийг орчуулагч “нус нулимстайгаа ноцолдож” (2015:16), Иван Ильич эмчид үзүүлж ирээд арай ядан ор луугаа очиж “дэрэн дээрээ сулбайж унасан” (орос эхэд: повалился назад на подушку) гэснийг “дэрэн дээрээ гэдрэг савж уналаа” (2015:61) гэх зэрэг орчуулсан байна.

Орчуулах явцад үг нэмэх тохиолдол гарах боловч үг нэмснээр эх зохиолын утга санаа найруулгыг өөрчилж буй эсэхийг анхаарах ёстой. Хэрэв зохиолчийн хэлэх гэсэн санааг гуйвуулж өөрчилж байвал үг нэмсэн нь оновчгүй болсныг илтгэнэ. Тухайлбал:

С рождением ребенка, попытками кормления и различными неудачами при этом, с болезнями действительными и воображаемыми ребенка и матери, в которых от Ивана Ильича требовалось участие, но в которых он ничего не мог понять, потребность для Ивана Ильича выгородить себе мир вне семьи стала еще более настоятельна гэсэн өгүүлбэрийг *Хүүхэд төрж, хооллох гэж оролдон элдвээр бүтэлгүйтэж, эх хүүхэд хоёр үнэн худал өвдөж, тэр болгонд шинэ аав учраа олохгүй, ямар ч нэмэргүй атлаа байнга оролцож байх шаардлагатай болсон нь Иван Ильичэд өөрийн ертөнцийг гэр бүлээс ангид, тусад нь байлгах шаардлагыг улам ч тулгамдуу, амин чухал болгожээ* гэж орчуулжээ (2015:29). Тус өгүүлбэрийн зурсан хэсгүүдийг харьцуулж үзвэл зохиолын гол дүр болох Иван Ильич эхнэр хүүхдээ “худал үнэн” өвддөг гэж итгэл алдарсан мэтээр орчуулах нь түүнийг хатуу сэтгэлтэй, дэндүү хувиа хичээсэн этгээд хэмээн

бараантуулж харуулах учраас тухайн дүрийг үнэн зөв дүрслэн харуулахад “эх хүүхэд үнэхээр өвдөх, заримдаа хий санаа зовох” гэж орчуулах нь үнэмшилтэй санагдана. Дээрх өгүүлбэрийг дараах байдлаар орчуулж байна: *Хүүхэд төрснөөс эхлээд хүүхдээ хооллох гэж элдвээр оролдоод бүтэлгүйтэх, эх хүүхэд үнэхээр өвдөх, заримдаа хий санаа зовох бүрийд Иван Ильичийг заавал оролцохыг шаардаж байсан боловч тэр бээр ямар ч тус нэмэр болж чадахгүй байв. Тиймээс ч өөрийгөө гэрээсээ тусгаарлаж амьдрах нь түүнд амин чухал хэрэгцээ болсон юм* (2015, 29).

Цаашлаад тус орчуулгад орос хэлний нэр үгийг нэр үгээр орчуулснаас үүдээд -лт дагавартай үг олширсон байна. Тухайлбал: хууралт, хүлээлт, чагналт, товшилт, өвдөлт, мэхлэлт, цохилт, таталт гэх мэт. Нөгөөтгээгүүр *зовлон шаналан* (зүй нь: зовлон шаналал), *сэтгэлийн энэлэн* (зүй нь: сэтгэлийн энэлэл) зэрэг хоршоо үг үүсгэсэн нь -н нөхцөлийн үүргийг эндүүрсэн бололтой.

Дүгнэлт

Ийнхүү дээр өгүүлснийг нэгтгэн дүгнэвэл Л.Н.Толстойн алдарт бүтээлийн орчуулга монгол түмний хүртээл болсныг талархан хүлээн авахын сацуу хэл, найруулгын талаар зарим нэгэн засаж залруулах зүйл байгааг тодорхой жишээн дээр авч үзэж, уг орчуулгыг цаашид чанаржуулж, дахин хянан нягталж засан найруулбаас уншигчдын эх хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд зохих хувь нэмэр болно гэж бодож байна.

Резюме

В этой статье с точки зрения переводческой компетенции рассматриваются вопросы языка и стилистики монгольского перевода знаменитой повести великого русского писателя Л.Н.Толстого “Смерть Ивана Ильича”. Данный перевод заслуживает похвалы по той причине, что является первым переводом на монгольский язык, который был издан в 2015 году. На основе сравнительного анализа перевода с оригиналом обнаруживаются некоторые ошибки и неточности в языке переводе. Автор считает, что дальнейшее исправление ошибок и редакция данного перевода внесёт определённый вклад в повышении знания родного языка.

Ном зүй

1. Вербицкая М. В, Соловов М.Ю (2010). Компоненты и уровни переводческой компетенции. Лингвистика и межкультурная компетенция. Вестник Московского университета. Сер. 19. №4. С. 9-18.

2. Дамдинсүрэн Ц., Лувсандэндэв А. (1982) Орос- монгол толь, Улсын хэвлэлийн газар, нэмж зассан хоёрдугаар хэвлэл, редактор Ш.Лувсанвандан, 840х.
3. Комиссаров Н.В. (2002). Современное переводоведение, издательство ЭТС. 421с.
4. Папина А.Ф. Текст: его единицы и глобальные категории. Москва. 367с.
5. Толстой Л.Н. (2015) Иван Ильичийн үхэл. Орчуулсан Ч.Баатар, редактор Н.Жавхлан, Д.Мөнхцэцэг, Ч.Мөнхтуяа, Монсудар хэвлэлийн газар, 112х.
6. <https://all-the-books.ru/books/tolstoy-lev-smert-ivana-ilicha/>
7. <https://open.lib.umn.edu/ivanilich/chapter/full-text-english/>

ШҮҮМЖЛЭЛ СУДЛАЛ “УНТСАН” ГЭЭД “СУЛДАА ГАНХАЖ” БОЛОХ УУ?

С.Эрдэнэмаам³³

Аннотация: В последние годы в нашей стране наблюдается небывалая активизация работы по переводу зарубежной литературы, в результате чего полки книжных магазинов постоянно заполнены различного жанра книгами, большими и маленькими, толстыми и тонкими, что, разумеется, заслуживает всяческой похвалы. Однако из-за того, что качество перевода не учитывается, не судится, не обсуждается и не оценивается, многие наши переводчики уже начинают привыкать к тому, что это так и должно быть, что они могут переводить так, как хотят, и даже так, как могут. Основная цель данной статьи – привести несколько конкретных примеров относительно качества их работы и высказать свое мнение.

Түлхүүр үг: шүүмжлэл судлал, орчуулгын чанар, утга зохиолын шүүмжлэл, уран сайхны чанар чансаа

Хөгжим, уран зохиол, кино, уран баримал, уран зураг гэх зэрэг урлагийн бүхий л төрөл зүйл өөрийн шүүмжлэл судлалтай байж гэмээ нь улам чамбайран хөгждөг жамтай. Criticism /оросоор “критика”/ гэдэг үг нь κριτικός – “шүүгч этгээд” хэмээх утга бүхий герег үгээс үүсжээ. Шүүхийн аливаа байгууллага үнэн худлыг дэнсэлж, зөв бурууг ялган, бусдад гэм хор учруулсан нэгнийг шийтгэж, нийгэмд дэг журам тогтоох замаар хууль сахиулдаг бол урлаг, утга зохиол судлалын уулзвар болсон утга зохиолын шүүмж судлал нь урлагийн аливаа бүтээлд үнэлэлт дүгнэлт өгч, алдаа оноог нь цэгцлэн дүгнэж, уншигч, үзэгч, сонсогчдын гоо зүйн боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах замаар уран бүтээлчдэд “ташуур өгч” байдаг тун чухал салбар билээ. Тийм ч учраас “Утга зохиолын шүүмж судлал бол утга уран зохиолын шинж байдал, агуулга чанар, түүнчлэн түүний дотоодод болж байгаа аливаа хөдөлгөөн, хөгжлийнх нь явцад гарч буй урсгал чиглэлд хяналт тавих үүрэгтэй. Тэрээр энэхүү үүргээ аливаа бүтээлийг задлан шинжилж, ололт

³³ МУБИС-ийн зөвлөх профессор, хэл бичгийн ухааны доктор (Ph.D)

амжилт, сул талыг нь илрүүлэн гаргаж, эдгээртээ үндэслэн зохих үнэлэлт дүгнэлт өгөх замаар биелүүлж байдаг юм хэмээн”³⁴ судлаач эрдэмтэд тэмдэглэсэн байдаг.

Утга зохиолын шүүмж судлалын салшгүй нэгээхэн хэсэг болсон орчуулгын шүүмж судлал манайд зогсонги байдалд байгаа учраас сүүлийн жилүүдэд орчуулгын уран зохиолын чанар нэлээд доголдох болов. Орчуулга угаасаа, бүр эхнээсээ л “шүүмжлэлийн бай” болсоор ирсэн түүхтэй, яагаад гэвэл орчуулга бол орчуулга, эх зохиол биш, хоёрдогч бүтээгдэхүүн, хоёрдогч учраас эх зохиолоо огт гүйцдэггүй хэмээн үздэг гутранги үзэлтэй цөөн тооны судлаач байдаг бол, нөгөөтээгүүр, орчуулгагүйгээр гадаадын уран зохиолын сор болсон бүтээлүүдээр ард олныхоо оюун ухааныг гэгээрүүлэн цэнэглэх боломжгүй гэж дийлэнх эрдэмтэд ярьж бичдэг. Ингэхлээр орчуулга хэрэгтэй, хэрэггүй хэмээн маргах нь нэгэнт утгагүй учир, орчуулга чанартай байх ёстой гэдэгт л хамаг анхаарлаа чиглүүлэх учиртай ажээ.

Ер нь уран зохиолын орчуулгыг уран сайхны чанар чансаагаар нь, техникийн чиглэлийнхийг нэр томъёоны зөв оноолтоор нь, зар сурталчилгааныхыг олон түмэнд нөлөөлөх чадвараар нь, мэдээ мэдээллийн чиглэлийн орчуулгын чанарыг танин мэдэхүйн үр өгөөжөөр нь үнэлж дүгнэдэг гэдэг³⁵.

Энэ үүднээс аваад үзвэл, номын дэлгүүрүүдийн лангуун дээр борооны дараах мөөг шиг овоорсон орчуулгын уран зохиолын том жижиг, нимгэн зузаан, эрээн мяраан олон ном чанарын шаардлага аль хэр хангаж байгаа бол гэх эргэлзээ өөрийн эрхгүй төрөх болов. Яагаад ийнхүү эргэлзэх болов хэмээвээс, их дээд сургуулийн орос-англи хэлний багш мэргэжлийн ахлах ангид үздэг орчуулгын онол, дадлагын хичээл дээр оюутнуудаар харьцуулсан дүгнэлт хийлгэх зорилгоор өнгөрсөн хавар Ф.М.Достоевскийн “Бесы” хэмээх дэлхийн сонгодогт зүй ёсоор тооцогддог романы орчуулгыг худалдан авч, эхний бүлгийг орос эхтэй нь тулган үзсэн юм. Ингэхэд сургалтад шууд ашиглах боломжгүй, найруулга тааруухан, үг сонголтын болон зохиолынхоо эхийг хагас дутуу ойлгосон, орос хэлний дүрмийн нарийн мэдлэг хомс байгаа зэргээс үүдэлтэй алдаа мадаг бүхий өгүүлбэр нэлээн олон тааралдсаны заримыг энд дэлгэрүүлэн авч үзье.

Орос хэлний дүрмийн мэдлэг хомсоос улбаатай алдаа мадаг:

1. “ ... диссертацию **о возникавшем было** гражданском и ганзеатическом значении немецкого города Ганау...” гэсэн өгүүлбэрийг “ ... үүсэж эхэлсэн иргэний болон худалдааны нөхөрлөлийн учир холбогдлын тухай...” гэжээ. Энэ өгүүлбэрт байгаа “было” гэдэг сул үг нь өнгөрсөн цагт хэлбэржсэн үйл үгтэй хавсран “эхэлсэн боловч, үр дүнд хүрээгүй үйл”-ийг илэрхийлдэг билээ. Иймд энэ хэсгийг “үүсэж эхэлсэн” биш, “үүсэж

³⁴ Курилов А. Литературный критик: кто он и кому нужен? №2021/47,14.12.2021 <https://litrossia.ru/item/literaturnyj-kritik-kto-on-i-komu-nuzhen/>

³⁵ Нормативные требования к переводу <https://study-english.info/translation-normative-requirements.php>

бий болохоо шахсан...” гэсэн бол зохиогчийн санаа бүрэн гарах байжээ. Ийм төрлийн алдаа хэд хэд байна. Нэмээд ганцыг дурдвал: “... Варвара Петровна **бросилась было** всецело ...” – үүнийг “... тэр чигээрээ **дайран орж...**” гэсэн байна. Зүй нь “... дайран орохоор **завдаж ...**” гэх байжээ. “Дайран орох”, “дайран орохоор завдах” нь утгын хувьд ихээхэн өөр юм.

2. “... сыном, **оканчивавшим** тогда курс в .. лицее ...” гэснийг “... лицейд номын дамжаа **дүүргэсэн...**” хэмээн орчуулжээ. “Оканчивавший” – энэ бол төгс бус байдлын үйл үгээс үүссэн үйлт нэрийн өнгөрсөн цагийн хэлбэр бөгөөд төгс бус байдлын үйл үг учраас үйлийн үр дүнг биш, үйл явцыг илэрхийлнэ, тэгэхлээр “дүүргэсэн” биш, “лицейн төгсөх ангид сурч байсан” гэх маягаар орчуулах байжээ.

3. “... но и в солнце пятна” гэснийг “... гэвч наран дээр ч толбо байх” хэмээн буулгасан нь хэвшмэл хэллэгийг үгчилж орчуулж болохгүй гэсэн дүрмийг түр умартсаных болов уу, уг нь “сайнтай муутай сав дүүрдэг гэгчээр” гэсэн шиг орчуулсан бол зохиогчийн санаанд нэлээн дөхөх байжээ.

4. “Они всё брали **из книжек...**” - энэ өгүүлбэрийг “Тэд бүх санаа оноог **номоос** авна” гэж орчуулжээ. “Книги” гээгүй “книжки” гэсэн нь тэдгээр номыг үл тоосон, басамжилсан утга шингээсэн байгаа учраас “Тэд яриад байгаа зүйлээ **шалдар булдар элдэв номоос** л олж авдаг байлаа” хэмээсэн бол агуулгадаа илүү дөхөх байжээ. Мөн үйл үг нь өнгөрсөн цагт хэлбэржсэн байгааг анзаарсангүй бололтой.

5. “... в девицах она долго жила в Петербурге” гэснийг “... **залуудаа** Петербургт **удаан аж төрсөн**” гэжээ. Энд тухайн жинхэнэ нэрийн үгийн сангийн утгыг анзаараагүй, эсвэл мэддэггүйгээс утга гажсан байна. Зүй нь “**Нөхөрт гарахаасаа өмнө** Петербургт олон жил суусан” гэсэн шиг орчуулах байсан болов уу.

6. “Однажды, **недели две** после отставки, ... “ гэдэг өгүүлбэрийг “Нэг удаа, салснаас **хоёр долоо хоногийн** дараа, ...” гэж орчуулсан нь орос хэлний тооны нэрийн хэрэглээний онцлогийг сайн ойшоогоогүйгээс болоод утгыг гажуудуулахад хүрсэн байна. Тооны нэр нь жинхэнэ нэрийнхээ ард орвол ойролцоо утгыг илэрхийлдэг учраас зүй нь “Нэг удаа, **сална гэснээс хоёр ч билүү, гурван ч билүү** долоо хоногийн дараа ...” гэсэн бол зохиогчийн санаа бүрэн гарах байжээ. Ийм төрлийн алдаа мөн л нэлээн олон байгаагаас дахиад хоёр гурвыг дурдвал: “... их зазвал **раза два ... - хоёр ч удаа** авчирч дөнгөжээ – (**хоёр гурван ч удаа** авчирч дөнгөжээ); “... всплакнул **раза два...**” – “... **хоёр ч удаа** нулимс унагасан - (**хоёр гурван ч удаа...**); “Мальчику было тогда **лет восемь**”. – “Тэгэхэд хөвүүн **наймтай...**” – (Тэр үед хөвүүн **долоо найм хэрийн** настай); “... отделился еще **шага на три...**” – “...цаашлан **гурван алхам** холдож...” – (... **гурав дөрвөн алхам...**) г.м.

7. “... за **немецкой книгой...**” энэ холбоо үгийг орчуулахдаа угтварынх нь утгад хэт хөтлөгдөөд, агуулгыг нь онц анзаараагүй бололтой, -“... герман **номны цаана байгаа...**” хэмээн махчилжээ. Зүй нь “...**герман ном бариад суучихсан...**” гэсэн санаа юм.

8. “Он не задумался ..., едва лишь оно капельку **подросло**”. - энэ өгүүлбэрийг “Бяцхан амьтныг хоног тоолон **өсөхийн хэрээр** анд нөхрөө болгохоос **цэрвэсэнгүй**” хэмээн орчуулжээ. Энд орос хэлний үйл үгийн байдлын айн тухай нарийн мэдлэг хомсодсон, эсвэл хайхрамжгүй хандсан тал байна. Нэгдүгээрт, “не задумался” гэдэг нь “цэрвэсэнгүй” гэсэн үг биш, утгыг гажуудуулсан байна, хоёрдугаарт, “подросло” гэж төгс байдлын үйл үг, аливаа үйл үр дүнд хүрснийг илтгэдэг, гэтэл “өсөхийн хэрээр” гээд төгс бус байдлынх мэтээр, өөрөөр хэлбэл үйлийн явц мэтээр андуурчээ. Зүй нь: “Тэгээд л тэр бяцхан амьтныг жаахан **том болонгуут нь** ямар ч эргэлзээгүйгээр **найзаа болгоод** авчээ” гэсэн шиг утгатай өгүүлбэр юм.

9. Үйл үгийн төгс ба төгс бус байдлын айн утгын нарийн ялгамжийг харгалзан үзээгүй учраас дараах өгүүлбэрт мөн агуулга гажсан байна: “... а днём прятал его под тюфяк и даже не пускал женщину **перестилать** постель, ... - өдөр нь бол **бамбай доогуураа** нуучаад, орыг нь хураах гэсэн авгайг **оруулахгүй байсан**. “Перестилать” гэдэг нь төгс бус байдлын үйл үг бөгөөд олон удаа давтагдан үйлдэгдэх үйлийг илэрхийлэх учир “Оруулахгүй байсан” хэмээн ганц удаагийн үйл мэтээр биш, “... орыг нь хураах гэсэн үйлчлэгч авгайг тийш нь **хавьтуулдаггүй байв**” гэсэн маягаар, олон удаа, байнга гэсэн өнгө аяс оруулж орчуулах байжээ.

10. “... сумел ... вызвать **в нём** первое, еще неопределенное ощущение той вековой, священной тоски... – энэ өгүүлбэрт байгаа “в нём” гэдэг биеийн төлөөний үгийн хүйсийг анзааралгүй “... **тэр чавхдасны** үүрд мөнхийн, ариун гэгээн санагалзах гунигийн хараахан зүгшрээгүй анхны мэдрэмжийг хөглөсөн” хэмээн орчуулснаас болоод утгыг айхавтар гажуудуулжээ. “В нём” гэдэг бол “он”, эсвэл “оно” гэсэн, эр, эсвэл эрс хүйсийн жинхэнэ нэрийг төлөөлөөд, Предложный тийн ялгалд хувирсан биеийн төлөөний үг. Гэгээн мөрөөдлийн амтыг юунд мэдрүүлж чадсан бэ? гэхлээр чавхдасанд биш, яагаад гэвэл “чавхдас- оросоор **струна** – эм хүйсийн үг, харин зүрхэнд, яагаад гэвэл “зүрх – оросоор сердце” – эрс хүйсийн үг. Нарийн ширийн энэ ялгааг мэдэхгүйгээс, эсвэл мэдсэн ч анзаараагүйгээс болоод зүрхэнд мэдрүүлсэн юмыг чавхдасанд гэж алджээ. Мөн “гэгээн ариун санагалзах гунигийн хараахан зүгшрээгүй анхны мэдрэмж” гэж маш болхи өгүүлжээ. Орчуулагчдын энэ мэтийн хачин найруулгаас болоод орчин үеийн залуус, тэр ч атугай нэлээд нэрд гарсан телевизийн зарим сэтгүүлч “ийм мэдрэмж төрлөө, тийм мэдрэмж авмаар байна” гэж ярьж бичдэг болжээ. Эх хэл нь эвдрээгүй унаганаараа байгаа хөдөөгийн малчин өвөө: “бороо ороод сайхан мэдрэмж төрж байна, мал төллөөд эхлээсэй, сайхан мэдрэмж авахыг хүсэж байна” гэж хэзээ ч хэлэхгүй, яагаад гэвэл тэдний хэл – жинхэнэ монгол хэл. Зүй нь: “... сэтгэлийнх нь хамгийн нарийн нандин чавхдасыг хөндөж дөнгөснөөр балчир андынхаа зүрхэнд үүрд мөнхийн ариун гэгээн мөрөөдлийн амтыг бүдэг бадаг ч гэлээ мэдрүүлж чаджээ” гэх маягаар буулгах байсан болов уу.

11. “... доход с ее имени...” – энэ хэсгийг “...**эдлэн газрынх нь** орлого ...” гэж орчуулсан нь ганцхан эдлэнтэй мэтээр ойлгогдож, зохиолчийн санаа гажсан байна.

Өөрөөр хэлбэл “имений” гэсэн харьяалахын тийн ялгалын олон тоонд хэлбэржсэн үгийг таньсангүй юу, анзаарсангүй юу. Зүй нь: “...эдлэн **газруудынх нь** орлого ...” юм.

12. “Он **решился**, однако...” – гэсэн өгүүлбэрийг “Гэвч ... **шийдсэн**” гэжээ. Энд “решиться – решить” гэдэг хоёр үйл үгийн утгын нарийн ялгааг гаргаж чадаагүй учир зохиогчийн санаа бүрхэгдэхэд хүрчээ. “Решить” гэдэг нь шийдэх, “-ся-”-тай болохоороо ихээхэн хүчин чармайлт, зориг гаргаж байж арай гэж нэг юм шийдэх гэсэн үг. Тэгэхлээр нь уг нь: “Гэхдээ ... **арай гэж нэг юм зориглон шийджээ**” гэсэн маягаар орчуулах ёстой байжээ.

Уг буруу сонгосон, агуулгыг ойлгоогүйгээс гарсан алдаа мадаг

1. “... и какие-то **атлеты** ее наконец достраивают ...”. Энд “атлеты” гэдэг үгийг орчуулахдаа зохиолынхоо агуулга, хам сэдвийг сайн бодож үзсэн бол “... **элдвийн тамирчин эрс**” гэхгүй, “**хүдэр чийрэг эрчүүд**” гэж, шилжсэн утгаар нь орчуулах байжээ.
2. “Усы и **бороду** он брил” гэснийг “Сахал, **хуузаа** сайхан хусна” гэж орчуулсан нь үгийн сангийн утгыг гажуудуулжээ, уг нь “Уруул, **эрүүнийхээ** сахлыг...” юм. “Хууз сахал”-ыг “бакенбарды” гэнэ.
3. “Но, по некоторому **гражданскому кокетству...**” гэдэг өгүүлбэрийг “Гэхдээ, **иргэний** зарим нэг сэртэндэх зангаар..” гэж орчуулсан нь монгол уншигчдад тун ойлгомжгүй болжээ. “Иргэний сэртэндэх зан” гэхлээр яг юу гэж ойлгох ёстой вэ? Зүй нь: “Гэхдээ мань эр **сээтэгнүүр зантай зарим хөгшид шиг...**” гэвэл арай монголжуу болох байжээ.
4. “... и когда уже достраивают до самого верху, то **обладатель, положим хоть Олимпа**, убегает в комическом виде, ... “ гэсэн өгүүлбэрийг “... тэгээд яг оройг нь барьж дуусахын үес, **эзэгнэгч нь, яах вэ Олимпа гэж саная**, хөгийн инээдтэй дүрээр зугтан одож...” гэж буулгажээ. Энд “Олимп” гэдэг үгээ ойлгосонгүй учраас “**Олимпа гэж саная**” хэмээн ташаарчээ. Чухамдаа Олимп гэдэг нь эртний герег үлгэр домогт “Бурхдын орон” юм. Иймд “...оройн хэсгийг нь дуусгахын даваан дээр Эзэн (**Бурхдын орных ч байсан байж магадгүй**) нь элэг хөшим байдалтайгаар зугтан одно гэсэн шиг орчуулах байв.
5. “... человек, ... стоявший весьма близко у дела” гэсэн хэсгийг “**ажил явдалд** нэн ойрхон байдаг ...” гэжээ. “Ажил явдал” гэхлээр “оршуулга” гэсэн санаа өөрийн эрхгүй сэтгэлд бууна. Зүй нь: “...эзэн хаанд **нэн ойрын байдаг...**” гэсэн утга цаана нь байх ажээ.
6. “Варвара Петровна овдовела и **облеклась** в полный траур” гэсэн өгүүлбэрийг “Варвара Петровна бэлэвсэрч, гашуудлын өмсгөлд **умбасан**” хэмээн орчуулсан нь нэн хариуцлагагүй хандсан хэрэг юм. Нэгдүгээрт, өгүүлбэрийг “-сан, -сэн, -сон”, -сөн” гэж үйл үгийн өнгөрсөн цагийн ийм хэлбэрээр төгсгөсөн газар маш олон таарч байгаа нь найруулгыг туйлын болхи болгож байна. Хоёрдугаарт, “умбах” гэдэг үйл

үгийг сонгохдоо орос үгийн утгад хэтэрхий автаж шууд буулгажээ. Гэтэл энэ бол ихээхэн эерэг утгатай үг билээ. Монгол хэлний их тайлбар тольд энэ үгийн утгыг: 1. *Тогтоол болон урсгал усанд орох, сэлэх, шумбах: усанд умбах (усанд сэлэх);* 2. [шилжсэн] *Элбэг идээ ундаа, торго дурданг дураар хэрэглэх: торгонд умбах* (торгыг зүйл бүрээр нь хэрэглэх, торгоор элбэг байх); 3. [шилжсэн] *Эзлэх, автах: нам гүмд умбах (нам гүм болох, нам гүм байдал ноёрхох)* хэмээн тайлжээ. Тийм учраас “гашуудлын хувцсанд умбуулж” яагаад ч болохгүй. Зүй нь: Варвара Петровна бэлэвсэрч, гашуудлын хувцас **өмсжээ** гэх байжээ.

7. Орос үг хэллэгийн үгийн сангийн утгад дэндүү их баригдсан алдаа түгээмэл байна. Жишээлбэл: 1. “Замечу **в скобках**” – “**хаалтад хийх маягаар** нэмж дурдъя”. Энэ бол зүгээр л “**үгийн далимд хэлчихье**” гэсэн санаа юм. 2. “... скорее **по художественной своей натуре - сонин зангийнхаа улмаас** л тэгсэн байх. “художественный” гэдэг үгийг нарийн ажиглаагүй бололтой, зүй нь: “**уран бүтээлч хүн юм болохоороо** л...” гэх байжээ.

Тухайн үеийн нийгмийн түүх, амьдралын онцлогийг судлаагүйгээс улбаатай алдаа

1. “... заявил, что **сапоги ниже Пушкина**, и даже гораздо” гэсэн өгүүлбэрийг шуудхан л “... гутал бол **Пушкин шиг чухал биш, бүр хавьтах ч үгүй**” хэмээн орчуулжээ. Уг нь жаахан судлаад үзэх хэрэгтэй байжээ. Хэрвээ тэгсэн бол 1860-1910 онуудад Оросын эзэнт гүрэнд үндэс угсаагаа мэдэх, улс орондоо болон дэлхий дахинд ямар байр суурь эзэлбээс зохилтой гэдгээ олж тогтоох гэсэн сэхээтний давхаргын зарим төлөөлөл энгийн ардуудтай ойр дөт байх зорилгоор хөдөлгөөн үүсгэж, түүнийгээ “народничество” буюу “ард түмэнсэг хөдөлгөөн” гэж нэрлэж байв. Тэдний үзэл сурталчид: “Пушкингүйгээр болохдоо л нэг болно, харин гуталгүй бол хаа холдох билээ, тийм учраас гутал бол түүнээс хавьгүй дээр юм, Пушкин гэдэг бол язгууртнууд тансаглахад л хэрэгтэй юм биз” хэмээн номлож байснаас үүссэн хэллэг гэдгийг олж мэдээд: “Пушкинээс гутал чухал, хамаагүй чухал гэсэн үзэл бол гутамшиг” хэмээн буулгах байсан болов уу.

2. “... о доме Краевского, которого никто и никогда не мог простить господину Краевскому, ...” гэдэг өгүүлбэрийг “**Краевскийг хэзээ ч хэн ч өршөөж эс чадах түүний ордны тухай...**” гэж огт ойлгомжгүй өгүүлбэрээр “орчуулсан” нь мөн л судалгаа дутсаны ажээ. Краевскийг өршөөх тухай яриад байна уу, байшинг нь өршөөх тухай юм уу гэдэг нь ойлгогдохооргүй, найруулга нь тийм болхи болжээ. Гэтэл судлаад үзэх юм бол А. А. Краевский (1810–1889) гэж “Отечественные записки” сэтгүүлийн эрхлэгч байсан юм байна. Тэрээр хувьдаа “Отечественные записки”, “Голоса” гэдэг хоёр сэтгүүлийн редакц байрладаг нэгэн байшинтай байжээ. Достоевскийн бодлоор бол, сэтгүүл гаргаж бизнес эрхэлдэг Краевский олон зохиолчийг, тэдгээрийн дотор Достоевскийг ч мөлждөг байж. Достоевский тэмдэглэлийнхээ дэвтэрт: “Хэдийгээр гайгүй авьяастай ч, уран зохиолоор байшин сүндэрлүүлдэг, өөрөөр хэлбэл, зохиолчдыг

мөлжиж баяждаг зохиолч өнөө цагт олон байна. Краевскийн байшин бол хэвлэлийн газрын эзний захиалгаар хэдхэн төгрөгийн төлөө боол мэт хөдөлмөрлөдөг, мөлжигдөгч зохиолчдын хөлс цусаар боссон, мань этгээд гэтэл байшин сүндэрлүүлээд авчихсан” хэмээн бичсэн байдаг ажээ. Тэгэхлээр энэ өгүүлбэрийг зүй нь: “... зохиолчдын хөдөлмөрийг шулж барьсан уучилшгүй нүгэлт Краевскийн байшин сууцны тухай...” гэсэн маягаар орчуулсан бол зохиолынхоо агуулгыг бүрэн гаргах байжээ.

3. Зарим газар ихээхэн залхуурчээ. Тухайлбал:

“Век и Век и Лев Камбек,
Лев Камбек и Век и Век” гэж сүүл толгой холбон шүлэглэн бичсэн энэ хоёр мөрийг “ямар ч утгагүй шүлгийн хоёр мөр” гээд орхичихсон байна. Зүй нь, “Век” гэж юу вэ, “Лев Камбек” гэж хэн байв? гээд судлаад үзчих байжээ. Хоёрхон мөр энэ шүлгийн цаана “Сэтгүүлийн эрхлэгчид сэтгүүлүүдийг гаргаа аваад, зохиолчдыг шулаад байна” гэсэн том санаа явж байгаа юм. Хэрвээ түүхэн цаг үеийг нь өнгөцхөн ч атугай судлаад үзсэн бол “Век” гэдэг нь П.И.Вейнберг гэдэг этгээдийн Петербург хотод эрхлэн гаргадаг байсан долоо хоног тутмын сэтгүүлийн нэр, Лев Камбек гэдэг нь “Семейный круг”, “Санкт-Петербургский вестник” гэдэг хоёр ч сэтгүүлийг ганц ганцхан жил эрхлэн гаргаад орхичихсон шалихгүй нэгэн сэтгүүлч байсныг олж мэдээд:

“Век, Век гэхлээр л Лев Камбек,
Лев Камбек гэхлээр л Век, бас л Век бодогдоод”

гэсэн маягаар ч гэлээ орчуулаад, энэ хоёр нэрэндээ зүүлт хийж тайлбарлах байсан болов уу.

4. Судалгаа сайн хийгээгүйн өөр нэг жишээ бол “**Принц Гарри**” гэснийг “**Жонон Гарри**” хэмээн буулгасан явдал юм. Зүй нь “**Гарри хунтайж**” гэх байжээ. Учир нь: а/ Принц гэхийг толь бичигт “жонон, тайж, хунтайж, аг” гэж орчуулжээ. Монгол хэлний их тайлбар толь-д “жонон гэдэг бол Хаан ширээ залгамжлахаар нэр заагдсан хан хөвгүүний цол” гэсэн бол “хунтайж гэдэг нь хааны төрсөн хүү” хэмээн тайлбарлажээ. Бидний орчуулж буй зохиолд Варвара Петровнагийн хүүг принц Гарри гэж нэрлэж байгаа. Яагаад гэвэл тэр хүү эрх танхи, танхай балмад, архи, мөрийтэй тоглоомд автсанаараа хожим 5-р Генрих хаан болсон Гарри хунтайжтай адилтгасан хэрэг. Гарри хунтайж бол залуудаа буюу зүгээр хааны хүү байсан үедээ тийм задгай явдалтай байсан болохоос биш, үе залгамжлах хан хүүд өргөмжлөгдсөн хойноо тийм байгаагүй юм байна, иймд түүнийг “Гарри жонон” гэх үндэслэл байхгүй. б/ Жонон Гарри гэж хэргэм цолыг өмнө нь хэлэх нь орос хэлний онцлогт баригдсан хэрэг. Монгол хэл, ахуй соёлоор бол хэргэм цолыг ард нь хэлнэ: Богд хаан, Галсан мээрэн г.м. (Хаан богд, Мээрэн Галсан гэхгүй.)

Эцэст дүгнэн тэмдэглэхэд, олон зуун хуудас бүхий энэ том романы орчуулгаас эхний цөөн хэдийг эхтэй нь тулган уншихад ийм олон алдаа мадаг тааралдсан учир орчуулгын хичээлд гарын авлага болгон ашиглах гэсэн зорилго маань талаар болсон юм. Орчуулгыг бүхэлд нь нягтлан үзэх, шүүмжлэх, хэн нэгнийг муулж гоочлох, нэр төрд нь

халдах зорилго огтхон ч агуулаагүйг уншигч мэргэд ойлгон хүлээж авах буй заа. Энэхүү өгүүллийг бичсэн гол зорилго бол манай улсад утга зохиолын, нэн ялангуяа орчуулгын шүүмжлэл унтаахай байдалд хэтэрхий автаж, орчуулагчид маань “сулдаа ганхаж”, үүний цаана уншигч олон түмэн маань хохирсоор байгааг л эрдэмтэн судлаачдын сонорт хүргэх гэсэн явдал болой.

Ашигласан ном зохиол

1. Курилов А. Литературный критик: кто он и кому нужен? №2021/47,14.12.2021
<https://litrossia.ru/item/literaturnyj-kritik-kto-on-i-komu-nuzhen/>
2. Нормативные требования к переводу// <https://study-english.info/translation-normative-requirements.php>

“ШИНЭ ОРЧУУЛСАН УЛААН АСРЫН ЗҮҮД”-ИЙН ОРЧУУЛГЫН УРАН ЧАДВАРТ ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Ц.Ичинхорлоо³⁶

Abstract: *Mongolians have skilfully translated a number of the best fictional works of China, a long-time neighbor since ancient times. One of them is "A Newly Translated Ulaan Asriin Zuud" by Khasbuu. This work is the Mongolian version of the work "Ulaan Asriin Zuud" or the first version translated from Chinese to a foreign language.*

During our exploration, we observed the following. It includes:

- *When Khasbuu translated the novel "Ulaan Asriin Zuud" into Mongolian, based on the theory and methodology of traditional Chinese literary criticism, he made a perfectly rational review with emphasis after each chapter. When the author translated 120 chapters of this work by abridging it into 40 chapters, 13 chapters of the original text were completely changed, some contents of 86 chapters were changed, and 30 chapters were not translated at all. In doing so, he translated it into the Mongolian language very skillfully without destroying the main meaning, vivid description, and artistic features of the novel.*
- *More than 70 foreign words are used in the work, and they were mainly nouns borrowed from Chinese, Tibetan, and Manchu languages, and verbs were very rare.*

Keywords: *"Newly Translated Ulaan Asriin Zuud", Khasbuu, abridged translation, foreign word*

I. “Бэхэнд дурлагч” Хасбуу ба “Шинэ орчуулсан улаан асрын зүүд”

Монголчууд нь эртнээс нааш хөрш зэргэлдээ орших Хятадын сор болсон олон арван бүтээлийг монгол хэлнээ орчуулж утга зохиолын онол шүүмжийг чадварлаг хийсээр ирсэн. Монголын нэрт академич Ц.Дамдинсүрэн "Монголын уран зохиол долоон зуун жилийн түүхтэй байхад, монгол уран зохиолын судлал лав гурван зуун жилийн түүхтэй юм", ӨМБИС-ийн эрдэмтэн судлаач Б.Гэрэлт “Юань улсаас нааших хэдэн эринд монголчууд хятад хэлээр ч бага бус онол бодролыг бичиглэж үлдээжээ... Монгол

³⁶ Доктор, МУИС, Ховд сургууль

зохиолын онол өгүүлэхүйн түүхийг бөөнд нь арван долоодугаар зууны эхээс татаж хэлэхэд буруудахгүй”³⁷ гэжээ. Энэхүү түүхийг бүтээлцэж хойч үеийнхээ бахархал нь болсон олон суутнуудын нэг бол Хасбуу юм. Түүний гарвал сурвалжийн талаарх илүү тодорхой мэдээлэл байхгүй ч орчуулж цохолсон “Долоон сургаалын бичиг” /цохолбор/, “Улаан асрын зүүд”/13-р бүлгийн цохолбор/ зэрэг бүтээлүүдээс нь 18-р зууны сүүлч 19-р зууны эхэн үед Өвөр Монголын Зостын хошуунд амьдарч байсан, тайж язгууртан гаралтай, “бэхэнд дурлагч”, зураг зурах болон шүлэг тэрлэх зэрэгт гарамгай, төвд, хятад, манж хэлийг гойд сайн эзэмшсэн нэгэн байсныг мэдэж болно.

Өвөр Монголын эрдэмтэн Б.Гэрэлт “Хасбуу болон Ванчинбал нь нэг хүн”³⁸ судлаач Наранмандуулаа “Хасбуу=Ванчинбал”³⁹, судлаач Өнө-Улаан “Хасбуу нь Гулиранс ч биш, Ванчинбал ч биш, Хасбуу нь Инжинашийн гэр бүлтэй ямар ч холбоогүй бие даасан өөр нэгэн билээ”⁴⁰ хэмээснээс үзвэл энэ агуу зохиолчийн талаарх мэдээлэл төдийлөн тодорхой бус байна. Ямартаа ч Хасбуу нь хятадын эртний хэд хэдэн алдартай зохиол болох “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл”, “Эрт эдүгээх гайхамшигтай үзэмжийн бичиг”, “Долоон сургаалын бичиг”, “Тан улсын ордны тэмдэглэлийг нөхсөн бичиг”, “Улаан асрын зүүд” зэргийг монгол хэлнээ орчуулахын зэрэгцээ өвөрмөц онцлог бүхий утга зохиолын шүүмжийг туурвисан байгааг харахад үнэхээрийн бахархууштай. Эдгээрээс хамгийн алдартайд тооцогдох бүтээл бол түүний орчуулж, цохолсон “Шинэ орчуулсан улаан асрын зүүд” юм. Энэхүү бүтээл нь 18-р зууны эхэн үе гэхэд Монголчуудын тэр дундаа Монголын язгууртан гаралтай сэхээтнүүдийн “ширээний ном” болтлоо хэрэглэгдэх болжээ. Түүнчлэн энгийн ард түмний дунд ч аман болон бичгийн байдлаар ихээхэн дэлгэрсэн байна. Судлаачид В.Инжинашийн бичсэн “Нэгэн давхар асар” хэмээх романыг дээрх бүтээлийн монгол хувилбар ч гэж үздэг.

Хасбуу нь хятадын дэлхийд гайхуулдаг “4 оргил” бүтээлийн нэг 120 бүлэгт “Улаан асрын зүүд” романыг 40 бүлэг болгон хураангуйлан монгол хэлнээ орчуулахдаа туужийн гол утга санаа, яруу дүрслэл, уран сайхны онцлог зэргийг нь эвдэхгүйгээр чадварлаг орчуулсан байдаг. Өөрөөр хэлбэл Хасбуу нь хятад үндэстний уламжлалт уран зохиолын шүүмж бичих онол аргазүйд тулгуурлан бүлэг бүрийн ард төгс оновчтой цохолбор бичихдээ монголчуудын уламжлалт орчуулгын онол аргаар хураангуйлан орчуулсан байна. Судалгааны явцад бид энэ бүтээлийн талаарх хэд хэдэн онцлогийг тодруулав. Үүнд:

“Шинэ орчуулсан улаан асрын зүүд” бол хятад хэлнээс харь хэлнээ орчуулагдсан хамгийн анхны хувилбар мөн. Одоогоор “Улаан асрын зүүд”-ийн харь хэлнээ орчуулагдсан 50 гаруй хувилбар байна. Тэрээр саяхныг болтол хамгийн анх англи хэлнээ

³⁷ Б. Гэрэлт профессорын өгүүллэийг монгол зохиолын онол өгүүлэхүйн "Турамсан бүтэц"


³⁸ 《哈斯宝研究论文集》内蒙古文化出版社，1987年，第25-29页。

³⁹ 《哈斯宝研究论文集》内蒙古文化出版社，1987年，第30-35页。

⁴⁰ 《哈斯宝研究论文集》内蒙古文化出版社，1987年，第16-19页。

орчуулагдсан гэж үзэж байв. Гэтэл бидний судалгаанаас Хасбуу нь 18-р зууны эхэн үе буюу 1819 оны сүүлчээр энэ бүтээлийг хятад хэлнээс монгол хэлнээ орчуулсан тухай баримт байна. Бид Монгол улс болон БНХАУ-ын номын сангуудад хадгалагдаж буй “Шинэ орчуулсан улаан асрын зүүд”-ийн 5 гар хуулбаруудад зэрэгцүүлсэн шинжилгээ хийх явцад Монгол улсын Үндэсний номын санд хадгалагдаж буй “Шинэ орчуулсан Хунлоумэн бичиг”-ийн “Оршил”-д “Улаан асрын зүүд”-ийн харь хэлнээ орчуулагдсан хамгийн анхны хувилбар болохыг батлах он цагийн тэмдэглэгээс байгааг судлав. (Зураг-1)

Зураг-1 (Монгол Улсын Үндэсний номын санд хадгалагдаж буй “Шинэ орчуулсан Хунлоумэн бичиг” гар бичмэлийн “Оршил” хэсэг)



Энэхүү гар бичмэл нь /Индекс: 7409-18/96/ бийрээр, хар бэхээр, муутуу цаасан дээр бичигдсэн, утсаар үдэж дэвтэрлэсэн, нийт дэвтрийн тоо 10 ш ба 396 хуудастай, дэвтэр тус бүрд 2 бүлгийг бүртгэсэн бөгөөд 1-20-р бүлэг хадгалагдаж байна. Номын урт нь 26 см, өргөн нь 25 см, 1-р дэвтрийн хавтасны нүүрэнд "Хунлоумэн бичиг" гэж манж хэлээр галигласан байх ба 2-р нүүрэнд "Улаан асрын зүүдний шинэ орчуулга" гэж монгол бичгээр галигласан байна.

Тус гар бичмэлийн “Оршил”-д **“Сайшаалт ерөөлтийн харагчин тvvлай жилийн өвлийн 10 сарын**

Дашрамд дурдахад Монгол Улсын Үндэсний номын сан 1927 онд анх баригдаж байхад тухайн үед "Баримт бичиг, материалын судалгааны хүрээлэн" нэртэй байжээ. “Баримт бичгийн судалгааны хүрээлэн” байгуулагдахад “Богд хааны музей” болон хувийн сан хөмрөгөөс 8000 гаруй гар бичмэл, номыг Үндэсний номын санд цуглуулсны дотор "Хунлоумэн бичиг" гар бичмэлийг цуглуулсан гэдэг. Энэ үед Монголын утга зохиолын үнэт өвийг цэгцэлсэн боловч цуглуулсан цаг хугацаа, хэн цуглуулсан тухай мэдээлэл одоогоор байхгүй байна. 17-18-р зуун бол манжийн эзэнт гүрний ноёрхол дор монгол, хятад 2 үндэстнүүд зэрэгцэн оршиж хэл, соёлын хувьд нэлээдгүй харилцан холбоотой байсан цаг үе юм. Тухайн үед Хасбуу нь “Улаан асрын зүүд” бүтээлийг монгол уншигчдын хүртээл болгохын төлөө өөрийн эрдэм мэдлэгт дулдуйдан энэхүү бүтээлийг эртний монгол хэл найруулгаар орчуулсан нь монголын эртний утга зохиолын түүхэнд юугаар ч үнэлж баршгүй үнэ цэнтэй өв санг үлдээжээ.

Ийнхүү Хасбуугийн “Шинэ орчуулсан улаан асрын зүүд” бол Цао Шүэ Чиний “Улаан асрын зүүд”-ийн харь хэлнээ орчуулагдсан хамгийн анхны хувилбар бөгөөд онцолбол эртний монгол хэл найруулгаар бичигдсэн, зохиолын агуулгыг уран чадварлаг хураангуйлж орчуулсан бие даасан бүтээл хэмээн үзэж болно.

II. “Шинэ орчуулсан улаан асрын зүүд”-ийн орчуулгад хийсэн ажиглалт

Хасбуу нь 120 бүлэгт “Улаан асрын зүүд”-ээс зөвхөн зохиолын гол баатар болох Бао Юй, Дай Юй хэмээх 2 хастай холбоотой хэсгийг хураангуйлан орчуулсан байдаг. Ингэхдээ эх зохиолын шүлэг дуулал, уран яруу байдал, мөр шад зэрэгцсэн эсэх зэргийг анхаарахын зэрэгцээ нэг агуулгыг нөгөө агуулгад холбох холболтыг маш чадварлаг хийсэн нь ихээхэн анхаарал татав. Түүнчлэн бүлэг бүрийн ард үйл явдал бүрд тохирсон дүр, өрнөл, агуулга, хэл ярианы илэрхийлэл, тухайн үйл явдалд холбогдох түүхэн хэрэг явдлын талаарх хийсэн цохолбор /шүүмж/ нь монгол үндэстний утга зохиолын онолын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан гэж үзэж болно. Судалгааны явцад тухайн орчуулагчийн дараах уран чадамжуудыг онцлон ажиглав. Үүнд:

1. Хасбуу нь эртний хятадын эртний бичиг үсэгт бүрэн нэвтэрсэн төдийгүй уламжлалт ёс заншил, аж төрөх ухаанд гүн гүнзгий “ууссан”, “Үг дотор үг дайх” ухааныг чадварлаг эзэмшсэн нэгэн байсан. Тэрээр омог бардам “Энэ бол зөвхөн миний л орчуулж туурвисан “Охорхон улаан асрын зүүдэн минь”⁴¹ хэмээн нэрлэсэн байгаагаас харвал орчуулах ур чадвар хэр арвин байсныг илтгэж байна.
2. Зохиолч уг зохиолыг орчуулахдаа дүрүүдийн хоорондын ялгааг гаргаж ирэхийн тулд өөрийн өвөрмөц онолыг бий болгож зохиолын үйл явдлыг хураангуйлах явцдаа ашигласан байгаа нь харагдаж байна. Тэрээр зохиолын гол баатар болох Бао Юй болон Дай Юйгийн хайр сэтгэлийн холбоог зохиолын гол өрнөл болгож зарим дүрийг зориуд орхигдуулах эсвэл дахин давтахгүй байх зэргээр үйл явдлын хураангуйг зангидсан байгаа нь олонтоо тааралдав.
3. Зохиол 43 бүлэг цохолбортой ба энэхүү цохолборуудын үзэл санаа, дүр дүрслэлээс харвал Хасбууг жинхэнэ утга зохиол шүүмжлэгч болохыг илтгэж байна. Түүний бичсэнээр “Хэлбэр байвал сүүдэр бий, сүүдэр байвал хэлбэр бий болно. Хэлбэр байвал сүүдэргүй бол бүрхэг, сүүдэр, дүрс байвал хачирхалтай. Нийтлэлд хориотой зүйл, хачин байдал бол нийтлэлийн гайхамшиг юм. Өгүүлэлд ойлгомжгүй байдал нь хориотой зүйл юм.”⁴² хэмээснээс харвал түүний уран зохиолд хандсан бүтээлч чадвар, логик шинж нь хэр давамгай болохыг харж болно.
4. Бүтээлээс мөн Хасбуу нь орчуулагч, утга зохиол шүүмжлэгчээс гадна түүхч болохыг мэдэж болно. Түүний түүхийн мэдлэг нэн арвин. Нэн ялангуяа хятадын эртний түүх, соёлд бага наснаасаа эхэлж нэвтэрсэн бөгөөд хятадын эртний түүхэн сурвалжуудыг нэгд

⁴¹ Хасбуу “” Шинэ орчуулсан улаан асрын зүүд”-ийн “Бүгдийн хуулал”.

⁴²Хасбуу “” Шинэ орчуулсан улаан асрын зүүд”-ийн “Бүгдийн хуулал”

нэггүй уудлан судалсан нь түүний цохолбор бүрд илэрхий харагддаг.

- Судалгааны явцад бид Хасбуу нь монголын уламжлалт утга зохиолын онолыг хятадын сонгодог уран зохиолын онол зарчимтай хослуулан 120 бүлэгтэй эхийг хураангуйлан 40 бүлэг болгон орчуулах явцдаа эх зохиолын зарим бүлгийн агуулгыг нэг бүлэгт нь хураангуйлан нэгтгэж **өөрчлөн орчуулах** /变译/, зарим бүлгийг **бүрэн орчуулах** /全译/, зарим бүлгийг **огт орчуулаагүй** /不译/ гэх мэт орчуулсан байна.

Бүрэн орчуулсан бүлгүүд:

Хасбуу нь эх зохиолын I-IV бүлгийг бүрэн орчуулсан бөгөөд хүснэгтэд байгаа бусад бүлгийг сэлгэж шилжүүлэлгүй, бүрэн орчуулсан байна. /Хүснэгт-1/

Зохиолын нэр	Бүлгийн дугаар													
Улаан асрын зүүд /эх/	1	2	3	4	19	20	28	40	41	97	98	119	120	
Шинэ орчуулсан Хунлоумэн бичиг	1	2	3	4	6	7	11	16	17	31	32	39	40	

Өөрчлөн орчуулсан бүлгүүд:

Энэ бүлгүүдэд зохиолын өрнөлийг 2 хасын / Бао Юй, Дай Юй/ хайр сэтгэлийн харилцааг гол болгохыг илүүд үзэж зарим үйл явдлын гогцоог дараагийн үйл явдалд уяж, зарим хэсгийг орхин, өөрчилж орчуулсан байна, /Хүснэгт-2/ Жишээлбэл, 8-р бүлгээс Бао Юй, Дай Юй 2 улам бүр дотноссон хэсэг, Бао Чай зарц нарын зүрх сэтгэлийг эзэмдэж буй хэсэг, Ши Рэн Бао Юйд үйлчилж буй хэсэг, Бао Юй нь Ли Шян Юань, Бао Чай хоёрт очиж зөн билэгт хаш чулуу, алтан цоож үзүүлдэг хэсгүүдийг 5-р бүлэгт багтааж хураангуйлсан, 22-р бүлгийн эхэнд Жя Лянь Фэн эгч хоёр Шюэ Бао Чайн төрсөн өдрийг тэмдэглэх талаар ярилцсаныг орчуулаагүй, Жягийн ээж Ши Шян Юныг орхин явахад Бао Юй, Дай Юй, Бао Чай, Шян Юн нар Зэнгийн бясалгалын тоглоом тоглож, Жя Фэй дэнлүүний оньсого илгээх хүртэл эхэлдэг. Энэ хэсгийг 8-р бүлэгт хураангуйлан орчуулсан, 22-р бүлгийн хоёрдугаар хагасаас, бяцхан тайганы илгээсэн дэнлүүний оньсогоос бүлгийн төгсгөл хүртэл орчуулсан ба 23-р бүлгийн эхийг орчуулаагүй үлдээсэн ба орчуулга нь Жя Юань татвар эм Жягийн хүүхдүүдийг Да гуан цэцэрлэгт амьдрахыг тушаасан үеэс эхэлж, эргэн ирэх үед дуусдаг боловч Баоюйгийн 4 улирлын тухай шүлгийг орхигдуулж, орчуулаагүй, эх зохиолын 44-р бүлгийн эхний хагасыг эхнээс нь орчуулж Дайюй хуучин алчуур дээр гурван шүлэг бичээд орондоо хэвтэх хүртэл орчуулаагүй орхисон, эх зохиолын 37-р бүлгийн эхний хагасыг эхнээс нь орчуулаад дунд нь 1700 гаруйтай тэмдэгт орчуулагдаагүй орхисон гэх мэтээр 120 бүлэг эх зохиолын бүрэн агуулгыг 40 бүлэгт хураангуйлж нэг бүлгийн агуулгыг нөгөөд чадварлаг уяж үйл явдлын гол санааг орхигдуулалгүй уран холбосон байна. Ингэхдээ зайлшгүй орчуулах ёстой гол санааг хадгалах, агуулгыг хялбарчлах зарчим баримталж орчуулжээ. Гэхдээ орчуулаагүй бүлгүүдийн агуулгыг бүлэг болгонд нөхөж тайлбарлах явцад уялдаа холбоогүй, танил бус дүрүүд уншигчдыг төөрөгдөлд оруулан гарч ирэх тохиолдол ч мэр сэр гарч байв.

Хүснэгт-2

(Эх зохиолоос өөрчлөн орчуулсан бүлгүүдийн жагсаалт)

“Шинэ орчуулсан Хунлоумэн бичиг”-ийн бүлгүүд	“Улаан асрын зүүд /эх/”-ээс нэгтгэсэн буюу өөрчилж оруулсан бүлгүүд
5-р бүлэгт	5, 6, 8, 13, 14, 16, 17
8-р бүлэгт	21, 22
9-р бүлэгт	22, 23
10-р бүлэгт	17, 24, 25, 26, 27
12-р бүлэгт	29, 30
13-р бүлэгт	32, 33
14-р бүлэгт	34, 35, 36
15-р бүлэгт	37, 38
18-р бүлэгт	42, 45
19-р бүлэгт	46, 49, 50
20-р бүлэгт	50, 57
21-р бүлэгт	58, 62, 63
22-р бүлэгт	63, 64, 67
23-р бүлэгт	70, 71, 73, 74
24-р бүлэгт	74, 75
25-р бүлэгт	76, 77, 78, 79
26-р бүлэгт	79, 81, 82, 83
27-р бүлэгт	83, 84, 85, 86, 87
28-р бүлэгт	89, 90, 91, 92
29-р бүлэгт	94, 95
30-р бүлэгт	95, 96
33-р бүлэгт	99, 100, 101, 102, 104
34-р бүлэгт	105, 106, 107, 108
35-р бүлэгт	108, 109
36-р бүлэгт	110, 111, 113, 114
37-р бүлэгт	114, 115, 116, 117
38-р бүлэгт	117, 118
40-р бүлэгт	120, 103, 104


Орчуулаагүй бүлгүүд:

Үүнд эх зохиолын 7, 9, 10, 11, 12, 15, 18, 31, 39, 43, 44, 47, 48, 51, 53, 54, 55, 56, 59, 60, 61, 65, 66, 68, 69, 72, 80, 88, 93, 112 –р бүлгүүд багтаж байна. Дээрх өгүүлсэн гол санааг бид нэгтгэн бүдүүвчээр харуулбал, Хасбуу нь 120 бүлэгт эх зохиолын 11%-ийг нь бүрэн орчуулсан, 25%-ийг нь огт орчуулаагүй, 64 %-ийг нь өөрчлөн орчуулж нийт 40 бүлэг болгон хураангуйлсан болохыг ажиглаж болно. Ингэхдээ өөрчлөн орчуулсан хэсгүүдэд зарим талаараа өөрийн үг хэллэгийг нэмсэн байгаа ажиглагдсан ба бүрэн орчуулсан хэсэгт өөрийн үг хэллэг огтхон ч ашиглаагүй нь байна.

Тэрээр Цао Шүэ Чиний “Улаан асрын зүүд” эхийг бүрэн орчуулаагүй шалтгаанаа “Мэдлэг нимгэн би бээр гагцхүү 2 хасын хэрэг явдлыг ишлэн 40 бүлэг болгон орчуулав.”⁴³ хэмээжээ.

Хасбуу нь зохиолын аль хэсгийг өөрчлөх, аль хэсгийг хасаж орчуулах тал дээр өөрийн гэсэн орчуулах зарчимтай байсан нь илт байна. Үүнийг бүлэг бүрийн ард бичсэн цохолбороос харж болно. Тухайлбал, “Энэ судар Бао Юй, Дай Юй хэмээх 2 хасын хувь тавиланг өгүүлжээ. Номын эхний хагас нь энэ хоёр хүний учрал бөгөөд хоёр хүний төгсгөл нь бүхэл бүтэн номын төгсгөл юм.” гэжээ.

Ихэнх судлаачид “Шинэ орчуулсан Хунлоумэн бичиг” нь одоогийн хятад хэлээр



хэвлэгдсэн бүхий л эхтэй /”Улаан асрын зүүд”/ гол утга санаа нь таарч, эх бүтээлийн сэтгэлгээний мөн чанар, уран сайхны хэв маяг нь гайхалтай болохыг баталсаар байна. “Шинэ орчуулсан Хунлоумэн бичиг”-ийн 40-р бүлгийн цохолборт Хасбуу өөрийгөө “Цао Шюэчиний хойч үеийн итгэлт хүн” хэмээн зарлаж “ “Мэдлэг дутмаг” тул Цао Шюэчиний “Улаан харшийн зүүд”-

ийг бүрэн орчуулж эс чадав. Иймд хураангуйлан орчуулсан энэхүү бүтээлээ <Шинэ орчуулсан улаан асрын зүүд> гэж нэрлэв.” хэмээжээ.

Ш. “Шинэ орчуулсан улаан асрын зүүд”-ийн харь үгийн тухайд

Бидний дээр дэвшүүлсэн “Шинэ орчуулсан улаан асрын зүүд” нь хэдийгээр хятадын үргэлжилсэн үгийн зохиолын охь сорыг монгол хэлний уран үгийн шидээр гайхамшигтай орчуулсан байх боловч энэхүү бүтээлд орчуулагчийн амьдарч байсан тухайн нийгэм, цаг үеийн байдлаас шалтгаалан хятад, манж, төвд үг хэллэг багагүй шингэсэн байна. Хасбуу нь эх зохиолд тааралдах бурхан шашны холбогдолтой үг хэллэгийг **төвд** нэрээр, хэргэм зэрэг, албан тушаалын нэр, авгайлсан нэрийг **манж** нэрээр, харин эд агуурстай холбогдох зарим үг хэллэгийг **хятад** нэрээр галиглан буулгасан байна. Бид дээрх бүтээлийн харь үгсийг судлан доорх ажиглалтыг хийвэл:

⁴³ Хасбуу. Шинэ орчуулсан Хунлоумэн бичиг. Бүгдийн хуулал /хуулбар гар бичмэл/.

- a) Хасбуу нь манж чин улсын үеийн монгол үндэстэн зохиолч. Иймд тухайн үед хэрэгжиж байсан засаг захиргааны болоод хэргэм зэргийг илэрхийлсэн нэр, нэршлийг тэр хэвээр нь авч хэрэглэсэн байна.
- b) Бурхны эд агуурс, зан үйлтэй холбоотой үг хэллэгийг эртнээс нааш монголчууд төвд нэрээр нь илэрхийлдэг уламжлал байсаар ирсэн одоо ч байгаа. Иймд энэхүү учир шалтгаан түүнд нөлөөлсөн байх талтай. Гэхдээ орчуулагч тайлбар орчуулгыг зүйж өгч болох байсан гэж үзэж байна.
- c) Орчуулагчийн аж төрж байсан нутаг орны байршил нь түүний хятад үгийг өргөн хэрэглэх нөхцөл болсон. Өөрөөр хэлбэл Хасбуу нь одоогийн Өвөр Монголын зүүн өмнөд нутаг Зостын хошуунд төрж өссөн ба тус бүс нутагт хятад, монгол үндэстэн маш олноор холилдон суурьшсан тул 2 үндэстэн хоорондын соёлын нөлөө харилцан ихээхэн шингэсэн байдаг. Иймд орчуулагч нийгмийн энэ мэт хүчин зүйлээс ангид бүтээлээ туурвих боломжгүй байсан ба зарим эд агуурсын нэрийг хятад нэршлээр нь буулгасан байгаа нь олонтоо ажиглагдсан. / Хүснэгт-3/

Хасбуугийн “Шинэ орчуулсан улаан асрын зүүд” бүтээлээс бид нийт 70 гаруй харь үгийг шүүсэн бөгөөд одоогоор доорх үгсийг онцлон авч үзлээ. Тухайлбал:

Хүснэгт-3. (Хасбуугийн “Шинэ орчуулсан улаан асрын зүүд”-ийн харь үгсийн жагсаалт)

Д.д	Затранскрибированные варианты по Хасбуу	В оригинале	На монгольском языке
1	Жан	丈	хос алд
2	Шан	山	Уул
3	ши ту жи	石头记	чулууны бичиг
4	Фүүрэн	夫人	эзэгтэй (хатагтай)
5	Лаоеэ	老爷	Ноёнтон, авгай (авгайлсан нэр)
6	шэн +/ийн ноён/	省	хошууны ноён
7	жун +/ийн/+ (дуу)	钟声	Хонхны /дуу/
8	бай бань	外班	Алба,хэрэг
9	(цааз) лин	令	(цааз) зарлиг
10	Наймаа	买卖	худалдаа, арилжаа
11	Шяньшэн	先生	эрхэм, ноён
12	Сяожэ	小姐	Авхай
13	Гүнзы	公子	Хөвгүүн
14	шаан цонх	纱窗户	даавуун цонх
15	шян (үүд хаалга)	间 (大门)	хаалгыг тоолох нэгж
16	Пайз	牌子	Хаяг
17	Мөөмөө	嬷嬷	настан (эмэгтэй)
18	Чий	漆	Будаг
19	Мяо	庙	хулу сүм
20	да гөгө	大哥哥	их (том) ах
21	Найнай	奶奶	Эмэг
22	Ляо		хувь /тоолох нэгж/
23	Ший	戏	дуулалт жүжиг
24	чуан (ширээ)	床	ор

25	пай наадах	打牌	хөзөр наадах
26	и няань	姨娘	нагац ээж
27	гү пай	骨牌	Даалуу
28	вэй пин тан	围屏灯	өлгөдөг дэн
29	няань няань	娘娘	ээж (авгайлсан нэр)
30	ван дайпуу	王大夫	Ван эмч
31	Ляо	料 (一料丸药)	багц (нэг курс эм)
32	муши+ (цэцэг)	木樨+ (花儿)	ману цэцэг
33	Шаа	纱	Тор
34	(хоёр) луу	(两)罗	Жад
35	дуан янгийн улирал	端阳节	5 сарын 5ны өдөр
36	туя+(ж)	推	Түлхэж
37	(нэгэн)+ чу ший	(一)+出戏	нэгэн дуулалт жүжиг
38	шаа +(өмд)	纱+(裤子)	торгон өмд
39	Юань	园	хүрээлэн, хүрээ
40	ляо хуа	寥花儿	шимэлдэг цэцэг
41	дан суу	单	нимгэн тэрлэг
42	дийз, пял	茶筌茶孟	цайны аяга, таваг
43	Хайтан	海棠	хайтан цэцэг
44	гүй хуа+ны +(навч)	菊花儿+(叶)	гүй цэцгийн навч
45	Шүн	寻	алд, дэлэм
46	ин+ (гүн улаан)	银红	зосон улаан (өнгө)
47	нэй су шаа	上用内造的	дотуур хүрэм (торго)
48	тин гүй	顶柜	тавиур (эдийн тавиур)
49	Пял	盘	сав, том таваг
50	бай юү чин (хөгжим)	白比目磬	хаш дохиурт хөгжим
51	Лянхуа	莲花	Лянхуа
52	фу эр	副儿	даалууны тоо (2+)
53	фу шөү	佛手	ургамлын үрийн нэр
54	чин жин	青金(de)	цул алтан
55	Чуан	床	Ор
56	Тин	亭	Сүүдрэвч
57	мэй (цэцэг)	梅 (花儿)	сарнай цэцэг

Эдгээрээс авч үзвэл доорх хэд хэдэн онцлог ажиглагдав. Үүнд:

1. Дээрх үгсийн дийлэнх хувь нь үгсийн аймгийн хувьд эд юмсыг нэрлэн заасан нэр үгс байгаа ба чухам ямар ахуйд хэрэглэгдэх эд агуурсыг зааж байгаа нь бидний анхаарлыг ихээхэн татаж байна. Тухайлбал дээр өгүүлсэн цэцэгсийн нэрсийг монгол хэлнээ орчуулан буулгах нь ихэд төвөгтэй. Учир нь эдгээр цэцэгс нь халуун чийглэг оронд ургадаг бөгөөд монгол үндэстний аж ахуйд төдийлөн ашиглагдах нь ховор билээ. Иймд орчуулагч эдгээр цэцэгсийн нэрийг хятад нэршлээр нь галиглан буулгажээ. /улаан өнгөөр ялгасан байгаа/
2. Орчуулагч эдгээр үгсийг монгол хэлний эгшиг, гийгүүлэгч авиаг сэлгэн бүтэн ба хагас галиглан буулгасан байна. Жишээ нь: шэн +/ийн ноён/, гүй хуа+ны +(навч), (нэгэн)+ чу ший, ин+ (гүн улаан), мэй (цэцэг), дуан янгийн улирал, туя+(ж) гэх мэт.

3. Хамгийн сонирхол татсан 1 ажиглалт бол эдгээр 70 гаруйтай харь үгсийн олонх нь нэр үг байсан. Харин цорын ганц хагас галиглан буулгасан үйл үг тааралдав. Өөрөөр хэлбэл, “推-tui /түлхэх/” гэсэн хятад үг дээр монгол хэлний зэрэгцүүлэх, нөхцөлдүүлэн холбох нөхцөл “ж”-г залгаж хагас галиглаж буулгасан байгаа нь сонирхол татав.

ДҮГНЭЛТ

- “Улаан асрын зүүд” бол тухайн үеийн нийгмийн муу муухай, худал хуурмагийг тод илчилсэн, үнэн сайхныг уянгалан сайшаасан бүтээл бөгөөд зохиолын гол судас Бао Юй, Дай Юй нарын хайр дурлалыг өгүүлсэн эмгэнэлт роман юм. Хасбуу нь тус бүтээлийг 40 бүлэг болгон хураангуйлан орчуулахдаа 2 хасын хайр дурлалын түүхийг бүрэн харуулахыг зорьсон. Энэ тухай “Шинэ орчуулсан улаан асрын зүүд”-ийн 22-р бүлгийн цохолборт “Энэ бичгийн их хагас нь даруй энэ 2 хүний учир болой. Энэ 2 хүний эцэс төгссөнийг үзвээс даруй энэ бичгийн төгсгөл болой.” гэжээ.
- Эртний хятад хэлээр бичигдсэн “Улаан асрын зүүд” нь орчуулагчаас ихээхэн уран чадамж шаардсан болох нь дамжиггүй юм. Тэрээр энэхүү бүтээл үе үеийн монгол уншигчдын хүртээл болж монголын орчуулгын уран зохиолын түүхэнд арилшгүй хувь нэмэр оруулсаар иржээ. Тэрээр 120 бүлэгтэй “Улаан асрын зүүд” –ийн 64% -ийг өөрчлөн, 11%-ийг нь бүрэн, үлдсэн 25% -ийг нь орчуулагүйгээр шууд хасаж орчуулсан байна. Бүтээлийг монгол хэлнээ орчуулах явцдаа зүүг сүвлэх, татах, түлхэх, шугам түлхүүр тавих, зураг хөдөлгөх зэрэг монголын орчуулгын уламжлалт аргуудыг өргөн ашиглажээ.
- Хасбуу нь өөрийн бүтээлдээ харь үгийг харьцангуй цөөн ашигласан байна. Энэ нь түүний орчуулгын ур чадвар хэр өндөр байгааг илтгэх мэт. Учир нь Хасбуу нь амьдарч байсан нийгмийн хэл соёлын тэр дундаа хятад, манж хэлний нөлөөг тун бага тусгаж, тэр нөлөөнд төдийлөн автаагүй байгаа нь түүний орчуулгын уран чадвар хэр өндөр байгааг илтгэж байна.

Ийнхүү Хасбуу нь тухайн цаг үеэ байлдан дагуулсан нэртэй орчуулагч байсан төдийгүй түүний монгол хэлнээ орчуулан буулгасан “Шинэ орчуулсан улаан асрын зүүд” бүтээл нь орчин үеийн хэл шинжээчид болон утга зохиол судлаачдын анхаарлын төвд байж оньсого мэт олон нууцыг агуулсан тул эрдэм шинжилгээний эргэлтэд далайцтай оруулан цаашид эрчимтэй судлах хэрэгтэй хэмээн онцлон тэмдэглэж байна.

НОМЗҮЙ

Эх сурвалжууд:

1. “Хунлоумэн” нар бичмэл, Монгол улсын үндэсний номын сан
2. “Шинэ орчуулсан хунлоумэн бичиг” гар бичмэл, Өвөр Монголын номын сан

3. “Шинэ орчуулсан хунлоумөн бичиг” гар бичмэл, Өвөр Монголын Их сургуулийн номын сан
4. “Шинэ орчуулсан хунлоумөн бичиг” гар бичмэл, Өвөр Монголын хэл соёл, түүхийн хүрээлэнгийн номын сан

Бүтээлүүд:

1. 曹雪芹著：无名氏续：程伟元、高鹗整理：《红楼梦》人名文学出版社，2008年。
2. 魏绍昌：《红楼梦版本小考》中国社会科学出版社，1982年。
3. 杜春耕：《〈红楼梦〉版本概述》黑龙江教育出版社，2003年。
4. 《哈斯宝研究论文集》内蒙古文化出版社，1987年
5. Я.Ганбаатар “Нангиадын сонгодог утга зохиолын товчоо” УБ, “Эдмон” хэвлэлийн газар, 2006 он.
6. М.Чимэдцэеэ “Монгол хэлэнд орчуулагдсан Хятадын сонгодог уран зохиолын судалгаа”, 2008 он С.Дулам “Дорно дахины уран зохиолын үүд” УБ, 2004 он.

ЭШ-ний өгүүлүүд:

1. 巴·格日勒图，《蒙古文论精粹》，内蒙古大学报，1985年。
 2. 宝音贺希格《哈斯宝“新译红楼梦”年代考》，内蒙古大学学报（哲学社会科学版），1978年，第1期
 3. 巴·格日勒图《关于哈斯宝的〈新译红楼梦〉及其它》，内蒙古大学学报（哲学社会科学版），1976年，第1期
 4. 巴·格日勒图：《论哈斯宝在蒙古文学中的历史地位》：内蒙古大学学报（哲学社会科学版），1988年，第2期。
 5. 扎拉嘎：《哈斯宝生平考略》：《民族文学研究》，2004年4月。
- 周双利：《哈斯宝和他的〈小红楼梦〉》，内蒙古民族师院学报，1995年。

ОРЧУУЛГЫГ ДААТГАЯ⁴⁴

М.Амартайван⁴⁵

요약: 언어와 문화, 그리고 사고방식의 연결고리를 명확하게 보여주는 문학번역을 가볍게 여겨서는 안 된다. 지난 20 년간 많은 문학작품이 한국어에서 몽골어로 번역되었지만 번역비평이 턱없이 부족한 실정이다. 특히 번역가를 양성하는 대학에서는 번역훈련의 개선에 특별한 관심을 기울여야 하며 번역작업에 대한 연구와 토론을 정기적으로 수행하고 번역비평이 활발하게 이뤄져야 한다. 또한 번역단계를 건너뛰지 않고 철저히 지켜야만 한다.

Түлхүүр үг: орчуулгын шүүмж, орчуулгын алдаа, солонгос хэлний орчуулга, сэтгэлгээний онцлог, соёлын ялгаа, орчуулах үе шат

Орчуулга, орчуулагчийн тухай олон янзаар тодорхойлдог. Тэдгээрээс уран зохиолын орчуулгад илүү хамаатайг дурдвал “Орчуулга мөсөн дээр гулгаж байгаа юм шиг амархан уншигдах ёстой” (Ж.Нэргүй)⁴⁶, “Зохиолчийн урыг гүйцэхгүйн шаналан их хэцүү” (Х.Мэргэн)⁴⁷, Орчуулагч хүн бол “соёлын жинчин” (Б.Ринчен)⁴⁸ гэдэг. Эдгээрийг нэгтгэн тайлбарлавал, орчуулагч хүн харилцан адилгүй соёлыг холбон зорчих соёлын жинчний хувьд мөсөн дээр гулгаж байгаа мэт хялбархан уншигдахаар орчуулахын төлөө мэрийвч зохиолчийн урыг гүйцэхгүйн шаналан тун хэцүү байдаг ажээ.

⁴⁴ Анх цахим орчинд ижил нэртэй нийтэлж байсан агуулга(Одоо дараах нэр хаягаар уншиж болно. “Орчуулгыг даатгая” 2014-03-21 <http://www.bolod.mn/>)-аа эргэн нягтлаад зарим хэсгийг нэмж дэлгэрүүлэв. Мөн ОУУБИС-ийн “Хэл-соёл, боловсрол судлал” салбарын хуралд 2023 оны 3 сарын 21-нд илтгэн хэлэлцүүлэв.

⁴⁵ ОУУБИС, Солонгос хэл соёлын тэнхимийн багш, магистр

⁴⁶ Ж.Нэргүй: Орчуулга гэдэг мөсөн дээгүүр гулгаж байгаа юм шиг уншигдах ёстой, 2010-05-05, Цаг төр сэтгүүл (www.tsagtur.mn)

⁴⁷ Х.Мэргэн: Зохиолчийн урыг гүйцэхгүйн шаналан их хэцүү, 2015-11-26 (<https://gogo.mn/>)

⁴⁸ Я.Ганбаатар: Орчуулга бол бие даасан мэргэжил, цогц шинжлэх ухаан, нэгэн зүйл урлаг, Өнөөдөр сонин, 2020-08-06 (<https://www.unuudur.mn/>)

Сэтгэлгээний өвөрмөц хэв маяг, онцлог шинж, төрх байдал нь хэлээр дамжин илэрч, тухайн үндэстний өвөрмөц соёлыг бүрдүүлдэг. Сэтгэлгээ тийнхүү хэлэнд тусаж хэлээр дамжин илэрч, алив нэгэн соёлыг бүрдүүлдэг бол соёлын хөгжил цэцэглэл нь хэлийг улам баяжуулж, хэл баяжсанаар сэтгэлгээний цар хүрээ өргөжин тэлдэг зүй тогтолтой ажээ. Тиймийн учир үндэстний сэтгэлгээ үгүй аваас хэл үгүй, хэл үгүй аваас соёл үгүй хэмээдэг. Аливаа нэг улс үндэстнийг сайтар таньж мэдсүгэй хэмээвээс тухайн хэлт үндэстний сэтгэлгээ, соёлыг нь, тэрхүү сэтгэлгээ соёлын ялгаа зөрөөг сайтар таньж мэдэх нь туйлын чухал хэмээхийн учир үүнд оршино (М.Чимэдцэеэ, 2013:58). Энэчлэн хоёр орны сэтгэлгээний онцлог, соёлын ялгааг нарийн тусгадаг, орчуулагчийн ур ухааныг сорьдог уран зохиолын орчуулгад хэрхэвч хөнгөн хуумгай хандаж болохгүй.

Солонгос судлаач Г.Эрдэнэчимэг, “Сүүлийн хорь гаруй жилд солонгос хэлтэй орчуулагч, судлаач олширч, Солонгосын уран зохиолын 400 гаруй бүтээлийг монгол хэлээр орчуулсан ч орчуулгын шүүмж бараг гарсангүй” (2021:134) гэж нэгэн өгүүлэлдээ бичсэнчлэн мэргэжлийн орчуулагч бэлддэг их дээд сургуульд сургалтаа чамбайруулахад онцгой анхаарч, орчуулгын бүтээлүүдийг судалж, хэлэлцэх ажлыг тогтмол өрнүүлж, орчуулгын шүүмжийг дэлгэрүүлэх хэрэгтэй байна. Энэ үйлсэд өчүүхэн цучил нэмэхээр арваад жилийн өмнө бичсэнээ эргэн нягталж олон хүнд хүргэхээр сэтгэл шулуудлаа.

Орчуулгыг эхтэй тулгаж үзэх болсон шалтгаан

1985 онд Солонгосын утга зохиолын тавцанд “Өвлийн ёгт үлгэр” зохиолоороо анх хөл тавьсан зохиолч эмэгтэй Шинь Гёнсүг 신경숙 (申京淑) эдүгээ нэгэн жарны босгыг давж байна. Тэрээр 2011 онд Солонгосын соёл урлагийн шагнал, 2012 онд Азийн утга зохиолын шагнал хүртсэн авьяаслаг нэгэн ажээ. 2008 онд хэвлүүлсэн “Ижийгээ даатгая” **엄마를 부탁해** романаараа дэлхий дахинд нэрээ дуурьсгаж, энэхүү зохиолыг нь дэлхийн хорь гаруй орны хэлээр орчуулагджээ⁴⁹. Монголд 2012 оны намар “Эжийгээ даатгая” нэрээр монгол орчуулга нь гарсан юм.

Энэ романыг Suren блогийн⁵⁰ эзэн Сүрэн 2011 онд уншсан шилдэг ном хэмээн шалгаруулаад⁵¹ уулзсан ярилцсан хүн болгондоо унш гэж зөвлөөд зогсохгүй монгол

⁴⁹ 이지현, 한국어 힌디어 번역 오류 분석: 한국어 소설 “엄마를 부탁해”의 힌디어 번역을 중심으로, 인문사회 21, 2019, vol.10, no.1, 통권 32 호 pp.1503-1514.

⁵⁰ Suren блог (<https://surensuren.blogspot.com/>)

⁵¹ Сүрэн энэ зохиолын тухай бичсэн нь:

Нэгэн өдөр Сөүлийн буудал дээр ээж алга болоход бүгд ээжийнхээ эрэлд гарна. Дөрвөн хүүхэд аавтайгаа хамт ээжийгээ хайхдаа өнгөрсөнөө санаж, дурсаж, гэмшиж, ээжийнхээ тухай, өөрсдийнхөө тухай олныг бодож эргэцүүлнэ. Зохиол таван хэсгээс бүрдэнэ: 1) зохиолч охины өгүүлэл, 2) компанид ажиллах хүүгийн өгүүлэл, 3) эхнэртээ бүгдийг даатган амьдрах аавын өгүүлэл, 4) алга болсон ээжийн өгүүлэл, 5) төгсгөл хэсэг буюу дахиад зохиолч охины өгүүлэл. Сонирхолтой нь зөвхөн ээж л “би” хэмээн нэгдүгээр биеэс өөрийнхөө тухай ярина. Охин, аавын

уншигчдад танилцуулах зорилгоор зохиолын зарим хэсгийг англи, япон орчуулгаас харгуулан монголоор дам орчуулж блогтоо нийтэлж байсан болохоор(Suren блог, 2012)⁵² түүнтэй уг номын монгол орчуулгын тухай ярилцаж санал солилцсон юм. Сүрэн, “Англи, япон орчуулгатай тулгахад орчуулгын алдаа нэлээд ажиглагдсан. Гэхдээ би солонгос хэл мэдэхгүй учир үгний сонголт, орчуулгын утгын алдаанаас илүү дараах дөрвөн асуудал(1. Аавын хэсгийг “та” гэх ёсгүй, 2. Олон анхаарлыг тэмдэг, 3. Замбараагүй цуваа цэг, 4. Зохиолын төгсгөлийн өгүүлбэрийг тусдаа мэт сэтгэгдэхээр салгаж бичсэн)-ыг хөндмөөр байна.” гэснийг тулгаж үзэхэд бүгд ортой байв. Тэгээд орчуулгын эхнээс л өөр алдаа ажиглагдлаа.

<p>오빠 집에 모여 있던 너의 가족들은 궁리 끝내 전단지를 만들어 엄마를 잃어버린 장소 근처에 돌리기로 했다. 일단 전단지 초안을 짜보기로 했다. 옛날 방식이다. 가족을 잃어버렸는데, 그것도 엄마를 잃어버렸는데, 남은 가족들이 할 수 있는 일은 몇가지 되지 않았다. (10 쪽)</p> <p><u>Ахынхаа гэрт цугласан танайхан нухацтай бодсоны эцэст тараах хуудас хэвлүүлж эжийнхээ төөрсөн газрын эргэн тойронд наахаар болж эхний ээлжид тараах хуудасныхаа эхийг бэлтгэх ажил оров. Гэр бүлийн хүнээ алга болоход тэр тусмаа эжийгээ алга болоход үлдсэн гэрийнхэн нь хийж чадах зүйл гэвэл хэдхэн л байлаа. (8)</u></p>	<p>“Танайхан ахындаа цуглаад” Солонгос үгийн утга нь “эргэн тойрон” биш, “ойр хавь” буюу 근처 ажээ. Бас солонгост хаа дуртай газраа зар нааж болдоггүй, 전단지를 만들어 돌리다⁵³ гэж байгаа учир “тараах” гэх нь ойр юм.</p> <p>Зар яаж бичихээ л ярилцаж байгааг “эхийг бэлтгэх ажил” гэдэг нь албархуу болгожээ. “... эхийг бэлдэхээр болов”</p> <p>“Ижийгээ олъё гэхэд бидний хийж чадах зүйл бараг байсангүй.”</p> <p>옛날 방식이다. “Хуучны арга.” гэсэн өгүүлбэрийг орчуулаагүй орхижээ.</p>
--	---

Иймд Сүрэнд зөндөө анзаарагдсан гэх бас бус алдааг олж мэдэхээр орчуулгыг эхтэй нь тулгаж агуулга, хэлбэрийн алдаа гэж ангилаад тоймлон өгүүлэхээр шийдэв.

Хэлбэрийн алдаа

хэсэг нь хоёрдугаар биеэс (өөрийгөө “чи” гэх өгүүлэл), хүүгийн хэсэг нь гуравдугаар биеэс (“тэр ингэжээ” г.м.) бичигдсэн нь зохиомжийн нэг онцлог. (Шинь Гёнсүг "Ээжийгээ даатгая" IV (төгсгөл) - 2012/05/21)

⁵² Сүрэнгийн блог дахь энэ сэдэвт холбогдох сэтгэгдэл, орчуулгууд

"Ээжийгээ даатгая" – гайхав 2014/01/15 (“Ээжийгээ даатгая” номын монгол орчуулгын талаарх Сүрэнгийн сэтгэгдэл)

Шинь Гёнсүг "Ээжийгээ даатгая" I - 2012/04/05 (Сүрэнгийн орчуулга. Охины хэсэг)

Шинь Гёнсүг "Ээжийгээ даатгая" II - 2012/04/17 (Сүрэнгийн орчуулга. Хүүгийн хэсэг)

Шинь Гёнсүг "Ээжийгээ даатгая" III - 2012/05/15 (Сүрэнгийн орчуулга. Ээжийн хэсэг I)

Шинь Гёнсүг "Ээжийгээ даатгая" IV (төгсгөл) - 2012/05/21 (Сүрэнгийн орчуулга. Ээжийн хэсэг II)

⁵³ 돌리다 гэдэг үгний 8 дахь утга нь “тараах”. 국립국어원 한국어-몽골어 학습사전 Солонгосын Үндэсний хэлний Хүрээлэнгийн Солонгос-Монгол сургалтын толь бичиг (<https://krdict.korean.go.kr/>)

<p>-그럼 얼마를 적을까요? / -백만원? / - 그건 너무 적어요./ -삼백만원? / -그것도 적은 것 같은데? (14 쪽)</p> <p>- Тэгвэл хэд гэж бичих вэ? / -Сая вон? / -Тэр чинь бага байна аа. / -Гурван сая вон? / - Тэр ч бас <u>бага юм шиг байна даа?</u> (12)</p>	<p>“... бага юм шиг байна даа.” Асуултын тэмдэг хэрэггүй. Бас “Тэр чинь, тэр ч” илүүджээ. Солонгос хэлээр л энэ мэт төлөөний үгтэй ярьж бичнэ. Солонгос хэлний “тэр” гэснийг монголоор “энэ” гэж орчуулах ч эвтэйхэн үе таардаг.</p>
<p>한 인간에 대한 기억은 어디까지일까. 엄마에 대한 기억은? Хэн нэгний тухай <u>аль</u> <u>хүртэл нь санах бол.</u> Тэр тусмаа <u>эжийнхээ</u> <u>тухай дурсамжийг?</u> (15)</p>	<p>“Ер нь хүмүүс хэн нэгнийг хэр их дурсан санадаг бол? Тэр тусмаа ижийгээ.” Солонгос, монгол хэлэнд асуултын тэмдгийг өөрөөр хэрэглэдэг нэг жишээ.</p>
<p>엄마가 글을 읽을 줄 모른다는 것을 너는 언제 알았을까.(21 쪽)</p> <p>Чи анх хэзээ эжийгээ бичиг үсэг тайлагдаагүйг нь мэдлээ. (18)</p>	<p>“... хэзээ ... мэдлээ?” Солонгос хэлний зөв бичих дүрэмд сулхан асуулт бол асуултын тэмдэг тавихгүй, гарчиг, урианд асуултын тэмдэг хэрэглэхгүй гэж бий.⁵⁵ Монгол хэлэнд асуултын тэмдэг хэрэгтэй.</p>

Баймжит бүтээврийг өмнөх үгтэй холбож бичсэн нь:

<p>Энэ талд “Ах аа!” гэж эхэлж ороод, хэдэн мөрийн дараа “<u>Ахаа!</u>”, “Ах аа!” бас хэдэн өгүүлбэрийн дараа “<u>Ахаа!</u>” гэжээ. (33)</p>	<p>“Ах аа!” Дуудах утгатай “аа, ээ, оо, өө” баймжит бүтээврийг өмнөх үгээс нь салгаж бичдэг. “Ахаа” гэвэл “ахыгаа” гэсэн утгатай. Бас энэ олон хос анхааруулга их эвгүй харагдана. Дан байх учиртай.</p>
<p><u>Үгүй ерөө</u>, (194)</p>	<p>“Үгүй ер.”, “Үгүй ер өө.”, “Үгүй ер дөө”. Энэ орчуулгад “Битгий хараа. Ерөө.” гэж ойлгогдохоор байна.</p>

Агуулгын алдаа:

Цааш нь агуулгын алдааг нөхцөл буруу хэрэглэсэн, оноосон нэр ба жинхэнэ нэр буруу орчуулсан, зүйрлэл үгчилсэн, аялга үг, дуурайх дүрслэх үг хуулбарласан, үг буруу сонгосон, зохимжгүй найруулсан гэж багцалж авч үзье.

Нөхцөл буруу хэрэглэсэн нь

<p>엄마가 곁에 있을 땐 까마득히 잊고 있던 일들이 (17 쪽) Чи эжийгээ хажуудаа байхад нь анзааралгүй өнгөрүүлж байсан зүйлсүүд...(15)</p>	<p>Зүйлсүүд? Олон тооны нөхцөл давхардуулсан байна. Зүйлс гэхэд болно. Утгаараа “Ижийнхээ дэргэд байхдаа анзаараагүй бүхэн” гэвэл зүгээр мэт. Нөхдүүд, газрууд гэхгүй, нөхөд, газар гэнэ.</p>
<p>서울의 이 많은 집들마다 초인종 눌러가며 혹시 여기 우리 어머니 안 계시냐고</p>	<p>“Олон айлын хонх” Европ хэлнийх шиг “нүднүүдээс нулимснууд унацгаалаа” гэхгүй.</p>

⁵⁵ Солонгос хэлний зөв бичих дүрэм 한글 맞춤법 <https://www.law.go.kr/>. Цэг цэглэлийн тухай заалтууд хавсралтад байдаг.

물어요? (135 쪽) Сөүлийн энэ олон айлуудын хонхнуудыг дараад “Нөгөө нэг, танайд манай ээж байхгүй биз гэж асуух уу?” (127)	Түүнчлэн айлаас хүн сураглахдаа төвөг удаж байна гэж бодвол “Уучлаарай” л гэх байх.
1938 년 7 월 24 일생이라고 엄마의 생년월일을 적는데 (11 쪽) Чи 1938 оны 7 сарын 24 ны өдөр төрсөн гэж эжийнхээ төрсөн он сар өдрийг бичтэл (8)	“24-ний өдөр” ⁵⁶ “Чамайг... бичтэл” Уг орчуулгад “чамайг”, “чинь” гэж бичиж болох хэсэгт “чи” гэж орчуулжээ.
공장과도 같았다. 장이 담가지고 청국장이 발효되고 쌀이 찜어지는. Багахан үйлдвэр шиг л байлаа. Жан <u>хийгдэж</u> , буурцагны жан исэж, будаа <u>бутлагддаг</u> тийм л үйлдвэр. ... (10)	“Жан исгэж, будаа тээрэмддэг үйлдвэрийг санагдуулав.” “Үзэгдэх, харагдах, сонсогдох, амтагдах, бодогдох, санагдах” гэх зэрэг мэдрэхүйд өртөх үйлийг илэрхийлснээс бусад тохиолдолд солонгос хэлний бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийн нөхцөлийг монголоор өөрөө үйлдэх, бусдаар үйлдүүлэх хэвээр орчуулах нь тохиромжтой байдаг.
Бие засах өрөө <u>жижиг талдаа</u> . (88)	“Бие засах өрөө жижгэвтэр.” Солонгос хэлний –은 편이다 нөхцөлийг “-втар”, “-дуу” гэж орчуулах нь эвтэйхэн.

Оноосон нэр, жинхэнэ нэр буруу орчуулсан нь:

“Сүүлчийн эзэн хаан” кинон дээр гардаг хөгшин <u>Фу И</u> бага насаа өнгөрүүлсэн хааны ордондоо... (17)	Энд гарч байгаа Манжийн хааны нэр ханзаар 溥儀, солонгосоор 푸이, латинаар Puyi. Иймд монголоор Пү И гэнэ. Солонгос хэлээр п, ф, бас л, р, тэгээд в, б-г ижил галигладаг нь гадаад хүний нэрийг солонгосоос монголоор орчуулахад ярвигтай, нэмж тодруулах хэрэгтэй болгодог.
택시를 타고 서오릉 어디계로 가서 ... таксинд суугаад <u>Соурин Одигэ</u> руу очиж (245)	“Соурин одигэ – Гёнги аймгийн Гуяан сумд байдаг газрын нэр” гэж тайлбарлажээ. 서오릉(西五陵) “Баруун таван бунхан” буюу Жусоны үеийн вангийн бунхан байдаг газар. 어디계로 гэдэг нь 어디쯤 “хаа нэгтээ”. “... таксигаар Баруун таван бунхан тийшээ очиж”
미켈란젤로 <u>Михиал Анжело</u> (250)	“Микеланжело”
평양 Пехьян. (212)	Орос галигийг дагаж Пхеньян гэлгүй солонгос дуудлагад ойртуулья гэвэл Пён-ян гэж болно. Харин Г.Эрдэнэчимэг, Б.Сумьяабаатар нарын эрдэм шинжилгээний

⁵⁶ Тоо тодотгол болон орсон нэг жишээг энд дурдъя. “69-н настай.” (10) гэж байгааг угтаа “69 настай” гэхэд болно. Ард нь нөхцөл ороогүй бол үгийн үндсийг илтгэх тогтворгүй “н”-ийг бичдэггүй.

	бүтээлд түлхүү хэрэглэдэг галигаар бол “Пхйөн-йан”, Пхен-ян. ⁵⁷
성모 <u>Гэгээн Сонму эхийн хөшөө...</u> (229) Гэгээн эхийн баримал (125)	“Гэгээн эх”, “Гэгээн Мариа” Орчуулгад нэгдмэл чанар гэж байх ёстой. Нэг нэрийг нэг зохиолд хэд хэдэн янзаар орчуулаад байж болдоггүй. 125-р талд зөв орчуулсан хэрнээ 229-р талд Сонму гэдэг солонгос хүний нэр шиг болгожээ.
Хёнчолийн <u>аав</u> аа (238)	Солонгосчууд ингэж дууддаг нь үнэн. Гэхдээ монголд эр нөхрөө яаж дууддаг ёсоор орчуулбал зүгээр. “Та” гэж хүндэлдэг бол “та”, “чи” гэдэг бол “чи”. “Хань”, эхнэрээ “хонгор” ч гэнэ. Бүр заримдаа “хөгшин”, “өвгөн” гэдэг.
귀뚜라미 (19 쪽) <u>тэмээлзгэнэ</u> (17)	“хүрэлзгэнэ” Амьтан ургамлын нэрийг ч ахин дахин нягталж байлтай. Ялангуяа латин нэрээр нь тулгаж харах, мэргэжлийн толиос лавлах чухал байдаг.

Зүйрлэл үгчилсэн нь:

엄마!하고 부르면 뒤돌아보는 너의 엄마의 우직한 소 같은 눈엔 눈물이 그렇그렇 고여 있었다. Эжий!! гэхэд эргэн харахад нь <u>үнээний нүд шиг том алаг нүдэнд</u> нь дүүрэн нулимс цийлэгнэсэн байлаа. (21)	Монголчууд хүний нүдийг үнээнийхтэй зүйрлэдэггүй. Тугал алаг нүд гэж харин бий. Энд бол “торомгор алаг нүд” бололтой.
어찌나 이마를 강하게 찌푸렸는지 미간에 굵은 철사 같은 주름이 쳐 있었다.(30 쪽) Духаа байдгаар нь үрчийлгэн хоёр хөмсөгнийх нь хооронд <u>төмөр шиг зузаан үрчлээ</u> гарчихсан байв. (27)	Солонгос эхдээ “төмөр утас шиг зузаан үрчлээ” гэсэн боловч монголоор “Хөмсгөө байдгаар нь зангидсанаас хөмсөгний хооронд гүн үрчлээ тогтжээ” гэвэл болох мэт.
이모는 년 네 에미랑 국화빵이다! 했다.(32 쪽) Чи эжийтэйгээ <u>удвал цэцгийн жигнэмэг шиг!!</u> гэдэг байлаа. (29)	“Удвал цэцгийн жигнэмэг” гэж солонгосчууд “яг адил” гэдгийг зүйрлэн хэлдэг хэллэг. Монголчууд “усны дусал шиг адилхан” гэдэг.

Аялга үг, дуурайх дүрслэх үг хуулбарласан нь:

⁵⁷ Г.Эрдэнэчимэгийн “Солонгосын түүх – Дэд дэвтэр” номын хавсралт 16-31-р талд оруулсан “Солонгос оноосон нэрийг кириллээр галиглах нь”-ыг үзнэ үү. Энэхүү түүхийн номын хавсралтын индекс хэсэг 8-р талд “Пхйөн-ян” гэж галигласан байх бөгөөд, “йө, е” эсвэл “йа, я” аль нэгийг нь ижилсүүлж сонгох нь зөв гэж үзсэн учир Пхйөн-йан, Пхен-ян-ы аль нэгээр бичих нь зүйтэй болов уу.

<p>그들이 와아, 웃었다. (42 쪽) Тэд, - <u>Оо</u>, гээд инээцгээлээ. (39)</p>	<p>Аялга үгийг хэд хэдэн удаа уулга алдмаар орчуулсан байна. Монголоор “нирхийтэл инээх” гэнэ.</p>
<p>하지만 책이라든가 영화티켓이라든가 그런 거면 어?하고 가만 들여다볼 것 같은데. (99 쪽) <u>Үүний</u> оронд ном, киноны тасалбар ч юмуу өгвөл “<u>Өөн?</u>” гээд л тогтож нэг харна шүү дээ. (92)</p>	<p>“Ямар гоё юм бэ?”, “Хүүе ээ.” гэж утга дүйцүүлж болмоор санагдана.</p>
<p>-아니오, 잃어버렸소. / -네에? (142 쪽) - Үгүй ээ, төөрчихсөн. / -<u>Юу үү?</u> (131)</p>	<p>“Юу гэнэ ээ?”, “Яалаа гэнэ ээ?”</p>
<p>얼굴을 두 손으로 벽벽 문질렀다. (147 쪽) Нүүрээ хоёр гараараа <u>паг паг</u> үрлээ. (137)</p>	<p>“... ширүүн үрлээ.” “... ширүүн гэгч нь үрлээ.”</p>
<p>딸이 참지 못하고 수화기 저편에서 어- 어어어 소리내어 울었다. (198 쪽) Охин харилцуурын цаанаас тэвчилгүй <u>ын-ын</u> гээд уйлж эхэллээ.(185)</p>	<p>“... цурхиран уйллаа.” “... эхэр татан уйллаа.”</p>

Үг буруу оноосон нь:

<p>태어나서 백일을 넘기지 못하고 죽는 아이들이 많아서 이삼년 키워본 다음 <u>호적</u>에 올렸다는 것이다. (11 쪽) Төрөөд зуу ч хонолгүй нас барах тохиолдол их байсан болоод төрсний дараа хоёр гурван жилийн хойно <u>ургийн бичигтээ</u> бүртгүүлдэг байсан гэлээ. (9)</p>	<p>Энд ургийн бичиг гэж андуурсан <u>호적</u> утга бол өрхийн бүртгэл. Солонгост 2008 он хүртэл хэрэглэж байжээ. Одоо гэр бүлийн бүртгэлд бүртгэдэг.⁵⁸</p>
<p>다 모이면 <u>직계</u>만 스물둘이었다. Бүгдээрээ цуглавал <u>ач зээ нийлээд</u> хорин тавуулаа болно. (9)</p>	<p><u>직계</u> гэсэн үг “төрлийн хүн” буюу өвөө эмээ, аав ээж, үр хүүхэд, ач зээг хамруулдаг. Энд ээж нь настай хүн болохоор ач зээ нийлээд гэсэн нь ноцтой алдаа биш боловч ээж нь залуу хүн байсан бол аав ээж, өвөө эмээг нь орхисон болно.</p>
<p>엄마의 <u>회초리</u>질은 매서웠다. Эжийгийн <u>ташуурдах</u> аймаар байлаа. (95)</p>	<p><u>회초리</u> нь хулсан саваа. Бэрээ, торлог ч гэж болно.</p>
<p>홍어 <u>껍질</u>을 벗기다가 (27 쪽) дэвүүрт <u>загасны хальсыг</u> хуулж байгал (24)</p>	<p>“... загасны хайрс хусах” “... хайрс цэвэрлэх”</p>
<p>... эрт цагийн <u>дурсамжууд ар араасаа</u> <u>сөхөгдөж</u> эхэллээ. (112)</p>	<p>“дурсамж хөвөрч”</p>

⁵⁸ 한국민족대백과사전 <https://encykorea.aks.ac.kr/> (검색어: 호적)

<p>딸의 침대 아래 요를 깔고 등을 모로 세우고 (133 쪽) ... орны урдуур гудас дэвсэн нуруугаараа хажуулдан (125)</p>	<p>“хажуулдан”</p>
<p>그의 어머니의 꿈을 좌절시킨 것이라고는 생각지 못했다. (137 쪽) эжийнхээ хүсэл мөрөөдлийг ч давхар үнсэн товрог болгож орхисон юм гэдгээ төсөөлж ч байсангүй. (128)</p>	<p>“хүсэл мөрөөдлийг баллаж хаясан”</p>
<p>너는 ... 계요리를 먹고 있었다. (20 쪽) Чи ... хавчаар хийсэн хоол зооглож байлаа. (18)</p>	<p>Чи “зооглох” гэж хүндэтгэлийн үгээр орчуулах учиргүй. Одоогийн бид “Надад таалагдаж байна” гэж өөрийгөө хүндэлдэг болчихсон. Энэ нь “Би үүнийг түүнийг таалж байна” гэснээс ялгаагүй.</p>
<p>그는 등을 펴고 고개를 뒤로 젖혀봤다. (113 쪽) Тэрээр нуруугаа тэнийлгэн толгойгоо хойш үрэв. (104)</p>	<p>“Тэрээр нуруугаа цэхэлж, толгойгоо гэдийлгэлээ.”</p>
<p>8-н пён – 1 пён 9м (88)</p>	<p>Пён бол талбайн нэгж. Тэгэхээр метр байж таарахгүй. 1 пён нь 3.3м².</p>

Зохимжгүй найруулсан нь:

<p>한껏 멋을 낸 모습이였다. (13 쪽) ... гоёхын дээдээр гоёсон төрхтэй байсан юм. (10)</p>	<p>“гоёхын дээдээр гоёсон” Орчуулагч солонгос хэлний 모습 гэсэн үгийг нэлээд олон удаа “махчилж” илүүдүүлжээ.</p>
<p>Эжий гэрийнхнийгээ ирэхийг хүлээнгээ зах гарч танилтайгаа уулзах, эсвэл тосгоныхоо хүмүүстэй энэ тэрхнийг ярихдаа цоглог байж басхүү гайхуулах байрын хөдөлгөөн гаргадаг байлаа. (9)</p>	<p>“Ижий гэрийнхнээ ирэхийг хүлээх зуур зах гарч танилуудтайгаа, тосгоныхонтой таарвал энэ тэрийг сэтгэл хөөрөн ярьдаг нь сайрхаж байгаа мэт санагддаг байв.”</p>
<p>해볼 수 있는 일은 다 하고 있어. (15 쪽) Бид хийж чадах бүхий л боломжоо ашиглаж байна даг. (13)</p>	<p>“Бид чадах бүхнээ л хийж байна.”</p>
<p>엄마의 실종을 어떻게 풀어나가야 할지 상의하러 모였다가 (15 쪽) Танайхан эжийнхээ төөрсөн асуудлыг яаж шийдэх талаар ярилцах гэж цуглаад (13)</p>	<p>“Ижийгээ хэрхэн олох талаар ярилцах гэж цуглаад”</p>
<p>너는 입을 다물었다. 너는 어머니를 잃어버린 나흘 후에나 알았으니까. (16 쪽) Чи дуугарсангүй. Чи эжийгээ төөрсөн гэдгийг нь дөрөв хонож байж л мэдсэн учраас. (14)</p>	<p>“Ижийгээ төөрснийг дөрөв хоногийн дараа л мэдсэн болохоор чи үг дуугарсангүй.” Солонгос хэлээр шалтгааныг нь ингэж сүүлд хэлж бичих нь элбэг. Монголоор орчуулахдаа аль болох шалтгааныг нь эхэнд нь оруулбал эвтэйхэн санагддаг.</p>
<p>행주질을 하는 너의 어머니의 입에서는 노래가 흘러나왔다.</p>	<p>“Ижий юм арчиж цэвэрлэж байхдаа амандаа байнга дуу аялна.”</p>

Тэгж арчиж байхдаа <u>байнгын</u> амандаа дуу аялна. (21)	
웃을 수만 없는 게 아니라 울지도 못할 정도였다. (37 쪽) Үгүй ээ, инээж ч чадахгүй гэхээсээ илүүтэйгээр уйлж ч чадахгүй байсан юм. (33)	“Үнэндээ инээх ч хэцүү, уйлах ч хэцүү байв.” “Инээх нь бүү хэл, уйлахад ч бэрх байв.”
박수소리가 들리고 너는 네 손에 들린 책을 가지고 자리로 돌아왔다. (41 쪽) Чи <u>алга таших чимээтэй хамт</u> номоо барин <u>суудалдаа эргэн суулаа</u> . (37)	“Хүмүүс алга ташихад чи гартаа ном барьсаар байрандаа эргэн ирлээ.”
그러나 너의 생각은 지난가을에 조각이 났다. (26 쪽) Гэвч <u>чиний итгэж байсан тэр зүйлс</u> өнгөрсөн намар <u>хэлтэрхий болон бутарч</u> билээ. (23)	“Итгэж байсан бүхэн чинь ноднин намар талаар өнгөрч билээ.”

Дам орчуулгатай харьцуулахад:

Одоо харин солонгосоос монголоор орчуулсан хоёр жишээг Сүрэнгийн англи, япон хэлнээс дам орчуулсантай харьцуулъя.

누구이기에 저리 반가운 걸까? 궁금해 너도 뒤따랐다. Хэн болоод тэгж баярладаг байна аа? гэсэн бодлоор чи ч бас даган гарлаа.	Эжийн сэтгэл юунд ингэж хөдлөө вэ? Сониуч зандаа хөтлөгдөн дагаж гартал... (Сүрэнгийн орчуулга)
엄마에게도 열두살 혹은 스무살이 있었다는 것을 상상해본 적이 없었다. 너는 처음부터 엄마를 엄마로만 여겼다. 처음부터 엄마로 태어난 인간으로. ... арван хоёр настай үе, бүр хорин настай үе байсан талаар төсөөлж ч байгаагүй юм байна. Чи анхнаасаа л “Эжий” бол эжий гэж тэр хэвээр нь л бодож ирсэн болохоор.	Эжид ч гэсэн ... арван хоёр, бүр хорин настай үе байсан гэдгийг тэр өдөр хүртэл ерөөс төсөөлөөгүй явж. Ээж бол үргэлж ээж. Төрөхөөсөө л ээж байсан. (Сүрэнгийн орчуулга)

Солонгос хэлнээс нь англи, японоор сайн орчуулсныг уншаад тухайн англи, япон орчуулгаас монголоор дам орчуулсан гэхэд давгүй сайн орчуулсан жишээг бид харлаа. Иймд эх хэлнээс нь орчуулж байгаа хүн улам сайн хичээж, солонгосоор зөв ойлгох, улмаар монголоор “үнэн орчуулж” сурах нь зүйтэй. Түүнээс гадна, ялангуяа орчуулагч бэлддэг их дээд сургуулиуд орчуулгын шүүмжийг өрнүүлж, орчуулгыг эхтэй нь тулган хэлэлцэж, алдаа онооноос суралцаад зогсохгүй орчуулах үе шатыг сайтар баримтлах явдал нэн чухал байна.

Дүгнэлт

Орчуулах хөрвүүлэх ажилд соёлын ялгаа зөрөөг дамжуулж илэрхийлэхдээ бэлэн хэв загварт шүтэн, утга дүйх үг хэллэгээр шууд орлуулах бус, харин тухайн соёлын учир холбогдол, гарвал түүх, ялгаа зөрөө, өвөрмөц онцлог зэргийг олон талаас нь шүүн

тунгааж, бүрнээ илтгэн гаргах нь туйлын чухал (М.Чимэдцэеэ, 2013:63) учраас наанадаж ил, далд агуулга санааг бүрэн ухааж ойлгох, цаашилбал утга хэлбэрийг гүйцэд гарган зохистой найруулж орчуулах эрдэмд өдрөөс өдөрт шамдах суралцах хэрэгтэйг орчуулгын сайн муу олон жишээнээс бид тольдон харж болно.

Орчуулгын алдаанаас сэргийлэхийн тулд орчуулах үе шатыг ч алгасалгүй нягт нямбай дагаж баримтлах хэрэгтэй байдаг. Хэрэв зүгээр шуудхан орчуулаад л, эсвэл дутуу хагас хянуулаад л дуусгачихвал тааруухан орчуулга болно. Харин зохиол ба зохиолчийн талаар таньж мэдэж, холбогдох хэрэглэгдэхүүнийг үзэж судалж, агуулга хэлбэрийг анхааран орчуулж, эргэж нягталж, эмхэтгэж цэгцэлбэл (Чвэ Жон Хва, 2004:148-170) өгүүлэлд дурдсан алдаануудыг цөөлөхөд нэмэртэй байх нь дамжиггүй.

“Орчуулагч хүн уншигчаар таавар таалгаж болохгүй” гэдэг. “Эжийгээ даатгая” зохиолыг солонгосоос монголоор орчуулахдаа эхийн догол мөрийг эвдчихсэн байсан болохоор тулгаж үзэх гэж хэрэндээ зүдэрлээ. Гэвч сайхан зохиолыг орчуулсан нэгэн орчуулагчийн хүсэл зорилгыг мохоох гэсэндээ биш⁵⁹, орчуулга, тэр тусмаа уран зохиолын орчуулга амаргүй шүү гэдгийг хэн хүнд ойлгуулж, хэдийгээр өгүүлбэрийн ерөнхий бүтэц адилхан хэл боловч монгол, солонгос хэл өөр өөрийн үг хэллэгтэй, найруулгатай, дүрэмтэй байдгийг сануулах гэж үүнийг бичлээ. Авах гээхийн ухаанаар хандана уу. Өсөх ирээдүйтэй орчуулагч нарт, мөн билигт сайн орчуулагч нарт “Орчуулгыг даатгая”.

Үг ончтой, утга тодорхой байх болтугай.

Ашигласан ном, сайт

1. Чвэ Жон Хва, “Хэлмэрчлэх орчуулах үндэс”, УБДС, 2004.
2. Чимэдцэеэ М., Соёл хийгээд орчуулга, “Орчуулгазүй №1”, МУИС, ШУС-ийн ЭШБ, 2013.
3. Шин Гён Сүг, Эжийгээ даатгая, УБ, 2012.
4. Эрдэнэчимэг Г., Модон бар уу? Төмөр бар уу?, “Орчуулгазүй №9”, МУИС, ШУС-ийн ЭШБ, 2021.
5. Эрдэнэчимэг Г., Солонгосын түүх – Дэд дэвтэр, УБ, 2006.
6. 김도훈, 문장부호의 번역학, 한국문화사, 2011.
7. 신경숙, 엄마를 부탁해, 창비, 2008.
8. Монгол хэлний их тайлбар толь (<https://mongoltoli.mn/>)
9. Suren блог (<https://surensuren.blogspot.com/>) 2012.
10. 국립국어원 한국어-몽골어 학습사전 Солонгосын Үндэсний хэлний Хүрээлэнгийн Солонгос-Монгол сургалтын толь бичиг (<https://krdict.korean.go.kr/>)

⁵⁹ Иймд орчуулагчийн нэрийг өгүүлэлд зориуд дурдсангүй.

11. 한국민족대백과사전 Солонгос үндэстний их нэвтэрхий толь
(<https://encykorea.aks.ac.kr/>)
12. 한글 맞춤법 Солонгос хэлний зөв бичих дүрэм ([https://www.law.go.kr/.](https://www.law.go.kr/))

МОНГОЛ РОМАНЫ СОЁЛЫН ОНЦЛОГ ҮГИЙН ОРЧУУЛГЫН СУДАЛГАА

Ч.Золзаяа⁶⁰

***Abstract:** This study analyzes how the culture-specific items (words and phrases) of the Mongolian language have been translated into English based on literary examples. The translation of the culture-specific word is unique and difficult for foreigners to understand because it is inextricably linked with the language, culture, and customs and reflects the national characteristics. As a result of this research, the author has analyzed the literary translation of culture-specific words (realia), especially how culture-specific words in literature were translated from Mongolian into English. The study was done based on the selected Mongolian novel. During the research work, some culture-specific words were left untranslated, and in some cases, one word was translated in many different ways. In addition, there are cases where the original text's eloquent, historical, and cultural examples were omitted during the translation process. Therefore, this work will contribute to the promotion of our national heritage and researchers researching this topic.*

***Keywords:** Culture-specific item, translation, culture, language, literature*

I. Introduction

The language and culture of any nation cannot be understood separately from its people. Language is closely related to the culture of every nation in the world. Thus, the issue of the translation of culture-specific items has been one of the main themes for linguists. In this paper, the author reviewed the scholars' concepts about classifying and translating culture-specific words through research work. When learning a native language and a foreign language, a person not only establishes separate vocabulary and grammar rules, but also learns the history and customs of the people, gets used to the established way of life, and even finds the way of thinking. In modern linguistics, language is considered a means of communication and cognition and a form of culture that preserves, carries, and expresses its way of life.

The purpose of this research work is to analyze the translation of culture-specific words in literary discourse, consider how they were translated, and make theoretical conclusions about

⁶⁰ Доктор Ph.D, ШУТИС, ГХС, Англи хэлний тэнхим

how to solve the culture-specific item without losing its meaning. Realia is described as follows (plural noun) are words and expressions for culture-specific material elements. The word realia itself originated from medieval Latin, in which it originally meant “the real things”, i.e. material things, as opposed to abstract ones. The realia shows many specific aspects of the lifestyle, customs, traditions, and social development relations of the people who speak the language and contains different cultural patterns. As the living style of the country develops and changes, it is natural that the language, which is metaphorically the lifeblood of the people, and in the process of its evolution, the vocabulary, including the culture-specific words, also develops itself through the use of language.

Mongolian scholars and writers Ts. Damdinsuren, academician B. Renchin, translators G. Akim, D. Dashdavaa, R. Gurbazar, G. Tomtogto, E. Ravdan, and Ts. Olziyhutag have studied the realia words of the Mongolian language and contributed to the research on linguistics. In addition, Linguist J. Tomurtseren, (2001) in his study of the dictionary of the Mongolian language, points out that "Words reflect the national identity of the people who speak that language to some extent." Moreover, he stated that words with cultural meaning constitute a certain part of the vocabulary of any language. Also, according to "phenomena, characteristics of the real world, their relationships, reflected in the human consciousness through words." Mongolian linguist E. Bayarsaikhan (1988: 168) has conducted some research materials translated into Russian on the realia of the novel “Gologdson khuukhen” by famous writer Ts. Damdinsuren. Moreover, he points out that two or more phenomena of two languages were compared, and there were some universal things and some culture-specific items that exist in the cultures. It is related to social and cultural differences, geographical differences, people's lifestyle, and customs" indicating that the meaning of the culture-specific realia does not correspond exactly when it is expressed in the language of other people. Regarding realia words, R. Gurbazar (1996: 110) said, "The names and contents of objects and phenomena that reflect the features of the nation, people's lifestyle, customs, and tradition, civilization, and social organization are expressed in the language of that specific country, and words and combinations that cannot be translated into other languages are called realis. For example, there is no way to directly assign such words of the Mongolian language such as *ovoodoo*, *ölzii /khe/*, *tashmag*, *Bumba*, *aimag*, *ger*, *bielgee*, *boshgo /office/*, *yuj*, *khoemii*, and *maliin zus* in any foreign language. All these words are culture-specific words that can't be translated with equivalent words in other languages. D. Badamdorj points out that “Cultural values, everyday life items, relics of the unique nomadic civilization, unique ethnic artifacts and creations within the framework of Mongolian national culture will be unique things created by Mongolian people, not common among the people of the world. He thinks that the word marked with such a concept is a realia word, such as *ger*, *deel*, *utc*, *yogurt*, and *auspicious thread* [5, p. 206] and specifically noted the method of translation of these words. G. Tomtogtokh, (1996) a linguist points out that it would be a great contribution to the development of the comparative and

cultural studies fields if culture-specific words are studied in detail within broad perspectives so that semantic categories of the language can be defined well enough. R.Gurbazar (1996), a scholar on translation studies defines the characteristics of the culture-specific realia by stating that “within the source language text the realia show their original meaning whereas, in the target texts, they can be translated by calqued”. Moreover, he points out that relia words are unambiguous and contain phonetics and word formation of their native language and express their own meanings, and are used in scientific, literature, and informal discourse. Culture-specific words are used in their cultures with their full original meanings. However, these words are translated into other languages. R. Gurbazar (1996) classified culture-specific words into several different categories including ethnography, mode of life, oral stories, legends, and social and history-related words. [4, p. 110].

Newmark (1988: 45) clearly defines the methods of translation as follows: word-for-word translation, literal translation, faithful translation, semantic translation, adaptation, free translation, idiomatic translation, and communicative translation. Each method differs from other translation techniques. Moreover, Newmark (1988: 45) defines culture as the way of life and its manifestations that are peculiar to a community that uses a particular language as its means of expression.

II. Methods

The purpose of the study is to analyze the translations of the culture-specific items (realia) in Mongolian novel and how the source texts are translated into English. Specifically, the resources of the research material were G. Mend-Oyo’s (2017) “Gegeenten” translated by Simon Wiksmith (2021) It is an interesting fact that “Gegeenten” was translated by a foreign translator and we hypothesize that some culture-specific items would be lost in the target text. With these expectations, the author chooses the novel “Gegeenten” as the resource of the study. There were several steps were taken for the study. First, the novel in Mongolian were thoroughly analyzed and the culture-specific items (realia) were marked and selected as the data of the realia. Second, the chosen culture-specific items’ English translations in the target language were examined thoroughly in comparison with the source language texts. The translations of the realia in the target language were analyzed by Newmark’s (1988) methods. Moreover, the source language examples of realia were written in Roman, and English translations were provided just after the examples. In this study, the semantic meanings of the culture-specific items were thoroughly checked based on the Explanatory Dictionary of the Mongolian Language (2016). In addition, the study also focuses on the target texts and whether the chosen equivalent words of the culture-specific words’ meanings were correct or not so they were used as the source for the study as well. Moreover, in this study, the Romanization System is used to transcribe the Mongolian examples. The main focus is on the English and Mongolian examples comparing to each other. In this study, we use abbreviations for the Explanatory Dictionary of the Mongolian Language (EDML: 2016) and the Cambridge Dictionary (CD: 2022) for the readers to be clear enough.

III. A Contrastive Analysis of the Translations of Culture-specific Realia in “Gegeenten” by Mend-Oyo (2021) novel

“Gegeenten” (2021) by G.Mend-Oyo and its English translation were selected as the main research material for the study. Realia (culture-specific items) were selected within the theoretical framework of the realia and marked as the data for the study. The study analyzes the culture-specific items in detail and reveals that realia words were translated in different ways and which means those words were not constant but with frequent changes in the words and phrases resulting in a misunderstanding in the target texts for readers. Thus, the culture-specific realia’s translation process must be a focus of the study for researchers.

Also, as a result of observations during the research, it is believed that several things should be taken into account when translating culture-specific words. In the case of literary translation, it is not enough for the translator to know the language at the level of use, and it is believed that having knowledge of the culture of the people in the language of the original text is the most important requirement. In this regard, the researcher Ts. Magsar (2018: 41) classified common mistakes made during the translation as follows. It includes; mistakes due to a lack of cultural knowledge, cognitive meaning-dependent errors, word-by-word translation errors, errors caused by not knowing a previously established translation, errors caused by not noticing the conditions, errors caused by source ambiguity, meaning errors, and mistakes caused by source text error. In addition, scientist D. Dashdavaa (1977: 44) points out that “A translator cannot provide the readers with that important thing without knowing the history and culture of the people and the people who speak the language they are translating” Knowledge of history, culture, customs, and philosophy is also important for translation. Consider the examples of culture-specific realia words and their translation below:

Mongolian: source text: (1a) Solbio buhtei khugshin shar **at** unasan gandmal ulaan **deetlei** uvgun khun Dalai goviig zahlan baruun zugiig zamnaje. (Gegeenten, 2021).

English: target text: (1b) An old man in tattered red (2b) **deel**, riding an old yellow **camel** with crossed humps, was crossing this oceanic desert, heading westwards. (The Holy One, 2021).

Looking at this example, (1a) “*at*” is translated into English as (1b) “*camel*”. According to the explanatory dictionary the word “*at*” refers to “a mature male camel over five years old” (EDML 2016). But the word “*camel*” is defined as “a large animal with a long neck, that lives in the desert and has one or two humps”, a big animal. (CD 2022) Since this translation is not satisfactory in terms of semantic understanding, it is considered appropriate to translate or quote as “ camel over five years old, ” meaningfully giving readers the source text.

(2a) *deel* is transliterated as (2b) *deel* because there is no equivalent word in English. Example (2a) The word “*deel*” is explained as “an outer garment with a lapel collar to wear outside” (EDML 2016). The negative side of words translated by transliteration is that ordinary readers who read the literature will not get the real meaning and will not get a full understanding.

Mongolian: source text: Tudev bi khorin tavtaidaa (3a) “Tsagaan sumiin” (4a) **takhilchiin** tangarag urgusun khun. Khamag yum ar nuruun deerh alga daram tal saran (5a) **mengetei** mini kholbootoi. (6a) **Noyon gegeenii** ilgeesen dohio! Minii aav **Ongoi** (7a) iim(8a) **temdegtei**. (Gegeenten, 2021).

English: target text: When I, was twenty-five, I was honored to receive the vow as (4b) **guardian** of the (3b) **White Temple**. Everything came together in a moon-shaped (5b)

blue spot, as wide as a hand, on my back. It was a sign, sent by (66) *the Holy One*! My father (76) *Ongio* had exactly the same (86) *mark*. (The Holy One, 2021).

(3a) The word "Tsagaan Sum" is defined in the Explanatory Dictionary of Mongolian as "a place for religious rituals such as worshipping God, preaching, and holding meetings." (EDML 2016) In example (3b), the word "White Temple" is defined as "a building used for the worship of a god or gods in some religions" or "a building used for the worship of a god or gods in some religions"(CD 2022) and is equivalent in terms of semantic understanding.

In example (4a) the word "tihilch" is explained as "who performs sacrifices, a priest who offers sacrifices"(EDML 2016). But when translating this example into English (4b), the word "guardian" was chosen and its meaning is explained as "someone who protects something"(CD 2022). The translation of this word has been translated equivalently, and although its structure is clear, it is considered to translate it as "monk in charge of the objects used in sacrifices" or "monk in charge of the objects used in sacrifices".

In example (5a) the word "menge" expresses the meaning of which is a "symbolic color given to an individual by nature"(EDML 2016), but this word (5b) is translated as "blue spot" which is only for Mongolians. In fact, the word "menge" and "blue spot" is different in meanings in the source texts. Mongolians believe that someone can reborn after death so they mark the body. However, blue spots are found in the area of the newborn child's back of the ass. In the target text, it was translated as a blue spot which provides readers with different ideas. Thus, to translate culture-specific words, we need to study more about that culture, tradition, and language as well.

The next example (6a) is "Noyon" which is defined as a "local high-ranking official or ruler" (EDML 2016), the word "saint" in English is defined as "a person who specializes in religious teachings: the holy owner [obsolete] (a person who has the knowledge to penetrate many things like the sun and the moon)" and it is translated by the translator (6b) as the Holy One, and this example is explained as "related to a religion or a god: very religious one" In the Holy Bible, (Isaiah 43:15) says, "I am the Lord, your Holy One, Israel's Creator, your King." (6a) The word Mr. Gegeen means not only a religiously enlightened person, but also the lord of the province or locality, so it is considered appropriate to transliterate it as "Gegeenten".

The word "temdeg" mentioned in example (8a) is not a culture-specific word in the sense of the characteristic or feature of anything described in the dictionary of the Mongolian language. (EDML 2016). But the Mongolians put some special sign before burying the dead, and it is a cultural feature that they recognize when they come to the next generation. In the example sentence (8a), the word "meaning" has the meaning of this custom, so it was marked as the culture-specific realia in this context. This example (8b) explains that the word "mark" has 18 different meanings in the dictionary. From these, it is believed that the meaning of "something that shows or proves a particular quality, feeling" or "something that shows or proves a particular quality, feeling" has been selected and translated, taking into account the culture-specific meaning of the example "mark" in English. (CD 2022)

In the example sentence (7a) **Ongoi** and (9a) **Naryaa** are proper names, which the translator transliterated as (7b) **Ongio** and (9b) **Nariya**. In general, it is observed that the method of translating the given name from a foreign language, transliterating it according to the phonetic features of the language being translated, and replacing it with a meaningful word is widely spread in the practice of translation. Scholars have generally agreed that transliteration is correct when translating proper names.

Mongolian: source text: (10a) **Khadag** (11a) **embuu seltesiig negen myangan** (12a) **lan mungu ed baraa** dagalduulan (13a) **Bogd gegeen** tanii ulmii bat orshihiiin danshigt urguj buig bolgoono uu? (ГЭГЭЭНТЭН РОМАН, 2021).

English: target text: With these thousand silver (126) *pieces*, and these (116) *other gifts*, and this offering (106) *scarf*, may we hold a ceremony for the (136) *Bogd Gegeen*'s long and stable life? (The Holy One, 2017).

In example (10a), the word "Khadag" is explained as "a thousand woven fabric that is presented to Mongolian elders and guests to show their respect" (EDML 2016). However, in example (3b), it is translated as scarf, this word is defined as "a strip, square, or triangle of cloth, worn around the neck, head, or shoulders to keep you warm or to make you look attractive", square or triangular fabric. In example (3b), the English noun and verb of the word scarf has 5 different noun meanings or is translated as a ribbon-shaped scarf. However, in English, the word (3b) scarf means a person's clothing and neck scarf, so the reader does not understand the word literally and it is not understood that Mongolian people express respect, so it is necessary to transliterate it as "khadag" in this context. The purpose of the "khadag" and "scarf" is very different in reality.

In example (11a), the word "embuu" can be replaced by similar words "silver ingot" or "a piece of metal, usually in the shape of a narrow brick", "silver ingot weighing about 50 lan" (EDML 2016) or "silver ingots weighing about 50 lan" can be interpreted, while in (11b), "other gifts" is translated together with other words or even omitted without translation. (11a) the word "embuu" means "a solid coin made by casting gold and silver in a special mold; an old-time monetary unit; usually the upper part is thin, the lower part is flat, or the shape of a fist or ring-shaped lobe, usually the size of fifty lan. (EDML 2016)

The word (12a) "lan" is translated as (12b) pieces, while the word (12a) lan is defined as "a measure of weight; one lan is equal to 7.3 grams; (12b) the word "pieces" is explained as "a part of something" (CD: 2022). Culture-specific words such as "lan" can be translated by transliterating with explanations.

In example (13a), the word "Bogd Gegeen"/-a.Gegeen ezen, (13b) is transliterated as Bogd Gegeen, which means Bogd Khan, the leader of Buddhism in Mongolia. In example (13a), the meaning of "Bogd Gegeen" is written in different ways in the novel "Gegeenten" and translated differently in the target text, i.e. transliteration, and equivalent methods. This is likely to be confusing for readers. For example, *Bogd Javzandamba- Bogd Jetsudamba, Saint of Darnad, Jetsun Taranatha, Saint of Darnad - Taranatha Incarnation, Bogd- Bogd, The Bogd Gegeen- The Bogd Gegeen*

Mongolian: source text: (14a) **Gobid** chin delger zun hovor tohiolddog bolhoor ch teruu, (15a) mori uraldaj, найр (16a) **naadam** uusgehed hugshin huvuugui noyod yadusgui l chuulchih yum daa. (Gegeenten, 2021).

English: target text: Such a beautiful summer was rare in the (146) *Gobi*, but for (166) *the games* and (156) *horse racing*, rich and poor mixed together without the old divisions. (The Holy One, 2021).

In example (14a), "Gobi" is transliterated as (14a) Gobi. In example (14a), the word Gobi is explained as "sparse vegetation, forests, and running water are rare, sandy and gravelly soil, marmots are not introduced, and in some cases, it is translated as "desert". The definition of the word "Desert" is "an area, often covered with sand or rocks, where there is very little rain and not many plants" or "covered with sand, stones. (EDML 2016)

Mongolian: source text: Mori malaa (17a) *nemnej*, (18a) emeel yugaa avaad(19a) **ger** baraa ruugaa shahtsaldan ortsgooloo. (Gegeenten, 2021)

English: target text: They (17b) **blanketed** the animals, removed the (18b) tack, and we all squashed into (19b) ger with all our possessions. (The Holy One, 2021).

In example (17a), the word “nemneh” is interpreted as "to cover the animal's back"(EDML 2016), while (17b) the word blanketed is defined as "to cover" or “to protect in English. (CD 2022) This word is interpreted with its equivalent word in the target language.

In example (19a), the word "ger" is interpreted as "a traditional, national felt dwelling of Mongolian ethnicity" in the dictionary of the Mongolian language. (EDML 2016). In the target text the word “ger” is transliterated as “ger” which is unique with its traditional style of housing.

Mongolian: source text: Nairin (20a) *ikh geriin* (21a) **khoimort noyod ihes suugaad l idee budaa tsagaa olj**, yaria huuruu delgej baital (22a) **geriin deever** (23a) **tsavag nevtlen end tendgui** dusaal goojin baij suukh gazargui bodlog baina. (Gegeenten, 2021).

English: target text: The nobles all sat eating at (216) the **back of** the (206) **large** festival **ger**, the talk flowed, there were drops falling here and there through the (226), (236) **felt roof**, there was not a place to sit down. (The Holy One, 2021).

In example (20a), the word "ikh ger" is defined as "large ger is divided by the number of walls, the gers of local high-ranking officials or rulers usually have gers with 6-8 walls, the gers of the provincial head offices have gers with 10-12 walls"(EDML 2016). When translating it (20b) as large ger, a combination of transliteration and simile was used.

In example (21a), the word "hoimor" is defined as "the space behind the pillar of the house, a respectable seat" in the dictionary of the Mongolian language. (EDML 2016) In example (21b), "the back of" is explained as follows: "the inside or outside part of an object, vehicle, building, etc. that is furthest from the front" or "the inner and outer part furthest from the front, such as objects, vehicles, buildings,(CD:2022) etc. So, although this translation is semantically correct, it is believed that the meaning of "respectable seat" is not fully understood.

The word "geriin deever" is translated as "felt roof" in (23b). The term "geriin deever" is defined as "insulation outside the house, over the roof" in the dictionary of Mongolian language. (EDML 2016) "felt roof" would be: felt: noun, "a thick cloth" made from a pressed mass of wool, hair, or fur" or "thick cloth made from a pressed mass of wool, hair, or fur", but roof: noun, "the covering that forms the top of a building, vehicle, or another object” or “the cover that forms the upper part of buildings, vehicles, and other objects”. In example (23a) "tsavag" which refers to ger’s roof related object /"layer for the roof of a Mongolian ger" (EDML 2016) is left untranslated.

We have classified the realia in the novel "Gegeenten" by Mend-Oyo (2021) as follows: **related to customs:** *temdeg, khadag, hoimor, ald khadag, khuurug*, **related to religion and social development:** *Bogd Javzandamba, Saint of Darnad, Bogd, Saint of Bogd, Tsagaan Sum, Noyon Gegeen, Tushee Ghun, God with gongerva*, **related to domestic life:**, *khaya, tono, tsavag* **related to geography:** Gobi, Khurenbelchiri area, Inner Khamar, **related to folklore:** hangards, semberem of Bure Bishgur, **related to folk measurement:** it can be classified as *lan* and so on.

IV. Conclusion

In the course of the research work, it has been noted that the large-scale analysis and study of the culture-specific realia words have been studied thoroughly in detail. When translating realia, the translator must understand the meaning and content of the original work

and source text, try not to confuse words with culture-specific words, and have a good knowledge of the national characteristics culture, history, and social system. It is necessary to think about history, culture, and customs in comparison with today's life. In this way, readers can be fully introduced to another world, another culture, other customs, morals, and life. It is necessary to accurately identify the words in the original text and their corresponding words, and make tireless efforts for this.

When translating realia, the translator must understand the meaning and content of the original work, in other words, source text information tries not to confuse words with realia, and have a good knowledge of the culture, history, and social system. It is necessary to think about history, culture, and customs in comparison with today's life. In this way, readers can be fully introduced to another world, another culture, other customs, morals, and life. It is necessary to accurately identify the words in the original text and their corresponding words, and make tireless efforts for this. We emphasize the importance of the translation of the realia because it will contribute to the development of linguistics, specifically, to the culture study field. In conclusion, it is advisable for the translator to use transliteration and interpretation methods, or a combination of them, without leaving the words of the national culture untranslated.

V. Reference

Mongolian:

Badamdorj, D. (1997) *Fundamentals of Semantics of Modern Mongolian Language*, Ulaanbaatar,

Bayarsaikhan, Y. (1988) "The translation of Mongolian reals into Russian," *Association of Translators*, pp. 168-172 p., No. 5

Gurbazar, R. (1996) *Fundamentals of translation theory and practice*, Ulaanbaatar.

Dashdavaa, D. (1977) *Some Problems of Translation*, Ulaanbaatar, 1977.

Magsar, Ts. "Requirements for Literary Translation: About Concepts of Equivalence and Conformity," *Translation Studies*, p. 41, 06 2018.

Tomtogh, G. (2000) *Thesaurus-semantic study of words with national characteristics of the Mongolian language*, Ulaanbaatar.

Tömurtseren, J. (2001), *Mongolian vocabulary study*, UB. Gunprint LLC, M. h. e.

Mend-Oyo, G. (2021) *Gegeenten*, novel, Ulaanbaatar.

Explanatory Dictionary of the Mongolian Language (EDML 2016)

English:

Cambridge Dictionary (CD 2022)

Holy Bible, (Isaiah 43:15)

Newmark, P. (1988) *A Textbook of Translation*. New York and London Prentice-Hall.

S. W. G. Mend-Ooyo, *The Holy One*, Ulaanbaatar, 2021.

Internet resources

<https://mongoltoli.mn/dictionary/>, 2026. UB.

<https://dictionary.cambridge.org/>

<http://www.bolor-toli.com/dictionary/>

<https://www.britannica.com/>

<https://www.britannica.com/art/snuffbox>

<https://mn.wikipedia.org>

<https://www.buddhism.mn/static/129/133>

http://www.touristinfocenter.mn/cate15_more.aspx?ItemID=1090

МОНГОЛ ЯРУУ НАЙРГИЙН ЧЕХ ОРЧУУЛГАД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Д. Энхжаргал⁶¹

Abstract. In this research article, we present observations on the Czech translation of Mongolian poetry. Observations were made on the translation of 10 poems from the poetic works included in the book “Tea on the Steppe” or “10 Contemporary Mongolian Poets”, which was translated by the Czech Mongolian researcher Jiří Šima and other translators. According to the research, it was determined that the works were translated with different meanings, the realia were replaced with other words, they were translated with the same ones, and some words were omitted.

Түлхүүр үг: яруу найраг, чех орчуулга, тайлбарлах арга, үгчлэх арга, үндэсний онцлог үг

Яруу найргийн орчуулгын онолын асуудал

Монголд яруу найргийн онол, орчуулгатай холбоотой гарсан онолын ном зохиол нь “Орчуулах эрдэм 1” (УБ, 1972), “Орчуулах эрдэм 2” (УБ, 1976), “Орчуулах эрдэм 3” (УБ, 1982), “Орчуулах эрдэм 4” (УБ, 1986), “Орчуулах эрдэм 5” (УБ, 1988), “Орчуулах эрдэм 6” (УБ, 1989), Д. Цэрэнсодном “Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал” (УБ, 1977), Б. Магсаржав “ХХ зууны жараад оны монгол шүлгийн туурвил зүйн зарим онцлог” (УБ, 2006), Р. Бигэрмаа “Цаг үе-яруу найраг шинэчлэл” (УБ, 2002), “Г. Мэнд-Ооёогийн уран бүтээлийн судлал шинжлэл” 1993-2021 (УБ, 2022), “Орчуулгазүй: Яруу найргийн орчуулга” (УБ, 2015 №04 (422)) зэрэг болно. Монгол яруу найргийн бүтээлийг орчуулсан тухайд судлаачдын бичсэн судалгааны өгүүлүүд байна. Тухайлбал, “Орчуулгазүй: Яруу найргийн орчуулга” (УБ, 2015 №04 (422)) сэтгүүлд хэвлэгдсэн Д. Цэдэнжав, “Монгол ардын дууг орос хэл рүү орчуулах асуудал”, Н. Гэрэлмаа, Ф. Албаярак “Монголын нууц товчоон” дахь нэгэн шүлгийн турк орчуулгын тухай”, Н. Ундраа, Н. Оюунзаяа “Б. Явуухулангийн “Туулын шугуй” шүлгийн англи болон орос орчуулгын утга, дүйлгэц” зэргийг нэрлэж болно.

Лефеве (Lefevere, 1975), Басснетт (Bassnett, 1991) нарын судалгаанд үндэслэн яруу найргийг орчуулах дараах аргууд бий гэж үздэг. Үүнд: авиалбарын орчуулга (phonemic

⁶¹ Доктор Ph.D, МУИС, ШУС, ХУС, Европ судлалын тэнхим

translation), үгчилсэн орчуулга (literal translation), хэмжих орчуулга (metrical translation), энгийн орчуулга (prose translation), сүүл холбосон (rhymed translation), задгай шүлгийн орчуулга (blank verse translation), тайлбарлах (interpretation) зэрэг болно. М. Цэдэндорж (1982)-ийн хэлснээр монгол орчуулагчид яруу найргийг “...үгчилсэн орчуулга, хадмал орчуулга, шүлэглэсэн орчуулга гэж гурван янзаар хэвлэж байсан уламжлал байжээ. Санааг авч монгол шүлгийн аргаар шүлэглэх, эхийг баримталж шүлэглэх гэсэн хоёр зарчим чиглэлийг монгол орчуулагчид баримталж иржээ. Эл хоёр аргыг зохиолч Ц. Дамдинсүрэн, А. С. Пушкины шүлгийг орчуулахдаа хэрэглэсэн байна. «Алтан загасны үлгэр» орчуулахдаа, санааг авч, цөөн мөр шүлгийг монгол ерөөл магтаалын журмаар шүлэглэсэн бол сүүлд орчуулсан «Хүрэл хөшөө», «Полтав» найраглалыг эхийг яг баримтлах аргыг хэрэглэн орчуулсан (Орчуулах эрдэм 3, 1982, хууд. 74) байна. Төлөөлүүлэн орчуулах, өөрөөс үг тодотгол нэмэх нь буруу бөгөөд толь бичигт байгаа үгээр яруу найргийг орчуулж боломгүй, үгийн аясыг мэдэрч орчуулах нь гол зүйл гэж дүгнэжээ. Яруу найрагт орсон үг тэнд тухайн өнгө аясаа олдог” гэжээ.

Судлаач С. Баясгалан: яруу найргийн орчуулга гэдэг бол: нэгдүгээр үг, өгүүлбэр, хоёрдугаарт-өвөрмөц хэллэг, ёгт санаа, гуравдугаарт-гоо сайхны нээлт, шүлгийн хэлбэр, дүр дүрслэл; дөрөвдүгээрт-утга уянгын өвөрмөц дуу хоолойг нь алдагдуулахгүйгээр нэг хэлний сэтгэхүйгээс нөгөө хэлний сэтгэхүйд буулгаж байгаа уран сайхны логик үйлдэл мөн (Орчуулах эрдэм 4, 1984, хууд. 37) гэж тодорхойлжээ.

Ц. Сүхбаатар: Яруу найргийг яруу найрагч орчуулах нь эх зохиолын утга санааг бүрэн дүүрэн гаргаж, зохиолчийн өвөрмөц онцлог, уг бүтээлийн уран сайхныг эх зохиолынх нь түвшинд ойр буулгахад дөхөмтэй гэж үзжээ. (Орчуулах эрдэм 4, 1984, р. 50)

Уран зохиолын орчуулгад, тэр дундаа яруу найргийн орчуулгыг судлахад үндэсний онцлог үгийн орчуулга ихээхэн анхаарал татдаг. Аливаа хэлний үгийн сан дахь уламжлалт амьдрал, зан заншил, эрхэлдэг аж ахуйн олон талт үйл ажиллагаа, нийгэм улс төр, шашин, соёлын болон газар нутаг, амьтан ургамлын онцлогийг тусгасан утга бүхий үг хэллэгийг *үндэсний онцлог үг* (Томтогтох, 2012) хэмээн тодорхойлдог. Энэхүү судалгааны өгүүлэлд монгол яруу найргийн үндэсний онцлог үгийг хэрхэн орчуулсныг бид авч үзлээ. Чехийн монгол судлаач эрдэмтэн Йиржи Шима болон бусад орчуулагчдын хамтран орчуулсан, 61 бүтээл бүхий “Хээр талын цай” буюу “Монголын орчин цагийн 10 яруу найрагч” (Čaj ve stepi, Deset současných mongolských básníků, 1979) хэмээх номд орсон яруу найргийн бүтээлүүдээс 10 шүлгийн орчуулгад ажиглалт хийснээ танилцуулж байна. “Хээр талын цай” номд Б. Ринчен, Ц. Дамдинсүрэн, Ч. Лхамсүрэн, Ч. Чимид, Б. Явуухулан, М. Цэдэндорж, Д. Пүрэвдорж, М. Ширчинсүрэн, Ш. Дулмаа, С. Дашдооров нарын яруу найргийн бүтээл оржээ.

Монгол яруу найргийн чех орчуулгад хийсэн ажиглалт

1.Б. Ринчений яруу найргийн орчуулга

Их эрдэмтний “Нөхдөдөө мэнд хүргэе” 1956, “Тыны сүмд” 1956, “Бэр цэцэг” 1955 зэрэг нь Чехийн ард түмэнд зориулан бичсэн яруу найргууд юм. Эдгээр нь чехийн орчуулагч Иозеф Петеркагийн орчуулгаар „Čaj ve stepi“ номд 1979 онд Прага хотод чех хэлээр гарчээ. Эдгээр яруу найргийн монгол эхийг Монголын уран зохиолын дээж (цаашид МУЗД (Монголын уран зохиолын дээж, 27-р боть, хуудсд. 15-41)-с авсан болно. Б. Ринчений шүлгүүдээс “Нөхдөдөө мэнд хүргэе” шүлгийн орчуулгад ажиглалт хийе.

“Нөхдөдөө мэнд хүргэе” (Pozdrav přátelům)

Багш Хусын түмэн чамд балчир сурагч наснаасаа Бахданхан дурладаг би чинь, үс буурал болсон хойно, Ах дүү сайхан улс, сэтгэлд минь дотно нутагт чинь Айлчланхан ирж, баясанхан гийчилж явахдаа Санаа сайт ард түмнийхээ яруу найрагч би чинь Садан нөхөд та бүхнээ түмнийхээ мэндийг хүргэж ирлээ.	Národe mistra Jana, od školních let Ma tebe myslím, tebou se pyšním, mám rád tvůj svět Staří jsem dospěl, a teď, když mi zešedly vlasy, Stal jsem se hostem tvé podivné blízké vlasti. Přátelské srdce má můj lid, jsem jeho básník, a rád Přináším ti pozdrav ze země stepí a stád.
--	---

Чех орчуулгыг үгчилбэл:

Багш Хусын түмэнд сургуулийн наснаасаа
Чамайг бодож, чамаар бахархаж, чиний ертөнцөд би дуртай
Хөгшин болоод, үс минь бууралтаж
Би чиний гайхалтай сэтгэлд дотно нутгийн
Зочин нь болжээ...

гэх зэргээр эхний 4 мөрийг орчуулагч үгчлэн буулгасан бол сүүлийн хоёр мөрийг тайлбарлан орчуулсан байна. Тухайлбал монгол шүлэгт *Садан нөхөд та бүхнээ түмнийхээ мэндийг хүргэж ирлээ* гэж байхад чех орчуулгад *...Тал нутаг, мал сүргийн орноос мэндчилж байна ...* гэж буулгажээ.

Танай олон хотын эх болсон алтан хонгор Прага Тансаг сайхан үүрд залуу энхрий тэр хотыг Байгуулсан ард түмний эр зориг авьяас чадал Баяр зовлонг Прагын чулуу бүхэн надад илтгэн амуу.	Hoře i radost národa, odvaha, bystrost a snaha Hovoří ze všech kamenů, z nichž je postavena Praha, Praha, věčná kráska, všichni ji mají rádi Pro její svěžest, pro její staleté mládí.
---	---

Чех орчуулгыг үгчилбэл:

Үндэстний гуниг баяр, эр зориг, авхаалж, хичээл зүтгэлийг
Прагыг босгосон чулуу бүхэн хэлдэг
Шинэлэг байдал, олон зууны турш залуу байгаад нь
Прага хот, мөнхийн үзэсгэлэн, бүгд түүнд хайртай

Олон хотын эх болсон Алтан Прага гэдгийг орчуулсангүй үлдээжээ. ...Тансаг сайхан үүрд залуу тэр хотыг... гэснийг ...Шинэлэг байдал, олон зууны турш залуу байгаад нь... гэж буулгажээ.

Монгол эх	Чех орчуулга
Манай нутгаар хамт явж, бор гэрт хүсэлт зочин болж, Маш ариун сайхан доторт эрэлхэг зоригт түмэнд минь Наран гэрэлт анхилмал хээр талд минь дурласан Найзтайгаа эртний Карлын гүүр дээгүүр явж	Sem tam od věže k věži jsem chodil starým kamenným mostem S přítelem, který v našich jurtách z hovězích kůži byl hostem Zamiloval si můj státečný, můj prostosrdečný lid, Zavítý do klubka slunních a vonných stepí, kde dokáže žít.

Чех орчуулгыг үгчилбэл:

Миний эрэлхэг, сайхан сэтгэлт ард түмнийг хайрласан.

Амьдрах боломжтой нарлаг болон анхилуун талд минь татагдсан.

Үхрийн арьсан гэрт зочилж байсан найзтайгаа

Ийш тийш цамхгаас цамхаг руу хуучин гүүрээр би явсан.

Орчуулагч ...манай нутгаар хамт явж гэхийг ...ийш, тийш цамхгаас цамхаг руу.. гэж буруу ойлгож орчуулсан байна. Монгол эхэд Монголд зочилж, нутгаар нь явсан найзынхаа тухай өгүүлсэн байтал Чехээр хамт явсан найзтайгаа чулуун гүүрээр явсан болгож буруу орчуулжээ. Уг нь Чехэд найзтайгаа зөвхөн Карлын гүүрээр явсан. Өмнөх мөрүүд бүгд Монголтой холбоотой байна. ...бор гэрт... гэхийг ...үхрийн арьсан гэрт... гэж буулгажээ. ...Эртний Карлын гүүр дээгүүр явж... гэхийг ...хуучин чулуун гүүрээр... гэж орчуулаад Карлын гүүр гэсэнгүй.

Хайсын чулуунд Непомукийн Яныг Влтав мөрнөө Хаясан тушаа сийлэнхэн шигтгэсэн загалмайн тэнд Харлан урсагч усыг харан харан удтал зогсож, Надад Венецийг санагдуулсан тогтуун татуурын уснаа Намрын хүйтэн Влтаваас айсан шиг эргэлдэн Алтан шар навч аяархан унаж байхыг харлаа.	Tam, kde byl kdysi vryt kříž do kamenného zábradlí Tam, kde oči Jana Nepomuckého se do proudu propadly, Hodiny jsem hleděl do temné vody Hleděl jsem na vedlejší rameno, kde řeka starým domům myje schody, Okolo zlatavé listy se snášely do vody, do trávy, Odkláněly se, kroutily, jak by se bály chladné říjnové Vltavy
---	--

Энд монгол эхэд буй *Надад Венецийг санагдуулсан* гэсэн мөрийг хасаж орчуулжээ.

Бусад мөрүүдийг үгчлэн буулгасан байна. Монгол эхэд буй толгой болон сүүл холбох аргыг чех орчуулгад хадгалсан байна.

Бичиг атган бодлого болсон Карл Ване Бие нь гүүрийн халаагүй манаанд чилсэн бололтой Тэртээ холын цэнхэр буданд Долиборын цамхагаас	Zelenou bulu v ruce, stál Karel král, Z té dlouhé hlídky u mostu už se znavený zdál Z Daliborka, bílý stín skrz mlhu modravou, Daleké, bolestné tóny ronila nad Prahou.
---	--

Тэсгэлгүй гунигт хурын чимээ нь дуулах мэт ажам.	
--	--

Чех орчуулгыг үгчилбэл:

Ногоон хууль гартаа бариад Карл хаан зогсож байна.

Гүүрийн дэргэдэх урт харуулаас залхсан бололтой.

Далиборын цамхгаас хөх мананг нэвтэлсэн цагаан сүүдэр

Холын өвдөлттэй дуу чимээ Прагыг хучив гэжээ.

Орчуулагч бичиг гэдгийг *ногоон хууль* гэж буулгажээ. Чехийн түүхэнд Алтан хууль гэж байснаас *ногоон хууль* гэж байгаагүй. Орчуулагч ташаарсан гэж үзэж байна.

Сүүлийн бадаг

Анд нөхөд та нартаа хэзээний элэгтэй намайг баясан Авьяс зориг хөдөлмөр зүтгэлийг чулуу бүхэн гэрчлэгч Таатай сайхан танай нутгаар найртай гийчлэн явахад Бахдах сэтгэлээр эх орноо хайртай хүүхэн мэт, эх мэт Баясан энхрийлж, эх орноо өргөмжлөх магтаал шиг Та бүхний эх хэл тань миний чихэнд юутай сайхан бэ?	Rodní druží, na něž myslím už tolik let, Raduji se, že mne přijal váš vzrušující svět, Každý kámen tu dýchá vůni talentu Česká řeč zní libě ke mně, Čistý chorál této země, Které se oddáváš jak milence, jak matce...
---	---

Чех орчуулгыг үгчилбэл:

Олон жил санасан хамаатан садан

Танай сэтгэл хөдөлгөм ертөнц намайг хүлээж авсанд баяртай байна.

Эндхийн чулуу бүрээс авьяас билгийн анхилуун үнэр ханхалдаг.

Хайртай хүн шиг, эх хүн шиг

Энэ нутгийн цэвэр дуулал,

Чех хэл надад сайхан сонсогдож байна... гэж буулгажээ.

Монгол эхийн сүүлийн ...Таатай сайхан сэтгэлт түмнийхээ яруу найрагч би Та нартаа садан нөхдөдөө амар мэндийг хүргэж ирлээ... гэсэн хоёр мөрийг орчуулаагүй үлдээжээ. ...Та бүхний эх хэл... гэхийг чех хэл гэж орчуулжээ.

2. Ц. Дамдинсүрэнгийн яруу найргийн орчуулга

Ц. Дамдинсүрэнгийн “Гэсэрийн баатрын магтаал” (Chvalozpěv na hrdiny), “Наалинхай хоёр нүд чинь” (Tvoje oči plně něhy), “Найрын дуу” (Hodovní píseň), “Анчны дуу” (Píseň lovce), “Бүүвэйн дуу” (Ukolébavka), “Хайрын захидал” (Milostný dopis) зэрэг шүлгүүд Йиржи Жаачекийн орчуулгаар “Хээр талын цай” номд орсон байна. Эдгээр бүтээлийн монгол эхийг чех орчуулгатай тулгахдаа МУЗД 26-р ботийг (УБ 1997) баримталсан болно.

“Анчны дуу” шүлгийн орчуулгад хийсэн ажиглалт

Монгол эх	Чех орчуулга
Арын ууланд ургасан	Bože jak jsou krásné květy
Алаг цэцэг сайхан аа	V horách v dáli na severu
Амраг хөөрхөн бүсгүй минь	Krásnější než všcky květy

Алаг цэцгээс сайхан аа.	Je má milá Na mou věru
-------------------------	---------------------------

Орчуулагч эхний бадгийн ...сайхан аа.. хэмээн дуу алдаж буй санааг гаргахдаа *Bože* “бурхан минь”, *Na mou věru* “миний итгэснээр” гэсэн хэллэг нэмж ашиглажээ.

Өврийн ууланд ургасан	Bože jak jsou krásné květy
Өнгийн цэцэг сайхан аа.	V jižních horách mezi křovím
Өөрийн янаг бүсгүй минь	Krásnější než všechny květy
Өнгийн цэцгээс сайхан аа.	Je má milá Však já to vím

Сайхан аа хэмээн дуу алдсан хэсгийг *Však já to vím* “Би үүнийг мэддэг” гэсэн нэмэлт өгүүлбэр оруулж орчуулсан байна. Харин гурав дахь бадгийг орчуулахдаа *хангай* гэдэг үгийг оноосон нэр гэж бодож, орчуулалгүй хэвээр хэрэглэжээ.

Монголоор	Чехээр
Хамаг ангийн дотроос	Jak je krásný horský jelen
Хангайн буга сайхан аа.	Na Changaji na pohoří
Хайрт манай хүүхнүүд	Krásnější je ale dívka
Хангайн буганаас сайхан аа.	Pro kterou mé srdce hoří

“Хайрт манай хүүхнүүд

Хангайн буганаас сайхан аа” гэсэн хоёр мөрийг “Миний сэтгэлийг хөдөлгөдөг бүсгүй илүү сайхан” гэж орчуулсан байна. Өөрөөр хэлбэл хүүхнүүдийг хэлсэнгүй, нэг л эмэгтэйн тухай өгүүлснээр буулгажээ.

3. Б. Явуухулангийн яруу найргийн орчуулга

Гэр (Jurta), Эх орны тухай дуу (Píseň o vlasti), Чи минь наддаа ирнэ (Přijdeš ke mne), Алтайн оргил (Vrchol Altaje), Цаг ирлээ ч гэсэн би үхэхгүй (Až se dovrší můj čas), Гэнэн насны дурлалын хойноос дуулсан дуу (Píseň o lásce z mládí), Сайхан чамдаа (Tobě má láska), Ай даа дуул, алтан гургалдай минь (Zpívej zpívej slavíčku)...зэрэг яруу найргийн бүтээл Йиржи Жаачекийн орчуулгаар “Čaj ve stepi” номд орсон ажээ. Б. Явуухулангийн яруу найргийн бүтээлүүдийн монгол эхийг МУЗД 34-р боть (УБ, 1998), Б. Явуухулан “Түүвэр зохиол” (УБ, 1985) зэрэг бүтээлээс авсан болно.

Б. Явуухулангийн “Гэр” шүлэгт ажиглалт хийе.

“Гэр” (Jurta)

Хаяа нь дэрвэсэн цагаан гэрийг	Vítr fíčí duje do kraje
Харуулдаж суугаа миний нүдэнд	Třese jurtou kde má láska je.
Аянч хун жигүүрээ дэлгэн	Bílá jurta začíná se chvět
Алс нисэх гэж байх шиг харагдлаа.	Jako labuť když chce uletět

Чех орчуулгыг үгчилбэл:

Тал нутагт салхи исгэрч байна.

Миний хайрын гэрийг ганхуулж байна.

Цагаан гэр ганхаж эхэллээ.

Нисэн одоохыг хүсэх хун шиг...

...Аянч хун... гэдгийн ...аянч... гэсэн үгийг орчуулалгүй үлдээжээ.

Айснаас болж дотор минь палхийвч	Srdce se mi svírá bolesti
Андурснаа мэдээд сэтгэлээ барилаа	Vítr mě chce okrást o štěstí

Янаг хүүхний минь суудаг гэр Яг л нисчих гээд байх шиг зовоох юм.	Moje srdce strachy chvěje se. Že mou milou vítr odnese
--	---

Чех орчуулгыг үгчилбэл:

Зүрх минь өвдсөндөө зовж байна.

Салхи миний аз жаргалыг хулгайлахыг хүсэж байна.

Зүрх минь айснаас болж чичирч байна.

Миний хайртыг салхи аваад явчих вий гээд

...Янаг хүүхний минь суудаг гэргэсэн хэсгийг орчуулсангүй, ...Миний хайртыг салхи аваад явчих вий... гэж ташаа орчуулжээ.

4. М. Цэдэндоржийн яруу найргийн орчуулга

М. Цэдэндоржийн *Хүн хүндээн, Уурга барьж өссөн би, Хасаг өвгөнд бичсэн захидал...* зэрэг бүтээл “Сaj ve steri” номд Владимир Яновичийн орчуулгаар гарчээ. Монгол эхийг МУЗД 51-р ботиос (УБ, 1998) авсан болно. М. Цэдэндоржийн шүлгүүдээс “Уурга барьж өссөн би” шүлгийн орчуулгад ажиглалт хийе.

“Уурга барьж өссөн би” (Vyrůstal jsem s úrgou v ruce)

Монгол эх	Чех орчуулга
Уртын дуу шиг цангинасан салхи сөрж Уурга барьж өссөн би	<i>Vitr mi vetkal do vlasů svou píseň Vyrůstal jsem s úrgou v ruce.</i>

Чех орчуулгыг үгчилбэл: Салхи үсэнд минь дуугаа нэхэв.

Гартаа уургатай өссөн би.

Энэ хоёр мөрийн орчуулгад ...уртын дуу шиг цангинасан салхи... гэдгийг орчуулсангүй. Зүгээр салхи гэж буулгажээ. Уурга гэдэг үгийг орчуулалгүй үндэсний онцлог үг хэмээн үзэж уурга гэдгээр нь ашигласан байна.

Усны түрхрээ шиг шаагсан адуугаа хурааж Уурга барьж өссөн би	<i>Svolával jsem tiché stádo koní A bylo to, jako když se blíží vodopád. Vyrůstal jsem s úrgou v ruce</i>
--	---

Чех орчуулгыг үгчилбэл: Би намуухан адуун сүргээ хурааж байсан.

Тэгэхэд усны хүрхрээ ойртсон мэт байсан.

Гартаа уургатай өссөн би.

Уулын хяр дээр нартай уралдан гарч Уурга барьж өссөн би.	<i>V horách vzdoroval jsem slunci Vyrůstal jsem s úrgou v ruce,</i>
---	---

Чех орчуулгыг үгчилбэл: Уулан дээр нарыг угтаж

Гартаа уургатай өссөн би.

Унааны нуруун дээр гарахдаа Уурга тулж дассан би	<i>V letu vyskakoval do sedla V letu o úrgu se opíral.</i>
---	--

Чех орчуулгыг үгчилбэл: Эмээл рүүгээ харайхдаа

Уурга тулдаг байсан.

Уурга хаяхад үзэгдэмгүй Ургамал сахлаг нутагтай би.	<i>V našem kraji roste nejhustější tráva Všechno, i úrga se v ní ztrátí</i>
--	---

Чех орчуулгыг үгчилбэл: Манай нутагт хамгийн өтгөн өвс ургадаг

Бүх юм, уурга хүртэл өвсөнд гээгддэг... гэж буулгажээ.

Гурын хүзүүгээр сүлжсэн	Zhotovil jsem pružnou úrgu
-------------------------	----------------------------

Гурамсан урт хуйвтай Хангайн модноос залсан Хярсан хусан уургатай	z březové panny changajského lesa Smyčka je dlouhá, ze tří řemínků, spletených z kůže srnčí šíje.
---	---

Чех орчуулгыг үгчилбэл:

Хангайн ойгоос авсан хус модоор уян уурга бэлдсэн би
Гурын хүзүүний арьсаар сүлжсэн
Гурван нарийн суран оосортой хуйв нь урт.

Үгчлэн орчуулсан нь оновчтой болжээ.

Агтын манлай болсон аргамаг таргамаг морьтой Урьдын өвөг дээдэс минь уургачин туургачин удамтай	Mám ztepilého argamaka, který jde v čele mého stáda. Mám v sobě svoje dávné předky, Co byli zkušenými lovci koní.
--	--

Чехээр орчуулсныг үгчилбэл:

Гоолиг биетэй аргамаг хүлэг надад бий
Аргамаг хүлэг миний сүргийн толгойд явдаг
Адуу уургалдаг туршлагатай
Эртний өвөг дээдэс надад бий.

Энэ бадагт орсон *аргамаг* гэсэн үгийг орчуулалгүй, үндэсний онцлог үг хэмээн үзэж хэвээр үлдээжээ.

Хур дэлт хөлөгтэй Хуурчин дуучин алдартай	Mám argamaka s dlouhou hřívou A pověst lidového barda.
--	---

Чехээр орчуулсныг үгчилбэл: Урт дэлтэй аргамаг хүлэг бий.

Ардын дууны алдар бий.

Энэ бадагт хур дэл гэснийг орчуулагч урт дэл гэж буулгажээ.

Унааныхаа хурдыг шилж, уургынхаа уртыг барьж Тарсан адуугаа хураасан монгол Тасархай улсаа нэгтгэсэн монгол	To kdysi Mongol vybral nejlepší své koně, Uchopil nejpružnější úrgy, Shromáždil zatoulaná stáda, Sjednotil rozdrobenou zemi,
--	---

Чехээр орчуулсныг үгчилбэл:

Нэгэн цагт монгол хүн хамгийн сайн морьдоо сонгож
Хамгийн уян уургыг атгаж
Тарсан адуун сүргээ хураасан
Бутарсан улсаа нэгтгэсэн гэж буулгажээ.

Чех орчуулгад буй энэ бадаг монгол эхэд алга байна.

Do cvalu dal se na divokých koních, Do úrgy začal chytat cizí svět. Kdykoli synové chánů propadli neshovnosti, Pokaždé stáli se oběti nájezdníků	Чех орчуулгыг үгчилбэл: Давхиут дундаа зэрлэг адуунд мордож Харийн ертөнцийг уургалж эхэлсэн. Хан хөвгүүд түнжин хагарах бүр Харийн дайчдын олз болж байв.
---	--

Дараагийн бадаг:

Монгол эх	Чех орчуулга
Улайрсан дайсны хомхой зүрхэнд Улайдсан туурайгаар тамга дараад Атар талын уургачин ард	Lid s úrgou v ruce na rozlehlých pláních kouřící podkovou vypálil cejch do srdce chamtivého nepřitele

Амар жаргалыг эмээллэн одном.	Pro sebe osedlal štěstí a klid.
-------------------------------	---------------------------------

Чех орчуулгыг үгчилбэл:

Өргөн уудам тал нутагт

Уурга барьсан ард түмэн

Хомхой дайсны зүрхэнд

Улайссан туурайгаар тамга дараад

Аз жаргал амар тайвныг өөртөө эмээллэсэн юм.

Монгол эх	Чех орчуулга
Унааны сайн, замын нөхөр гэж Удамт монголын үгсийн сүрэгт орж Усгал дөлгөөн жороог нь олж Уургалж авчирлаа би	Dobrý kůň, říka se je dobrým souputníkem Proto jsem ulovil zvláštního kopytníka a vtáhl jej do stáda mongolských slov.

Чех орчуулгыг үгчилбэл:

Сайн морь сайн хань гэдэг.

Иймээс би тусгай туурайтныг барьж

Монгол үгийн сүрэгт оруулав.

Орчуулагч ...Усгал дөлгөөн жороог нь олж... гэсэн өгүүлбэрийг орчуулсангүй, орхижээ.

Уншигч танд би эмээлэж өгье Хазаар дугтралтгүй унаа шүү Хангай давах хөлөг шүү Ташуур хүргэлтгүй унаа шүү Тал туулах хөлөг шүү.	Pro tebe sedlám ho, můj milý čtenáři. Ten kůň i bez úzdy Changajské hory překoná, Ten kůň i bez biče Přemůže step.
---	--

Сүүлийн бадгийг үгчлэн орчуулсан бөгөөд утгын зөрүү гарсангүй.

5. Ч. Лхамсүрэнгийн яруу найргийн орчуулга

“Шөнийн Улаанбаатар”, “Дөрвөн мөрт” зэрэг 6 шүлэг “Čaj ve stepi” номд Иосеф Петеркагийн орчуулгаар оржээ. “Skály v rodném kraji” (Төрсөн нутгийн хад), “Vítání hostů” (Зочдыг угтахуй), “Fotografie” (Фото зураг), “Holčička maluje moře” (Бяцхан охин тэнгис зурж байна.) гэсэн дөрвөн шүлгийг монгол ном зохиолоос хайсан боловч олдсонгүй. Ч. Лхамсүрэнгийн бүтээлүүдийн монгол эхийг МУЗД-ийн 36-р ботиос авсан болно.

Шөнийн Улаанбаатар (Ulánbátar v noci)

Уулын цаад руу нар жаргах үеэр Улаанбаатар сая живаа дэнгээ асааж Маргааш өглөөний мандах нарыг авчрах Манхайн цайгч үүрийн туяаг хүлээхдээ	Když zarudlé slunce za hory ubíhá, V Ulánbátaru se tisíce světýlek rozžihá, Když město čeká jitřenku, jež zítra Všem ohlásí příchod čerstvého jitra,
--	---

Эхний бадагт буй ...живаа дэн” гэх үгийг олон мянга гэж буулгасан байна. Сүүлийн хоёр мөрийн *мандах нар авчрах үүрийн туяа* гэсэн өгүүлбэрийг *...шинэ өглөө ирснийг зарладаг үүрийн туяаг хот хүлээж байхад...* гэж орчуулжээ.

Хав харанхуйг гийгүүлэх бамбараа өргөсөөр Хан тэнгэрийн ододтой шивнэнхэн хонодог л Орой шөнөөр ээлжийнхэн солигдож Олон арван үйлдвэр завод нижигнэн ажиллаж нь Тайван нойрссон их нийслэлийн минь зүрх Тааламж дөлгөөн цохилж байгаа нь тэр ээ.	Když zajiskří hvězdy na nebeské báni, To město jak věčné ohniště plane bez ustání, Po celou noc se směny střídají V zavodech, jež běží, vrní, broukají To srdce mého města svůj den pracovní má, Klidně bije, i když všecho dřímá,
---	---

Энэ бадагт буй *...орой шөнөөр ээлжийнхэн солигдож, олон арван үйлдвэр завод нижигнэн ажиллах нь...* гэсэн өгүүлбэрийг *...Шөнөөр ээлжийнхэн солигдож, үйлдвэрт гүйлдэж, хашхиралдаж, түжигнэдэг. ...гэж орчуулсан нь үйлдвэр заводыг үйлийн эзэн болгосонгүй, тэнд ажиллаж буй хүмүүсийг үйлийн эзэн болгож, утгын ялгаатай орчуулжээ.*

Шөнийн гэрэлтэй Улаанбаатараа харан байж Сүрт түмэн дэнлүүнээс нэгийг нь бас асааж Сүүмэлзэн далдирах биш цэлэлзэх гэрэлд нь сууж Шүлгээ бичих минь миний насны жаргал аа.	Ulánbátar září do tmy a já ho pozoruji, Jeden plamínek z tisíců i já zapaluji, Je pravidelný, pevný, ani v silném větru mihotavý, Já při něm píšu báseň a strašně mě to baví.
---	---

Чех орчуулгыг үгчилбэл:

Улаанбаатар шөнийн харанхуйд гялалзаж, би түүнийг ажиглана.

Мянга мянган дэнлүүнээс нэгийг би бас асаадаг.

Тэр нь тогтмол, бат бөх, хүчтэй салхинд ч анивчихгүй

Би дэнлүүний дэргэд шүлгээ бичиж, энэ нь намайг жаргаадаг.

...Шөнийн гэрэлтэй Улаанбаатараа харан байж... гэхийг ...Улаанбаатар шөнийн харанхуйд гялалзаж, би түүнийг ажиглана гэж буулгажээ. ...Сүүмэлзэн далдрах биш цэлэлзэх гэрэлд нь... гэхийг... Тэр нь тогтмол, бат бөх, хүчтэй салхинд ч анивчихгүй гэж орчуулжээ. Цэлэлзэх гэрэл гэснийг орхижээ.

6. Ч. Чимидийн яруу найргийн орчуулга

Ч. Чимидийн Лимбэчин (Flétnista), Хоёр гургалдай (Dva slavíci), Намар цаг (Podzim), Эх орон Өлгий минь (Vlast, má kolébka), Говийн дуу (Gobijská píseň), Баатар (Hrdina) Чамдаа (Tobě) зэрэг 7 яруу найраг эрдэмтэн Йиржи Шимагийн орчуулгаар “Čaj ve stepi” номд орсон байна. Монгол эхийг тулгахдаа Ч. Чимид “Түүвэр зохиол” (УБ, 1984), МУЗД 7-р боть зэргийг баримтлав. МУЗД 7-р ботийн 270-р талд “Чамдаа” (Tobě) шүлэг нэргүйгээр нийтлэгджээ. Чех орчуулгад “Tobě” “Чамд” гэсэн нэртэй байна.

Монгол эх	Чех орчуулга
Санасан бодсоноо хэлэхэд Сайхан чи минь мишээх юм. Сайхан чи минь мишээхэд Сарны туяа тусах юм.	Jenom co rozevřu duši, Odpovíš úsměvnou tváří. Úsměv ti náramně sluší, Jak luna na nebi září.

Чех орчуулгыг үгчилбэл:

Сэтгэлдээ байгаагаа хэлэхэд

Инээмсэглэлт царайгаараа хариулах юм.

Тэнгэрт буй саран гялалзах шиг

Инээмсэглэл чамд сайхан зохиж...

Хоёр дахь бадаг

Сайхан туяа сайхан Сайхан гэвч гүехэн Сарны туяа саруулхан Саруул гэвч хүйтхэн	Nebeská luna je mámivá, Živoucí krev jí schází. Luna je bledá a chladivá A taky někdy mrazí.
---	---

Чех орчуулгыг үгчилбэл:

Тэнгэрийн саран сайхан
 Амьд цус түүнтэй уулзана
 Сарны туяа цагаан бас сэрүүн
 Бас заримдаа хөлддөг.

Гурав дах бадаг

Сарны туяа шиг мишээлтээ Нарны илчээр тэтгээч Нарны илч шиг хайраар Намайг чи ивээгээч.	Úsměv jak paprsky měsíce Rozeřej slunečním teplem. Dobrotou vesmírné stálice Chraň mě a buď mi světlem.
--	--

Сүүлийн бадагт буй *...Нарны илч шиг хайраар Намайг чи ивээгээч...* гэхийг *огторгуйн одны сайхан сэтгэлээр намайг хамгаалаач, надад гэрэл болооч* гэж орчуулжээ.

7. Д. Пүрэвдоржийн шүлгийн орчуулга

Д. Пүрэвдоржийн “Чи минь битгий мартаарай” (Nezapomeň na mě), Хээр талын цай (Čaj uprostřed stepi) зэрэг 4 шүлэг мөн Владимир Яновичийн орчуулгаар гарсан байна. “Jestli mě nemiluješ” (Хэрвээ чи намайг хайрлахгүй бол), “Já nechci do ráje” (Би диваажинд очихыг хүсэхгүй) гэсэн шүлгүүдийн монгол эхийг олж чадсангүй. Монгол эхийг тулгахдаа МУЗД 35-р ботид (УБ, 1998) орсныг баримтлав. Эдгээр шүлгээс “Чи минь битгий мартаарай” шүлгийн орчуулгад ажиглалт хийе.

Чи минь битгий мартаарай (Nezapomeň na mě)

Хархан нүдний талимаанд чинь Хайлан уяран суухдаа Ханийн жаргал амласнаа Хайрт минь би мартаагүй.	Když jsem tonul se tvých očích, Zakoušeje chvíle blaha, Slíbil jsem ti život ve dvou Nezapomněl jsem, má drahá.
--	--

Чех орчуулгыг үгчилбэл:

Чиний нүдэнд өртөж
 Аз жаргалыг туулж байхдаа
 Хамтын амьдрал амласнаа
 Би мартаагүй хайрт минь

Утга нь ерөнхийдөө гарсан боловч *хархан нүд, талимаа* зэрэг үгсийг орчуулсангүй.

Шан туушин гэзгийг чинь Шанхыг илбэн суухад минь Чин хайраа амласнаа Чи минь битгий мартаарай.	Když jsem hladil tvoje vlasy, Copy, jež sis rozpustila, slíbilas mi čistou lásku. Nezapomeň, roztomilá.
---	--

Чех орчуулгыг үгчилбэл

Чиний үс, чиний задалсан
 гэзгийг илж байхдаа
 цэвэр хайраа амласнаа
 Чи минь битгий мартаарай.

Шан туушин, шанх зэрэг үгсийг орчуулсангүй.

Алиа хөөрхөн аашинд чинь Аясан эрхлэн суухдаа Амьдын жаргал амласнаа	Když jsem laskal tě a škádlil -ty ses přitom veselila- Slíbil jsem ti věčnou lásku.
--	---

Амраг минь би мартаагүй.	Nezapomněl jsem, má milá.
--------------------------	---------------------------

Чех орчуулгыг үгчилбэл

Чамайг энхрийлж, шоолж байхад

Чи хөгжилтэй байсан

Чамд би мөнхийн хайраа амласан

Хайрт минь би мартаагүй.

...Амьдын жаргал... гэсэн үгийг ...мөнхийн хайр... гэж орчуулжээ.

Бадамлянхуа уруулын чинь	Když jsem z lotosových rtků
Балыг амтлан суухад минь	Bral med-ach ta sladká mana-
Хорвоогийн жаргал амласнаа	Slíbilas mi věčné štěstí.
Хонгор минь битгий мартаарай.	Nezapomeň, milovaná.

Чех орчуулгыг үгчилбэл:

Бадамлянхуа уруулаас

Балын амт, чихэрлэг амтыг амтлахад

Чи надад мөнхийн жаргалыг амласан.

Битгий мартаарай, хайрт минь.

...Хорвоогийн жаргал... гэдгийг ...мөнхийн жаргал... гэж орчуулжээ.

8. М. Ширчинсүрэнгийн яруу найргийн орчуулга

М. Ширчинсүрэнгийн Ай намар цаг (Sladký podzim), Хүүгээ санаж явна (Myšlenka na syna), Хайр (Láska), Дөрвөн мөрт (Čtyřverší), Өгүүлэл (Vyznání), Ээжийн цай (Maminčin čaj) зэрэг бүтээлүүд Карл Сийсийн орчуулгаар “Čaj ve stepi” номд орж нийтийн хүртээл болжээ. Монгол эхийг орчуулгатай тулгахдаа МУЗД 54-р боть (УБ, 1998), М. Ширчинсүрэн “Хүслийн хүлэг” (УБ, 1987) зэргийг баримталсан болно.

“Хайр” шүлгийн эхний бадагт ажиглалт хийснээ өгүүлье.

Их л хайртай юм даа би чамд	Ó jak tě miluji
Их хайртай юмаа.	Jak velice tě miluji
Хайрынхаа ихийг мэдрүүлж	Kdybys chtěla vyzkoušet mou lásku
Хан хурмаст уулын	Kdybys řekla abych přinesl
Орой дээр гарч	Světlo které hoří na hvězdách
Одон саранд сарвайж	Abych na posvátnou horu vystoupil
Амьд насанд ханахааргүй	Na Chanchurmast kde sídlí bohové
Альмад гэгээн жаргалыг	Zlezl bych i její ostrý vrcholek
Авчирч өгөө гэвэл	Kam nedoletí nikdo ani pták
Шувуу ч нисэж хүрэхээргүй	A tvoje přání drahá vyplnil
Шовх оргилд нь гарахаар	A navrátil se k tobě zpátky na zem.
Яваад л өгөх хүн дээ би	

Чех орчуулгыг үгчилбэл:

Ээ, Би чамд ямар их хайртай юм бэ?

Үнэхээр их хайртай юм аа.

Хэрэв чи миний хайрыг шалгах гэж

Оддын тэнд буй гэрлийг

Авчирч өгөөч гэвэл

Бурхдын суудаг Хан хурмаст руу

Ариун дагшин уул руу авираач гэвэл
 Шувуу ч нисэж хүрдэггүй
 Тэр шовх оргил руу авирах л байсан
 Чиний хүслийг биелүүлчхээд
 Газарт эргээд чам руу ирэх л байсан.

Утгын хувьд зөрүүтэй орчуулжээ. Энэ шүлэгт буй *Хан хурмаст* гэдэг үгийг орчуулалгүй хэвээр үлдээжээ. Тэгэхдээ Хан хурмаст уулын орой дээр гарч гэхийг ... *Abych na posvát nou horu vystoupil Na Chanchurmast kde sídlí bohové* ...Бурхдын оршдог Хан хурмаст руу, ариун уул руу намайг авир гэвэл... гэж орчуулжээ.

9. Ш. Дулмаагийн яруу найргийн орчуулга

Ш. Дулмаагийн “Бүсгүй” (Dívčí úsměv буюу Бүсгүйн инээмсэглэл), “Газар шороондоо би хайртай” (Mám ráda svůj rodný kraj), “Эцгийн голомт” (Otcovský krb) зэрэг бүтээлийг Яна Моравцовагийн орчуулгаар *Čaj ve stepi*” номд оруулжээ. “Vzpomínky na venkov” (Хөдөөгийн дурсамж), “Vlny modravého jezera” (Цэнхэр нуурын долгио), “Můj kůň” (Миний морь) зэрэг шүлгийн монгол эхийг олж чадсангүй.

Монгол эхийг орчуулгатай тулгахдаа Ш. Дулмаа “Талын энгэр” УБ, 1989, МУЗД 79-р боть (УБ, 2000) зэрэг бүтээлийг баримтлав. “Газар шороондоо би хайртай” шүлгийн үндэсний онцлог үг хэллэг агуулсан эхний гурван бадагт ажиглалт хийе.

“Газар шороондоо би хайртай” (Mám ráda svůj rodný kraj)

Хөлд орохдоо унаж босож мөрөө гаргаж Хүйтэн булгийн уснаас нь шүдээ таштал залгилж Талын тогоруу нуурын ангир үргээж Таанын толгой цэцгийн дэлбээ түүж явсан болохоороо Газар шороондоо би хайртай.	Mé první krůčky byly samý pád. Korálky - šňůra stop. Z ledových studánek doušky mi zvonily o zuby. Plašivala jsem divoké husy a ve stepi jeřáby, Trhala jsem si květy a barevné paličky česneku- Proto mám ráda svůj rodný kraj.
---	---

...Газар шороондоо би хайртай... гэхийг ...би төрсөн нутагтаа хайртай... гэж орчуулжээ.

Толгодын энгэрээр хургаа хариулж явахдаа Тоодон дээлэндээ чулуу хормойлж гэр барин Хөрст газрыг нь хотойтол хөл нүцгэн гүйж Хөнгөн залуу насаа талд үдсэн болохоороо Газар шороондоо би хайртай.	Na jižních stránách jsem pásala jehňata, Sbírala jsem si kámenky a stavěla domečky, Běhávala jsem bosa-stopy tam zůstaly, I s dětskou hravostí jsem je tam nechala- Proto mám ráda svůj rodný kraj.
--	---

Үгчилбэл, Уулын өмнөд талаар хурга хариулж
 Чулуу түүж, байшин барьж
 Хөл нүцгэн гүйж-мөр тэнд үлдсэн
 Хүүхдийн томоогүй насаа үдсэн
 Тийм учраас төрсөн нутагтаа би хайртай.

...Тоодон дээлэндээ чулуу хормойлж, гэр барин... гэхийг ...чулуу түүж, байшин барьж... гэж орчуулсан нь үндэсний онцлог үгийг орчуулалгүй хассан алдаа болжээ.

Чехүүдийн хувьд *тоодон дээл, чулуу хормойлох, гэр барих* гэх мэт ойлголт соёлд нь байхгүй.

Ээжийн минь амгалан үедээ өрхийг нь татаж Энгэр бэл дээр цэмцийн харагддаг байсан Төрсөн гэрийн минь буурь мөөгөн хүрээ татаж Төө зайгүй амьдралын илч шингээж байдагт нь Газар шороондоо би хайртай.	Co zbylo z mé jurty, je jako otisk hnízd, Jak vzpomínka na jižním svahu vše zůstalo. Maminka v jurtě vždy ōrhí srovnala, Mé dětství prosáklo celým domovem- Proto mám ráda svůj rodný kraj.
---	---

Үгчилбэл,

Миний гэрээс үлдсэн зүйл нь үүрний ул мөр
Дурсамж болгон бүх зүйл өмнөд энгэрт үлджээ.
Гэрт ээж үргэлж өрхийг засдаг байсан,
Миний бага нас бүхэл бүтэн гэрт шингэсэн
Тийм ч учраас би төрөлх нутагтаа хайртай

Өрх гэдэг үгийг ...*ōrhi* ... гэж орчуулалгүй хэвээр үлдээжээ. ...мөөгөн хүрээ... гэсэн үгийг орчуулсангүй.

10. С. Дашдооровын яруу найргийн орчуулга

С. Дашдооровын “Монгол зан” (Mongolská povaha), “Чиний гоо сайхан” (Tvoje krása), “Цонхны цаана хүүхнүүд инээлдэнэ” (Dívky za oknem), “Би хоньчин явлаа” (Když jsem byl ovčákem), “Нүүдлийн шувуу” (Stěhovací ptáci), “Амьдын жаргал” (Štěstí života), “Мөнх нэгэн цэцэг” (Květina věčně zelená), “Ширүүн борооны өмнөхөн” (Před líkákem) зэрэг бүтээл Карел Сийсийн орчуулгаар “Čaj ve stepi” номд орсон байна. Монгол эхийг орчуулгатай тулгахдаа С. Дашдооров “Тал бид хоёр” (УБ 1978) бүтээлийг баримтлав. “Монгол зан” шүлгийн эхний 3 бадгийн орчуулгад ажиглалт хийе.

Монгол зан (Mongolská povaha)

Монгол эх	Чех орчуулга
Хүсэл зөгнөлийн биелэл мэт Усан зэрэглээ цэлэлзэх талд Хүврэх замын харуул мэт Уулсын бараа цэнхэрлэх тэртээд	Nad stepí se chvěje fata morgána Plníc tušení a tajná přání A za ní v dálce kde se hory modrají Bdí strážci křivolakých stezek

Чех орчуулгыг үгчилбэл:

Талд зэрэглээ татна
Зөгнөл болон нууц хүсэл биелж
Түүний цаана уулс цэнхэртэх алсын замд
Жирэлзэх замын харуул сэрүүн байна.

Монгол эх	Чех орчуулга
Аянчин гийчний бараа харуутаа Улаан галаа яаран асаадаг Аагтай хонгор цайгаа аягалж Уран гарынхаа үзүүрт дэвшүүлдэг	Spatří-li pocestného Spěšně rozdmýchají silný plamen A již rozlévají horký čaj Který stěží jemných pstech udržís

Чех орчуулгыг үгчилбэл:

Аянчин гийчнийг харвал
Хүчтэй галаа яаран асаадаг
Халуун цайгаа аягалж
Зөөлөн хуруундаа барьдаг

Орчуулгад ялгаатай байгаа зүйл нь *...аагтай хонгор цайгаа аягалж...* гэхийг *...халуун цайгаа аягалж...* гэж орчуулжээ.

Монгол эх	Чех орчуулга
Малчны бяцхан хот	Pohled'-v této malé osadě
Манайх гэж нэг айл бий	Stojí má rodná jurta
Элбэг талын эгэл эзэн	Hospodyní v této bohaté stepi
Эжий минь гэж нэг авгай бий.	Je má matka

Чех орчуулгыг үгчилбэл:

Энэхүү жижиг сууринг харвал
Миний төрсөн гэр бий.
Энэхүү баян талын эзэгтэй нь
Миний ээж мөн.

Энэ бадагт буй *...малчны бяцхан хот...* гэсэн үгийг *...жижиг суурин...* гэж буулгажээ. Малчны хот гэсэн ойлголт Чехэд байхгүй учир ингэж дүйлгэсэн байна.

ДҮГНЭЛТ

1979 онд Чехословакт монгол яруу найргийг чех хэлээр чех орчуулагчид орчуулан *Čaj ve stepi* “Хээр талын цай” буюу “Монголын орчин үеийн 10 яруу найрагч” гэсэн ном хэвлэн гаргажээ. Энэхүү номд Б. Ринчен, Ц. Дамдинсүрэн, Ч. Лхамсүрэн, Ч. Чимид, Б. Явуухулан, М. Цэдэндорж, Д. Пүрэвдорж, М. Ширчинсүрэн, Ш. Дулмаа, С. Дашдооров нарын 61 яруу найраг орсон байна. Б. Ринчений “Нөхдөдөө мэнд хүргэе”, Ц. Дамдинсүрэнгийн “Анчны дуу”, Б. Явуухулангийн “Гэр”, М. Цэдэндоржийн “Уурга барьж өссөн би”, Ч. Лхамсүрэнгийн “Шөнийн Улаанбаатар”, Ч. Чимидийн “Чамдаа, Д. Пүрэвдоржийн “Чи минь битгий мартаарай”, М. Ширчинсүрэнгийн “Хайр”, Ш. Дулмаагийн “Газар шороондоо би хайртай”, С. Дашдооровын “Монгол зан” зэрэг 10 бүтээлийн орчуулгыг эх бүтээлтэй тулгаж, чех орчуулгыг үгчлэн буулгаж, утгын зөрүү байгаа эсэхийг ажиглаж дараах дүгнэлтэд хүрэв.

- Монгол яруу найргийн бүтээлийг чех хэлэнд орчуулж нийтийн хүртээл болгосон нь талархууштай. 61 бүтээлийг чех хэлэнд орчуулсан нь бага тоо биш.
- Үндэсний онцлог үг хэллэгийг орчуулалгүй хассан, буруу ойлгож буруу орчуулсан, зарим тохиолдолд үндэсний онцлог үгийг хэвээр хадгалан орчуулгад ашигласан гэх мэт олон янзын орчуулгын хэв маяг байгаа нь орчуулагчдаас хамаарсан байж болох юм. Тухайлбал, *бор гэр* гэхийг “үхрийн арьсан гэр”, *малчны хот* гэхийг “жижиг суурин”, *...Тоодон дээлэндээ чулуу хормойлж, гэр барин...* гэхийг *...чулуу түүж, байшин барьж...* гэж буулгажээ. Эдгээр яруу

найргийн бүтээлд *уурга, өрх, аргамаг, хангай, ханх урмаст* зэрэг үгсийг орчуулалгүй хэвээр хэрэглэжээ.

- Зарим бүтээлийн утга санаа төдийлөн сайн гарсангүй. Соёлын ялгаатай үг хэллэгийг зарим тохиолдолд тайлбарлаж орчуулсныг дээрх бүтээлүүдээс харах боломжтой байна.
- Чех яруу найргийн хэмнэлд оруулах гэж монгол бүтээлд буй үг хэллэгийг хасах, үгийн тоо зөрүүтэй байх, соёлын ялгаанаас болж зөрүүтэй орчуулсан гэх мэт онцлог байна.
- Орчуулсан орчуулагчдыг харахад Йиржи Шима эрдэмтнээс бусад нь монгол судлаач биш, дам орчуулга хийсэн байх магадлалтай байна. Аль хэлнээс чех хэлэнд орчуулсныг дурдаагүй байна.

Номзүй

Англи хэлээр

Bassnett. (1991). Translation Studies. Routledge.

Lefevere. (1975). Translating Poetry: Seven Strategies and a Blueprint. Amsterdam: Van Gorcum.

Монгол хэлээр:

1. Дашдооров С.(1978) Тал бид хоёр, УБ
2. Дулмаа Ш. (1989) Талын энгэр, УБ
3. Монголын уран зохиолын дээж 108 боть, Нууц янаг, 7-р боть, 1994
4. Монголын уран зохиолын дээж 108 боть, 27-р боть, Цогт тайж, УБ, 1997
5. Монголын уран зохиолын дээж 108 боть, 26-р боть, Ц. Дамдинсүрэн, УБ, 1997
6. Монголын уран зохиолын дээж 108 боть, 34-р боть, Б. Явуухулан, УБ, 1998
7. Монголын уран зохиолын дээж 108 боть, 35-р боть, Эрээн уул, УБ, 1998
8. Монголын уран зохиолын дээж 108 боть, 36-р боть, Ч. Лхамсүрэн, УБ, 2005
9. Монголын уран зохиолын дээж 108 боть, 44-р боть, Магеллан хаагуур явсан бэ?, УБ, 1998
10. Монголын уран зохиолын дээж 108 боть, 51-р боть, Бурхан буудайн хөх салхи, УБ, 1998
11. Монголын уран зохиолын дээж 108 боть, Шувуутай мод, 54-р боть, УБ, 1998
12. Монголын уран зохиолын дээж 108 боть, 79-р боть, Би ертөнцийн хүүхнүүдийн нэг, УБ, 2000
13. Монголд яруу найргийн онол, орчуулгатай холбоотой гарсан онолын ном зохиол нь
14. Орчуулах эрдэм 3, УБ, 1982
15. Орчуулах эрдэм 4, УБ, 1986
16. Орчуулгазүй: Яруу найргийн орчуулга, УБ, 2015 №04 (422)
17. Томтогтох, Г. (2012). *Хэл шинжлэлийн удиртгал*. УБ.

18. Чимид Ч. (1984) Түүвэр зохиол, УБ
19. Ширчинсүрэн М. (1987) Хүслийн хүлэг, УБ
20. Явуухулан Б. (1985) Түүвэр зохиол, УБ

Чех хэлээр

Čaj ve stepi, Deset současných mongolských básníků, Praha, Československý spisovatel, 1979

ИРЙӨН УУ? ИЛЬ НОЁН УУ?

Г. Эрдэнэчимэг⁶²

요약

지난 20 여년 동안 몽골에서 한국문학작품 번역이 매우 활발하게 이루어졌지만, 번역에 대한 비평은 거의 찾아볼수 없습니다. 하지만 번역에 대한 심도 있는 비평이 이루어져야 번역의 수준이 향상될수 있습니다.

저는 이번에 한국의 문학번역원 지원으로 출간된 ‘한국학의 즐거움’의 몽골어 번역본을 읽어보았습니다. 번역본은 전반적으로 몽골어 번역이 매끄럽지 못해서 원저자의 의도를 제대로 살리지 못한 부분이 상당히 여러 군데 보였습니다. 번역이 매끄럽지 못하다는 것은 정확한 어휘 대역이 이루어지지 않았고, 번역문 몽골어의 문체가 일반 몽골인 독자들에게 생경하거나 부자연스럽다는 것입니다. 각 분야에서 왕성하게 활동중인 필자 22명의 원고를 몽골어로 좀더 정확하고 매끄럽게 번역했다라면 몽골독자들이 ‘한국적인 것’을 좀더 깊이 이해하는 계기가 되었을 것이라는 아쉬움이 남습니

Түлхүүр үг: соёл судлал, үг оноолт, хам сэдэв, бялангач үзэл, хятадчилах, сэдэ, садэбу,

БНСУ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Технологийн Яамны харьяа Солонгос Судлалыг Дэмжих Албанаас Солонгос судлал (Korean Studies) гэдэг ухагдахууныг мэргэжлийн түвшинд тодорхойлох шаардлагатай гэж үзээд 2009 оны өвөл нэр хүндтэй эрдэмтэн судлаачдын дунд хэлэлцүүлэг өрнүүлсэн ажээ. Хэлэлцүүлгийн дүнд 2011 оны 8-р сард Их сургуулийн профессор эрдэмтэн, гүн ухаантан, яруу найрагч, утга зохиолын шүүмжлэгч зэрэг Өмнөд Солонгосын 22 соён гэгээрүүлэгчийн бичсэн өгүүллийг эмхэтгэсэн “Солонгосыг судлахын цэнгэл (한국학의 즐거움)” хэмээх бүтээл уншигчдын гарт очжээ. Уг бүтээлийг БНСУ-ын их дээд сургуулиудад ахисан түвшинд суралцаж, мэргэжлээрээ чамгүй олон жил ажилласан, их дээд сургуулийн багш голцуу монгол судлаачид орчуулж, 2017 онд “Солонгос түмнийг тольдохуй” нэрээр хэвлэн монгол уншигчдын гарт хүргэв.

Аливаа бүтээлийг орчуулахад соёл судлалын үүднээс хандах, уг хэлний өнгөн бүтэц төдийгүй, түүний гүн чанадад орших соёлын утга агуулгыг нь бүрнээ

⁶² Ph.D, МУИС, ШУС, ХУС-ын Ази Судлалын тэнхим

нээж илтгэхийг чухалчилж буй⁶³ эдүгээ үед ийм бүтээл гарсанд ихэд олзуурхсан боловч уншиж үзээд урам хугарав. Тэгээд орчуулгын чанарын талаар хэдэн үг нэмэрлэх нь зүйтэй гэж бодлоо. Алив бичиг зохиолд уншууртай байх гэж нэг чухал чанар бий. Үг үсгийн алдаагүй, утга төгөлдөр, найруулга сайтай бүтээлийг унших нь автомашинаар зүйрлэвэл толь шиг замаар салхи сэнгэнүүлэн давхих мэт гацаж торохгүй хурдан байдаг. Уг номыг уншихад эхний хуудаснаасаа энхэл догол замаар элэг бөөрөө доргион сэгсчүүлэх мэт санагдсаныг нуух юун.

Гэхдээ 22 өгүүлэл бүгд ийм уншуургүй биш. Номд орсон солонгос зохиолчдын бүтээл хэзээ ч үнэ цэнээ алдахгүй. Ямар нэг бичиг зохиолыг хэдэн ч хүн, хэдэн ч удаа орчуулж болох тул эдгээр өгүүллийг монгол уншигчдад илүү сайн хүргэхээр авьяас чадвараа сорих боломж манай орчуулагч, судлаачдад байна.

Энэ удаад бид уг номын арван хоёрдугаар өгүүлэл болох Нам Гёнтэ зохиолчийн “Солонгос түүх - Түүхийн нууцлагдмал код, Түүхийг эргэцүүлэхүй” хэмээх өгүүллийн орчуулгын талаар авч үзье. Уг өгүүлэл нь солонгосчуудын түүхийг үзэх үзэл, эх орныхоо түүхэнд хандах хандлага зэргийг ойлгоход тус болох чухал агуулгатай учраас анхаарал татахуйц, монгол уншигчдад хэрэгтэй, ач холбогдолтой өгүүлэл байв.

Гэвч эхнээсээ л ойлгомж муутай байлаа. Уг өгүүллийн “Үндэстэн угсаатан гэж ангилахын алдаа” хэмээх дэд хэсгийн амин сүнс, гол ухагдахуун гэж хэлж болох 사대주의 гэдэг үгийг Хятадын үзэл суртал (222-р нүүр), хувиа бодсон үзэл санаа (223-р нүүр), бялдуучилсан хэмээн гурван янзаар ташаа оноожээ. Гэтэл энэ нь илүү хүчирхэг улс, хүчирхэг хүчнийг аялдан дагалдах үзлийг хэлнэ. Тэгэхээр бялангачлах үзэл хэмээн оноож болох юм. Хорьдугаар зууны эхээр хэт үндсэрхэг үзэлтнүүд хүчирхэг, том улсад долдойдох эрх баригчдыг шүүмжлэн энэ үгийг хэрэглэх болжээ. 사대 гэдэг үг нь Солонгосын хувьд гадаад харилцааны уламжлалт бодлогыг нэрлэх үг бөгөөд олон улсын харилцаанд идэвхтэй оролцож, илүү хүчирхэг улстай тогтвортой найрсаг харилцсанаар өөрийн орны эрх ашгийг хамгаалахыг хэлдэг.⁶⁴

Солонгосын түүх нь Хятадын түүхтэй нарийн холбоотой. Тиймээс Солонгосын түүхийн холбогдолтой зүйлийг орчуулахад Хятадын түүхийн мэдлэг зайлшгүй хэрэгтэй. Мэдэхгүй бол хайж олж, эрэл хайгуул хийх хэрэгтэй. Харин орчуулагч энэ талаар тун хангалтгүй ажиллажээ. Тухайлбал, Хятадын төрт улсын нэрийг ташаа оноожээ. Тан улсыг мөхсөний дараа Ляо, Тан, Жин, Хань, Жоу

⁶³М.Чимэдцэеэ, “Улсыг засах, жараахай шарах хоёр адилхан. Харин амархан уу? Хэцүү юу?”, Орчуулгазүй №03, МУИС, Күнзийн Институт, 2014

⁶⁴[사대주의 - 위키백과, 우리 모두의 백과사전 \(wikipedia.org\)](http://www.wikipedia.org)

хэмээх улс байгуулагдсаныг түүхэнд Таван төрт улс гэж нэрлэдэг. Гэтэл үүнийг “Тан улс сүйрлийн дараах таван угсаа залгамжлалын цаг үе (223-р нүүр)” хэмээн ташаарсан байна. Мөн хятадчилах, Хятадын хэл соёлд уусгах гэсэн утгатай үгийг Хятадын даяарчлал хэмээн ташаа оноосны улмаас (223-р нүүр) нэг нүүр бичвэр тэр чигтээ учир утга нь олдохгүй бүрхэг болжээ.

Жиндөг хатан ванг Жиндөг хаан (222-р нүүр) гэх зэргээр бараг мөр бүрд үг ташаа оноосон алдаа гарч байна. Солонгосчууд улс төрийн тэргүүнээ эртнээс хаан бус ван гэж цоллож ирсэн бөгөөд дундад зууны Солонгос нь олон улсын Хятад төвт дэг журмыг хүлээн зөвшөөрсөн улс байлаа. Дэлхийн соёл иргэншлийн төв – Дундад улсын эзэн хэмээн өөрийгөө өргөмжилсөн Мингийн хуанди болоод түүнийг нь хүлээн зөвшөөрч, их улсад бага улс нь үйлчлэх ёстой гэж боддог Чосөн-ий ван хоёрын цол хэргэм нь зэрэг дэвийн хувьд ялгаатай. Цол хэргэмийн нэр нь солонгосчуудын, түүхэн хөгжлийн явцад бүрэлдэн тогтсон ертөнцийг үзэх үзлийн тусгал, уламжлалт соёлын тод илэрхийлэл тул бага гэж үл тоох зүйл биш юм.

Орчуулагчийн алтан дүрэмд “Үг өгүүлбэрийг хасаж болно. Утга санааг хасаж болохгүй” гэж бий. Гэтэл утга санааг огт орчуулалгүй хасаж орхисон зүйл цөөнгүй харагдаж байна. Тухайлбал, 218-р нүүрт “Өнгөрсөн алдаандаа дүгнэлт хийж, одоо цагт ч ул мөрөө үлдээсэн сөрөг элементийг засаж залруулахгүйгээр хөгжиж сайжирна хэмээн найдах аргагүй гэдэг бол хувь хүнд төдийгүй улс оронд ч адил гэдэг нь мэдээжийн зүйл юм”, 219-р нүүрт “Залгамж холбоогүй бол түүх биш”, 224-р нүүрний “тэнгисийн эрэг хавийн газарт нүүрлэсэн хар салхины тухай мэдээг нийслэлд мэдэгдэхийн тулд хэдэн өдөр болдог, нийслэлээс захирамж ирэхэд хэдийнээ хар салхи дайраад өнгөрчихсөн байдаг байлаа”, 223-р нүүрт буй “Ань Лу шаны бослого гарахад Сычуань руу зугтсан Тангийн Рүйзун” зэрэг өгүүлбэрийн доторх утгат хэсгүүдийг орчуулалгүй орхижээ. Тан улсын Рүйзун-г Тангийн Хёнжон гэх мэтээр хятад оноосон нэрийг солонгос дуудлагаар, кирилл үсгээр галигласан нь уншигчийг төөрөгдүүлэх зүйл болжээ. Мөн улс оронд нь үймээн самуун дэгдэж, Ань Лу шаны бослогын улмаас Сычуань руу зугтсан Тангийн Рүйзун-д тайтгаруулах элч илгээсэн атал “талархлын элч илгээсэн” хэмээн ташаа орчуулжээ.

Солонгосын түүхэн хүнийг монгол хүн гэж андуурсан зүйл байна. Үүнд 220-221 дүгээр нүүрэнд “тухайн үед эрх баригч байсан Иль ноён ба Есүнхэй” хэмээсэн нь орчуулагч хам бичвэрээ ойлгоогүйн илрэл гэлтэй. Энд Иль ноён хэмээн ташаа оноосон хувраг Ирийөн нь Корйөгийн сүүл үед “Гурван улсын нөхсөн судар” хэмээх албан бус түүхийг эмхэтгэн бичсэн хүн бөгөөд уг сурвалж бичгийг “Гурван улсын түүхэн тэмдэглэл”-тэй хамтаар Солонгосын түүх судлалын хос багана гэж үнэлдэг. Энд орчуулагч “Гурван улсын нөхсөн судар”-

ын нэрийг “Гурван улсын түүхийн он тоолол” хэмээн ташаа оноожээ. Мөн “Их вангуудын магтуу”-г зохиосон И Сын хюүг Есүнхэй гэдэг монгол хүн болгож орхисон байна.

Уг өгүүлэлд гарч буй нэр томъёо, ухагдахууны талаар сайн мэдэхгүйн улмаас жигдлээгүй, нэг үгийг хэдэн янзаар ташаа оноосон зүйл багагүй байна. Тухайлбал, “Орогсдын шалгалт”-ыг 225-р нүүрт “эзэн хааны төлөөх шалгалт”, “эзэн хаан шалгаруулах шалгалт”, “хааны шалгалт” хэмээн хэдэн янзаар оноожээ. Гэтэл орогсдын шалгалт гэдэг бол Хятад болоод Зүүн Азийн улс орнуудын нийгэм, соёлыг ухааж ойлгох үндсэн ухагдахууны нэг бөгөөд орчуулагчийн зүгээс тухайлан тайлбар, зүүлт хийх шаардлагатай байлаа.

Өгүүлийн тавдугаар хэсэг нь “*Садэбү* нар төр барьсан түүх” нэртэй. Орчуулагч садэбү-г төр баригч түшмэд хэмээн оноосон нь бас л оновчтой бус болжээ. Уг номын өөр нэгэн өгүүлэл болох “Солонгосын ном хэвлэл” хэмээх өгүүлэлд садэбү нарын тухай тодорхой тайлбарласан нь буй. *Садэбү* гэж хэн болохыг зохиогч бээр өгүүлэлдээ “Неоконфуцизмын үндсэн зарчмаар төр улс/нийгмийг сэхээтнүүд удирдах ёстой. “Бичиг уншвал *са* (士) хэмээмүй. Төрд зүтгэвэл *тэбү* (大夫) хэмээмүй” гэсэнчлэн *садэбү* нар нь үндсэндээ уншигчид байлаа. Эдгээр уншигчид “орогсдын шалгалт”-т тэнцсэнээр түшмэл болж, засаг захиргааны ажилд зүтгэнэ” хэмээн тодорхой тайлбарласан байна. Тэгэхээр төр баригч түшмэл гэхээр хэт ерөнхий, оновчгүй болох тул “садэбү” гэж галиглаад тайлбар зүүлт хийсэн бол уншигчдад илүү ойлгомжтой болох байлаа.

Орчуулагч тайлбар зүүлт хийгээгүйн улмаас ойлгомжгүй болсон зүйл бас нэлээд их гарч байна. 232-р нүүрт “сэдо улс төр” гэж гарч байгааг жирийн уншигч уншаад юу болохыг ойлгохгүй. Гэтэл энэ нь улсын вангийн нэрийн өмнөөс төр барьсан тодорхой нэг хүн юм уу, эсвэл улс төрийн хүчин, эсвэл вангийн нэрээр төр барьсан вангийн хадам талын цөөн гэр бүлийнхнийг хэлдэг.⁶⁵ Дээр нь энэ хэсэгт Англи-Жусоны хаант улс гэж хаана ч байхгүй, байгаа ч үгүй улс гаргаж иржээ. Эх бичвэрийг нягтлахаар Ёнжо ба Чөнжо вангийн засаглалын тухай бичжээ.

Эцэст нь дүгнэхэд:

Орчуулгын ажлын үе шатыг орчуулга хийх гэж буй хүн сайтар мэдэх шаардлагатай. Чимхлүүр, нягт нямбай ажиллагаа шаарддаг энэ ажлын тодорхой үе шатыг гүйцэтгэлгүй, бэх нь хатаагүй шахам анхны нооргоо хэвлэлийн газар руу барьж гүйдэг⁶⁶ байж болохгүй. Солонгос хэлнээс орчуулахад солонгос

⁶⁵ [세도정치 - 나무위키 \(namu.wiki\)](http://namu.wiki)

⁶⁶ (Р. Гүрбазар, Орчуулгын онол дадлагын үндэс, 7-9 тал)

бичгийн хэлний мэдлэг, Солонгосын соёл, түүхийн мэдлэг, монгол хэлээрээ найруулан бичих чадвар, үгийн баялаг сайтай байх нь тун чухал. Үг ташаа оноосон зүйл цөөнгүй тул нэг бүрчлэн тоочсонгүй. Нэг үгийг хэдэн янзаар оноох нь уншигчийг төөрүүлж орхино.

Оноосон нэрийг монгол кирилл үсгээр галиглахдаа ямар галигийн журам ашигласан нь тодорхойгүй. Солонгос хэлний оноосон нэрийг монгол хэлээр галиглах журам байдаг ч улсын хэмжээнд нэг мөр мөрдөхөөр батлаагүй тул түр орхив.

Орчуулагч хүн бол орон судлаач байх хэрэгтэй. Орчуулах гэж буй зүйлийнхээ талаар мэдлэг хомс, утга учрыг нь олоогүй бол яаран орчуулах гэж оролдох хэрэггүй. Эхлээд холбогдолтой ном, материалыг олж уншиж судлах нь нэн чухал. Орчуулагч хүн бүгдийг мэдэх албагүй. Харин байнга эрж хайж, сурч судлах шаардлагатай. Толь бичгээс өөр “багаж зэвсэг”-гүй ахмад үеийн орчуулагч нартай харьцуулахад интернэтийн эриний залууст эрэл хайгуул хийх нь хялбар ажил болсныг сануулах юун.

Орчуулгыг ариутган шүүх үүргээ редактор гүйцэтгэсэнгүй. Номын редактор хийх хариуцлагатай үүргийг хүлээж авсан бол нэрээ тавиад орхих бус, мэдлэг, ерөнхий боловсролоо зузаатгасны үндсэн дээр⁶⁷ ажил үүргээ үнэнчээр гүйцэтгэж, монгол хэлээ эвдэхгүйн төлөө хичээж чармайх хэрэгтэй.

Сүүлийн хорь гаруй жилд солонгос хэлтэй орчуулагч, судлаач олширч, Солонгосын уран зохиолын 400 гаруй бүтээлийг монгол хэлээр орчуулсан ч орчуулгын шүүмж бараг гарсангүй. Цаашид чанар чансааг нь сайжруулах шаардлагатай тул солонгос-монгол орчуулгын үйлсэд санаа аваасай хэмээн хэдэн үг нэмэрлэв.

Ном зүй

Монгол хэлээр :

1. Гүрбазар Р (1996), Орчуулгын онол дадлагын үндэс, ШУА, ХЗХ, УБ
2. Орчуулгазүй, МУИС, Күнзийн Институт, №1-6
3. Оюунзаяа Н.(2014), Монгол орчуулгын онолын уламжлал, “Орчуулга зүй” МУИС, ШУС-ийн ЭШБ, №03
4. Солонгос түмнийг тольдохуй, 2017, УБ, Соёмбо принтинг
5. Чимэдцэе М(2014), “Улсыг засах, жараахай шарах хоёр адилхан. Харин амархан уу? Хэцүү юу?”, Орчуулгазүй, МУИС, Күнзийн Институт, №03
6. Г. Эрдэнэчимэг, Солонгосын түүх, Тэргүүн дэвтэр, 2006, Адмон
7. Йё Бйөн мү, Солонгосын түүх, ОУУБИС, 2016
8. Д. Ундрах бусад, Дэлхийн соёл иргэншил, МУИС, Пресс хэвлэлийн газар, 2020

⁶⁷ Б. Ринчен, <http://mongoliantranslation.blogspot.com/2010/05/1958.html>

Солонгос хэлээр :

1. 김용심, ‘문체반정, 나는 이렇게 본다’, 보리 2012
2. 주영하 외 지음, 한국학의 즐거움, Humanist, 2011
3. 이제정 글, 문화재 이름도 모르면서, 나는 책, 2015,

Цахим сүлжээнээс :

1. Б. Ринчен, Марк Твений минь махыг идэж дээ.

<http://mongoliantranslation.blogspot.com/2010/05/1958.html>

[사대주의 - 위키백과, 우리 모두의 백과사전 \(wikipedia.org\)](http://wikipedia.org)

2. <https://news.joins.com/article/2657833>

**ХЯТАД ХЭЛНИЙ “把 (БА)” БҮХИЙ ӨГҮҮЛБЭРИЙГ
ОРОС ХЭЛНЭЭ ОРЧУУЛАХ НЬ**
(ЗЯН РУНЫ “ЧОНОН СҮЛД” РОМАНЫ ЖИШЭЭГЭЭР)

Л.Одонтуяа⁶⁸

Б.Гэрэлт-Ирээдүй⁶⁹

Навий Л.Н⁷⁰

Саригай⁷¹

***Abstract:** A feature of Chinese grammar, the sentence with “把 (ba)” is a frequently used sentence form in modern Chinese. Chinese is a language with an invariant root structure, while Russian is a complex language with many functions, so the syntactic structure of these languages is very different. In this article we will discuss how the sentence with “把 (ba)” was rendered in Ageev's Russian translation of the novel “Wolf Totem” which is a modern famous work of the Chinese writer Jiang Rong. The structure of the sentence with “把 (ba)” is quite complicated, and we first look at “把” which occurs in the novel “Wolf Totem” according to Fan Xiao's classification based on the features of the sentence with “把 (ba)” in Chinese. Sentences with “把 (ba)” were classified. According to these 9 categories, the Russian translation of those sentences was analyzed, and the method used in its translation and the structure of the Russian translation were considered.*

***Түлхүүр үг:** Хятад хэлний “把 (ба)” бүхий өгүүлбэр, “Чонон сүлд” роман, орос орчуулга, үгийн давтамж, хятад хэлний өгүүлбэр зүй, тийн ялгал*

⁶⁸ Доктор Ph.D, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Гадаад хэлний төвийн профессор, 0000-0001-6585-0063

⁶⁹ Доктор Ph.D, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Ази судлалын тэнхимийн дэд профессор, 0000-0002-8988-9904

⁷⁰ Доктор Ph.D, Профессор кафедры Педагогика и психологии, Кокшетауский университет им.Ш.Уалиханова

⁷¹ Магистр, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Ази судлалын тэнхим

“把 (ба)” бүхий өгүүлбэр нь орчин цагийн хятад хэлэнд түгээмэл хэрэглэгддэг бөгөөд түүнийг судлах нь хятад хэл шинжлэлийн судалгааны нэгэн чухал хэсэг юм. Хятадад “把 (ба)” бүхий өгүүлбэрийг судлаад 100 жил болжээ. Энэхүү судалгаа нь хамгийн анх эрдэмтэн Ли Зиньсигийн “Тусагдахууны тухай өгүүлэх нь”/1924/ бүтээлээс эхтэй. Тэрээр эхлээд өгүүлбэрийн бүтцийг судалсан ба өгүүлбэрт үйл үгийн ард байдаг тусагдахуун нь “把 (ба)” бүхий өгүүлбэрийн хувьд үйл үгийнхээ өмнө орох болсныг онцолсон байдаг.⁷² Мөн улсын эрдэмтэн Лань Сяолин хятад хэлний “把 (ба)” бүхий өгүүлбэрт тохирох орос хэлний өгүүлбэрийн бүтцийг судалсан байна.⁷³

Оросын эрдэмтэн А.П.Кошкин хятад хэлний найман төрлийн угтвар үгсийг нарийвчлан судалсан бөгөөд үүнд “把 (ба)” хэмээх угтварыг зургаа дахь ангилалд багтаагаад, “把 (ба)” бүхий өгүүлбэрийн үндсэн бүтцийг тодорхойлсон байдаг⁷⁴.

Хятад хэлний хэлзүйн нэг онцлог болох “把 (ба)” бүхий өгүүлбэр нь орчин цагийн хятад хэлэнд өргөн хэрэглэгддэг өгүүлбэрийн нэг хэлбэр юм. Ийм өгүүлбэр нь орчин цагийн хятад хэлэнд давтамж ихтэй хэрэглэгдэх ба түүний бүтэц нь хэл шинжээчдийн анхаарлыг татдаг. “把 (ба)” бүхий өгүүлбэрийн үндсэн бүтэц нь “把 (ба)” + тусагдахуун + үйл үг” байдаг.

“把 (ба)” бүхий өгүүлбэрийн хэрэглээ, утгын талаарх судалгаа нэлээд хийгдсэн боловч түүнийг орос хэлэнд орчуулах талаар хийсэн судалгаа хомс байна. Бусад хэлэнд хятад хэлний “把 (ба)” бүхий өгүүлбэртэй төстэй өгүүлбэр маш цөөн байдаг. Ийм өгүүлбэрийн бүтэц нь адармаатай, агуулга нь баялаг, хятад хэлний өөр бусад үгтэй харилцан хамаарал ихтэй тул “把 (ба)” бүхий өгүүлбэрийг орос хэлнээ зөв оновчтой орчуулахад их төвөгтэй байдаг. Тиймээс бид энэ өгүүлэлдээ Хятадын зохиолч Зян Руны орчин цагийн алдартай бүтээл болох “Чонон сүлд” романы Н.Агеевын⁷⁵ орос орчуулгад “把 (ба)” бүхий өгүүлбэрийг хэрхэн буулгасан талаар судаллаа.

Дан “把 (ба)” гэх ханз үсгийн утга болон “把 (ба)” бүхий өгүүлбэр дэх “把 (ба)” нь хоорондоо ялгаатай. “把 (ба)” нь хятад хэлэнд нэр үг, үйл үг, тэмдэг нэр, тооллого үг, угтвар үг болдог. Үүнээс харахад “Чонон сүлд” романд байгаа “把 (ба)” орсон өгүүлбэр бүр бүгд “把 (ба)” угтвар үг бүхий өгүүлбэр биш гэдэг нь харагдаж байна. Харин бид энэхүү судалгаандаа “Чонон сүлд” зохиолд гарч буй “把 (ба)” орсон өгүүлбэрийн дотроос зөвхөн “把 (ба)” угтвар үг бүхий өгүүлбэрийн орчуулгыг авч үзсэн юм.

“把 (ба)” бүхий өгүүлбэрийн бүтэц нь нэлээд ярвигтай бөгөөд түүнийг орос хэлнээ ямар бүтцээр хэрхэн буулгасныг судлахын тулд бид эхлээд Хятадын эрдэмтэн Фань Сяогийн хятад хэлний “把 (ба)” бүхий өгүүлбэрийн онцлогт тулгуурласан

⁷² 王力, 汉语语法史 (Хятад хэлний хэлзүйн түүх), 北京, 高等教育出版社, 1993.

⁷³ Лань Сяолин, Хятад, орос хэлний хэл зүй заах аргазүйн судалгаа, 2009.

⁷⁴ А.П.Кошкин, Некоторые вопросы синтаксиса предлогов субъектно-объектных отношений китайского языка, 2014.

⁷⁵ (Н.Агеев, 2007:1-544)

ангиллын дагуу “Чонон сүлд” романд тохиолдож буй “把 (ба)” бүхий өгүүлбэрүүдийг 9 хэсэг болгон ангилсан юм. Энэхүү ангиллын дагуу тэдгээр өгүүлбэрийн орос орчуулгыг задлан шинжилж, түүний орчуулгад хэрэглэсэн арга хийгээд орос орчуулгын бүтцийг авч үзлээ. Үүний зэрэгцээ энэхүү ангиллын дагуу орос орчуулга дахь өгүүлбэрийн бүтцийн давтамжийг тодруулан, “把(ба)” бүхий өгүүлбэрийг орос хэлнээ орчуулахад байнга хэрэглэгдэж буй бүтцийг тодорхойлохыг зорьсон юм.

“Чонон сүлд” романы хятад эхэд “把 (ба)” бүхий өгүүлбэр өндөр давтамжтай тохиолдож байна. Бидний тооцоолсноор, уг зохиолд нийт 1171 “把 (ба)” бүхий өгүүлбэр (үүнд 把 (ба)-ийн утгаар хэрэглэгддэг “将 зян” бүхий өгүүлбэр болон шүлэгт орсон “把 (ба)” бүхий өгүүлбэрийг тооцоогүй болно) байна. Эдгээрээс 41 өгүүлбэрийн өгүүлэхүүний бүтцийг аль нэг ангилалд оруулахад төвөгтэй байсан тул дээрх ангиллын алинд ч оруулсангүй, харин бусад 1130 “把 (ба)” бүхий өгүүлбэрийг дараах 9 төрлийн ангилалд багтааж байна.

Хүснэгт 1. “Чонон сүлд” романы хятад эх дэх “把 (ба)” бүхий өгүүлбэрийн давтамжийн ангилал

№	Бүтэц	Давтамжийн тоо	Давтамжийн хувь
1.	“Үйл үг-угтвар үг” хэлбэр	407	36 %
2.	“Үйл үг-чиглэл заасан нөхвөр гишүүн” хэлбэр	221	19.55 %
3.	“Үйл үг-үр дүнгийн нөхвөр гишүүн” хэлбэр	201	17.8 %
4.	“Дан үйл үг” хэлбэр	93	8.2 %
5.	“Үйл үг -得 (дө)” хэлбэр	76	6.7 %
6.	“Үйл үг-туслах үг” хэлбэр	66	5.85 %
7.	“Үйл үг-тусагдахуун” хэлбэр	42	3.7 %
8.	“Үйл үг-тооллого үг” хэлбэр	22	1.9 %
9.	“Байц гишүүн-үйл үг” хэлбэр	2	0.2 %
	Нийт	1130	100 %

Дээрх ангиллаас харахад эхний 3 хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн хувь тус бүр 10%-аас их ба нийт 73,4 % болж, үлдсэн 7 хэлбэр тус бүр 10% хүрэхгүй буюу нийт 26,6% болж байна.

Бид энэ ангиллын дагуу эдгээр өгүүлбэрийн орос орчуулгыг задлан шинжилсэн юм. Ингэснээр хятад хэлний “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтцийг тодорхойлох боломжтой болно. Үүний тулд бид Фань Сяогийн ангиллын аргаар нийт 1130 “把 (ба)” бүхий өгүүлбэрт дараах байдлаар задлан шинжилгээ хийлээ.

1. “Үйл үг-угтвар үг” хэлбэр

“把 (ба)” бүхий өгүүлбэрийн “үйл үг-угтвар үг” хэлбэр нь өгүүлэхүүн болох үйл үг нь угтвар үг бүхий холбоо үг авч бүтсэн байдаг. Энэхүү бүтцийн угтвар үг нь гол төлөв “给 ба 与 (өгөх), 在 ба 于 (-д, -т), 到 ба 至 (хүрэх, очих), 往 ба 向 (-руу, -рүү)” зэрэг үгс байна.

“把 (ба)” бүхий өгүүлбэрийн үйл үг-угтвар үгийн хэлбэрийн орчин цагийн хятад хэлэн дэх бүтэц нь: “S + “把 (ба)” + O1 + V + “给 ба 与 (өгөх)/在 ба 于(-д, -т)/到 ба 至 (хүрэх, очих)/往 ба 向 (-руу, -рүү)” + O2”.

а. “Үйл үг + 在, 于 (-д, -т)” хэлбэр

“Чонон сүлд” романд энэ ангилалд багтаж буй “Үйл үг + 在,于 (-д, -т)” хэлбэр бүхий өгүүлбэр нийт 122 байна. Энэ нь нийт “үйл үг-угтвар үг”-ийн хэлбэртэй нийт өгүүлбэрийн 29.98%-ийг эзэлж байна. Энэ төрлийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн тусгагдахуун нь голдуу байршил заасан нэр үг болон нэр үгнээс бүтсэн холбоо үг байна. Тусгагдахууны ард ихэвчлэн 上 (дээр), 下 (доор), 里 (дотор), 外 (гадна), 中 (дунд) гэх зэрэг байрлал заасан үг орсноор тусгагдахууныг тодотгож өгдөг. Ийм “把 (ба)” бүхий өгүүлбэр нь бүхэлдээ аливаа зүйлийн байрлал өөрчлөгдсөн утгыг илэрхийлж байна. Жишээ нь: 说完, 杨克就把钩到的羊平放在结实的雪面上。(p.33)

Ярьж дуусаад Ян Кө бугуйлдсан хонио хөр цасан дээр аятайхан тэгсхэн тавив. (хуу.33)

Сказав это, он аккуратно вытащил туши овец на твёрдую снежную поверхность. (хуу.26)

б. “Үйл үг + 到 ба 至 (хүрэх, очих)” хэлбэр

Хятад хэлний 至 ба 到 угтвар үг нь “хүрэх, очих” гэсэн утгыг илэрхийлдэг. Бидний бүртгэснээр “Чонон сүлд” романд ийм хэлбэрийн нийт 191 өгүүлбэр байна. Жишээ нь:

杨克说: ”我真得谢谢你把我鼓动到草原上来”。(p.23)

Ян Кө “Та намайг ятган тал нутагт авчирсанд би үнэнхүү баярлаж байна” хэмээн хэлэв.

Я и вправду благодарен тебе, что ты уговорил меня поехать в степь. — сказал Ян Кэ. (хуу.23)

в. “Үйл үг + 给 ба 与 (өгөх) хэлбэр

给 ба 与 хэмээх хоёр угтвар үг нь “өгөх” гэсэн утгыг илэрхийлнэ. “Чонон сүлд” романд ийм хэлбэрийн өгүүлбэр нийт 94 байна. Жишээ нь:

额仑草原的牧民总是把他们最好的东西送给北京学生。(p.68)

Өлүн нутгийн малчид хамаг сайн юмаа үргэлж Бээжингийн оюутанд өгдөг.

Скотоводы степи Элуны всегда самое хорошее дарили пекинским студентам.

Хүснэгт 2. “Чонон сүлд” роман дахь “үйл үг-угтвар үг” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц

Хятад өгүүлбэрийн хэлбэр	Орос орчуулга	Орчуулгын бүтэц
把……放在 (…… -г …… -д/-т тавих)	вытащить кого-что поставить кого-что ставить кого-что	үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……揣在 (…… -г…… -д/-т хийх)	прижать кого-что	үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……鼓动到 (…… -г…… -д/-т авчрах)	уговорить кого	үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……甩到 (…… -г …… -д/-т унагах)	сбросить кого-что	үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……送给 (…… -г …… -д/-т өгөх)	дать кого-что кому-чему	үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/ + дательный падеж /өгөх оршихын тийн ялгал/

把……还给 (... -г... -д/-т буцааж өгөх)	возвращать кого-что кому	үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/ + дательный падеж /өгөх оршихын тийн ялгал/
把……留给 (… -г... -д/-т үлдээх)	оставить кому, которые...	үйл үг + дательный падеж /өгөх оршихын тийн ялгал/+ холбоос үг

2. “Үйл үг-чиглэл заасан нөхвөр гишүүн” хэлбэр

“Үйл үг-чиглэл заасан нөхвөр гишүүн” хэлбэр гэдэг нь “把 (ба)” бүхий өгүүлбэрийн өгүүлэхүүн нь үйл үг болон чиглэл заасан нөхвөр гишүүнээс бүтсэн байна. Орчин цагийн хятад хэлний ийм хэлбэрийн өгүүлбэрийн бүтэц нь: “S + “把 (ба)” + O + V + чиглэл заасан нөхвөр гишүүн” байна. Энэ хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэр нь ямар нэг хүчин зүйлийн нөлөөгөөр аливаа зүйлийн байрлалд өөрчлөлт гарсан утгыг илэрхийлдэг. Чиглэл заасан нөхвөр гишүүн нь дан болон хоёр үет үйл үгээс бүтсэн байна. Жишээ нь:

1. 对老王头说：明儿我就把羊油给您送去。(p.228)

Ван хөгшинд би маргааш танд хонины өөх аваачиж өгье гэж хэлэв.

Завтра я принесу тебе овечий жир. (хуу.228)

2. 陈阵把马驹的头、胸、颈这些被狼咬过的部分用斧子剁下来。(p.248)

Чэнь Жэнь чононд уруулсан адууны толгой, цээж, хүзүүний хэсгийг сүхээр цавчиж авав.

Чэнь Жэнь отрубил топором голову, грудь и шею лошади, укушенной волком. (хуу.248)

Хүснэгт 3. “Чонон сүлд” роман дахь “үйл үг + дан үет чиглэл заасан нөхвөр гишүүн” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэр

Ангилал	V+进 (орох)	V+回 (буцах)	V+过 (өнгөрөх)	V+来 (ирэх)	V+出 (гарах)	V+起 (босох)	V+上 (дээш гарах)	V+下 (буух)	V+去 (очих)	нийт
Тоо	7	16	2	15	23	1	16	14	6	103

Хүснэгт 4. “Чонон сүлд” роман дахь “үйл үг + дан үет чиглэл заасан нөхвөр гишүүн” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц

Хятад өгүүлбэрийн хэлбэр	Орос орчуулга	Орчуулгын бүтэц
把……拔出 (… -г сугалж гаргах)	выдернуть что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……拽出 (… -г татаж гаргах)	вытащить кого-что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……送去 (… -г хүргэж очих)	принести кого-что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……低下 (… -г доошлуулах)	прижать кого-что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/

Хүснэгт 5. “Чонон сүлд” роман дахь “үйл үг + хоёр үет чиглэл заасан нөхвөр гишүүн” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэр

Ангилал	V+上来 дээш гарч ирэх	V+上去 дээш гарч очих	V+回来 эргэж ирэх	V+回去 эргэж очих	V+进来 орж ирэх	V+进去 явж орох	V+下来 бууж ирэх	V+下去 бууж очих	V+出来 гарч ирэх	V+出去 гарч явах	V+过来 явж ирэх	V+过去 явж очих	V+起来 босч ирэх
Тоо	4	4	4	4	1	7	15	6	48	2	7	5	19

Хүснэгт 6. “Чонон сүлд” роман дахь “үйл үг + хоёр үет чиглэл заасан нөхвөр гишүүн” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц

Хятад өгүүлбэрийн хэлбэр	Орос орчуулга	Орчуулгын бүтэц
把……咬下来 (… -г хазах)	снять что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……剁下来 (… -г цавчих)	отрубить что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……拽出来 (… -г чирч гаргах)	вытянуть кого-что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……抓出来 (… -г барьж гаргах)	поймать кого	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……挖出来 (… -г ухаж гаргах)	выкопать что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/

3. “Үйл үг-үр дүнгийн нөхвөр гишүүн” хэлбэр

“Үйл үг-үр дүнгийн нөхвөр гишүүн” хэлбэр гэдэг нь “把 (ба)” бүхий өгүүлбэрийн үйл үгийн ард үр дүнг илтгэх үг нөхвөр гишүүн болон орж, тусагдахуун нь үйл хөдөлгөөний нөлөөнөөс болж ямар нэгэн үр дүн ба нөхцөл байдалд хүрснийг илэрхийлнэ. Фань Сюэгийн тайлбарласнаар, үр дүнгийн нөхвөр гишүүн нь дараах 3 утгыг илэрхийлнэ. Үүнд:

1/ үйлийн үр дүн: хөлдөж муудсан, бордож таргалсан, гижигдэж инээлгэсэн г.м.

2/ үйл хөдөлгөөний хэм хэмжээ: их идсэн, нимгэн хувцасласан, оройтож ирсэн г.м

3/ үйлийн байдал: үгийн утгыг улам тодруулах юмуу бүдгэрүүлэх утгыг илэрхийлдэг. Ийм нөхвөр гишүүн болдог үгс: “到 дао (хүрсэн), 着 焦 (болсон), 住 жү (зогссон), 上 шан (дээшилсэн), 完 вань (дууссан), 好 хао (дууссан), 掉 дяо (унасан), 起来 цилай (эхэлсэн), 下去 сяцюй (бууж явсан) гэх мэт. Жишээ нь: 狼嫌跑起来刮草碍事, 它自个儿把伤腿咬断了。(p.145)

Чоно гүйхэд нь өвсөнд тээглэн саад болно хэмээн өөрийнхөө хөлийг тас хазаж хаяв.

Волк, убегая, отбрасывает то, что ему мешает, он сам перекусил лапу. (хуу.145)

Хүснэгт 7. “Чонон сүлд” роман дахь “үйл үг-үр дүнгийн нөхвөр гишүүн” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц

Хятад өгүүлбэрийн хэлбэр	Орос орчуулга	Орчуулгын бүтэц
把……撞醒 (… -г мөргөж сэрээх)	будить кого-что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……烧尽 (… -г шатааж дуусгах)	загореться	Эс тусах үйл үг
把……勒死 (… -г боож алах)	удавиться	Эс тусах үйл үг
把……咬断 (… -г хазаж тасдах)	перекусить кого-что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……压严 (… -г чанга дарах)	засыпать и утрамбовать кого-что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/

4. “Дан үйл үг” хэлбэр

“Дан үйл үг” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэр гэдэг нь “把 (ба)” бүхий өгүүлбэрийн өгүүлэхүүн болох үйл үгийн өмнө хойно ямар ч нэмэлт үг ороогүй байна. Жишээ нь:

万一哪匹马, 哪头牛踩塌了洞顶, 就可能把小狼活埋。(p.221)

Чонын үүрийг адуу, үхэр санаандгүй цөм гишгэвэл бэлтрэг нь амьдаараа булагдах болно.

Если лошадь или корова упадут на крышу пещеры, она может заживо похоронить маленького волка. (хуу.221)

Хүснэгт 8. “Чонон сүлд” роман дахь “дан үйл үг” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц

Хятад өгүүлбэрийн хэлбэр	Орос орчуулга	Орчуулгын бүтэц
把……忘记 (… -г мартах)	забыть о ком о чём	Үйл үг + предложный падеж
把……垦	распахать что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/

把……相提并论 (… -г адилтгах)	отождествлять что с чем	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/ + предложный падеж
把……活埋 (… -г амьдаар нь булах)	похоронить кого-что заживо	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/ + дайвар үг

5. “Үйл үг-得 (дө)” хэлбэр

Энэ нь үйл үгийн ард 得 (дө) туслах үг өөр үгтэй хамт орж бүтсэн “把 (ба)” бүхий өгүүлбэрийг хэлнэ. Бүтэц нь “S +”把 (ба)”+O+V+得 (дө) + нөхвөр гишүүн” болно. Энэ төрлийн “把 (ба)” бүхий өгүүлбэр нь үйлийн үр дагаврыг илэрхийлсэн байна. Жишээ нь:

草原闹起大灾来, 人和狼找食都不容易, 吃羊就该把羊吃得干干净净。(p.83)

Тал нутагт том гамшиг болж, хүн болон чононд хоол олдоход бэрх болсон тул хонины мах идэхдээ ясыг нь цэвэрхэн болтол мөлжих хэрэгтэй.

Когда в степи бывает стихийное бедствие, людям и волкам очень трудно найти еду, тогда съедают овца подчистую. (хуу.83)

Хүснэгт 9. “Чонон сүлд” роман дахь “үйл үг-得 (дө)” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц

Хятад өгүүлбэрийн хэлбэр	Орос орчуулга	Орчуулгын бүтэц
把……吃得干干净净 (… -г юу ч үлдээлгүй идэх)	съедать кого-что подчистую	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/ + дайвар үг
把……解脱得彻底 (… -г бүр мөсөн салах)	происходить что полностью	Үйл үг+ винительный падеж /заахын тийн ялгал/ + дайвар үг
把……挖得到处 (… -г энд тэндгүй сэндийчэх)	перекопать что	Үйл үг+ винительный падеж /заахын тийн ялгал/

6. “Үйл үг-туслах үг” хэлбэр

“Үйл үг-туслах үг” хэлбэрийн үйл үгийн ард байдал заасан туслах үг 着 (жө)、了 (лө)、过 (гуо) орсон өгүүлбэр болно. “Чонон сүлд” романд “үйл үг-туслах үг” хэлбэрийн “把(ба)” бүхий өгүүлбэр нийт 66 байна. Жишээ нь:

1. *把这么机灵的小狼当犯人奴隶一样拴着, 我想想心就疼。(p.263)*

Ийм сэргэлэн чонын бэлтрэгийг ялтан боол шиг уяатай байгааг бодох бүрийд миний сэтгэл өвдөх юм. (хуу.263)

Мне грустно привязывать к пленному такого умного волка, как раба.

2. *杨克气得脖子上青筋暴跳, 大叫: 这条该死的狼, 把咱俩给耍了。(p.89)*

Ян Кө уурлан гүрээний судас нь хөхрөн гүрэлзэж, энэ үхвэл таарсан чоно бид хоёроор тоглочихлоо гэж чангаар хаширав.

Ян Кэ закричал в негодовании: Эта обречённая на смерть волчица ещё играла с нами! (хуу.89)

3. *狼开始报复之后, 狼群把牧民及羊群袭击过, 所以牧民们带着猎狗一起下夜守护羊群。 Чоно өшөө авч эхлэхээрээ сүргээрээ малчны хонин сүрэг рүү*

гэнэдүүлэн дайрдаг тул малчин анч нохойтойгоо хамт шөнө хонио манадаг.

После того, как волки начали мстить, волки напали на пастухов и овец, поэтому пастухи взяли охотничьих собак, чтобы вместе охранять овец следующей ночью.

Хүснэгт 10. “Чонон сүлд” романы “үйл үг-туслах үг” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц

Хятад өгүүлбэрийн хэлбэр	Орос орчуулга	Орчуулгын бүтэц
把……耍了 (… -р тоглоом хийх)	обыграть кого играть с кем	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/ Үйл үг + творительный падеж

把……忘了 (… -г мартах)	забыть про кого-что	Үйл үг + предложный падеж
把……丢了 (… -г гээх)	потерять что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……拴着 (… -г хүлэх)	привязывать к кому-чему	Үйл үг + дательный падеж
把……揣着 (… -г өвөртлөх)	обнять кого	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……动过 (… -г хөдөлгөх)	переместить кого-что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/
把……袭击过 (… -г довтлох)	напасть на кого-что	Үйл үг + винительный падеж /заахын тийн ялгал/

7. “Үйл үг-тусагдахуун” хэлбэр

“Үйл үг + тусагдахуун” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн хэлзүйн бүтэц нь “S + 把 (ба) + O1 + V + O2” байна. “Чонон сүлд” романд ийм хэлбэрийн өгүүлбэр 42 байна. Үүнээс “把 (ба) ……告诉 (хэлэх) + тусагдахуун”, “把 (ба) ……给 (өгөх) + тусагдахуун”, “把 (ба) ……+ 当作 (болгох) + тусагдахуун” бүтэцтэй хэлбэрийн давтамж өндөр байна. Жишээ нь:

1. 陈阵又把小狼嗥声所引来的种种危险告诉张继原。(p.254)

Чэнь Жэнь чонын бэлтрэгний улих дуунд ямар аюулын дохио байгааг Жан Зи Юаньд хэлэв.

2. Чэнь Жэнь **рассказал о том, как волчонок выдал себя волкам своим воем.** (хуу.254)

2. 你把干马粪给我。(p.80)

Чи хатсан хомоолыг надад өгөөрэй.

Дай мне лошадиный навоз. (хуу.80)

3. 陈阵希望小狼能记住他的养育之恩，至少能把他当作一个真心爱它的异类朋友。(p.216)

Чэнь Жэнь бэлтрэг өөрийнх нь өсгөж тэжээсэн ачийг боддог байгаасай гэж хүснэ, ядаж л өөрийг нь түүнд үнэн сэтгэлээсээ хайртай найзаа гэж үздэг болоосой гэж бодно.

Чэнь Жэнь надеялся, что волчонок сможет запомнить его добро, когда он кормил, самое меньшее, хотя бы будет **считать** его любящим другом. (хуу.216)

Хүснэгт 12. “Чонон сүлд” романд буй “үйл үг + тусагдахуун” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц

Хятад өгүүлбэрийн хэлбэр	Орос орчуулга	Орчуулгын бүтэц
把……告诉…… (… -г …… -д хэлэх)	передать кому что	Үйл үг + дательный падеж + винительный падеж
	рассказать о чём, что	Үйл үг + предложный падеж + винительный падеж
	говорить кому, что	Үйл үг + дательный падеж + винительный падеж
把……给/与…… (… -г …… -д өгөх/олгох)	дать кому что	Үйл үг + дательный падеж + винительный падеж
	покрыть кого-что	Үйл үг + винительный падеж
	отдать кому что	Үйл үг + дательный падеж + винительный падеж
把……当作…… (… -г …… гэх)	Считать кого-что кем-чем	Үйл үг + винительный падеж + творительный падеж

8. “Үйл үг-тооллого үг” хэлбэр

“Үйл үг-тооллого үг” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн бүтэц нь “S + “把 (ба)”+O+V+ үйлийн тоо хэмжээ + үйлийн тооллого үг” байна. Чонон сүлд романд ийм хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэр нийт 22 байна. Жишээ нь:

它蹲在大鼠前喘气，等胸部起伏平稳之后，使用舌头把嘴巴外沿舔了两圈。

Тэр том хулганы өмнө оцойн сууж уухилсан амьсгаагаа дараад хэлээрээ амаа 2 удаа долоов.

Он присел на корточки перед крысой и тяжело дышал, дождавшись, пока грудь плавно поднимется и опускается, он дважды лизнул языком внешний край рта.

Хүснэгт 13. “Чонон сүлд” роман дахь “үйл үг-тооллого үг” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц

Хятад өгүүлбэрийн хэлбэр	Орос орчуулга	Орчуулгын бүтэц
把……喝了一半 (... -г талыг нь уух)	выпить половину чего	Үйл үг + винительный падеж
把……吃了一大半 (... -г ихэнхийг идэх)	перекопать всё что	Үйл үг + тоо хэмжээ заасан үг + винительный падеж
把……舔了两圈 (... -г хоёр долоох)	лизнуть что дважды	Үйл үг + винительный падеж + тоо хэмжээ заасан үг

9. “Байц гишүүн-үйл үг” хэлбэр

“Байц гишүүн-үйл үг” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн бүтэц нь “S + 把 (ба) + O + байц + V” болно. Жишээ нь:

(1) 杨克把茶碗往桌上一扣, 大声说: 嗨, 你说什么时候去? (p.75)

Ян Кө цайныхаа аягыг ширээн дээр хөмрөнгөө “хөөе чи хэзээ очно гэнэ ээ?” гэж чангаар хэлэв.

Ян Кэ пристегнул чашку на столе и громко сказал: Когда ты хочешь пойти?

(2) 这回高建中把蛋饼用锅铲一切, 盛到嘎斯迈母子的碗里。(p.199)

Энэ удаа Гао Зеньжун өндөгтэй гамбирыг хусуураар зүсээд Галсмаа болон хүүгийнх нь аяганд хийж өгөв.

На этот раз Гао Цзяньчжун разрезал омлет лопаткой и положил его в миску матери и сына Гасымая. (хуу.199)

ДҮГНЭЛТ

Хятад хэл нь үл хувирах язгуур бүтэц бүхий хэл бол орос хэлний хэлзүйн бүтэвэр нь олон үүрэгтэй нугархай хэл тул эдгээр хэлний өгүүлбэрзүйн бүтэц нь хоорондоо асар их ялгаатай. “Чонон сүлд” роман дахь хятад хэлний “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын судалгааг хийхдээ бид эхлээд “Чонон сүлд” романд гарч буй 1130 “把 (ба)” бүхий өгүүлбэрийг хятад хэлний “把 (ба)” бүхий өгүүлбэрийн онцлогт тулгуурласан эрдэмтэн Фань Сяогийн ангиллын дагуу 9 хэсэгт ангиллаа. Үүнээс “үйл үг-угтвар үг”, “үйл үг-чиглэл заасан нөхвөр гишүүн”, “үйл үг-үр дүнгийн нөхвөр гишүүн” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн давтамж хамгийн их буюу 17,8% - 36%, харин “дан үйл үг”, “үйл үг -得 (дө)”, “үйл үг-туслах үг”, “үйл үг-тусагдахуун”, “үйл үг-тооллого үг”, “байц гишүүн-үйл үг” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн давтамж бага буюу 0,2% – 8,2% байна.

Дээрх ангиллын дагуу бид “Чонон сүлд” роман дахь “把 (ба)”- тай өгүүлбэрүүдийг орос хэлэнд орчуулсан өгүүлбэрийн хэв шинжид дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. “Үйл үг-угтвар үг” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн угтвар үг нь 给 ба 与 (өгөх) бол орос орчуулгын өгүүлбэрийн бүтэц нь “үйл үг + винительный падеж + дательный падеж”, “үйл үг + дательный падеж + холбоос үг” гэсэн хэлбэртэй, харин угтвар үг нь 到 ба 至 (хүрэх, очих), 在, 于 (-д, -т) бол орос орчуулгын өгүүлбэрийн бүтэц нь “үйл үг + винительный падеж” хэлбэртэй байна.

2. “Үйл үг-чиглэл заасан нөхвөр гишүүн” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц нь “үйл үг + винительный падеж” хэлбэртэй байна. Орос орчуулгын үйл үгийн ихэнх нь мөн чиглэл заасан утгатай үгс байна.
3. “Үйл үг-үр дүнгийн нөхвөр гишүүн” хэлбэрийн “把(ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц нь “үйл үг + винительный падеж” болон “эс тусах үйл үг” гэсэн 2 хэлбэртэй байна. Энэ хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн үр дүнгийн нөхвөр гишүүний утга нь орос хэлнээ үйл үгээр илэрч байна.
4. “Дан үйл үг” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц нь “үйл үг + предложный падеж”, “үйл үг + винительный падеж”, “үйл үг + винительный падеж + предложный падеж”, “үйл үг + винительный падеж + дайвар үг” гэсэн 4 хэлбэртэй байна. Энэ хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэр дэх дан үйл үг нь орос хэлнээ орчуулах үед мөн л үйл үгээр илэрч байна. Зарим үед үйл үгийн утга бүрэн гардаггүй учир түүнийг дайвар үгээр тодотгосон байна.
5. “Үйл үг-得 (дө)” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц нь “үйл үг + винительный падеж”, “үйл үг + винительный падеж + дайвар үг” гэсэн 2 хэлбэртэй байна. Энэ хэлбэрийн үйл үг нь орос орчуулгад мөн л үйл үгээр илрэх ба үйл үгийн утга төгс бус үед дайвар үгээр тодотгосон байна.
6. “Үйл үг-туслах үг” хэлбэрийн “把(ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц нь “үйл үг + винительный падеж”, “үйл үг + предложный падеж”, “үйл үг + творительный падеж”, “үйл үг + дательный падеж” гэсэн 4 хэлбэртэй байна. Энэ хэлбэрийн үйл үгийн орос орчуулга нь бүгд өнгөрсөн цаг дээр байна.
7. “Үйл үг-тусагдахуун” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц нь, хэрэв хятад өгүүлбэрийн үйл үг нь 告诉 (хэлэх) бол “үйл үг + дательный падеж + винительный падеж”, “үйл үг + предложный падеж + винительный падеж” гэсэн 2 хэлбэртэй, харин хятад өгүүлбэрийн үйл үг нь 给 (өгөх) бол “үйл үг + дательный падеж + винительный падеж”, “үйл үг + винительный падеж” гэсэн 2 хэлбэртэй, хятад өгүүлбэрийн үйл үг нь 当作 (болгох) бол “үйл үг + винительный падеж + творительный падеж” хэлбэртэй байна.
8. “Үйл үг-тооллого үг” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц нь “үйл үг + винительный падеж”, “үйл үг + винительный падеж + тоо хэмжээ заасан үг”, “үйл үг + винительный падеж + цаг хугацаа заасан үг” гэсэн 3 хэлбэртэй байна. Энэ хэлбэрийг орос хэлнээ орчуулахдаа өгүүлбэрийн утгаас шалтгаалан үйл үг болон тусагдахуун нэмэх байдлаар утгыг тодруулсан байна.
9. “Байц гишүүн-үйл үг” хэлбэрийн “把 (ба)” бүхий өгүүлбэрийн орос орчуулгын бүтэц нь “үйл үг + винительный падеж” гэсэн хэлбэртэй байна. Ийм бүтцийн үйл үг нь ихэвчлэн нэг үет үг байх тул үүнийг орос орчуулгад ихэнхдээ ганц үйл үгээр илэрхийлсэн байна.

Ерөнхийд нь дүгнэж үзвэл, хятад хэлний “把(ба)” бүхий өгүүлбэрийг орос хэлнээ орчуулахдаа гол төлөв орос хэлний үйл үг эсвэл үйл үг болон түүний тусагдахууны тийн ялгалын хувирлаар илэрхийлсэн байна. Үүнд “үйл үг + винительный падеж” хэлбэр давамгайлж байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

1. Болд Л., Монгол хэл шинжлэлийн асуудал, УБ., 2006.
 2. Комиссаров В. Н., Орчуулгын онол, сурах бичиг, УБ., 2008.
Гадаад хэлээр:
 1. Агеев Н., Волчий тотем, Москва, изд. Мир книги, 2007.
 2. 范晓, 动词的配价与汉语的把字句(Фан Сяо, Үйл үгийн валент ба хятад хэлний “把 (ба)” бүхий өгүүлбэр), 中国语文, 2001.
 3. 冯学芳, 汉语 “一把……” 结构的语义阐释和英译 (Фөн Сюзфан, Хятад хэлний “1+把...” өгүүлбэрийн бүтцийн утга ба англи орчуулга), 解放军外国语学院学报, 2015.
 4. 姜戎, 狼图腾 (Зян Рун, “Чонон сүлд” роман), 长江出版社, 2004.
 5. 王力, 汉语语法史 (Ван Ли, Хятад хэлний хэлзүйн түүх), 北京, 高等教育出版社, 1993.
 6. 徐峰, ”把 NP — V” 的句法、语义和语用功能 (Сюй Фөн, “把 (ба)” бүхий өгүүлбэрийн бүтэц, утга, хэрэглээ), 汉语学习, 2014.
 7. 张伯江, 论”把”字句的句式语义 (Жан Бозян, “把 (ба)” бүхий өгүүлбэрийн хэлбэр, утга), 《语言研究》, 2000.
 8. 张旺熹, 汉语句法的认知结构研究 (Жан Ванси, Хятад хэлний өгүүлбэр зүйн танихуйн бүтцийн судалгаа), 北京, 北京大学出版社, 2006.
- 郑定欧, 词汇语法理论与汉语句法研究 (Жөн Динөү, Үгсийн хэлзүйн онол ба хятад хэлний өгүүлбэрзүйн судалгаа), 北京语言文化大学出版社, 1999.

**МОНГОЛ УЛСЫН АРДЫН УРАН ЗОХИОЛЧ Т.ГАЛСАНГИЙН
ОРЧУУЛГЫН УР ЧАДВАРЫН ТУХАЙ**
(Л.РЕБРЯНУГИЙН “ИОН” РОМАНЫ МОНГОЛ ОРЧУУЛГЫН ЖИШЭЭН
ДЭЭР)

Э.Батжавхлан⁷⁶

Abstract: This article analyzes the Mongolian translation of the novel "Ion" by the famous Romanian writer Liviu Rebreanu. The Mongolian translation of this novel was made by a duet of translators T. Galsan and B. Chimiddorz, published in the State Publishing Department in Ulaanbaatar in 1988. Using several examples, the author of the article analyzes in detail the features of the Mongolian translation, comparing them with the Romanian original of the novel, evaluating the work of translation as an example of a good innovative translation, where the ways of conveying the creative work of the Romanian writer were thoroughly studied and implemented, and translated into the Mongolian language, taking into account the features mentality of Mongolian readers. The author also criticizes the fact that many good Mongolian translations of the second half of the twentieth century still remain outside the attention of researchers, one of such invaluable translation publications is the translation work of the famous Mongolian writer T. Galsan. Over the past few years, many literary translations have been published in Mongolia, but in addition to the quantity, the quality of translations is clearly deteriorating due to the increasingly widespread processed machine translations. Therefore, the author of the article also calls for studying the creative experience of translations of older generations, as an example of reference translation works.

Түлхүүр үг: орчуулгын уран зохиол, румыны уран зохиол, “Ион” роман

Орчуулгын уран зохиол нь хэл, сэтгэлгээ, соёлын харилцааны нэгэн том ундарга болж тухайн ард түмний хэл, утга соёлын хөгжил шинэчлэлийн төлөв, хандлагыг тодорхойлогч чухал хүчин зүйлийн нэг байдаг юм. Аль ч улс үндэстний уран зохиолын хөгжил хувьслын түүхийг харахад уран сайхны сэтгэлгээний уламжлалт суурь мөн чанарыг нь шинэ агуулга хэлбэрээр баяжуулж тодорхой шинэчлэл рүү хөтлөхөд нөлөө

⁷⁶ доктор, дэд профессор, МУИС, ШУС, ХУС-ын Утга зохиол, урлаг судлалын тэнхим

түлхэц болсон суурь шалтгааны дотор уран зохиолын эко орчны хүрээнд буюу улс төр, нийгэм, соёлын амьдралд гарсан өөрчлөлт хувьсал, дотоод гадаад харилцааны хүчтэй идэвхжил байдаг.

XX зуун бол Монголын орчин үеийн утга соёл хөгжиж төлөвшсөн түүхэн цаг үе байсан гэдэг нь нэгэнт маргашгүй үнэн билээ. Нийгэм цаг үеийн өөрчлөлт шинэчлэлтийн их хувьсал энэ зууны утга зохиолд нөлөөлсний адил уран зохиол ч нийгэмдээ мөн нөлөөлж харилцан салшгүй шүтэлцээтэй хөгжлийн замыг туулжээ. Шинэ цагийн уур амьсгал, үзэл санаа, урлан туурвихуйн цоо шинэ арга барил, чиг хандлагаар Монгол орны бүтээн байгуулалт өрнөж, тэр дундаа утга зохиол баяжиж бүхэлдээ орчин цагийн гэсэн тодотголтой болох нөхцөлийг агуулсан юм⁷⁷.

Чухам түүхэн энэ цаг үед их төлөв энэтхэг, төвд, хятадын утга соёлоос орчуулж ирсэн монголын орчуулгын уламжлал дорнын хүрээ хязгаараас хальж дэлхийн утга зохиолын баялаг сангаас өргөнөөр орчуулах болсон төдийгүй монголын утга зохиол ч дэлхийн олон улс орны уншигчдын хүртээл болон танигдаж, түүний хэрээр судлаач шүүмжлэгчдийн анхааралд өртөх, үнэлэмж нь нэмэгдэх, олон талт судалгаанууд нь гүнзгийрэх болсны хувьд орчуулгын уран зохиолыг зүй ёсоор манай утга зохиолыг хөгжил шинэчлэл рүү нь хөтөлсөн, тэрхүү орчныг нь нөхцөлдүүлж өгсөн чухал хүчин зүйлийн нэг байсан гэж хэлж болно. Энэ үед Ж.Цэвээн, Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, Б.Ренчин нараас эхлээд үе үеийн эрдэмтэн, зохиолч, сэхээтнүүд маань шилмэл сайн орчуулгуудыг хийсээр ирсэн билээ.

Уран зохиолын, тэр дундаа орчуулгын уран зохиолын түүхэнд ганцаараа бие дааж бус хамтарч хийсэн уран бүтээлийн шилдэг жишээ цөөнгүй байдаг билээ. Үүнд бид ах дүү Якоб ба Вильгельм Гримм, Ильф ба Петров гээд цөөнгүй жишээг дурдаж болно. Жишээ нь хятадын орчуулгын уран зохиолын түүхэнд өрнийн утга соёлыг хятад уншигчдад анх таниулсан нэрт орчуулагч, зохиолч, уран зураач Линь Шү (林纾, 1857-1927) өрнийн зохиолуудыг найз нөхдөөрөө япон орчуулгаас дам дамжуулан хэлүүлж, түүнийг нь тэмдэглэн аваад үндсэн агуулгыг нь хятадын сонгодог уран зохиолын маягаар уламжлалт бичгийн хэлээр найруулан буулгадаг байв. Тийм учраас түүний орчуулга нь уг эхээсээ нэлээд хол, чөлөөт хэлбэртэй байв. Гэхдээ тэр бээр төрөлхийн авъяас билиг, туурвил зүйн ур чадварынхаа ачаар уншигчдын сэтгэлийг хөдөлгөхүйц дүр дүрслэл, уран яруу хэрэглүүрүүдийг чадамгай хэрэглэсэн бүтээлүүдийг туурвиж байснаараа онцлог. орчуулгын уран бүтээлийнхээ гарааг 1898 онд «Парижаас ирсэн камелия бүсгүйн гэрээслэл» (《巴黎茶花女遺事》) буюу А.Дюма /хүү/ (Alexandre Dumas /fils/ 1824-1895)-гийн «Камелия авхай» («La Dame aux Camélias» 1848) хэмээх романыг анх нийгэм-улс төрийн зүтгэлтэн, зохиолч, орчуулагч Ван Шөүчан (王壽昌 1864-1926)-тай

⁷⁷ Батжавхлан Э., Баттөр Ш., Мөнх-Оргил А. (2017), XX зууны монголын уран зохиол, УБ., 29 дүгээр тал

хамтран орчуулж хэвлүүлснээс эхэлсэн бөгөөд орчуулгын уран бүтээлийнх нь санд А.Конан Дойлын (1859-1930) «Шерлок Холмс», Ж.Свифтын (1667-1745) «Гулливерын аялал», Л.Кэрроллын (1832-1898) «Алиса гайхамшгийн оронд», Д.Дефогийн (1660-1731) «Робинзон Крузо», Чарльз Диккенсийн (1812-1870) «Оливер Твистийн адал явдал» гээд Англи, Франц, Америк, Япон, Швед, Бельги, Норвеги зэрэг олон орны 150 гаруй зохиол багтаж байна⁷⁸. Энэ мэт жишээг бид дэлхийн орчуулгын уран зохиолын түүхээс олныг дурдаж болно.

Гэвч нөгөө талаар авч үзвэл хамтарч хийсэн орчуулгуудын үнэлэмжийн асуудал бүрхэг тодорхойгүй үлдэх, үл ойшоогдох нь бий. Өөрөөр хэлбэл, орчуулгын уран зохиолын талбарт мэдлэг боловсрол, авьяас чадвараа зориулсан үгийн урлагийн шилдэг төлөөлөгчдийн дотроос өөр өөрийн орчуулах арга барилаар ялгарч тодорхой амжилтад хүрсэн нь олон байдаг хэдий ч судлал шүүмжийн төвшинд тэр бүр нэр нь дурдагдалгүй үлдсэн нь ч бас цөөнгүй бий. Манай орчуулгын түхэнд авч хэлбэл орчуулгын уран бүтээл нь мэргэжлийн судлаач нарын анхаарлаас тийнхүү орхигдсон нэгэн зохиолч бол Монгол Улсын Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн, Монголын уран зохиолын ноён оргилын нэг Тангадын Галсан мөн юм. Түүний орчуулгын уран бүтээлийн санд Вьетнамын яруу найрагч То Хыу-гийн “Цус цэцэг” (Ред.: Л.Дашням. УХГ.УБ., 1976) түүврийг С.Дашцэвэлийн хамт, Румыны зохиолч Ливиу Ребрянугийн “Ион” (Ред.: Л.Баярмандах. УХГ. УБ., 1988) романыг Б.Чимиддоржийн хамт, Юнна Морицын “Ягаан муурын нууц” (Сурах бичиг, хүүхдийн номын хэвлэлийн газар, УБ., 1991.) хүүхдийн зохиолын түүврийг Д.Даваанямын хамт, мөн Т.Етекбайн хамт Ж.Какейн “Диважинд залрахын нууц” (1994) бүтээлүүд тус тус багтаж байна.

Туульч өөлд Тангадын Галсан 1932 оны хаврын тэргүүн сарын шинийн есөнд Цэцэрлэг Мандал аймгийн Чандмань уулын хошуу (Одооны Баянхонгор аймгийн Заг гол сумын нутаг) Бумбатад малчны гэр бүлд төржээ. монголын ноёдын нууц чуулга чуулдаг байсан Биндэрьяа хөх нуурын хөвөөнд хурга тугал хариулж, Чингис хаан Наймантай тулалдаж дийлсэн Заг-Байдрагийн Хүрэн бэлчирт хурдны морь унаж, анхны болзоонд давхиж өссөнөөрөө бахархдаг⁷⁹ буюу нүүдэлчин монгол ахуй соёлын дунд төрж, өсөж, хүмүүжсэн нь ертөнцийг үзэх түүний үзэл зарчмыг төлөвшүүлж, билиг авьяасыг нь хурцалж, монгол оршихуйгаа эрхэмлэх, эх орон, нутаг усаа хайрлах, эх хэл бичиг, утга соёлоо дээдлэх, түүх уламжлалаараа бахархах, аж төрөхүйн хүмүүнлэг ёс, эрх чөлөөт үзэл санаа, шударга ёсны төлөө тууштай тэмцэх үнэт зүйлсийг нь тодорхойлж өгсөн юм. Энэ чанар нь ч түүний амьдрал, ажил хөдөлмөр, уран бүтээл туурвилынх нь замналаас тод томруун харагддаг билээ. Тэр ч байтугай орчуулгынх нь уран бүтээлийг харахад ч

⁷⁸ Батжавхлан Э. (2019), XX зууны эхэн үеийн монгол, хятадын уран зохиолын харьцуулсан судалгаа. “Танзам пресс” хэвлэл. УБ., 121-122 дугаар тал

⁷⁹ Сампилдэндэв Х. (2004), Туульч өөлд Тангадын Галсан (намтар, уран бүтээлийн товчоон). “XX зууны монгол зохиолчид” цуврал. № 13. УБ., 4 дүгээр тал

гадаадын уран зохиолыг хэрхэн монгол хөрсөнд, монгол сэтгэлгээнд уран яруу таацуулан орчуулахыг эрхэм болгож, авьяас мэдлэг, сэтгэл зүтгэлээ зориулж ирсэн бүтээлч хандлага ажиглагддаг. Тийм ч учраас Т.Галсангийн орчуулсан, шүүн найруулсан бүтээлүүд нь өөрийнх нь уран бүтээлээс дутуугүйгээр монгол уншигчдын сэтгэлийг булааж таашаал талархлыг нь хүлээдэг билээ.

Т.Галсаны орчуулгын талбарт гаргасан ололт амжилтын нэгэн түүхээс дурдвал 1970 оны 2-р сард Монголын Зохиолчдын Хорооны орчуулгын тасгаас уран зохиолын орчуулгыг хөгжүүлэх, орчуулагчдын уран чадварыг дээшлүүлэх зорилгоор Оросын нэрт зохиолч А.С.Пушкины “Телега жизни” хэмээх шүлгийг орчуулах уралдаан зарлажээ. Уралдааныг Зохиолчдын Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний шийдвэрээр батлагдсан комисс дүгнэсэн бөгөөд уг комиссын бүрэлдэхүүнд Б.Ринчен, Х.Пэрлээ, яруу найрагч-орчуулагч Ч.Чимид, Д.Пүрэвдорж, М.Цэдэндорж нар багтаж байв. Улмаар нийтдээ энэ уралдаанд 88 хүний 91 орчуулга ирүүлсний дотроос 1, 2-р байранд орсон хүн байхгүй, харин шагналт гуравдугаар байранд тухайн үед ШУА-ийн Хэл утга зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан байсан Д.Цэдэв, «Үнэн» сонины ажилтан байсан Ц.Хасбаатар нар “утгыг бүрэн ойлгож, хэлбэрийг зарим талаар хадгалахыг хичээсэн” тул бусдыгаа тэргүүлж шалгарсан бол энэ хоёрын ард Т.Галсан, Ж.Лхагваа, З.Дорж, Н.Пүрэв нарыг “орчуулгын утгыг зөв ойлгож, хэлбэрийг зарим талаар хадгалахыг бодсон, ураар бусдаас харьцангуй дээр болсон” гэж үзэж урамшуулах байранд оруулсан байдаг. Үүнээс харахад даруй тавь гаруй жилийн тэртээгээс Т.Галсан орчуулгын талбарт хүч авьяасаа сорьж, үнэлүүлж дүгнүүлж явсан байна. Харин түүнээс хойш авч хэлбэл Т.Галсангийн орчуулгын уран бүтээл, ур чадварын талаар дурдаж ярьсан нь бараг үгүй гэхэд хилсдэхгүй.

Тиймээс бид энэхүү өгүүллийн сэдвийн хүрээнд Т.Галсангийн орчуулгын онцлог, ур чадварынх нь нэгээхэн баримт болгож Румыны нэрт зохиолч, сэтгүүлч, нийгмийн зүтгэлтэн Ливиу Ребряну (1885-1944)-гийн алдарт “Ион” (1920) романы орчуулгаас нь зарим нэг жишээг татаж дурдахыг зорилго болгосон юм.

Энэхүү романд Трансильваны нэгэн жижиг тосгоныхны амьдралын тухай өгүүлдэг. Тэгэхдээ романд хоорондоо үл сүлжилдэх хоёр шугамаар нэг талаас эгэл тариачин эр Ион, нөгөө талаас тосгоны чинээлэг дээдэс болох санваартан Белчуг, Хердел багш нарын гэр бүлийн дотор өрнөж буй үйл явдлыг харуулсан байна. Тус зохиол нь дүрүүдийн сэтгэл зүй, нийгмийн анги давхаргын ялгааг тод харуулдаг төдийгүй газрын төлөөх зөрчил тэмцэл эцэстээ хүнийг хэрхэн цөхрүүлж, араатнаас дор нэгэн болгож сүйрэлд хүргэж буй ард түмний бодит амьдралын гашуун үнэний тухай өгүүлдэг. Чингэхдээ энэ зохиолын дүр дүрслэл, хэл найруулга нь гойд өвөрмөц бөгөөд тухайн нутаг, тариачин ардын хэл яриа, XX зууны эхэн үеийн европын нэгэн жижиг тосгоны амьдралыг нүдэнд харагдаж чихэнд сонсогдтол яруу сайхан бичсэн тул тэр бүгдийг орчуулгад, ялангуяа соёл иргэншил, хэл, сэтгэлгээний хувьд тэс өөр ертөнцөд хамаарах

монгол хэлт уншигчдад хүргэнэ гэдэг орчуулагчийн хувьд тун амаргүй даваа болох юм. Үүнийг Т.Галсан, Б.Чимиддорж нар орчуулгадаа хэрхэн шийдвэрлэсэн арга туршлагыг сонирхон үзье.

Зохиолд гарах оноосон нэрийн тухайд хот тосгодын нэрийг хэвээр үлдээж харин газар усны нэрийг монгол хэлнээ орчуулсан нь оновчтой шийдэл болжээ. Тухайлбал, Эх зохиолд:

Lăsând Jidovit, a, drumul urcă întâi anevoie până ce-s, i face loc printre dealurile strămtorate, pe urmă însă înaintează vesel, neted, mai ascunzându-se printre fagii tineri ai Pădurii Domnes, ti, s, i poposind put, in la Cis, meaua Mortului, unde picură ves, nic apă de izvor răcoritoare, apoi cote s, te brusc pe sub Râpele Dracului, ca să dea buzna în Pripasul pitit într-o scrântitură de coline. [L.Rebreanu, 2017:9]

Монгол орчуулгад:

Жидовиц өнгөрөөд зам нэлээд өгсүүр болж, толгодын дундуур гаруутаа чигээрээ дуурайснаа Ноёны шугуйн зулзаган эвэрлэг моддын хоорондуур бараа тасран булгийн сэрүүн тунгалаг ус мөнхөд дуслэгч Санваартны түгээгүүрт худаг хүрээд тэндээсээ Четгөрт гангын доорхноос гэнэт мурийн эргэж уулын энгэр нөмөрдсөн Припас тосгонд давхин иржээ. [Л.Ребряну, 1988:11]

Мөн энэ хэсэгт Л.Ребряну зам харгуйн үргэлжлэх байдлыг нэг талаар амьшуулан хөдөлгөөнт шинжтэй болгож, нөгөө талаар тэрхүү хөдөлгөөнийг мэдрэхүйн шинжтэй холбон эсрэгцүүлэн дүрслэх байдлаар тун уран илтгэсэн байгааг “lăsând” – “унаа хөсгөөр өнгөрөн явах”; “se ridică cu greu la” – “хүчлэн өгсөх”, “тамирдан мацах”; “cede” – “уруудан буух”, “буун унах”, “бууж өгөх”; “înaintează vioi” – “урагш хурдан сэргэг алхах”; “lin” – “тайвуун урагшлах”; “ascunzându-se” - “далдран нуугдах”; “opriindu-se bine”- “ил зогтусах”; “coboară brusc”- “гэнэтхэн уруудан”; “pentru a se repezi în”-“дайран орох” гэдгээс тодхон харж болно. Энэ нь Л.Ребрянугийн зохиолын хэлний уран сайхны нэгэн онцлог, найруулгын нэгэн өвөрмөц шийдэл нь болдог төдийгүй реалист зохиолын байгалийн зураглалыг бүтээхдээ зохиолын үйл явдал, дүр, үзэл санааг тодотгох чухал элемент болгон ашигладаг туурвил зүйн хэв шинжийг ч гайхам урласны жишээ болох юм. Нарлаг атлаа нозоором нам гүм байдал дор гуравдугаар биеэс хүүрнэн өгүүлэгчийн алсыг бараалан харах нүдний харц, дотоод сэтгэлийн байдлыг илтгэж, ертөнцийн мухар мэт буйдхан алсад буй Румыны олон тосгоны нэгэнд гаднаас нь үзвэл онцын гойд зүйлгүй, уйтгарт хэвийн байдалтай мэт харагдавч хүний амьдрал, аж төрөхүйн эрэлт хэрэгцээ, газар хөрөнгийн төлөөх хүсэл шунал мөн адил буцлан байж, зөрчил тэмцэлтэй хатуухан ертөнц рүү уншигчийг аянчин лугаа адил зам харгуйн дүрслэлээр алгуурхан хөтлөн оруулдаг. Тэгвэл үйл үгээр дамжуулан бүтээсэн эл дүрслэлийг монгол хэлний үйл үгээр оноон орчуулахад “өнгөрөөх”, “дуурайх”, “бараа тасрах”, “хүрэх”, “мурийн эргэх”, “нөмөрдөх”, “давхин ирэх” зэргээр замын үргэлжлэх дүрслэлийг гагцхүү үйл хөдлөлийн

явцыг голлож илэрхийлсэн нь амьшууллын шинжийг тусгахын хамт монгол хүний алсыг бараалан төсөөлөх сэтгэхүйд нийцүүлэн илэрхийлсэн байна.

Орчуулгад энэ зарчмыг тууштай баримталж ирснийг бид өөр бусад хэсгийг орчуулсан байдлаас мэдэж болно. Тухайлбал зам харгуйн дүрслэл гарч буй өөр нэгэн хэсгийг хэрхэн орчуулсан байгааг үзье.

Эх зохиолд:

Fundătura pleacă din Ulit, a din dos, de lângă biserică, se adânceș, te mereu între dealuri sila Ștefan Ilina, se despica în două. Un brat, mai scurt o ia la stânga, numai printre vreo trei-patru căsute, apoi se face drum de car, se catără pe coastă și se pierde în câmp: cellalt însă merge înainte, cu casele tot mai rare, pe urmă, mereu pe lângă Pârâul Dracului, din ce în ce mai serpuie, până ce intră în Pădurea Fulgerată... [L.Rebreanu, 2017:49]

Монгол орчуулгад:

Мухрын гудамж, сүмийн хажуугийн гудамжнаас эх авч, толгодыг ороон, Штефан Илиний гаднаас салаалжээ. Богино салаа нь зүүн тийш эргэн хоёр гурван байшин өнгөрмөгцөө дардан замд нийлээд, уулын бэлийг ташлан, тариан талбайд шургажээ. Нөгөө салаа нь тосгоны зах дахь өөвөр цөөвөр байшингуудын дундуур сүлжин Чөтгөрийн голын эргээр тахирласаар Аяндын шугуйд шургажээ... [Л.Ребряну, 1988:48]

Үүнд “pleacă” – “эхлэх” гэдгийг “эх авах”; “a din dos” – “хойно, ард” гэдгийг “ороох”; “se despica în două” – “хоёр хуваагдах” гэдгийг “гаднаас салаалах”; “ia la stânga” – “зүүн тийш эргэх”; “printre” – “дундуур, голоор” гэдгийг “өнгөрмөгц”; “face drum” – “зай тавьж өгөх” гэдгийг “нийлэх”; “catără pe coastă” – “эрэг өөд өгсөх” гэдгийг “уулын бэл ташлах”; “pierde în câmp” – “тариан талбайд далдрах” гэдгийг “тариан талбайд шургах”; “merge înainte” – “дундуур нь урагшлах, голоор нь урагшлах” гэдгийг “дундуур сүлжих”; “serpuie” – “ороох” гэдгийг “тахирлах”; “intră în” – “орох” гэдгийг “шургах” гэж тус тус оноосон байгаа нь эх зохиолд зам, гудамжны үргэлжлэх байдлаар тосгоны орчныг зураглан дүрсэлснийг монгол хэлнээ орчуулахдаа зүг чиг, орон байрны утга заасан үгсээс зайлсхийн үйл үгийн сонголтыг сайтар анхаарч, аль болох давталгүйгээр илэрхийлэхийг зорьсон нь орчуулгын найруулгыг уран яруу болгосон төдийгүй монгол хүний төсөөлөлд шууд буухаар дүрсэлж чадсан нь оновчтой шийдэл болсныг бид харж болох байна. Мөн эх зохиолд “trei-patru căsute” – “гурав дөрвөн байшин” гэж тооны нэрээр тоймчлон өгүүлснийг “өөвөр цөөвөр байшингууд” гэж, “Pârâul Dracului” гэсэн ардын домгийн алдарт дүрийн нэрээр нэрлэсэн голын нэрийг “Чөтгөрийн гол” гэж ерөнхийлж, “Pădurea Fulgerată” гэх ойн нэрийг “Аяндын шугуй” гэж орчуулан буулгасан нь монгол уншигчдад илүү ойлгомжтой, гадаад нэрээс шалтгаалж анхаарал сарнилгүй уран төсөөлөлд шууд хүртэгдэхээр орчуулсан байна.

Энэ мэтчилэн монгол хэлний үг, хэллэгийн баялаг сангаас ашиглан эх зохиолын дотор давтан хэрэглэж байгаа үг хэллэгүүдийг аль болох давталгүйгээр буулгахыг

хичээсэн нь тус орчуулгын нэг давуу онцлог болох юм. Жишээ нь: *“томоогүй хүүхдүүд”* гэснийг *“Дүрсгүй жаалууд”, “тархигүй гайхлууд”, “дүрсгүй хоолны савнууд”*; үнэн алдарт шашны ламыг хам сэдвийн тухайн утга агуулгаас хамааран *“санваартан”, “лам”, “ламтан”, “ламбугай”, “гэгээн эцэг”, “багштан”, “дээдэс”* гэх мэтээр орчуулсан байна. Түүнчлэн зохиолд шашны зан үйл, сүсэгтэн олны тухай өгүүлсэн хэсгийг орчуулахдаа бурхан шашны соёлын улбаатай нэр томьёо, хүндэтгэлийн үг хэллэгийг түлхүү хэрэглэсэн байхын сацуу *“дуганыхаа жавдан дээрээс ном айлдаж байгаа юм шиг”* гэх мэт хэллэгүүдийг зохистой газар нь оновчтой ашигласан нь утга санааг тодруулахад, орчуулгын хэл найруулгыг олон талтай, баялаг болоход нөлөөлсөн байна.

Эх зохиолын утга агуулгыг яруу тод илэрхийлэх үүднээс өгүүлбэрт дүр дүрслэлийг тодотгох үүрэгтэй орсон гишүүнийг солих: *“сүүн цагаан муур”* гэдгийг *“цав цагаан муур”, “хүндээр амьсгаадах”* гэдгийг *“байдгаараа уухилан аахилах”, “хүдэр биетэй согтуу эр мэт”* гэж нэр үг дээр суурилж илэрхийлсэн салхины адилтгалыг *“согтуу юм шиг гуйвлан”* хэмээн үйлийн шинжийг нь онцолсон зүйрлэл болгосон байхаас гадна *“нохой шиг”* гэдгийг *“яс горилж байгаа нохой шиг”, “ярианд оролцохоос эмээн”* гэдгийг *“үг хэлж зүрхлэх ч үгүй дэмий л гөлөлзөн”* гэх зэргээр нэмэн дэлгэрүүлж утгыг улам тодорхой болгосон хувиргалын жишээ ч цөөнгүй байна.

Ливиу Ребряну “Ион” романаа туурвихдаа хурц үг хэллэг, түүний дунд өвөрмөц хэлц, хэвшмэл хэллэгийг маш их ашигласан нь түүний зохиолын хэлийг тун яруу баялаг болгох үндсэн нэг шинжийг нь бүрэлдүүлсэн байдаг. Тэгвэл уул романы монгол орчуулгыг бүтээхэд Т.Галсан, Б.Чимиддорж нар монгол хэлний хэлц хэллэгийг өргөн дэлгэр ашигласан байхаас гадна өөрсдөө ч утгын гайхалтай тансаг тогтвортой нийлэмж бүтцүүдийг зохиож хэрэглэсэн нь тус орчуулгын хэлийг маш уянгалаг, амьд болгоход чухал үүрэг үзүүлсэн байна. Жишээ нь: *“хүссэн юм хүзүүн дундуур татах”, “амандаа орсон шар тосыг хэлээрээ түлхэх”, “ичих нүүрэндээ элэг наах”, “жаргалын далайд умбах”, “лусын дагина шиг”, “усан хулгана болох”, “яарвал даарна”, “аргатай хүн алтан аяганаас ус ууна”, “өнгөрсөн борооны хойноос цув өмсөх”, “аз хүү ирвэл ёоз хүүгээр гэр барина”, “бүдэрдэггүй морь, энддэггүй хүн гэж хаана байх вэ”, “суувай эм”, “ам булаалдах”, “урам хугарах”, “эр хүнд итгэхээр эрхий хуруундаа итгэ”, “бодоод бодоод бодын шийр дөрөв”* гэх мэт монголчуудын дунд түгээмэл хэрэглэгддэг хэлц, хэллэгүүд олон байхаас гадна эх зохиолын утга санаанаас үүдэлтэй *“эрийн сайхантай суулаа гэж эрдэнэ шиш илүү ургахгүй, хөгжжөөнтэй сэргэлэн эртэй боллоо гээд хүссэн бүхэн чинь аандаа бүтчихгүй”, “ухаан мухар бол үйлс сохор”, “өр гэдэг үстэй толгой давлаа”, “өр өсөх нь хулс ургахаас хурдан”, “хар нохойг угаавч цагаан болдоггүй”, “бурхнаас ч айхгүй, хүнээс ч эмээхгүй”* гэх мэт бүтээлч туршлагын жишээ ч цөөнгүй байна.

Мөн түүнчлэн “бэлэвсрэх гэдэг нь гашиун зовлон” гэдгийг “эр нөхрөө алдана гэдэг шороо үмхэнэ гэсэн үг дээ”, “лааны тос шиг зөөлөн” гэдгийг “хайлсан тос шиг зөөлөн”, “эрүүл болтугай” гэдгийг “ерөөлөөр болтугай”, “сэтгэлдээ тээх” гэдгийг “зүрхэнд уяатай”, “нүгэл ихтэй хүн” гэдгийг “нүглийн сав шүү дээ”, “толгой гудайн дуугүй зогсох” гэдгийг “хор нь буцалж, шар нь гозойно”, “санаснаар минь байдаггүйд сэтгэл минь өвдөж харуусдаг” гэдгийг “сэтгэлийн там, гунигийн үүл болсон тэр үгэнд орохгүй юм”, “сэргэлэн юм аа” гэдгийг “чоно борооноор”, “... юу руу гаа тонил, бурхан минь өршөө” гэдгийг “далд ор... газрын гай минь”, “бүх аргаа бараад” гэдгийг “эрийн арван гурван мэхээ гаргаад”, “хашираагаад өгнө өө” гэдгийг “дөрий чинь дугтраад өгнө өө” гэх зэргээр хэлц, хэллэгийг ашиглан эх зохиолын утга санааг гүнзгийрүүлсэн, дүрслэлийг дэлгэрүүлэн чимсэн, зохиолын дүрүүдийн харилцан яриаг монгол хүн уншихад сэтгэлд ойр, амьдлаг болсон орчуулгын сайн жишээ олныг дурдаж болохоор байна.

“Ион” романы монгол орчуулга эх зохиолын үзэл санаа, дүр дүрслэлийг бүтээсэн уран яруу хэрэглүүрийг хэл найруулгын түвшинд хэрхэн ончтой сайхан буулгасны жишээ болгож Белчуг ламтныг дүрсэлсэн нэг хэсгийг харьцуулан үзье. Эх зохиолд байгааг үгчлэн буулгавал “Тэр эхнэртээ маш хайртай байв, [эхнэрээ] алдсан энэ уй гашиу түүний сэтгэлийг хатаажээ. Өвчинд баригдан маш их турж эцсэн тул хэн бүхэн түүнийг харуутаа “яаж шуухан амьд явна даа” гэж бодох аж” гэсэн хоёр өгүүлбэрийг орчуулгад “Эхнэртээ голоосоо хайртай байсан тэр, талийгаачийн хойноос сэтгэлээр унаж, амь нь хаана байгаа юм гэмээр яс арьс болжээ” гэж бүтцийн хувьд нэгтгэн нийлүүлсэн байх төдийгүй монгол хэлний үг, хэллэгийг оновчтой тохируулан утга санааг нь тодруулж, уншихад ойлгомжтой, хэл найруулгын хувьд уран цэгцтэй болсон нь илэрхий харагдана. Мөн Роза Лангийн тухай өгүүлэх өөр нэгэн хэсгээс үгчлэн буулгавал “Та ч бас сэгсгэр болгоныг магтах гэж юунд яарна... Түүнийг сайхан гэвэл намгийн шулмыг юу гэх вэ? Румын хэл ч мэдэхгүй мунхаг эмэгтэй яаж сайхан байх вэ дээ” гэснийг “Дүрсгүй банди минь, тэр муу сувай эмийг магтах юун... Түүнийг сайхан гэвэл боохолдойг юу гэх болж байна? Румын хэл ч мэдэхгүйг бодоход ялдмаасаа тэнэг нь илүү байх” орчуулсан нь хэл найруулгын аль ч талаасаа монгол хэл соёлд ойр, орчуулгын модон хэлнээс хол, монгол хүний ой тойнд шууд буухаар илэрхийлж чадсан нь орчуулагчдын ур чадварыг тод харуулж байгаа юм.

Мэдээж хэрэг Ливиу Ребрянугийн “Ион” романы монгол орчуулгын цөөн зарим жишээгээр бид Т.Галсангийн орчуулгын ур чадварыг бүрэн дүүрэн гаргаж ирнэ гэдэг боломжгүй. Гэхдээ өрнийн уран зохиолыг хэрхэн дорнын хөрсөнд идээшүүлж, нүүдлийн соёл иргэншилтэй монгол хүнд, монгол хэл соёл, монгол сэтгэхүйд хүргэж, хүртээж болдог арга туршлагын тодорхой баримт болгох үүднээс, өнөө цагт газар аваад байгаа модон орчуулгын өөдөөс үлгэр болгон үзүүлэхийн тулд зах зухаас нь өргөн толилуулсан билээ. Монголын бичиг номын мэргэд дэлхийн утга соёлын өв сангаас төрөлх хэлнээ

гарамгай сайхан орчуулж, тэр ч байтугай монгол хэл соёлын салшгүй нэгэн хэсэг болтол нь нутагшуулж өөриймшүүлж ирсэн орчуулгын баялаг түүх уламжлалыг бүтээсэн билээ. XX зуунд орчуулгын уран зохиол маш эрчимтэйгээр хөгжсөн бөгөөд тэргүүн эгнээнд нь эрдэмтэн, зохиолч, яруу найрагчид түүчээлэн ирсний нэг нь өөрийн гэсэн орчуулгын арга барилтай, гойд сайхан хэл найруулгатай содон төлөөлөгч бол яах аргагүй Ардын уран зохиолч Т.Галсан мөн гэдэг нь түүний орчуулгын бүтээлүүдээс тодорхой харагдаж байна.

Эдүгээ залуу орчуулагчид олноор төрөн гарч, жил ирэх тусам орчуулгын уран зохиолын тоо чанар нэмэгдэж байгаа хэдий ч сайны дотор саар гэгчээр хэт үгчлэн буулгасан модон орчуулгууд ч олон байгаа нь үнэн билээ. Энэ нь басхүү борлуулалтын ашиг хонжоог хөөцөлдөн гаднаа гяланцаг дотроо паланцаг орчуулгууд газар авч байгаатай ч холбоотой юм. Машины орчуулгыг өнгөц боловсруулах төдийгөөр богино хугацаанд хийж гаргасан, чамин ганган хавтастай орчуулгууд үүний тод жишээ. Иймд тоог бус чанарыг, хугацааг бус чансааг, ашгийг бус ач холбогдлыг анхаарч залуус маань зөвхөн гадаад хэлийг сохроор шүтэлгүй мөн эх хэл, утга соёлоо дээдлэн, мэдлэг боловсролоо гүнзгийрүүлэн, ахмад үеийнхнийхээ орчуулгын баялаг туршлагаас илүүхэн судалж суралцахыг хичээн явбал зохилтой байна.

НОМ ЗҮЙ

1. Liviu Rebreanu. (2017), *Ion*. Interbellum Scriptorium. București.
2. Ливиу Ребряну. 1988), *Ион*. Орч.: Т.Галсан, Б.Чимиддорж, УБ
3. Батжавхлан Э., Баттөр Ш., Мөнх-Оргил А. (2017), XX зууны монголын уран зохиол, УБ
4. Батжавхлан Э. (2019), XX зууны эхэн үеийн монгол, хятадын уран зохиолын харьцуулсан судалгаа, УБ
5. Сампилдэндэв Х. (2004), Туульч өөлд Тангадын Галсан (намтар, уран бүтээлийн товчоон). “XX зууны монгол зохиолчид” цуврал № 13, УБ

АНГЛИ-МОНГОЛ ЗҮЙР ҮГИЙН ОРЧУУЛГАД ХИЙСЭН АНАЛИЗ

Я.Бадамсүрэн⁸⁰

Ц. Энхцэцэг⁸¹

Л.Халиун⁸²

Abstract: *The research aim is to analyze the English-Mongolian proverb translation by students who are studying academic English at the intermediate level at the National University of Mongolia. It was very difficult for students to translate English proverbs into the Mongolian language due to the first attempt to translate English proverbs.*

A good translation sticks to the reader and can be understandable. It is required not only to have adequate knowledge and experience in translation theory and methods but also to have a great knowledge of the language, culture, customs, and traditions of both languages to translate proverbs. As a result of the survey, we conclude that the proverb translation ability/skill of the students was not enough, because they didn't have any experience in translating proverbs.

Түлхүүр үгс: *зүйр цэцэн үг, орчуулга, англи монгол хэл*

Судалгааны зорилго нь англи зүйр цэцэн үгс (English proverbs)-ийг монгол хэлнээ буулгахад тухайн хоёр орны ард түмний соёл, хэл, сэтгэлгээний онцлогийг зөв илэрхийлэхийн тулд ямар шалгуур шаардлагуудыг баримталж орчуулах ёстойг оюутнуудад ойлгуулах нь чухал байлаа. Үүний тулд академик англи хэл судалж байгаа оюутнуудын англи зүйр цэцэн үгийг орчуулах чадвар, арга барилыг тодорхойлох, тулгарч байгаа бэрхшээлийг нь олж илрүүлэхийг судалгааны гол зорилго болголоо. Энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүллээ.

1. Оюутнууд сайн дурын үндсэн дээр 20 англи зүйр үгийг монгол хэлнээ орчуулах

⁸⁰ Доктор, МУИС, ШУС, ГХСТ

⁸¹ Ахлах багш, МУИС, ШУС, ГХСТ

⁸² Доктор, МУИС, ШУС, ГХСТ

2. Оюутнуудын орчуулгад анализ хийж, орчуулга хийхэд тулгарч байгаа бэрхшээлийг тодорхойлох

Удиртгал

Орчуулга буюу “translation” гэдэг үг Латин гаралтай авчрах, зөөх, дамжуулах гэсэн утгатай. Зүйр цэцэн үг нь тухайн үндэстэн, ард түмний амьдралаас урган гарсан яруу найргийн хэлбэрээр бичигдсэн, богино хэмжээний сургаал үгсийн охь гэж хэлж болно. Эрдэмтэн Ш.Гаадамба “Оюун дүгнэлтийн аргаар нэгтгэн дүгнэсэн гүн утга, өргөн санаа агуулсан цөөн үгийн тогтмол бүтэцтэй үг хэллэгийг цэцэн үг гэнэ.” (Гаадамба, Сампилдэндэв, 1988:174) хэмээн тодорхойлжээ. Монголчууд зүйр цэцэн үгийнхээ баялаг арвиныг бахархан “Зүйргүй үг байдаггүй, зүйдэлгүй дээл байдаггүй” гэж зүйрлэн ярьдаг билээ. Зүйр цэцэн үгийн агуулгыг харахад цэцэлсэн, зүйрлэсэн, сургамжилсан зэрэг өргөн хүрээтэй байх тул судлаачид “Цэцэн үг, зүйр үг, мэргэн үг” хэмээн хэд хэдэн янзаар нэрлэсэн байдаг. Зүйр цэцэн үгийн гол онцлог нь адил төстэй юмс үзэгдлийг хооронд нь жишин зүйрлэх аргаар утга санааг нь улам лавшруулан гаргадаг байна. Эрдэмтэн, зохиолч Б. Содном (1953) “цэцэн үг, ард түмний өдөр тутмын аж амьдралд үргэлж хэрэглэгдсээр байдаг, ихээхэн өргөн дэлгэр утгатай, голдуу товч богино, оновчтой, мэргэн сургамжийн чанартай бөгөөд хүн ярианыхаа дунд, аль хэрэгтэй газартаа санамсаргүй юм шиг хэрэглэдэг нь олон үг хэрэглэж ямар нэг утга санааг гаргах бус хэлэх санааг хураамжилж өгдөг байна “ гэж бичжээ. Хэл бичгийн ухааны доктор О. Адьяа Английн мянган зүйр цэцэн үгийг Монгол, Орос орчуулга болон дүйцэлтэй нь бичсэн байна. Шинжлэх ухааны доктор Ц. Дашдондов “аливаа хэлний үг зүй, утга зүй, найруулга зүйн хамгийн онцлог шинжийн цогц бүрдэл гэвэл зүйр цэцэн үг хийгээд сургаал үг, хэвшмэл, хэлц хэллэг юм. Түүнд тухайн улс үндэстний ард зоны ажил байдал, ахуй соёл, ёс заншил, сэтгэлгээний түвшин үнэлж таашаах болон, үзэн ядах хандлага бүгд бүрдмэл” гэж зүйр цэцэн үгийг оновчтой тодорхойлсон байна. Зүйр цэцэн үгийг “юм үзэгдэл, үйл явцын шинж төлөвийн төсөөт байдлаар нь утга шилжүүлэн хэрэглэх /үүнийг Зүйрлэл (metaphor, metaphore/” (Ж. Баянсан Ш. Одонтөр, 2004:169) явдал гэж ойлгоно.

Эрдэмтэн С. Дулам, Ц. Хасбаатар нар “Хэлний аливаа үгс өөр хоорондоо холбогдож нэгдэхдээ цоо шинэ утга чанартай болж, уран сайхны дүрийн баялаг бололцоог бий болгож байдаг. Уран зохиолын хэлний үгсийн санд ихээхэн тохиолддог үгийн чухал нэг чанар бол салаа утга бөгөөд юм үзэгдлийг аль болох тодорхой, амьд дүрслэхэд зохиолчдоод хэрэг болдог зүйл юм” гэж тодорхойлжээ. Түүнчлэн 20-р зууны гарамгай сэхээтэн, соён гэгээрүүлэгч, эрдэмтэн, зохиолч Б. Ринчин, академич Ц. Дамдинсүрэн, П. Хорлоо, Ш. Гаадамба, Ц. Дашдондов, Ш. Чоймаа, Б. Содном, Ж. Дашдорж, Г. Ринчинсамбуу, доктор, профессор Г. Эрдэнэ-Очир, Ж. Бат-ирээдүй, А. Шагдарсүрэн, Б. Идэрбаяр, О. Адьяа, судлаач Г. Аким, Д. Ганболд, Г. Одхишиг, И. Бүрэн-Өлзий нарын эрдэмтэн судлаачид зүйр цэцэн үгийг бүтэц, утга, онцлог, гүйцэтгэх үүрэг,

ач холбогдлын талаар авч үзэхийн зэрэгцээ тольчлох, зүйлчлэх, системчлэх, тайлбарлах талаас нь судалсан байна.

Коллинсын англи хэлний тайлбар толь бичигт зүйр цэцэн үгийг тодорхойлохдоо хүмүүсийн байнга иш татдаг, сургамж, зөвлөгөө өгөх зорилготой, эсвэл амьдралын ухааныг цөөн үгээр илэрхийлсэн богино өгүүлбэр юм(*Collins English Dictionary*) гэжээ. Монгол төдийгүй гадаадын эрдэмтэд Монгол зүйр цэцэн үгийг судалсан байдгийн нэг нь Дженис Рэймонд монгол ардын зүйр цэцэн үгсийг Англи хэлэнд орчуулжээ. Америкийн нэрт эрдэмтэн Алан Дандес, Б. Милнер, Норик Английн зүйр цэцэн үгт дүн шинжилгээ хийсэн байна. Хонек, Лакофф мөн Тернер зэрэг эрдэмтэд англи зүйр цэцэн үгсийг когнитив хэл шинжлэлийн чиглэлээр судалсан байна. Мөн судлаач Волфган Миэдэрын тодорхойлсноор зүйр цэцэн үг гэдэг нь ардын мэргэн ухаан, ёс суртахуун, уламжлалт үзэл бодлыг зүйрлэл, тогтсон хэлбэр мөн цээжилж тогтооход хялбар байхаар зохиогдсон богино өгүүлбэр юм гэжээ. (Волфган Миэдэр, 1993:24)

Бид энэхүү судалгаандаа эх хэрэглэгдэхүүн болгож эрдэмтэн судлаач Г.Акимын “Англи-Монгол, Монгол-Англи зүйр цэцэн үгийн толь” /Улаанбаатар 1995/-ийг ашигласан болно.

Үндсэн хэсэг:

Судалгаанд оролцогчид

Энэхүү судалгаанд 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улиралд МУИС-д академик англи хэлийг дунд түвшинд судалж байгаа 3 бүлгийн 69 оюутан хамрагдсан болно. Судалгаанд оролцогчид нь 1-4 дүгээр түвшний 17-21 насныхан байв.

Судалгаанд оролцогсод англи зүйр үгийг монгол хэлнээ орчуулахдаа үндсэн 3 арга замаар орчуулах оролдлого хийж эсвэл бүр орчуулалгүй үлдээсэн байна.

1. Монгол зүйр үгтэй дүйцүүлэн орчуулах оролдлого хийсэн
2. Үгчлэн орчуулсан
3. Бусад
4. Огт орчуулаагүй

Оюутнуудын орчуулсан байдлыг 4 графикаар харууллаа.

График 1 -ийг задалж өгүүлбэл,

1. ***Honesty is the best policy*** /It's always better, to tell the truth than it is to lie/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Үнэнээр явбал үхэр тэргээр түүлай гүйцнэ гэж 18 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар үнэнч шударга байх нь хамгийн сайн зан чанар гэж 41 оюутан оноосон, хуурамч хүн хуулиас аймтгай, худлыг үнэн гүйцнэ, хурдныг сүм гүйцнэ, зөв явбал зөөлөн зөөлөн замбуулин гэх мэтчилэн бусад хувилбараар 5 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн мөн 5 оюутан байна.
2. ***You can't always get what you want*** /Don't complain if you don't get what you want/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Их санасан газар есөн шөнө хоосон

гэж 4 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Үргэлж хүссэн болгоноо авах боломжгүй байдаг гэж 52 оюутан оноосон, Хүсэвч хясна, Хүнс голбол хоолгүй, хүн голбол нөхөргүй, Хүссэн юм хүзүү орооно, Авснаар баяждаггүй, өгснөөр хоосордоггүй гэх мэтчилэн бусад хувилбараар 10 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг орт орчуулаагүй үлдээсэн 3 оюутан байна.

3. **Beauty is in the eye of the beholder** /What is “beautiful” is different for each person/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Таван хуруу тэгшгүй, хүний сэтгэл адилгүй гэж 6 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Үзэсгэлэн үзэгчийн нүдэнд оришино гэж 28 оюутан оноосон, Гаднаа гяланцаг, дотроо паланцаг, Хүн бүрийн харах өнцөг өөр, Гоо сайхан ертөнцийг аварна, Нүд бол сэтгэлийн толь юм, Адууны алаг сайхан, аяганы алаг муухай, Эрдэмтэй хүн даруу, их мөрөн дөлгөөн, Хүн хүний нүд өөр гэх мэтчилэн бусад хувилбараар 21 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 14 оюутан байна.
4. **Don't bite the hand that feeds you** /Don't make someone angry or hurt someone who is helping you or paying for you/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Сүүдэрт нь суувал модыг бүү март /цай уусан аяга руугаа шороо бүү цац/ гэж 2 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Чамайг тэжээж байгаа гарыг бүү хаз гэж 34 оюутан оноосон, Өөх өгсөн хүнтэй өглөө босоод заргалдах, Сиймхий ч гэсэн гэр минь, Тусыг тусаар хариул, Хэний ачаар хэн болсноо хэзээ ч бүү март, Өрөвдөхөөр өр лүү бүү өшиглө, Ишиг эврээ ургахаар эхийгээ мөргөнө, Тэжээсэн бяруу тэрэг эвдэнэ, Түрийний бөөс толгой дээр гарах гэх мэтчилэн бусад хувилбараар 28 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 5 оюутан байна.
5. **Don't put off until tomorrow what you can do today** /If you can do something today, do it. Don't wait until tomorrow, don't procrastinate/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Мүү хүнд хойтон жил олон гэж 3 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Өнөөдөр хийж чадах зүйлээ маргааш гэж бүү хойшлуул гэж 58 оюутан оноосон, Маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушги дээр , Залхуу хүнд маргааш өдөр олон гэх мэтчилэн бусад хувилбараар 4 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг орт орчуулаагүй үлдээсэн мөн 4 оюутан байна.





График 2 -ийг задалж өгүүлбэл,


6. **Don't put too many irons in the fire** /Don't try to do too many things at the same time; focus on one thing at a time/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Хоёр туулай хөөсөн хүн хоосон хоцорно гэж орчуулсан хүн гараагүй бөгөөд Гал дээр тос нэмэх гэж 51 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Галд хэт их төмөр хийж болохгүй гэж 4 оюутан оноосон, Гал дээр тос бүү нэм, Долоо хэмжиж нэг огтол, Хайр ихэдвэл хартай, халгай ихэдвэл цэврүүтэй, Яарвал даарна гэх мэтчилэн бусад хувилбараар 9 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 5 оюутан байна.
7. **Easy come, easy go** /When you make money quickly, it's very easy to lose it quickly as well/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Олзны юм гарзгүй гэж 2 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Амархан ирж амархан явах гэж 27 оюутан оноосон, Амар олдсон олз амархан үрэн таран хийгдэнэ Асуудлыг хүндээр бүү хүлээж ав, Амар хялбар явах, Амар олдсон зүйл удаан тэсэхгүй, Буруу замаар будаа тээвэл, буцахдаа шороо тээнэ, Амархан олдсон зүйл гараас амархан

мултардаг, Амархан ирж, амархан явах гэх мэтчилэн бусад хувилбараар 35 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 5 оюутан байна.

8. **Good things come to those who wait** /If you are patient, good things can happen/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Эзэн хичээвэл заяа хичээнэ гэж 4 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Хүлээж чаддаг хүнд сайн зүйл ирдэг гэж 42 оюутан оноосон, Хүлээсэн хүнд сайн зүйл ирдэг, Сайныг дагавал сарны гэрэл гэх мэтчилэн бусад хувилбараар 19 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 4 оюутан байна.

9. **Hope for the best, prepare for the worst** /In any situation, be optimistic about the result, but always be ready for the worst outcome/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Их санасан газар есөн шөнө хоосон гэж 3 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Сайныг хүсэж мууд бэлтгэлтэй бай гэж 55 оюутан оноосон, Балд дуртай бол зөгийд хатгуулахаас бүү ай гэх мэтчилэн бусад хувилбараар 10 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 1 оюутан байна.

10. **If you play with fire, you'll get burned** /If you get involved in something dangerous or beyond your abilities, you will probably experience negative consequences/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Өөдөө шидсэн чулуу өөрийн толгой дээр гэж 3 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Галаар наадвал шатна гэж 42 оюутан оноосон, Бие нь жижиг ч бэлчээр нь том, Өөрийн тарьсан зүйлээ өөрөө үүрэх, Галаар оролдвол аминд халтай, Үхэл нь ирсэн хулгана муурын сахлаар оролдоно гэх мэтчилэн бусад хувилбараар 22 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 2 оюутан байна.






График 3 -ийг задалж өгүүлбэл,

- 11. Keep your friends close, and your enemies closer** /If someone is your enemy, treat like them a friend so you can be ready if they ever try to betray you/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Уул усны ойр нь дээр, ураг төрлийн хол нь дээр гэж 2 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Найзтайгаа ойр бай, дайсантайгаа тэрнээс ч ойр бай гэж 14 оюутан оноосон, Инээсэн бүхэн нөхөр биш, уурласан бүхэн дайсан биш, Ой мод урттай богинотой, олон хүн сайнтай муутай, Дайснаа найзаасаа ч ойр байлга гэх мэтчилэн бусад хувилбараар 50 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 3 оюутан байна.
- 12. People who live in glass houses should not throw stones** /Don't criticize someone if you're not perfect either; don't be a hypocrite/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Өмдгүй байж өвдөг цоорхойгоо шоолох, Өөрийн толгой дээрх бүхлыг хараагүй байж, хүний толгой дээрх өвсийг харах гэж 5 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Шилэн байшинд амьдардаг хүн чулуу шидэх эрхгүй гэж 24 оюутан оноосон, Хүнийг хэлбэл өөрийгөө хэлсэнтэй адил, Хүний бурхан өөрийн буг хоёр адил, Хүнд хэлүүлсэн хүлэгт бариулсан хоёр адил, Хүн болгон адилгүй, Хүлэг болгон жороогүй гэх мэтчилэн бусад хувилбараар 22 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 18 оюутан байна.
- 13. It is easy to be wise after the event** /Once something has happened, and all the facts are known/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн ниргэсэн хойно нь хашихрах гэж 10 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Өнгөрсөн хойно нь ухаалаг дүр эсгэх амархан гэж 36 оюутан оноосон, өнгөрсөн борооны хойноос цув нөмрөөд нэмэргүй гэх мэтчилэн бусад хувилбараар 18 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 5 оюутан байна.
- 14. The grass is always greener on the other side** /People always want what they don't have/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Хүний тугал бяруу шиг, өөрийн тугал хурга шиг гэж 4 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Өвс нөгөө талд үргэлж ногоон байдаг гэж 27 оюутан оноосон, Могойн эрээн гаднаа, хүний

эрээн дотроо, Хайр нь гаднаа хал нь дотроо, Аливаа зүйлээс илүү сайхан зүйл хаа нэгтээ байж л байдаг, Уулын мод урттай богинотой, Үнэнийг хэзээд үнэнээр батална, Жаргалтай газар хүн тогтохгүй, өвстэй газар мал тогтохгүй, Айлын хоол амттай, нөгөө эгнээ түгжрэлгүй гэх мэтчилэн бусад хувилбараар 27 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 11 оюутан байна.

15. *There is no place like home* /Your home is the most comfortable place in the world/ - энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Сиймхий ч гэсэн гэр минь, сэгсгэр ч гэсэн ээж минь гэж 1 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Гэр шиг сайхан газар хаана ч байхгүй гэж 40 оюутан оноосон, Дассан газрын даавуу зөөлөн Одоогоороо амьдар, Маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушги, гэх мэтчилэн бусад хувилбараар 10 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 8 оюутан байна.

График 4 -ийг задалж өгүүлбэл,

16. *There is no time like the present* /Don't wait to do something. Do it now/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Ямааны мах халуун дээрээ гэж 2 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Одоо шиг цаг хэзээ ч байхгүй гэж 27 оюутан оноосон, Одоо биш бол хэзээ ч биш, Цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй гэх мэтчилэн бусад хувилбараар 36 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 7 оюутан байна.

17. *Two heads are better than one* /It's easier to do something as a team than by yourself/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэж 8 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Ганц толгойноос хоёр толгой нь дээр гэж 32 оюутан оноосон, Ганц хүн айл болохгүй, ганц мод гал болохгүй, Олуулаа хийх нь үргэлж дээр, Хүн хүндээ хүлэг эрчдээ, Бултаараа хэлэлцвэл буруугүй, Цувж явсан бараас, цугларч суусан шаазгай дээр, Олны хүч оломгүй далай гэх мэтчилэн бусад хувилбараар 26 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 3 оюутан байна.

18. *You can lead a horse to water, but you can't make him drink* /You can try to help someone by giving good advice, but you can't force them to accept it or follow it/ - энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Дургүй ламд дарж байж сахил хүртээх, /Ус үүхгүй үхрийн толгойг бүү дар, үг мэдэхгүй хүний толгойг бүү ил/ гэж 16 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Чи морийг услахаар ус руу дагуулж явж чадна, гэхдээ ус уулгаж чадахгүй гэж 13 оюутан оноосон, Дургүйд хүчгүй, Илжигний чихэнд ус хийсэн ч сэгсэрнэ, алт хийсэн ч сэгсэрнэ, Ганц хүн айл болохгүй, ганц мод гал болохгүй, Хүн хэлээрээ мал хөлөөрөө, Талх өгөх биш хийх аргыг нь зааж өг, Аманд орсон шар тосыг хэлээрээ түлхэх гэх мэтчилэн бусад хувилбараар 33 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 7 оюутан байна.

19. When in Rome, do as the Romans do /When you are in a new place or situation, try to act like the majority of people in that place or situation/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Усыг нь уувал ёсыг нь дагана гэж 41 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Ромд байхдаа Ромчууд шиг л бай гэж 28 оюутан оноосон буюу өөр хувилбараар орчуулсан болон огт орчуулаагүй тохиолдол гараагүй байна.

20. Where there's smoke, there is fire /if something seems wrong, it probably is; also, there is usually some truth to a rumor/ -энэ зүйр үгийг монгол зүйр үгтэй дүйцүүлэн Овоо босгоогүй бол шаазгай хаанаас сүүх вэ? гэж 12 оюутан орчуулсан, үгчилсэн байдлаар Тэнд утаа байгаа бол гал байна гэсэн үг гэж 21 оюутан оноосон, Утаа байгаа газар гал оршино, Гараа сайн бол бариа сайн, Нүд үнэн, чих худал гэх мэтчилэн бусад хувилбараар 27 оюутан орчуулсан бол энэ зүйр үгийг огт орчуулаагүй үлдээсэн 9 оюутан байна.

Дүгнэлт

Оюутнуудын хувьд англи хэлийг мэргэжлийн бус хичээлээр судалж байгаа төдийгүй зүйр цэцэн үгийг орчуулах анхны оролдлого/туршилт гэхэд бас чамлахааргүй үр дүнтэй байлаа гэж үзэж байна. Судалгаагаас харахад оюутнууд зүйр үгийг орчуулахдаа ихэвчлэн үгчлэн орчуулахыг хичээсэн байна.

Оюутнууд зүйр цэцэн үгийг орчуулахдаа юун түрүүнд үгчлээд ч болов утгыг нь гаргахыг хичээсэн хэдий ч тухайн санаа монгол хэлнээ ямар агуулгаар дүйхийг хараахан лавшруулан ойлгож ухаараагүй, олсон санаан дээрээ дөрөөлж дүйцэх агуулгыг илэрхийлэх үг хэллэгийг хэрхэн сонгох талаар ойлголтгүй, хамгийн харамсалтай нь монгол хэлний зүйр цэцэн үгсийг төдийлөн мэдэхгүй байгаа нь судалгаанаас харагдаж байлаа.

Түүнчлэн ахуй болоод соёлын ялгаатай, үндэсний онцлог агуулгыг орчуулж байгаа хүн нь хоёр улсын хэлийг мэддэг байхаас гадна хоёр улсын хэл, соёл, уламжлалт ахуйн талаар нэлээд гүнзгий ойлголттой байх нь чухал гэдгийг оюутнуудад энэ судалгаанд оролцож, зүйр цэцэн үгсийн орчуулгын талаар ярилцаж, алдаа оноогоо дүгнэж цэгнэснээр ойлгож туршилтын ажил хийсэн нь судалгааны ач холбогдлын өргөж өглөө.

Орчуулж буй зүйр цэцэн үгийн монгол хэлний утга тохирох зүйрлэлийг бодож олохыг хичээх хэрэгтэй бөгөөд өвөрмөц зүйрлэлүүд нэгдүгээрт, монгол хүний сэтгэхүйд ойр байх, хоёрдугаарт, өгүүлбэрийн хэлбэржилт зөв байх, гуравдугаарт, учир шалтгааны хувьд алдаагүй байх гэсэн гурван шалгуурыг хангасан нөхцөлд илүү сайн оносон орчуулга гарна гэдгийг харилцан ярилцаж зөвхөн англи төдийгүй зарим нэг өдөр тутам хэрэглэгддэг монгол зүйр цэцэн үгсээ ч мэдэж тогтоож авсан нь ач холбогдолтой боллоо гэж үзэж байна.

Номзүй

Монгол хэлээр:

1. Аким Г., (2001) Монгол зүйр цэцэн үгийн товч тайлбар толь, Улаанбаатар

2. Аким Г., (1995) Англи-Монгол, Монгол-Англи зүйр цэцэн үгийн толь, Улаанбаатар
3. Баянсан Ж., Ш. Одонтөр., (2004) Хэл шинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь, Улаанбаатар
4. Баянсан Ж., (2002) Соёл, хэл, үндэсний сэтгэлгээ, Улаанбаатар
5. Гаадамба Ш., Цэрэнсодном Д., (1978) Монгол ардын аман зохиолын дээж бичиг, Улаанбаатар
6. Ням-Осор Н., Өлзийсүрэн Б., (2011) Монгол хэлний зүйр, цэцэн үгийн товч тайлбар толь, Улаанбаатар
7. Өлзийхутаг Ц., (1979) Монгол хэлний үгсийн сан судлал, Улаанбаатар
8. Равдан Э., (2000) Орчин цагийн хэл шинжлэлийн үүд, Улаанбаатар
9. Содном Б., (1964) Монгол цэцэн үгийн далай, Улаанбаатар

Гадаад хэлээр:

1. Brosh, H., (2013) Proverbs in the Arabic Language Classroom, International Journal of Humanities and Social Science, Annapolis: Language and Culture Department, Vol.3
2. Harris and Mieder W., (1994) When Evensong and Morrow song Accord: Three Essays on the Proverb. Cambridge: Harvard University Press
3. Mieder, W., (2008) Proverbs speak louder than words: Folk wisdom in art, culture, folklore, history, literature, and mass media, New York.
4. Nida & Taber., (1982) The Theory and Practice of Translation, Boston

ЯРУУ НАЙРАГЧ КИМ СО ВӨЛИЙН ШҮЛГИЙН МОНГОЛ ОРЧУУЛГЫН ТУХАЙД

Б.Дулмаа⁸³

***Abstract:** Abstract of the Mongolian language translation of two poems by Kim So-Wol, a famous Korean poet. One of the prominent poet Kim So-Wol's poems is famous for being like "traditional folk song lyrics". Kim So-Wol is well known for expressing the feeling of Korean people's "sadness and sorrow" through his poems. In this study, I tried to do side by side comparison of Mongolian language translation by 3 different translators' work in his poems "Azalea Flower" and "Calling the Soul". In these two poems, one describes the sorrow of feeling separated from his love of life by no choice but to let her go, and the other poem describes the sadness of a heart that is already gone and not able to do anything about their love. In this research, I did a quantitative analysis of a number of words, lines, and stanzas. Also, the poem's context and cultural adaption were researched. The research paper's main purpose was to reveal how Korean poetry was Mongolianized in the nature of the unique characteristics of the country's culture, customs, consciousness, and expressions embedded in poetry.*

***Түлхүүр үг:** яруу найраг, хурц улаан цэцэг, ардын дуу, гуниг, хөдөө тосгон, сүнс дуудахуй, хагацал*

Удиртгал

БНСУ-тай дипломат харилцаа тогтоосноос хойш хагас жаран өнгөрч, хоёр улсын хамтын ажиллагаа бүхий л салбарт хурдтай хөгжиж, хоёр орны ард иргэд хоорондын харилцаа холбоо өргөжин тэлсээр байна. Түүнчлэн “халлийү” солонгосын давлагаа дэлхий олон улс оронд тархаж байгаа энэ үед солонгосын соёл урлаг, уран зохиолыг сонирхон судлах, танилцах хүсэлтэй хүмүүсийн тоо багагүй байна. 1990 оны эхэн үеэс эхлэн БНСУ-ын уран зохиолтой монголын уншигчид танилцах боломж олохын хамт Монголын уран зохиолтой танилцах боломж Солонгосын ард түмэнд олдсон билээ.

Монгол хэлэнд орчуулсан уран зохиолыг 1921-1990 он хүртэл, 1990 оноос хойш гэж хоёр ангилж(Н.Мэнд, 2005:133) үзэж байна. Харин Солонгос (БНСУ) хэлээр

⁸³ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим

орчуулсан монголын уран зохиолыг 1990 оноос хойш (Б.Дулмаа, 2009:159) гэж болох бөгөөд Юү Вонсүгийн 1994 онд орчуулсан “Монголын нууц товчоо” юм. Үүнээс хойш өдгөөг хүртэл монгол, солонгосын уншигчид олон арван уран зохиолтой танилцсан байна.

Яруу найргийн орчуулгын хувьд авч үзвэл Квон Сон хүн “Солонгосын орчин цагийн шүлэг” (Тэргүүн дэвтэр, 2005), “Орчин цагийн солонгосын шүлэг” (Дэд дэвтэр, 2007), И Ан На “Солонгосын шилдэг тавин шүлэг” (2006), Д.Нармандах “Агарууны цэцэг” БНСУ-ын яруу найрагч Ким Со Вөлийн шүлгийн түүврийг тус тус гаргасан байна. Солонгосын шүлэг яруу найргийн орчуулгын тухай дорвитой бүтээл ховор “Нэгэн шүлгийн дөрвөн орчуулгыг шүүн тунгаахад” (М.Амартайван, 2015:159-168) гэсэн өгүүлэлд солонгос шүлгийн орчуулгын тухай тэр дундаа Ким Су Вөл яруу найрагчийн “Хурц улаан цэцэг” шүлгийн дөрвөн орчуулгыг харьцуулан авч үзсэн байна.

Энэ удаа БНСУ-ын орчин цагийн яруу найргийг үндэслэгч нэрт яруу найрагч Ким Со Вөлийн хамгийн алдартай уншиж үзээгүй солонгос хүн байхгүй “Хурц улаан цэцэг” (Таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг, 1957:4086) (진달래꽃 杜鵑花), “Сүнс дуудахуй” шүлгийг гурван орчуулагчийн монголын уншигчдад хүргэсэн орчуулгыг зэрэгцүүлэн судлахыг чадан ядан оролдлоо.

Солонгосын яруу найрагч Ким Со Вөл

Юуны өмнө солонгосын яруу найргийн тухай товч дурдвал, Солонгосын орчин цагийн яруу найргийг цаг үеэр нь “...эхний үе Нээлтийн бодлого баримталж эхэлсэн 19-р зууны сүүлээс 1945 он хүртэлх, сүүл үе Японы эрхшээлээс чөлөөлөгдсөн 1945 оноос хойших үе” (Квон Сон Хүн, 2005:113) гэж хоёр хуваасан байна. Эхний үеийн яруу найрагчид бүгд няцаж шантаршгүй эх оронч үзэлтэн гэдгээрээ онцлог юм. Тэдний нэг болох яруу найрагч Ким Со Вөл нь 1920 оны 8-р сарын 6-ны өдөр Солонгосын хойд нутагт төржээ. Тайж угсаатай түүний амьдрал тийм ч сайн байгаагүй. 2 настай байхад нь түүний эцэг төмөр зам дээр ажиллаж байсан япон хүний халдлагад өртөж, ухаан санаа нь эрүүл бус болсон учир бяцхан хүү өвөө, эмээтэйгээ хамт амьдрах болсон байна. Хүүд өвөө нь бичиг үсэг зааж, эмээ нь эртний хууч яриа ярьж өгдөг байв. 1915 онд Усаны дунд сургуульд элсэн орсон боловч 1919 оны 3-р сарын 1-ний хөдөлгөөний дараа, тус дунд сургууль хаагдаж, “Пэжэ” дунд сургуульд шилжин суралцаж төгсжээ.

Ким Со Вөл дунд сургуульд байх үеэсээ шүлэг зохиол оролдож Жу Ман Шиг, И Дун Хуа, Ким Ог зэрэг багш нар нь түүний авьяасыг олж харж чиглүүлж өгсөн байна. Тэр бээр 1923 онд Токиогийн удирдлагын их сургуульд орж суралцаж байтал 9-н сард хүчтэй газар хөдлөлт болж сургуулиа арга буюу орхин эх орондоо эргэн иржээ. Төрсөн нутагтаа ирээд янз бүрийн ажил хийсэн явсан боловч амьдралын хүнд хэцүү байдлаа тэвчилгүй бор дарсанд орж улмаар 1934 онд 32-хон настай цэл залуугаараа мөнх бусыг үзүүлжээ. 1968 оны 3 сард “Солонгосын өдөр тутмын мэдээ” сонины газраас Нам ууланд Ким Со Вөл найрагчийн гэгээн дурсгалд зориулан түүний шүлгийг сийлсэн гэрэлт

хөшөөг нь мөнхөлжээ. Найрагчийн анхны шүлгүүд 1920 оны 2-р сард “Чанжу” хэмээх уран бүтээлийн сэтгүүлд хэвлэгдсэнээс хойш уншигч, судлаач шүүмжлэгчдийн зүгээс өндөр үнэлгээ авсаар ирсэн байдаг. Тэрээр хүний сэтгэлийн гунигийг эмэгтэйчүүдийн дүрээр дамжуулан солонгос шүлгийн 2 3, 3 3 4 гэсэн үе, өргөлтийн уламжлалт аргаар дүрслэн гаргасан нь өвөрмөц агаад хойч үедээ өв болон үлдсэн юм.

Түүнчлэн түүний шүлэг яруу найргийн онцлог нь “ардын дуу шүлгийн уламжлал” болон солонгосын өвөрмөц сэтгэл хөдлөлийн “хан⁸⁴”-аараа алдартай. Амьд ахуйдаа хэвлүүлсэн “Хурц улаан цэцэг” түүвэрт нь 150 орчим шүлэг нь хэвлэгдсэн байдаг. Түүнийг нас барсны дараа шүүмжлэгч Ким Ог “Со Вөлийн шүлгийн үүсэл” (1939) нэртэй шүлэг, шүүмжийн түүвэр хэвлүүлсэн байдаг. Ким Со Вөлийн зохиол бүтээл солонгосын үндэсний сэтгэлгээг харуулж, яруу найргийн нэг шатад 7 болон 5 үетэй (류근조, 1999:75) 3 өлмийт шүлгийн хэмнэл (ритм) бүтэцтэй байдаг. Энэ нь түгээмэл хэмнэл, хагацал, хүсэл тэмүүлэл, шантралын тухай өгүүлдэг.

Тухайн үеийн яруу найрагт хайрт та минь, гэр орон, эх орон ч үгүй хэмээн тусгаар тогтнолоо алдсандаа харамссанаа илэрхийлж байсан байна. Мөн солонгос бүсгүйн хайртай хүнээ хайрлах сэтгэл, даруу бүрэг ичимхий байдлыг гаргахын зэрэгцээ японы дарлалд зовж буй солонгосчуудын эх оронч сэтгэлийг илэрхийлэх нь Солонгосын яруу найрагт шинэ зүйл байсан аж.

Харин Ким Со Вөл хайртай залуугаа санаж мөрөөдөж буй бүсгүйн сэтгэлээр шүлгээ бичдэг онцлогтой. Тэрээр тухайн үед жишиг болж байсан европ маягаас ангид солонгосын уламжлалд тулгуурлан шүлгээ бичдэг байв (Квон Сон Хүн, 2005:113). Түүний хамгийн алдартай бүтээл болох “Хурц улаан цэцэг”, “Сүнс дуудах”, “Хожмын өдөр” зэрэг шүлэгт солонгос хүний “харуусал” (Квон Сон Хүн, 2005:113)-ыг чадварлаг уран яруу илэрхийлсэн байдаг тухай судлаачид олонтоо дурдсан байдаг.

Түүгээр зогсохгүй 3-р сарын 1-ний тусгаар тогтнолын хөдөлгөөн⁸⁵, соёлыг түгээх эрмэлзэл, уламжлалаа сэргээхийн төлөөх тэмцэл гээд тухайн үеийн солонгосчуудын

⁸⁴ 汗/хан – гэдэг нь зөрчилдсөн сэтгэл, тэр зөрчил өөрөө аяндаа бий болж, ямар нэгэн шийдэл гаргах аргагүй болдог. Өөрөөр хэлбэл, шантарсан үед ч хувь тавилантайгаа эвлэрч, өөрийгөө буруутгаж бусдад гомдоллох үед үүсдэг гэдэг.

⁸⁵ Японы дарангуйллыг тэсвэрлэх аргагүйд хүрсэн Солонгосчууд 1919 оны 3 сарын 1 өдөр “Солонгос орон мандтугай” хэмээн бослого явуулж, Тусгаар тогтнолын хөдөлгөөн үүссэн түүхтэй юм. Хэдэн өдрийн турш томчууд, хүүхдүүд, оюутнууд бүгд гудамжинд гарч “Солонгос улсын тусгаар тогтнол мандтугай” гэж орилон жагсаал хийсэн ба үүнийг “Турван сарын нэгний өдрийн тусгаар тогтнолын хөдөлгөөн” хэмээн нэрлэжээ. Япончууд энэхүү хөдөлгөөнийг зэвсгээр зогсоохыг оролдсон ба олон мянган солонгосчууд тэр үеэр амиа алдаж, зарим нь шоронд хоригдож байжээ. Солонгосчууд энэхүү тусгаар тогтнолын хөдөлгөөнийг санан дурсахын тулд 3 сарын 1-ний өдрийг амралтын өдрөөр тогтоон, төрөл бүрийн үйл ажиллагаа зохион явуулсаар

мэдэрсэн сэтгэлийн болон бие махбод, эд материалын бүх зовлон зүдүүр сэтгэлийн шаналлыг шингээсэн байдаг.

“Хурц улаан цэцэг” анх 1922 онд “Гэбёг буюу шинэ ертөнц” гэдэг сэтгүүлийн 7-р сарын 25-р дугаарт хэвлэгдэн олны хүртээл болсон байна. Энэ үед солонгосын уран зохиол тэр дундаа яруу найрагт чөлөөт⁸⁶ болон үзэл суртлын гэсэн хандлага байв. /자유시와 경향시/ Ким Со Вөл бол уламжлалт хандлагыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан яруу найрагч юм. Тэр өөрийн багш Ким Ог-ийн нөлөөгөөр уламжлалт “ардын дууны” 민요시란 민요조의 음울을 가진 시 маягаар бичдэг байв. Тийм ч учраас энэ шүлэг солонгосын ард түмэнд хөгжмийн хэмнэл мэт уламжлалт шүлгийн хэмнэл ханхлуулж, нутаг усаа гэх дулаахан мэдрэмжийг мэдрүүлж чадсан билээ.

Ким Со Вөлийн “Хурц улаан цэцэг” шүлэг нь дараах онцлогуудыг хадгалсан гэж үздэг байна.

Ким Со Вөл “Хурц улаан цэцэг”	
Төрөл	Чөлөөт, уянгын
Шинж чанар	Уламжлалт, ардын дууны шүлэг, яруу уянгалаг, күнзийн суртлын үнэр үнэртсэн, хөдөө тосгоноо гэсэн сэтгэл
Хандлага	Күнзийн суртлын, хүмүүнлэг (эмэгтэй хүн дуулгавартай байх, эр нөхрийнхөө үгээр байх)
Гоо зүйн мэдрэмж	Гуниг гэдэг нь хэдий хэцүү ч эмэгтэй хүний “гуниглал”-харууслын гоо сайхныг гаргасан
Хэмнэл айзам	Ардын уламжлалт 7 болон 5 үет буюу гунигтай хэмнэлтэй, төгсгөл холбосон
Бүтэц	Толгой сүүл холбосон, 4 бадаг
Онцлог	<ol style="list-style-type: none"> 1. “Гуниг”-ийг уран яруугаар дүрсэлсэн 2. Ардын дууны уламжлалаар бичсэн 3. Хөдөө тосгоны амьдрал, аялгууг шингээсэн 4. Эмэгтэй хүний дуулгавартай байдлыг тухайн үеийн хүмүүс хүлээн зөвшөөрч байсныг уран яруугаар илэрхийлсэн

Харин “Сүнс дуудахуй” нь бүтцийг харвал дараах онцлогтой байна.

Ким Со Вөл “Сүнс дуудахуй”	
Төрөл	Чөлөөт, уянгын
Шинж чанар	Ардын дуу, гашуудалтай, мэдрэмжтэй, уламжлалт, уур хорсол
Хандлага	Сүнс дуудах, сүнс дуудахад нөлөөлдөг хүчтэй мэдрэмж
Гоо зүйн мэдрэмж	Гуниг гэдэг нь хэдий хэцүү ч эмэгтэй хүний “гуниглал”-харууслын гоо сайхныг гаргасан
Хэмнэл айзам/ өнгө аяс	3 өлмийт/ хүсэмжлэн хашхирах, шууд хашхирах, эмэгтэйлэг
Холбогдох домог	үлгэр Манбугсог буюу Чулуу болон мөнхөрсөн үлгэр, эртний зохиогч нь үл мэдэгдэх дуу “Чи сүл ён гуг”

байна. Мөн гудамж, гэртээ төрийн далбаагаа өлгөж “Гурван сарын нэгний баяр”-ыг тэмдэглэдэг байна.

⁸⁶ Чөлөөт гэдэг нь тухайн үеийн солонгосын “шижу” буюу богино дуу шиг үгийн тоо, мөрийн тоо тэнцүү хэлбэртэй бичдэг байснаас огт өөр чөлөөтэй бичих болсныг хэлж буй.

Бүтэц	Толгой сүүл холбосон, 4 бадаг
Онцлог	- 3 өлмий бүхий ардын дууны хэмнэлт (7 ба 5 үет) - Давталг, сэтгэл зүрхний гүнээс хайн хашхирах, сэтгэл хөдлөлийн шууд илэрхийлэл - Шүлгийг цуваа хэлбэрээр чөлөөтэй холбосон (2 ба 3-р бадгаас бусад) - Ардын үлгэр домгоос сэдэвлэсэн

Солонгосын яруу найргийн монгол орчуулга

“Хурц улаан цэцэг” шүлгийг 2005 онд Квон Сон Хүн багшийн орчуулсан орчуулга. Нэрээ орчуулахдаа “Хурц улаан цэцэг” (진달래꽃 杜鵑花) гэдэг үгийг Бээжинд хэвлэгдсэн “Таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг”-т 杜鵑花 буюу хурц улаан цэцэг гэж тэмдэглэснээр орчуулсан байна. Монгол хэлэнд ургамал амьтны нэрийг өөр улс орон хийгээд далай тэнгист байдаг ургамал амьтны нэрийг ч өвгөд дээдэс маань оноон өгсөн нь байдаг тул тус толинд гарсан “хурц улаан цэцэг” гэж оноон тэмдэглэсэн үгээр орчуулсан байна. Энэ нь бид монгол хэлний баялаг зөв тайлбарлан оноож өгсөн үгсийг өргөн дэлгэр түгээн тархахад орчуулгын хэлний оруулж буй бас нэгэн чухал асуудал гэж бодож байна. Цаашид орчуулагчид маань энэ мэт монгол хэлнээ аль эрт буулгаж оноон өгсөн нэршил, үг хэллэгийг олж орчуулах нь монгол хэлний уран тансаг байдлыг хадгалан уламжлуулж, амьд харилцаад оруулан хэрэглэхэд оруулах хувь нэмэр болох бөлгөө.

진달래 꽃

나 보기가 역겨워
가실 때에는
말없이 고이 보내 드리오리다

영변에 약산
진달래꽃
아름 따다 가실 길에 뿌리오리다

가시는 걸음 걸음
놓인 그 꽃을
사뿐히 즈려 밟고 가시옵소서

나 보기가 역겨워
가실 때에는
죽어도 아니 눈물 흘리오리다

Хурц улаан цэцэг (Квон Сон Хүн, 2005:5)

Намайг харахаас дургүй чинь хүрдэг болохоор

Нааш гэхгүй дуугай л явуулья
Йөнбөний Ягсан уулын хурц улаан цэцгээс
Тэвэр тэврээр аян замд чинь цацна.
Алхам алхамдаа тэр бутарсан цэцгийг
Аажим аажим гишгээд яваарай
Намайг харахаас дургүй чинь хүрдэг болохоор
Наана чинь яасан ч, би хамар шархираахгүй

2006 онд И Ан На “Солонгосын шилдэг тавин шүлэг” номынхоо эхэнд орчуулан хэвлэсэн байна. Тэрээр “Даль цэцэг” гэдэг нэрээр орчуулж өөр олон тайлбаргүй зөвхөн солонгос нэрийг галиглан “жиндаллай” гээд зүүлт болгон оруулсан байна.

Даль цэцэг (И Ан На, 2006:8)

Намайг хараад үзэн ядаж
Явахад тань
Дув дуугүйхэн явуулья аа

Ёнбён нутгийн Яг ууланд
Даль цэцгийг
Тэвэр тэврээр түүж явах замдаа цацалъя

Алхам тутамд
Тавигдсан тэрхүү цэцгийг
Аяар аяар гишгэн яваарай

Намайг хараад үзэн ядаж
Явахад тань
Үхсэн байлаа ч нулимс унагахгүй ээ

Б.Нармандах 2010 онд Ким Со Вөлийн шүлгийг орчуулан түүвэр болгон хэвлүүлсэн бөгөөд “Хурц улаан цэцэг” шүлгийг “Агарууны цэцэг” хэмээн орчуулж түүврийн эхэнд оруулсан байна. Чухам яагаад орчуулагч “агарууны цэцэг” хэмээн орчуулсан тусгай тайлбар байхгүй байгаа бөгөөд агарууны төрлийн мод гэвэл гол төлөв арцат ургамлыг хэлдэг байна. Үүнээс үзэхэд орчуулагч магадгүй андууран орчуулсан байх магадлалтай байна. Харин “гүүглэ” (google) хайлтаар солонгосоор “진달래꽃” хэмээн хайхад “азалия цэцэг”⁸⁷ буюу замбага цэцэг гэж гарч ирж байна.

Агарууны цэцэг (Б.Нармандах, 2010:7)

Намайг хараад

⁸⁷ <https://translate.google.com/?sl=ko&tl=mn&text=%EC%A7%84%EB%8B%AC%EB%9E%98%EA%BD%83&op=translate>

Нүүр буруулан явахад тань
Нэг ч үг хэлэлгүй үдэж өгье дөө
Ён голын эрэг, Яг уулын
Жиндальлэ (агарууны) цэцэгсийг
Тэвэр тэврээр
Явах замд тань
Яруухан дурсгал болгон дэвсэж өгье дөө
Алхам бүрд тааралдах тэрхүү цэцэг
Алгуур алгуур гишгэлэн яваарай
Намайг хараад
Нүүр буруулан явсан болохоор
Насан эцэслэсэн ч нулимс унагахгүй

Яруу найргийн /утга уянгын/ зохиол бүтээлийн орчуулга үргэлжилсэн үгийнхээс их ялгаатай. Зохиолын хэлний үгийг тодорхой хэмжээ журамд тохируулж жирийн ярианд байдгаас өөрөөр хэрэглэн хувааж нугалж нарийн эрэмбээр эгнүүлэн бичсэн зохиол туурвилыг шүлэглэсэн зохиол гэдэг. Шүлэг нь хүний сэтгэл хөдлөлийн өнгө аясыг тод илэрхийлэх зориулалттай тул бүтцийн хувьд айзам хэмжээ үүсгэдэг, толгой сүүл холболт, мөр, бадаг, өлмий зэрэгт хавчигдан үгийг чөлөөтэй хэрэглэх боломжоор хомс байдаг (Р.Гүрбазар, 1996:25) гэж үздэг. Үнэхээр ч энэ шүлгийн эх нь толгой сүүл холбож, солонгосын ардын дууны шүлгийн адил хэмнэл нь жигд, үгийн дуудлага нь зохиолчийн төрөлх нутгийн аялгуугаар бичсэн байдаг.

Эхний бадгийн 2-р мөрний сүүлийн хэсэг “말 없이 고이 보내 드리우리다”-г Квон Сон Хүн, И Ан На нар орчуулахдаа “...дуугай л / дуугүйхэн явуулъя /аа” гэсэн бол Б.Нармандах “... нэг ч үг хэлэлгүй үдэж өгье дөө” гэж орчуулсан байна.

Энэ мөрний эхний хэсэг “... дуугүй/нэг ч үг хэлэлгүй” гэдэг утга байгаа боловч сүүлийн хэсэг нь “... тэр хүн нь явж байгаа бус, явж ч магад, явуулъя/ явна гэвэл явуулж чадна даа/ явуулахаас өөр аргагүй” гэсэн утга буй юм. Тэрнээс яг явж байгаа учраас үдье явуулъя гэсэн шууд утгыг илэрхийлээгүй болно. “Шүлгийг орчуулах гэгч уг утгыг орчуулах төдий биш, түүний найруулгын хэв журам ба уран хэл, сэтгэлийг хөдөлгөх чадлыг бүрнээ орчуулах хэрэгтэй (Орчуулах эрдэм, 1972:86) гэж Ц.Дамдинсүрэн абугай бичсэн байдаг. Үнэхээр энэ шүлгийн хэлэх гэсэн гол чухал санааны нэг нь энэ мөрөөр илэрч байна. Тэр орхиод явах, бас түүний явуулах гээд буй “хэн гуай” түүний амраг хайрт ч байж болох талтай ч тухайн үеийн нийгмийн нөхцөл байдалтай уян холбож үзвэл “эх орон” гэсэн санаа байж ч болох юм.

Мөн уг шүлгийн хамгийн сүүлийн мөр “... 죽어도 아니 눈물 흘리우리다” гэдэг нь нэг талаасаа егөөдсөн утга гаргаж байна. Учир нь үгчлэн орчуулбал “үхсэн ч үгүй нулимс унагахгүй ээ” гэсэн утгатай байна. Ямар ч байсан өөрийнхөө үзэл санаа, шийдвэртээ бат зогсох нэг утга байгаа ч нөгөө талаас өөрөө хэцүү байдалд орсон учраас

яасан ч, хичээн хэцүү хүнд байсан ч тэр өөрт нь тулгараад буй үйлтэй санал нийлэхгүй дээ гэж хэлэхийн хамт өөртөө бас давхар хэлж өөрийгөө магадгүй зоригжуулж байх шиг.

Гурван орчуулагчийн орчуулсныг зэрэгцүүлэн харвал,

Квон Сон Хүн	Намайг харахаас дургүй чинь хүрдэг болохоор Наана чинь яасан ч, би хамар шархираахгүй
И Ан На	Намайг хараад үзэн ядаж Явахад тань Үхсэн байлаа ч нулимс унагахгүй ээ
Б.Нармандах	Нүүр буруулан явсан болохоор Насан эцэслэсэн ч нулимс унагахгүй

Эндээс харахад И Ан На орчуулахдаа шууд үгчлэн орчуулсан бол Б.Нармандахын орчуулгаас харахад өмнөх мөрөнд явчихсан болохоор түүнийг нас эцэслэсэн ч араас нь нулимс унагахгүй гэжээ. Б.Нармандахын орчуулгыг харвал энэ шүлгийн далд утга санааг сайн ойлгоогүй яруу найрагчийн шүлгийн арга барил, далд утга санаа илэрхийлдэг тэр агуулгыг гарган орчуулаагүй байна. Харин Квон Сон Хүн юу ч болж байсан нулимс ч унагахгүйгээс гадна “хамар шархираахгүй” гэж орчуулсан нь уншигч “Яагаад хамраа шархираахгүй гэж?” уг нь хүн хамраа шархираахгүй байж чадахгүй аяндаа сэтгэл уярам, эсвэл гунигтай зүйл тохиолдоход хамар хар аяндаа шархирдаг байхад “Яагаад?” гэж нэгийг бодож хоёрыг тунгаахаар зохиолчийн “уншигч – тухайн үеийн солонгосын ард түмэнд хандсан санаа” агуулгыг нь чадварлаг гаргасан байна.

Яруу найргийн орчуулгад чанарын болон тоон үзүүлэлт (Ц.Магсар, 2015:20-21) ээр дүгнэх нь буй. Мэдээж зөвхөн доорх хүснэгтээр эхийн орчуулгыг дүгнэх боломжгүй ч нэг ижил эх шүлгийг хэрхэн яаж орчуулсан болохыг зэрэгцүүлэн харж дүгнэх үүднээс хүснэгтлэн гол төлөөлөл үзүүлэлтээр харахыг хичээсэн болно. Гурван орчуулагчийн шүлгийн солонгос хэлнээс монгол хэл рүү хөрвүүлсэн байдлыг харахад:

	Үзүүлэлт	Квон Сон Хүн	И Ан На	Б.Нармандах
Тоон үзүүлэлт	Үгийн тоо анхдагч эхтэйгээ таарч буй эсэх	34	40	47
	Орчуулагчаас аль хэр нэмсэн буюу гэсэн	Нэмж гээгээгүй	Нэмж гээгээгүй	Нэмсэн
	Үг орчуулгадаа хэл зүйн хэлбэрээ хадгалж чадсан эсэх	Чадсан	Чадсан	Зарим хэлзүйн хэлбэр, үг нэмсэн
	Шүлгийн үеийн тоо болон шүлгийн өргөлтийн шинжийг хадгалсан эсэх	Эхийн болон монгол шүлгийн шинжийг хадгалсан	Хадгалан орчуулсан	Эхийн өргөлтийн шинжийг эвдсэн
Чанарын	Шүлгийн гоо зүй алдагдсан эсэх (хэмжээ, хэмнэл, бүтэц, найруулга)	Эхийн хэмнэлийг хадгалахын хамт монгол шүлгийн хэмнэл, бүтэцтэй	Эхийн утгыг буулгахдаа монгол шүлгийн бүтэц, хэмнэлтэй	Эхийн хэмнэлийг монгол болгон орчуулсан
	Утга эндүүрсэн эсэх	Байхгүй	Байхгүй	Байна

Үгийн утгын өнгө эхэд байгаатай нийцүү болж чадсан эсэх	Эхтэй, монгол шүлгийн аястай нийцсэн	Эхтэй нийцсэн	Эхээс нь өөр монголжуу болгосон
Яруу найргийн хэлээр орчуулагдсан эсэх	Тийм	Тийм	Тийм
Дүрслэн илэрхийлсэн байдал нь оновчтой, анхдагч эхдээ нийцтэй болсон эсэх	Анхдагч эхийн далд утгыг ч илэрхийлсэн	Анхдагч эхтэй адил	Өөрчилсөн, утгад өөрчлөлт орсон
Өгүүлбэрийн байгууламж, мөр, шад, бадгийн логик алдагдсан эсэх	Үгүй	Үгүй	Өөрчлөгдсөн
Орчуулагчаас субъектив зүйл нэмсэн эсэх	Үгүй	Үгүй	Нэмсэн

Гурван орчуулагч гурвуулаа яруу найргийн хэлээр уран яруу орчуулсан бөгөөд Квон Сон Хүн, И Ан На нар үгийн тоог эхтэй харьцангуй ойролцоо барьж орчуулсан байна. Харин Б.Нармандах орчуулахдаа эхэд байхгүй үгийг нэмж орчуулсан ба үгийн тоо нь эхийн үгийн тооноос их байгааг харж болно. Утга эндүүрэн орчуулсан гэхээр зүйл Б.Нармандахын орчуулгаас хэд хэдэн зүйл ажиглагдаж байна. Тухайлбал, уг шүлэгт явах гээд буй хүнийг явсан утгаар бичээгүй байхад явсан учраас “үдсэн” гэж, Ёнбён гэдэг газрын нэрийг Ён гол болгон ташаа орчуулсан байна. Шүлгийн 4 бадгийг агуулгыг нь анхааран орчуулах нь зүйтэй юм. Гэтэл Б.Нармандах нь бадгийн заагийг сайн гаргалгүй үргэлжлүүлэн орчуулсан байдал ажиглагдаж байна. Харин И. Ан На яг эхтэй адил 12 мөрөөр орчуулсан бол Квон Сон Хүн 9 мөр боловч эх шүлгийн яруу найрагчийн гаргаж хэлэх гэж буй агуулгаас гадна далд ёгт утгыг ч сайн гаргаж оруулсан байна. Дорно дахины шүлгээс ялгардаг монгол шүлгийн толгой холбоц аргыг хэрэглэсэн нь шүлгийг илүү яруу сайхан болгон монгол хэлэнд нутагшуулан орчуулсан байна.

Ким Со Вөл яруу найрагчийн өөр нэг алдартай “Сүнс дуудахуй” (초혼/招魂) шүлэг анх 1925 онд хэвлэгдсэн “Хурц улаан цэцэг” түүвэрт анх хэвлэгдсэн байна. Энэхүү шүлэг нь Ким Со Вөлийн яруу найргийн онцлог, түүний ертөнцийг үзэх үзлийг харж болох бичсэн цаг үе нь тодорхойгүй шүлгийн нэг билээ.

Шүлгийн гол агуулгыг судлаачид өгүүлэгч хайртай хүнээсээ хагацаад түүнийгээ үгүйлэн шаналж, түүний хойноос гашуудан гаслан орь дуу тавин хашхиран уйлавч хайртай хүн нь эргэж ирэхгүй одсон байдаг. Ийнхүү санагалзан тэмүүлэх сэтгэл нь хайраа хүлээн зөвшөөрч чадаагүйнхээ төлөө гэмших гэмшлийн улмаас улам илүү харамсах мэдрэмжээр насан эцэслэсэн түүнийхээ төлөө “сүнс дуудаж/초혼⁸⁸” буй тухай гардаг.

⁸⁸ Хүн нас барахад сүнсийг нь дууддаг. Дээвэр дээр гаран талийгаачийн өмсөж байсан хүрмийг зүүн гартаа барьж, баруун гараа бэлхүүс дээрээ тавин хойд зүгт хараад “Аль нэг тосгоны хэн ээ” хэмээн гурвантаа дуудах ёс.

Ким Со Вэлийн шүлгийн хэмнэл гол төлөв 7 болон 5 үет 3 өлмийт байдаг бол “Сүнс дуудахуй” шүлэг нь 3 ба 2 өлмийт арай өөр хэмнэлтэй бичигдсэн болохыг харж болно.

초혼 (진달래꽃, 1924)

산산이 부서진 이름이여!
허공(虛空) 중에 헤어진 이름이여!
불러도 주인 없는 이름이여!
부르다가 내가 죽을 이름이여!

심중(心中)에 남아 있는 말 한마디는
끝끝내 마저 하지 못하였구나.
사랑하던 그 사람이여!
사랑하던 그 사람이여!

붉은 해는 서산(西山) 마루에 걸리었다.
사슴이의 무리도 슬피 운다.
떨어져 나가 앉은 산 위에서
나는 그대의 이름을 부르노라.

설움에 곱도록 부르노라.
설움에 곱도록 부르노라.
부르는 소리는 비껴 가지만
하늘과 땅 사이가 너무 넓구나.

선 채로 이 자리에 돌이 되어도
부르다가 내가 죽을 이름이여!
사랑하던 그 사람이여!
사랑하던 그 사람이여!

Сүнс дуудахуй

Замхран алсалсан хүний нэр
Замлинд сарнисан чиний нэр
Хашхиран дуудсан ч хариугүй нэр
Хашхируулсаар намайг элээх нэр
Сэтгэл чилээсэн ганц үгээ
Сэрхийтэл хэлж чадсангүй
Хайрын шүтээн минь
Хан тэнгэр минь

Улбар наран уулын хормойг гийгүүлж

Уянгалаг гунигаар буга урамдана

Алслах тэр уулын хэцээс

Амрагийнхаа нэрийг би дуудна

Гунигтаа живж дуудна

Гунигтаа хөтлүүлж дуудна

Дуудах дуу минь цуурайтавч

Дээд тэнгэр газраас алс юм

Харж мөрөөдсөөр чулуу болсон ч

Хэлүүлсээр намайг элээх нэр

Хайрын шүтээн минь!

Хан тэнгэр минь!

Сүнс дуудахуй

Тархаж бутарсан нэр чинь ээ!

Хоосон агаарч замхарсан нэр чинь ээ!

Дуудсан ч гэсэн эзэн үгүй нэр чинь ээ!

Дуустлаа дуудах нэр чинь ээ!

Сэтгэл зүрхэн дэх нэг л үгээ

Эцсээ хүртэл бүгдийг нь хэлсэнгүй юмаа

Хайрлаж байсан тэр хүн ээ!

Харлаж байсан тэр хүн ээ!

Баруун уулын оройд суух улбар наранд

Бугын сүрэг ч гуниглан уйлдаг юм

Бусдаас тасархай сууж байгаа уулан дээрээс

Таны нэрийг дуудна аа, би

Гунигаа барьж дийлэхгүй тэр чинээгээр дуудна даа, чамайгаа

Гашуудлаа барьж дийлэхгүй тэр чинээгээр дуудна аа, чамайгаа

Дуудах чимээг чиглэн зүглэн явавч

Тэнгэр газар хоёр хоорондоо дэндүү хол байдаг л даа

Зогссон хэвээрээ энэ газарт чулуу болох гэлээ ч

Дуустлаа дуудах нэр чинь ээ!

Хайрлаж байсан тэр хүн ээ!

Харлаж байсан тэр хүн ээ!

Гуйлт

Өөрөө уул шиг байж хугалсан нэр шүү

Өргөн орчлонгийн хоосонд хөвсөн нэр шүү

Дуулим хорвоод дуудуулах эзэнгүй нэр шүү

Дурлалд учирсан би л дуустлаа дурсах нэр шүү
Сэтгэлд үлдсэн нэг л үгийг чинь
Шимширч сэмэрсэн ч хэлж чадахгүй нь
Хайрын минь тэнгэр та юм шүү
Хайрын минь тэнгэр та юм шүү
Бусдын юм шиг улаан наран
Баруун уулын цаагуур шингэлээ
Бугын сүрэг миний гунигийг хувааж
Буцаж ирэхгүйгээр уйтай урамдана
Тэрхэн зуур уулын гэртээх цуурай
Танхилхан миний сэтгэлийг хуваалцах шиг болно
Аяа, би шившин шившин дуудавч
Ая дуу минь хүрэхгүй л байна уу даа
Тэгэлгүй яах вэ дээ
Тэнгэр газар зайтайнх шүү
Зогссон чигээрээ чулуу болсон ч
Цуцгалаа дуудах нэр юм шүү
Хайрын минь тэнгэр та юм шүү
Хайрын минь тэнгэр та юм шүү

Шүлгийн эхний бадгийг орчуулсныг харвал Квон Сон Хүн, И Ан На нар шүлгийн хайртай хүнээ үгүй болсныг мэдэрч түүний хойноос гашуудан шаналж буй утгыг нь шингээж чадсан. Нас барсан учраас “замхарсан, замхран үгүй болох” гэсэн утгатай үгийг зөв орчуулж, зохиолчийн хэдий нэрийг нь дуудавч хий хоосон хэн ч хариу өгөхгүй дуудсан нэр нь “замхран” алга болж буйг илэрхийлж чадсан. Харин Б.Нармандахын орчуулгаас дээр дурдсан “замхрах” гэдэг утга байхгүй, нэрийн тухай мэт эндүү ташаа буулгасан байна.

Хоёрдугаар бадгийн хувьд хайраа илчлэн, хүлээн зөвшөөрч, хэлж чадаагүйдээ харамссан сэтгэлийг И Ан На “...Сэтгэл зүрхэн дэх нэг л үгээ

Эцсээ хүртэл бүгдийг нь хэлсэнгүй юмаа...” гэж орчуулсан

бол Квон Сон Хүн “...Сэтгэл чилээсэн ганц үгээ

Сэрхийтэл хэлж чадсангүй...” хэмээн орчуулсан байна. Яахын аргагүй

хэлэхийг хүссэн үгээ хэлж чадаагүйг харуулан орчуулсан байна. Б.Нармандахын хувьд арай өөр маягаар “...хэлж чадахгүй нь” гэж орчуулжээ. Уг шүлэгт хайртай хүн нь аль хэдийнээ энэ ертөнцийн хүн биш болсон тухай гарч байхад Б.Нармандах амьд буй хүнд хэлж чадахгүй байгаа мэт буулгасан байна.

Гуравдугаар бадгийн агуулга нь уулын оройд тусах нарны тухай хэдий ч өдөр шөнө, энэ ертөнц ба нөгөө ертөнц, амьдрал ба үхлийн зааг, бугаар ер бусын амьд амьтныг

өрөвдөх сэтгэлийг илэрхийлсэн гэж судлаачид үздэг. Хүн ийм нөхцөл байдалтай үхэлтэй нүүр тулахдаа хичээн арчаагүйгээ мэдэрч, амьдрал утга учиргүй мэт санагддаг гэдгийг илэрхийлэхийг хүссэн аж. Тэр заагийг Квон Сон Хүн:

“Алслах тэр уулын хэцээс

Амрагийнхаа нэрийг би дуудна...” гэсэн бол И Анна:

Бусдаас тасархай сууж байгаа уулан дээрээс

Таны нэрийг дуудна аа, би...” гэж эхийн далд утга санааг боломжийн хэлбэрээр орчуулсан байдаг. Б.Нармандах огт өөр утгаар орчуулаад зогсохгүй нэг мөрийн утгыг огт өөр утгаар орчуулсан байна.

Дөрөвдүгээр бадгийн энэ ертөнц болон хойд ертөнцийн хоорондын зай гээд гурвуулаа тэнгэр газрын хоорондын зай хол гэдэг санааг гаргаж чадсан байна.

Сүүлийн бадагт солонгос ардын үлгэр болох “хайртай хүнээ алдаад дэргэд нь уйлж гашуудсаар чулуу болдог тухай үлгэрийн үзэл санаанд үндэслэн бичсэн гэдэг. Энэ бадгийг Квон Сон Хүн: Харж мөрөөдсөөр чулуу болсон ч, И Ан На: Зогссон хэвээрээ энэ газарт чулуу болох гэлээ ч гэж үлгэрийн утга санаатай дүйцүүлэн орчуулсан байна. Харин Б.Нармандах: Зогссон чигээрээ чулуу болсон ч гэж мөн л утга дүйцүүлэн орчуулж, төгсгөлийн давталтаар төгсгөсөн байна. Эндээс харахад үлгэрийн утга агуулгыг хамгийн оновчтой тусган орчуулсан орчуулга Квон Сон Хүний орчуулга байна. Хайртай хүнээ харж хүлээсээр чулуу болдог тухай тэр үлгэрт гардаг.

Шүлгийн орчуулгад хийсэн тоон ба чанарын үзүүлэлтийг дараах хүснэгтээс харж болно.

	Үзүүлэлт	Квон Сон Хүн	И Ан На	Б.Нармандах
Тоон үзүүлэлт	Үгийн тоо анхдагч эхтэйгээ таарч буй эсэх	70	95	97
	Орчуулагчаас аль хэр нэмсэн буюу гээсэн	Нэмж гээгээгүй	Нэмж гээгээгүй	Нэмсэн
	Үг орчуулгадаа хэл зүйн хэлбэрээ хадгалж чадсан эсэх	Чадсан	Чадсан	Зарим хэлзүйн хэлбэр, үг нэмсэн
	Шүлгийн үеийн тоо болон шүлгийн өргөлтийн шинжийг хадгалсан эсэх	Эхийн болон монгол шүлгийн шинжийг хадгалсан	Хадгалан орчуулсан	Эхийн өргөлтийн шинжийг эвдсэн
Чанарын үзүүлэлт	Шүлгийн гоо зүй алдагдсан эсэх (хэмжээ, хэмнэл, бүтэц, найруулга)	Эхийн хэмнэлийг хадгалахын хамт монгол шүлгийн хэмнэл, бүтэцтэй	Эхийн утгыг шууд буулгасан, монгол шүлгийн бүтэц, хэмнэлтэй	Эхийн хэмнэлийг монгол болгон орчуулсан
	Утга эндүүрсэн эсэх	Байхгүй	Байхгүй	Байна

Үгийн утгын өнгө эхэд байгаатай нийцүү болж чадсан эсэх	Эхтэй, монгол шүлгийн аястай нийцсэн	Эхтэй нийцсэн	Эхээс нь өөр монголжуу болгосон
Яруу найргийн хэлээр орчуулагдсан эсэх	Тийм	Тийм	Тийм
Дүрслэн илэрхийлсэн байдал нь оновчтой, анхдагч эхдээ нийцтэй болсон эсэх	Анхдагч эхийн далд утгыг ч илэрхийлсэн	Анхдагч эхтэй яг адил	Өөрчилсөн, утгад өөрчлөлт орсон
Өгүүлбэрийн байгууламж, мөр, шад, бадгийн логик алдагдсан эсэх	Үгүй	Үгүй	Өөрчлөгдсөн
Орчуулагчаас субъектив зүйл нэмсэн эсэх	Үгүй	Үгүй	Нэмсэн

Шүлгийн эх 69 үгтэй бол тоонд хамгийн дөхүү орчуулгыг Квон Сон Хүн хийсэн байна. Квон Сон Хүн, И Ан На нар шүлгийг орчуулахдаа эхийн бүтэц хэмнэл зэргийг бараг эвдэлгүй орчуулсан байна. Мөн шүлгийн хагацан салсан хайртай хүндээ хандан сэтгэл нь догдлон хичээн хашхиран дуудавч хариу үгүйг, өөрийн сэтгэлийн үгээ нээж чадалгүй явуулсандаа харамсан бухимдаж буйг гаргаж чадсан байна. Түүнчлэн тухайн үеийн солонгосын шүлэг яруу найрагт далд хадгалагддаг “хайртай хүн” нь хүн байж болох ч тусгаар тогтнолоо алдан Японы эрхшээлд орсон эх орныхоо байдлын хэцүүг энэ ертөнц, нөгөө ертөнцөөр зүйрлүүлээд ард иргэдийн эрх чөлөөтэй болохыг мөрөөсөн хашхирах дуун гэж ч төлөөлүүлсэн байж болох тэр утгыг тодорхой хэмжээгээр гаргаж чадсан байна. Жишээлбэл: Бугын сүрэг ч гуниглан уйлдаг юм гэж И Ан На орчуулсан байхад Квон Сон Хүн Уянгалаг гунигаар буга урамдана гэсэн байна. Гуниглан уйлж, уянгалаг гунигаар урамдаж буй буга гэж зохиолчийн уран сайхны хэтрүүлгээр эрх чөлөөгөө алдсан ард түмнийхээ зовлон гунигийг хэлснийг монгол хэлээр орчуулахдаа мөн яг тэр аясаар уран яруу хэтрүүлэгтэй орчуулсан байна. Б.Нармандах Бугын сүрэг миний гунигийг хувааж гэж энгийн хайртай хүнээсээ хагацсан хүний сэтгэлийн зовлонгоос хуваалцан нимгэлж буй гэж ойлгогдохоор энгийнээр орчуулсан байна.

Мэдээж дээрх хэдхэн үзүүлэлтээр тэдний орчуулгыг дүгнэж харахад учир дутагдалтай. Гэсэн хэдий Ким Со Вөлийн шүлэг яруу найргийн тухайн үеийн нийгэмд ард иргэддээ нөлөөлж байсан гол чухал агуулгыг шингээн хэл, соёл, сэтгэлгээг хэрхэн буулгасан болохыг зэрэгцүүлэн харахыг хичээлээ. Квон Сон Хүн болон И Ан На нарын хувьд өөрийн эх хэлнээс монгол хэлэнд буулгаж буй тул агуулга, шүлгийн бүтэц, зохиолчийн хэлж дамжуулахыг хүссэн агуулгыг маш сайн ойлгон монгол хэлэнд хөрвүүлсэн нь харагдаж байна. Б.Нармандахын хувьд шүлгийн хувьд хэлбэр нь яруу үг нь буй боловч эх шүлгийн мөн чанар, гол агуулгыг ухан ойлгоогүй, судлаагүй, газар нутгийн нэрийг андуу ташаа орчуулах гэх зэрэг орчуулагчийн хувьд гаргаж боломгүй алдаатай орчуулгыг хийсэн байна.

Ким Со Вөлийн “Сүнс дуудахуй” шүлэг бол тухайн үеийн төдийгүй ямар ч цаг үед амьдран уншигдах увдистай шүлэг гэлтэй. Монголчуудын хувьд сүнс дуудах гэдэг нь

амьд хүний л сүнсийг дуудах ойлголт байдаг бол солонгосчуудын хувьд сүнс дуудах нь насан эцэслэсэн хүний сүнсийг л дууддаг гэдэг хоёр өөр ойлголт буйг анхааруулахгүй орхих аргагүй.

Төгсгөлийн оронд

Ким Со Вөл шүлгээрээ дамжуулан: “Уншигчид” гэж буй нь – “бид” тухайн нийгэмд тэр цаг үед амьдарч буй хүмүүс,

“Хагацан салсан хайртай хүн” нь – Эрх чөлөө тусгаар тогтнолоо алдсан эх орон нь,

“Цаг үе/тэгэх үед” – “Япончууд” байж болох юм, учир нь тухайн үед японы дарлалд ороод удаагүй байсан үеийн нөхцөл байдалд ард түмэндээ илгээсэн шүлэг гэдэг.

Тийм учраас бид шүлэг, яруу найргийг орчуулахдаа “... хэлбэрийг биш, агуулгыг эрхэмлэх нь хамгийн чухал(Р.Гүрбазар, 1996:34)” билээ. Орчуулга хийхэд анхны суурь судалгаа буюу хэн гэдэг ямар үзэл бодолтой хүний хэзээ, хаана, юуны тухай бичсэн зохиол болохыг судлах шаардлагатай. Мөн тухайн эх зохиолын өөрийн орны ард түмний дунд ямар байр суурь эзэлдгээр барахгүй тухайн орны судлаач, шүүмжлэгчдийн байр суурь, судалгааг сайтар нягтлан судалж гэмээ нь өөрийн эх хэлэндээ буулгавал зохилтой. Ингэж судалгаа хийн орчуулахын үр дүн нь тухай орны сэтгэлгээний онцлог, зохиолчийн ертөнцийг үзэх үзэл, агуулга, түүх соёлтой холбоотой, доод сэтгэлийн нарийн мэдрэмж гээд зохиол бүтээлдээ шингээсэн яруу тансаг, гайхамшигтай, гунигтай, хүсэл мөрөөдөл зэргийг бодолцон хөрвүүлэх хэрэгтэй. Ингэснээр уншигч улсын ард түмэн тэр орны тухай ойлгож мэдэх боломжтой болно.

Квон Сон Хүн орчуулахдаа монгол шүлгийн хэлбэрт оруулсан ч эхийн цаад далд утга, эргэлзээ, зөрчил, егөөдөл зэргийг чадварлаг хадгалж, уламжлалт монгол шүлгийн аргаар толгой холбоц хэрэглэсэн байна.

И Ан На-гийн орчуулга нь эх шүлгийн хэлбэр, хэмнэлийг тэр чигээр нь хадаж орчуулахын хамт монгол шүлгийн хэлбэрт оруулан орчуулсан байна.

Б.Нармандахын орчуулга нь эх шүлгийг солонгос хэлээр уншаагүй хүнд бол ямар нэгэн далд утга санаагүй, зүгээр нэг энгийн шүлэг гэж бодогдохоор ажээ. Харин солонгос хэлээр уншиж байсан, зохиолчийн тухай мэдэх хүнд арай өөр утга агуулгатай өөр шинэ шүлэг мэт харагдаж магадгүй юм.

Ким Со Вөлийн “Хурц улаан цэцэг” шүлгийн:

- Хүний эрхэнд байхын хэцүү хүнд зовлон, гуниг, эмэгтэй хүний энхрий ялдам зөөлөн “гуниглал”-ийн нэг тийм гэж хэлэхийн аргагүй гоо сайхан мэдрэмжийн үнэр,
- Солонгос эмэгтэй хүний эр хүний эрхшээлд байх болон үгүйлэн санах “гуниглал” хэцүүхэн боловч далд утгаараа өөрт нь тэр нь таатайг дорнын ард түмний “зовсны эцэст жаргана” гэдэгтэй агаар нэг утгатай болохыг орчуулагч

бүр гаргаж чадсан эсэхийг дэнслэн “амтлан таалах” боломжийг уншигчид үлдээх нь зүйтэй болов уу.

Уншигч бүр өөр өөрийн мэдрэмжээр зохиол бүтээлийн яруу сайхныг мэдэрдэг тул Ким Со Вөлийн “Хурц улаан цэцэг”, “Сүнс дуудахуй” шүлгийн гурван орчуулгыг мэргэн уншигчид эцсийн дүгнэлт, шүүмжийг хийх буй за.

Эцэст дурдахгүй өнгөрч болохгүй нэг зүйл бол Ким Со Вөл “Хурц улаан цэцэг” шүлгээ ардын дууны шүлгийн арга барилаар бичсэн учраас цаанаа нэг сонсголонтой хэмнэлтэй учраас нийтийн дуу болоод зогсоогүй рок дуу болсон байдаг. БНСУ-ын рок дуучин Ким Ён Сүг буюу Маяа 2003 онд дуулсан байдаг. Хэдий рок дуу ч гэлээ шүлгийн яруу тансаг хэмнэл нь чихэнд дэндүү сайхан сонсголонтой сонстох нь гайхан биширмээр.

Номзүй

1. М.Амаргайван. “Нэгэн шүлгийн дөрвөн орчуулгыг шүүн тунгаахад”, МУИС, “Орчуулгазүй”, №04 (422), УБ., 2015
2. Р.Гүрбазар. “Орчуулгын онол, дадлагын үндэс”, УБ., 1996
3. Б.Дулмаа. “Монголын уран зохиолыг солонгос хэлээр орчуулсан тойм”, “Солонгос судлал 2” сэтгүүл, УБ., 2009
4. И Ан На. “Солонгосын шилдэг тавин шүлэг”, УБ., 2006
5. Квон Сон Хүн. “Солонгосын орчин цагийн шүлэг(тэргүүн дэвтэр)”, 2005
6. Ц.Магсар. “Яруу найргийн орчуулгын уран чанарын тухайд”, МУИС, Орчуулгазүй, №04 (422), УБ., 2015
7. Н.Мэнд. “Монгол хэлээр орчуулсан Солонгосын уран зохиолын тойм”, “Солонгос судлал 2” сэтгүүл, УБ., 2005
8. Б. Нармандах. “Ким Су Воль Агарууны цэцэг шүлгийн түүвэр”, УБ., 2010
9. “Орчуулах эрдэм”, УБ., 1972
10. “Таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг”, Бээжин., 1957
11. 김소월. “시집 진달래 꽃”, 2020
12. 류근조, 한국 현대시의 은유구조, 1999
13. “김소월을 읽는다”, 2020
14. <https://translate.google.com/>

"СУБАШИД"-ЫН ТАЙЛБАРЫН ЧОЙЖАМЦЫН ОРЧУУЛГА

О. Дэмчигмаа⁸⁹

***Abstract:** As far as we know, four works explained the meaning of the crucial poem of the Subhashita by stories in Tibetan and two in Mongolian. Here, we compared the two different scriptures of Tibetan commentaries' translation by Chojiamts and tried to clarify not only the similarities and differences in the content, structure, and peculiarities of the original recording but also aimed to make predictions about the sources, in which period was the source, translators and initiator related, by looking for other sources based on the relevant information.*

For text A, the complete poem was translated with its devotional section and explained briefly, except for 50 stories, and the translator added the devotional and ending poems, written alliterated. Text B consists of 50 stanzas, their explanation stories, and epilogue, without the devotional poem.

It is likely that the translator of text B is Chojiamts, great-grandson of Altan khaan and participated in the translation of the Ganjuur, initiator is Mergen Daichin Taij, who also participated in the translation of the Ganjuur.

***Түлхүүр үг:** субашидын тайлбар, Чойжамцын орчуулга, тайлбарын орчуулга, сургаалын зохиол, орчуулгын эх*

Удиртгал

Товч нэрээр "Субашид" хэмээх 457 бадаг бүхий сургаалын шүлгийг одоогоос 800 гаруй жилийн тэртээ XIII зууны эхний хагаст Төвөдийн Сажан бандида Гунгаажалцан зохиожээ. Зохиосон цаг хугацаагаа төгсгөлийн үгэндээ тодорхой тэмдэглээгүй боловч "...Цогт Сажан-гийн хийдэд найруулав" хэмээн тэмдэглэсэнд үндэслэн 1244 оноос өмнө зохиосныг мэдэж болох юм. Учир юун хэмээвээс, тэр бээр Годан ноёны заллагаар монгол

⁸⁹ МУИС, ШУС, Монгол хэл хэл шинжлэлийн тэнхим, дэд профессор

нутагт морилж, 1244 оноос хойш Сажа хийддээ буцалгүй насан эцэслэтлээ монгол газар сууж байсан билээ.

"Субашид"-ын үндсэн эх шүлгийг үе үеийн монгол мэргэд эх хэл аялгуунаа орчуулан олны хүртээл болгосоор ирсэн. Тухайлбал, XIY зууны үеийн тарнич тойн Сономгара-гийн орчуулга одоо мэдэгдэж буйгаар хамгийн эртнийхэд тооцогдож буй. Түүний дараа ХҮI зууны үед Ойрадын Зая бандида Намхайжамц тод үсгээр, ХҮII-ХҮIII зууны үед Сөнөд хошууны хэлмэрч эрдэмтэн Данзанчойдор, ХҮIII зууны үед Урад хошууны Мэргэн гэгээн хэмээн алдаршсан Лувсандамбийжалцан, Цахар гэвш Лувсанчүлтэм нар орчуулснаас гадна, XIX зууны үед Буриадын эрдэмтэн Дана-гийн гэгээн буюу Төгөлдөрийн Галсанжинба Мэргэн гэгээний орчуулгыг хянан найруулсан (1889) бөгөөд мөн XIX зууны сүүлээр Буриадын эрдэмтэн Номтын Ринчэн буюу Сумадираднаа мөн хоёр удаа орчуулжээ.

"Субашид"-ад тайлбар зохиосон талаар: Аливаа зохиолын далд ёгт утга, хэцүү бэрх оньсыг тайлбарласан зохиол туурвих явдал эртний уламжлалтай бөгөөд "Субашид"-ад мөн үндсэн эх шүлгийн утга санааг хялбар дөхөм ойлгомжтой болгох үүднээс элдэв үлгэрээр жишээлэн чимж тайлбарласан зохиолууд төвөд, монгол хэлээр хэд хэд бий.

1. Төвөд тайлбарууд:

1. "Субашид"-ын анхны судалгаа гэж хэлж болох тайлбар Сажа бандидыг сэрүүн ахуй үед гарч байсан мэдээ байдаг. Анхны тайлбарыг Ринчэнбал хэмээгч хүн XIII зууны үед төвөд хэлээр зохиожээ. Сайн номлол эрдэнийн сангийн тайлбар нэртэй (1977:354). (Legs par bshad pa rin po che'i gter gyi 'grel pa)
2. Төвөд хэлээр бичсэн нэг тайлбар Лхас болон Монголын Их хүрээнд 19 дүгээр зууны үед модон бараар хэвлэгджээ. Түүний төгсгөлд Мардон Чойжал зассан тухай өгүүлсэн бөгөөд Сажа бандида Гунгаажалцаны дотны шавь тэрбээр Ринчэнбалын тайлбарыг найруулан засаж Сажа бандидыг сэрүүн ахуйд нь үзүүлж байсан хэмээн тэмдэглэсэн байна. Энэ нь *Сайтар номлосон эрдэнийн сан нэрт шастирын гол судар ба үлгэр тайлбар сэлт*⁹⁰ (legs par bshad pa rin po che'ш gter zhes bya ba'i bstan bcos 'grel pa dang bcas pa) нэртэй хоёр дахь төвөд тайлбар болно.

Дээрх мэдээнд үндэслэвэл 1251 оноос өмнө "Субашид"-ын хоёр ч тайлбар зохиогджээ гэж үзэж болно.

3-4. Эдгээрээс гадна мөн хоёр зүйлийн төвөд тайлбарыг олж үзсэн тухайгаа академич Ц.Дамдинсүрэн "...Цүлтэмбалын зохиосон нэг бичмэл тайлбар Улаанбаатарын Гандан хийдийн номын санд байна. Нөгөө нь Пагва ламын зохиолгосон бололтой "Цэцгийн эрх" гэдэг төвөд ном болно" (1990:18) гэж тэмдэглэжээ.

5. Төвөдийн тойн Содном бээр Ринчэнбалын тайлбарт үндэслэн "*Сайн номлолт эрдэнийн сан хэмээх шастирын тайлбар хэрэгтэй хүссэн бүхэн гарахуй*" нэртэй,

⁹⁰ Legs par bshad pa rin po'i gter gyi 'grel pa bzhugs so. 46 хуудас. Хувийн цуглуулгад буй.

дэлгэрэнгүй тайлбарыг зохиожээ. Төгсгөлийн үгэндээ "...Замбутивийн огоот мэргэдийн оройн чимэг цаст Төвдийн шажны эзэн Сажа бандида Гунгаажалцан сайн цогт бээр зохиосон Сайтар номлол Эрдэнийн сан хэмээх их шастирын тийн номлол Хэрэгтэй хүссэн бүхэн гарахуй хэмээх үүнийг тэрхүү богдын номыг дагаж, сүжгийг олсон Содном нэрт бээр тойн Ринчэнбал хэмээгчийн үлгэрлэж, бүдүүн тоймыг сайтар ялган үйлдсэнийг уг суурь болгож, бас бус зарим тайлбараас үлгэр цадиг нэмж гүйцээгээд Цогт төгөлдөр Норовчойнэл хийдэд гал морин жилийн хоёрдугаар сарын шинийн найманд сайтар бүтээж үйлдэв" (1995а) гэж бичсэн байна.

2. Монгол тайлбарууд:

Монголын эрдэмтэн лам нар "Субашид"-д тайлбар зохиол бичсэнийг дурдвал Цахар гэвш Лувсанчүлтэм, Буриадын Лувсанринчэн нар төвөд тайлбаруудыг нэмэн дэлгэрүүлж, эх хэлээрээ зохион бараар хэвлүүлжээ. "Сайн номлолт Эрдэнийн сан "Субашид"-ын тайлбар чандманийн түлхүүр" гэдэг тайлбарыг Цахар гэвш 1778-1779 оны үед зохиосон ажээ. Нөгөө нь Буриадын Номтын Ринчэн (1820-1907)-ий бичсэн "Сайн номлолт Эрдэнийн сан "Субашид"-ын тайлбар сангийн үүдийг нээгч Чандманийн түлхүүр" болно.

3. Тайлбаруудын орчуулгын талаар:

Ринчэнбалын тайлбарыг Ойрадын зая бандида Намхайжамцын шавь Тарсан ХҮП зууны үед орчуулсан нь тод үсгээр байдаг (1977:354) бөгөөд бас нэг монгол орчуулгыг ХҮП зууны орчим Тайгун Таюн шикү гүүш хийжээ.(1961:2; 1995b:90)

Мардон Чойжалын тайлбарыг ХҮП зууны орчим Мэргэн Дайчины дуртгасан ёсоор Чойжамц орчуулжээ. Энэ орчуулга Чойжилсүрэн багшид бий. Бас нэг хувь Дамдинсүрэнд бий. Ленинградын их сургуулийн дорно дахины факультетын номын санд бас нэг дутуу хувь бий (1977:354).

Мөн сүүлийн хуудас нь навтарч урагдсан тул орчуулагчийн нэр тодорхойгүй нэгэн сонирхолтой гар бичмэл орчуулга буй бөгөөд хэлний онцлогийг ажиглахад нэлээд эрт үед хамаарна.

Ингээд үзвэл эдүгээ миний мэдэж буйгаар дөрвөн монгол орчуулга, хоёр монгол тайлбар лавтай байна. "Субашид"-ын тайлбар болон орчуулгууд нь тухай тухайн цаг үеийнхээ нийгэм соёл, хэлний онцлогийг тусгасан, судалгааны ач холбогдол бүхий хэрэглэгдэхүүн болно. Энэхүү өгүүлэлд Чойжамцын орчуулгын талаар өгүүлэх юм.

4. Чойжамцын орчуулгын эхүүд:

Чойжамцын орчуулгын гурван эх буй мэдээ бий. Энд хоёр бүрэн эхийн тухай бичье.

A. Сайтар номлосон эрдэнийн сан нэрт шастир нугууд гол судар ба үлгэр тайлбар сэлт оршвой. *Sayitur nomlaysan erdeni-yin sang neretü sastar-nuγud γoul sudur ba üliγer tayilbur selte orosibai. ligs so.*

Хулсан үзгийн эх.

Цаасны хэмжээ: 44x8 см

Цаасны төрөл: муутуу

Мөрийн тоо: 31

Хуудасны тоо: 135

Бичлэгийн хэлбэр: Хар бэхээр тод гаргацтай бичсэн.

Б. "Сайтар номлосон эрдэнийн сан нэрт шастирын тайлбар хэмээгдэх нэрт судар оришвой. *Sayitur nomlaysan erdini-yin sang neretü šastir-un tayilburi kemegdekü neretü sudur orosibai.*

Хулсан үзгийн эх.

Цаасны хэмжээ: 21x7 см

Цаасны төрөл: зузаан шаргал , орос

Мөрийн тоо: 21

Хуудасны тоо: 91

Бичлэгийн хэлбэр: Үсгийн хэв жигд, хар бэхээр тод гаргацтай бичжээ.

5. Агуулга:

Уг хоёр эхэд нийт 50 бадаг шүлгийг үлгэрээр тайлбарласан бөгөөд тулган харгуулахад цөөвтөр үг үсгийн зөрөө байгааг эс тооцвол адил байна. Харин А эхийн хувьд 50 үлгэрээс гадна, зава шүлгийг мөргөлийн хэсэгтэй нь бүгдийг орчуулж, товч тайлбарласны сацуу орчуулагч мөргөлийн болон төгсгөлийн толгой холбон бичсэн шүлэг нэмжээ. Б эх уг 50 бадаг шүлэг болон түүний тайлбар үлгэр, төгсгөлийн үгээс бүрдэнэ.

6. А эхийн мөргөлийн шүлэг:

Галиг	Шинэ үсгийн хөрвүүлэг
1b. 1. getülgegči blam-a 2. yeke nigülesügči-yin 3. ölmei-dür oroï 4. ber mörgümüi. alimad 5. sačural-nuyud-ača 6. getülen eldeb jüyil 7. -ün uçiral-un mön 8. činar qotula-yi o- 9. ruyluyçi alimad 10. yurban yirtinčü-yin 11. jula tengsel ügei 12. čidaγči erketü tere 13. ba man-u alayčilal ügei 14. sadun γayiqamsiytu 15. ayiladqu ennerkü-yin a- 16. γuu nidü-ber amitan-i 17. sayitur ayiladuyad	Гэтэлгэгч лам их нигүүлсэгчийн өлмийд оройгоор мөргөмүй. ❖ Алимад сацрал нугуудаас гэтлэн элдэв зүйлийн учралын мөн чанар хотлыг оруулагч ❖ Алимад гурван ертөнцийн зул тэнсэлгүй чадагч эрхэт тэр ба манай ❖ Алагчлалгүй садан гайхамшигт айлдах энэрэхийн агуу нүдээр амьтныг сайтар айлдаад ❖ Аливаа гурван цагийн ялгуусныг үүсгэн зохиогч ламын чуулганаа насад би бээр залбирмуй. ❖ Гэмгүй мэдэгдэхүүний эрдэнээс бүтээд

<p>18. aliba yurban çay-un 19. ilayyusan-i egüsken 20. jokiyayçi blam-a-yin 21. çiyulyan-a nasuda bi ber 22. jalbiramui. gem gei 23. medegdekün-ü erdeni-eçe 24. bütüged gedergü eser-</p> <p>2a.</p> <ol style="list-style-type: none"> 1. gülügçi adqay 2. _tan-u kei ülü ködel 3. -ün keterkei gkir ügei 4. üyiles-ün usun-u 5. sang bügüde-yi bariyçi 6. kemjiyesi ügei sümbür 7. ayula metü bayşi sa- 8. dun tegün-e ber mör- 9. gümü. udqas-i ayiladuy- 10. çi tere mör-iyer qo- 11. tala-yi belgedügçi bayas- 12. qulang-iyar egün-i sitü- 13. besü aqui yeke bayasqu- 14. lang ber masi ketürkei 15. bayasayçi sang tengsel 16. ügei ilayyusan-u çimeg 17. -yi üjügülügçi duvaza 18. ber çoytay-a sayitur çi- 19. megsen tegüs çoytu çay- 20. lasi ügei kedün törül- 21. kiten-e masi gkir ügei 22. çoytu sayin singjilel 23. -iyer sayitur belgeden sayi- 24. tur bütügegsen sayin-u 25. sayin jarliy-i öcüken 26. qolbun nomlasuyai. <p>2b.</p> <ol style="list-style-type: none"> 1. egün-dür ene yeke boyda ber 2. yoyti kiged qolbun 3. nayirayulqui ba silüg-ün 4. çimeg kiged ners-i ilete 5. ögüleküü terigüten sas- 6. -tar-i merged oroqu 7. -yin egüde kiged qolbun 8. nayirayulqu-yin sastar 9. eldeb çeçeg-ün baylay-a 10. kiged ile ögülegçi 11. neretü sastar ügen-ü 	<ul style="list-style-type: none"> ❖ Гэдрэг эсэргүүлэгч атгагтны хий үл хөдлөн хэтэрхий ❖ Хиргүй үйлсийн усны сан бүгдийг баригч ❖ Хэмжээлшгүй Сүмбэр уул мэт багш садан түүнээ бээр мөргөмү. <ul style="list-style-type: none"> ➤ Утгасыг айлдагч тэр мөрөөр хотлыг бэлгэдэгч баясгалангаар үүнийг шүтвээс ахуй их баясгалан бээр маш хэтэрхий баясагч сан тэнсэлгүй ялгуусны чимгийг үзүүлэгч дуваз бээр цогтойяа сайтар чимсэн төгс цогт цаглашгүй хэдэн төрөлхтнөө маш хиргүй цогт сайн шинжлэлээр сайтар бэлгэдэн сайтар бүтээсэн сайны сайн зарлигийг өчүүхэн холбон номлосугай. ➤ Үүнд энэ их богд бээр ёгт хийгээд холбон найруулах ба шүлгийн чимэг хийгээд нэрсийг илт өгүүлэхүй тэргүүтэн шастирыг мэргэд орохын үүд хийгээд холбон найруулахын шастир элдэв цэцгийн баглаа хийгээд ил өгүүлэгч нэрт шастир үгийн сан тэргүүтэн мэргэдэд хэрэгт шастирыг олон зохиосноос энэ учраа ёгт шастирт чухал хэрэгт утгын чимэг хийгээд үлгэр номын утгад нийцдэхийн тийн ялгалын зүгийг нэгэн хэдий үлгэрлэн үзүүлсүгэй хэмээн таалсан хийгээд ертөнцийн үйл ба үйл бусын хувийг сайтар ялгахуйд мэргэшихийг хүсэгчид ёсны шастирт түшиж дээд номыг номлохуйяа таалсан хийгээд энэтхэгийн өмнө зүг дэх олонхиноо мэргэд лүгээ мэргэн учрах ба мэргэд лүгээ хаан учирваас урьд эс болсон шүлэглэсэн үг ба утга дээд чимгээр найруулсан билиг үгсийн шүлэг буй бөгөөс дээд мэргэд баясмуй за. Эд ба идээний
--	--

<p>12. sang terigüten merged 13. -dür kereg-tü sastar-i 14. olan jokiyaysan-ača 15. ene učir-a yoyti sas- 16. -tar-dur čiqula keregtü 17. udq-a-yin čimeg kiged 18. üliġer nom-un udq-a- 19. -dur neyičedküi-yin teyin 20. ilyal-un jüg-i nigen kedüi 21. üliġerlen üjügülüsü- 22. -gei kemen taġalaġsan 23. kiged yirtinčü-yin üyi- 24. le ba üyile busu-yin 25. qubi-yi sayitur ilyaqui 26. -dur mergesiküi-yi küsig-</p> <p>3a.</p> <p>1. -čid yosun-u sastar 2. -dur tusiju [tüsijü] degedü nom- 3. -i nomla_quy-a taġalaġsan 4. kiged enedkeg-ün emüne 5. jüg deki olang_kin-a 6. merged-lüġe mergen uči- 7. -raqu /ba merged-lüġe qaġan učarabasu/ urida ese boluy- 8. -san silüġligsen üġe 9. ba udq-a degedü čimeg- 10. -iyer nayiraġulusan 11. bilig üġes-ün silüg bui 12. bögesü degedü merged 13. bayasmui y-a. ed ba idegen- 14. -ü bilig-ün tedüyikin-e bayas- 15. suyči qatuytai qo- 16. -tala čin kiged balıad 17. dakin kümün-ü yosun mön 18. -ü tula merged-ün ilıaburi 19. _tu nom busu bolai. 20. teyimü-yin tula časutan- 21. -u ene oron-dur ču 22. merged-nuyud-ta ene 23. metü silüġligsen üġes- 24. -ün bilig bui bögesü ü- 25. jeskülen bolai kemen taġa- 26. -laju ene sastar jokiyabai.</p> <p>3b.</p> <p>1. egün-dür ġurban jüyil 2. udq-a bui-ača eng</p>	<p>билгийн төдийхнөө баясагч хатагтай ба хотол чин хийгээд балгад дахин хүмүүний ёсон мөний тул мэргэдийн ялгаварт ном бус болой. Тиймийн тул цастны энэ оронд ч мэргэд нүгүүдэдэд энэ мэт шүлэглэсэн үгсийн билиг буй бөгөөс үзэсгэлэн болой хэмээн таалж энэ шастир зохиовой.</p> <p>Үүнд: гурван зүйл утга буйгаас эн тэргүүтэн нэрийг өгүүлэхүй хийгээд тахилыг өгүүлэхүй нь: Намо Буддая Намо Дармая Намо Сангхая</p>
---	---

3. terigüiten nere-i ögüleküi	
4. kiged takil-i ögüleküi	
5. inü.	
6. namo buddhay-a	
7. namo dharmay-a	
8. namo sangghay-a.	

7. Үлгэрүүдийн тухайд:

Хоёр эхэд буй “аянч мэлхий”-н үлгэр Мардон Чойжалын төвөд эхэд үгүй. Ринченбал, Цүлтимбал нарын төвөд тайлбарт мөн үгүй. Содном тойны төвөд тайлбарт бий.

Чойжамцын энэ орчуулгад “... нэгэн хүн учирч энэ хоёр хэрээ **навтас** дамнаж явнам хэмээвээс мэлхий сонсож уурлаад би алтан яст мэлхий бөгөөтөл харин намайг навтас хэмээх дуун гарснаар зуусан модоо алдаж хөсөр унав” гэжээ. Энд навтас гэж монгол ахуйжуулсан нь харагдана.

171 дүгээр бадгийн хэрээ нууж тавьсан гэдгийг хэрээ бээр олсон махаа үүлээр тэмдэглэж газарт булах хийгээд хэмээн учир шалтгааны холбоог тайлбарлан орчуулсан байна.

8. Орчуулгын хэв маяг:

Хоёр эх дэх 50 бадаг шүлгийн орчуулга хоорондоо тохирч буй. “А” эх буюу бүрэн зава шүлэг багтсан эхийн орчуулгыг “Субашид”-ын үндсэн шүлгийн бусад орчуулгатай харьцуулж үзэхэд бие даасан тусгай орчуулга болох нь тодорхой байна. Орчуулгыг бүхэлд нь ажиглаваас, ерөнхийдөө Сономгара, Зая бандида нарын үгчилсэн орчуулгын хэв маягтай төстэй бөгөөд төвөд эхийг ягштал баримталсан шинжтэй. Энэхүү орчуулгыг бие даасан орчуулга гэж үзвэл Субашидын зава шүлгийн орчуулга мөн нэгээр нэмэгдэх юм.

9. Төгсгөлийн үг:

Орчуулгын төгсгөлд Сажа Бандида Гунгаажалцаны төгсгөлийн үг дээр орчуулагч Чойжамц толгой холбон шүлэглэж бичсэн байх бөгөөд түүндээ орчуулагч, дуртгагчийн нэрийг өгүүлжээ. А эх дэх *Эгүүрд (үүрд) удаж түдэлгүй Эрхэт* хэмээх дөрвөн үг Б эхэд үгүйг эс тооцвол хоёр эхийн төгсгөлийн үг үндсэндээ адил юм. А эхийн эрдмийн далай хэмээхийг Б эхэд хотлын далай гэсэн буй. Энэхүү төгсгөлийн үгэнд Субашидын үндсэн эх шүлгийг голлон, бусад тайлбаруудаас нэмж орчуулсан тухай дурджээ. Чингэхлээр, орчуулагч бэлэн төвөд тайлбар дээр өөр бусад тайлбаруудаас нэмэн найруулж орчуулсан бололтой байна.

А эх	Б эх
1346. 1. jokiyaysan-i tegüsbe. egüni cü saskyay-a	906. 1. egüni cü 2. bañcin-u jokiyaysan-u ijayur-un γoul

<ol style="list-style-type: none"> 2. pañčin-u jokiyaysan ijayur-un γoul 3. sudur-iyar erkilejü tayilburi terigüten-eče 4. čimegleng nemesün mongγulčilan 5. orčiyulbai. 6. erdem_ <i>dü</i> merged ber jasan 7. soyurq-a. <i>erelkin</i> merged ber 8. endegürejü buruγu bolγuqu 9. boluyujai.ergičegül_ün 10. sayitur sinjilebesü sayin 11. bölüge. erkin oyutu mergen 12. dayičin ber ene sastar-i 13. orčiyul kemegsen-iyer, <i>erdem</i> 14. <i>-ün</i> dalai yeke nomun küriyen 15. -dür, egel doradu čos 16. rgyamtsho neretü <i>dgečül</i> ber 17. erke ügei orčiyuluγsan 18. -iyar eke boluγsan qamuγ 19. amitan бүгүдегер, <i>egüride</i> 20. <i>udalju tüdel ügei</i> 21. <i>erketü</i> burqan-u qutuγ-i 22. olqu boltuγai 23. mangha lam. bivangdu. <p><i>Үүнийг ч Сажа</i> банчин зохиосон язгуурын гол судраар эрхэлж тайлбар тэргүүтнээс чимэглэн нэмж, монголчлон орчуулав. Эрдэмт мэргэд бээр засан соёрх. Эрэлхэн мэргэд бээр Эндүүрч буруу болгох болуузай. Эргэцүүлэн сайтар шинжилбээс сайн бүлгээ. Эрхин оюут мэргэн дайчин бээр Энэ шастирыг орчуул хэмээснээр <i>Эрдмийн</i> далай их номын хүрээнд Эгэл доорд Чойжамц нэрт гэцэл бээр Эрхгүй орчуулсан буянаар Эх болсон хамаг амьтан бүгдээр <i>Эгүүрд (үүрд) удаж түдэлгүй</i> <i>Эрхэт</i> бурхны хутгийг олох болтугай. Мангаалам. Бхаванду.</p>	<ol style="list-style-type: none"> 3. sudur-iyar erkilejü tayilburi terigüten 4. -eče čimeglen nemejü mongγulčilan orčiyulbai 5. erdem-<i>ten</i> merged ber jasan soyurq-a. 6. <i>erelkeg</i> merged ber endegürejü buruγu 7. bolγuqu boluyujai. ergičigül-ün sayitur 8. sinjilebesü sayin bölüge. erkin 9. oyutu mergen dayičing ber ene 10. sastar-i orčiyul kemegsen-iyer <p>91a.</p> <ol style="list-style-type: none"> 1. <i>gotala-yin</i> dalai yeke 2. nom-un küriyen-tür egel 3. dooradu čos rgyamtsho 4. neretü <i>dgetshul</i> ber erke 5. ügei orčiyuluγsan buyan- 6. -iyar eke boluγsan amitan бүгүдегер 7. burqan-u qutuγ-i 8. olqu boltuγai. <p>Үүнийг ч Сажа банчины зохиосны язгуурын гол судраар эрхэлж тайлбар тэргүүтнээс чимэглэн нэмж, монголчлон орчуулав. Эрдэмтэн мэргэд бээр засан соёрх. Эрэлхэг мэргэд бээр Эндүүрч буруу болгох болуузай. Эргэцүүлэн сайтар шинжилбээс сайн бүлгээ. Эрхин оюут мэргэн дайчин бээр Энэ шастирыг орчуул хэмээснээр <i>Хотлын</i> далай их номын хүрээнд Эгэл доорд Чойжамц нэрт гэцэл бээр Эрхгүй орчуулсан буянаар Эх болсон хамаг амьтан бүгдээр бурхны хутгийг олох болтугай. Мангаалам. Бхаванду.</p>
---	---

10. Орчуулагчийн тухай:

Төгсгөлийн үгэнд орчуулагчийн тухайд нэрээс өөр зүйлийг дурдсангүй. Олж үзсэн ном, судрын хүрээнд үзвэл монголын орчуулагч, бичгийн мэргэдийн дунд Чойжамц нэртэй хоёр хүн тохиолдож байна.

1. Алтан хааны жич хүү Чойжамц.

”Манжушрийн нэрийг үнэнээр өгүүлэхүй” гэдэг номыг алтан хааны жич хүү тойн Чойжамц монголоор орчуулж санскрит, төвөд, хятад, монгол дөрвөн хэлээр хавсарган 1591 онд модон бараар хэвлэж гаргасан байна. Энэ ном Монгол улсын номын санд бий.(1977:383) ХИҮ зууны үеэс “Ганжуур”-ын дотор орсон номуудыг монгол хэлээр орчуулсаар ирсэн бөгөөд Цахарын Лигдэн хааны зарлигаар 1629 онд “Ганжуур”-ыг бүхлээр нь монгол хэлэнд орчуулан дуусгасан байна. “Ганжуурыг монголчлон орчуулсан далаад хүний нэрсийг тоочсоны дотор Чойжамц гэлэний нэр буй (2017:24) бөгөөд Манжушри нама сангиди хэмээх судар зэрэг олон ном орчуулсан (1977:84) Алтан хааны жич хүү бичгийн мэргэн тойн Чойжамц бол ХҮI зууны төгсгөл ХҮII зууны эхэн үед амьдарч байсныг мэдэж болох юм.

2. Дарма гүүш

Чойжамц (Дарма гүүш) нь монголын түүхийн шилдэг сурвалж бичгүүдийн нэг “Алтан хүрдэн мянган хигээст” хэмээх сурвалжийг зохиосон болно. “Дарма гүүш бол Зуу-Үдийн чуулганы жарууд баруун хошууны хүн юм. “Үлэмж билигт эрдэнэ гүүш Чойжамц” хэмээн олонд алдаршсан бөгөөд тэнгэрийг тэтгэсний дөтгөөр он [1739]-д эл түүхийн тулгар бичгийг зохиожээ. 1741-1749 онд “Данжуур”-ын монгол орчуулгыг хянах ажилд оролцсон байна. Тэр бээр “Гангын урсгал”-ыг зохиосон Гомбожав гүнтэй ойр дотно харьцаатай байсан бололтой. Түүнчлэн, “Рашааны зүрхэн найман гишүүт нууц увдисын хураангуй цаг бусын үхлийн цалмыг огтлогч илдэн” хэмээхээс “Өвчний шалтгаан тэргүүтнийг үзүүлсэн судар”, “Онол наминчлахуйн тайлбар-гэмийн харанхуйг арилгагч наран зул” зэрэг анагаах ухаан хийгээд уншлагын тайлбар судрыг төвөд хэлнээс монголчилсон нь нэгэнт тодорхой байна (2006a:3-4). Мөн Данжуурын 226 ботийг орчуулсан эрдэмтдийн нэрсийн дотор “Жарууд гүүш аяга-ха тэхимлиг 66-р боть орчуулав” (2017:66) хэмээсний зэрэгцээ "Мэргэд гарахын орон"-ы төгсгөлд *Жаруд ширээт үлэмж билигт эрдэнэ гүүш Чойжамц* (1988:1426) гэж дурдсан нь уг толийг найруулахад оролцсоныг гэрчилнэ. Дарма гүүш ХҮIII зууны дунд үеийн алдартай орчуулагч, бичгийн эрдэмтэн байжээ. Эдгээр мэдээнээс үзвэл тэрбээр 17 дугаар зууны сүүл үеэс 18 дугаар зууны дунд үе хүртэл амьдарч байжээ.

Энэхүү тайлбарыг орчуулагчийн тухайд толгой холбон шүлэглэж бичсэн төгсгөлийн үгийн найруулга, ур маяг Дарма гүүшийнхтэй ойр төстэй байдал буй (2006b:4)

гэж зарим судлаач тэмдэглэсэн зүйл бий. Гэвч үүнийг бат нут баримт гэхэд эргэлзээтэй юм.

Дээрх хоёр Чойжамц бол хоёулаа дуун хөрвүүлэгч бөгөөд Ганжуур, Данжуурыг орчуулах, бэлтгэх ажилд хувь нэмрээ оруулсан бичгийн мэргэд болох нь тодорхой байна. Иймээс орчуулагчийг тодруулахын тулд цаашид түүхийн сурвалж судраас мөшгөж нарийн судлах шаардлагатай. Дарма, Номун далай зэрэг нэрсийг холбогдуулан нягталж үзвээс зохих юм.

11. Дуртгагчийн тухай:

"*Эрхин оюут Мэргэн дайчин бээр энэ шастирьг орчуул хэмээснээр*" гэж дуртгагч хэн болохыг тэмдэглэжээ. Чухам Мэргэн дайчин хэмээх нэртэй, мэргэн дайчин хэмээх цолтой хүний алин болох нь тодорхой бус боловч оноосон нэр болов уу хэмээн санана.

Эрхин оюут гэснээс үзэхэд бичиг номын хүн байх магадлалтай. Тиймээс бичгийн хүмүүсээс мөшгөвөл:

1. Ганжуур, Данжуурыг монгол хэлнээ орчуулах үйлсэд хувь нэмрээ оруулсан дуун хөрвүүлэгчдийн нэрсийн дотор "*Билигийн чанад хязгаарт хүрсэн зуун мянган тоот*" хэмээх зохиолын төгсгөлийн шүлэг ХҮШ зууны үеийн алдарт орчуулагч *Гүүш цорж*⁹¹, түүний дараах үеийн нэрт дуун хөрвүүлэгч *Мэргэн дайчин тайж хийгээд хэлмэрч Дорждаг нар төвөд эхтэй нь нийцүүлэн ахиж шүүдэглэн ариутган шүүж уг номын төгсгөлийн үгийг нэмэн баяжуулж бичсэн тул энэ нь 164 мөр бүхий асар өргөн дэлгэр агуулга бүхий том шүлэг болсон байна* (Цэрэнсодном 2017:37) хэмээснээс үзвэл "Билигийн чанад хязгаарт хүрсэн зуун мянган тоот" нэрт номын төгсгөлийн үгийг ариутган шүүж бичсэн Мэргэн дайчин нэрт дуун хөрвүүлэгч байсныг мэдэж болно.
2. Эрдэнэ мэргэн Дайчин тайжийн орчуулсан "Цагаан лянхуа нэрт дээд номын их хелген судар" хэмээх Бээжин модон барын судар байдаг. Энэ номыг монгол хэлэнд 16 дугаар зууны сүүлээр орчуулсан гэдэг (2006с:166).
3. Данжуурын 224-р ботийн дотор байгаа Хутагт сайн явдлын ерөөлийн хаан хэмээх судрын төгсгөлд Төгс билэгт Мэргэн дайчин тайж хэмээгдэх хэлмэрч урьд орчуулсныг шүүн засаж орчуулав (1977:386) гэсэн мэдээнээс данжуурыг орчуулж хэвлэхээс өмнө буюу 1740-өөд оноос өмнө уг зохиолыг орчуулсан гэдэг нь мэдэгдэж байна.

Эдгээр мэдээнд үндэслэхүл, 16 дугаар зууны сүүл 17 дугаар зууны эхэн хагаст Мэргэн дайчин тайж хэмээх дуун хөрвүүлэгч, бичгийн их хүн байжээ. Магадгүй энэ хүн "цагаан лянхуан нэрт дээд номын их хөлгөн судар", "хутагт сайн явдлын ерөөлийн хаан"

⁹¹ Гүүш цорж (...-1618)-ийн дараах үеийн нэрт дуун хөрвүүлэгч Мэргэн дайчин тайж. Билигийн чанад хязгаараа хүрсэн зуун мянган тоот хөлгөн судрыг орчуулсан төгсгөлийн үгэнд "...тэл хэлт Дорждаг нэрт дэлгэр банди хийгээд төгс эрдэмт мэргэн дайчин тайж хоёул нь дахиж аялгуусыг найралтайяа тохиолдуулж бүрүүн..." хэмээн бичжээ.

зэргийг орчуулсан байж болохоор байна. Лигдэн хааны үед Ганжуурыг орчуулахад оролцсон нь тодорхой байх бөгөөд Алтан хааны жич хүү Чойжамц ч мөн оролцсон байх тул энэ хоёр дуун хөрвүүлэгчийн амьдрал, ажил үйлс нэгэн цаг үед өрнөж байсан нь эрхгүй сонирхол татна. Түүнчлэн зарим судлаачид Б эхийг 17 дугаар зууны үед хамаатна хэмээх таамаглал дэвшүүлсэн билээ (2004:183).

Иймээс Чойжамцын орчуулсан “Субашид”-ын тайлбарын дуртгагчийг цаашид түүх сурвалжаас илүү нарийн тодруулах хэрэгтэй юм. Орчуулагч болон дуртгагч нэгэн үед амьдарч байсан нь гарцаагүй тул аль нэгийг үнэн зөв тодруулж чадваас нөгөөг тодруулахад ихэд дөхөм болох буй за.

12. Уг төвөд эхийн тухай асуудал:

Ямар төвөд эх ашиглаж орчуулсан бэ? гэдэг асуудал гарна.

1. Мардон Чойжалын тайлбартай харьцуулахад үлгэр ерөнхийдөө дүйж байна. 172 дугаар бадгийн бодисад сармагчны үлгэр Мардон Чойжалын тайлбарт дэлгэрэнгүй байхад орчуулгад нэлээд товч агуулгатай буй.

Арслан үнэгний үүргийг үүрсэн үлгэр төвөд тайлбарт дарааллын хувьд хойноо орсон.

Ер нь Мардон Чойжалын тайлбар Б эхтэй адил 50 бадаг шүлгийг үлгэрээр тайлсан юм. Гэтэл А эх бүх шүлгийг товч тайлбарлах маягаар орчуулсан.

Содном тойны тайлбарт бүх шүлэг багтсан, гэвч Мардон Чойжалын тайлбарлаагүй зарим бадагт дэлгэрэнгүй тайлбар үлгэртэй.

13. Бичлэгийн онцлог:

Чойжамцын орчуулан бичсэн энэхүү эхийн бичлэгийг ажиглавал хэд хэдэн онцлог харагдаж байна. Үүнд:

1. Хулсан үзгийн эхийн онцлогоор титэмгүй бичсэн.
2. Эр үгийн “Х” үсгийн толгойг жижиг бичсэн.
3. Эр үгийн дунд болон адагт дэвсгэрлэж орсон "Г" гийгүүлэгчийн өмнө хоёр дусал тавьсан. Жишээ нь: *baysi, jokiyaysan, čay, sakičsi, sarmayčin, qariyuluysan, aysan, alaysan, qamuγ* гэх мэт үгсийн дэвсгэр "Г" гийгүүлэгчийн өмнө дусал тавьсан байна.
4. Хойноо эгшигтэй, эр үгийн "г" гийгүүлэгчийн өмнө дусал тавиагүй.
5. Тийн ялгалын нөхцөлийн хатуу зөөлөн дэвсгэрээр төгссөн үгэнд залгах хэлбэрийг хольж бичсэн нь элбэг тохиолдож байна. Жишээ нь: *oi-tur [=oi-dur], kümün-tür [=kümün-dür], usun-tur [=usun-dur], darui-tur [=darui-dur], qayan-tur [=qayan-dur], quduγ-yi [=qutuγ-i], tegün-tür [=tegün-dür],*
6. Заахын тийн ялгалын тухайд эгшгээр төгссөн үгэнд –i хэлбэрийг дагуулсан, гийгүүлэгчээр төгссөн үгэнд –yi хэлбэрийг дагуулсан тохиолдол байна. Жишээ нь: *ayula-i, yuyulγ-a-i, nom-yi, šilüg-yi, sang-yi, baling-yi, qutuγ-yi*

7. Үг бүтээх дагаврыг салангид бичсэн тохиолдол элбэг байна. Жишээ нь: erdeni_tü [=erdenitü], bilig_ten [biligten], köl_tü [költü]
8. Салангид бичих нөхцөлийг нийлүүлж бичсэн нь элбэг байна. Жишээ нь: tegüneče [=tegün-eče], kümüni [=kümün-i], tegünü [=tegün-ü], duraba r[dur-a-bar], tendeče [tende-eče], šabınar [šabi-nar],
9. Аман дуудлагаар бичсэн үгс тохиолдож байна. Жишээ нь: quduу [qudduу], tegüni [=tegün-ü], noyon[=noyan], görösön [=görügesün], geji [=gejü], toуloуči [=toуlayči], yamaуan [=imaуan]
10. Авиа сэлгэсэн уламжлалт үгс ажиглагдаж байна. Жишээ нь: kiliglejü [=kilignejü], damlaju [damnajü]

Б эхэд үгийг мөр тасалж бичээгүй бөгөөд харин мөрийн дунд үгийг тасалж бичсэн нь ганц хоёрын төдий байна. Энэ нь сайтар төлөвлөж, хичээнгүйлэн хуулж бичсэнийг гэрчилнэ.

14. Орчуулгын эхийн тухай асуудал:

А эхийн тухайд зарим үгийг илэрхий гэсэн, хэсэг үг гээгээд энд тэнд нөхвөрлөн оруулсан, уртавтар нэг үгийг нэг мөрт хоёр гурав таслан бичсэн зэрэг байдлаас харахад хуулбар эх гэдэг нь тодорхой байна. Түүнчлэн хос шилбэний эхнийхийг богиноор бичсэн, зарим үгийн хэлбэр нутаг орны аялгууны онцлогийг илэрхийлсэн, өөрөөр хэлбэл өмнөд монгол аялгууны онцлогийг тусгасан гэж үзэж болохуйц ажээ.

Б эх ч мөн хуулбар бөгөөд аман дуудлагаар бичсэн үгс хэд хэд тохиолдож буй нь арай хожуу буюу орчин цагийн монгол хэл төлөвшиж эхэлсэн үед хамаарах бололтой.

Дүгнэлт

Нэг орчуулгын хоёр эхийн хувьд “А” эх түрүү үеийнх бөгөөд “Б” эх арай хожуугийнх бололтой. Чингэхдээ зөвхөн тайлбартай шүлгийг түүвэрлэн хуулжээ.

Ашигласан төвөд эхийн тухайд Мардон Чойжалын тайлбараас орчуулсан гэж үзүүштэй. Гэхдээ давхар өөр нэг төвөд тайлбар үзсэн болов уу. Магадгүй “Цэцгийн эрих” хэмээх тайлбарыг үзсэн ч байж болох юм. Цаашид нягтлах хэрэгтэй. Орчуулагч төвөд эхийг нэмэн дэлгэрүүлэх, товчлон хураангуйлах зэргээр засан найруулсан шинжтэй.

Орчуулагч нь Алтан хааны жич хүү Чойжамц, дуртгагч нь Ганжуурыг орчуулахад оролцсон Мэргэн Дайчин тайж байх магадлалтай байна.

Хэл найруулга, үгсийн сангийн бүрэлдэхүүн, бичлэгийн хэв хэлбэрийг цаашид нарийвчлан судлах нь зүйн хэрэг юм. Энэхүү орчуулга бол хэл, уран зохиол, аман зохиол, түүх, шашин соёл, орчуулга судлал зэрэг олон салбар чиглэлийн судалгааны үнэт хэрэглэгдэхүүн болно.

Ном зүй

Монгол хэлээр:

Гомбованжил. (2006). *Алтан эрих*. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн Д.Бүрнээ. Улаанбаатар.

Дамдинсүрэн Ц., Цэнд Ц. (ред). (1977). *Монголын уран зохиолын тойм II*. УБ.
Заяабаатар Д, Бадамдорж Д. (2004). “Эрдэнийн сан Субашид”-ын тайлбарын нэгэн орчуулга. *Acta Mongolica*. Vol 3(215). МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. Улаанбаатар.

Merged yarqu-yin oron. (1988). *Ündüsüiten-ü keblel-ün qoriy-a*.

Сажа бандида Гунгаажалцаны зохиол. *Эрдэнийн сан Субашид*. (1990) Цахар гэвш Лувсанчүлтэмийн орчуулга ба тайлбар. Ц. Дамдинсүрэн, Ж.Дүгэржав. УБ.

Хүрэлбаатар, Л. (1995b). *Монгол орчуулгын товчоон*. УБ.

Цанжид А., Чоймаа Ш. (хөр). (2006a). *Алтан хүрдэн мянган хигээст*. УБ.

Цэрэнсодном Д. (2017). *Монгол ганжуур, данжуурын төгсгөлийн шүлэг*. УБ.

Бусад хэлээр:

Legs par bshad pa rin po'i gter gyi 'grel pa bzugs so. 46 хуудас. Хувийн цуглуулгад буй.

Sa skya'i legs bshad kyi rtsa 'grel. (199b). *Mtsho sngon mi rigs dpe skrun khang*. Zi ling.

W.Heissig. (1961). *Mongolische Handschriften, Blockdrucke. Lanokarten, Wiesbaden*.

ХЯТАД ХЭЛНИЙ “BEI” (被) БҮХИЙ ӨГҮҮЛБЭРИЙН МОНГОЛ ОРЧУУЛГЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Б.Одгэрэл⁹²
Д.Бадмаанямбуу⁹³

***Abstract:** In order to clarify how “Bei” Sentence in modern Chinese appears in Mongolian, the study of “Bei” Sentences in Chinese, the structure of the sentence, its study in Mongolia, examples of translation and how Bei-Sentences appear in Mongolian are described. “The Dream of the Red Chamber” by Cao Xueqin of Chinese classical literary work and nine sentences out of forty-five sentences included in M.Chimedtseye’s “Hot Pot” were selected according to the summary structure of the sentence with “Bei” and how it is expressed in Mongolian with Chinese and Mongolian translations is a parallel study of the results and significance of the study.*

***Түлхүүр үг:** орчуулга, үйлийн хэв, үйлдэх, үйлдүүлэх*

УДИРТГАЛ

Монгол улс БНХАУ нь хөрш улсын хувьд манай хоёр орны харилцаа олон чиглэлээр хөгжиж ирсэн түүхэн уламжлалтай. Түүхэн хөгжлийн явцад соёлын харилцаа олон хэлбэрээр хөгжиж иржээ. Тухайлбал хөгжлийн ихэнх хугацаанд Монгол, Хятад хоёр орны соёлын харилцаанд (X зууны үеэс эхлэлтэй) орчуулгын хэлбэр зонхилж байсан бол орчин цагт уран зохиол, хэл шинжлэл, боловсрол судлалын чиглэл эрчимтэй хөгжих болжээ. Гадаад хэлний сургалт, боловсрол судлалын хүрээнд 1957 оноос эхлэн МУИС-д хятад хэлний мэргэжилтнийг бэлтгэж эхэлсэн түүхтэй ч цаг үеийн байдлаас шалтгаалан хятад хэлний хэрэглээ болон хэрэгцээ өнөөгийн түвшинд хараахан хүрээгүй байв. Өдгөө Монгол оронд шат шатны олон сургуульд хятад хэлний сургалт зохион байгуулж байгаагийн (Нийт 60 гаруй сургуульд) (В.Батмаа, 2014) зэрэгцээ хятад улсад

⁹² Магистр, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль

⁹³ Доктор, МУИС, ХУС, Ази судлалын тэнхимийн дэд профессор

боловсрол эзэмшигчдийн тоо жилээс жилд өссөөр байна. Үүнийг дагаад монгол, хятад хэлний зэрэгцүүлсэн судалгааны олон судалгааны ажил гарах болжээ.

Монгол, хятад хоёр хэл хэдийгээр хэв шинжийн хувьд төрөл бус хэлний ангилалд багтах боловч энэ хоёр хэлэнд дэлхийн нийт хэлний түгээмэл утгын олон ай, тухайлбал бидний судалж буй үйлдэх-үйлдэгдэхийн утгазүйн ай өөр өөрийн өвөрмөц хэлбэрээр илэрдэг байна. Түүнийг нарийвчлан судалж тухайн хоёр хэлийг сурах/сургахуй, уг хоёр хэлний хүрээнд цахим хөрвүүлэг хийх зэрэг үйлд чухал сурвалж болно хэмээн бид үзэж байна.

Сэдвийн үндэслэл

Судалгааны тоймоос үзэхэд монгол, хятад хэлний үйлийг заасан үгийн хэвийн харьцуулсан судалгаа төдийлөн сайтар хийгдээгүй байна. Энэ хүрээнд БНХАУ-д боловсролын чиглэлээр алдаа судлалын сэдвийн дор судалсан цөөхөн судалгаа бий. Гэвч тэдгээр нь зөвхөн хятад хэлний сургалтад зориулсан байдаг тул орчуулга болон монгол хэлний чиглэлийн судалгааг орхидог. Тиймээс бид судалгаанд монгол хэлний үйлдэх-үйлдэгдэх-үйлдүүлэх айн хэв шинж болон, хятад хэлний үйлдэх-үйлдэгдэх-үйлдүүлэх айн хэв шинж бүхий өгүүлбэрийн үйл үгийн хэвийн судалгааг иж бүрнээр нь авч үзэх шаардлагатай гэж үзэв. Хятад хэлний “BEI” (被) бүхий өгүүлбэр нь үйлдэх-үйлдэгдэх-үйлдүүлэх айн хэв шинжийг илэрхийлэх түгээмэл хэлбэр учраас төлөөлүүлэн авч үзсэн болно.

Судалгааны зорилго

Хятад хэлний A+“BEI”(被)+VP, A+(被)+B, (нэр үг ба нэрийн холбоо) +VP, A+“BEI” (被)+B (нэр үг ба нэрийн холбоо) + VP (үйлийн холбоо) өгүүлбэрийн бүтэц, үүрэг зэргийг тодруулан монгол хэлэнд хэрхэн илрэх талаар хятад эртний сонгодог бүтээл болон орчин цагийн шилдэг өгүүллийн орчуулгын жишээнээс эш татан түүвэрлэн авч харьцуулан авч үзсэн болно.

Судлагдсан байдал

1996 онд Гадаад хэлний дээд сургуулиас эрхлэн гаргасан «Монгол хэлийг төрөл бус хэлтэй зэрэгцүүлэн судлахын оршил» бүтээлд монгол хэлний үйл үгийн хэвийн хэлбэрийг орос, франц, англи хэлтэй товч хэлбэрээр харьцуулан тайлбарласан бол, 2015 онд Хүмүүнлэгийн Их Сургуулиас гаргасан «Зэрэгцүүлсэн хэл шинжлэл» бүтээлд хятад хэлний үйл үгийн хэвийн илрэх байдалтай зэрэгцүүлэн судалжээ. Ингэхдээ “хятад хэлний “BEI” (被) үсэг бүхий өгүүлбэр нь монгол хэлний бусдын эрхэнд үйлдэх хэв болон өөрөө үйлдэх хэвээр илэрнэ” гэсэн товч дүгнэлт гаргасан нь нэг талаар тус сэдвийн хүрээнд хийсэн судалгааг эхлүүлсэн сайн талтай бөгөөд уг сэдвийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатайг харуулсан дүгнэлт болсон юм.

С.Алимаа “Герман, халх монгол хэлний үйл үгийн зэрэгцүүлсэн судалгаа хийх товч агуулга” өгүүлэлдээ тус хоёр хэлний үйл үгийн хэвийн судалгаа хийж герман хэлний үйл үгийн хэв монгол хэлэнд илрэх байдлыг орчуулгын аргаар задлан шинжилжээ. 2014 онд Д.Баярмаа “Монгол, франц хэлний үйлдэгдэх хэвийн зэрэгцүүлсэн судалгаа” сэдвээр магистрын зэрэг горилсон бүтээл туурвисан байдаг.

Дээрх судалгаанд үндэслэн монгол хэлний үйл үгийн хэвийг хятад хэлний үйл үгийн хэвтэй харьцуулсан судлах шаардлагатай байгааг харуулж байна.

1. Орчин цагийн хятад хэлний “BEI” (被) бүхий өгүүлбэрийн тухай

Орчин цагийн хятад хэлний үйлдэгдэх хэвийг илэрхийлдэг хэд хэдэн төрлийн өгүүлбэр байдгаас “BEI” (被) бүхий өгүүлбэр нь хэлзүйн хэлбэр хийгээд утгыг хувьд харьцангуй өвөрмөц нь юм. “BEI” (被) бүхий өгүүлбэрийг нэр томьёо, үүрэг, хэлзүйн утга, бүтцийн талаас нь зонхилон судалдаг. Нэр томьёоны талаас нь эрдэмтэн Ван Ли⁹⁴ “BEI” (被) бүхий үйлдүүлэх хэвээс гадна “BEI” (被) –гийн тэг хэлбэрийн үйлдүүлэх хэв байгаа нь хэлбэр хийгээд утгын хувьд ижил юм⁹⁵ гэж тайлбарласан бол 1980 онд эрдэмтэн Гүн Чянь янь “Орчин цагийн хятад хэлэнд өртөгч бүхий өгүүлэгдэхүүнтэй өгүүлбэрийн “үйлэнд өртөгч өгүүлэгдэхүүнт өгүүлбэр (受事主语句) буюу “Үйлдүүлэх хэв (被动式)” хэмээн нэрлэнэ” гэж хоёр төрөлд ангилсан байна. Эрдэмтэн Дай Яожин (2003) “BEI” (被)-гийн тэг хэлбэртэй үйлдүүлэх хэв бүхий өгүүлбэрийг тогтвортой бус гэж үзээд ийм өгүүлбэрийг утгын талаас нь үйлдүүлэх хэв илэрхийлэх мэт боловч үйлдүүлэх хэв бүхий өгүүлбэрт оруулах нь тохиромжгүй гэж тайлбарлан судалсан аж.

Дээрх эрдэмтдийн саналыг нэгтэн харвал хятад хэлний “BEI” (被) бүхий өгүүлбэр нь үйлдүүлэх хэвийг илэрхийлэхээс гадна “BEI” (被)-гийн тэг хэлбэрийг үйлдүүлэхийн хэвд оруулах нь тохиромжгүй гэж үзсэн байна.

“BEI” (被) бүхий өгүүлбэрийн хэлзүйн үүргийн тухайд эрдэмтэн Жу Дөши 1982 онд хэвлүүлсэн өгүүлэлдээ “叫，让，给” зэрэгтэй адил үүрэг гүйцэтгэнэ гэж дүгнэснээр “BEI” (被) угтвар үгийг бусад үйлийн хэв илэрхийлэх угтвар үгтэй хамтад нь авх үзсэн юм. 1994 онд эрдэмтэн Ли Шань⁹⁶ хэлзүйн хүрээнд харьцангуй бүрэн тайлбарыг гаргав. Тэрээр “BEI” (被) –гийн үйлдүүлэх хэвийг гурван төрлөөр авч үзэх ёстой хэмээгээд

⁹⁴ 王力, 现代汉语语法, 商务印书馆, 1985, 第 87 [Ван Ли. Орчин цагийн хятад хэлний хэлзүй. Шан Ү хэвлэлийн газар, 1985, 87-р тал]

⁹⁵ 王力, 现代汉语语法, 商务印书馆, 1985, 第 87 [Ван Ли. Орчин цагийн хятад хэлний хэлзүй. Худалдааны хэвлэлийн газар, 1985, 87-р тал]

⁹⁶ 李珊: «现代汉语被字句研究».1994 年, 北京: 北京大学出版社. 47 [Ли Шань «Орчин цагийн хятад хэлний “BEI” бүхий өгүүлбэрийн судалгаа», 1994, Бээжин, Бээжингийн Их сургуулийн хэвлэлийн газар, 47-р тал]

(1) Өгүүлбэрийн эхэнд орж буй нэр үгийн шинжтэй өгүүлбэрийн гишүүн үйлийн өртөгч болно.

(2) Тэдгээрийн ард орж буй нэр үгийн шинжтэй өгүүлбэрийн гишүүн нь үйлийн эзэн болно.

(3) Өгүүлбэр нь бүхэлдээ учир шалтгаан ба үр дүнгийн илэрхийллээр уялдсан байдаг гэж тайлбарлажээ.

Энэхүү онол тайлбарыг сүүлийн үеийн олон эрдэмтэд хүлээн зөвшөөрөх хандлагатай байдаг. Зонхилох эрдэмтдийн хүлээн зөвшөөрдөг өөр нэгэн үзэл онол бол “BEI” (被) бүхий өгүүлбэр нь сөрөг утгыг агуулдаг хэмээх тайлбар юм. Тухайлбал үйлдүүлэх хэвээр илэрч буй үйлдэл нь хүсэн хүлээхээргүй, сайшаалд нийцэхээргүй үйлдэл байх агаад үйлэнд өртөгч нь мэхлэгдэх, гэмтэх, азгүйдэлтэй учрах гэх мэт сөрөг үр дагавар илэрдэг.

Дээрх эрдэмтдийн үзэл онолоос харахад орчин цагийн “BEI” (被) бүхий өгүүлбэрийн үйлд өртөгчийн үр дүнгээс хамаарч сөрөг, энгийн, хүсэн хүлээсэн, санаад оромгүй гэх мэт үр дагаварт хүрч болох агаад энэ нь тус өгүүлбэрийн үндсэн утга биш ажээ.

XX зууны эхэн үеэс эхэлсэн орчин цагийн хятад хэлний судалгаанаас хойш “被” бүхий өгүүлбэрийн бүтцийг олон янзаар ангилж иржээ. Тэдгээрийг хураангуйлан ангилбал:

- Нэрийн холбоо + “BEI” (被)+Үйл үг

- Нэрийн холбоо+ “BEI” (被)+Нэрийн холбоо+Үйл үг

- Нэрийн холбоо+ “BEI” (被)+Нэрийн холбоо + Үйл үг+бусад гишүүд

Бид дээрх бүтцийг хялбар болгох үүднээс дараах байдлаар хураангуйлав.

A: Үйлд өртөгч

B: Үйлийн эзэн

VP: Үйл үг болон үйлийн холбоо

Тиймээс дээрх үндсэн бүтцүүдийг A+“BEI” (被)+B+VP болгон хураангуйлаад тухайн бүрд нь тайлбарлав.

1) A+ “BEI”(被)+VP

Энэхүү бүтцэд нь B буюу үйлийн эзэнгүй хэлбэр юм. Жишээ нь:

(1) 我被赶出家门了.

Бүтэц: A (我 би) + 被 + VP (赶出家门了 гэрээсээ хөөгдөх)

(2)桌子上被堆满了书.

Бүтэц: A (桌子 ширээ) + 被 + VP (堆满了书 номоор дүүрэх)

(3) 过去的日子如玻璃,被打碎了.

Бүтэц: A (过去的日子如玻璃 Өнгөрсөн хугацаа шил мэт) + 被 + VP (打碎了 үйрэн нуржээ.)

(4) 他一直被重用.

Бүтэц: А (Тэр) + 被 + VP (ашиглуулсаар)

А + “BEI” (被) + VP бүхий бүтэцтэй дээрх гурван жишээний (1), (2), (4) үйл үг нь хүний оролцоотой хийгдэх үйлдэл тул тухайн өгүүлбэрүүдийн өгүүлэгдэхүүн нь идэвхтэй эзэн байх аж. (3) өгүүлбэрийн өгүүлэхүүн нь үйрэх, нурах гэсэн үйл үг агаад хятад хэлний эс тусах үйл үгэнд хамаарч өгүүлэгдэхүүн нь идэвхгүй эзэн байх юм.

2) А + “BEI” (被)+В (нэр үг ба нэрийн холбоо) + VP

А + “BEI” (被)+В+VP гэсэн бүтцийн В нь нэрийн холбоо байх дараах жишээг харвал:

(1) 我的汽车被公共汽车撞了。

Бүтэц: А (我的汽车 миний машин) + 被+ В (公共汽车 автобус) + VP (撞了 мөргөсөн)

(2) 你明天可能会被老师骂。

Бүтэц: А (你 чи) + 被+ В (老师 багш) + VP (骂 загнах)

(3) 哥哥的笔记本被我的朋友借走了。

Бүтэц: А (哥哥的笔记 ахын зөөврийн компьютер) + 被+ В (我的朋友 найз маань) + VP (借走了 зээлж явах)

(4) 那位参议员被选民抛弃了。

Бүтэц: А (那位参议员 хурлын гишүүн) + 被+ В (选民 сонгогч) + VP (抛弃了 хаях)

Дээрх өгүүлбэрүүдийн В гишүүн нь бүгд үйлийн идэвхтэй эзэн болж байна.

3) А + “BEI” (被)+В (нэр үг ба нэрийн холбоо) + VP (үйлийн холбоо)

А + “BEI” (被)+В+VP гэсэн бүтцийн VP нь үйлийн холбоо байх дараах жишээг харвал:

(1) 家里的钥匙被粗心的我弄丢了。

Бүтэц: А (家里的钥匙 гэрийн түлхүүр) + “BEI” (被)+ В (粗心的我 салан би) + VP (弄丢了 алга хийчихсэн.)

(2) 一个茶话会被他们开得冷冷清清。

Бүтэц: А (一个茶话 цайн дээр болсон яриа) + 被+ В (他们 тэд) + VP (开得冷冷清清 хүйтэн хөндий болж салав)

(3) 他被人赶出去了。

Бүтэц: А (他 тэр) + “BEI” (被)+ В (人 хүн) + VP (赶出去了 хөөж гаргасан)

(4) 他们被学生包围着，一边走，一边说。

Бүтэц: А (他们 Тэд) + 被+ В (学生 оюутнууд) + VP (包围着 тойрон бүчиж)

(5) 因为我从来没被人说服过。

Бүтэц: А (我 Би) + 被+ В (人 хүн) + VP (说服过 итгүүлж байгаагүй)

Дээрх жишээний 1-р өгүүлэхүүний бүрэлдэхүүнд үр дүнгийн нөхвөр гишүүн орсон бол 2-р өгүүлбэрийн өгүүлэхүүнийг боломж заасан нөхвөр гишүүн нэмэн дэлгэрүүлсэн байна. Харин 3-р өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүний бүрэлдэхүүнд чиглэл

заасан нөхвөр гишүүн багтжээ. 4, 5 өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүний араас “着” болон “过” гэсэн туслах үг орсон байна.

Бид орчин цагийн хятад хэлний “BEI” (被) бүхий өгүүлбэрийн дээрх бүтцийн монгол орчуулгыг харьцуулан шинжлэв.

2. Орчин цагийн хятад хэлний “BEI” (被) бүхий өгүүлбэрийн монгол орчуулгын харьцуулсан судалгаа

Орчин цагийн хятад хэлний “BEI” (被) бүхий өгүүлбэр нь угтвар үг бүхий бүтэцтэйн дээр хятад хэлний өвөрмөц өгүүлбэрийн нэг төрөл юм. Тиймээс уг өгүүлбэрийг монгол хэлнээ хэрхэн орчуулах боломжтойг нэрт орчуулагч Хасбуугийн орчуулсан “Шинэ орчуулсан Улаан асрын зүүд” (2009 уг бүтээлийг эрдэмтэн С.Хөвсгөл монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлсэн) болон “Хятадын орчин үеийн эмэгтэй зохиолчдын өгүүллэгийн дээжис” хэмээх түүвэр өгүүллэгийг орчуулсан нэрт орчуулагч М.Чимэдцэеэгийн орчуулгатай харьцуулан судлав. Ингэхдээ дээр өгүүлсэн орчин цагийн хятад хэлний “BEI” (被) бүхий өгүүлбэрийн ангиллын дагуу эрэмбэлэв.

- 1) А + “BEI” (被) + V бүтцээр илэрсэн өгүүлбэрийг монгол хэлэнд орчуулсан байдал

Хятад хэлний үйлийн хэв илэрхийлэх өгүүлбэрт багтах А “BEI” (被) BV хэлбэр дэх V буюу өгүүлэхүүн нь ардаа өгүүлбэрийн бусад гишүүнгүй байна. Энэ нь “BEI” (被) бүхий өгүүлбэрийн хэлбэр дотроо хамгийн энгийн бүтэцтэй өгүүлбэр байдаг. Уг өгүүлбэрийн орчуулсан байдлыг харвал:

- (1) 今日妙玉被劫. Эдүгээ Мяо Юй алдсанаас хойш (Цао Шюэчинь. 2019. 676:677)

Хятад өгүүлбэрийн “劫” гэсэн үйл үгийг “алдах” гэсэн монгол хэлний тусах үйл үгээр орчуулж үйлдэхийн хэвээр илэрхийлжээ.

- (2) 怕被人胳膊. Хүнд гижигдүүлэхээс айдаг байжээ. (М.Чимэдцэеэ. 2014. 42:43)

Дээрх хятад өгүүлбэрийн “怕” хэмээх гол үйл үгийг “айдаг” гэж эс тусах үйл үгээр орчуулан үйлдэхийн хэвээр харин “胳膊” гэсэн үгийг “гижигдүүлэх” хэмээн үйлдүүлэхийн хэвээр илэрхийлжээ. Энэ өгүүлбэрийн тус хоёр үйл үг нь эс тусах үйл үг тул үйлдэхийн хэвээр илэрсэн байна.

Уг хоёр жишээнээс үзвэл тус хоёр орчуулга дахь хятад хэлний А + “BEI” (被) + V бүтэцтэй өгүүлбэрийн үйл үгийг үйлдэхийн хэвээр илэрхийлэн орчуулжээ.

- 2) А “BEI” (被) BV “LE” (了) / “ZHE” (着) бүтэц бүхий өгүүлбэрийг монгол хэлэнд орчуулсан байдал

- (3) 幸亏宝玉被一个林黛玉缠绵住了. Хишгээр Бао Юй нэгэн Линь Дай юйд төөрөгдөн ороогдов.

Дээрх жишээний “缠绵住了” гэдэг үгийг “төөрөгдөн ороогдов” үйлдэгдэх хэвээр хэлбэржүүлэн өнгөрсөн цагийн “в” нөхцөл залган, үйлд өртөгчийн үйлийн өнгөрсөн цагийг илэрхийлсэн байна.

(4)...就再也不会被人盘问她们每天吃几顿饭了。

...өдөрт хэдэн удаа хооллодог тухай бусдад байцаагдахгүй болно.
(М.Чимэдцэеэ. 2014. 41:42)

Дээрх өгүүлбэрийн хураангуй бүтэц нь 被+В (人) + VP (问她们每天吃几顿饭了) юм. Уг жишээний “被人盘问” гэсэн үйлийн холбоо үгийн үйл үгийг “байцаагдахгүй” гэж үйлдэгдэхийн хэвээр илэрхийлжээ.

Уг хоёр жишээнээс үзвэл тус хоёр орчуулга дахь хятад хэлний А“BEI” (被) BV “LE” (了) / “ZHE” (着) бүтэцтэй өгүүлбэрийн үйл үгийг үйлдэгдэхийн хэвээр хэлбэржүүлэн орчуулжээ.

3) “А “BEI” (被) BVR” бүтэц бүхий өгүүлбэрийг монгол хэлэнд орчуулсан байдал

(5) 便伸手替他解衣,刚解开了钮子,被袭人将手推开,又自扣了. Даруй дээлийг нь тайлж өгөхөд сая нэгэн товч тайлтал, Ши Рэнь байг хэмээн гарыг түлхээд, мөнхүү өөрөө уг ёсоор товчлов. (Цао Шюэчинь. 2019. 94:95)

Хятад өгүүлбэр дэх “推开” гэсэн үр дүнгийн нөхвөр гишүүн бүхий үйл үгийг “түлхээд” хэмээн орчуулжээ. Монгол хэлэнд урьдчиллахын аад⁴ нөхцөл нь дараагийн үйлдлийг гүйцэтгэх урьдчилсан үйлдлийг илэрхийлдэг. Тус үйл үгийг монгол хэлнээ үйлдэхийн хэвээр хэлбэржүүлэн орчуулжээ.

(6) 这时,车身忽然悸动了一下,接着,车门被人关上了. Тэгтэл галт тэрэг чичирхийлэн хөдлөхтэй зэрэгцэн хүн хаалгыг нь тас хийтэл хаах нь сонстов.
(М.Чимэдцэеэ. 2014. 38:39)

“SHANG” (上) нь үр дүнгийн нөхвөр гишүүний үүрэг гүйцэтгэдэг агаад хавсрах, шүргэх гэх мэт үйлдлийг түлхүү заадаг. Хятад хэлнээ “被人关上了” гэсэн холбоо үгийг үгчлэн орчуулбал “хүнээр хаагдав” гэсэн санааг илтгэж байна. “被人关上了” гэсэн энэ хэлбэрийг монгол хэлээ р “хүн хаах” гэж үйлдэхийн хэвээр хэлбэржүүлэн орчуулжээ.

Уг хоёр жишээнээс үзвэл тус хоёр орчуулга дахь хятад хэлний “А “BEI” (被) BVR” бүтэцтэй өгүүлбэрийн монгол хэлний үйл үгийг үйлдэхийн хэвээр хэлбэржүүлэн орчуулжээ.

Дүгнэлт

Бид хятад хэлний “BEI” (被) бүхий өгүүлбэрийн А“BEI” (被) BV, А“BEI” (被) BV “LE” (了) / “ZHE” (着) / “GUO” (过), А “BEI” (被) BVR, А “BEI” (被) BVO гэсэн бүтэцтэй өгүүлбэрийг монгол хэлнээ хэрхэн буулгасныг Хасбуугийн орчуулсан “Шинэ орчуулсан Улаан асрын зүүд” болон М.Чимэдцэеэгийн орчуулсан “Хятадын орчин үеийн эмэгтэй зохиолчдын өгүүллэгийн дээжис” хэмээх түүвэр өгүүллийн орчуулгатай харьцуулан судлахад дараах үр дүн гарч байна.

- 1) А + “BEI” (被) + V бүтцээр илэрсэн өгүүлбэрийг тус хоёр бүтээлд монгол хэлний үйл үгийн үйлдэхийн хэвээр хэлбэржүүлэн орчуулжээ.
- 2) А“BEI” (被) BV “LE” (了) / “ZHE” (着) бүтэц бүхий өгүүлбэрийг дээрх хоёр бүтээлд үйл үгийг үйлдэгдэхийн хэвээр хэлбэржүүлэн орчуулжээ.
- 3) “А “BEI” (被) BVR” бүтэц бүхий өгүүлбэрийг бүтэцтэй өгүүлбэрийн монгол хэлний үйл үгийг үйлдэхийн хэвээр хэлбэржүүлэн орчуулжээ.

Эцэст нь дүгнэхэд хятад хэлний А“BEI” (被) BV, А“BEI” (被) BV “LE” (了) / “ZHE” (着) / “GUO” (过), А “BEI” (被) BVR, А “BEI” (被) BVO гэсэн бүтэцтэй өгүүлбэрийн эртний хийгээд орчин цагийн орчуулга ижилхэн байна.

Номзүй

Монгол хэлээр:

1. Хасбуу, Улаан асрын зүүд, 2013, Хөрвүүлсэн С.Хөвсгөл, УБ
2. Чимэдцэеэ, М, Халуун тогоо, 2014, УБ

Хятад хэлээр:

1. 王力,现代汉语语法,北京,商务印书馆,1985
2. 张延俊,汉语被动句历时研究,北京,中国社会科学出版社,2018
3. 刘承峰,中国语文,能进入“把 / 被”字句的光杆动词,北京,商务印书馆,2003
4. 陆俭明,有关被动句的几个问题,北京,语文出版社,2014

**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ОРЧУУЛГА**

ТӨВ АЗИД ДЭЛГЭРСЭН АЛЕКСАНДРЫН ТУУЖ^{97, 98}

Boyle, John Andrew (Манчестр)

Орчуулсан: Ц.Отгонсүрэн⁹⁹

Хянан зөвлөсөн: Б.Отгон¹⁰⁰

⁹⁷ 1972 онд Любект болсон Германы Дорно Дахины Нийгэмлэгийн хуралдаан дээр уншсан өгүүллийг дахин хянаж, засварласан эх юм.

⁹⁸ Эл өгүүллийг орчуулах явцад хийсэн тэмдэглэгээний талаар энд товч тайлбарласуу. Үүнд: 1. “1)” нь уг өгүүллийн зохиогчийн зүгээс тухайн бичвэрт холбогдох зүүлт, тайлбарт хийсэн тэмдэглэгээ болно; 2. “1)” гэсэн хөл тэмдэглэгээ (footnote) нь уг өгүүллийн орчуулагчийн зүгээс нэмэлт тайлбар (аль (монгол, англи) үгэнд тайлбар хийснээс хамааран үг тус бүрийн ард хөл тэмдэглэгээг хийсэн болно)-г өгсөн тэмдэглэгээ болно; 3. Оноосон нэр тус бүрийг галиглахдаа тухайн нэрийн холбогдох цахим бичвэрт тэмдэглэсэн дуудлагыг баримталсан бөгөөд ард нь хаалт “()” дотор уг эхийг хадгалах үүднээс өгүүлэл дэх тухайн оноосон нэрийн язгуур хэлбэрийг хэвээр нь бичиж, зарим нэр хийгээд хэрэг явдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүссэн судлаачид, уншигчдад зориулан хөл тэмдэглэгээг давхар хийж, холбогдох цахим хаяг болон бусад эх сурвалжийг оруулав; 4. Зарим эх сурвалж буюу зохиолын нэрийг орчуулж, уг өгүүллийн зохиогч үсгийн налуу хэлбэрээр ялган тэмдэглэсэн хийгээд оноосон нэр болон зарим тодотгол зэргийг том үсгээр тэмдэглэсэн, мөн түүнчлэн догол мөр, хоосон зай үлдээсэн зэргийг тус тус тэр хэвээр нь үлдээв.

⁹⁹ Доктор, МУИС, ШУС, ХУС-ын Их Британи, Америк судлалын тэнхим, <https://orcid.org/0009-0006-2843-9164>

¹⁰⁰ БНХАУ, Баруун Хойдын Үндэстний Их Сургуулийн Нийгмийн Шинжлэх Ухааны Сургуулийн профессор Б.Отгон (PhD)-ны удирдсан “*The major project of China’s National Social Science Fund: Translation and Comparative Study of Catalogues of the Mongolian Documents in Russian Collections* (Project No.18ZDA323)” төслийн хүрээнд Македоны Александр III (Аугаа Александр, НТӨ 365-323)-т холбогдох сурвалжууд болон баримт сэлтийн талаар дорно дахины судлаач, түүхч, Британийн эрдэмтэн JOHN ANDREW BOYLE (1916-1978)-ийн бичсэн эрдэм шинжилгээний өгүүлүүдийг орчуулан, зохиогчийн бичсэн он цагийн дарааллаар цуврал болгон хүргэж байгаагийн хоёр дахь нь болно. Эдгээр өгүүллийг орчуулах явцад холбогдох тайлбар, үг, хэллэг, нэр, нэршлийг орчуулж, галиглан буулгахад мэргэжлийн зөвлөгөө өгсөн МУИС-ийн, ШУС-ийн,

Берлин дэх Турфаны цуглуулгын гар бичмэлүүд дотор 14-р зууны эхэн хагаст эмхэтгэсэн буюу хураангуйлан бичсэн Александрын тууж¹⁰¹-ийн монгол хувилбарын нэгэн тасархай хадгалагддаг бөгөөд хожмоо нэрт монголч эрдэмтэн ПОППЕ (1957 онд)¹⁾, КЛИЙВЕЗ (1959 онд)²⁾ нар хянан найруулж, орчуулжээ.

Поппегийн үзэж байгаагаар “Александрын домог дундад зууны үеийн Европ, Африк болон Ази тивийн ард түмний дунд ихэд дэлгэрчээ. Эл домгийн этиоп, сири, араб, турк хэлээр бичсэн хувилбарууд өнөөг хүртэл үе уламжлагдан ирсэн ч монгол хэлээр бичсэн хувилбар байдаг тухай сонсож байсан удаагүй. Гэхдээ энэхүү хувилбараар (ч юм уу, бас өөр нэг хувилбараар ч байж болох талтай) дамжин хэдийнээ тархсан гэж үздэг. Тиймээс дээр дурдсан тэрхүү тасархайнуудад ач холбогдол асар их юм. Энэ нь Александрын домог монголчуудын дунд хэдийнээ танигдсанаас гадна монголын эртний уран зохиол бол бидний төсөөлж байснаас илүү өргөн цар хүрээг хамарч байсныг нотолж буй хэрэг юм.”³⁾

Гэхдээ энэхүү үнэт дурсгал, чухал баримт бидний үед бүрэн эхээрээ хадгалагдан үлдээгүй ч, Александрын тухай домог яриа Төв болон Зүүн Хойд Азид орж ирсэн гэх нотолгоо хангалттай байх агаад үүний нэг нь Александртай холбоотой домог яриа эрт цагаас нааш Түрэг, Монгол түмний үндэсний уламжлалд шингэсэн явдал юм. Уг үлгэр¹⁰²

ХУС-ын багш Б.Азаяа, Б.Арьяажав, Ц.Баттулга, Г.Бат-Учрал, С.Булгантамир, Н.Гэрэлмаа, Б.Пүрэвсүрэн, Г.Эрдэнэнаран нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

¹⁰¹ Англи хэлний “Romance” хэмээх үгэнд “1. ...; 2....; 5.Өнгөрсөнд болсон баяр жаргал, адал явдлыг магтан дуулсан үлгэр (*Oxford Advanced Learner’s Dictionary*, 2010)” гэх утга бий. Энэ үгийн монгол орчуулгыг шүүн үзвэл: 1. “1. ...; 4. Хүлэг баатрын/дайчин эрсийн туульс, роман” (*Oxford-Monsudar English-Mongolian dictionary*, 2004); “1. ...; 2. Адал явдал; ...” (Чинбат.Э, 2001); “1. ...; 2. Адал явдалт роман, дундад зууны үеийн баатар эрсийн туульс; 3. ...” (Ганхуяг.Ч, 2010) гэжээ. Харин “Романс” хэмээх нэр томъёог монгол хэлнээ: 1. “хөгжимтэй хамтран дуулах, уянгалаг аятай дуут хөгжим – энэ нь дуу, романс, найрал дуу, дуурийн ари гэх мэт (*Монгол хэлний их тайлбар толь*); 2. “Уянгал дуу” (Дулам. С & Хасбаатар. Ц, 1980); 3. “Хүүрнэл дуу” (Бадраа.Ж, 2017) гэх мэтээр оноожээ. Энэхүү орчуулгын утга уг эхийн агуулгатай төдийлөн дүйхгүй учир “Түүхэн үндэстэй хэрэг явдлыг уран сайхан оруулан хувиргаж бичсэн, томоохон хэмжээний шүлгээр юм уу үргэлжилсэн үгээр бичсэн зохиолыг хэлнэ (Ч.Билигсайхан)” (Мөнхбаяр.Б, 2011) гэснийг харгалзан “Тууж” гэсэн үгээр орчуулав.

¹⁰² Англи хэлний “story” гэх үгийг “1. Олон түмэнд танилцуулах зорилготойгоор зохиогч, өгүүлэгчийн хийсэн элдэв үйл явдал хийгээд хүмүүсийн тухай тодорхойлолт; 2. Хэн нэгэнд юу тохиолдсон тухай яриа; 3. Өнгөрсөнд болсон үйл явдал хийгээд хэрхэн өрнөсөн тухай хэрэг явдал; 4. ... ; 5. ” (*Oxford Advanced Learner’s Dictionary*, 2010) хэмээн тайлбарлажээ. Харин монгол хэлнээ “1. Явдал, хэрэг явдал; 2. Өгүүллэг, хүүрнэл, үлгэр; 3. Өгүүлэл; Зохиомол явдал; 4. Үйл явдал” (*Oxford-Monsudar English-Mongolian dictionary*, 2004); “1. Өгүүллэг, тууж; 2. ... ; 3. Түүх, үлгэр домог, үлгэр; 4. ... ; 5. Ярьсан зүйл, ам дамжсан яриа” (Чинбат.Э, 2001); “1. Үлгэр; 2.

(story)-ийг Несторын номлогчид¹⁰³ Төв Ази, Ойрх Дорнодод ирэхдээ авчирч, Александртай холбоотой Христийн домог⁴⁾-ийн хувилбар болгон түгээн дэлгэрүүлсэн байх магадлалтай бөгөөд энэ нь Ромын эзэнт гүрний зүүн хойд захаас холгүй нэгэн газар, 514 онд (магадгүй 515 онд) нэр нь үл мэдэгдэх зохиогч ертөнцийн төгсгөлийг зөгнөн бичсэн зохиол ажээ⁵⁾.

Александр хаан ширээнээ заларсны 2-р онд (7-р он байж болох талтай) энэ ертөнцийг бүхэлд нь таньж мэдэх зорилгоор нутгаасаа гарсан тухай уг домог (legend)-т өгүүлдэг. Зүүнш аялсаар тэрээр наран цаахантаа нь хөөрөх¹⁰⁴ нэгэн их далайд хүрч ирлээ. “Тэрхүү далайн чанадад нар мандах¹⁰⁵ -ын үест тэнд байсан хүмүүс уулсыг нүхэлж барьсан сууцандаа хэдэн зуу, хэдэн мянгаараа бүгж, зарим нь хэт халахаас айж ус руу орцгоож, бас нар гал адил төөнөх үед хүн, адгуусны алин болох нь үл ялгагдах нэг хэсэг нь газар түүрүүлгээ харан хэвтсэнтэй таарч байлаа”⁶⁾. Наран ургах¹⁰⁶ зүгт орших нэгэн улсын тухай өгүүлэх эл үлгэрийг Коран (The Quran¹⁰⁷) судар⁷⁾-т товч боловч дурдсан бөгөөд өөрөөр хэлбэл “задын чулуу¹⁰⁸ (rain-stone)”-ны уг гарвалийн тухай нэгэн домог (legend)-ийг Саманид (Sāmānid)-ын удирдагч Исмаил ибн Ахмад (Ismā‘īl ibn Ahmad)-ын цаг үед амьдарч асан Абу ал-Аббас Иса бин Мухамад ал-Марвази (Abu’l- ‘Abbās ‘Īsā b. Muhammad al-Marwazī)-ын даалгавраар 13-р зууны үеийн газарзүйч, Яахут (Yāqūt) тэнд

Өгүүллэг” (Ганхуяг.Ч, 2010) тус тус орчуулжээ. Дээрх тайлбар хийгээд орчуулга, мөн түүнчлэн эл өгүүлэлд дурдагдах “түүх (History)”-ээс ялгахын тулд ийнхүү “үлгэр” хэмээх үгээр буулгав.

¹⁰³ Энэхүү үг эл өгүүлэлд хэдэнтээ гарах агаад тодорхой, ойлгомжтой болгох үүднээс хамгийн эхэнд дурдсаныг “Христийн шашны” хэмээн тодотгосон бөгөөд энэхүү орчуулгад ийнхүү “Несторын номлогчид” гэнэ.

¹⁰⁴ Англи эхэд буй “rise” гэх үгийн тайлбарыг мөшгөн үзвэл “1. Байгаа байрнаасаа өөдөө чиглэх, өөдөө хөөрөх; 2. Босох, өндийх өөдлөх; 3. Нар, сар тэнгэрийн хаяанаас дээш гарч ирэх; 4.” буюу “хэвтээ тэнхлэгийн байранд байх юмс босоо байрлалд очих; доор байх зүйлс дээшээ, өөдөө болох” (*Oxford Advanced Learner’s Dictionary*, 2010) гэсэн ерөнхий утгыг нь гол болгож, энд наран өөдөө нэлээд гарчихсан тэр цаг үеийн тухай өгүүлж буй тул ийн “хөөрөх” хэмээх үгийг сонгов. Энэ нь могой цаг буюу 09:40-11:40 хүртэлх цаг аж. (Дулам.С, 2018b:105–143).

¹⁰⁵ “Наран мандах” цаг гэдэг нь 07:40-09:40 хүртэлх луу цаг (Дулам.С, 2018b:105–143).

¹⁰⁶ Наран газар дороос дөнгөж гарах буюу уулын цаанаас дөнгөж цухуйж буй мэт аажим мандах тул Монголчууд “ургах наран” гэх мэтээр хэлэлцэж, бичиж ирсэн уламжлал (Igor de Rachewiltz, 1972, 2013, 9603-р зүйлүүд)-ыг баримтлан ийнхүү “ургах” хэмээх үгийг энд сонгон хэрэглэв. Эл нь 05:40-07:40 цагийн хооронд аж (Дулам.С, 2018b:105–143). Гэвч энэ “наран хөөрөх”, “наран мандах”, “наран ургах” гэх хэлцүүд цаг хугацаа, орон зайн хувьд өөр хоорондоо ялгаатай тул эл өгүүллийн орчуулгад эдгээрийг ялгаж ойлгохыг дашрамд дурдахад илүүдэх юун.

¹⁰⁷ (*The Holly Quran*, 2000)-аас дэлгэрэнгүйг үзнэ үү.

¹⁰⁸ 1. Монголчууд гурвалжин гилбэр дүрстэй, эсвэл өндгөлжин хэлбэртэй, улаан хүрэн, улаавтар шар, хар өнгөтэй том нь нударган чинээ цахиурлаг чулууг «задын чулуу» гэдэг байжээ (Болдбаатар Ю, 2008:32); 2. Шинэ чулуун зэвсгийн үед холбогдуулж үздэг бүх талаас нь уртааш ялтас цуулж авдаг асан нэгэн зүйл шовх үлдцийг монголчууд «задын чулуу» хэмээн нэрлэж иржээ (Гонгоржав.Г, 2005:17).

оруулжээ. Огуз (Oghuz)-ын ханхүү “өөрийн өмнөх үеийн нэг өвөг нь эцэгтэйгээ зөрөн байж зүүнш зорчиж, нэгэн газар хүрч ирээд, нутгийн ардаас “нэгэн уул хаасны учир энэ газраас цааш явах боломж үгүй юм” хэмээн сонссон” тухай Абу ал-Аббас Иса (Abu'l-'Abbās 'Īsā)-ийн хүмүүс¹⁰⁹-г нэгэнтээ хүүрнэсэн байдаг. Тэдний хэлснээр “тэрхүү уулын цаанаас наран мандах агаад тэр нь газар дэлхийтэй ойр тул, халуу шатахгүй газар гэж үгүй” аж. Харин ханхүүгийн өвөг “Тэнд хүн, амьтан байдаг уу?” хэмээн асуухад “Байдаг” гэж тэд хариулжээ. Тэрээр мөн “Та нарын хэлсэн шиг тийм нөхцөлд тэд яаж амь зууж, аж төрдөг вэ” гэхэд “Газрын доогуур хонгил, уулын гүнд агуй байх агаад наран мандахын үест хүмүүс тэнд бүгж, шингэх¹¹⁰-ийн цагт тэндээсээ гарч ирдэг. Харин амьтад чулуу авч зогсдог нь туйлын хачирхалтай агаад үүний учрыг мэдэх чин хүслийг төрүүлжээ. Тэр амьтад бүгд нэг нэг чулуу авч, амандаа зуугаад, толгойгоо тэнгэр өөд өлийлгөн, өөрсдийгөө сүүдэрлүүлнэ. Удалгүй нэг хэсэг үүл хуралдаж, тэднийг нарнаас халхалдаг” гэж хариулжээ. Түрэгийн ханхүүгийн өвөг мөнөөх улсад нэвтэрч, сонссон бүхэн нь үнэн болохыг олж үзэв. Тэрээр дагалдан яваа хүмүүсийн хамт мөнөөх амьтад руу дайрч, чулуунуудыг нь авч цуглуулан, даах хэмжээгээр өөрийн улс руу зөөн аваачиж, тэр цагаас хойш өнөөг хүртэл хадгалсаар ирсэн бөгөөд цас бороо оруулахад хэрэглэж байжээ⁸).

Жон де Плано Карпини (John de Plano Carpini)-ийн “Монголчуудын түүх (Ystoria Mongalorum)” номдоо тодорхойлсончлон, тэрхүү “наран ургах зүгийн газар” гэдэг нь Чингис хааны байлдан дагуулж асан улсуудын нэг юм. Эл түүхийг “Татар¹¹¹-чуудын Харилцаа (The Tartar Relation)”⁹) нэртэй Жорж Д.Пэинтер (George D.Painter)-ийн саяхан нягтлан шүүж, орчуулсан зохиолын сонирхолтой хэсгийг нэмэлт болгон оруулсан хувилбараар ярих болжээ.

Чингис¹¹² (Chingis) цэргүүдийн хамтаар дүрвэж, баруунтаах уулсаас умарш чиглэн одов. Гурван сар тасралтгүй цөлөөр явсны эцэст цэргүүдэд хоол хүнс хомстсон учир арван цэрэг тутмын нэгийг идэх зарлиг буулгажээ. Тэд ийнхүү гурван сарын турш явсаар Нара иргэн (Naraygen) буюу Нарны хүмүүс (Nara гэдэг нь “Нарны Татарчууд”, харин Irgen гэдэг нь “Иргэн” гэсэн утгатай) гэсэн нэртэй газар сүндэрлэх уулсын дунд хүрэлцэн ирлээ. Тэр газар хүрээд нэг ч хүнтэй таарсангүйд ихэд гайхав. Гэтэл удаж төд удалгүй эхнэртэйгээ яваа

¹⁰⁹ Мэдээлэгчид

¹¹⁰ Наран шингэх цаг гэдэг нь тахиа цаг буюу 17:40-19:40 бололтой (Дулам.С, 2018b:105–143). Харин “наран шингэхийн урьдах цаг” гэх мэт хэллэг монголын уран зохиолуудад нэлээн дурдагдсаны нэгэн жишээ бол Монголын Нууц Товчоо (Igor de Rachewiltz, 1972, 2034, 4038, 5537, 6720, 8933, 10729, 11650-р зүйл) юм.

¹¹¹ “Тартар” буюу “Татар” гэх нэрийн тухай дэлгэрэнгүйг (Монголын эртний түүх, 2017:25–63)-ээс үзнэ үү.

¹¹² Энд зохиогч Чингис (Chingis) хэмээн бичиж, харин дараа нь Чингис хан (Chingis Khan) гэж тэмдэглэснийг уг эхийг хаалтад оруулж, тэр хэвээр нь үлдээв.

нутгийн нэгэн эртэй таарч эл нутгийн иргэд хааш одсоныг асуун шалгааж, тэд ууланд нүхэн гэр (буюу өрх)¹¹³ барьж суудаг талаар олон зүйлийг мэдэж аваад, “тэндээсээ гарч дайтах санаа бий эсэхийг асуулгахаар эмийг нь дэргэдээ олзлон авч үлдээд, мөнөөх эрийг илгээв. Тэр эрийг буцах замд наран мандах дуунаар татарчууд түрүүлгээ харан газар үхэтхийн унаж, олон хүн тэр дороо амьсгал хурааж байлаа. Тэдгээр нутгийн уугуул иргэд цэргүүдтэй тулгарч, шөнө дүлээр тэдэн рүү дайрч, маш олон татар иргэнийг хороожээ. Чингис хан (Chingis Khan) амьд үлдсэн хэдтэйгээ дутаахдаа олзолсон эхнэрийг нь хамт авч одов.

Тэдгээр татар иргэн өөрсдөө христийн шашны санваартан (friars) нарт хэлсэн учраас тэрхүү эм эцэстээ удаан хугацаагаар тэдэнтэй үлдэж, өмнө өгүүлж байсан улс энэ ертөнцийн хязгаарт бий, түүнээс цааш (хуурай)¹¹⁴ газар үгүй зөвхөн их далай л бий хэмээн эргэлзэх зүйлгүйгээр итгэл дүүрэн хэллээ. Нарантай ихэд ойр тул мандах тэр агшинд нэн ялангуяа зуны улиралд тэр мэт байгалийн болоод асар их хэмжээний хүчтэй дуу, нүжигнээн тийн сонсогддог аж. Энэ нь наран, тэнгэр хоёрын эсрэгцлээс үүдэлтэй бөгөөд наран нь нарны замаар дайран өмнөш эргэх хүртэл хэн ч байсан гадаа ил задгай газар байхын арга үгүй, түүнээс болоод шууд амиа алдаж мэдэх, эсвээс цахилгаанд цохиулсан мэт гэмтэж бэртэх аюултай. Тиймээс иргэд уулын агуй дотроо том хэнгэрэг болон бусад зэмсэг дэлдэж, тэдгээрээс гарах дуу чимээгээр нарны тэр их дууг дардаг. Энэ нутагт тэгш тал зонхилох бөгөөд хөрс нь үржил шим сайтай. Уулс нь хөндөлдөн тогтсон ч төдийлөн сүрлэг том биш юм.

Карпини бээр маш товч бичсэнээс төдийлөн зөрүүгүй энэхүү хувилбарт эл үлгэрийг Монголчууд үе дамжуулан хэлж ирсэн бөгөөд үүнийг Нарайргэн (Narayrgen (буюу наран ургах зүгийн газарт өгсөн “Нарны иргэд” гэсэн нэр)) гэх Монгол нэрээр нь баталж болохыг онцгойлон дурджээ. Япон (Jih-pen kuo (country of the source of sun (нарны эх болсон улс))) улсад өгсөн Хятад-Япон нэрийг монгол хэлэнд шууд буулгасан “кальк” орчуулга болох Нарайргэн (буюу Narayrgen) гэх нэрийг Профессор Д.Синор (Denis Sinor) сонирхон судалсан байдаг¹⁰). Энэ мэт тайлбарыг зөвхөн Карпинийн тэмдэглэсэн үлгэрийн хувьд үнэмшилтэй хэдий ч Бридиа (de Bridia)-ийн өгүүлсэн үлгэрийг Монгол уг эхээс нэлээд холдсон гэж үздэг. Гэвч “нарны иргэд (people of the sun)”-ийг “задын чулуу”-ны уг гарвацийн талаар өгүүлэх Христийн Домог (Christian Legend), Коран болон

¹¹³ “Монгол гэрийн сүлд гэгддэг “өрх” хэмээх үгийн гарал нь “erü-ke” буюу “erü-” (эрэ-, малта-) хэмээх үйл үгийн язгуураас үүссэн “малтмал”, “малтмал гэр”, “малтмал нүхэн гэр” гэсэн утга бүхий “erüke” гэдэг үг болох талаар манай хэл шинжлэлчид, үгийн гарал судлаачид [Б.Ринчин нар] нэгэнт тогтоожээ” (Дулам С. 2018а: 213–217).

¹¹⁴ Англи хэлний “land”, монгол хэлний “газар” хэмээх үгнүүд олон утгыг илэрхийлдэг тул илүү тодорхой болгох үүднээс ийнхүү нэмж оруулав.

10-р зууны үеийн Огузын Домог (Oghuz Legend)-т дүрсэлсэн, агуйд амьдардаг ер бусын шидтэй, балар эртний хүмүүс гэж үздэг.

Зүүнш, Баруунш зорчсон Александрын аялал түүнийг Дул-Харнайн¹¹⁵ (Dhu‘l-Qarnain) буюу “Хоёр эвэрт (The Two-Horned)” гэх нэрийг авахад хүргэсэн эсэхийг таахад нэн бэрх. Харин түүний дараа Умарш зорчсон бөгөөд энэ аялал нь түүний Гог, Магог¹¹⁶ (Gog and Magog)-ийн иргэдийг дотогш нэвтрүүлэхгүй хаалт болгож, уулын хавцлыг битүүлэх гэж төмөр, гуулиар хаалга хийлгэж байсан цаг хугацаатай давхцах агаад тэрхүү хаалгыг барих үйл явцыг дараах байдлаар дүрслэн бичжээ¹¹⁷.

“... Тэрээр (буюу Александр) чадварлаг гар урлаачдыг дэргэдээ байлгаж, тэрхүү сайн чанарын төмөр хаалгыг хийлгэж байсан (гурван мянган дархан бас тусдаа гуулин хаалгыг хийж байв) бөгөөд тэдгээр гурван мянган урлаачийн дундаас нэлээд хэдийг сонгож, хамтдаа аварга биетэй амьтны арьсыг өвчиж авав. Тэдгээр арьсаар дархны тулман хөөрөг хийж гал гаргаад, тэр галд гууль, төмөр хоёулыг нийлүүлж хайлуулав. Яг нэг хүн шавар зуурч буй мэт нэг металлыг нөгөөтэй нийлүүлэн холино. Тэгээд арван хоёр тохой өргөн, мөн тийм хэмжээний өндөртэй хаалга, дараа нь том босго хийлгэж, хоёр уулын дунд босгосон хаалганыхаа доор мөнөөх босгоо байрлуулжээ. Түүнийгээ газар ухан суулгаж, дээрээс нь төмөр, гуулины хайлмалаа урсгана. Төмөр, гуулин оньснуудыг босгоныхоо дээд доод талд нь тогтоолгов. Ийнхүү суурилуулж дуусгаад хаалгаа хаах зарлиг буулгажээ. Дараа нь тус бүрдээ арван хоёр тохой урттай хоёр оньс хийлгэж, хоёр уулын зүг аваачин, хаалгандаа чагтлахыг (дархнуудад) зарлиг болгож, түүндээ зориулан нугас хийлгэв.”

Бид Монгол үндэстэн үүсэн бүрэлдсэн хийгээд дахин хүчийг олсон тухай Эргэнэ Хун¹¹⁷ (Ergene Qun)-ийн домогт гардаг хэсгүүдийг эргэн сануулъя. Энэхүү домгийг Персийн түүхч Рашид ал-Дин (Rashīd al-Dīn) маш дэлгэрэнгүй өгүүлжээ¹². Рашид ал-Дины цаг үеэс даруй 2000 орчим жилийн тэртээ Монголчууд бараг бүгд хөрш зэргэлдээх овог аймгуудтайгаа хийсэн тулаанд ялагдан, ердөө хоёр эр эхнэрийн хамт амь гарч, “Эргэнэ Хун” хэмээн нэрлэгддэг, сүрлэг сайхан уул, битүү ургасан ой модоор тал бүрээрээ хүрээлэгдсэн, үржил шимт нэгэн сайхан хөндийд толгой хоргодон амь зуух болжээ. Цаг хугацаа өнгөрсөөр тэдний хойч болох Нэгүс (Negüs), Хияан (Qiyān) нэртэй хүүхдүүд өсөж үржин, мөнөөх хөндийдөө багталцахгүй болтлоо дүүрч, дараа нь тэндээсээ гарч

¹¹⁵ Монголчуудын дунд Сулхарнайн гэх нэрээр алдаршсан бөгөөд “Арабын Цүл харнайн буюу Дул харнайн хэмээх үг монгол хэлэнд сунжраад Сулхарнай болжээ. Утга нь хоёр эвэрт хэмээсэн үг. Араб нар Македоны Александрыг чингэж нэрлэдэг байжээ” (Дамдинсүрэн.Ц, 2017:180–192).

¹¹⁶ Зарим бичвэрт Мэигог гэж галигладаг хэдий ч Магог (*Ариун Библи*, 2013: 9); Магог (*Библи*, 2015: 41); Магог (буюу *マゴグ* (Magogu)) (*Bilingual Bible*, 1984:10) (The Old Testament)) зэргийг харгалзан “Магог” гэв.

¹¹⁷ Эргэнэ гүнгийн домог ч гэж бас хэлдэг.

шинэ нутагт бууя хэмээн цугаар ярилцаж тогтов. Тэрхүү уулсын нэгээхэн хэсэгт төмрийн уурхай байх агаад их хэмжээний мод, модны нүүрсийг цуглуулаад, уурхай байрлах эгц эргэцгийн хормойд аваачиж хураав. Дараа нь тэд далан үхэр, адуу нядалж, арьс ширээр нь мөн тооны дархны тулман хөөргийг хос хосоор нь хийв. Хураасан мод, модны нүүрсэндээ гал өрдөн, нөгөө далан хос хөөргөө нэгэн зэрэг үлээж, тэр их галд төмрийн хүдрээ хайлуулж урсган, шуудуу гаргаж, түүгээр уруудан тал нутаг руу урсгаж, нүхэн хоолой гаргав.

Тэдний соёлд байдгийн адил, Эргэнэ Хунгийн домог (The Ergene Qun legend)-ийг Монголчууд өөрсдийн Түрэг¹¹⁸ (Turkish) угсаатны өвөг дээдсээс уламжлан авч дамжуулсан бололтой. Хятадын түүхчдийн өгүүлсэнчлэн, Хөх түрэг (T'u-chüeh)-ийн уламжлалд уулын агуйн талаар хүүрнэх бөгөөд өөрсдийн анхны өвөг дээдэс болох бөрт чоно гэргийн хамтаар дайснаасаа дутааж, оромж хайн тэр агуйд ирсэн тухай өгүүлдэг. Тэр агуйгаар дамжин тэд хэдэн зуун мод талбай эзлэх, өвс ногоо жигдэрсэн тал сайхан газар одож, тэндээ хэдэн үеэрээ нутаглаж, эцэс сүүлдээ Алтайн өвөр биед очиж суурьшив¹³). Уулсын дунд айх аюул үгүй, амар тайван сууж асан Түрэг угсаатны өвгийг Несторын номлогчид Гог, Магогийн үндэстэн хэмээн үзсэн нь үндэслэл муутай ч, үгүйсгэж бас болмооргүй таамаглал юм. 13-р зууны үеийн монголчуудыг ийнхүү тэр иргэдтэй адилтгасныг бид өнөө цагт буй сурвалжуудаас мэдэх боломжтой. Европын аялагчдын бичсэнийг эс тооцвол, 1257 онд бичиж дуусгасан Садийн Бустан (Būstān of Sa'dī)-аас бид эш татаж болно. Тэрхүү зохиолоо Александр болон түүнийг бишрэн дагалдагч Атабег Абу Бакр (Atabeg Abū Bakr)-ын бичсэнээс арай өөрөөр буюу дараах байдлаар тэмдэглэжээ.

Александр гууль болон чулуугаар хана босгож, Гогийг энэхүү ертөнцөөс тусгаарлав. Тэрс үзэлт Гогийн эсрэг таны босгосон хана Александрын босгосон ханатай адил гууль биш харин алт билээ¹⁴).

Төмөр хайлуулсан үйл явцын тухайд, Эргэнэ Хунгийн үлгэр (Ergene Qun story) болон төмрийн дарх хийхээр Жужан (Juanjuan)-ыг зорьсон (Тэр цаг үеэс хойш тэд уулнаас бууж, Жужанчуудыг довтолж, нутгаас нь хөөн гаргажээ) Хөх түрэгүүдийн гүйцэтгэсэн үүргийг бэлгэдэн бичсэн Түрэгийн домог (Turkish legend) хоёр хоорондоо зөрүү үгүй юм. Нөгөө талаас авч үзвэл, энэ нь Гог, Магогийн иргэд эцэстээ Александрын босгосон төмөр, гуулин хаалгаар нэвтрэн орж, “аварга биетэй араатан амьтан”-ы арьсаар хийсэн тэр том

¹¹⁸ Өдгөө Түрэг судлал (Turkic studies or Turkology), Турк судлал (Turkish studies) нь судалгааны хамрах хүрээгээрээ ялгаатай тул тусдаа, бие даасан салбар болглоо хөгжиж, ийнхүү ялгаатай нэрлэгдэж хэвшжээ. Харин эл өгүүллийг бичиж хэвлүүлж байсан цаг үед ингэж ялгамжтайгаар авч үздэггүй байсан бололтой. Тиймээс зохиогчийн хэрэглэсэн “Turkish” гэх нэрийг түүний агуулгыг нь харгалзан “Түрэг”, мөн хойно өгүүлэх “Turks” гэх нэрийг “Түрэгүүд” хэмээн тус тус орчуулав.

дархны тулман хөөргийг бүтээсэн уран дархнуудын нэгэн адилаар өөрсдийн зорилгоо хэрэгжүүлжээ.

Александр цааш умарш одож, Харанхуйн Орон ((the Land of Darkness) энэ нь дундад зууны үед, магадгүй түүнээс ч өмнөх цаг үед одоогийн Оросын Хойно буюу Хойд туйлын наахна орших бүс нутагт өгсөн нэр байж болох юм.)-ны захад тулж ирэв. Аюулгүй буцаж ирэхийг бодолцон, бүгд хөхүүл унагатай гүү унаж, тэндээс дотогш нэвтрэхийг нутгийн уугуул иргэд тэдэнд зөвлөжээ. Учир нь нялх унагаа үлдээсэн гүү ямар ч тохиолдолд замаа олоод буцаж ирдэг аж¹⁵⁾. Энэхүү үлгэр Огуз Түрэгүүд (Oghuz Turks)-ийн өөрийн нь нэрээр нэрлэсэн Огузын Домог-ийн Рашид ал-Дины бичсэн хувилбарт бий. Огуз болон дагалдан яваа хүмүүс цугаар Харанхүлүг (Qaranghuluq) буюу нөгөө Харанхуйн Оронд нэвтэрч, унагануудыг нь хилийн заагт зэллэж орхиод, 4 гүү, 9 дудрай¹¹⁹⁾ унаж очив¹⁶⁾. Энэ тухай Марко Поло (Marco Polo)-ийн зохиолд ч бас тэмдэглэгдэн үлджээ. Тэрээр Цагаан Ордны нутаг (буюу одоогийн Төв Казакстан) буюу Кончийн хаант улс (Conchi's kingdom)-аас умарш нэлээд алсад орших “Харанхуй” хэмээх нэртэй газрын талаар өгүүлжээ. Мөн түүнчлэн тэрээр хэрвээ энэ үнэн бодитой байсан бол “наран үгүй, саран үгүй, одод бас үгүй... харуй бүрийд буй мэт зөвхөн харанхуй бүчих” энэ оронд Татарчууд хэрхэн нэвтрэн орж ирэх билээ? хэмээн хүүрнэсэн гэдэг. Түүний хэлснээр тэд унагатай гүү унаж, унагануудыг нь энэ газрын захад үлдээн нутгийн гүн рүү явлаа. Тэдгээр гүү өөрсдийн унагандаа заавал ирэх учраас буцах замаа хэн хүнээс илүү сайн мэдэх ажээ¹⁷⁾.

Энэхүү үлгэрийн талаар хэлэхэд, “Рашиддын Огуз-Намэ (Oghuz-Nāma)-д гардаг үйл явдал үүнийг маш эртнийх гэдгийг батлах биз ээ” хэмээн Юүлэ (Yule)-ийн хэлсэнтэй санал нийлэхгүй гэдгээ Пеллио (Paul Pelliot) илэрхийлсэн байдаг. Тэрээр “Рашиддын өгүүлсэн нь Мусулман¹²⁰⁾ шашны нөлөөгөөр нэлээд дэлгэрсэн бөгөөд Огуз-хан (Oguz-khan)-ны Уйгурын домог (Uighur legend)-т Харанхуйн орны талаар нэг ч үг дурдаагүй юм. Тэрхүү домгийг бичсэн цаг хугацаа Рашиддын цаг үеэс төдийлөн эртгүй ч, бичихдээ Мусульман шашны үзэл санааг огт тусгаагүй. Мөн түүнчлэн Рашид, Поло хоёул үнэн хэрэгтээ шууд биш ч Александрын туужийн боловсронгуй болгосон Дорнын хувилбарыг эх сурвалжаа болгосон юм”¹⁸⁾. Хүмүүс энэхүү гаргалгааг хүлээн зөвшөөрөх ч дахин засварласан Мусульманы нэгэн хувилбарт “Александрын домгийг Түрэгүүд бас Монголчуудад хүргэсэн” хэмээн шууд дүгнэснийг дагахад нэн бэрх. Тиймээс миний бие “энэхүү Харанхуйн оронд хүрсэн тухай үлгэр нь наран ургах зүгийн ард түмний түүх болон төмөр, гуулин хаалганы тухай үлгэрийн нэгэн адил, Төв Азийн ард түмний тогтсон уламжлалд өөрийн байр суурийг эзлэх болсон нь Несторийн номлогчид тэдгээр улсад орж ирснээс үүдэлтэй” гэсэн нэгэн саналыг дэвшүүлж байна. Мөн түүнчлэн Рашид-ал-Дин төдийгүй 11-р зууны үеийн толь зүйч Кашгарын Махмуд (Mahmūd al-

¹¹⁹⁾ Эм илжиг (Монгол хэлний их тайлбар толь, буюу <https://mongoltoli.mn/dictionary/detail/35287>)

¹²⁰⁾ Зохиогч Musulman, Muslim, Islam хэмээн бичсэнийг тохиолдсон газар бүрд уг эхээр нь үлдээв.

Каӡгагӡ) болон исламын шашинд орсон 10-р зууны үеийн нэгэн Зороастр (Zoroastrian)¹⁹⁾-ийг баримтлагч Ибн ал-Мухафа (Ibn al-Muqaffa)-ийн зөвшөөрлөөр Гардиз (Gardīz)-ийн өгүүлсэн задын чулууны уг гарвацийн талаарх нэгэн домогт гардаг, Түрэгийн өвөг болох Иафет (Japhet)¹²¹-ийн талаар дүрслэн бичсэнийг “*Муслимын гэхээсээ илүү Христийн шашны нөлөө байна*” гэсэн бас нэгэн зүйл санал гаргаж байна.

Зүүлт, тайлбар

- 1) Nicholas POPPE, Eine mongolische Fassung der Alexandersage (Александрын туужийн монгол хувилбар), ZDMG (Zeitschrift der Deutschen Morgenländischen Gesellschaft), CVII, 105-129-р тал
- 2) Francis W. CLEAVES, An Early Mongolian Version of the Alexander Romance (Александрын туужийн эрт үеийн Монгол хувилбар), HJAS (the Harvard Journal of Asiatic Studies), XXII, 1-99-р тал
- 3) Eine mongolische Fassung... (Александрын туужийн монгол хувилбар), 105-р тал
- 4) Энэ зохиолын англи орчуулга. E.A.Wallis BUDGE, The History of Alexander the Great (Аугаа Александрын түүх), (Cambridge, 1889), 144-158-р тал.
- 5) Theodor NÖLDEKE, Beiträge zur Geschichte des Alexanderromans (Александрын туужийн түүхэнд оруулсан хувь нэмэр) зохиолыг үзнэ үү, Denkschriften der Kaiserlichen Akademie der Wissenschaften, philologisch-historische Klasse, XXXVIII (1890), Abhandlung V, 31.
- 6) BUDGE, The History of Alexander the Great (Аугаа Александрын түүх), 148-р тал.
- 7) xviii, 88-89-р тал: “Дараа нь тэрээр [Dhu’l-Qarnain] нэгэн замыг дагаж явсаар наран ургах газар хүрээд, хүмүүсийн дээр наран мандахыг олж үзээд, түүнээс халхлах зүйл тэдэнд үгүй болохыг мэджээ.”
- 8) J.A.BOYLE, Turkish and Mongol Shamanism in the Middle Ages (Дундад зууны үеийн Түрэг, Монгол бөө мөргөл) зохиолыг үзнэ үү, Folklore, LXXXIII, 177-193 (187-188)-р тал.
- 9) R.A.SKELTON, Thomas E.MARSTON, George D.PAINTER, The Vinland Map and the Tartar Relation ((Винландын газрын зураг ба Татарчуудын харилцаа), (New Haven and London, 1965)), 21-106 (64-66)-талыг үзнэ үү. Карпинийн хувилбарт байхгүй үг, хэллэг, зарим тохиолдолд бүтэн өгүүлбэрийг ялгахын тулд Пэинтер үсгийн налуу хэлбэрийг сонгон хэрэглэжээ. Карпинийн хувилбар дахь тэдгээртэй дүйхүйц бичвэрийн латин эхийг сонирхож байвал A.van den WYNGAERT, (Sinica Franciscana (Францискана урсгалыг баримтлагч дорнынхон), I (Quaracchi-Florence, 1929), 62-63-р тал)-ыг үзнэ үү. Мөн англи орчуулгыг сонирхож байвал Christopher DAWSON, The Mongol Mission ((Монгол Элч), (London, 1955),) 24-25-р талыг үзнэ үү.

¹²¹ Зарим бичвэрт “Жеифет” гэсэн хувилбар байх хэдий ч “Иафет” (*Ариун Библи*, 2013:10); “Эфээт” (*Библи*, 2015:41); “Яапет” (буюу *ヤベテ* (Yapete)) (*Bilingual Bible*, 1984:10) (The Old Testament)) зэргийг харгалзан “Иафет” гэж галиглав.

- 10) Denis SINOR, Mongol and Turkic Words in the Latin Versions of John of Plano Carpini's Journey to the Mongols (1245-1247) ((Плано Карпиний Монгол руу хийсэн аялын латин хувилбар дахь монгол, түрэг үгс), Л.Лигети (Louis LIGETI) хянан найруулав, *Mongolian Studies* (Amsterdam, 1970) 537-551 (542-545)-р тал).
- 11) Миний бие Христийн Домог (Christian Legend)-оос бус өдгөө хадгалагдаж үлдээгүй араб хувилбар дээр тулгуурлан бичсэн Александрын туужийн Этиоп хувилбараас эш татсан. Учир юу хэмээвээс, Коран ((the Koran) (xviii. 88-89)) болон Эргэнэ Хунгийн домог (хойно өгүүлнэ, 269-р тал)-оос гадна Домог (Legend)-ийн уг эхэд лавтайя өгүүлэх дархны тулман хөөргийг хэрхэн хэрэглэх талаарх тайлбар сэлт багтсанд оршино. Мөн энд эш татсан хэсгийг Е.А. Wallis BUDGE, The Life and Exploits of Alexander the Great ((Аугаа Александрын туулсан амьдрал, байгуулсан гавьяа), (London, 1896), I, 237) зохиолоос харж болно.
- 12) Sbornik Letopisei (Судрын чуулган), I/1, L.A. KHETAGUROV (Moscow-Leningrad, 1952) орчуулав. 153-154-р тал.
- 13) LIU MAU-TSAI, Die chinesischen Nachrichten sur Geschichte der Ost-Türken (T'u-küe) (Зүүн Түрэгийн түүхийн талаарх Хятад мэдээ), (Wiesbaden, 1958), I, 40.
- 14) E.G. BROWNE, A Literary History of Persia (Персийн утга зохиолын түүх), III (Cambridge, 1928), 16-р тал.
- 15) Эл түүх утгаа Сюүдө Келистенийз (Pseudo Callisthenes)-ээс уламжлагдан ирсэн. Тиймээс Христийн Домог-ийн үргэлжилсэн үгийн төрлөөр бичсэн хувилбарт багтаагүй ч Сирийн яруу найрагч Сару (Saruq, 521 онд таалал төгссөн)-ын шүлгийн хэмнэлээр бичсэн хувилбарт бий. NÖLDEKE-ийн “Beiträge... (Александрын туужийн түүхэнд оруулсан хувь нэмэр)”-ээс харна уу. 30-р тал.
- 16) Karl JAHN (орчуулав), Die Geschichte der Oguzen des Rašid ad-Dīn (Рашид ал-Диний бичсэн Огузын түүх), (Vienna, 1969), 26-р тал.
- 17) L.F. BENEDETTO (орчуулав), The Travels of Marco Polo (Марко Пологийн аялал), (London, 1931) 387-р тал.
- 18) Paul PELLIOT, Notes on Marco Polo (Марко Пологийн тухай тэмдэглэл), II (Paris, 1963), 618-р тал.
- 19) BOYLE, Turkish and Mongol Shamanism (Түрэг, Монгол бөө мөргөл), 186-187-р тал.

Орчуулахад ашигласан хэрэглэгдэхүүн

Монгол хэлээр

1. *Ариун Библи.* (2013). Ариун Бичээс Нийгэмлэг.
2. Бадраа.Ж. (2017). *Судлах, сургахын арга ухаан.*
3. *Библи.* (2015). Монголын Библийн Нийгэмлэг.
4. Болдбаатар Ю. (2008). *Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн задын шүтлэг.*
5. Ганхуяг.Ч. (2010). *English-Mongolian Dictionary.* Улаанбаатар.

6. Гонгоржав.Г. (2005). *Монголчуудын чулуун өв соёл*. Улаанбаатар.
7. Дамдинсүрэн.Ц. (2017). *Сулхарнайн тууж: Vol. IV боть*. МУИС-ийн Монгол Судлалын Хүрээлэн, МУИС-ийн Түүхийн Тэнхим, ШУА-ийн Түүх Археологийн Хүрээлэн. Улаанбаатар.
8. Дулам. С, & Хасбаатар. Ц. (1980). *Уран зохиолын онолын үүд*. Улаанбаатар.
9. Дулам.С. (2018а). “*Eriike*” хэмээх үгийн гарал хийгээд утга бэлгэдэл: *Vol. I (IV)боть*. МУСУИС. Соёл, Урлаг судлалын сан хөмрөг.
10. Дулам.С. (2018b). *Цагийн бэлгэдэл*. МУСУИС. Соёл, Урлаг судлалын сан хөмрөг.
11. *Монголын эртний түүх: Vol. Тавдугаар боть*. (2017). МУИС-ийн Монгол Судлалын Хүрээлэн, МУИС-ийн Түүхийн Тэнхим, ШУА-ийн Түүх Археологийн Хүрээлэн.
12. Мөнхбаяр.Б. (2011). *Монголын уран зохиолын тайлбар толь*. Улаанбаатар.
13. *Oxford-Monsudar English-Mongolian dictionary* (1st edition). (2004). Монсудар хэвлэлийн газар.
14. Чинбат.Э. (2001). *Англи-Монгол толь*. Улаанбаатар.

Гадаад хэлээр

15. Abdullah Yusuf Ali (орчуулав.) (2000). *The Holly Quran*. Worldworth Editions Limited. Great Britain.
16. *Bilingual Bible*. (1984). World of Life Press.
17. Igor de Rachewiltz. (1972). *Index to the Secret History of the Mongols*. Indiana University. Bloomington
18. *Oxford Advanced Learner's Dictionary* (8th edition). (2010).

Цахим эх сурвалж

Монгол хэлний их тайлбар толь. ([Монгол толь \(mongoltoli.mn\)](http://mongoltoli.mn))

УЛС УУ? ХАНТ УЛС УУ?
МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ХААН БОЛОН ХАН ЦОЛНЫ ТУХАЙ

Ким Ходон¹²²

Солонгос хэлнээс орчуулсан: Г. Эрдэнэчимэг¹²³

Abstract: *It was Ögödei who took the title of qa'an for the first time among the Mongol emperors. Although that title was later widely employed by the supreme rulers of the empire, it had been rarely used in the Mongolian steppe before his adoption. At first, qa'an was a unique title for Ögödei but later it was adopted as a general title for Mongol emperors. This change was almost complete in the time of Qubilai. In the meantime, the title of khan was used, before 1206, to designate rulers of tribe, tribal confederacy or a dynasty. After 1206, only the supreme ruler of the empire could use that title. Although we can find a few princes — e.g., Jochi and Batu — who were called khan, it was an honorary title attached after their death. It was only from the late 1250s when Hülegü came to West Asia with a huge army that Chinggisid princes began to be called khan. As is well known, Hülegü and his successors were called il khan whose meaning is not 'a subordinate khan' but 'khan of il (i.e., ulus).' However, it was not a title monopolized by the Hülegüid rulers; Jochid rulers were also addressed by that title. It should be pointed out that khan was not an official title adopted by the Mongol Empire. The official title to designate Chinggisid princes was kö'ü(n) in Mongolian, and it was translated into oghul in Turkic, shahzāda in Persian, and wang (or zhuwang, dawang) in Chinese. Qubilai introduced an institution of investment and divided Chinggisid princes into six hierarchically ordered groups, which were distinguished by the materias and the shape of the seals bestowed to them. 'The Table of Princes' in Yuan shi shows this six-hierarchy institution was current only within the realm of the Qa'an Ulus, and no prince in the large three western uluses was found there. However, we know that Hülegüid princes received various seals engraved with the expression of zhibao(之寶), and their officials also received zhiyin(之印) seals. * Seoul National University. After the reform of the institution in 1282 the imperial court stopped to bestow zhibao seal because it was regarded to be used only by emperors. Nonetheless, the Hülegüid princes continued to use the zhibao seals within their realms as we see in the letter of Arghun in 1289 and in the edict of Ghazan in 1302. They went so far as to cast a new zhibao seal for themselves as evidenced by its use in 1305*

¹²² БНСУ, Сөүлийн Их Сургууль

¹²³ Доктор, МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим

and in 1320. The mode of employment of the khan title and the zhibao seals suggests the fact that the Hülegüid princes, and probably other rulers in the three western uluses, practiced a policy of 'internally emperor, externally king(外王内帝).' This policy allowed the Mongol Empire to maintain its unity in spite of growing independency of the three western uluses.

Key words: *The Mongol Empire, ulus, khanate, qa'an, khan, the institution of investment, seal*

Удиртгал

1206 онд Тэмүжин, Чингис хан өргөмжлөгдөн их сууринд сууснаар Монголын эзэнт гүрэн буюу Их Монгол Улс бий боллоо. Тэр бээр дөрвөн хүү, дөрвөн дүүдээ тодорхой тооны ард иргэдийг хуваарилан өгч, зүүн болон баруун нутагт суулгав. Үр дүнд нь Чингис ханы захиргааны төв улс, баруун болоод зүүн талд нь тус бүр дөрөв дөрвөн улс үүсжээ. Ингээд Их Монгол Улс нь есөн улсаас бүрдсэн нэгдмэл улс болж хувирлаа.¹²⁴

Чингисийн хөвүүд, дүү нар хожим өөрсдийн улсыг дахин үр хүүхдүүдээ хувь болгон хувааж өгснөөр бүр олон тооны улс үүсэн бий болов. Эхэн үеийн есөн улсыг “дээд улс” гэвэл тэдгээрээс үүссэн жижиг нэгжүүдийг “доод улс” гэж нэрлэж болох юм. Эдгээр доод улсуудын тоо ширхэг болоод тархалтыг нарийн тодорхой мэдэх аргагүй. Гэхдээ Монголын эзэнт гүрэн бол энэ мэт олон тооны том жижиг улсаас тогтсон давхацмал бүтэцтэй аварга том улс төрийн систем байж гэдэгтэй маргах зүйлгүй.

Хожим эдгээр дээд, доод улсууд нь эзэнт гүрний дотоод болоод гадаадад өрнөсөн үйл явдлын нөлөөгөөр хөгжих нь хөгжиж, буурах нь буурчээ. Зарим нь суларч доройтон газар нутаг нь жижгэрэх юм уу, эсвэл ойр тойрны илүү хүчтэй улсын харьяанд, эсвэл хамгаалалтад оров. Улс төрийн мандал буурлын үр дүнд хэдийгээр гаднаас нь харахад нэгэн их эзэнт гүрэн мэт байсан ч дотооддоо хэдэн том улс болж хуваагдсан өөрчлөгдлөө.

Ялангуяа Хайду үхэж(1301), Чапар бууж өгөн дагаж орсноор (1308) Өгөдэйн улс Хаан улсын дотоод руу шилжсэн 14-р зууны эхэн үе гэхэд Монголын эзэнт гүрэн нь дөрвөн том улс болж бүрэлдэн тогтоод байлаа. Өөрөөр хэлбэл, Евроазийн зүүн талыг эзэлсэн Хаан улс, Төв Азийн Цагаадайн улс, Кипчакийн тал нутгаар төвлөсөн Зүчийн улс, Баруун Азийн Хүлэгүгийн улс юм.

Гэхдээ энэ бол зөвхөн дөрвөн том улс үлдээд бусад нь үгүй болсон гэсэн үг биш. Эдгээр дөрвөн том улсын дотор ч урьдын хэвээр олон жижиг улсууд оршсоор байлаа. Тэгэхээр Монголын эзэнт гүрэн ийнхүү дөрвөн том улс болж тогтсон нь эзэнт гүрний бүрэлдэхүүнд оршиж ирсэн улсуудын хүчний харьцаа өөрчлөгдсөнийг харуулж байгаа болохоос эзэнт гүрнийг бүрдүүлэх зарчим, улсын тогтолцоо нь үгүй болсон гэсэн үг огт бус юм.

Тэгвэл тухайн үеийн монголчууд Их Монгол Улс гэдэг эзэнт гүрэн ийнхүү дөрвөн аварга том улс болж тогтсон нөхцөл байдлын талаар ямар бодол санаатай байсан

¹²⁴ Энэ талаар 김호동, 몽골제국의 ‘울루스 체제의 형성’, 동양사학연구 131 (2015). Pp 338-386-г үзнэ үү.

бол? Эдгээрийг тус тусдаа улс төрийн хувьд тусгаар тогтносон вант улс юм уу, эсвэл төр улстай адил гэж бодож байсан болов уу? Эсвэл урьдын хэвээр Чингис ханы Монголын эзэнт гүрний нэг хэсэг, гэхдээ эзэнт гүрний газар нутгийг л хуваан захирч байгаа гэж бодож байв уу?

Монголын эзэнт гүрний түүхийг судалдаг орчин цагийн эрдэмтэд ерөнхийдөө эхэн үеийн Нэгдсэн эзэнт улс (a unified empire) задарснаар (dissolution) Юань улс тэргүүтэй Цагаадайн хант улс, Иль хант улс, Кипчакийн хант улс гэсэн дөрвөн залгамжлагч улс (successor states) үүссэн гэж ойлгодог. Ерөнхийдөө Юань гүрний эзнийг, эзэнт гүрнийг төлөөлөх төлөөлөгчийн хувьд “бэлгэдлийн” төдийгөөр хүлээн зөвшөөрдөг бөгөөд тэр нь ч бас нэр төдий зүйлээс хэтрэхгүй, үнэн хэрэгтээ өөр хоорондоо адил тэнцүү, тусгаар тогтносон төрт улс байсан гэж үздэг. Тиймээс “Дөрвөн хант улс (Four Khanates, 四汗國)” гэж нэрлэдэг юм.¹²⁵

“Хан (khan) -ы захирдаг улс” гэдэг утгатай учраас Хант улс (汗國, khanate) гэж нэрлэдэг. Тэр талаас нь авч үзвэл өөрийгөө хан гэж нэрлэдэг эзний захирсан өрнийн Гурван хант улсын хувьд нэр нь тохирсонгүй гэж хэлэх аргагүй.¹²⁶ Харин хааны захирдаг Юань улсыг хант улс гэж нэрлэх нь хэр зохимжтой бол. Юу боловч Чингис ханы байгуулсан Монголын эзэнт гүрэн хожмоо өөрсдийгөө хан гэж нэрлэсэн үр удмынхных нь захирдаг олон хант улс болж хуваагдсан гэдэг ойлголт дээр үндэслэн эрдэмтэд ингэж нэрлэх болсон нь тодорхой.

Тэгвэл нэгдмэл нэг эзэнт гүрэн хэрхэн олон хант улс болж хуваагдах болсон үйл явц, нөхцөл байдлыг ойлгохын тулд хэзээнээс хан цолыг хэрэглэх болсон бэ гэдэг асуудлыг хөндөхгүй орхиж болохгүй. Өрнийн гурван хант улсын удирдагчид бүгд хан цолтой байсан нь тодорхой. Гэхдээ хэзээнээс, ямар шалтгаанаар энэ цолыг хэрэглэх болсон бэ? Тэдний улс төрийн байр суурьт энэ нь утга учиртай зүйл байв?

Энэхүү өгүүлэлдээ бид эдгээр асуултын хариуг олохыг зорив. Мөн Юань тэргүүтэй “дөрвөн хант улс” гэж нэрлэдэг, Монголын “залгамжлагч улсууд” нь улс төрийн хувьд ямархуу байр суурьтай байсныг тодруулна. Энэ ажил маань, миний бичсэн “улс хэмээх тогтолцоо”-ны тухай хийсэн судалгааны хамтаар Монголын эзэнт гүрний

¹²⁵ H. Franke, D. Twitchett, eds., *The Cambridge History of China*, vol. 6 (Alien regimes and border states, 907-1368) (Cambridge: Cambridge University Press, 1994), pp. 412-3, 387; 本田實信, 『モンゴル時代史研究』 (東京: 東京大學出版會, 1991), p. 387. Cf. Kim Hodong, “The Unity of the Mongol Empire and Continental Exchanges over Eurasia,” *Journal of Central Eurasian Studies* 1(2009), pp. 5-42

¹²⁶ Энэ талаас нь үзвэл өрнийн зарим эрдэмтэд сүүлийн үед хэрэглэх болсон “Yuan Khanate” гэдэг нэрийн утгыг дахин шинжих шаардлагатай. Жишээлбэл, T. Sen, “The Yuan Khanate and India: Cross-Cultural Diplomacy in the Thirteenth and Fourteenth Centurie,” *Asia Major* (Third Series) 19, no. 1/2 (2006), pp. 299-326; B. Zvi Ben-Dor, “Follow the white camel: Islam in China to 1800,” in *The New Cambridge History of Islam*, ed. D.O. Morgan, A. Reid (Cambridge: Cambridge University Press, 2010), pp. 418, 423.

бүтэц, зохион байгуулалт, мөн түүний өөрчлөлт хувиралтын талаарх ойлголтыг улам гүнзгийрүүлнэ хэмээн найдаж байна.

Хаан болон хан цолны хэрэглээ, ач холбогдол

Хаан цолны өөрчлөлт

Монголын эзэнт гүрний үеийн “хаан”, “хан” цолны хэрэглээний тухай Рахевилц гуай хэдийнээ судалсан нь бий. “Монголын нууц товчоон”-ы жишээнүүдийг нарийвчлан судалсан түүний судалгаанаас үзэхэд 1229 онд Өгөдэйг хаан ширээнд суухаас өмнө “хаан” цолыг хэрэглэж байгаагүй ч гол аймаг болон аймгийн холбоо, мөн үндэстний удирдагчдыг “хан гэж нэрлэж байжээ. Жишээлбэл, монгол аймгийн ахлагч байсан Хабул, Хутула, Амбагай нар, мөн Хэрэйдийн Тоорил, Найманы Буйруг нар “хан” цолтой байлаа. Бас монгол бус харь аймаг, улсын удирдагчдыг “хан” гэж нэрлэж байсан ба Алтан улсын Алтан хан, Харлугийн Арслан хан нар түүний жишээ болно. 1229 оноос хойш “хаан” цолоор Өгөдэй болон түүнийг залгамжлан эзэнт гүрний тэргүүн болсон хүмүүсийг цоллох болсон төдийгүй Чингис хийгээд түүний өвөг дээдсийг нэхэн цоллох болжээ. Харин “хан” цолоор Чингисийн удмын олон вангуудыг цоллох болов. Түүний үр дүнд “хан”-ыг “хаан”-аас доод зэргийн цол хэмээн ойлгоход хүрчээ.¹²⁷

Энэхүү үзэл ойлголтыг зохиогч миний бие ерөнхийд нь зөвшөөрч байна. Гагцхүү энэ хоёр цолыг хэрэглэж эхэлсэн тодорхой цаг хугацаа, түүний учир холбогдол, тэрчлэн Монголын эзэнт гүрний улс төрийн зэрэг дэв, дэг жаягт хэр зэрэг хүндтэй байр эзлэх талаар илүү нарийн судлах шаардлагатай гэж үзэж байна.

Чингис ханы уг нэр нь Тэмүжин гэдгийг эс мэдэх хүн үгүй. Өөрөөр хэлбэл, “Чингис хан” бол түүний өргөмжит цол юм. Тэгвэл Өгөдэйн хувьд ямар байсан бэ? Түүнийг их сууринд өргөмжлөөд “хаан” гэж цоллосон байна. “Чингис хан” нь зөвхөн Тэмүжинг өргөмжлөх цол байсантай адил “хаан” нь зөвхөн Өгөдэйг өргөмжлөх цол нэр байлаа.¹²⁸ Гэвч Өгөдэйг нас барснаас хойш байдал өөрчлөгдөж эхлэлээ. Түүнийг залгамжилсан Гүюгийг бидний үед уламжлан ирсэн бараг бүх сурвалжид “хан” гэж тэмдэглэжээ. Эрдэмтэд ч сурвалжийн тэмдэглэлийг даган “Гүюг хаан” гэхгүй, харин “Гүюг хан” гэж нэрлэдэг. Гэхдээ цөөн ч гэсэн “хаан” гэж нэрлэсэн тохиолдол байна. Тухайлбал, хижрийн тооллын 646 (НТ 1248 оны орчим) онд Гүржийн нутгаас олдсон 5-р Давидын үеийн мөнгөн зоосон(dirham) дээр Gūyūg Qā’ān гэдэг бичиг байсан тухай мэдээ бий. Мөн энэ үеийн латин хэлээр бичсэн дурсгалд Гүюгийг chaam хэмээн тэмдэглэснийг “хаан” гэдэг үг бололтой хэмээн таамагладаг.¹²⁹ Эцэст нь, хэдийгээр тухайн цаг үеийнх бус боловч 14-р зууны тэргүүн хагаст Аль Умари тэмдэглэлдээ Гүюгийг Мөнх, Хубилай нарын

¹²⁷ Igor de Rachewiltz, “Qan, Qa’an and the Seal of Güyüg,” in *Documenta Barbarorum: Festschrift für Walther Heissig zum 70. Geburtstag*, ed. Walther Heissig, et al. (Wiesbaden: Otto Harrassowitz, 1983), pp. 272-281.

¹²⁸ *Ibid.*, p. 275.

¹²⁹ *ibid.*, pp. 275-76, 278 (note 8).

хамтаар хаан(qa'an) хэмээн бичжээ.¹³⁰ Гэхдээ энэ мэт цөөн тохиолдлыг эс тооцвол Гүюгийг ерөнхийдөө хаан бус хан хэмээн цоллож байна. Тэгэхээр хаан гэдэг үг нь хараахан эзэнт гүрний хамгийн өндөр дээд удирдагчийг заасан утгатай, өргөн хэрэглэдэг цол болж хэвшээгүй байсан гэсэн үг болно.

Харин Гүюгийг залган хаан ширээнд суусан Мөнхийг хан бус хаан гэдэг цолоор цоллосон жишээ хамаагүй олон давтагдаж эхэлнэ. Жишээ нь, Мөнхийг их сууринд суусны дараахан 1252 оны 5-р сард Хархорумд хүрэлцэн очиж, ордонд нь айлчлаад тэнд жил гаруй суусан Жувэйни түүхч түүнийг хаан гэхээс өөрөөр дуудахгүй байна.¹³¹ Гэхдээ тэр бээр, Өгөдэйн тухай өгүүлэхдээ нэрийг нь хасаж зүгээр л хаан гэсэн байх бөгөөд энэ нь Мөнхийн тухайд ямагт “Мөнх хаан” гэснээс эрс ялгарна. Энэ хоёр хүнийг зориуд ингэж өөрөөр дуудахын учир нь өмнө дурдсанчлан “хаан” гэдэг үг нь зөвхөн Өгөдэйд л зориулж хэрэглэх цол байсанд орших болов уу хэмээн таамаглаж байна.

Жувэйни “хаан” гэдэг цолыг хэрхэн хэрэглэснээс үзэхэд уг цолыг эзэнт гүрний удирдагчийг заасан утгаар өргөн хэрэглэж байсан ч хараахан “албан ёсны” цол болж тогтоогүй байжээ хэмээн дүгнэж болно. Үүнийг Шаолины сүмийн хөшөөний бичгээс ч тодруулж болох бөгөөд 1253 онд Мөнх аман зарлигтаа өөрийн биеийг хаан бус харин хан(qan) гэсэн нь бас нэгэн баримт болно. Сонирхол татах нэг зүйл бол уг сүмийн гэрэлт хөшөөг 1257 онд босгож, аман зарлигийг орчуулан сийлэхдээ Мөнхийг хаан(qaghan, 𐰺𐰋𐰏 qa'an) гэсэн байна. Гэхдээ бид ордноос илгээсэн албан бичгийг уг хөшөөнд тэр чигээр нь шууд сийлсэн бус, харин уг аман зарлигийн тухай магтууг сийлсэн гэдгийг сайтар анхаарах ёстой.¹³² Өөрөөр хэлбэл, зарлигийн эхийг тэр чигээр нь орчуулсан гэсэн үг бус юм. Тийм учраас зарлиг мэтийн албан бичигт төр улсын удирдагчийг албан ёсоор хан гэж цоллосон хэвээр байж гэж үзэх хэрэгтэй.

Мөнхийг их сууринд суусны дараахан 1253-54 оны хавьцаа Монголд очсон Рубрук ч бас Мөнхийг хаан гэхгүй, зүгээр л “Мангу хан(Mangu Chan)” гэсний дээр Гүюгийг ч бас Гүюг хан(Cuucus Khan) гэж тэмдэглэжээ.¹³³ Түүнээс өмнө Монголд очсон Карпини мөн л Өгөдэйд хаан гэлгүй Өгөдэй хан(Occodai Khan) гэсэн байна.¹³⁴ Эндээс үзэхэд тэд тэмдэглэлдээ тухайн үеийн цол, дуудах нэрийг хэр зөв тодорхой бичсэнийг нягтлахад хэцүү. Тэд хаан ба хан гэдэг хоёр үгний урт богино эгшгийн дуудлагад төдийлөн ач холбогдол өгөөгүй ч байж болохыг үгүйсгэх аргагүй.

¹³⁰ al-Umarī, *Das Mongolische Weltreich: al-Umarī's Darstellung der mongolischen Reiche in seinem Werk Masālik al-abṣār fi mamālik al-amṣār*, ed. K. Lech (Wiesbaden: Otto Harrassowitz, 1968), p. 104.

¹³¹ 'Aṭā Malik Juwaynī, *The History of the World-Conqueror*, trans. John Andrew Boyle, 2 vols. (Cambridge, Mass.: Harvard University Press, 1958), 555ff. үүнээс хойш Juwaynī/Boyle гэж товчилно.

¹³² 中村淳, 松川節, 「新発見の蒙漢合璧少林寺聖旨碑」, 『内陸アジア言語の研究』 8(1993), p. 63.

¹³³ William Rubruck, *The Mission of Friar William of Rubruck: His journey to the court of the Great Khan Möngke 1253-1255*, tr. P. Jackson (London: The Hakluyt Society, 1990), pp. 94, 122.

¹³⁴ Plano Carpini, *The Story of the Mongols Whom We Call the Tartars*, ed. E. Hildinger (Boston: Branden Publishing Company, 1996), pp. 64, 80, 85-86.

Энэхүү хэсэгт бид хаан, хан цолны тухай тухайн үеийн түүхэн сурвалж, тухайлбал Жувэйнигийн тэмдэглэл, Мөнхийн үеийн хөшөөний бичээс тэрчлэн Карпини, Рубрук нарын тэмдэглэлийг шинжлэв. Түүний дүнд дараах дүгнэлтийг хийлээ. Өгөдэйг нас барсны дараа зөвхөн Өгөдэйн л цол байсан хаан гэдэг үг аажмаар эзэнт гүрнийг оройлон удирдагчийг нэрлэх ерөнхий нэр болон хэвшиж эхэлснээр сурвалж бичигт уг үгийн гарах тоо давтамж ч олширчээ. Гэхдээ Мөнхийн үед хаан цол нь албан ёсны цол болж тогтоогүй хэвээр байсан бөгөөд тийм ч учраас эзэнт гүрний тэргүүнийг заримдаа хан, заримдаа хаан гэж дууддаг байжээ.

Хубилайн засаглалын үеэс Монголын эзэнт гүрний удирдагчийг энэчлэн хоёр өөр цолоор дуудахаа болив. Бидний үед уламжлан ирсэн сурвалжуудад бүгдэд нь Хубилайг хаан гэж тэмдэглэсэн нь үүнийг гэрчилнэ.¹³⁵ Дөрвөлжин бичгээр бичсэн аман зарлигууд яг адил “mǒngke tengri-yin kücün-dür, yeke su jali-yin ihe'en-dür, qa'an-u jarliq manу гэсэн үгээр эхэлнэ.¹³⁶ Эдгээр зарлиг нь “хаан” гэдэг үг эзэнт гүрний дээд удирдагчийг заасан цол болон хэвшиж тогтсоныг харуулна.

Гэхдээ бид энд нэг зүйлийг анхаарах ёстой. Юу гэвэл, Хубилайн үед үйлдсэн зарлиг бичгүүдэд Өгөдэйг хуучин хэвээр нэрийг нь дурдалгүй, зүгээр л хаан гэсэн хэвээр байна. Жишээлбэл, 1280 онд Шаньши мужийн таван замын Баруун Сычуаний Ли Дао жянь түшмэл (陝西五路西蜀四川提點 李道謙)-д буулгасан зарлигт өмнө дурдсантай адилхан үгээр эхэлсэн ч, 9-р мөрөнд “Cǐnggis Qan-u ba Qaan-u ba jarliq-dur” гэсэн байна. Тэрчлэн эдгээрийг 白話體 碑文 хөшөөний бичигт “成吉思皇帝 哈罕皇帝聖旨里” мөн “成吉思皇帝 皇帝聖旨里” гэж орчуулжээ.¹³⁷ Өөрөөр хэлбэл, Хубилайн үед хэн нэгний нэргүйгээр, зүгээр л qa'an гэвэл эзэнт гүрнийг бүхэлд нь удирдан захирагч (буюу Хубилай)-ийг хэлж байна хэмээн хүлээж авдаг болжээ. Гэхдээ зарлиг бичигт урьдын адилаар qa'an гэдэг цол нь Өгөдэйг заасан үг болж хэрэглэгдсээр байв. Энэ нь эзэнт гүрний дээд удирдагч нэг л хүнийг заан нэрлэх цол болж хараахан хэвшээгүйг үзүүлнэ. Иймэрхүү тодорхойгүй бус байдал нь Хубилайг залгамжлагч Төмөр (Өлзийт хаан)-ын үед төгсгөл боллоо. Төмөр их сууринд суусныхаа дараа буулгасан зарлигтаа өмнөх эзэд хаадын зарлигийн тухай дурдангаа “Cǐnggis Qan-u ba Öködee Qaan-u ba Sečen Qaan-u ba jarliq-dur” гэжээ. Өөрөөр хэлбэл, Хубилайн үед зүгээр л хаан гэж дууддаг байсан Өгөдэйг энэ үеэс эхлэн “Өгөдэй хаан” гэж жигдлэн нэрлэх болов.¹³⁸ Хубилайг нас барсны дараа

¹³⁵ 杉山正明, 『モンゴル帝國と大元ウルス』 (京都: 京都大學學術出版會, 2004), p. 382

¹³⁶ Жишээ нь. 呼格吉勒圖, 薩如拉 編著, 『八思巴字蒙古語文獻匯編』 (呼和浩特: 內蒙古教育出版社, 2004), pp. 1-47 -г үзнэ үү.

¹³⁷ Ibid., pp. 32-34; 蔡美彪, 『元代白話碑集錄』 (北京: 北京科學出版社, 1955), pp. 23, 30, 35

¹³⁸ 呼格吉勒圖, 薩如拉 編著, 『八思巴字蒙古語文獻匯編』, pp. 51, 60, 80-81; 蔡美彪, 『元代白話碑集錄』, pp. 37, 40, 43 гэх мэт. 蔡美彪 『元代白話碑集錄』 39 тал болон 41-р талд ‘哈罕皇帝’ гэж илэрхийлсэн хоёр ширхэг зарлиг бичигтэй хөшөөний бичээсийг оруулаад тус тус 1296 он болон 1297 онд буулгасан зарлиг гэсэн боловч оныг эндүүрсэн байна.

Төмөр их сууринд суусан 1294 оноос л хаан цол нь эзэнт гүрнийг оройлон захирах цор ганц хүнд хэрэглэх цол болон тогтсон байна.

Хан цол

Тэгвэл хаантай харьцуулахад улс төрийн доогуур зэрэг дэв буюу Монголын олон вангийн хэрэглэж байсан хан цолыг хэн, хэзээ гаргасан бэ? Хан цолны хэрэглээ нь өмнө дурдсан “хаан” цолны жишээн дээр авч үзсэн өөрчлөлттэй нягт холбоотойгоор өөрчлөгдөн хувирч ирсэн гэж таамаглах бүрэн үндэстэй. Учир нь эзэнт гүрний хамгийн оройн дээд захирагч болох Гүюг болон Мөнх нар “хан” цолтой байхад захиргаан дахь олон ван нар нь өөрсдийгөө хан гэж өргөмжлөх хэцүү л байсан болов уу. Тэгэхээр эзэнт гүрний тэргүүн “хан” цолыг хэрэглэхээ байж, “хаан” гэж цоллуулснаас хойш л олон вангууд хан цолыг хэрэглэж эхэлсэн байх боломжтой. Бидний энэхүү таамаглал таарах эсэхийг холбогдох сурвалжийн материалуудаас тодруулъя.

1260-аад оны үед “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх”-ийг бичсэн Жувэйни бээр, Чингис ханы залгамжлагчид “Эзний суудалд суух болбол хан юм уу, эсвэл хаан цолны аль нэгийг хэрэглэдэг. Өөр юу ч хэрэглэхгүй. Түүний бусад хөвүүд, ах дүү нарыг (өөрийг нь) байхад, эсвэл байхгүй үед ч, төрөхөд нь өгсөн тэр л нэрээр дуудна” гэжээ.¹³⁹ Өөрөөр хэлбэл, Мөнхийн засаглалын үед ингэж бичсэн Жувэйни бидэнд хан, хаан цол нь эзэнт гүрний эзэнд л олгодог цол бөгөөд бусад хамаатан садныг нь зөвхөн нэрээр нь дууддаг байсныг тодорхой өгүүлж байна.

Гэтэл Мөнхийн засаглалаас өмнөх үеийн хүмүүс дунд хуанди бус атлаа хан цолоор цоллуулсан жишээ байна. Юуны өмнө Карпини, их хан байгаагүй Зүчийн талаар бичихдээ нэрийг нь Tossu, бас Tossus гээд “хуанди гэсэн утгатай хан (Can)” гэдэг үгээр цоллодог хэмээн тэмдэглэжээ.¹⁴⁰ Тэр бээр 1245-46 онд Хар тэнгисийн баруунтаах тал нутаг болон Казахстаны өргөн талыг туулж, Хархорум хүрээд буцаж ирсэн тухайн үеийн монголчуудаас сонсож дуулснаа энэ мэтчилэн бичиж тэмдэглэжээ гэж үзэж болох юм.

Зүчийн нэрийг Tossu, бас Tossuc гэж тэмдэглэсэн тухайд бол, Зүчи гэдэг монгол нэрийг түрэг хэлтнүүд Tösi гэж дууддаг байсан болов уу хэмээн Пеллио таамагласан бөгөөд улмаар Жувэйнигийн TWSY, бас Насавүи (Nassawī)-гийн DWSY зэрэг нь ч тэрхүү авиа болно хэмээжээ. Карпинигийн Tossu (с) ч мөн л Tösi-тэй төстэй авиалбараар сэлгэсэн хувилбар гэж таамаглажээ.¹⁴¹

Зүчийн нэрийн талаар тийм байжээ гэж бодъё. Харин Зүчи амьд сэрүүн үедээ өөрийгөө хан гэж цоллож байсан болов уу. Карпини Зүчийг хан гэж дуудахыг сонссон цаг хугацаа бол Зүчийг нас барснаас бараг хориод жилийн дараах явдал болно. Аавынхаа

¹³⁹ Juwaynī/Boyle, vol. 1, p. 26 (Qazvini text, p. 19).

¹⁴⁰ P. Pelliot, Notes sur l'histoire de la Horde d'Or (Paris: Adrien-Maisonneuve, 1949), pp. 10-26; J.A. Boyle, “On the titles given in Juvaynī to certain Mongolian princes,” Harvard Journal of Asiatic Studies 29, no. 3-4 (1956), pp. 148-52; 김호동 역주, 『몽골제국기행』 (서울: 까치, 2015), p. 8

¹⁴¹ P. Pelliot, Notes sur l'histoire de la Horde d'Or, pp. 10-27; Juwaynī/Boyle, vol. 1, p. 40.

эхлүүлсэн өрнийг байлдан дагуулах дайнд оролцож явахдаа хан гэж дуудуулж явсан тухай сурвалжийн мэдээ байхгүйн дээр тухайн цаг үеийн нөхцөл байдал ч тэгэх боломжгүй байсныг харуулна. 1223-4 оны үед Хорезмыг байлдан дагуулсны дараа Чингис хан заавар тушаалаа биелүүлж чадсангүй хэмээн Зүчийг буруушааж, эцэг хүү хоёрын харилцаа хүйтэрч хөндийрсөн байв.¹⁴² Удалгүй 1227 онд ааваасаа хэдэн сарын өмнө тэнгэрт хальсан тул Зүчийг энэ үед хан гэж цоллодог байсан гэхэд хэцүү. Тэгэхээр Зүчийг нас барснаас хойш түүний үр удмынхан нэхэн дурсагдаа хүндэтгэж хан хэмээн дууддаг байсан болов уу хэмээн таамаглаж байна.

Үнэндээ Рашид ад Дины “Судрын чуулган”-ыг нарийвчлан судалбал хан цолны талаар тун сонирхолтой зүйл олж мэдэж болно. Тухайлбал, Чингисийн удмын олон вангуудын дунд “... хан” буюу нэрийнх нь ард хан цол залгасныг хоёр ангилж болохоор байна. Эхнийх нь (А) нас барсных нь дараа нэгэн төрлийн хүндэтгэлийн нэр болгож залгасан байх бөгөөд Чингис ханы дөрвөн хүүгээс их хан болж чадаагүй Зүчи, Цагаадай, Тулуйг хан хэмээжээ. Нөгөөдөх нь (В) Иран нутгийн захирагч болсон Рашид ад Дин урьд өмнөх захирагч нараа “Хүлэгү хан”, “Абака хан”, “Ахмад Текүтер хан”, “Аригүн хан”, “Гэйхату хан” гэсэн байна.

Эхлээд (В)-гийн хувьд, яах аргагүй бүгдээрээ Хүлэгүгийн улсын удирдагчид бөгөөд хожуу байлаа гэхэд 1250-аад оны эцсээс “ил хан” хэмээн нэрлэгдэх болжээ. Энэ тухайд дараагийн хэсэгт нарийн тодорхой өгүүлэх тул үүгээр товчилъё. Харин (А)-гийн хувьд, Рашид ад Дины тэмдэглэлийг эс тооцвол Зүчи, Цагаадай, Тулай гурвыг амьд сэрүүнд нь хан хэмээн дуудаж байсныг батлах баримт хаана ч алга. Тэгэхээр үүнд үндэслэн энэ гурвыг тухайн үеийн монголчууд нас барсных нь дараа “хан” гэж хүндэтгэн дуудах болсон гэж үзэж болно.

Зүчийн хүү Батыг “сайн хан(Sāin Khān)” гэж дууддаг байсан нь үүнтэй төстэй.¹⁴³ Сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд Бат амьд сэрүүндээ хан гэж дуудуулаагүй бөгөөд 1280-аад оны сүүл үе болж байж, үр ач нар нь Зүчийн улсын улс төрийн үзэл суртлыг бэхжүүлэх зорилгоор “хан” хэмээн цоллож эхэлсэн ажээ.¹⁴⁴ Зүчийн улсын захирагч нарын дундаас анх удаа Мөнхтөмөр (1276-80) л амьд сэрүүндээ хан хэмээн цоллуулсныг мөнгөн тэмдэгт, зарлиг бичиг зэргээс үзэж болно.¹⁴⁵

Рашид ад Дин нь Чингисийн угсааны дээрх хоёроос бусад олон вангуудын нэрд “хан” цол залгаагүй. Цагаадайг залгамжлан түүний улсыг захирсан Есөнмөнх, Алгуй, Барак, Дува нар, Зүчийн улсад Батыг залгамжилсан Бэрх, Мөнхтөмөр, Гөдмөнх, Гохта нарыг зүгээр л нэрээр нь тэмдэглэжээ. Өгөдэйн улсын төлөөлөгч болохын зэрэгцээ Төв

¹⁴² Minhāj al-Dīn Jūzjānī, Ṭabaqāt-i nāsirī (tr. H.G. Raverty, New Delhi: Oriental Books Reprint Corp, 1970), p. 1101; C.P. Atwood, Encyclopedia of Mongolia and the Mongol Empire (New York: Facts On File, 2004), pp. 278-279

¹⁴³ 『칸의 후예들』, p. 165.

¹⁴⁴ R. Iu. Pochekaev, Batyi: Khan, kotoryi ne byl khanov (Moskva: Ast Evraziia, 2006).

¹⁴⁵ A. N. Nasonov, Russkaia zemlia i obrazovanie territorii drevnerusskogo gosudarstva: istoriko-geograficheskoe issledovanie (Sankt-Peterburg: Nauka, 2002), p. 237

Азид хүчирхэг цэргээ удирдсан Хайдугийн нэрд ч хан цол залгаагүй. Тэгвэл бид Рашид ад Дины энэ мэт тэмдэглэлд үндэслэн Чингисийн угсааны олон вангийн дундаас дээрх хоёр тохиолдлыг эс тооцвол бусдыг нь “хан” гэж дуудаж байгаагүй гэж үзэх ёстой юу? Үгүй юм. Учир нь, тэднээс гадна хан гэж дуудуулсан Чингисийн угсааны олон вангууд байжээ гэдгийг бид өөр бусад сурвалжаас нягталж болно. Юуны өмнө, дээр дурдсанчлан Зүчийн улсад Мөнхтөмөрийг хан гэж цоллосноос хойш залгамжлагч нар нь бүгд хан гэж дуудуулах болжээ. Жишээлбэл, Тохта (1290-1312 онд захирсан) 1299 онд хийсэн мөнгөн зоосон дээр өөрийгөө ‘Khān al-‘ādil Тоqtoqā (шударга хан Тохтох) хэмээн сийлүүлжээ.¹⁴⁶ Өзбег (1313-41 онд захирсан) бол яах аргагүй хан цолтой байв. “Судрын чуулган”-д “Анхнаасаа Ордын угсааныхны дунд, тэдний залгамжлагч болсон хүмүүс Батын угсааны хан нар руу явсан удаа үгүй”¹⁴⁷ гэсэн өгүүлбэр буй. Энэ нь Рашид ад Дин өөрөө ч Зүчийн улсын удирдагчдыг хан гэж дууддагийг мэдэж байсан болохыг гэрчилж байна.

Эндээс дараах асуудал урган гарч байна. Дээр өгүүлсэнчлэн бусад улсын удирдагчдыг хан гэж дууддаг байхад Рашид ад Дин ямар шалтгааны улмаас тэднийг хан гэсэнгүй вэ? Уг асуултын хариуг олъё гэвэл дахин нэг удаа түүний тэмдэглэлийг нарийн шүүж үзэх хэрэг гарна. Рашид ад Дины тэмдэглэлд өмнө дурдсан (А) ба (В) хоёр бүлгээс бусад Чингисийн угсааны олон вангуудыг ямар цолоор дууддаг байсан бол?

Товч хэлбэл, Рашид ад Дин тэднийг хоёр янзаар тэмдэглэсэн байна. Эхнийх нь Бэрх, Барак нарын адилаар зүгээр л нэрээр нь тэмдэглэсэн бол нөгөөх нь ван хөвүүн гэсэн утгатай цолыг нэрд нь залгаж тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, түрэг хэлний огул (oghūl), перс хэлний шяхзада (shahzada) гэдэг үгийг олонтоо хэрэглэжээ. Тэр бээр Чингисийн угсааны олон вангуудыг өөрсдөө хан цол хэрэглэдэг байсан эсэхээс үл хамааран бүгдийг нь дээрх хоёр аргын нэгээр тэмдэглэсэн байна.

Үүнээс удаах аргын талаар дэлгэрүүлэн авч үзье. Огул, мөн шахзада гэдэг нь монгол хэлний хөвүүн (kò’ün- köbegün; kò’üd- köbegüd) гэдэг үгийг үгчлэн орчуулсан хэлбэр юм. Нангиад бичгийн сурвалжид олонтоо гардаг ван, их ван, олон ван зэрэг нь үнэндээ энэхүү монгол үгийг орчуулсан хувилбар гэдгийг судлаачид хэдийн судалж тогтоожээ.¹⁴⁸ Жишээлбэл, “Монгол хэлнээс орчуулсан үг”-д ‘大王 口’, ‘太子 口’ хэмээн тайлбарласны ‘口’ нь даруй хүү буюу kò’ün-ны орчуулга юм. Ханзаар 大王, мөн 太子 нь даруй монгол хэлний kò’ün-тэй адил утгатай болно.¹⁴⁹

Мөн Хар хотын малтлагаар гарсан бичиг(黑城出土文書)-д Сангашири их вангийн бичиг бий. Түүний нангиад бичээсийг уйгаржин бичээстэй харьцуулж үзээд

¹⁴⁶ B. Nyamaa, *The Coins of Mongol Empire and Clan Tamgha of Khans (XII-XIV)*(Ulaanbatar: Mongol Uls, 2005), p. 199.

¹⁴⁷ 『칸의 후에들』, p. 155.

¹⁴⁸ 杉山正明, 八不沙大王の令旨碑より, 『東洋史研究』 52/3 (1993); 姚大力, 『北方民族史十論』: 廣西師範大學出版社, 2007; 村岡倫, モンゴル時代の山西平陽地區と諸王の權益 — 聖姑廟識牢大王令旨碑より —, 『13・14世紀東アジア史料通信』 10(2009).

¹⁴⁹ 『蒙古譯語』(至順刊本 豐事林廣記)續集卷8 文藝類 譯語 蒙古譯語 君宦門 8a.

桑哥失里大王 Sangasiri köbegün хэмээн тэмдэглэснийг нягталж болно.¹⁵⁰ Баруун Азийн сурвалж бичгээс хэдий цөөн боловч уг цолыг бас хайж олов. Жишээлбэл, Армений түүхч Аканз (Grigor of Akanc, 1250-1335) Зүчийн улсын Ногай-ыг Noqai kö'ün гэсэн байна.¹⁵¹ Рашид ад Дин ч мөн тэмдэглэлдээ Аригбөхийн хүү Малигтөмөрийн нэгэн хүүг Mingqān Kūn гэжээ.¹⁵² Хүлэгүгийн улсын удирдагч Абу Саидыг 1335 онд үхсэний дараа залгамжилсан Агра Ке'ün гэгч бий. Энэхүү Ке'ün гэдэг үг нь монгол хэлний kö'ün-ыг үгчлэн орчуулсан хувилбар гэдэгт эргэлзэх шаардлага алга.

Дурдахгүй өнгөрч болохгүй бас нэгэн сонирхолтой зүйл гэвэл Чингисийн угсааны олон вангуудыг хан гэж дуудалгүй, зөвхөн нэрээр нь дуудсан юм уу, эсвэл ван хөвүүн гэдэг утгатай цолоор дуудсан нь зөвхөн Рашид ад Дины тэмдэглэл төдийгүй “Юань улсын судар”-т хүртэл адилхан гарч буй явдал юм. Жишээ нь, Хүлэгүг “Юань улсын судар”-т олонтоо 旭烈, 旭烈兀, 諸王旭烈, 旭烈大王 зэргээр тэмдэглэсэн бөгөөд эдгээр нь Нүлегү, мөн Нүлегү kö'ün-ий орчуулсан хувилбар юм. Абага ханыг 諸王阿八合, эсвэл 阿八合大王, Газаныг 哈贊大王, Өлзийт ханыг 哈兒班答大王, Абу Саид ханыг 諸王不賽因 гэж тэмдэглэжээ. Энэ нь мөн л Абага kö'ün, Qasan kö'ün, Qarbanda kö'ün-ыг орчуулсан нь юм. Зүчи болон Цагаадайн улсын олон вангуудын хувьд ч мөн адил. Өзбегийг 月即別, мөн 北邊諸王月即別(умард хязгаарын олон ван Өзбек) гэж дууддаг байсан ба Дува-г 都哇, мөн 北邊諸王都哇 гэж дууддаг байжээ. Улсын том жижгээс үл хамааран бүх л олон ванг иймэрхүү маягаар дууддаг байсан бөгөөд баруун зүгийн улсын олон вангуудыг ерөнхийд нь өрнийн олон ван, эсвэл өрнийн фань ван (藩王) гэж дууддаг байв.

Бидний мэдэхээр “Юань улсын судар”-ын “Уг тэмдэглэл”-ийг “Үнэн магад тэмдэглэл”-д үндэслэн эмхэтгэсэн бөгөөд харин “Үнэн магад тэмдэглэл”-ийг албан ёсны тайлан илтгэл, албан ёсны бичиг тэмдэглэлд үндэслэн эмхэтгэсэн болно. Хаан ба олон вангуудын харилцааны бичиг тэмдэглэлийг мэдээжээр монгол хэлээр бичсэн нь лавтай. Харин заримыг нь л ханз бичгээр орчуулан “Үнэн магад тэмдэглэл”-д оруулсныг хожим Мин улсын эхэн үед эмхэтгэсэн “Юань улсын судар”-т ашиглажээ.¹⁵³ Эндээс бид, хаан болон улсуудын удирдагчдын харилцааны бичигт олон вангуудыг зүгээр л нэрээр нь юм уу, эсвэл нэрийн ард хүүн (kö'ün) гэдэг үгийг залгаж тэмдэглэснээс бус хан гэдэг цолыг огт хэрэглээгүйг мэдэж болно. “Юань улсын судар”-т ганц л өөр тохиолдол байгаа нь 1310 онд Чапар бууж өгөөд Хайсаны ордонд, хуралдайд бараалхах үед Якутү “Бат ханы

¹⁵⁰ 吉田順一, Chimeddorji, 『ハラホト出土モンゴル文書の研究』(東京: 雄山閣, 2008), pp. 80-81(문서번호 F116:W204), p. 91(문서번호 F116:W572); 李逸友, 『黑城出土文書: 漢文卷』(北京: 學出版社, 1991), pp. 128-131.

¹⁵¹ F. W. Cleaves, “The Sino-Mongolian Inscription of 1362 in Memory of Prince Hindu,” *Harvard Journal of Asiatic Studies* 12/1-2(1949), pp. 1~133.

¹⁵² 『부족지』, p. 200.

¹⁵³ 金浩東, 「元代 漢文實錄과 蒙文實錄: 『元史』 「本紀」의 中國中心의 一面性의 解明을 위하여」, 『東洋史學研究』 109 (2009).

үр удам толгой бөхийлгөн дагаж оров. Тэрслүү ван Чапар ураг төрлөө дагуулан ирэв. Иргэн болоод газар бүгдээр нэгэн гэр бүл боллоо” гэж айлтгасан тухай тэмдэглэл юм.¹⁵⁴ Гэхдээ энэ ч бас нас бараад бараг хагас зуун болсон Батыг хүндэтгэн дуудсан хэрэг гэж үзэж болох юм.

Одоо бид өмнө дурдсан зүйл, өөрөөр хэлбэл Рашид ад Дин, (А) ба (В) хоёр бүлгээс бусад Чингисийн угсааны олон вангийн нэрд ямар учраас хан цол залгаж дуудаагүй тухайд тодруулах болно. Учир юу гэвэл, тухайн үеийн Монголын эзэнт гүрний дотоодод албан ёсоор өргөн хэрэглэдэг арга нь тийм байсанд оршино. Өөрөөр хэлбэл, хан гэдэг цол бол Чингисийн угсааны олон ванд олгосон албан ёсны цол биш байлаа. 1260-аад оноос хойш өрнийн Гурван вант улсын удирдагчид өөрсдийгөө хан гэж цоллож байсан хэдий ч, тэр нь дотооддоо өөрсдийн байр суурь, эрх дархыг илэрхийлэх зорилготойгоос бус, бүхэл эзэнт улсын удирдагч болох их хан тэднийг хүлээн зөвшөөрч, соёрхсон цол огтоос бус байлаа. Бусад вант улсын удирдагчид ч өөр хоорондоо энэхүү цолоор биесээ цоллон дуудаж байсангүй.

“Судрын чуулган”-ыг шадар сайд Рашид ад Дины удирдлагаар эмхэтгэсэн хэдий ч Хүлэгүгийн улсад Газаны зарлигаар уг сурвалжийг бичих ажил эхэлж, Өлзийт хааны үед дуусгасан гэдгийг мартаж болохгүй. Тиймээс түүний бичвэрт гарч буй Монголын эзэд хаадын нэр цолыг санаан зоргоор бичсэн бус, харин Хүлэгүгийн улс дотор албан ёсоор хэрэглэдэг ёс жаягийн дагуу тэмдэглэсэн гэж үзэж болно. Чингис ханы хөвүүд болоод Хүлэгүгийн улсын удирдагчдаас бусад бүх олон ванг зүгээр л “тэр тэр” хэмээн нэрээр нь тэмдэглэсэн бөгөөд эсвэл “... ван хөвүүн” гэсэн нь Монголын эзэнт гүрэнд албан ёсоор хүлээн зөвшөөрсөн арга хэлбэр байлаа.

Рашид ад Дин бээр Газан болон Өлзийт, тэдний өмнөх удирдагчдыг хан гэж цоллосон учир нь тэднийг өөрийн өвөг дээдэс, эзэн захирагчаа хэмээн үзсэнтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, Хүлэгүгийн улсын дотоодод улсын захирагчийг хан хэмээн дуудаж ирсэн заншлыг дагажээ. Энэ хэв ёс нь Хүлэгүгийн улс төдийгүй өрнийн Гурван улсад ч нийтлэг үзэгдэл байлаа. Зүчи болон Цагаадайн улсын удирдагчид дотооддоо бүгд хан гэж дуудуулж байлаа. Гэхдээ энэ цолыг гадаадад, бас албан ёсоор хэрэглээгүйн дээр бусдыг хан гэж цоллохыг хүлээн зөвшөөрч байсангүй.

Бидний мэддэгчлэн Хүлэгүгийн улсад “ил хан” цолыг өргөн хэрэглэдэг байсан тул эдүгээ Хүлэгүгийн улсыг Ил хант улс гэж нэрлэдэг. Тэгвэл энэ “ил хан” цол хэзээ гарч ирсэн болон ямар учир утгатай болох талаар эргэцүүлэн бодъё.

(3) “Ил хан(*il khān*)” цол

Амитай профессор (R. Amitai), 657/1258-59 оны орчим монгол цэрэг Маяфарикиныг бүслэх үед анх “ил хан” гэдэг цол сурвалжид гардаг хэмээн судалжээ.

¹⁵⁴ 『元史』, 卷 117, p. 2909

Монгол цэргийн удирдагч болох Хүлэгүгийн хүү Ёшимүтыг тийнхүү дуудаж байжээ.¹⁵⁵ Харин тэр үе бол Багдадыг Хүлэгү дөнгөж эзлэсний дараахан үе (1258 оны 2-р сар) болох тул хараахан бие даасан “хант улс”-ын тухай мөрөөдөх цаг биш байсны дээр хүү нь болох Ёшимүтүгийн хувьд бүр ч тийм байлаа. Тэгвэл Хүлэгү ч бай, Ёшимүтийг ч бай, яахаараа тэгж дууддаг билээ?

Өдийг хүртэл судлаачид “ил хан” цолны “ил” гэдэг үгийн утгын талаар харилцан зөрүүтэй санал бодолтой байна. Зарим нь “...-нд харьяалагдах” гэсэн утгатай тэмдэг үг¹⁵⁶ гэж ойлгож байхад зарим нь монгол хэлний улс гэдэг үгийг түрэг хэлээр орчуулсан хувилбар гэж үздэг.¹⁵⁷ Тухайн үед “ил” гэдэг үгийг хэрхэн хэрэглэж байсныг ажиглахад энэ хоёр санал хоёулаа боломжтой.¹⁵⁸ Гэхдээ өмнө дурдсанчлан Чингисийн угсааны олон вангууд нь их ханы өмнө өөрсдийгөө хан гэж дуудах боломжгүй байснаас үзэхэд “(их хан)-д харьяалагдах хан” гэсэн утгатай цолыг хэрэглэж байж гэж үзэхэд хэцүү.

Түүний дээр монголчуудын дунд энэ цолыг хэрэглэж байсан гэх баримт олдохгүй. Хааны улсад үйлдсэн ямар ч баримт бичигт, монгол хэл, нангиад бичиг, төвд хэлээр бичсэн гэдгээс үл хамааран “ил хан”-д дүйцэх орчуулгын үгийг олж чадахгүй. Түүгээр тогтохгүй, Хүлэгүгийн улсад үйлдсэн мөнгөн тэмдэгтийг ажиглахад араб бичигтэй мөнгөн тэмдэгтээс монгол бичигтэй мөнгөн тэмдэгтийн эрс ялгарах нэг зүйл нь улсын захирагчдыг зүгээр нэрээр нь тэмдэглэсэн бөгөөд “ил хан” гэдэг үг огт олдохгүй. Жишээлбэл, араб бичигтэй мөнгөн тэмдэгтүүдэд бүгдэд нь ““qā’ān al-a’ḡam il-khān al-mu’azzam (хамгийн аугаа хаан, аугаа ил хан)” гэсэн бичиг байдаг бол уйгуржин үсэгтэй мөнгөн тэмдэгтэд il khān гэдэг үг огт байхгүй, оронд нь “qaγan-u nereber Aбаqa-yin deletgölügse(n) (хааны нэрээр, Абакагийн дэлэтгүлүгсэн - Зоос цутгах гэсэн утгатай. Орч.)” зэрэг үг бий. Газан ханаас хойш ч “qaγanu nereber” гэдэг нь “tngri-yin küčün-dür” гэдэг үгээр солигдсон төдий бөгөөд ил хан гэдэг үг олдохгүй.¹⁵⁹

Нөгөө талаар, перс болон уйгур хэлээр бичсэн тухайн үеийн сурвалжуудад il болоод ulus гэдэг хоёр үгийг зэрэгцүүлэн адил утгатайгаар хэрэглэсэн жишээ тоогүй олон буйг нягталж болно. ‘ulus гэдэг үгийг орчуулсан нь ‘il’ гэж үзвэл il khān нь монголоор ‘ulus-un qan’ болж байна. Урьд цагт Зүчийг улсын эзэн буюу ‘ulush idi’ гэж байсантай адил утгатай. Үүнтэй холбогдуулан саяхан D. DeWeese бээр Ибн ал Фувати (1244-1323)-гийн бичсэн Majma’ al-adab fi mu’jam al-alqab хэмээх тэмдэглэлээс нэгэн

¹⁵⁵ R. Amitai, “Evidence for the Early Use of the Title ilkhān among the Mongols,” *Journal of Royal Asiatic Society* 3rd series, 1/3 (1991), pp. 353~361.

¹⁵⁶ A. Mostaert, F. W. Cleaves, “Trois documents mongols des Archives secrètes vaticanes,” *Harvard Journal of Asiatic Studies* 15/3-4 (1952), pp. 419~506

¹⁵⁷ 本田實信, 『モンゴル時代史研究』 (東京: 東京大學出版會, 1991), pp. 201-202 нөгөө талаар Buel нь il qan ~ el qan-ыг “Qan of a pacified area” гэсэн утгатай гэжээ. Cf. P.D. Buell, *Historical Dictionary of the Mongol World Empire* (Lanham, Md: Scarecrow Press, 2003), p. 48, p. 150, p. 165.

¹⁵⁸ G. Doerfer, *Türkische und Mongolische Elemente im Neupersischen*, vol. 2 (Wiesbaden: Franz Steiner, 1963), pp. 207-209.

¹⁵⁹ Ö. Diler, *İlhanlar: İran Moğollarının Sikkeleri* (Istanbul: Turkuaz Kitapçılık, 2006); B. Nyamaa, *The Coins of Mongol Empire and Clan Tamgha of Khans*, 211 ff. -ыг үзнэ үү.

чухал зүйлийг илрүүлжээ.¹⁶⁰ Фувати 1260-70 онд, хорь гаруй жил Марагагийн номын санд ажилласныхаа дараа алдартай түүхч, улс төрч Ата малик Жувэйний санал болгосноор 1280-81 онд төрсөн нутаг Багдадын Мүстансириа Мадраст харьяалагдах номын сангийн эрхлэгчээр томилогдож, 1312-13 оныг хүртэл ажилласан хүн юм. Тухайн үеийнхээ алдарт хүмүүсийг нэр цолных нь дарааллаар жагсааж, товч намтрыг нь бичсэн бүтээлдээ Чингис ханыг ““al-mughūlī al-īlkhān al-a‘ḡam ” буюу “монгол хүн, хамгийн аугаа ил хан” гэжээ.

Мэдээж Чингис ханыг нас барснаас хойш удаан хугацааны дараа бичсэн энэ бичигт үндэслэн түүнийг амьд сэрүүнд нь ингэж дуудаж байсан гэх аргагүй. Гэхдээ энэ жишээ нь “ил хан” гэдэг цолтой холбоотой хоёр чухал зүйлийг бидэнд ойлгуулж байна. Нэгдүгээрт, “...-нд харьяалагдах” гэсэн утгатай биш болохыг харуулна. Хэрэв тийм утгатай үг байсан бол Чингис ханыг тэгж дуудна гэдэг төсөөлөх ч аргагүй хэрэг юм. Хоёрдугаарт, Чингис ханыг “ил хан” гэж цоллож байсан гэдэг бол уг цол нь зөвхөн Хүлэгү болон түүнийг залгамжлагчдын л цол байсан гэсэн үг биш болохыг үзүүлж байна. Рашид ад Дины “Судрын чуулган” болон бусад сурвалжид Зүчийн улсын удирдагчдыг “ил хан” гэсэн баримт олдож байгаа бөгөөд энэ нь зохиогчдын алдаа бус харин бодит байдал дээр тэднийг бас тэгж дуудаж байсныг нотлох баримт юм.¹⁶¹

Би бээр одоо Рүм Сэлжүкийн засаг газарт ажиллаж байсан Ибн Биби-гийн 680/1281-2 онд бичсэн ‘al-awāmir al-‘alā’iyūa fi’l-umūr al-‘alā’iyūa (эрхэм дээд ажил үүргийн тухай дээд зарлиг)’ -т тулгуурлан “ил хан” цолын үүсэл гарлын тухай өгүүлэл бичихээр бэлдэж буй тул цаашид энэ талаар илүү тодорхой бичихээс түдгэлзэв.¹⁶² Гэхдээ урьдчилсан байдлаар, ил хан цолыг Баруун Азийн түрэгүүд Монголын эзэнт гүрний Хар Хорум дахь удирдагчдыг дууддаг цол байснаа хожим Хүлэгү тэр газрыг эзэлж, шинэ удирдагчаар тодормогц Хүлэгү болон түүний залгамжлагчдыг дуудах цол болжээ хэмээн дүгнэж байна.

Ингэж үзэх аваас бид Жувэйнигийн тэмдэглэлээс нэгэн сонирхолтой зүйлийг тодорхой ойлгох боломжтой болно. Юу гэвэл, Хүлэгү Баруун Азийг дайлаар мордоод, 1256 оны 11-р сард Рүкн ал Дин-ыг захирч асан Исмайлын хүчинг төвшитгөх үеийн талаар өгүүлсэн хэсэгт Хүлэгүг “ил хан” гэсэн байдаг. Өмнө дурдсанчлан Баруун Азийн түүхэн сурвалжид уг цол анхлан гарах цаг хугацааг 1258-59 оны хавьцаа, Маяафарикин

¹⁶⁰ Devin DeWeese, “Cultural Transmission and Exchange in the Mongol Empire: Notes from the Biographical Dictionary of Ibn al-Fuwatī,” In *Beyond the legacy of Genghis Khan* (ed. L. Komaroff, Leiden: Brill, 2006), pp. 11-29.

¹⁶¹ Хүлэгүгийн улсынхаас гадна бусад олон ванг “ил хан” гэж нэрлэсэн баримтын талаар Michael Hore-ын “Some Remarks about the Use of the Term ‘īlkhān’ in the Historical sources and Modern Historiography of the Mongol Empire”-ыг үзнэ үү.

¹⁶² Станбулын Аяасофия номны санд хадгалагдаж буй эхийн хуулбарыг 1957 онд Ibn-i Bibi. EI-Evamirü’l-‘Alā’iyūe fi’l-umūri’l-‘Alā’iyūe (ed. N. Lugal, A. S. Erzi. Ankara) нэртэй хэвлэсэн ба, H.W. Duda-гийн герман хэлээр, түүвэрлэн орчуулсныг хэвлэсэн байна. (Die Seltchukengeschichte des Ibn Bibī, Kopenhagen: Munksgaard, 1959). Саяхан Иранд Al-Avāmir al-‘alā’iyah fīal-umūr al-‘alā’iyah (Tehrān: Pizhūhishgāh-i ‘Ulūm-i Insānī va Muṭāla‘āt-i Farhangī, 2011) нэртэй хэвлэжээ.

руу довтлох үед гэж Амитай профессор өгүүлсэн билээ. Харин Жувэйни аль 1256 оны үйл явдлыг дүрслэн бичихдээ Хүлэгүг хоёр ч удаа “ил хан” хэмээжээ.¹⁶³ “Ил хан” цолны талаар өмнө бидний хийсэн дүгнэлтийг санавал энэ нь байж болох үзэгдэл юм.

Ингээд товч дүгнэлт хийвэл, “хан” гэдэг цол нь угтаа Чингисийн угсааны ноёдыг дуудах “албан ёсны” цол биш байжээ. Хааны харьяаны олон улсын удирдагчдыг, улсынх нь том жижгээс үл хамааран албан ёсоор хүүн (kò'ün) гэж дууддаг байв. Гэхдээ Хүлэгүгийн баруун тийш хийсэн байлдан дагуулал амжилттай болж, өргөн уудам газар нутаг, хүн амыг захиран суух болсноос нь хойш нутгийн оршин суугчид шинээр тодрон гарсан монгол ноёдыг “хан” гэж дуудах болсон байна. Хүлэгү болон түүний залгамжлагчдыг “ил хан” гэж цоллох болсон бөгөөд улмаар Зүчийн улсын удирдагчдыг ч мөн “хан” гэж цоллох болжээ.

Энэчлэн “хан” цол нь Монголын эзэнт гүрний улс төрийн дэг журмыг илэрхийлэх албан ёсны цол биш юм бол эзэнт гүрний хамгийн дээд удирдагч болох хаан болон түүний захиргааны олон вангуудын эрэмбийг чухам ямархуу аргаар илэрхийлдэг байсан юм бол? Эзэнт гүрнийг бүрдүүлэх улсуудын удирдагчид нь бүгд улс төрийн хувьд адил зэрэг дэвтэй байгаагүй нь тодорхой. Тэд хааны эрэмбэлснээр зэрэг дэв нь тогтдог, түүнийг дагаад тодорхой эрх ямба эдэлдэг байв. Би бээр энэхүү эрэмбэ, зэрэг дэвийг харуулах гол зүйл бол цол хэргэм, тамга тэмдгийн журам гэж үзэж байна. Хаан нь Чингисийн угсааныхан болон хааны хүргэн, гавьяат сайд нарт цол хэргэм олгож, түүндээ дүйх тамга тэмдэг цутгаж өгдөг байлаа. Одоо бид энэхүү хэргэм цол, тамга тэмдгийг хэрхэн олгодог байсан тухай журмыг нарийвчлан судалснаар Монголын эзэнт гүрний улс төрийн дэг журмын нэгээхэн хэсгийг илүү тодорхой болгоё.

2. Монголын эзэнт гүрний хэргэм зэрэг олгох журам

(1) Хаан улсын хэргэм зэрэг, тамга тэмдгийн журам

Монголын эзэнт гүрэнд тамга тэмдэг соёрхох журам Чингис ханы үеэс эхэлжээ. Чингис хан бага дүү Отчигиндоо “Хуандигийн дүүгийн эрдэнийн тамга” гэдэг бичигтэй тамга соёрхсон¹⁶⁴ ба зээ Алчидай – Хачиуны хүүд “Хуандигийн зээгийн эрхэм дээд, эрдэнийн тамга” гэдэг бичигтэй тамга соёрхжээ. Мөн Өгөдэй, ах Цагаадайдаа “Хуандигийн ахын эрдэнийн тамга” гэсэн бичигтэй тамга соёрхож байв.¹⁶⁵ Чингисийн угсааны биш хүнд ч тамга олгосон тохиолдол байна. Жишээлбэл, Мухулайд “Улсын ван” цолны зэрэгцээ “Үр ачид нь уламжлуулсан улс, үеэс үед үл тасрах” гэсэн бичээстэй алтан тамга, хонгирад аймгийн Алчин ноёнд мөнгөн тамга соёрхжээ. Үүнээс гадна, Онгудын хүргэн Сэнгүи, Зүрчидэйн хүү Хэтэи, Үидарын хүү Манга нарт ван цол, тамга соёрхож байв.¹⁶⁶ Ер нь бол Хятадад 寶 юм уу, 璽 үсгийг зөвхөн хуандид л хамаатуулж ашигладаг

¹⁶³ Juwaynī/Boyle, p. 632, p. 636.

¹⁶⁴ 元史, 卷 134 「撒吉思傳」, p. 3243

¹⁶⁵ 元史, 卷 139 「乃蠻台傳」, p. 3352.

¹⁶⁶ 李治安, 『元代政治制度研究』 (北京: 人民出版社, 2003), pp. 435-436

тул олон ванд “эрдэнийн тамга” гэсэн үсэг бүхий тамга олгох нь Хятадын уламжлалт үзлээс туйлын харь хөндий зүйл гэж хэлж болох юм.

Хубилайн засаглалын үед хэргэм зэрэг, тамга тэмдэг олгохыг албан ёсоор журамлаж эхэлжээ. Тухайлбал, энэ талаар “Юань улсын судар”-ын “Олон вангийн шастир”-т дараах тайлбар бий.

Юань улс мандан бадарснаар хааны хүргэдийг “олон ван” хэмээн нэрийдэв. Ёсны юм хуваарилах, хувь газар олгох зэрэг нь ерөнхийдөө ураг төрлийн ёсыг гүйцэтгэж буйг илэрхийлж буй явдал тул (уг хэрэг нь) ач ивээлийг өгүүлшгүй. Гэхдээ анхандаа энэ журам нь нэлээд бүдүүн бааз байж, хэргэм зэргийн нэр үгүй, зөвхөн тамгыг нь харж байж, хүнд хөнгөнийг ялгадаг байв. Хожим хойно, улс болон идэх хотын нэртэй болгосон ч тамга соёрхох нь урьдын хэвээр.¹⁶⁷

Хубилай хаан 1287 онд Сэнгийн саналыг хүлээн авч, олон вангуудад “之寶” гэдэг үсэгтэй тамга олгохыг болиулжээ.¹⁶⁸ Мөн тамгыг хийсэн материал, ур хийцээр зургаан хэргэм зэрэгт тааруулан олгох 紐獸 журамтай байсан бөгөөд “Юань улсын судар”-ын 108 дугаар дэвтэрт (1)араатан бариулт алтан тамга - 金印獸紐, (2) мухар луун бариулт алтан тамга - 金印螭紐, (3) тэмээн бариулт алтан тамга - 金印駝紐, (4) алтан түрхэцтэй, тэмээн бариултай тамга - 金鍍銀印駝紐, (5) яст мэлхийн бариултай алтан тамга - 金鍍銀印龜紐, (6)яст мэлхийн бариултай мөнгөн тамга - 銀印龜紐 гэж тэмдэглэжээ. Хубилай хаан ураг төрлийн барилдлага, авааль ба татвар эмийн үр, улс төрд гүйцэтгэсэн гавьяа зэргийг харгалзан зэрэг дэв тогтоожээ. Уг илтгэлд Юанийн сүүл үеийг хүртэл соёрхсон 150 орчим ван цол болоод уг цолыг хүртсэн хүмүүсийн нэр бий.

Хубилайн үед энэ мэт зэрэг дэвд тааруулан хэргэм цол олгох журмыг харьцангуй хатуу мөрдсөн ба Төмөрийн засаглалын үе хүртэл дагаж мөрджээ. Ли Шиань-ий судалгаанаас үзэхэд Хубилайн засаглалын сүүлийн жилүүдэд 37 хүнд ван цол болон тамга соёрхсоноос нэгдүгээр зэргийн ван цол хүртсэн хүн гэвэл дотоод харьяат улс Корйөгийн улсын вангаас гадна ураг төрлийнх нь хоёрхон л хүн байна. Хоёр болон гуравдугаар зэрэгт ч бас Хубилай хааны хатнаас мэндэлсэн хоёр хүү, сул хатнаас мэндэлсэн хоёр хүүгээс гадна, их сууринд суухад нь тусалсан Дондао-гийн олон ван Есүнгэ болон Зауту, түүний зээ Шириги, Еронташи, Чандун нар л байна. “Корйөса - Корйө улсын төрийн түүх. Орч.” -д Корйөгийн Чхүннйөл ван нь 1294 оны 4-р сард болсон ордны найранд 7-р зэргийн суудалд суусан бол 1300 оны 6-р сарын найранд 4-р зэргийн суудалд дэвшжээ.¹⁶⁹

¹⁶⁷ 『元史』, 卷 108 「諸王表」, p. 2735

¹⁶⁸ 『元史』, 卷 14 「世祖・十一」, p. 301: “戊寅, 桑哥言, ‘北安王王相府無印, 而安西王相獨有印, 實非事例, 乞收之. 諸王勝納合兒印文曰皇姪貴宗之寶, 寶非人臣所宜用, 因其分地改為濟南王印為宜.’ 皆從之.”

¹⁶⁹ 『高麗史』 卷 31, 忠烈王 20 年(1294) 四月甲午, 上, p. 633; 忠烈王 26 年(1300) 六月壬子, 上, p. 647

Тэр бээр харьяат улсын эзэн атал хэрхэн ингэж өндөр зэргийн суудалд хуваарилагдсаны учир юу вэ гэвэл, нэгдүгээр зэрэгт тэнцэх алтан тамга эзэмшиж байсанд оршино.

Гэвч Хайсан болон түүний залгамжлагчдын үед энэ мэт үзэл санааг ихэд булингартуулж, хэргэм зэргийг замбараагүй олгох болсон байна. Хубилайн үед ердөө хоёрхон байсан нэгдүгээр зэргийн олон вангийн тоо 37 болон олширч, “ургийн ван бус бол нэг үсэгтэй хэргэм зэрэг олгохгүй” гэдэг зарчим алдагдан садан төрлийн олон ван, хүргэн, гавьяат сайдууд хүртэл нэг үсэгтэй хэргэм хүртэх болжээ. Улмаар нэг хүнд нэг л хэргэм цол олгох журам алдагдаж, хэд хэдэн хэргэм цол олгох үзэгдэл хүртэл гарав. Энэ бол их сууринд суухад нь тусалсан гавьяатныг урамшуулан шагнах, ямбатан дээдсийг аргадан тайтгаруулах, улс төрийн хувьд урвуулан талдаа татах арга зэрэгтэй холбоотойгоор үүсэн гарсан ажээ.¹⁷⁰

Гэхдээ энэхүү “Олон вангийн шастир”-ыг нарийн ажиглавал ван цол хүртсэн 150 хүн дунд Зүчи болон Хүлэгүгийн улс, тэрчлэн Төв Азийн Цагаадайн улсын удирдагчдаас бараг л хүн алга буйг нягталж болно. Ердөө хоёр л хүн буй нь, 1-р зэргийн су ван Тогтох болон 5-р зэрэгт хамаарах жин юань ван Хачан нар юм. “Юань улсын судар”-ын 107-р дэвтэрт Тогтох нэртэй хүн Зүчи тайзын 太子位下 -д нин сү ван Тогтох гэж тэмдэглэсэн байдаг бол түүний хүүг сү ван Гуанчэ гэж тэмдэглэсэн байна.¹⁷¹ Нөгөө талаар 合贊 нь мөн л 107-р дэвтрийн Хүлэгү их вангийн 位下 -д жин юань ван 合贊 гэж тэмдэглээд гуан пин ван Харбанд гэдэг дүүтэй гэсэн нь буй.¹⁷² Ингээд үзэхээр тус тус Зүчийн улсын эзэн Тогто (Тоqто), Хүлэгүгийн улсын эзэн Газан (Ghazan) мөн Харбанда (Kharbanda буюу Öljeitü Khan)-ыг хэлж буй мэт. Хэрэв энэ нь үнэн аваас баруун зүгийн хоёр улсын удирдагчид бээр хаан улсын хэргэм зэрэг олгох журмыг дагаж байсан гэсэн үг болно.

Гэхдээ 107, 108 дугаар дэвтэрт буй эдгээр тэмдэглэл нь бодит байдалд нийцэхгүй байна. Юуны өмнө, “Олон вангийн шастир”-т сү ван, мөн нин сү ван(寧肅王) гэж тэмдэглэсэн Тогтог Зүчийн үр удам бус, харин Цагаадайн удамд хамаарах Чүбэйн хүү гэж ойлгох нь зөв. Учир нь, Козловын экспедицийнхэн авч одсон Хар балгаснаас олдсон бичиг дунд, тухайлбал ТК204, ТК248-д 赤令兄失加大王, мөн 亦令只失加普寧肅王 гэж тэмдэглэсэн хүний нэр гарах бөгөөд тэр бол даруй Цагаадайн удмын Тогтохын ач хүү юм. Тогтох нь жиюаний тэргүүн (1308) онд нинсү ван цол, дараа жил нь алтан тамга хүртжээ.¹⁷³ Тийм учраас “Юань улсын судар”-ын 107-р дэвтэрт Тогтохыг 赤太子位下

¹⁷⁰ 野口周一, 「元代武宗期の王號授與について」, 『アジア諸民族における社會と文化(岡本敬二先生退官紀念論集)』, 1984).

¹⁷¹ 『元史』, 卷 107 「宗室世系表」, p. 2715

¹⁷² 『元史』, 卷 107 「宗室世系表」, p. 2720.

¹⁷³ 赤坂恒明, 「バイダル裔系譜情報とカラホト漢文文書」, 『西南アジア研究』 66 (2007), pp. 53~55 赤坂恒明 бээр энэхүү Тогтох нь “Юань улсын судар”-ын 107-р дэвтэр, 「宗室世系表」-нд

гэж тэмдэглэсэн нь “Юань улсын судар”-ыг эмхэтгэгчдийн алдаа эндэл гэж үзэхэд хүргэж байна. 靖遠王 合贊-ыг мөн л Хүлэгүгийн улсын Газан гэж үзэх нь учир дутагдалтай. “Юань улсын судар”-ын өөр хэсэгт 靖遠王 гэдэг нэр гардаг бөгөөд ”Алтан ургийн гэрийн бичгийн тэмдэглэл(宗室世系表)”-д түүний удмыг Өгөдэй → Хүчү(闊出) → Ширэмүн (昔列門太子) → Болладчи 不拉드奇(孛羅赤大王) → 靖遠王合歹 гэж тэмдэглэсэн байх¹⁷⁴ ба жиюаний 27-р (1290) онд Хубилай хаан түүнд алтаар бүрсэн мөнгөн тамга соёрхжээ.¹⁷⁵ Дундад Иргэн Улсын Хэвлэлийн газрын редакторууд нягталж зассанчлан 靖遠王合贊-ыг 靖遠王合帶(эсвэл 合歹)-ий алдаатай хуулбар гэж үзэх хэрэгтэй. 廣平王 哈兒班答 ч мөн л 廣平王 哈班(Qaban)-ийг алдаж хуулсан хувилбар гэдэг нь тодорхой.¹⁷⁶ 宗室世系表-д гарах эдгээр алдаа нь Тао Зун и (陶宗儀)-гийн “Өмнөд тосгонд тариаланг зогсоосон тэмдэглэл (南村輟耕錄)”-ий “Их Юанийн алтан ургийн угийн бичиг (大元宗室世系)”-г тэр хэвээрээ давтагдаж байна. Этвүүд(С. Atwood)-ий дурдсанчлан уг хоёр бичвэр нь адилхан нэг сурвалжаас ишилсэн тул¹⁷⁷ эдгээр алдаа нь эх бичгийн алдаанаас үүдсэн гэдэг нь ч тодорхой байна.

Дээрхээс үзэхэд бид “Юань улсын судар”-ын Олон вангийн шастирт гарч буй ван цолтнууд бүгдээрээ Хаан улсын газар нутагт оршин суугчид байжээ хэмээн дүгнэж болно. Тэгвэл Хаан улсын цол хэргэм хүртээх журам нь ямар ач холбогдолтой зүйл байв? Уг журам нь Монголын улс төрийн уламжлалт ёсонд суурилсан зүйл бус бөгөөд Хубилайг их сууринд сууснаас хойш шинээр хэрэгжүүлсэн журам, гэхдээ Хятад маягийн журмыг хуулбарласан зүйл гэдэгтэй маргах зүйл байхгүй. Тэгвэл үүнийг Монголын эзэнт гүрний ноёлогч анги болох Чингисийн удмынхны улс төрийн дэг журам, эрэмбэ дэсийг хятад маягаар илэрхийлсэн журам гэж үзэж болох уу. “Юань улсын судар”-г гарах олон вангийн дунд идэх хот, эзэмших газрынх нь ганц ханз үсэгтэй, эсвэл хоёр ханз үсэгтэй нэрийн араас ван гэж залгасан бүлэг хүн байхад эзэмших газрын нэргүйгээр зөвхөн өөрийнх нь нэрийн араас их ван, эсвэл ван гэдэг үсэг залгасан хэсэг хүн байна. “Юань улсын судар”-ын Олон вангийн шастирт цөөхнийг нь л тэмдэглэсэн бөгөөд бодит байдал дээр Юанийн үед идэх хотгүй олон вангийн тоо хамаагүй их байсан болов уу. Энэчлэн Хаан улсын олон вангуудыг хэргэм зэрэг хүртсэн ч идэх хоттой ба идэх хотгүй гэж хоёр бүлэгт хувааж болохоор байна. Тэгвэл тэдний хооронд ямар ялгаа байна вэ? Олон ван цолонд залгасан идэх хотын нэр нь зүгээр л хэлбэрдэх гэсэн юм уу, эсвэл нэр төрийг илэрхийлсэн төдий зүйл байв уу. Би бээр, тийм бус гэж үзэж байна. Идэх хотын

гарах 朮赤太子位下-ы нинсу ван Тогтохтой ижил нэртэй өөр хүн гэж үзсэн ба гэхдээ тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан үзвэл 「宗室世系表」-ын алдаа гэж үзэх нь зүйд нийцнэ.

¹⁷⁴ 『元史』, 卷 107 「宗室世系表」, p. 2717

¹⁷⁵ 『元史』, 卷 16 「世祖・十三」, p. 333

¹⁷⁶ 『元史』, 卷 33 「文宗・二」, p. 744

¹⁷⁷ C.P. Atwood, “Six Pre-Chinggisid Genealogies in the Mongol Empire,” *Archivum Eurasiae medii aevi* (2012), pp. 5~58.

нэр нь ерөнхийдөө Хятадын тодорхой газар нутгийг зааж байсан бөгөөд тэр нь даруй уг олон ван умард Хятадад өөрт нь хувь болгож олгосон эзэмшил газар болон ард иргэнтэй байсныг харуулна. Гэхдээ олон вангууд нь голцуу л Хятадын газар нутагт бус харин умардын тал нутаг буюу эх нутагтаа амьдран суудаг байв.¹⁷⁸ Эх нутагт нь өөрсдийнх нь эзэмшил газар, захирдаг ард иргэд нь байлаа. Тийм учраас эдгээр идэх хоттой олон вангуудыг эх нутагтаа болоод Хятадад хувь эзэмшил газар, харьяалсан иргэдтэй хүмүүс гэж хэлж болох бөгөөд өөрөөр хэлбэл өөрийн гэсэн улс(ulus) эзэмшдэг байсан нь тодорхой байна. Энэ талаас нь харвал Хубилайн хэрэгжүүлсэн хэргэм зэрэг олгох журам бол Монголын “улс тогтолцоо”-нд хятад маягийн хэлбэр оруулснаар үүссэн үр дүн гэж хэлж болох юм.

(2) Өрнийн гурван улсын цол хэргэм-Хүлэгүгийн улсын жишээн дээр

Ингээд бид “Юань улсын судар”-ын “Олон вангийн шастир”-т зөвхөн Хаан улсын газар нутагт оршин суусан олон вангуудын нэр л байхаас, дотроо аварга том улсуудтай Өрнийн гурван улсын олон вангуудаас ганцынх нь ч нэр байхгүйг нягтлалаа. Тэгвэл их хан өрнийн олон ванд хэргэм зэрэг, тамга тэмдэг соёрхдоггүй, эзэнт гүрний хэргэм зэрэг олгох журам тэдгээр вангуудад хамаагүй зүйл байв уу? Үүнийг тэрлэгч би бээр, тийм бус гэж үзэж байна. Учир нь хаан эдэнд ч бас хэргэм зэрэг, тамга тэмдэг соёрхсон тухай мэдээ олон сурвалжид гарч байна.

Хүлэгүгийн улсын эзэд хаадын зарлиг бичигт хааны соёрхсон тамга болов уу гэмээр хэд хэдэн тамга дараатай буй. Жишээ нь, 1289 оны Аргуны захидалд ‘輔國安民之寶(Төр улсыг баригч, түмэн олныг төвшрүүлэгчийн тамга гэсэн утгатай)’ гэсэн бичээстэй тамга, 1302 оны Газаны зарлиг бичигт ‘王府定國理民之寶’ гэсэн бичээстэй тамга дараатай байдаг¹⁷⁹ ба энэ нь Хүлэгүгийн улсын эзэд ханз үсэг сийлсэн тамгатай байжээ гэдгийг харуулах баримт юм. Мэдээж, монгол хаад ханз үсгийн хэв зэрэг нарийн ширийн зүйлийг ялгаж, утгыг нь мэддэг байгаагүй л болов уу. Зүгээр л үл мэдэгдэх үсэг сийлээтэй, алтаар хийсэн төрийн тамгыг улаан бэхэнд дүрээд өөрийн зарлиг бичигт дарах тэр үйлдэл нь улс төрийн эрх мэдлийн бэлгэдэл болдог, түүнийг хүлээн зөвшөөрдөг байсанд оршино. Хүлэгүг үхсэний дараа Абагаг өргөмжлөх ёслолыг гүйцэтгэхийн тулд Хубилай хаанаас зарлиг бичиг (farmān, jarlīgh)ирэхийг хүлээсэн хэмээн Рашид ад Дин тэмдэглэжээ.¹⁸⁰ Өөрөөр хэлбэл, Хүлэгүгийн улсын удирдагчийг их сууринд залахын тулд их хан түүнийг соёрхсон зарлиг бичиг явуулдаг байсан бөгөөд

¹⁷⁸ Шожи Мураками(村上正二)-ын үзсэнээр ‘本投下’ нь нүүдэлчдийн газар нутагт орших, урьд өмнөх эзэмшил хувь газар нутгийг нь хэлэх бөгөөд байлдан дагуулсан газар нутгийн ард иргэдийн бүртгэл гэж хэлж болох ‘一般投下’-ээс ялгаатай гэжээ. Түүний 『モンゴル帝國史研究』(東京: 風間書房, 1993), pp. 9-15-ыг үзнэ үү.

¹⁷⁹ A. Mostaert & F. W. Cleaves, “Trois documents mongols,” үзнэ үү.

¹⁸⁰ Rashid al-Din Tabib, Jami‘u‘t-Tawarikh: Compendium of Chronicles, tr. W. M. Thackston (3 vols., Harvard University, Dept. of Near Eastern Languages and Civilizations, 1998), vol. 3, p. 517.

ингэхдээ түүний байр сууринд тохирох тамга тэмдгийг хамт илгээдэг байсан болов уу хэмээн таамаглаж болох юм.

Гэхдээ өмнө дурдсанчлан Ахмадын санал болгосноор 1287 оноос хойш ‘之寶’ гэсэн үсэгтэй олон вангийн тамга олгохоо байжээ. Аргүн, Газан нарын тамга нь бүгд 1287 оноос хойших бичиг баримт дээр дараатай хэдий ч хэрвээ хааны соёрхсон тамга гэж үзвэл 1287 оноос өмнө хэдийн хийгээд илгээсэн тамга гэж үзэх нь зүйд нийцнэ. ‘輔國安民’ юм уу, эсвэл ‘王府定國理民’ гэсэн бичээс нь Хүлэгүгийн улсын удирдагчдыг эзэнт гүрний хамгийн дээд захирагч болох хаанд тусалж, вант засаглалаа бэхжүүлэн улс орноо амар амгалан байлгахын төлөө хүчин зүтгэхийг хөхүүлэн шаардсан утга агуулгатай тул их ханы соёрхсон тамга гэж үзэх нь зөв. Гэхдээ 1305 оны Өлзийтийн болон 1320 оны Абу сайдын захидалд дарсан тамганы ‘眞命皇帝天順萬夷之寶’ гэдэг бичээс анхаарал татаж байна. Уг тамганы бичиг болон хийсэн газрын талаар эрдэмтэд санал зөрдөг. Эхлээд бичгийг тайлж унших тал дээр санал зөрдөг бөгөөд ‘天順萬事’ уу? Эсвэл ‘天順萬夷’ үү? гэдэг дээр санал нийлээгүй хэвээр байна.¹⁸¹

Нөгөө талаар хаана хийсэн тамга вэ гэдэг талаар ‘眞命皇帝’ гэдэг үсэгтэй тамгыг хаан хүн олон ванд илгээх учиргүй тул Хүлэгүгийн улсынхан өөрсдөө дотооддоо хийсэн хэмээн А. Mostaert болон F. Cleaves нар үздэг бол¹⁸² ‘眞命皇帝’ нь Төмөр хааныг хэлж бөгөөд Төмөр хаан Өлзийт хааныг сууринд залах ёслолд хэрэглүүлэхээр илгээсэн гэж Т. Allsen үзжээ.¹⁸³ Миний бодоход хуанди тамгаа зон ван(宗王)-д өгч хэрэглүүлнэ гэдэг төсөөлөхөд бэрх хэрэг мэт. Тийм учраас Өлзийт хааны засаглалын үед “皇帝” буюу хуанди хэмээн өөрийн биеийг хэт дөвийлгөж цоллосон үсэг бүхий тамгыг Хүлэгүгийн улсын дотоодод хийжээ хэмээн үзэх нь зөв болов уу.

Эдгээрээс үзэхэд Хүлэгүгийн улсын захирагчдад хэдийгээр хаан улсын зургаан дэвтэй хэргэм зэргийн журам үйлчилдэггүй ч хааны үйлдэж, соёрхсон тамгыг хэрэглэж байснаас үзэхэд эзэнт гүрэнд бүхэлд нь хүчинтэй уг журмын хүрээнд оршин байжээ гэдгийг харж болохоор байна.

1287 онд тамганы журамд өөрчлөлт оруулснаас хойш урьдын ‘之寶’ гэдэг үсэг бус, харин ‘之印’ гэдэг үсэг сийлсэн шинэ тамга хүлээн авсан болов уу хэмээн таамаглаж байна. Хүлэгүгийн улсын захирагчид 1287 оноос хойш ч урьд өмнө хэрэглэж байсан ‘之寶’ үсэгтэй тамгаа үргэлжлүүлэн хэрэглэсэн нь шинэ тамгыг “зэрэг бууруулсан” тамга гэж үзсэнтэй холбоотой гэж таамаглах боломжтой. Сүүлийн үед Хүлэгүгийн улсаас гаргасан хэдэн зарлиг бичиг шинээр олдож, тэр талаар судлаачид судалгааны үр дүнгээ хэвлүүлсээр байгаа бөгөөд үр дүнд нь ‘之印’ гэдэг үсэг сийлээтэй дөрвөн ширхэг тамгыг судалгааны эргэлтэд нэмж оруулжээ. Тухайлбал, (1) 1305 оны *ṣaḥib dīvān*(財務長官)-

¹⁸¹ 照那斯圖,「蒙元時期宮廷文書的印章文字」,『民族語文』,3(1997).

¹⁸² A. Mostaert & F.W. Cleaves, “Trois documents mongols des Archives secrètes vaticanes,” pp. 484-485.

¹⁸³ Thomas T. Allsen, *Culture and Conquest in Mongol Eurasia* (Cambridge, UK: Cambridge 中央아시아 研究 第 21 號 第 2 卷 - 20 -

гийн хэрэглэж байсан 行戶部尙書印, (2) 1293 онд vazīr(宰相)-ын хэрэглэж байсан 王府之印, (3) Qutluq Shāh(1307 онд насан эцэслэсэн)-ы хэрэглэж байсан 右樞密使之印, (4) Amīr Ḥusayn(1322 онд насан эцэслэсэн) хэрэглэж байсан 總官隱院之印 тамганууд болно.¹⁸⁴

Эдгээр тамганы бичээсэнд ‘行戶部’ юм уу, эсвэл ‘王府’ гэдэг үг хэрэглэснээс үзэхэд Хаан улсын тэргүүн Дундад Бичгийн Ямаар дамжуулан бусад олон вангийн засаг газар 王府 болон төлөөний яам 行省 руу илгээсэн тамгатай төстэй хэлбэрээр хийсэн болохыг илтгэнэ. Тэгэхээр тамгыг Хаан улсад хийгээд илгээсэн үү, эсвэл Хүлэгүгийн улсын дотоодод хийсэн үү гэдгийг шууд хэлэх аргагүй. Гэхдээ хаана ч хийсэн бай, тамганы бичээс нь Хүлэгүгийн улсыг Хаан улсын дотоодын нэгэн төлөөний яам, вангийн засаглал хэмээн тооцсныг илэрхийлж буй нь тодорхой юм. Гэхдээ энэ нь Хүлэгүгийн улсын захирагч Өлзийт болон Абу саид нарын ‘眞命皇帝’ буюу “Чэнзун хуанди” гэдэг үсэгтэй тамга хэрэглэж байсантай эрс зөрчилдөнө гэдгийг бид анхаарах шаардлагатай. Тэд хаантай харилцахдаа өөрсдийгөө “хуанди” гэж нэрлэх нь байж болшгүй зүйл тул уг тамгыг зөвхөн өөрийн улсын дотоодод ашигладаг байжээ гэж үзэх нь зүйд нийцнэ. Тэгэх юм бол энэ нь даруй Зүүн Азийн улс орнуудад нэлээд түгээмэл үзэгдэл болох гадагш харилцахдаа тэргүүнээ ван гэж дуудаад, дотоодын харилцаандаа хуанди гэж өргөмжилдөг журмаас өөрцгүй зүйлгүй болж байна. “Юань улсын судар”-аас үзэхэд Хүлэгүгийн улсын Абу саид нь хүндтэй гавьяа байгуулсан Чубан (出班, Chuban)-д албан тушаал, хэргэм зэрэг олгохыг их хаанаас хүсэхэд 開府儀同三司 · 翊國公 гэдэг тушаалын хамтаар мөнгөн тамга, алтан гэрэгэ 金符 соёрхсон гэдэг.¹⁸⁵ Өөрөөр хэлбэл, дотооддоо албан бичигт “Чэнзун хуанди” гэдэг үсэгтэй тамга хэрэглэдэг Абу саид нь гадаад харилцаандаа буюу хаанд өргөх бичиг барихдаа өөрийн албатдаа хаан улсад нийтэд нь хүчинтэй үйлчилдэг журмын дагуу хэргэм зэрэг хүртээхийг хүссэн байна. Энэ бол Хүлэгүгийн улс, эзэн хааны оройддог Монголын эзэнт гүрний нэгэн хэсэг гэдгээ дахин нотлохын зэрэгцээ өөрийн улсын дотоодын улс төрийн зэрэг дэвийг эзэнт гүрний улс төрийн зэрэг дэвтэй уяж холбох гэсэн хүсэл эрмэлзлийг илэрхийлж байна. Хубилайг нас барснаас хойш ч Хүлэгүгийн улсын удирдагчид дотоод гадаад харилцаандаа хаан = хуанди л хэрэглэж болох нэр томьёог хэрэглэсэн жишээ цөөнгүй олдож байна.

Жишээлбэл, их хааны нэрийн өмнөөс тушаасан албан бичгийг л зарлиг (jarligh; 聖旨) гэж нэрлээд бусад хүнийхийг бүгдийг нь үг (üge; 令旨 · 懿旨 · 法旨) гэх нь тухайн

¹⁸⁴ Gottfried Herrmann, *Persische Urkunden der Mongolenzeit: Text und Bildteil* (Wiesbaden: Harrassowitz Verlag, 2004), *Urkunde nrs*, 3, 5, 6, 7; Yokkaichi Yasuhiro, “Chinese Seals in the Mongol Official Documents in Iran: Re-examination of the Sphragistic System in the Il-khanid and Yuan Dynasties,” 『吐魯番學研究: 三屆吐魯番學暨歐亞游牧民族的起源與遷徙國際學術研討會』 (2010); “Āl-tamghā (Vermilion Seal) and Altūn-tamghā (Golden Seal) in the Sphragistic System of the Ilkhanid Dynasty (in Japanese),” 『歐亞學刊(Ouya xuekan)』10 (2012), pp. 311–355; “Four Seals in Phags-pa and Arabic Scripts on Amīr Čoban’s Decree of 726 AH/1326 CE,” *Orient* (The Society for Near Eastern Studies in Japan) 50(2015), pp. 25-33

¹⁸⁵ 『元史』, 卷 47 「泰定帝」, p. 651.

үеийн албан бичгийн үндсэн зарчим байлаа. Гэхдээ Газан ханаас хойш Хүлэгүгийн улсад үйлдсэн албан бичгийг шинжилбээс уг зарчмыг төдий л хатуу мөрдөж дагаагүйг мэдэж болно. Газан хан бээр шинэчлэлт хийхээр шийдээд зарлаж түгээсэн тушаах агуулгатай бичгүүдийг *yarlīgh* гэсэн нь тодорхой жишээ юм.

Энэ мэтээр улсын тэргүүнээ гадаад албан харилцаанд ван, дотоод албан харилцаанд хаан= хуанди гэсэн жишээг Хүлэгүгийн төдийгүй Цагаадайн улсынхаас ч олж харж болно. Энэ талаар “Өлзийтийн түүх”-нд нэгэн сонирхол татахуйц зүйлийг тэмдэглэж үлдээжээ. 1316/7 онд Цагаадайн улсын удирдагч Эсэнбөх (*Esen Buqa*), Алтай нутагт цэрэглэн суусан Хаан улсын цэргийн жанжин Тогачи чинсан (*Toghachi Chingsang*)-д элч илгээв.

Элч нар “Эсэнбөхийн зарлиг (*yarlīgh*) ийм байна” хэмээхэд Тогачи “Амаа тат! Зөвхөн эзэн хаан л зарлиг буулгана. Вангийнхыг линжи (*līngjī*) гэдэг юм” хэмээн зандарчээ. Тэгэхэд Балтөмөр “Эсэнбөх алтан ургийн хүн тул бидний хувьд эзэн хаан гэсэн үг” хэмээв.¹⁸⁶

Эндээс үзэхэд Цагаадайн улсын эзэн Эсэнбөхийн илгээсэн элчис эзнийхээ тушаалыг зарлиг *yarlīgh* гэж нэрлэхэд хааны илгээсэн жанжин болох Тогачи бээр, вангийн тушаалыг хэрхэн зарлиг хэмээн зүрхэлж нэрлэв хэмээн ундууцаж байна. Тэгэхээр Хүлэгүгийн улсад болсонтой адилаар Цагаадайн улсад ч бас дээрх нэр томъёоны асуудалтай холбоотой хэрэг явдал давтагдаж байжээ. Тэгвэл Зүчийн улсад мөн л иймэрхүү байсан болов уу хэмээн таамаглаж байна.

Гэхдээ өрнийн Гурван их улс нь урьдын хэвээр Их Монгол Улсын нэгэн хэсэг хэвээр байлаа. Гаднаас нь харахад ямартай ч эзэнт гүрнийг оройлох удирдагч нь хаан хэвээр байсан бөгөөд түүнийг бусад улсын тэргүүнүүд хүлээн зөвшөөрч байв. Энэ талаар Мамлюкын түүхч Үмари 1340 онд “Чингис ханы залгамжлагч болох их хан (*qān kabīr*)”-ы талаар бичсэнийг дор сийрүүлэе.

Тэр бээр дорно зүгт, Китаи-н Ханбалигт суудаг бөгөөд түрэгийн эртний улс болох Туран нутгийн гол эзэн юм. Тэр бээр (өрнийн) бусад гурван (удирдагч)-ийг яг л халиф мэтээр захирах эзэн эрхтэй (*ishāra*). Улсын чухал хэрэг, тухайлбал дайн тулаан хийх, ял үйлдсэн их амир яса буюу хууль (*ḥukm*)-ийн дагуу цаазлуулах болбол энэ талаар удирдагч (тус бүр) түүнд мэдэгдэнэ. Заавал тэгэх ёстой бус хэдий ч нэгэн төрлийн тогтсон хэв ёс болжээ. Пазл низам үд дин бин ал хаким ал катиб ал бусайдын өгүүлснээр бол хан (*qān*) нь бусад гурван хан (*qānāt thalātha*)-д ямагт бичиг илгээн эв нэгдэл, найрсаг журамтай байхын чухлыг анхааруулан сануулдаг ажээ. Тэдэнд илгээх захидалдаа бусад бүх хүнээс урьд бичих авч, тэд түүнд захидал илгээх үед нэрээ дурдахаас өмнө түүний нэрийг эхлээд бичнэ. Тэд сайн дураараа түүнд бүрэн тэргүүлэх эрхийг өгчээ.¹⁸⁷

¹⁸⁶ Abū al-Qāsim ‘Abd Allāh Kāshānī, *Tārikh-i Uljāitū* (ed. M. Hambly, Tehrān, 1348/1969), p. 203.

¹⁸⁷ al-Umarī/Lech, p. 110 (Arabic text, p. 27)

Үмари үүнийг хэдийгээр Мамлюкын улсад бичсэн хэдий ч Хүлэгүгийн улс болон Зүчийн улсын эрдэмтэн сайд, элчсээс тун чухал мэдээлэл олж авч чаджээ. Түүний ишлэлд дурдсан “Ал катаб ал бүсаиди” гэгч бол хамгийн сүүлчийн ил хан болох Абу саид(1316-1335)-ын ордны бичээч (kātib) асан тул Хаан улс ба бусад улсын харилцааны бичгийн хэлбэр, агуулгын талаар тун сайн мэдэж байсан болов уу.¹⁸⁸

Үмариин тэмдэглэлээс үзэхэд өрнийн Гурван их улсын эзэд дотооддоо бие даасан эзэн захирагч мөн хэдий ч гадаад талдаа бол хуучин хэвээр их ханы эрхэмсэг байр суурийг хүлээн зөвшөөрч, дотооддоо болсон чухал хэргийн талаар айлтган мэдэгддэг байсан байна. Гэхдээ энэ нь албат харьяатын эзэндээ гүйцэтгэх ёстой үүрэг мэт зүйл бус, харин нэгэн төрлийн “хэвшсэн ёс” мэт зүйл бөгөөд тэд сайн дураараа их ханы “тэргүүлэх эрх”, “эзэн эрх” -ийг хүлээн зөвшөөрдөг байжээ. “Юань улсын судар”-т Тогоонтөмөрийн засаглалын сүүл үе хүртэл эдгээр “баруун зүгийн олон ван”-гууд алба өргөж, түүнд таарсан “ёсны юм” буюу бэлэг сэлтийг хаан хариу барьсан тухай тэмдэглэл бий. Гэхдээ энэ бол Хятадын уламжлалт “алба барих” ёсыг дагуулан сударч түшмэд дураараа бичсэн зүйл бус харин тухайн үеийн Гурван улс ба Хаан улсын харилцааны хэргийн протоколын агуулгыг тусгажээ хэмээн үзэж болно.

Дүгнэлт

Монголын эзэнт гүрний дээд удирдагчийг нэрлэх хаан хэмээх цол нь Монголын эзэнт гүрнийг бий болохоос өмнө, 12-р зууны Монголын тал нутагт бараг хэрэглэж байгаагүй үг бөгөөд Өгөөдэйг их сууринд суумагц зөвхөн Өгөөдэйг заасан цол болон хэрэглэж эхэлжээ. Түүнийг нас барсны дараа Гүюг, Мөнхийн хаанчлалын үед улсын удирдагчийг заасан цолны утгаар хэрэглэж байсан ч урьдын хэвээр албан ёсны цол болж тогтоогүй байлаа. Тэгж байгаад Хубилайн үеэс Эзэнт гүрний удирдагчийг л заах цол болон хэвшиж тогтсон бөгөөд зарлиг бичгийг орчин цагийн хэлээр буулгасан хувилбарт хаан гэдэг үгийг орчуулахдаа хуанди хэмээн оноожээ. Төмөрийг их сууринд суусны дараа хаан цол нь эзэнт гүрний дээд удирдагчийг л нэрлэх албан ёсны цол болж тогтов. Хан цолыг Чингис ханаас өмнө ч Монголын тал нутагт аймаг болон аймгийн холбоо, бас улсын удирдагчийг заасан утгатайгаар нэлээд өргөн хэрэглэж байсан бөгөөд Чингис ханаас хойш ч тэр хэвээр хэрэглэгдэж байжээ. Жувэйнийн тэмдэглэлээс үзэхэд Монголын эзэнт гүрний удирдагч биш, гэхдээ алтан ургийн олон ванг нэрээр нь дууддаг байсан хэдий ч Зүчи болон Батын хувьд нас барснаас нь хойш нэгэн төрлийн хүндэтгэлийн нэр маягтайгаар Зүчи хан, Бат хан гэж дууддаг болжээ. Алтан ургийн олон вангууд “хан” цолыг харьцангуй өргөн хэрэглэж эхэлсэн үе бол Монголын эзэнт гүрэн баруун тийш өргөжин тэлснээс хойших үе болно. Чингис болон Өгөөдэйн үед монголчууд аль хэдийн Баруун Ази руу довтолж эхэлсэн бөгөөд Хүлэгүгийн удирдсан их цэрэг хүрч очин, Халифын дэглэмийг нурааж, амжилттай байлдан дагуулсны дараа,

¹⁸⁸ Ibid.

ноёлогч болон удирдагчдаа хан хэмээн нэрлэж дадсан нутгийнхан шинэ монгол удирдагчаа хан хэмээн цоллох болжээ. Ил хан хэмээн цол тийнхүү үүссэн бөгөөд ил нь “...-нд харьяалагдах” гэсэн утгатай бус, харин “олон хүн буюу улс, иргэд” гэсэн утгатай бөгөөд монгол хэлний улс гэдэг үгэнд дүйх түрэг үг юм. Хүлэгүгийн улсын удирдагчдыг ихэвчлэн “ил хан” хэмээн нэрлэдэг байсан ба Зүчийн улсын удирдагчдыг ч бас заримдаа тэгж нэрлэдэг байлаа. Гэхдээ “хан” цолыг Баруун болон Төв Азид хэрэглэж байснаас бус Монголын эзэнт гүрэнд нийтэд нь хэрэглэх албан ёсны цол биш байлаа. Монгол хэлний “олон ван”-тай дүйх үг нь хүү kö'ü(n) юм. Түрэгээр oghul, перс хэлээр shahzāda, ханзаар 王 · 諸王 · 大王 хэмээн орчуулна.

Хэргэм зэрэг, тамга тэмдэг олгох журам бол Монголын эзэнт гүрэнд харьяалагдах олон вангийн зэрэг дэвийг тогтоохын тулд гаргасан журам юм. “Юань улсын судар”-ын “Олон вангийн шастир”-аас үзэхэд Хубилайн үед хэвшиж тогтжээ. Уг журмаар нэгээс зургаа хүртэл зэрэг дэв тогтоож, түүнд нь таарсан тамга соёрхдог байв. Зэрэг дэвд нь таарсан эрх ямба олгох бөгөөд олон вангуудыг идэх хоттой ба идэх хотгүй гэж ангилдаг байв. Эхнийх нь Хятад болоод Монголын тал нутагтаа өөрийн гэсэн эзэмшил газартай хүмүүс юм. Уг журмыг Монголын уламжлалт улсын тогтолцоотой уялдуулан хэрэгжүүлсэн гэж үзэж байна. Идэх хоттой олон ван гэдэг нь даруй өөрийн улстай хүмүүс байжээ гэж хэлж болно.

Нөгөө талаар өрнийн Гурван их улсын олон вангийн нэр “Юань улсын судар”-т гарахгүй байна. Тэд хаан улсын зэрэг дэв олгох журмын гадна байжээ. Гэхдээ Хүлэгүгийн улсын жишээнээс харахад хаан тэдэнд тамга тэмдэг, ван цол соёрхож байсан нь тодорхой. Гэхдээ тэдэнд соёрхсон “...ний эрдэнийн тамга” нэртэй тамгууд нь 1287 оны шинэчлэлтээс хойш “..ний тамга” нэртэй болж өөрчлөгдсөн хэмээн таамаглаж байна. Харин Хүлэгүгийн улсын захирагчид эзэн хааны соёрхсон шинэ тамгыг хэрэглэлгүй, хуучин хэвээр “..ний эрдэнийн тамга”-аа зарлиг бичиг, албан бичигтээ дарсаар байжээ. Түүгээр зогсохгүй “Чэнзун хуанди” гэсэн үсэгтэй тамгыг үйлдэн хэрэглэж байв.

Үүний зэрэгцээ Улсын доторх том түшмэд нь урьдын хэвээр Хаан улсад “...ны тамга” гэдэг тамга хэрэглэж байв. Ийм хоёр төрлийн тамгатай байж гэдэг нь Хүлэгүгийн улсын хоёрдмол байр суурийг илэрхийлж байна хэмээн бодоход хүргэнэ. Өөрөөр хэлбэл, Хүлэгүгийн улс нь Хаан улсын хувьд нэгэн төрлийн төлөөний яам юм уу, эсвэл вангийн засаглалтай адил дотор нь харьяалагдах оршихуй байсныг харуулна. Тиймээс Хүлэгүгийн улсын удирдагчид урьдын хэвээр, улс төрийн хувьд эзэн хааны дор орших зэрэг дэвийг илэрхийлэх нэр томъёог хэрэглэж, түшмэд сайд нарт нь ч түүнд таарсан тамга тэмдэг соёрхжээ. Гэхдээ түүний зэрэгцээ Хүлэгүгийн улсын удирдагчид “...-ны эрдэнийн тамга”-ыг өөрсдийн дураар үйлдэн хэрэглэж, зарлиг бичгээ хүртэл зөвхөн хаан хүний хэрэглэж болох үгээр буюу yarligh хэмээн нэрлээд дотооддоо хуанди мэтээр их эрх мэдэл эдэлж байлаа. Би бээр энэхүү хоёрдмол байр суурийг “гадна талдаа ван, дотор талдаа хуанди (外王內帝)” гэж томъёолсон бөгөөд энэ нь зөвхөн Хүлэгүгийн улсаар

тогтохгүй өрнийн Гурван улсад бүгдэд нь адил байсан болов уу гэж үзэж байна. Энэ нь Монголын эзэнт гүрний дотоодод нэг улс нөгөө улстай харилцахад нийтлэг хэрэглэсэн улс төр, дипломат харилцааны арга хэлбэр, өөрөөр хэлбэл “улс, улс төр(the ulus politics)” -ын онцлог юм.

Тиймээс Хүлэгүгийн улсын удирдагчид Европын эзэн хаадад илгээсэн захидал бичигтээ ийм “улс, улс төр (the ulus politics)” -д баригдалгүйгээр “..-ы эрдэнийн тамга”-аа дардаг байжээ. Эцэст нь дүгнэж хэлэхэд Монголын эзэнт гүрэн нь 14-р зууны эхэн гэхэд улс төр, эдийн засаг, цэргийн хүчний хувьд бие даасан дөрвөн том улс буюу өөрөөр хэлбэл Дорнын Хаан улс ба Өрнийн Гурван улс болон хуваагдаж, тус бүр бие даасан байдалтай хөгжсөн байна. Гэхдээ гадна өнгөндөө бол хаан оройтой, нэгдсэн эзэнт гүрэн гэдэг нэгдмэл шинжээ хадгалсаар байлаа. Гурван их улсын удирдагчид нь “гадна талдаа ван, дотор талдаа хуанди” гэдэг хоёрдмол байр суурийг баримталснаар өөрийн улс төрийн тусгаар байдал, эзэнт гүрний нэгдмэл байдал хоёрыг тэнцвэржүүлдэг байжээ.